In partnership with Canada

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОР

IDLO
Creating a Culture of Justice
International Development Law Organization

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХОХИРОГЧ ТӨВТЭЙ ХАНДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ГАРЫН АВЛАГА

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХОХИРОГЧ ТӨВТЭЙ ХАНДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ГАРЫН АВЛАГА

Хоёрдугаар хэвлэл

In partnership with Canada

Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж буй
“Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг
бэхжүүлэх” (2019-2022) төслийн хүрээнд бүтээв.

Улаанбаатар хот
2021 он

Тус гарын авлагыг бэлтгэн гаргахад Канад Улсын Засгийн газрын дэмжлэгтэй Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)-ын хэрэгжүүлж буй "Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх" (2019-2022) төслийн хүрээнд санхүүжүүлэв.

Энэхүү төслийн зорилго нь иргэний нийгмийн болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлсэнээр жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжийг нэмэгдүүлж, хохирогч төвтэй үйлчилгээг хүргэж, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх юм.

Зохиогчийн эрх@ 2020. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)

Энэ гарын авлагын агуулга, илэрхийлэгдсэн үзэл бодлыг зохиогчид бие даан боловсруулсан бөгөөд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, түүний гишүүдийн үзэл бодол, байр суурийг илэрхийлэхгүй болно.

©Зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан.

Энэхүү гарын авлага нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд сургалтын зорилгоор ашиглах бол албан ёсны зөвшөөрөл авч, эх сурвалжийг дурдсаны үндсэн дээр үнэ төлбөргүй ашиглаж болно. Үүнээс өөр шалтгаанаар олшруулах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээхийг хориглоно. Дахин хэвлэх бол Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагад мэдэгдэж, зөвшөөрөл авна.

www.idlo.int

@IDLOmongol

Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж,
Бодь цамхаг, 603 тоот
Улаанбаатар 15160, Монгол Улс

"Би Си Ай" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

Паулет Келли

ӨНӨӨДӨР НАДАД ЦЭЦЭГ БЭЛЭГЛЭВ...

Өнөөдөр надад цэцэг бэлэглэв.
Өнөөдөр миний төрсөн өдөр биш, ямар нэгэн тэмдэглэлт өдөр ч биш.
Урд шөнө бид хэрэлдсэн, энэ нь анхных байв,
Тэр намайг гомдоохоор хэрцгий үг их хэлсэн.
Тэр харамсаж байгааг би мэдэж байна, үнэхээр гомдооно гэж хэлээгүй.
Яагаад гэвэл өнөөдөр тэр надад цэцэг бэлэглэсэн.

Өнөөдөр надад цэцэг бэлэглэв.
Өнөөдөр бидний ойн баяр биш, ямар нэгэн тэмдэглэлт өдөр ч биш.
Өчигдөр орой тэр намайг хананд шахаад, багалзуурдсан
Яг л хар дарсан зүүд шиг.
Үнэхээр болсон гэдэгт итгэж чадахгүй байна.
Өглөө босоход хамаг бие минь хөхөрч, хөндүүрлэсэн байв.
Тэр харамсаж байгааг би мэдэж байна.
Яагаад гэвэл өнөөдөр тэр надад цэцэг бэлэглэсэн.

Өнөөдөр надад цэцэг бэлэглэв.
Өнөөдөр эх үрсийн баяр биш, ямар нэгэн тэмдэглэлт өдөр ч биш.
Өнгөрсөн шөнө тэр намайг дахиад зодсон.
Энэ удаа өмнөхөөсөө илүү хэрцгий байсан.
Хэрвээ би түүнийг орхивол, би юу хийх вэ?
Хүүхдүүдээ яах вэ?
Мөнгөгүй яах вэ?
Би түүнээс айж байна, орхиж явахаас эмээж байна.
Гэхдээ тэр харамсаж байгааг би мэдэж байна.
Яагаад гэвэл өнөөдөр тэр надад цэцэг бэлэглэсэн.

Өнөөдөр надад цэцэг бэлэглэв.
Өнөөдөр маш онцгой өдөр байлаа.
Энэ өдөр миний ажил явдал болсон.
Өнгөрсөн шөнө тэр намайг хөнөөсөн юм.
Тэр намайг амь тавьтал зодсон.
Хэрвээ зориглож чадсан бол
Зүрхлээд түүнийг орхисон бол
Өнөөдөр би ...цэцэг авахгүй байсан.

Орчуулсан Сүхбаатарын Эрдэнэ

ӨМНӨХ ҮГ

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ) нь тогтвортой хөгжил, хууль дээдлэх соёлыг бий болгохын төлөө дагнан ажилладаг засгийн газар хоорондын олон улсын байгууллага юм. Тус байгууллага 2012 оноос Монгол улсад үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд Монгол улсын Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд болон олон улсын хамтын нийгэмлэгтэй үр бүтээлтэй хамтран ажиллаж байна.

ОУЭЗХБ нь жендэрийн тэгш байдлыг хангасан хууль тогтоомжийн хэрэгжилт, түнш байгууллагуудыг дэмжиж жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдэд шударга ёс болон хууль зүйн үйлчилгээг хүртээмжтэй болгох, тогтвортой хөгжилд хүрэхийн тулд олон нийтийн эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхийн төлөө ажилладаг. ОУЭЗХБ-ын төсөл хөтөлбөрт Жендэрт суурилсан хүчирхийллийн хамгийн тулгамдсан хэлбэр болох эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох нь нэн тэргүүний зорилт юм.

ОУЭЗХБ нь Канад улсын Засгийн газрын санхүүжилтээр "Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх" (2019-2022) төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Уг төслийн зорилго нь иргэний нийгмийн болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн салбарын ажилтнуудын чадавхийг бэхжүүлснээр жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх хүртээмжийг нэмэгдүүлж, хохирогч төвтэй үйлчилгээг хүргэн, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх явдал юм.

Энэхүү гарын авлага нь цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудад зориулсан практик хэрэгсэл бөгөөд төслийн хүрээнд гаргаж буй хоёр дахь бүтээл билээ. Энэ удаа АНУ-ын Төрийн департаментын дэргэдэх Хар тамхитай тэмцэх, хууль сахиулах олон улсын товчооны санхүүжилтээр 2017 онд хэрэгжсэн өмнөх төслийн хүрээнд боловсруулан гаргасан эхний гарын авлагыг шинэчлэн найруулсан болно. Энэхүү шинэчилсэн хувилбарт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн дагуу шинээр боловсруулагдаж гарсан зохих журмууд, холбогдох хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тусгаж, хохирогч төвтэй хандлагад суурилан шинэчлэн боловсруулсан.

Хохирогч төвтэй хандлага гэдэг нь хохирогчийн нэн тэргүүний хэрэгцээнд тулгуурлаж хариу үйлчилгээ үзүүлэхийг хэлэх ба хохирогчтой хүнлэг, хүндэтгэлтэй харилцах, тэдний аюулгүй байдлыг хангах, дэмжлэг үзүүлэх, буруутгахгүй байх орчинг бий болгох, бие даан шийдвэр гаргахад нь бололцоотой бүх мэдээллээр хангах ба тэдний орон зайг хүндэтгэж, нууцлалыг хадгалах зэрэг нь уг хандлагын гол зарчим юм. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх чиглэлд ахиц дэвшил гарна гэдэгт найдаж байна.

Гарын авлагыг шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэсэн зохиогчид, хамтран ажилласан бүх хүмүүст болон энэхүү төслийг санхүүжүүлэгч Канад Улсын Засгийн газар болон төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж буй Монгол улсын Засгийн газарт талархлаа илэрхийлье.

Тара С.Нил

ОУЭЗХБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгч

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ХОХИРОГЧ ТӨВТЭЙ ХАНДЛАГААР ТЭМЦЭХ ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БАГ

Б. Цэнгэлбаяр

ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хурандаа

Э. Баярбаясгалан

ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч

Ч. Нармөнх

ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн сэтгэл зүйч, цагдаагийн дэслэгч

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН БАГ

Г. Золзаяа

Сонгино хайрхан дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор

Г. Оюунболд

Монголын хуульчдын холбооны Эрүүгийн эрх зүйн хорооны тэргүүн

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БАГ

С. Билгүүн

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Тамгын газрын дарга

Н.Одонтуул

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР

Р. Оюун

Хорих 421 дугээр ангийн сэтгэл зүйч

ЗӨВЛӨХ:

Б. БАТЦЭРЭН — Улсын Дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимын шүүгч

РЕДАКТОР:

П.ЦЭЦГЭЭ — Монголын Хуульч эмэгтэйчүүдийн холбооны Гүйцэтгэх захирал

АГУУЛГА

НЭГ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА 8
ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА 12
2.1 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН МЭДЛЭГ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН ШИНЖ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА 12
Сэдэв 1. Жендэр ба жендэрт суурилсан хүчирхийлэл 12
Сэдэв 2. Гэр бүлийн хүчирхийллийг танин мэдэх нь 14
Сэдэв 3. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч 16
2.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН БОЛОН ШҮҮГЧИЙН НИЙТЛЭГ АНХААРАХ АСУУДАЛ 18
Сэдэв 1. ГБХ-ээс урьдчилан сэргийлэхэд салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа 18
Сэдэв 2. Хохирогч төвтэй хандлага 25
Сэдэв 3. Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ 27
Сэдэв 4. ГБХ-ийн гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах нь 28
3.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН БОЛОН ШҮҮГЧИЙН АНХААРАХ ОНЦЛОГ АСУУДАЛ 37
Цагдаагийн ажилтны анхаарах асуудал 37
Сэдэв 1. ГБХ-ийн дуудлага, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх ажиллагаа 37
Сэдэв 2. ГБХ-ийн гомдол, мэдээлэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах 38
Сэдэв 3. ГБХ-ийн үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулах 40
Сэдэв 4. ГБХ-ийн хохирогчид тусламж үзүүлэх ажиллагаа 43
Прокурорын анхаарах асуудал 44
Сэдэв 1. ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт 44
Сэдэв 2. ГБХ үйлдэх зөрчилд зөрчлийн хэрэг нээх, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт. 46
Сэдэв 3. ГБХ-ийн үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын онцлог 49
Сэдэв 4. ГБХ-ийн гэмт хэргийг яллах ажиллагааны онцлог 52
Шүүгчдийн анхаарах асуудал 56
Сэдэв 1. ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх онцлог 56
Сэдэв 2. Шүүгчээс ГБХ үйлдэгч, гэрч, хохирогчтой харилцах арга барил 62
Сэдэв 3. ГБХ үйлдэх зөрчил гаргагчид шийтгэл оногдуулах, гэмт хэрэг үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах, ял оногдуулах ажиллагааны онцлог 63
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны анхаарах асуудал 64
Сэдэв 1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт 64
ГУРАВ. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН 66
Нэг. Сургалтын өмнө ба сүүлд авч болох сорил 67
Хоёр. Оролцогчдын хандлагыг тандахад ашиглаж болох сорил 68
Гурав. Сургалтын үнэлгээний хуудас 69

НЭГ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

ЯАГААД?

Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) болон ГБХ-ийн ээдрээ төвөгтэй, өвөрмөц харилцааны нөхцөл байдлаас шалтгаалан энэ төрлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд нэг байгууллага төдийгүй тус тусдаа боловсруулсан бодлогоор шийдвэрлэх боломжгүй байдаг. ГБХ-тэй тэмцэж буй сайн туршлагаас харахад шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагууд, орон нутгийн болон бүс нутгийн эрх бүхий байгууллага, түүнчлэн төрийн бус байгууллагууд (ТББ) болон бусад холбогдох байгууллагуудын хоорондын үр дүнтэй хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой.

Гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, үүнээс гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтрагчийн зүгээс 10 эмэгтэйн 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртдөг. Эдгээр эмэгтэйчүүдийн 4 хүн тутмын 1 нь (26.5%) хэнд ч ханддаггүй болох нь Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүн амын сангийн судалгаагаар тогтоожээ[9].

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд цагдаагийн байгууллага нь хохирогчдод хамгаалалт, үйлчилгээ үзүүлэх тусгай нэгж болон гэр бүлийн хүчирхийллийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог бий болгож, өнөөдрийн байдлаар 60 орчим мэргэжилтэн ажиллаж байна[10].

Шинэ хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш буюу 2018 оноос Мэдээлэл, шуурхай удирдлагын төв 102 дугаарын утсанд ирсэн мэдээллийн бүртгэлд ГБХ-тэй холбоотой дуудлага, мэдээлэл, түүний дагуу авсан арга хэмжээний талаарх мэдээллийг бүртгэж эхэлсэн байна. Эргүүлийн цагдаагийн алба хаагч дуудлага мэдээллийг "Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн сан" -д бүртгэж хүчирхийллийн түүхийг шалгах, хохирогчийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах шийдвэр гаргахад ашиглах боломж бүрдсэн байна[11].

ЗБ-ын "Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд хууль зүйн салбарын чадавхийг бэхжүүлэх" төслийн хүрээнд 2016-2019 онд ГБХ-тэй тэмцэх чиглэлээр 1000 гаруй хууль сахиулах шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтныг сургажээ. Цагдаагийн байгууллагын статистик мэдээгээр ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалах чиглэлд давхардсан тоогоор төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 12500 гаруй алба хаагчийг сургалтад хамруулжээ[12].

Хэдий тийм боловч цагдаагийн алба хаагчаас ГБХ-ийн дуудлагыг үл ойшоох, ноцтой гэж үзэхгүй байх, дахин давтагдах эрсдэлийг бууруулах, эргэж хяналт тавих ажиллагаа хангалтгүй хийгдэж байгаа болон аюулын зэргийн үнэлгээг зөвхөн хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэхгүй байгаагийн илрэл юм[13].

Иймд ГБХ-тэй тэмцэх чиглэлээр сургалт тогтмол явуулж, арга зүйн мэдлэг, ур чадвар олгож, мэргэшүүлэх ажил тасралтгүй хийгдэх шаардлага байна. Ялангуяа гэмт хэрэг гарсан газар хамгийн түрүүнд хүрч очиж ажилладаг эргүүлийн офицер болон хамтарсан багийн гишүүнээр ажилладаг хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчийг сургаж хүчирхийллийн болзошгүй эрсдэлийг эрт шатанд илрүүлэх, хохирогчийн аюулгүй байдалд хяналт тавих ажлыг анхаарч, эрчимжүүлэх нь төрийн болон бусад байгууллагуудын үүрэг юм[14].

9 "Хүчирхийллийн нүцгэн үнэн" судалгааны тайлан 2017 YCX, UNFPA, Swiss Agency for development & cooperation SDC, Australian AID Нэгдсэн Үндэстний Байгууллага, "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл" мэдээллийн хуудас, 2011 он

10 "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчид хүлээлгэн өгсөн үүргийн хэрэгжилт" мониторингийн тайлан 2018 ХЭҮТ, UNFPA, Swiss Agency for development & cooperation SDC

11 мөн тэнд

12 мөн тэнд

13 мөн тэнд

14 "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийр цагдаагийн алба хаагчид хүлээлгэн өгсөн үүргийн хэрэгжилт" мониторингийн тайлан 2018 ХЭҮТ, UNFPA, Swiss Agency for development & cooperation SDC

Монгол Улсын төрийн байгууллага, түүний дотор шүүх болон хууль сахиулах байгууллагад мэргэжилтнээ сургах, тэдний мэргэжлийн хөгжлийг дэмжих хэрэгцээ улам бүр нэмэгдэж буй энэ үед "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр шүүх болон хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх" сургалтын хөтөлбөрийг хохирогч төвтэй хандлагыг тусгаж шинэчлэн боловсруулан хүргэж байна. Уг сургалтын хөтөлбөрийг цагдаа, прокурор, шүүхийн байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд хамтран боловсруулсан бөгөөд зүгээс техникийн туслалцаа үзүүлсэн болно.

ЯМАР ЗОРИЛГОТОЙ ВЭ?

Мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийн зорилго:

- Шүүх, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын (цагдаа, прокурор, шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч) гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдлэг, ойлголтыг баяжуулах, гүнзгийрүүлэх;
- Тэдний гэр бүлийн хүчирхийллийн асуудалд хандах хандлага, тогтсон хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд нөлөөлөх;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хохирогч төвтэй хандлагыг нэн тэргүүнд тавихад шаардлагатай ур чадвар, арга тактикыг эзэмшүүлэх, хөгжүүлэх;

Сургалтын хөтөлбөрийн зорилт:

- Хүчирхийллийн асуудалд мэдрэмжтэй хандах, түүнд хандах өөрийн хандлагад дүгнэлт өгөх

Монгол Улсад гурван эмэгтэй тутмын нэг нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэхэд мэргэжилтэн тухайн асуудалд хэрхэн хандах өөрийн хандлагыг мэддэг, дүгнэлт өгсөн байх шаардлагатай. Түүнчлэн хохирогчид туслалцаа, үйлчилгээ үзүүлэхдээ хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэхийг энэ сургалтаар анхаарч байгаа бөгөөд сургалтын явцад олж авсан мэдлэгтээ суурилан хандлагаа өөрчлөх боломж олгох явдал юм. Гэр бүлийн хүчирхийллийг өмнө нь буруугаар ойлгож дүгнэж байсан бол түүнээсээ зайлшгүй салах ёстой, тэгж байж сая өөрийн албаны үүргээ амжилттай биелүүлж, хүчирхийлэлд өртсөн хохирогчид тусалж чадна.

- Хохирогчид үр дүнтэй туслалцаа үзүүлэх

ГБХ нь хамгийн нуугдмал хэлбэрийн хүчирхийлэл юм. Асуудлыг зөв таних төдийгүй, юуны өмнө хүчирхийллийн нөхцөл байдалд тохирсон туслалцаа үзүүлдэг байх нь хамгийн чухал. Хохирогч ичиж зовсны улмаас, өөрийгөө буруутгасны улмаас, эсвэл айж сүрдсэний улмаас мэдээлэл өгөх дургүй байдаг. Энэ байдал нь тэднээс өртсөн хүчирхийллийн талаар мэдээлэл олж авах, тэдний зүгээс мэргэжилтнүүдтэй харилцахад хүндрэл учруулдаг. Иймээс хохирогчийн байдлыг зөв танин мэдэж, ойлгох нь чухал.

- Хамтран ажиллах

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод шаардлагатай туслалцааг үзүүлэхийн тулд мэргэжилтэн хүчирхийллийн талаар мэдлэгтэй байх зайлшгүй шаардлагатай. Мөн олон талт хамтын ажиллагааны үр дүнд л хохирогчийг бүрэн хамгаалж чадна. Тухайлбал, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн салбарын мэргэжилтнүүд, мөн бусад ГБХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэгчид (эрүүл мэнд, нийгмийн ажилтнууд, нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байр г.м.) хэдийгээр өөр өөр үүрэгтэй боловч нэг нэгнийгээ харилцан дэмжиж, уялдаа холбоотой байдаг чиг үүргүүдийг ойлгож хэрэгжүүлэх хэрэгтэй.

ХЭРХЭН СУРАЛЦАХ ВЭ? *Агуулгын хувьд*



- Сургалтад оролцогчид гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт, түүний хэлбэр, хүчирхийллийн тойрог зэргийг авч үзэхийн зэрэгцээ энэ талаар тогтсон, хэвшмэл хандлага ба бодит байдлын талаар мэдээлэл солилцоно.
- Мөн ГБХ-ийн хохирогчийг илүү сайн таних, мэдрэхэд хэрэгтэй мэдээллийг судлахын зэрэгцээ хүчирхийлэл үйлдэгчийн хэвшмэл дүр зураг, тэдний үйлдэл, санаа зорилгыг судалсны үндсэн дээр хууль хэрэгжүүлэх үйл явцад хохирогчтой хэрхэн ажиллах арга, тактикаа боловсруулах дадлага хийнэ.
- ГБХ-ийн хохирогчид аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, хийсэн үнэлгээг хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг шалгах, хянан шийдвэрлэх,шүүхийн шатанд үнэлэхэд хэрэглэх зэрэг асуудал нь ХСБ-ын ажилтнууд, шүүгчдийн судлах хэрэгтэй нийтлэг асуудал тул оролцогчид эдгээр агуулгыг судлах нь зүйтэй юм.

Арга зүйн хувьд:

- Сургалтад насанд хүрэгчдийн сурах онцлог болон тэдний хэрэгцээг харгалзан оролцогчдын үйл ажиллагаанд тулгуурласан арга, аргачлалыг ашиглана.
- Сургалтыг явуулахдаа дараах зүйлсийг анхаарна. Үүнд:
    - Мэдлэг эзэмших нь ямагт идэвхтэй сургалтад суурилсан байдаг.
    - Мэдлэгийг эзэмшихийн тулд илүү идэвхтэй оролцоо шаардагддаг. Өөрөө оролцож, хийх замаар олж авсан мэдлэг илүү үлдэцтэй байдаг.
    - Суралцагчдын идэвхтэй оролцооноос сургалтын үр дүн хамаарна. Зорилгод хүрэхийн тулд сургалтын зөвхөн агуулгад бус, сурах үйл явцад анхаарах нь чухал.

Сургалтын хөтөлбөрийн цаг, сэдвийн хуваарилалт (жишиг байдлаар)

Нэг: Гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ): мэдлэг, ойлголт		Хоёр: Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудын нийтлэг анхаарах асуудал	
	Цаг		Цаг
Жендэр ба жендэрт суурилсан хүчирхийлэлийг танин мэдэх нь	4	ГБХ-ээс урьдчилан сэргийлхэд салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа	2
ГБХ	2	Хохирогч төвтэй хандлага	1
ГБХ-ийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч	2	Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ	4
		ГБХ-ийн гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах нь	2
Нийт цаг	8		8

Гурав: Гэр бүлийн хүчирхийлэл ба мэргэжлийн ур чадвар							
Цагдаа	Цаг	Прокурор	Цаг	Шүүгч	Цаг	Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч	Цаг
ГБХ-ийн дуудлага, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх ажиллагаа	2	ГБХ-үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт	2	ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх онцлог	2	ГБХ үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт	2
Гэр бүлийн хүчирхийллийн гомдол, мэдээлэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах	2	ГБХ-ийн зөрчилд зөрчлийн хэрэг нээх, шалгах ажилллагаанд тавих прокурорын хяналт түүнд тавих прокурорын хяналт	2	Шүүгчээс ГБХ үйлдэгч, гэрч, хохирогчтой харилцах арга барил	2		
ГБХ-ийн үйлдэлд эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах	2	ГБХ-ийн үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэх, түүнд тавих прокурорын хяналт	2	ГБХ үйлдэх зөрчил гаргагчид шийтгэл ногдуулах, гэмт хэрэг үйлдэгчид ТСАХ, ял оногдуулах ажиллагааны онцлог	2		
ГБХ-ийн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ	2	ГБХ-ийн гэмт хэргийн яллах ажиллагааны онцлог					
Нийт цаг	8		6		6		2

ХОЁР СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

2.1 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН МЭДЛЭГ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН ШИНЖ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН ҮЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

Сэдэв 1. Жендэр ба жендэрт суурилсан хүчирхийлэл

Сэдвийн товч агуулга:

Жендэр болон жендэрийн тэгш байдал, жендэрийн хэвшмэл үзэл, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний шалтгаан нөхцөл, ГБХ-ийн талаарх эрх зүйн гол баримт бичгүүдийн талаар зөв ойлголт, мэдлэгтэй болоход сэдвийн зорилго оршино.

- Жендэрийн тухай ойлголт
- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын чиг хандлага, зөвлөмж
- Гэр бүлийн хүчирхийллийг тайлбарлах онолын урсгал, чиглэл

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- Жендэр, жендэрт суурилсан хүчирхийллийг тодорхойлж, бусад хүчирхийллээс ялгаж мэддэг болсон байна.
- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх арга хэрэгслүүдийг мэддэг болсон байна.
- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын хандлага, эрх зүйн баримт бичгүүд, зөвлөмжүүд, онол урсгалуудтай танилцсан байна.
- Гэр бүлийн хүчирхийллийг тайлбарлах онолын урсгал, чиглэлийн талаар мэддэг болсон байна.

Бодомж дээр ажиллах зааварчилгаа: Тараах материал 1-г хүн бүрт тарааж, оролцогчид хүснэгтийг бөглөнө.

Тараах материал 1:

Дараах бодомжуудтай санал нийлэх үү? Тохирох хариултыг тэмдэглэнэ үү. [15]

№	Өгөгдөл	Санал бүрэн нийлнэ	Санал нийлнэ	Эргэлзэж байна	Санал нийлэхгүй	Санал огт нийлэхгүй
1	Нийгэм хөгжин өөрчлөгдөж байгаа боловч эрэгтэй хүүхэд моринд эрэмгий, бөхөд хүчтэй болж өсөх ёстой.					
2	Жендэрт суурилсан хүчирхийллийн үйлдэгч нь эрэгтэй, хохирогч нь эмэгтэй байдаг.					
3	Хүйсийн ялгаа нь тухайн хүний жендэрийн байдлыг тодорхойлох үндэслэл болохгүй.					
4	Жендэрийн тэгш байдал гэдэг нь нийгмийн шинжтэй ойлголт бөгөөд хувийн амьдралын хүрээнд тэгш байдал хөндөгдөхгүй.					
5	Танихгүй л биш бол хамт ажилладаг, эсвэл хамт сурдаг хүмүүс нэгнийхээ биед хүрэх үйлдэл нь байдал л зүйл.					

15 Д.Энхжаргалын “Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх” амьдрах ухааны чадвар чиглүүлэгчийн багц гарын авлагаас авав.

Мэдээлэл өгөх:

Хүснэгт 1.1. Хүйс ба жендерийн ялгаа[16]

Хүйс	Жендэр
Биологийн ялгааг илэрхийлдэг.	Үүрэг хариуцлага, байр суурийн ялгаатай байдлыг илэрийлдэг.
Үл өөрчлөгдөх чанар өөрчлөгддөг.	Цаг хугацааны хувьд хувьсан
Түгээмэл. Бүх улс оронд адил.	Нийгэм соёл бүрд харилцан адилгүй.
Ижил хүмүүсийн хувьд адил	Ижил хүмүүсийн дунд ч ялгаа байдаг.

Дэд сэдвүүд:

- Жендэрийн тухай ойлголт
  - Жендэр, жендэр ба хүйсийн ялгаа
  - Жендэрийн тэгш байдал,
  - Жендэрийн хэвшмэл үзэл,
  - Жендэрийн ялгаварлан гадуурхалт,
  - Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүнтэй тэмцэх нь,
  - Монгол дахь жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүд
- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын чиг хандлага, зөвлөмж
  - Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
  - Венийн тунхаг бичиг
  - Истанбулын конвенц
  - Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал хариуцсан тусгай илтгэгч
  - Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг тунхаглал
  - Бээжингийн тунхаглал
  - Найробигийн дээд хэмжээний уулзалт
  - Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
  - "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян
  - НҮБ-ын 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр
- ГБХ-ийг тайлбарлах онолын урсгал, чиглэл (Сэтгэл судлалын онолын зарим тайлбар, социологийн онол, феминист онол, экологийн онол, чадваржуулах онол)

Үнэлгээ

А) Хяналтын асуулт:

Багшийн мэдээллийн дараа сэдвийг бататгах дараах асуултуудыг асууж, сайн дурын үндсэн дээр хариулт авна.

- Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж яагаад тодотгож нэрлэх болсон бэ?
- Жендэр ба ГБХ-ийн талаар судлах нь таны ажил мэргэжилтэй ямар холбоотой вэ?
- Таны бодлоор жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан нь юу вэ?
- Та энэ талаарх мэдлэг, чадвараа ажилдаа хэрхэн ашиглах вэ?

Б) Хичээлийн явцад яригдсан агуулгаас ямар ямар мэдээлэл, агуулга үлдсэнийг зөвхөн нэг үгээр хариултыг авч, самбарт бичнэ.

16 "Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх" амьдрах ухааны чадвар чиглүүлэгчийн багц гарын авлага. Д.Энхжаргал, Улаанбаатар хот, 2016 он, 31 дүгээр тал.

Дүгнэлт:

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно. Хамгийн сүүлд хичээлийн эхэнд ажиллуулсан бодомжийг маш хурдан хугацаанд ангиараа ажиллана.

Сургагч-багшид өгөх санамж:

Хүйс ба жендэрийн ялгааг сайтар тайлбарлах.

Хэвшмэл үзлээс шалтгаалан жендэрт суурилсан хүчирхийлэл үүсэх эрсдэлтэйг сайтар ойлгуулах- Бодомжийг давтан ярилцах.

Сэдэв 2. Гэр бүлийн хүчирхийллийг танин мэдэх нь

Сэдвийн товч агуулга:

ГБХ түүний онцлог шинж, хэлбэрийн талаарх мэдлэгээ бататгаж, ГБХ-ийн талаар ташаа ойлголтууд болон бодит байдлын ялгааг эргэцүүлэх, хүчирхийллийн хор уршиг-үр дагаврын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд сэдвийн зорилго оршино.

- ГБХ-ийн ойлголт, үндсэн шинж
- ГБХ-ийн хэлбэр
- ГБХ-ийн талаарх ташаа ойлголт
- ГБХ-ийн үр дагавар
- ГБХ-ийн суурь шалтгаан

Сэдвийн гол зорилтууд :

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ түүний онцлог шинжийг тодорхойлж, хэлбэрүүдийг нэрлэж, тойрог үе шатууд, тэдгээрийн онцлог, үр дагавар, нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх мэдлэгээ бататгасан байна.
- ГБХ-ийн талаар ташаа ойлголтууд болон бодит байдлын ялгааг дахин эргэцүүлж, өөрийн хэвшмэл ташаа ойлголтыг залруулсан байна. Мөн өөрийн эргэн тойрны хүмүүсийн ташаа ойлголтыг залруулах чадавхтай болсон байна.
- ГБХ-ийн үр дагаварыг хувь хүн болон улс орны түвшинд тооцоолж мэддэг болсон байна.
- ГБХ-д нөлөөлөх хүчин зүйл, суурь шалтгааны ялгааг гаргаж чаддаг болсон байна.

Багийн ажлын зааварчилгаа:

Тус бүр 4-5 хүнтэй багт хуваах, хоорондоо ярилцлага өрнүүлэн, ГБХ-ийн талаарх 2-3 ташаа ойлголтыг нэрлэж, яагаад сонгосон шалтгаанаа бусад багийнханд танилцуулна. Багийн илтгэгч гишүүнийг багш сонгож болно.

Мэдээлэл өгөх:

Хүснэгт 1.2. ГБХ-ийн үр дагавар

Хохирогч	Хүчирхийлэл үйлдэгч	Гэр бүлд	Нийгэмд
• Сэтгэхүйн дарамтад өртөх; • Өөрийн үнэлэмж буурах; • Ганцаардах, ойр дотны нөхөдгүй болох; • Хөдөлмөрийн бүтээмж буурах, ажилгүй болох, орлогоо алдах; • Хувь хүний хөгжилд сөргөөр нөлөөлөх; • Биеийн эрүүл мэнд нь муудах; • Бэртэж гэмтэх, хөдөлмөрийн чадвар алдах; • Сэтгэлийн хямралд орох; • Сэтгэцийн өвчтэй болох (сэтгэл гутрал) • Амиа хорлох; • Амиа алдах;	• Архидан мансуурах; • Амьдралын буруу зан үйлд орох; • Гэмт хэрэг үйлдэх, ял шийтгүүлэх, он удаан жил шоронд хоригдох; • Аваар осол хийх, орох; • Амиа хорлох; • Амь насаа алдах;	• Гэр бүлийн бүх гишүүд айдас түгшүүрт автах ба энэ нь сэтгэл зүйн хямралд оруулна. • Гэр бүлийн гишүүдийн хооронд эрүүл бус харилцаатай болох. • Хүүхдийн хөгжил, сэтгэл санаанд хүчтэй нөлөөлөх. • Гэр бүлийн харилцаа нь айдас түгшүүрт автах. • Гэр бүлээс хүүхэд нь дайжих, эсхүл сургуулиас завсардах • Гэр бүлийн эдийн засгийн чадавхи буурах.	• Хүн амын хөгжил,нийгмийн эрүүл мэндийн байдалд сөргөөр нөлөөлнө. • Нийгэм эдийн засгийн чадавхад удаан хугацаагаар нөлөөлнө. • Гэр бүл төлөвлөлт, хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлнө. • Гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэгдэх явдал ихэснэ. • Гэр бүл салалт, хүн амын өвчлөлт, архидалт, ядуурал, ажилгүйдэл нэмэгдэнэ г.м.

Дэд сэдвүүд:

- ГБХ-ийн ойлголт, үндсэн шинж, илрэх хэлбэр;
- ГБХ-ийн хэлбэр: сэтгэл санааны, бие махбодын , эдийн засгийн болон бэлгийн хүчирхийлэл, түүнийг танин мэдэх
- ГБХ-ийн тойрог: - үе шат (тойрог) динамик (давтамж) даамжрал. Эхлэл үе, хүчирхийллийн үе, эвлэрлийн үе, түүнийг тогтоох, түүнд нөлөөлөх хүчин зүйлс.
- ГБХ-ийн талаарх ташаа ойлголт ба бодит байдал
- ГБХ-ийн хамрах хүрээ, үр дагавар: Нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, хүний хөгжилд үзүүлдэг үр дагавар, хор уршиг.
- ГБХ-д нөлөөлөх хүчин зүйл: Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, ажилгүйдэл, боловсрол, ядуурлын түвшин, өргөн уудам нутаг дэвсгэр-алслагдмал байдал, уламжлал, архи, хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ. ГБХ-ийн суурь шалтгаан бол гэр бүл дэх эрх мэдлийн тэнцвэргүй байдал буюу жендэрийн тэгш эрх хангагдаагүй байдал юм.

Багийн ажлын зааварчилгаа: Энэ дасгалд багууд цаасан дээр ГБХ-ийн 4 хэлбэрийг хүснэгт байдлаар баганад оруулж бичиж дараах асуултанд хариуна.

ГБХ ямар үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрч болох вэ?

Бие махбодын	Бэлгийн хүчирхийлэл	Сэтгэл санааны хүчирхийлэл	Эдийн засгийн хүчирхийлэл

Үнэлгээ:

Сэдвийг бататгах дараах хяналтын асуултуудыг баг бүрт хуваарилан асууна.

- ГБХ-ийн талаарх таны өмнөх ойлголтод ямар өөрчлөлт гарсан бэ?
- ГБХ-ийн хэлбэрүүдийг тодорхойлоход анхаарах зүйлсийн талаарх Таны санал?
- ГБХ-ийн үе шатыг зөв тодорхойлох нь хэнд, ямар ач холбогдолтой вэ?
- ГБХ-ийн талаарх хүмүүсийн ташаа ойлголтыг өөрчлөх боломж бий юу? Яагаад?
- ГБХ-ийн улмаас нийгэмд учрах үр дагаврын талаар ярилцана уу.
- Өргөн уудам нутаг дэвсгэрээс шалтгаалан алслагдмал орон нутаг нь ГБХ даамжрах, нөлөөлөх хүчин зүйл болох уу?

Сайн дураар хариултуудыг авна. Зарим асуулт дээр багаар сууж буй ширээ бүрээс хариултыг сонсоно.

Дүгнэлт:

Багаар сууж буй ширээ бүрээс хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно. Хамгийн сүүлд ГБХ-тэй тэмцэхэд та юу хийж чадах вэ? гэж асууж, хариултыг нээлттэйгээр авна.

Сургагч-багшид өгөх санамж:

ГБХ-ийн ташаа ойлголтуудыг өөрсдөөр нь тайлбарлуулахад анхаарах,

Одоогийн манай улсын ГБХ-тэй тэмцэж буй арга хэлбэрийн үр нөлөөний талаар эргэцүүлэх.

Сэдэв 3. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч _____

Сэдвийн товч агуулга:

ГБХ-ийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл, сэтгэл зүйн онцлог, хандлагын талаарх мэдлэг, ойлголтыг өргөжүүлэхэд сэдвийн зорилго оршино.

- ГБХ-ийн хохирогч, түүний зан үйл
- ГБХ үйлдэгч, түүний зан үйл
- ГБХ ба хүүхэд

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ-ийн хохирогч гэж хэн болох, түүний сэтгэл зүйн онцлог, илрэх хэлбэрийг танин мэдэж, хохирогчтой харилцах, мэдээлэл авах, түүнд туслах арга хэмжээг төлөвлөх мэдлэг, чадвараа нэмэгдүүлсэн байна.
- ГБХ үйлдэгчийн зан үйлийн онцлогийг танин мэдэж, хүчирхийлэл үйлдэгчтэй харилцах оновчтой арга техникийг төлөвлөх мэдлэг, чадвараа нэмэгдүүлсэн байна.

Багийн ажлын зааварчилгаа: ГБХ-ийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчийн оролцсон шүүх хуралдааны бичлэгийг сонсгоно.

- Эхний 2 багт ГБХ-ийн хохирогчийн зан үйл, ГБХ үйлдэгчийн зан үйл гэсэн сэдвийг хуваарилан

өгч, өөрсдийн хэмжээнд тодорхойлон бусад багуудад танилцуулах даалгавар өгнө.

- Дараагийн 3 багт ГБХ-ийн хохирогч, ГБХ үйлдэгчийн зан үйл болох "ГБХ-ийн хохирогчийн гэмтлийн дараах хам шинж" гэсэн сэдвийн дагуу гарын авлагын материалыг таралаж, тодорхой хугацаанд танилцан, ярилцах даалгавар өгнө.
- Бэлтгэх хугацаа дуусаны дараа эхний хоёр багийн танилцуулгыг сонсоно. Үүний дараа дараагийн 3 баг эхний хоёр багийн дутуу үлдээсэн агуулгыг тайлбарлах замаар багийн ажлыг зохион байгуулна.
- Ажиллагаа бүрийн хугацаа, танилцуулгын хугацааг тооцож баримтлуулна.
- Багийн илтгэгч гишүүнийг багш сонгож болно.
- Багийн ажлыг өмнө үзсэн шүүх хуралдааны бичлэгтэй уялдуулахыг урьдчилан сануулна.

Мэдээлэл өгөх:

Дэд сэдвүүд:

- ГБХ-ийн хохирогч, түүний зан үйл
- Гэмтлийн дараах стресс эмгэг
- Бэлгийн хүчирхийллийн гэмтлийн хам шинж
- Аажим шатах хариу үйлдэл
- Стокгольмийн синдром
- Хохирогчийн зан үйл: харилцаа, хандлагын онцлог, айдас, түгшүүрийн түвшин
- Хохирогчийн сэтгэл зүйн төлөв
- Хохирогчийн сэтгэл зүйн болон биеийн эрүүл мэнд
- ГБХ үйлдэгч, түүний зан үйл
- ГБХ үйлдэхэд нөлөөлөх хүчин зүйлс
- ГБХ үйлдэгчийн зан үйл, сэтгэл зүйн онцлог шинж
- Хүчирхийлэл үйлдэгчийн хяналтаа тогтоох хэлбэр
- ГБХ ба хүүхэд
- Ялгаварлан гадуурхалтын олон хэлбэрт өртдөг бусад хохирогч

Үнэлгээ

А) Хяналтын асуулт:

Багшийн мэдээллийн дараа сэдвийг бататгах дараах асуултуудыг нээлттэйгээр асууна.

- ГБХ-ийн хохирогч, үйлдэгч бусад төрлийн хүчирхийллийн хохирогч, үйлдэгчээс ямар ялгаатай вэ?
- Хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн сэтгэл зүйн онцлог шинжийг судлах, танин мэдэхийн тулд юуг анхаарах шаардлагатай вэ? Үүнийг танин мэдэхийн ач холбогдол юу вэ? Таны бодол.
- ГБХ-д байгаа хүүхдийг хэрхэн таних вэ?

Сайн дураар хариултуудыг авна. Зарим асуулт дээр багаар сууж буй ширээ бүрээс хариултыг сонсоно.

Б) Багаар сууж буй ширээ бүрээс хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Дүгнэлт:

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч-багшид өгөх санамж:

ГБХ-ийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн онцлог, зан үйлийг өөрсдөөр нь тайлбарлуулахад анхаарах,

ГБХ-тэй ажиллахад хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн сэтгэл зүйн онцлогийг хэрхэн харгалзан үзэж, харилцдаг талаар, арга хэлбэрийн үр нөлөөний талаар эргэцүүлэх,

ГБХ-д их өртдөг бусад гэр бүлийн гишүүд болох хүүхэд, өндөр настаныг орхигдуулахгүй байх,

Ялгаварлан гадуурхалтын олон бөгөөд хавсарсан хэлбэрт өртдөг хохирогч байдаг талаар дурдах. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюуны бэрхшээлтэй иргэд, бэлгийн цөөнх, үндэстний цөөнх, шашны цөөнх, шилжин суурьшигчид, иргэний бичиг баримтгүй, төлбөрийн чадваргүй, гэрлэлтээ бүртгүүлээгүй, алслагдмал сум, багт амьдардаг болон малчин эмэгтэйчүүд, ГБХ-ийн улмаас хүчирхийлэл үйлдэгчийн амь насыг хөнөөсөн эмэгтэйчүүд зэрэг орно.

2.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН БОЛОН ШҮҮГЧИЙН НИЙТЛЭГ АНХААРАХ АСУУДАЛ

Сэдэв 1. ГБХ–ээс урьдчилан сэргийлэхэд салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа

Сэдвийн товч агуулга:

ГБХ-тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллага төдийгүй хамтарсан баг, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог хамарсан өргөн хүрээний асуудал байдаг. Энэхүү сэдвийг судалснаар ГБХ-тэй тэмцэхэд салбар хоорондын уялдаа холбооны ач холбогдлыг мэдэж авах боломжтой. Энэ сэдвийн хүрээнд дараах агуулгыг судална. Үүнд:

- ГБХ-ээс урьдчилан сэргийлэх цогц тогтолцоо,
- Хамтарсан багийн үйлчилгээ.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог тайлбарлах;
- Урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дурдаж, хамтарсан багийн үүргийг тодорхойлно;
- ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх ач холбогдлыг мэдэж авна.

Тараах материал 1: Таван асуулт бүхий сорил

Сургалтын өмнө авах сорил

1. Урьдчилан сэргийлэх ажил гэж юуг хэлж байна вэ?

   А. Гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн.

   Б. Гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн.

   В. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн.

2. Аль нь зөв бэ?

   А. ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажил бол зөвхөн хамтарсан багийн үүрэгт ажил юм.

   Б. ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажил бол бүхий л төрийн байгууллага, албан тушаалтан,

иргэдийн үүрэгт ажил юм.

В. ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажил бол цагдаагийн байгууллагын үүрэгт ажил юм.

3. Аль нь зөв бэ?

А. Хамтарсан баг нь урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ гэсэн 2 төрлийн үйлчилгээг үзүүлнэ.

Б. Хамтарсан баг нь дэмжих, холбон зуучлах гэсэн 2 төрлийн үйлчилгээг үзүүлнэ.

В. Хамтарсан баг нь зөвхөн хариу үйлчилгээг үзүүлнэ.

4. Ажлын бус цагаар эмнэлэг болон цагдаагийн байгууллагад ирсэн гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэлтэй хэн шуурхай танилцаж, бүртгэлд оруулдаг вэ?

А. Хорооны Засаг дарга

Б. Хорооны нийгмийн ажилтан

В. Хорооны хэсгийн байцаагч,

С. Хорооны өрхийн эмч

5. ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажлын зөв тогтолцоог дугуйлна уу.

А. Урьдчилан сэргийлэх ⟶ илрүүлэх, таслан зогсоох ⟶ Аюулгүй байдлыг хамгаалах

Б. Илрүүлэх, таслан зогсоох ⟶ урьдчилан сэргийлэх

В. Илрүүлэх, таслан зогсоох ⟶ аюулгүй байдлыг хамгаалах ⟶ урьдчилан сэргийлэх

Хариулт: 1А , 2В, 3А, 4В ө , 5А

"Хүн бүр багш" Дасгал ажлын жижиг зааварчилгаа: Хүн бүрт хэрчмэл мэдээлэл тарааж, танилцана. Оролцогчид бусад хүмүүсийн мэдээлэлтэй танилцахаар ангид явж дор хаяж 3 хүнээс мэдээлэл цуглуулж, өөрийн мэдээллийг мөн түгээнэ. Дараа нь авсан мэдээллээ эмх цэгцэнд оруулж, тэмдэглэл хийнэ.

Оролцогчид мэдээллээ нэгтгэж дуусаны дараа хэлэлцүүлэг өрнүүлж дараах асуултыг асууна. Үүнд:

- Таны цуглуулсан мэдээллээс хамгийн чухал нь юу байсан бэ? Яагаад чухал гэж үзэв?
- Та цоо шинэ ямар мэдээлэл авсан бэ?
- Та ямар мэдээллийг өөртөө үлдээж авсан бэ?

Тараах материал 2- Хэрчмэл мэдээллийг оролцогч бүрийн тоогоор бэлтгэн тараана.

1. Төрийн байгууллагуудын урьдчилан сэргийлэх чиг үүрэг, уялдаа холбоо нь Засгийн газрын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Цагдаагийн албаны тухай, Хүүхэд хамгааллын тухай, Боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдсан салбар дундын бүтэцтэй байна.

2. ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн зүгээс хөндлөнгийн оролцоог зайлшгүй шаарддаг учир засаг захиргааны анхан шатны нэгжийн хүрээнд иргэд, байгууллагууд оролцсон олон нийтийн бүлгүүдийг үүсгэж, хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, сурталчлах, хүчирхийллийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх нь чухал юм.

ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажил, хамтарсан багийн үйл ажиллагаа

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа нь: хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил цогц, тогтвортой, уялдаа холбоотой байх, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан,нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээ судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан, техник, технологийн орчин үеийн ололт, амжилт, шинэ мэдлэгт үндэслэсэн байх, зардал, үр өгөөжийн хувьд үндэслэлтэй байх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн, хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн байх, төрийн байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хуульд заасны дагуу оролцох үүрэгтэй бөгөөд төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох зэрэг зарчимд тулгуурлана.

4. ГБХ-ээс урьдчилан сэргийлэх цогц тогтолцоог эрх зүйн зохицуулалт талаас нь:
   - Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх;
   - Хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох;
   - Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах гэсэн чиглэлд хуваан авч үзэж болно.

   Энд гурван түвшний урьдчилан сэргийлэх асуудал яригдана.

   Нэгд, анхан шатны урьдчилан сэргийлэлт. Бүх нийтийн боловсролоор дамжуулж хүчирхийлэл үүсч буй шалтгаан, нөхцөлийг яаж арилгах вэ гэдэг рүү чиглэх нь зүйтэй.

   Хоёр дахь урьдчилан сэргийлэлт бол гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хүчирхийлэл үүсэх, дахин давтагдахаас хамгаалах чиглэлийн цогц ажиллагаа байна.

   Гурав дахь урьдчилан сэргийлэлт нь нөхөн сэргээх, дэмжлэг үзүүлэх, ялангуяа нэгэнт хохирогч болсон тохиолдолд хохирогч, гэр бүлийн гишүүдийг яаж эргүүлж хэвийн амьдралд нь оруулах вэ гэдгийг анхааран үзэх нь зүйтэй. Энд нийгэм-сэтгэл зүйн нөхөн сэргээх, хууль эрх зүйн тусламж, үйлчилгээ, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын үйлчилгээ зэрэг ажиллагаа багтана.

5. Хамтарсан баг гэдэг нь гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирогч хүүхдэд эрүүл мэнд, сэтгэл санааны хувьд хэвийн нөхцөлд эргэн ороход нь дэмжлэг үзүүлэх зорилготой мэргэжилтнүүдийн багийн бүрдэл юм.

   ГБХ-тэй тэмцэх хамтарсан багийн үйл ажиллагаа нь шууд утгаараа ГБХ-тэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, түүнийг илрүүлэх, хуулийн хариуцлага хүлээлгэхэд чиглэгдэж байгаа мэт боловч өргөн утгаараа нийгэм дэх сөрөг үйлдэл болсон хүчирхийлэлтэй тэмцэх, эдийн засаг, улс төр, эрх зүй, зан заншил, соёл, хүмүүжлийн болон нэгдмэл зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг цогцоор нь багтааж байдаг гүнзгий утга агуулгатай үйл ажиллагаа юм.

6. Хамтарсан баг нь өрхийн эмч, хороо, сум, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүл хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална .

7. Хамтарсан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
   - ГБХ-ээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;
   - Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;
   - Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
   - Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;
   - Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;
   - Хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх.

8. Хорооны Засаг даргын үүрэг

   Засаг дарга хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах арга хэмжээг шуурхай авах үүргийг хүлээнэ:
   - хүчирхийлэл үйлдэгчийг дуудан ирүүлж, шаардлага тавих, сануулга өгөх;
   - хохирогчийг эмнэлгийн яаралтай тусламжид холбох, шаардлагатай бол хохирогчийн байгаа орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, боломжтой бол хохирогчийг төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх;
   - хохирогчид энэ хууль болон бусад хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллээр хангах;
   - хохирогчийн зөвшөөрснөөр харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэх;
   - хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч, гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах;
   - хуульд заасны дагуу авсан арга хэмжээний талаар цагдаагийн алба хаагчид мэдэгдэж, холбогдох тэмдэглэлийг шилжүүлэх;
   - хуульд заасан бусад.

   Засаг дарга хохирогч бие махбод, сэтгэл санааны хувьд ноцтой хохирол хүлээсэн, хохирч болзошгүй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй гэж үзвэл хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд, эсхүл сургуулийн нийгмийн ажилтанд мэдэгдэнэ.

9. Цагдаагийн алба хаагчийн үүрэг

Цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор бусдын орон байранд нэвтрэн орж, дараах ажиллагааг явуулж болно:

- хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, хуульд заасан журмын дагуу аюулын зэргийн үнэлгээ хийж, түүнийг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх;
- хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардах;
- аюулын зэрэг өндөртэй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэх;
- хохирогчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр өгөх;
- шаардлагатай бол хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах;
- галт зэвсэг, хүчирхийлэл үйлдэхэд ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авах:
- хохирогчид орон байрнаасаа хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, баримт бичиг, хүүхдийн сургалтын хэрэгсэл, шаардлагатай хэрэглээний эд зүйлээ авахад нь туслалцаа үзүүлж, хүчирхийлэл үйлдэгчээс шаардан гаргуулна.

Цагдаагийн алба хаагч шаардлагатай бол гэрч, хохирогч, мэдээлэл өгсөн этгээд, тэдгээрийн гэр бүлийн бусад гишүүн, хохирогчид туслалцаа үзүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг авна.

10. Нийгмийн ажилтны үүрэг

Хорооны нийгмийн ажилтан дараах үүргийг хүлээнэ:

- хохирогчийг мэдээллээр хангах, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх;
- гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг үнэлэх;
- нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хохирогчийн хэрэгцээг тодорхойлж, хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;
- хохирогчийг асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ болон нийгмийн халамжийн тэтгэмжид хамруулах, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээг зохион байгуулах;
- хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлэх судалгааг баг, хорооны ажилтантай хамтран хийх, бүртгэл хөтлөх, үйл ажиллагаандаа ашиглах;
- гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах;
- хохирогчид үзүүлэх хамтарсан багийн үйлчилгээг төлөвлөх, уялдуулан зохицуулах, үйлчилгээний тайлан, мэдээнд үндэслэн дараа жилийн үйлчилгээнд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах саналыг Засаг даргад гаргах;
- хуульд заасан бусад.

11. Эрүүл мэндийн ажилтны үүрэг

Эрүүл мэндийн ажилтан хохирогчийг хамгаалах талаар дараах үүргийг хүлээнэ:

- эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулах;
- хохирогчийг шаардлагатай үйлчилгээний талаарх мэдээллээр хангах;
- ур чадвар эзэмших чиглэлээр сургалтад хамрагдах;
- хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нийгмийн ажилтантай хамтран ажиллах, мэргэжлийн дүгнэлт гаргах;
- хуульд заасан бусад.

12. Сургуулийн нийгмийн ажилтан

Боловсролын тухай хуульд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

- ГБХ-д өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх чиглэлээр хамтарсан багтай хамтран ажиллах;
- ГБХ-д өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, туслалцаа, дэмжлэгийн талаар эцэг, эх, багш, холбогдох бусад ажилтанд зөвлөгөө өгөх;
- ГХБХ, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагч, багш, боловсролын байгууллагын бусад ажилтан, эцэг, эхэд мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах;
- Хуульд заасан хөтөлбөр, стандарт, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.

13. Төрийн бус байгууллагын чиг үүрэг

Төрийн бус байгууллага нь дүрмийнхээ зорилгод нийцүүлэн ГБХ-тэй тэмцэх талаар дараах чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно:

- үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн арга зүйгээр хангахад дэмжлэг үзүүлэх;
- олон нийтэд ГБХ-ээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;
- хохирогчийг түр хамгаалах байраар хангах болон энэ хуульд заасан бусад үйлчилгээ үзүүлэх.

14. Хамтарсан багийн гишүүдийн харьяалах тус тусын байгууллагад тухайн гишүүний үйл ажиллагааны талаар мэдээлэл, тайланг Багийн ахлагч хүргүүлж болно. Хамтарсан багийн шийдвэр нь хурлын тэмдэглэлээр баталгаажна. Тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурсан байна. Хурлын тэмдэглэлд тухайн хурлаар хэлэлцсэн асуудлын холбогдох баримт бичгийн хувийг хавсаргаж болно.

15. Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэр бөгөөд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц үйлчилгээг үзүүлнэ.

Хамтарсан баг ажлаа хагас, бүтэн жилээр төлөвлөн хэрэгжүүлж, тайлангаа аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Мэдээлэл өгөх:

Дэд сэдвүүд:

- ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ойлголтын талаар
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх цогц тогтолцоо
- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх;
- Хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох;
- Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах

Үнэлгээ:

Багшийн мэдээллийн дараа сэдвийг бататгах дараах хяналтын асуултуудыг асууна.

- Хамтарсан багийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны дүрэм юу вэ?
- Хамтарсан багт ажиллахад цагдаагийн алба хаагчид ямар мэдлэг, ур чадвар шаардагдах бол?
- Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнууд хамтарсан багийн талаар нэгдсэн ойлголт, мэдлэгтэй байхын учир холбогдлыг тодорхойлно уу.

Дүгнэлт

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Сэдвийн өмнө авсан сорилыг дүгнэхээр зөв хариултуудыг хэлж өгнө. Дурдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно. Хамгийн сүүлд "ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажлын ач холбогдол юу вэ?" гэсэн асуултаар хичээлийг дуусгана.

Сургагч багшид өгөх санамж:

Энэ хичээлийг "Хүн бүр багш" гэсэн заах аргаар явуулах учраас суралцагчдыг идэвхтэй оролцуулах, тэдний яриаг анхааралтай сонсож тэмдэглэх нь хичээлийн дүгнэлтээ хийх, мэдээллээ бататгахад хамгийн ач холбогдолтой. Суралцагчид мэдээлэл олж авах, түгээх боломжийг хангах, сургалтыг эмх цэгцтэй явуулахын тулд анги танхимын зохион байгуулалтад анхаарах шаардлагатай.

Багш дараах эх сурвалжийг бэлтгэн, судалсан байх:

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 3 дугаар зүйл, 2019 он,
- МУ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 2016 он,
- Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017.10.04-ний өдрийн А/173, А/259, А/380 дугаартай хамтарсан тушаал, 1.3 дахь хэсэг.

Сэдэв 2. Хохирогч төвтэй хандлага

Сэдвийн товч агуулга:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтан албан хаагч болон төрийн, төрийн бус байгууллагын ажилтнууд ГБХ-ийн хохирогчийн хэрэгцээ шаардлагад үндэслэн тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар явуулж буй бүхий л үйл ажиллагаа нь хохирогч төвтэй байх ач холбогдлын талаар мэдлэгтэй болно. Энэ сэдвийн хүрээнд хохирогч төвтэй хандлагын талаарх ойлголт, баримтлах зарчим, талаар дэлгэрэнгүй үзэх болно.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно.

- ГБХ хохирогч төвтэй хандлагын талаар ойлгож, тайлбарлах;
- ГБХ-ийн үр дагаврын талаар ойлгох
- ГБХ-ийн хохирогчийн эдлэх бусад эрхийн талаар ойлгож, тайлбарлах;

Дасгал ажлын зааварчилгаа: Оролцогч бүрт 2-3 хэрчмэл мэдээлэл тараана. Мэдээллийг уншиж ойлгох талаар даалгавар өгнө. Самбарыг 2 хуваан хохирогч төвтэй хандлагыг илэрхийлсэн мэдээллүүдийг нэг талд нь хохирогч төвтэй хандлагыг илэрхийлээгүй мэдээллүүдийг нөгөө талд нь байрлуулахыг оролцогчдоос хүснэ.

Оролцогч бүрээс мэдээллийг хэрхэн ойлгосон талаар болон яагаад тухайн баганад байрлуулсан талаар асууж ярилцана.

Тараах материал 1: Хэрчмэл

Дараах хэрчмэл мэдээлэл хохирогч төвтэй хандлага эсэхийг тодорхойлно уу.

1. ГБХ-ийн хохирогчтой цагдаагийн газрын хүлээлгийн өрөөнд ярилцах нь
2. Хохирогчийн нэрний оронд дугаар ашиглах нь
3. Сонсголын бэрхшээлтэй ГБХ-ийн хохирогчтой дохионы хэл ашиглаж харилцах нь
4. Хохирогчийн гэмтсэн хэсгийн болон өөрийнх нь зургийг зөвшөөрөлгүй, тайлбаргүйгээр авах нь
5. Хохирогчид энэ удаад л хуулийн арга хэмжээ авахгүй бол дараагийн удаа хохирогчийг дахин хүчирхийлэлд өртөхөд тусалж чадахгүй гэж хэлэх нь
6. Хохирогчид сэтгэл зүйн болон хуулийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын мэдээллийн өгөх нь
7. Нөхрийгөө ажлаасаа ирэхэд нь гэртээ байсан бол нөхөр чинь уурлахгүй мөн таныг багалзуурдахгүй байх байсан гэж хохирогчид хэлэх нь
8. Хүчирхийллийн хохирогчтой ижил хүйсийн цагдаагийн алба хаагч уулзаж тухайн асуудлыг шалгах нь
9. ГБХ-ийн хохирогчоос тодруулаагүй дутуу үлдсэн асуудлыг тодруулах зорилгоор дахин мэдүүлэг авах нь
10. Эцэг эхийн зүгээс хүчирхийлэлд өртсөн 6 настай хүүхдээс хаана, хэнийд байх талаар асуух нь
11. Хүчирхийлэл үйлдэгчийг баривчлагдаж байх хугацаанд Баривчлах байрны төлбөрийг гэр бүлийн гишүүдээс нь гаргуулж болно. Учир нь хүчирхийлэл үйлдэгч ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй, эрхээ хязгаарлуулсан байгаа.
12. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчоос шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн шинжээчийн үзлэгийн төлбөрийг гаргуулах нь зүйн хэрэг. Үүнээс өөр арга байхгүй.
13. Эцэг эхийн хүчирхийлэлд өртсөн 15 настай хүүхдээс хаана, хэнийд байх талаар асуух нь
14. Дуудлага, мэдээлэл дээр очиход хохирогч болон хүчирхийлэгч аль аль нь байгаа тохиолдолд юуны түрүүнд тэднийг салгаж, тус тусад нь мэдүүлэг авна.
15. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн биедээ хүндхэн гэмтэл авсан хохирогчийг түр хамгаалах байр руу хүргэж өгөх нь
16. Гэмт хэрэг, зөрчлийг шалгаж буй ажилтан нь хохирогчид тохиолдсон явдлыг гэмт хэрэг /зөрчил/

бөгөөд үүнийг дутуу үнэлж болохгүй гэдгийг тайлбарлах нь

17. Хууль сахиулах байгууллагын ажилтан ГБХ-ийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч нарыг нэг цаг хугацаанд дуудаж уулзах нь
18. Хохирогчид эрхийн жагсаалтыг уншиж танилцуулах
19. Мэдүүлэг өгөхөд хохирогчийг гэр бүлийн гишүүн эсхүл ИНБ-ын төлөөлөгчтэй хамт ирэхийг дэмжих
20. Аюулгүйн төлөвлөгөө гаргасан эсэхийг асуух, хамтран гаргах
21. Хохирогчийн мэдүүлэгтэй холбоотой хэсгийг хавтаст материалд оруулах
22. Хүчирхийлэгчийн зан үйлийг өөрчлөх нь хохирогчийн үүрэг биш бөгөөд энэ бол гагцхүү тухай хүний үүрэг гэдгийг ойлгуулах.
23. Хүүхэдтэй нүүр тулан тэдний нүдний түвшинд, доошоо тонгойж эсхүл сууж ярилцах.
24. Хохирогчоос түүний хүссэн газарт мэдүүлэг авах
25. Яллагдагч болон түүний хамаарал бүхий этгээдтэй холбоотой шийдвэр, ач холбогдол бүхий үйл баримтын талаар мэдээлэл өгөх
26. Хохирогчоос нээлттэй асуулт асуух
27. Хохирогч болсон үйл явдлыг санахгүй бол хариулт өгөхийг шаардах
28. Шүүгдэгчийн өмгөөлөгчийн үүрэг болон шүүх хурал дээр хохирогчоос асууж болох асуултын талаар тайлбарлах.
29. Шүүх дээр хохирогч болон холбогдогчийн нэг хүлээлгийн танхимд оруулах
30. Шүүх хуралдааны дараа хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдийг хүчирхийлэл үлдэгчээс 15-20 минутын өмнө явах боломжийг олгох

Үнэлгээ:

Сургалтаа хэрхэн үр дүнтэй зохион байгуулсаныг дүгнэх зорилгоор дараах хяналтын асуултуудыг асууна.

- Хохирогч төвтэй хандлага гэж юуг хэлж байна вэ?
- Тухайн хичээлээс та яг юу сурч мэдсэн бэ?
- Таны ажилд ашиглагдах мэдээлэл байна уу?
- Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагад ажиллаж байгаа ажилтан алба хаагчдын үйл ажиллагаа хохирогч төвтэй байж чадаж байна уу? Жишээ дурдана уу?

Дүгнэлт

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно. Хамгийн сүүлд "Хохирогч төвтэй хандлага гэж юу вэ?" гэсэн асуултад НҮБ-ын тодорхойлолтыг дурдаж, хичээлийг дуусгана.

Сургагч багшид өгөх санамж:

Багш дараах эх сурвалжийг бэлтгэн, судалсан байх:

- Монгол Улсын холбогдох хууль
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам
- ГБХТТХ-ийг хэрэгжүүлэх чиглэлээр салбарын сайд нараас гаргасан журам

Сэдэв 3. Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ

Сэдвийн товч агуулга:

Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлийн түвшинг тогтоох, аюулын зэргийн үнэлгээ хийх хууль тогтоомжийн зохицуулалт, анхаарах зүйл, тэмдэглэл хөтлөх аргачлалд суралцах нь энэ сэдвийн зорилго оршино.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- Аюулын зэргийн түвшинг үнэлэх тухай ойлголт, ач холбогдол, анхаарах зүйлийг тодорхойлох
- Аюулын зэргийн үнэлгээний тэмдэглэлийг практикт хөтлөх ур чадвар сайжирна .
- Аюулын зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээний ялгаа, үнэлгээг үндэслэж авах арга хэмжээний талаарх мэдлэг нэмэгдэнэ.

Багийн ажлын зааварчилгаа: Оролцогчдыг 4 багт хуваах тараах материал 1, 2-ыг тус бүр 5 ширхэгийг тарааж өгнө. Оролцогчид кейсийг уншиж, аюулын зэргийн үнэлгээний хуудсыг бөглөнө.

Багууд бие биенийхээ хийсэн аюулын зэргийн үнэлгээг дүгнэнэ.

Тараах материал 1: Кейс

Кейс 1

Бат, Уянга 2 их сургуулийн нэг анги бөгөөд сургууль төгсөөд гэр бүлээ батлуулан, хамт амьдрах болсон. Бат хувиараа бизнес эрхлэн гэр бүлийн ихэнх орлогоо олж, Уянга төрийн байгууллагад ажиллаж байгаад сүүлийн 2 жилд хүүхэд асрахын чөлөөтэй байгаа.

Бат гэр бүлээ тэжээн тэтгэж байгаа гэсэн байдалдаа эрдэж сүүлийн үед архи уух нь олширч, архи уугаад гэртээ ирээд үл ялих зүйлээр эхнэр Уянгатай маргалдах, улмаар хааяа алгадах, цохих зэргээр зодох болсон.

Энэ оны 09 дүгээр сард Бат гэртээ орой 22 цагт эрүүл ирсэнийхээ дараа эхнэр Уянгыг хүүхдээ уйлууллаа гэж уурлан нүүрэн тус газар нь цохисоны улмаас Уянгын хамарнаас цус гарч, толгой доргин, улмаар эмнэлэгт 3 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.

Дээрх нөхцөл байдалд Аюулын зэргийн үнэлгээ хийнэ үү?

Кейс 2

Дүүргийн дугаар хорооны иргэн Сүрэн, Дорж нар 2017 оноос хамтран амьдрах болсон бөгөөд Сүрэнгийн охин Бурмаа 11-р ангид сурч байсан. Дорж, Сүрэн нарын дундаас 2020 оны 03 сард хүү Золбоот гарсанаас хойш Дорж дагавар охин Бурмааг ад үзэж, ээжийг нь ажилдаа явсан, гэртээ байхгүй үед янз бүрийн шалтгаанаар байнга загнаж, дарамтлах болсон.

Бурмаагийн төрсөн аав нь 3 настай байхад нь нас барсан бөгөөд Бурмаа багаасаа ээжийнхээ хайр, энхрийлэлд өссөн болохоор хүний үг даах чадвар сул, гомдомтгой. Бурмаа нь Доржид удаа дараа загнуулсанаас болж амиа хорловол Доржийг чадна, ээж болон Дорж харамсаж, гашуудна гэж бодож амиа хорлохоор эм уусан боловч эмнэлгийн тусламж авч, амь нас нь аврагдсан.

Дээрх нөхцөл байдалд Аюулын зэргийн үнэлгээ хийнэ үү?

Кейс 3

Аймгийн төвөөс алслагдсан суманд амьдардаг Бат, Хорлоо нар мал аж ахуйгаараа дундаж амьдралтай амьдардаг. Бат, Хорлоо нар хүү Гарьд /15 нас/, охин Хэрлэн /16 нас/ нарын хамт амьдардаг.

Энэ оны 08 дугаар сард Хорлоог эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байхад нь Бат найзынхаа хүүхдийн хуриманд явж, ирсэн орой Хэрлэнг үнсэж, бэлэг эрхтэнээр нь оролдсон байна. Болсон явдалыг Хэрлэн ээж Хорлоод 9 дүгээр сард хэлсэнээр, Хорлоо цагдаагийн байгууллагад өргөдөл гаргасан.

Дээрх нөхцөл байдалд Аюулын зэргийн үнэлгээ хийнэ үү?

Кейс 4

Хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Х.Болор 2020.10.28-ны өдөр гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын дагуу хорооны иргэн Галдаагийнд очиход Галдаа эхнэр Отгоны эрх чөлөөнд халдаж танхайрсан байдалтай байжээ.

Ахмад Х.Болор гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн гэж үзэн Аюулын зэргийн үнэлгээ хийж, Отгоноос болсон асуудлыг тодруулахад би дуудлага өгөөгүй, асуултанд хариулахгүй, гомдолгүй гэсэн байна. Ахмад Х.Болор гэр орны байдал, гэрт байсан хүү Галт /7 нас/, хүү Бадрал /15 нас/ нараас болсон асуудлыг тодруулан Аюулын зэргийн үнэлгээ хийхэд, эрсдэлийн түвшин "Бага" гарсан тул үнэлгээ хийсэн тэмдэглэл дээр Отгоноор гарын үсэг зуруулж, Отгоныг Түр хамгаалах байранд хүргэж өгсөн.

Эрх зүйн дүгнэлт хийнэ үү?

Тараах материал 2: Аюулын зэргийн үнэлгээний хуудас. /Гарын авлагын хавсралтаас авна уу/

Мэдээлэл өгөх:

- Анхаарал татсан материал (статистик, график гэх мэт);
- Аюулын зэргийн үнэлгээ хийх хууль тогтоомжийн зохицуулалт;
- Аюулын зэргийн үнэлгээ хийхэд анхаарах зүйл;
- Аюулын зэргийн үнэлгээ хийсэн тэмдэглэл хөтлөхөд анхаарах зүйл;
- Аюулын зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээний ялгаа.

Үнэлгээ:

Хяналтын асуулт:

- ГБХ-ийн хохирогчийн аюулын зэргийн түвшинг үнэлэхэд юу анхаарах ёстой вэ?
- ГБХ-ийн хохирогчийн аюулын зэргийн түвшинг үнэлсэн үнэлгээ нь гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг болзошгүй аюул, халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл болох уу?
- Аюулын зэргийн үнэлгээний түвшинг үндэслэн ямар арга хэмжээ авах вэ?
- Аюулын зэргийн үнэлгээг хохирогчоор бөглүүлж болох уу? Олон хохирогч байвал яах вэ?
- Аюулын зэргийн үнэлгээ нотлох баримт мөн үү?

Дүгнэлт:

Оролцогчдоос хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан), мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч-багшид өгөх санамж:

"Аюулын зэргийн үнэлгээ хийх журам"-ыг судалсан байх.

Сэдэв 4. ГБХ–ийн гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах нь

Сэдвийн товч агуулга:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан журмуудад заасан хамгаалалтын арга хэмжээг хэрхэн хохирогч төвтэй хэрэгжүүлэх талаар ойлголттой болох нь энэ сэдвийн зорилго оршино.

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээний төрөл, хэлбэрүүд;

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэхээр дагалдаж гарсан журмууд;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхээр дагалдаж гарсан зарим журмууд;
- ГБХ-ийн гэмт хэргийн гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, хамгаалалтад авах, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц, тэдэнд хуульд заасан туслалцаа үзүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа боловсруулах;

Сэдвийн гол зорилтуудыг жагсаана:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг тодорхойлж, хэрхэн хохирогч төвтэй хандлагатай хэрэгжүүлэх талаар мэргэжлийн ур чадвартай болно.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль дахь хохирогчийн аюулгүй байдлыг хангах заалтуудыг бусад хуулиудтай харилцан уялдаа холбоотой хэрэгжүүлнэ.

Мэдээлэл өгөх:

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтүүд, сүүлийн 4 жилд хамгаалалтад авагдсан ГБХ-ийн хохирогчдын тоон мэдээ (статистик, график гэх мэт);
- Прокурор, шүүгчид ГБХ-ийн хохирогчийг хамгаалалтад авахуулах хүсэлт гаргахад хэрэг бүртгэгч, мөрдөгчөөс бүрдүүлэх материал, хэрэглэгдэх маягтуудыг танилцуулах;
- ГБХ-ийн хохирогчдын онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ, бусад аюулгүй байдлыг хамгаалах заалтуудын хоорондын уялдаа холбоог харгалзан зохион байгуулах;
- Гэрч хохирогчийг хамгаалах хамгаалалтын арга хэмжээ авахад хохирогч төвтэй хандлагуудыг танилцуулах

Тараах материал 1: Хамгаалалтад авахуулах хүсэлт гаргахад хэрэглэгдэх маягтууд

1. Хууль зүйн сайдын 2015 оны А/88 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх тэмдэглэл", "Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх /өөрчлөх/ тухай санал", "Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг цуцлах тухай санал", "Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээс татгалзах тухай санал" маягтыг ашиглах.
2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /Гэрч, хохирогчийг хамгаалах "код 511"/-ээс Маягт ЦБҮАЖ №511.51а "Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх тухай" маягтыг мөрдөгч ашиглах.
3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/83 дугаартай тушаалаар батлагдсан "Аюулын зэргийн үнэлгээ хийх журам", тушаалын хоёрдугаар хавсралт "Аюулын зэргийн үнэлгээний тэмдэглэл"-ийг Гарын авлагаас авч ашиглах.

Маягт ЦБҮАЖ №511.51а

Маягт-1

Хууль зүйн сайдын 2015 оны 04 дүгээр сарын 28 -ны өдрийн А/88 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УРЬДЧИЛАН САНУУЛАХ ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

20 ... оны .... сарын .... өдөр № .....хот, аймаг

.....албан тушаалтай.....
би доорх нэр бүхий иргэнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлд заасныг үндэслэн Урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн тухай тэмдэглэл үйлдэв.

Нэг. Биеийн байцаалт:

1. ...../ургийн овог/...../эцэг эхийн нэр/ ...../нэр/
2. Регистрийн дугаар.....нас.....хүйс.....
3. Боловсрол.....мэргэжил.....
4. Эрхэлсэн ажил.....
5. Ам бүлийн байдал.....
6.Оршин суух хаяг (албан ёсны болон түр оршин суух хаягаа хоёуланг бичнэ)
.....

Хоёр. Хэргийн товч мэдээлэл:

1. Эрүүгийн хэргийн дугаар.....зүйл, хэсэг.....
2. Эрүүгийн хэрэг үүсгэсэн огноо.....
3. Хэргийн товч утга.....
.....
.....
.....

Гурав. Урьдчилсан сануулах хамгаалалтын арга хэрэгжүүлэх болсон шалтгаан:

.....
.....
.....
.....
.....

Дөрөв. Хүлээлгэх хариуцлага:

Таны 20.....оны .....сарын .....өдөр хийсэн үйлдэл нь дахин давтагдвал Монгол Улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн.....дугаар зүйлийн .....дэх заалтыг зөрчсөн үйлдэл гэж үзэн дээрх хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээж

Маяг-2

Хууль зүйн сайдын 2015 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/88 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ТАНИЛЦСАН.....
.....

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ / ӨӨРЧЛӨХ/ ТУХАЙ САНАЛ

20 .... оны .... сарын .... өдөр .....хот, аймаг

..... албан тушаалтай ..... би доорх нэр бүхий иргэнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20, 21 дүгээр зүйл өмгөөлөгч, прокурор, шүүгч ..... -ны санал, гэрч, хохирогч .....-ны хүсэлтийг үндэслэн Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх /өөрчлөх/ тухай саналыг .....-д хүргүүлэв.

Нэг. Биеийн байцаалт:

1. ...../ургийн овог/...../эцэг, эхийн нэр/ ...../нэр/
2. Регистрийн дугаар .....нас.....хүйс.....
3. Боловсрол.....мэргэжил.....
4. Эрхэлсэн ажил.....
5. Ам бүлийн байдал.....
6. Оршин суух хаяг (албан ёсны болон түр оршин суух хаягаа хоёуланг бичнэ)

.....

Хоёр. Хэргийн товч мэдээлэл:

1.Эрүүгийн хэргийн дугаар.....зүйл, хэсэг.....
2. Эрүүгийн хэрэг үүсгэсэн огноо.....
3. Хэргийн товч утга .....

.....

Гурав. Хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх болсон шалтгаан, үндэслэл:

.....

.....

САНАЛ ГАРГАСАН:

.... / /

(албан тушаал) (цол, зэрэг дэв) (гарын үсэг) (нэр)

Тайлбар: Уг хамгаалалтын арга хэмжээний хуудас нь 3 хувь үйлдэгдэх бөгөөд 1 хувь нь эрүүгийн хэрэгт, 2 дах хувь нь прокурор, шүүхийн байгууллагад, 3 дах хувь нь гэрч, хохирогчийн хувийн хэрэгт үлдэнэ.

Маягт-3

Хууль зүйн сайдын 2015 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/88 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ТАНИЛЦСАН.....

.....

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ЦУЦЛАХ ТУХАЙ САНАЛ

20 .... оны .... сарын .... өдөр .....хот, аймаг

..... албан тушаалтай ..... би Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3 дахь хэсэгт заасныг үндэслэн Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг доорх үндэслэлээр цуцлах тухай саналыг .....-д хүргүүлэв.

Нэг. Биеийн байцаалт:

1...../ургийн овог/ ..... /эцэг, эхийн нэр/ ...../нэр/

2. Регистрийн дугаар .....нас ..... хүйс.....

3. Боловсрол.....мэргэжил.....

4. Эрхэлсэн ажил.....

5. Ам бүлийн байдал .....

6. Оршин суух хаяг (албан ёсны болон түр оршин суух хаягаа хоёуланг бичнэ)

.....

Хоёр. Хэргийн товч мэдээлэл:

1. Эрүүгийн хэргийн дугаар.....зүйл, хэсэг.....

2. Эрүүгийн хэрэг үүсгэсэн огноо.....

3. Хэргийн товч утга.....

.....

Гурав: Хамгаалалтын арга хэмжээг цуцлах болсон шалтгаан, үндэслэл

.....

.....

САНАЛ ГАРГАСАН:

.... / /

(албан тушаал) (цол, зэрэг дэв) (гарын үсэг) (нэр)

Тайлбар: Уг хамгаалалтын арга хэмжээг цуцлах хуудас нь 3 хувь үйлдэгдэх бөгөөд 1 хувь нь эрүүгийн хэрэгт, 2 дах хувь нь прокурор, шүүхийн байгууллагад, 3 дах хувь нь гэрч, хохирогчийн хувийн хэрэгт үлдэнэ.

Маяг-4

Хууль зүйн сайдын 2015 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/188 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ТАНИЛЦСАН.....
.....

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАХ ТУХАЙ САНАЛ

20 .... оны .... сарын .... өдөр .....хот, аймаг

..... албан тушаалтай.....
би доорх нэр бүхий иргэнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээс татгалзах тухай саналыг .....-д хүргүүлэв.

Нэг. Биеийн байцаалт:

1. ..... /ургийн овог/ ...../эцэг, эхийн нэр/
..... /нэр/
2. Регистрийн дугаар .....нас ..... хүйс.....
3. Боловсрол.....мэргэжил.....
4. Эрхэлсэн ажил.....
5. Ам бүлийн байдал .....
6. Оршин суух хаяг (албан ёсны болон түр оршин суух хаягаа хоёуланг бичнэ)
.....

Хоёр. Хэргийн товч мэдээлэл:

1. Эрүүгийн хэргийн дугаар.....зүйл, хэсэг.....
2. Эрүүгийн хэрэг үүсгэсэн огноо.....
3. Хэргийн товч утга.....
.....

Гурав. Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхээс татгалзах болсон шалтгаан, үндэслэл:

.....
.....

САНАЛ ГАРГАСАН:

.... / /
(албан тушаал) (цол, зэрэг дэв) (гарын үсэг) (нэр)

Тайлбар: Уг хуудас нь 2 хувь үйлдэгдэх бөгөөд 1 хувь нь прокурор, шүүхийн байгууллагад, 2 дах хувь нь тухайн байгууллагад үлдэнэ.

Маягт-5

Хууль зүйн сайдын 2015 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/88 дугаар тушаалын тавдугаар хавсралт

/Иргэн, албан тушаалтнаас авах баталгаа/

БАТАЛГАА

20.... оны .... сарын .... өдөр .....хот, аймаг

.....(Байгууллагын нэр)
.....(ажил/ албан тушаал)
.....овогтой ..... би

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21.6 дахь хэсэгт "Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээний талаар мэдэгдсэн иргэн, албан тушаалтан бусдад энэхүү мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй" гэж заасны дагуу нууцлалыг чанд хадгалж, хамгаалахаа баталж байна. Хэрэв би энэхүү үүргийг биелүүлээгүй эсвэл нууц задруулбал Монгол Улсын Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх болно.

БАТАЛГАА ГАРГАГЧ:

.....(овог, нэр)

.....(гарын үсэг)

.....(регистрийн дугаар)

.....(утасны дугаар)

БАТАЛГАА ГАРГУУЛСАН:

.....(албан тушаал)

.....(нэр).....(гарын үсэг)

СЭТГЭЛ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

20 .... оны .... сарын .... өдөр Улаанбаатар хот

..... албан тушаалтай ..... цолтой ..... би эрүүгийн ..... дугаартай, аюулгүй байдал хамгаалалтын арга хэмжээний хяналтын ..... дугаартай хэрэгтэй танилцаад ОЛСОН нь:

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх хэсэгт зааснаар .... /гэрч, хохирогч, түүний хамаарал бүхий этгээд/-д сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор ТОГТООХ нь:

1. ..... /гэрч, хохирогч, түүний хамаарал бүхий этгээд/-д Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасан сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авсугай.

2. Шийдвэрийн хэрэгжилтийг хангах, нууцлалыг хамгаалж ажиллахыг .... газар, хэлтсийн ..... албан тушаалтай ..... цолтой ..... – д даалгасугай.

3. Энэ шийдвэрийг хамгаалуулагч ..... /гэрч, хохирогч, түүний хамаарал бүхий этгээд/-д танилцуулсугай

МӨРДӨГЧ: ..... цолтой ..... /...../

гарын үсэг нэр

СЭТГЭЛ ЗҮЙЧ: ..... цолтой ..... /...../

гарын үсэг нэр

ТАНИЛЦСАН ДАРГА: ..... /...../

гарын үсэг нэр

Багийн ажлын зааварчилгаа:

a) Оролцогчдыг ширээнд суусан байдлаар нь 6 багт хуваана. Хэлэлцүүлгийг үр дүнтэй болгохын тулд багийн ахлагчийг томилно.

b) Хичээлийн эхэнд баг бүрийн ширээн дээр тараах материал тарааж байрлуулсан байна.

c) Баг бүр өмнө сэдвийн хүрээнд (АЗҮ) ажилласан 4 кейс дээр дахин ажиллана. Кейсд дурдагдсан хохирогчийг хамгаалалтад авахуулах материалыг бүрдүүлнэ.

d) Дасгал ажлын төгсгөлд багийн ахлагч бусад оролцогчдод хохирогчийг хамгаалалтад авахуулах маягтыг хэрхэн бүрдүүлсэн үр дүнгийн талаар илтгэнэ.

Үнэлгээ:

Багш сэдвийг бататгах дараах асуултуудыг оролцогчдоос асууна.

Хяналтын асуулт:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний онцлог, сул талыг нэрлэнэ үү?
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний онцлог, давуу талууд юу вэ?
- Мөрдөгч аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх тухай санал гаргах эрхтэй юу?
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан ямар хамгаалалтын арга хэмжээг мөрдөгч бие даан хэрэгжүүлэх эрхтэй вэ?
- ГБХ-ийн гэрч, хохирогч хамгаалалтад авхуулах хүсэлтээ хэнд, хэрхэн гаргах вэ?
- Эрх бүхий албан тушаалтан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэр гаргахдаа хуульд заасан ямар нөхцөлийг харгалзах вэ?

Дүгнэлт:

Багаар сууж буй ширээ бүрээс хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

3.1 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН БОЛОН ШҮҮГЧИЙН АНХААРАХ ОНЦЛОГ АСУУДАЛ

Цагдаагийн ажилтнуудын анхаарах асуудал

Сэдэв 1. ГБХ–ийн дуудлага, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх ажиллагаа

Сэдвийн товч агуулга:

ГБХ-ийн дуудлага, мэдээллийг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээний талаар мэдлэгээ гүнзгийрүүлж, хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлыг судлахад сэдвийн зорилго оршино.

- ГБХ-ийн дуудлага, мэдээллийг хүлээн авах цагдаагийн алба хаагчийн үүрэг, анхаарах зүйл
- ГБХ-ийн дуудлага, мэдээллийг хүлээн авахад жижүүрийн мөрдөгч, ахлах мөрдөгчийн үүрэг, анхаарах зүйл
- ГБХ-ийн дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж байгаа алба хаагчийн анхаарах зүйл, хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх
- Хүүхдийн аюулгүй байдлыг хангах

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ-ийн дуудлага мэдээлэл хүлээн авах арга зүй эзэмшинэ.
- ГБХ-ийн дуудлага, мэдээллийг бусад дууддлага мэдээллээс ялгах, ур чадвартай болно.
- ГБХ-ийн дуудлага, мэдээллийг шалгаад хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид авах арга хэмжээний талаар гүнзгийрүүлсэн мэдлэгтэй болно.

Мэдээлэл өгөх:

Дэд сэдвүүд:

- Анхаарал татсан материал (статистик, график гэх мэт);
- Дуудлага, мэдээлэл шалгах ажиллагааны онцлог, анхаарах зүйл;
- Цагдаагийн алба хагчийн эрх, үүрэг;
- Дуудлага мэдээлэл шалгах ажиллагааны үе шат;

Багийн ажлын зааварчилгаа: Оролцогчдыг 5 багт хуваж, тараах материалыг тараан өгнө. Оролцогчид кейсийн дагуу дуудлага, мэдээллийг хүлээн авч, цаашид авах арга хэмжээг тодорхойлно.

Тараах материал:

Кейс-1

Иргэн С нөхөр Б-тэй 2008 онд танилцан гэрлэлтээ батлуулж 2 хүүхдийн эцэг, эх болсон байна. Б нь гэрлэлтээ батлуулсан үеэс эхлэн эхнэр С-ыг ажил хөдөлмөр эрхлэхэд нь дургүйцэн, хардаж зоддог болсон. Үүний улмаас С, Б нарын анхны хүүхэд зодуурын улмаас эндэж, том хүү Э төрөлхийн саажилт өвчтэй төрсөн байна. С байнгын хүчирхийлэлд өртдөг байдлаа эцэг эх, хамаатан саднаасаа байнга нууцладаг байсан бөгөөд 2018 онд нөхөртөө зодуулсан талаараа 2 удаа цагдаагийн байгууллагад хандан дуудлага мэдээлэл өгсөн боловч Б-ийн ятгалга, дарамтын улмаас өргөдлөө буцаан татаж авсан байна. С, Б нарын 2 хүүхэд байнгын хүчирхийлэлд өртдөг байдлаасаа шалтгаалан зарим тохиолдолд орондоо бие засах, шалтгаангүйгээр орилж уцаарлах, эсхүл удаан хугацаагаар дуугаа хураах болсон. Мөн Б нь 2 хүүхдийнхээ дэргэд байнга архидан согтуурч, согтуу үедээ хүүхдүүдээ зодож, өвлийн хүйтэнд гадаа хөл нүцгэн зогсоох, удаан хугацаагаар хоол өгөхгүй байх зэргээр тарчлаадаг байсан.

2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 02 цагийн орчимд Б нь согтуурсан үедээ С-ыг боомилон, хутгаар гарыг нь зүсч, галын хайчаар 2 гуя, хэвлий хэсгийг нь түлэн, 2 хүүхдийнх нь хамт гэрээс нь хөөсөн байна. С эмнэлгийн байгууллагаас тусламж авсныхаа дараа гэрлэлтээ цуцлуулах талаар Б-д хэлэхэд Б өөрийнхөө зүүн гарын эрхий хуруунд тайрч С-д өгөөд гэрлэлтээ цуцлуулбал амиа хорлоно гэж сүрдүүлсэн байна. 2019 оны 08 дугаар сард Б согтуурсан үедээ дахин С-г зодож бүгдийг нь ална гэж заналхийлэн олон ширхэг нойрны эмийг С болон 2 хүүхэддээ хүчээр уулгасан байна. Энэ байдлыг сонссон хөрш айл цагдаагийн байгууллагад дуудлага өгсөн.

Үнэлгээ:

Хяналтын асуулт:

- Дуудлага хүлээн авахад цагдаагийн алба хаагчийн үүрэг юу вэ?
- Дуудлага, мэдээлэл авах үе шатыг нэрлэнэ үү.
- Дуудлага, мэдээллийн онцлог, анхаарах асуудал юу вэ?
- Цагдаагийн ажилтны харилцаанд анхаарах зүйлсийг тодорхойлно уу. Тухайлбал:
- Хохирогч тантай таагүй харилцвал (хэрэлдэх, доромжлох гэх мэт) ямар санагдах вэ? Таны уур хүрэх үү, та хариу уурлах уу? Ичих үү?
- Хохирогчийг тайвшруулж, итгэлийг нь олж, үр дүнтэй ярилцах ямар арга техник байна вэ?
- Практикт гарч байгаа алдаа, түүнийг яаж шийдвэрлэх вэ?
- Дуудлага, мэдээллийн газарт буй хүүхэдтэй ярилцахад цагдаа нар бэлэн байдаг уу? Хүүхэдтэй ярилцах нь бусад хохирогчтой ярилцахаас ямар ялгаатай вэ?
- Илтгэх хуудас /тэмдэглэл/-ыг бичихэд анхаарах асуудал юу вэ?

Дүгнэлт:

Оролцогчдоос хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан), мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч-багшид өгөх санамж:

ГБХ-ийн дуудлага мэдээлэл хүлээн авч, шалган, шийдвэрлэх ажиллагаанд хохирогч төвтэй хандлагыг судалж, тодорхойлсон байх

Сэдэв 2. ГБХ–ийн гомдол, мэдээлэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах

Сэдвийн товч агуулга:

ГБХ үйлдэх зөрчлийг бусад зөрчлөөс ялган зүйлчлэх, шалган шийдвэрлэх ажиллагаа, түүний онцлог, анхаарах зүйлсийг судалж, хохирогчийн аюулгүй байдлыг хангаж, тусламж үйлчилгээ үзүүлэхэд хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэхэд мэдлэгээ нэмэгдүүлэх нь энэ сэдвийн зорилго оршино.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ-ийн зөрчлийн шинж, бусад зөрчлөөс ялгагдах онцлогийг тодорхойлно.
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны онцлог, анхаарах асуудлыг тайлбарлана.
- Нотлох баримт цуглуулах, баримтжуулахад анхаарах асуудлыг онцолно.
- Хохирогчийн аюулгүй байдлыг хангах, тусламж үйлчилгээ үзүүлэхэд цогц мэдээлэлтэй болно.

Багийн ажлын зааварчилгаа: 6 төрлийн кейсийг хоёр хүний дунд 1-г тараан өгч, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд гарч байгаа хүндрэл бэрхшээлийг оролцогчдоор бичүүлнэ. Дараад нь хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Тараах материал:

Кейс-1

Бат, Дөлгөөн хоёр бэлгийн цөөнх бөгөөд хамтран амьдраад 1.6 жил болж байгаа. 2018 оны 01 сарын 14-ны өдөр Бат хардалтын улмаас Дөлгөөнийг зодсон.

Цагдаагийн алба хаагч дуудлагаар очиж Бат, Дөлгөөн хоёрыг эр хүмүүсийн хоорондох асуудал, гэр бүлийн хүчирхийлэл биш гэж үзсэн байна.

Цагдаагийн алба хаагчийн шийдвэр зөв үү?

Кейс-2

Урнаа, Хүлэг хоёр гэр бүлтэй бөгөөд гэр бүлээс гадуур харьцаатай болоод 2 жил болж байгаа. Хүлэг сүүлийн үед Урнааг хардаж зодох болсон бөгөөд Урнаа цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн талаар гомдол гаргасан.

Хэсгийн байцаагч Урнаа, Хүлэг нарыг гэр бүлийн хамаарал бүхий этгээдүүд биш гэж үзэн зөвлөгөө өгөөд явуулсан байна.

Хэсгийн байцаагчийн шийдвэрт дүгнэлт хийнэ үү?

Кейс-3

Сүрэн төрийн байгууллагад мэргэжилтэн, эхнэр Ундрах үсчин ажилтай. Сүрэн, Ундрах нар 2-16 насны 2 хүүхэдтэй. Сүрэн 7-14 хоног тутам гэртээ найз нартайгаа архи уудаг. Энэ байдлыг нь мэдсэн хөрш нь цагдаагийн байгууллагад гомдол гаргасан.

Сүрэн гэртээ архи уух нь хувийн асуудал, архи уугаад хүүхдээ зодох, айлгах явдал гаргадаггүй гэж тайлбарладаг. Хэсгийн байцаагч Сүрэнд ямар нэгэн арга хэмжээ тооцоогүй.

Хууль зүйн дүгнэлт хийнэ үү?

Кейс-4

Хэсгийн байцаагч Дорж гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн Готовын үйлдлийг хохирогчийн өргөдөл, мэдүүлэг, аюулын зэргийн үнэлгээ зэрэг нотлох баримтаар тогтоон баривчлах шийтгэл оногдуулахаар материалыг дүүргийн шүүхэд шилжүүлсэн.

Шүүгч нөхцөл байдлын үнэлгээ байхгүй гэсэн шалтгаанаар Готовын үйлдлийг шийдвэрлээгүй.

Аюулын зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээ нотлох баримт мөн үү. Хууль зүйн дүгнэлт хийнэ үү.

Кейс-5

Эрдэнэ ам бүл гурвуулаа бөгөөд хувийн хэвшилд ажиллаж гэр бүлийн амьдралаа авч явдаг. Эхнэр Гэрэл архины хамааралтай, хүүхэд нь 3 настай саажилттай байнгын асаргаанд байдаг.

Эрдэнэ Гэрэлийг байнга хардаж зоддог ба хэсгийн байцаагч гомдолын дагуу Эрдэнийг баривчлуулахаар материал бүрдүүлж байгаа. Гэвч Гэрэл байнга архи ууж хүүхдээ асрах үүргээ биелүүлдэггүй хүндрэл учирч байна.

Хэсгийн байцаагч хүүхэд асрах хүнгүй байгаагийн улмаас Эрдэнэд торгох шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн.

Эрх зүйн дүгнэлт хийнэ үү.

Кейс-6

Анхаа, Солонго 2 хамт амьдраад 10 жил болж байгаа. Солонго хөнгөн явдалтай бөгөөд энэ байдалд Анхаа уурлаж хааяа архи уудаг, гэвч зоддоггүй. Солонго Анхааг архи их хэмжээгээр ууж, өөрийн үйлдлийг удирдах чадваргүй үед нь цагдаагийн байгууллагад дуудлага өгдөг.

Цагдаагийн алба хаагч дуудлагаар очиход Солонго гэр бүлийн хүчирхийллийн талаар зохиомол зүйл хэлж аюулын зэргийн үнэлгээ хийлгэж улмаар Анхаа 2 удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэж шүүхээр баривчлагдсан. Анхааг баривчлуулсанаар Солонго өөрийн дураар байх боломж нь гардаг.

Хууль зүйн дүгнэлт хийнэ үү.

Мэдээлэл өгөх:

Дэд сэдвүүд:

- Анхаарал татсан материал (статистик, график гэх мэт);
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн шинжийн талаарх ойлголт;
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны онцлог, анхаарах зүйл;
- Хохирогчийн сэтгэл зүйн байдал
- Хохирогчтой ярилцахдаа хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх

Үнэлгээ:

Багийн ажлыг нэгтгэн сэдвийн агуулгыг үнэлэхдээ хяналтын асуултыг ашиглана.

Хяналтын асуулт:

- Зөрчил шалгаж буй алба хаагчийн үүрэг юу вэ?
- Гэр бүлийн хүчирхийллийн шинжийг тодорхойлно уу?
- Зөрчил шалгах ажиллагааны анхаарах асуудал юу вэ?

Дүгнэлт:

Оролцогчдоос хичээлийн үеэр яригдсан бөгөөд агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан), мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Хамгийн сүүлд түлхүүр асуулт асууна. Жишээ нь: ГБХ-ийн хохирогчтой ярилцахад юуг хамгийн түрүүнд анхаарах вэ?

Сургагч-багшид өгөх санамж:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг судлах.

Түлхүүр асуултын хариултыг бэлдсэн байх.

Сэдэв 3. ГБХ–ийн үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулах

Сэдвийн товч агуулга:

ГБХ-ийн гэмт хэргийн шинжийг зөв ойлгож, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, анхаарах зүйл, зүйлчлэлийн тухай гүнзгийрүүлэн судлахад энэ сэдвийн зорилго оршино. Түүнчлэн оролцогчдоос мэдүүлэг авах аргачлал, ялангуяа хохирогч төвтэй хандлагаар хохирогчтой харилцахад анхаарч, хүчирхийлэл үйлдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээ, нотлох баримт цуглуулах ажиллагааны онцлогийг дурдана.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ-ийн гэмт хэргийн шинжийг зөв ойлгож, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогийг тодорхойлох
- ГБХ-ийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхажиллагаанд хохирогч төвтэй хандлагыг тодорхойлох, зөв зүйлчлэл сонгох.
- ТСАХ, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд анхаардаг болно.

Мэдээлэл өгөх:

- Анхаарал татсан материал (статистик, график гэх мэт);
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинж, бусад гэмт хэргээс ялгагдах онцлог;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, анхаарах зүйл;
- Мөрдөн шалгах ажиллагааны нотлох баримт;
- Хохирогч, холбогдогчоос мэдүүлэг авахад анхаарах зүйл;
- Суралцах сэдвүүдийн тойм;

Багийн ажлын зааварчилгаа: Оролцогчдыг 1 эгнээнд зогсоож 1-ээс 5 хүртэл тоолуулан, ижил тоотойг 1 баг болгон хуваах, тараах материал 1-ийг тарааж өгнө.

Тараах материал 1:

Кейс 1

"Г" нь 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр "Миний нутаг" нэртэй хүнсний дэлгүүрт "О"-г утсаар ярьж хардлаа гэж уурлан түүний нүүрэн тус газарт гараараа нэг удаа алгадаж унагаан эрүүл мэндэд нь "зүүн талын зулайн дэлбэнгээс доош даган хөхлөг сэртэн дайрсан үргэлжилсэн шугаман хугарал, тархины эдийн няцрал, тархины баруун талын дух ба зулай хэсэгт цусархаг няцрал" бүхий хүнд хохирол санаатай учруулсан гэмт хэрэг үйлдсэн болох нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу бэхжүүлэгдэн хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтуудаар нотлогдсон.

Асуулт: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж бусдын биед хүнд гэмтэл учруулсан үйлдэл мөн үү?

Кейс 2

"Ө" нь гэртээ эхнэр "Д"-г жирэмсэн гэдгийг мэдсээр байж 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 11 цагийн үед "морь үргээлээ" гэх шалтгаанаар, 14 цагийн үед "хонинд явсангүй" гэх шалтгаанаар 2 удаа зодсон, 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 18 цагийн үед "ээжийгээ өмөөрлөө" гэх шалтгаанаар зодсон, 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 10 цагийн үед "хувцас шатаалаа" гэх шалтгаанаар зодож гэрт нь цоожлон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хохирогч "Д"-ийн биед тархины доргилт, зүүн нүдний алимны салстын цус харвалт, баруун бугалга, бүсэлхий, зүүн мөр, баруун зүүн өвдгөнд цус хуралт гэмтэл үүссэн.

Асуулт: Эрүүгийн хуулийн ямар зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах вэ?

Кейс 3

"Г" согтуурсан үедээ буюу 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдөр, мөн 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдрүүдэд Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 0-тоотод гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн болох өөрийн эхнэр "А"-ийн үснээс нь зулгааж өшиглөж, цохиж зодсон үйлдэлдээ тус тус Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээсний дараа 2019 оны 10 дугаар сарын 05-ны өдөр дахин өөрийн эхнэр "А"-ийн үснээс нь зулгааж, өшиглөж зодсон үйлдэл нь байнга давтагдаж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан.

Асуулт: Зүйлчлэл зөв үү?

Кейс 4

"Х" нь 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр гэртээ хамтран амьдрагч "О"-той хамт архи ууж байгаад үл ялих зүйлээс болж маргалдан, улмаар архины шилээр "О"-ийн толгойн тус газар нь цохиж, уг цохилтын улмаас "О" тархиндаа хүнд гэмтэл авч амь хохирсон.

"Х", "О" нар гэр бүлийн баталгаагүй, 7 жилийн турш хамт амьдарч байсан, "О" архины хамааралтай байсан.

Асуулт: Эрүүгийн хуулийн ямар зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах вэ?

Кейс 5

"Б" нь 2019 оны 03 дугаар сарын 28, 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрүүдэд гэр бүлийн хамаарал бүхий буюу хамтран амьдрагч "И"-г зодож гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, мөн 2019 оны 05 дугаар сарын 11-ний өдөр дахин зодож эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан.

Асуулт: Эрүүгийн хуулийн ямар зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах вэ?

Үнэлгээ:

Багаас нэг төлөөлөгч дараагийн багт очиж кейсээ танилцуулж, дүгнэлт хийлгэнэ. Сургагч багш төлөөлөгчдийг самбарт урьж 2 багийн дүгнэлтийг нэгтгэн танилцуулахыг хүснэ. Дараах хяналтын асуултуудыг нийт багт тавина.

Хяналтын асуулт:

- Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн шинж, онцлог нь юу вэ?
- Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог юу вэ?
- Хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааны үйл явц, тактик ямар онцлогтой вэ?
- Хүчирхийлэгчээс мэдүүлэг авах ажиллагааны тактикийн онцлог юу вэ?
- Нотлох баримтыг цуглуулах болон бэхжүүлэхэд юу анхаарах вэ?
- Хориглох асуулт гэж ямар асуултыг энэ төрлийн хэрэг дээр авч үздэг вэ?

Дүгнэлт гаргана:

Оролцогчдоос хичээлийн үеэр яригдсан бөгөөд видео шторкоор харуулахыг зорьсон агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан), мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч-багшид өгөх санамж:

ГБХ-ийн гэмт үйлдэлд эрүүгийн хэрэг, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад ямар хохирогч төвтэй хандлага хэрэгжүүлдэг талаар мэдээлэлтэй байх.

Сэдэв 4. ГБХ-ийн хохирогчид тусламж үзүүлэх ажиллагаа

Сэдвийн товч агуулга:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд, цагдаагийн алба хаагчид ГБХ-ийн хохирогчдод хэрхэн тусламж үйлчилгээ үзүүлдэг болон үйлчилгээний төрөл, онцлог, анхаарах асуудлын талаар дэлгэрэнгүй судлахад энэ сэдвийн зорилго оршино.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно.

- ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогчийн хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлох;
- Хохирогчдын эрхийг хангах, хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай байгууллага, үүрэг хүлээсэн мэргэжилтнийг тодорхойлж, холбон зуучлах боломжтой болно.

Мэдээлэл өгөх:

Дэд сэдвүүд:

- ГБХ-ийн тусламж үйлчилгээ, түүний төрөл;
- Цагдаагийн байгууллагаас үзүүлэх тусламж үйлчилгээ;
- Аюулгүй байдлын хамгаалалт;
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ;
- Сэтгэл зүйн үйлчилгээ;
- Эрх зүйн туслалцаа;
- Нийгмийн халамжийн үйлчилгээ;
- Холбон зуучлах үйлчилгээ.

Дүрд тоглох багийн ажлын зааварчилгаа: Оролцогчдод ГБХ-д өртөн тусламж үйлчилгээ шаардлагатай болсон хохирогчийн тухай кейс тараана, танилцана. Оролцогчдыг дараах дүрд хуваарилна. Үүнд:

Хохирогч, Хохирогчийн хүүхэд, Цагдаагийн алба хаагч, сэтгэл зүйч, өмгөөлөгч, хорооны нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, Засаг дарга, төрийн бус байгууллагын ажилтан, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн мэргэжилтэн. Бусад оролцогчдыг ажиглагчаар оролцуулна.

Ингээд оролцогчдоос хохирогчид хуульд заасан тусламж үйлчилгээ үзүүлэхийг хүснэ. Үүний дараа хохирогч, түүний хүүхдийн дүрд тоглосон оролцогч, хөндлөнгийн ажиглагч нараас хэрхэн тусламж үйлчилгээ үзүүлсэн, ямар алдаа дутагдал, ололт амжилт гаргасан талаар асууж ярилцана.

Үнэлгээ:

Дүрийн тоглолтын үед тохиолдсон ойлгомжгүй болон бэрхшээлтэй асуудлын талаар хэлэлцүүлэг хийнэ. Ингэхдээ дүрд тоглосон оролцогчдыг дүрийнхээ талаар эргэцүүлэх, дүр аваагүй оролцогчид ажигласан зүйлээ ярилцах зорилгоор дараах хяналтын асуултуудыг оролцогчдоос асууна.

- Цагдаагийн ажилтан хохирогчид ямар төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх ёстой вэ?
- Цагдаагийн ажилтан хохирогчийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн тодорхойлох вэ? Ийнхүү тодорхойлохын ач холбогдол юу вэ?
- Хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрлийг нэрлэнэ үү.
- Цагдаагийн ажилтан хохирогчийг ямар байгууллагад хэрхэн холбон зуучилдаг вэ?
- Хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрийн бусад алба хаагч нар ямар үүрэг хүлээдэг, хамтын ажиллагаа ямар байх ёстой вэ?

Дүгнэлт:

Баг бүрээс хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч-багшид өгөх санамж:

Хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэхэд хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх талаар судалж, хичээлийн явцад тохиромжтой үед нь сануулах. Дараах эх сурвалжуудыг судалсан байх.

Эх сурвалж:

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам

ГБХТТХ-ийг хэрэгжүүлэх чиглэлээр салбарын сайд нараас гаргасан журам

Прокурорын анхаарах асуудал

Сэдэв 1. ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт

Сэдвийн товч агуулга:

Гэр бүлийн хүчирхийллийн гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллагад хүлээн авах, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлог нь юу болох, цаашид анхаарвал зохих асуудлуудыг судлах, нэн ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг бусад төрлийн гомдол, мэдээллээс ялгагдах онцлогийг тодорхойлоход энэ сэдвийн зорилго оршино.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн бусад төрлийн гомдол, мэдээллээс ялгагдах онцлогийг тодорхойлох;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгах ажиллагааны онцлог, түүнд тавих прокурорын хяналтын анхаарвал зохих асуудлуудын талаарх мэдлэгээ дээшлүүлнэ.

Багийн ажлын зааварчилгаа: Багш оролцогчдыг 3 багт хуваах сургалтын зорилтууд болох 3 сэдвийг өгч, оролцогчдын хүлээлтийг самбар дээр тэмдэглүүлж сонсоно, дараа нь зорилгоо хамтран тодорхойлно.

Даалгаварт өгөх сэдвүүд:

1. ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн бусад төрлийн гомдол, мэдээллээс ялгагдах онцлог,
2. ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлог,
3. ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлог.

Мэдээлэл өгөх:

1. ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн бусад төрлийн гомдол, мэдээллээс ялгагдах онцлог.

ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг:

- гэр бүлийн дотно харилцаа, хамаарал бүхий хүмүүсийн хооронд үүссэн,
- аюулын өндөр эрсдэл, хор уршгийг дагуулсан,
- даамжирсан, давтамжтай,
- нуугдмал ,
- нэн даруй, шуурхай арга хэмжээ авах шаардлагатай,
- гэрчгүй үйлдэгддэг,
- хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчээс хамааралтай буюу ихэнх хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэй байнга хамт байдгаар нь бусад төрлийн гомдол, мэдээллээс ялгана.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн гол онцлог шинж нь:

- Үл ялих зүйлээр шалтагласан,
- Тодорхой нэг шалтаг, шалтгаангүй,
- Танхайн шинжтэй байх гэсэн шинжүүдийг агуулна.

2. ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлог.

- Гомдол мэдээллийг хүлээн авах ажиллагаанд тавих прокурорын хяналт
- Гомдол мэдээллийг шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт
- Гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагааны явцад анхаарвал зохих асуудлууд
- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчилд хүүхэд өртсөн тохиолдолд прокуророос анхаарвал зохих асуудлууд

Үнэлгээ:

Сургалтаа хэрхэн үр дүнтэй зохион байгуулсаныг дүгнэх зорилгоор дараах хяналтын асуултуудыг асууна. Үүнд:

- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдэллийн бусад төрлийн гомдол мэдээллээс ялгагдах онцлог нь юу болох?
- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шалгахад зайлшгүй хийгдвэл зохих ажиллагаа болон түүнд тавих прокурорын хяналтын онцлог юу болох?

Дүгнэлт:

Суралцагчдаас хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч багшид өгөх зөвлөмж:

Хичээлийг багаар буюу жижиг бүлгээр ажиллуулах байдлаар явуулах тул бүгдийг тэгш, идэвхтэй оролцуулахад анхаарч, тэднийг ажиллаж байх хугацаанд эмх цэгцтэй байлгах, ажиллах нөхцлийг хангах, зохион байгуулалтад оруулах шаардлагатайг анхаарах.

Сэдэв 2. ГБХ үйлдэх зөрчилд зөрчлийн хэрэг нээх, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт.

Сэдвийн товч агуулга:

Энэхүү сэдэвт ГБХ үйлдэх зөрчил гэж юуг ойлгох, хуулийг хэрхэн хэрэглэх, ямар үйлдлийг ГБХ үйлдэх зөрчлийн хэрэг гэж үзэх, гэмт хэргээс ямар шинжээр нь ялган зүйлчилж, шалгахад анхаарвал зохих асуудлуудыг судлана.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ үйлдэх зөрчлийн хэрэг нээх, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлогийг тодорхойлно.
- ГБХ үйлдэх зөрчил гэж юуг ойлгох, хуулийг хэрхэн хэрэглэх, гэмт хэргээс хэрхэн ялган зүйлчлэх талаарх ойлголтыг авна.

Багийн ажлын зааварчилгаа: Суралцагчдыг 4 баг болгон бодит 4 кейс тараан, танилцуулна. Багууд кейс дээр зөрчлийн хэрэг нээнэ

Баг тус бүр дүгнэлтээ гаргаж танилцуулна. Ингэхдээ багаас төлөөлөл гарч ирж танилцуулна

Тараах материал 1:

Кейс 1.

Цагдаагийн байгууллагад 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдөр иргэн "О"-оос "нөхөр согтуу зодоод байна" гэх дуудлага, мэдээлэл иржээ. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаагаар,

"Э" нь 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, Хилчиний 5-63 тоотод байх гэртээ төрсөн охин 10 настай "А"-г "хичээл хийсэнгүй" гэх шалтгаанаар 2 гарыг нь өргүүлэн, галын шилээвэр төмрөөр гуя, бөгс хэсэгт нь 2-3 удаа цохиж,

Мөн 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдөр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ хамтран амьдрагч "О"-той "архи уулаа" гэх шалтгаанаас болж маргалдан улмаар толгой руу нь гараараа 4-5 удаа цохиж, хоолойг нь боож, 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдөр "шөнө хүүхдүүдээ авч явна" гэж маргалдан хоолойг нь боон, сандлаар толгой руу нь 1 удаа цохин тус тус зодсон нөхцөл байдал тогтоогдсон байна.

"Э" нь урьд нь 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдөр СХД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хамтран амьдрагч "О"-г зодсон гэх зөрчлөөр 40 цагийн албадан сургалтанд хамрагдаж, 30 хоногийн баривчлах шийтгэлээр шийтгүүлж байжээ.

1. Дээрх тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн аль нь болохыг тодорхойлж, зүйлчлэлийг хийнэ үү?

2. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаагаар хийгдвэл зохих ажиллагаануудыг тодорхойлно уу?

Кейс 2.

Цагдаагийн байгууллагад 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр иргэн "Г"-ээс "нөхөр согтуу зодоод, эд зүйл эвдээд байна" гэх дуудлага иржээ. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаагаар:

"М" нь Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороо, Орбитын 8-3 тоотод байх гэртээ 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ хамтран амьдрагч "Г"-тэй "амтгүй хоол хийлээ" гэх шалтгаанаар маргалдан, хэл амаар доромжилж, гараараа нүүр рүү нь 2-3 удаа цохиж,

Мөн 2020 оны 03 дугаар сарын 05-ны орой мөн л согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ

"хаалга тайлж өгсөнгүй" гэх шалтгаанаар гаднаас монгол гэрийнхээ хаалгыг өшиглөн, эвдэн орж "Г"-ийн толгой руу нь гараараа 2 удаа, галын шилээвэр төмөр авч гуя руу нь 4 удаа цохиж, улмаар үснээс нь зулгаан чирж, гэрээсээ хөөж гарган хаалгаа түгжээд оруулахгүй байсан нөхцөл байдал тогтоогджээ.

1. "М"-ийн үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ГБХ үйлдэх зөрчлийн аль шинжийг агуулж байгаа? Тохирох хэсгээр зүйлчилнэ үү?

2. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаагаар хийгдвэл зохих ажиллагаануудыг тодорхойлно уу?

Кейс 3.

Цагдаагийн байгууллагад 2020 оны 03 дугаар сарын 08-ны өдөр насанд хүрээгүй "Г"-ээс "аав согтуу зодоод байна" гэх дуудлага иржээ. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаагаар:

"Д" нь 2020 оны 02 дугаар сарын 28-ны шөнө 03 цагийн үед согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хороо, Хилчиний 5-9 тоотод байх гэртээ эхнэр "М"-д агсан тавьж, хэл амаар доромжлон, орноос нь хөөж босгон архины мөнгө нэхэн, "өгөхгүй бол ална" хэмээн заазуур авч дайран айлган сүрдүүлсэн,

Мөн 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ эхнэр "М"-г "утсанд чинь мессеж ирлээ" гэж уурлан бусадтай хардаж, хэл амаар доромжлон, утсыг нь авч шидэн эвдсэн,

2020 оны 03 дугаар сарын 08-ны 23 цагийн үед согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ төрсөн хүү 11 настай "Г"-г "аягатай хоол авч өгсөнгүй" гэх шалтгаанаар толгой руу нь гараараа 2 удаа цохин, үснээс нь зулгаан "гэрээс зайл" гэж унтлагын хувцастай нь хөөж гарган, гэрийнхээ хаалгыг түгжин оруулахгүй байсан нөхцөл байдал тогтоогдсон байна.

1. "М"-ийн үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ГБХ үйлдэх зөрчлийн аль шинжийг агуулж байгаа? Тохирох хэсгээр зүйлчилнэ үү?

2. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаагаар хийгдвэл зохих ажиллагаануудыг тодорхойлно уу?

Кейс 4.

Цагдаагийн байгууллагад 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдөр иргэн "Н"-ээс хүү согтуу ирээд агсан тавиад байна" гэх дуудлага иржээ. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаагаар:

"Т" нь Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороо, Баруун баян уулын 2-9 тоотод байх гэртээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ 2020 оны 01 дүгээр сарын 13, 2020 оны 01 дүгээр сарын 24, 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдрүүдэд төрсөн эх 75 настай "Н"-д агсан тавьж, архи, тамхины мөнгө нэхэн, шөнө унтуулахгүй орноос нь хөөж босгон, гэрээсээ хөөж гарган хаалгаа түгжин оруулдаггүй зэрэг нөхцөл байдал тогтоогджээ.

Мөн "Т" нь урьд нь төрсөн эх 75 настай "Н"-ыг зодож Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 20 цагийн албадан сургалтанд хамрагдаж, 20 хоногийн баривчлах шийтгэлээр шийтгүүлж байсан болох нь шийтгэвэр, АСАП сангийн лавлагаа зэргээр тогтоогдсон байна.

1. "М"-ийн үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ГБХ үйлдэх зөрчлийн аль шинжийг агуулж байгаа? Тохирох хэсгээр зүйлчилнэ үү?

2. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаагаар хийгдвэл зохих ажиллагаануудыг тодорхойлно уу?

Мэдээлэл өгөх:

-ГБХ үйлдэх зөрчилд зөрчлийн хэрэг нээх ажиллагаанд тавих прокурорын хяналтын анхаарвал зохих асуудлууд

-ГБХ үйлдэх зөрчлийн хэргийг шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын анхаарвал зохих асуудлууд

-Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн хэргийн үндсэн шинж

Үнэлгээ:

Сургалтаа хэрхэн үр дүнтэй зохион байгуулсаныг дүгнэх зорилгоор дараах хяналтын асуултуудыг асууна.

- ГБХ үйлдэх зөрчлийн хэргийн гэмт хэргээс ялгагдах онцлог?
- ГБХ үйлдэх зөрчлийн хэрэг нээх, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлог?

Дүгнэлт:

Суралцагсдаас хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч багшид өгөх зөвлөмж:

Хичээлийг багаар буюу жижиг бүлгээр ажиллуулах байдлаар явуулах тул бүгдийг тэгш, идэвхтэй оролцуулахад анхаарч, тэднийг ажиллаж байх хугацаанд эмх цэгцтэй байлгах, ажиллах нөхцлийг хангах, зохион байгуулалтад оруулах шаардлагатайг анхаарах.

Багш шаардлагатай тохиолдолд дараах эх сурвалж мэдээллийг бэлтгэн оролцогчдод өгнө.

Эх сурвалж:

"Байнга зодож" гэснийг: Улсын Дээд шүүхийн 2010 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 13 дугаар тогтоол"-д зааснаар "... тодорхой нэг хохирогчийн эсрэг чиглэсэн, хэвшмэл маягтай, гурав ба түүнээс дээш удаа биемахбодын хүчирхийлэл хийсэн байхыг хэлнэ" гэснээр ойлгох.

"Харгис хэрцгий харьцаж" гэснийг: Улсын дээд шүүхийн 2010 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 13 дугаар тогтоолд"-д "Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэх болон бусад хэлбэрээр /хүнийг хууль бусаар хорих, сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт хууль бусаар байлгах, бэлгийн хүчирхийлэлд оруулах, өлсгөх, цангаах, орон гэрээс нь хөөх гэх мэт/-ээр илэрнэ" гэснээр ойлгох.

"Догшин авирлаж" гэснийг: "Олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн үйлдлийг ичгүүр, сонжуургүй авирлаж, харгис хэрцгий аргаар зориуд удтал үргэлжлүүлэн хийсэн байхыг ойлгоно" гэснээр ойлгох.

"Тарчлаах" гэснийг: "Монгол улсын Дээд шүүхийн 2010 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 13 дугаар тогтоолд "бие махбодын болон сэтгэл санааны шаналгаа, өвдөлт үүсгэсэн аливаа үйлдэл хийсэн байхыг ойлгоно" хохирогчид ямар нэгэн байдлаар бэртэл гэмтэл учруулахгүй ч байнга буюу олон удаа үйлдэгддэг үйлдлүүдээр илэрнэ. Жишээлбэл: байнга чимхэх, зулгаах, унтуулахгүй байх, байнга хэл амаар доромжилж, хараан зүхэх гэх мэт" гэснээр ойлгох.

"Хуваарьт болон дундын эд хөрөнгөө ээмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан" гэснийг": Иргэний хуулийн 126-128 дугаар зүйл болон Улсын дээд шүүхийн 2009 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 20 дугаартай "Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 3 дугаар дэд бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай" тогтоолд зааснаар ойлгох.

"Хүүхэд" гэснийг: 18 насанд хүрээгүй хүнийг гэснээр ойлгох.

"Ахмад настан" гэснийг: "Ахмад настны тухай" хуулийн 3 дугаар зүйлд зааснаар "60 түүнээс дээш настай эрэгтэй, 55 түүнээс дээш настай эмэгтэй Монгол улсын иргэн"-ийг гэснээр ойлгох.

"Хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэснийг: "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" хуулийн 4 дүгээр зүйд: "бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг" хэлнэ гэснээр ойлгох.

"Асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан" гэснийг: Асрамжийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагын ажилтан, алба хаагч гэснээр ойлгох.

"Таслан зогсоох гэсэн хүн" гэснийг: "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн 7 дугаар зүйлд "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг хориглох" гэсэн заалтад заагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл өгсөн этгээд, гэрч, хохирогчид туслалцаа, дэмжлэг үзүүлсэн этгээд, энэ хуульд заасан үүргээ гүйцэтгэж байгаа албан тушаалтан, ажилтан"-ыг ойлгоно гэснээр ойлгох.

Сэдэв 3. ГБХ-ийн үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын онцлог

Сэдвийн товч агуулга:

Мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлж, хэргийг шийдвэрлэдэг. ГБХ-ийн гэмт үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэх асуудлыг нэн даруй шийдвэрлэх нь тухайн хүчирхийллийн үйлдлийг шалгаж тогтоох, хохирогч, гэрчийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг асуудлыг шуурхай шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Иймд энэ сэдвийн хүрээнд гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахад анхаарах асуудал, прокуророос хянавал зохих зүйл, анхдагч нотлох баримтыг цуглуулах, үнэлэхэд шаардагдах ур чадвар, мөрдөгчийг хэргийг мөрдөн шалгаж, нотлоход чиглүүлэх, нотолгооны тактикийн асуудлыг хэрхэн хамтран шийдвэрлэх талаар судлах зорилготой юм.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахад энэ төрлийн хэргийн онцлогт тохирсон шийдвэр гаргах;
- Эрүүгийн хэрэг үүсгэхэд хянавал зохих асуудал, анхдагч нотлох баримтыг цуглуулах;
- Мөрдөн шалгах ажиллагааны явцад гардаг хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх;
- Прокуророос мөрдөгчийг хэргийг нотлоход чиглүүлэх, нотолгооны тактикийн асуудал хамтран шийдвэрлэх.

Тараах материал 1:

Сургалтын өмнө авах сорил

1. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл шалгах хугацаа хэрэг бүртгэлтийн хугацаанд хамаарах уу?

А) Үгүй, тусдаа ойлголт

Б) Тийм

В) Хуульд тодорхой зохицуулалт байхгүй

С) Аль нь ч биш.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны "Даруй" гэсэн нэр томьёоны утгыг хуульд хэрхэн тайлбарласан бэ?

А) Боломжит богино хугацаа

Б) Мөрдөгч үзэмжээрээ тогтоож оролцогчдод мэдэгдэх хугацаа

В) Шүүх тогтоож оролцогчид мэдэгдэх хугацаа

С Нэг цагаас багагүй хугацаа

3. Аль нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болохгүй үндэслэл вэ?

А) Тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа

Б) Хуулийн этгээдийг төлөөлөн тухайн хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргасан хүн нас барсан

В) Хохирогчийн эрх ашгийг хамгаалж байсан өмгөөлөгч ажиллагаанд оролцох боломжгүй болсон

С) Тухайн хэргийг сайн мэдэх гэрч нас барсан

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагааг явуулахад хөндлөнгийн гэрч олдохгүй боловч ажиллагааг хийх шаардлагатай тохиолдолд асуудлыг шийдвэрлэх журмыг хуульд хэрхэн тогтоосон бэ?

А) Ажиллагааг зогсоож хөндлөнгийн 2-оос доошгүй гэрчийг заавал оролцуулж явуулна.

Б) Ажиллагааг түр түдгэлзүүлж хөндлөнгийн 1 гэрчийг заавал оролцуулж явуулна.

В) Дуу, дүрсний бичлэгээр тухайн ажиллагааны явц, үр дүнг бэхжүүлнэ.

С) Хөндлөнгийн гэрч оролцуулахгүй явуулах зөвшөөрлийг прокуророос утсаар авч, ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулна.

5.Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналыг прокурорт хүргүүлэх үндэслэлд аль нь хамаарахгүй вэ

А) Хэрэг бүртгэлтийн явцад ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлд заасан тохиолдол үүсээгүй

Б) Тухайн хүн, хуулийн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх нөхцөл байдал тогтоогдсон

В) Яллагдагчаар татах хүн, хуулийн этгээд хаана байгаа нь тодорхой бол

С) Хэрэг бүртгэлтийн явцад гэмт хэрэг илэрсэн бол

Багийн ажлын зааварчилгаа: Оролцогсдод кейс таралаж өгч танилцах хугацаа өгнө. Эрүүгийн хэрэг үүсгэх явцад гарсан алдаа, үүний улмаас гэрч, хохирогч бусад хүний амь насанд учирсан эрсдэл, түүнийг цаашид хэрхэн шийдвэрлэх байсан бэ гэдэгт тодорхой хариулт өгч ярилцана, тодорхой шийдэл гаргуулна.

Тараах материал 2:

Бодит кейс

Хохирогч Насанбаяр нь Улаанбаатар хотод төрсөн. Коллеж төгссөн, дээд боловсролтой. 2014 оны 08 дугаар сарын эхээр нөхөр Баяраад зодуулсан бөгөөд мөн оны 08 дугаар сард ХУД-ийн цагдаагийн хэлтэст өргөдөл гаргаж, шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн магадлагаагаар хөнгөн зэргийн гэмтэл тогтоогдсон. Яармагийн 5 дугаар байрны 34 тоотод нөхөр охины хамт амьдарч байсан.

Нөхөр Баяраа нь эрх зүйч мэргэжилтэй, өөрийгөө өмгөөлөгч хийдэг гэж ярьдаг. 2013 оны 10 сараас хойш буюу нэг гэрт амьдрах болсон үеэс хойш байнга архи ууж, согтуу ирэх бүрдээ хэрүүл маргаан хийж гар хүрч, хэл амаар доромжилдог байсан. Долоо хоногт 3 удаа архи уудаг. Баяраа, Насанбаяр нар нь нэг охинтой, одоо 1 нас 7 сартай. Баяраа архи уух бүрдээ хэрүүл хийж Насанбаярыг алгадах, өшиглөх, түлхэх зэргээр гар хүрдэг.

Насанбаяр нь 2014 оны 08 сараас хойш сүүлийн 10 сар өөрийн аавын гэрт аав, ээж, охины хамт амьдарч байгаа. Баяраа намайг утсаар байнга дарамталж, сүрдүүлдэг. Би өмгөөлөгч учраас

хүүхдээ өөр дээрээ авч, чамтай хэзээ ч уулзуулахгүй болгож чадна гэх зэргээр хэлдэг. 2015 оны 01 сард аавынд юмаа авах гэж ирээд агсан тавихаар нь 102 дуудаж цагдаад өгсөн. Насанбаяр хүүхдээ хараад гэртээ байдаг. Хүчирхийлэл 2013 оны 10 сараас эхлээд одоо болтол үргэлжилж байна. Одоо гадуур явахдаа эргэж хардаг, айдастай, энд тэндээс нөхөр Баярааг гарч ирэх болов уу гээд сэтгэл санаа тогтворгүй байдаг. Анх суухаасаа өмнө нөхрийнхөө архи уудаг, түрэмгий занг нь таниагүй. Одоо бие зүгээр. Нөхөртэйгээ хамт байхад агсан согтуу тавихад нь бие чичэрч, салганадаг байсан. Нөхөртэйгээ 2012 оны 11 сард танилцсан. 2013 оны 06 сар хүртэл өөрийгөө аз жаргалтай байна гэж боддог байсан. Нэг гэрт орж амьдарсанаас хойш нөхрийн архи уудаг, түрэмгий авиртайг мэдсэн. Гараараа, гэрийн улавчаар, шүхрээр нүдэж зоддог байсан. Насанбаяр айлийн ганц охин.

Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналтайгаар мөрдөгчөөс прокурорт ирсэн гомдол мэдээллийн материалаас.

Эрүүгийн хэрэг үүсгэхэд анхаарах асуудал, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийнэ үү.

Мэдээлэл өгөх:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хуулийн холбогдох зүйл хэсгийн талаар нэгдсэн ойлголт,
- Эрүүгийн хэрэг үүсгэхэд анхаарах асуудал

Үнэлгээ:

Багш сэдвийг бататгах дараах асуултуудыг оролцогчдоос асууна.

Хяналтын асуулт:

1. ГБХ-ийн гэмт хэрэгт явуулах хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт нь бусад төрлийн гэмт хэргийг хянахаас ямар ялгаатай вэ? Яагаад?
2. Энэ төрлийн гэмт хэрэгт прокурор онцгойлон хяналт тавихын учир холбогдлыг тодорхойлно уу.
3. Эрүүгийн хэрэг үүсгэх үе шатанд прокурор хяналт тавьж, мөрдөгчтэй хамтран ажилласаны ач холбогдол юу вэ?

Дүгнэлт

Оролцогчдоос хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Сургалтын өмнөх сорилын үнэлгээг хийж, зөв хариултыг танилцуулна.

Зөв хариулт: 1б, 2а, 3а, 4в, 5г

Сургагч багшид өгөх зөвлөмж:

- Сэдвийн агуулгын хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахад түгээмэл гардаг алдаа, мөрдөгч прокурорын үл ойлголцол хэргийн шийдвэрлэлтэнд хэрхэн нөлөөлдөг, хохирогч төвтэй арга барилын үр нөлөө, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах,, мөрдөн шалгах ажиллагааны явцад анхаарах нотолгооны арга зүйг тайлбарлаж, хэрэг хянан шийдвэрлэх анхдагч нотлох баримт, эрүүгийн хэрэг үүсгэх явцад цуглуулсан нотолгоо чухал үүрэгтэй болох, түүнийг прокуророос хэрхэн хянахыг онцолно.
- Мөн Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах ажиллагаа, хуулийн хэрэглээ буюу холбогдох Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйл хэсгийг хэрхэн хэрэглэх талаар системтэй мэдээлэл өгнө.
- Дараах эх сурвалжийг судалж, бэлтгэсэн байна.

Эх сурвалж

- Эрүүгийн хууль /2020 оны нэмэлт, өөрчлөлт орсон/ , 2015 он,
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль/2020 оны нэмэлт, өөрчлөлт орсон/ 2017 он,
- Прокурорын хяналтын ажлын заавар /хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихтай холбоотой/, практик
- Гэмт хэргийн гэрч, хохирогч, гэмт хэргийн мэдээлэгч, тэдгээрийг хамгаалах үндэслэл, журам, таслан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэглэх боломж тодорхой шийдвэрүүд

Сэдэв 4. ГБХ-ийн гэмт хэргийг яллах ажиллагааны онцлог

Сэдвийн товч агуулга:

ГБХ-тэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн найруулснаар ГБХ үйлдэх гэсэн үйлдлийг байнга бол эрүүгийн гэмт хэрэгт тооцож, учруулсан хохирлын хэмжээгээр нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүний амьд явах эрхийн эсрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн аль тохирохоор нь зүйлчилж байх шинэ зохицуулалтууд бий болсон. Иймд энэхүү шинэ гэмт хэргийг шийдвэрлэх, хэргийг зүйлчлэх, шүүх хуралдаанд тухайн гэмт хэргийн онцлогийг мэдэхгүйгээр прокурор яллахад хүндрэлтэй байх тул энэ гэмт хэргийн шинжийг хэрхэн харгалзан үзэх талаар мэдлэг олгоход энэ хичээлийн зорилго оршино.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ-ийн гэмт хэргийн шүүх хуралд улсын яллагчаар оролцох онцлогийг тодорхойлох;
- ГБХ-ийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлүүлэхэд прокурорын мэтгэлцэх ур чадварыг дээшлүүлэх;

Тараах материал 1:

Сургалтын өмнө авах сорил

1. Яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрөө хүсвэл өмгөөлөгчгүйгээр хэрэг хянан шийтгэх ажиллагаанд оролцуулж болох уу?

А. Болно.

Б. Болохгүй.

В. Өмгөөлөгч оролцуулах эсэхийг прокурор шийднэ.

С. Хуульд зааснаас бусад тохиолдолд оролцогч өөрөө хүсэлт гаргасан бол өмгөөлөгчгүйгээр оролцуулж болно.

2. Эрүүгийн хэргийн талаар дүгнэлт гаргахаар томилогдсон шинжээч хавтаст хэрэгтэй танилцах эрхтэй юу?

А. Прокурор зөвшөөрсөн тохиолдолд хэргийн материалтай бүрэн танилцана.

Б. Мөрдөгч зөвшөөрсөн тохиолдолд хэргийн материалтай бүрэн танилцана

В. Хавтаст хэрэгтэй танилцах эрхгүй, мөрдөгч болон оролцогчид асуулт тавих эрхтэй.

С. Хавтаст хэргийн материалаас шинжилгээ хийх зүйлд холбогдох хэсэгтэй танилцах эрхтэй.

3. Дүгнэлт гаргасан шинжээч прокурор, мөрдөгчийн дуудсан цагт ирж, мэдүүлэг өгөх үүрэг хүлээх үү?

А. Мэдүүлэг өгөх үүрэгтэй.

Б. Энэ талаар хуулиар зохицуулаагүй.

В. Дүгнэлтдээ асуудлыг бүх талаас нь бүрэн дүүрэн тусгасан байдаг тул ирж мэдүүлэг өгөх

үүрэггүй гэж хуульд заасан.

C. Мэдүүлэг өгөх эрхтэй.

4. Прокурор шинжээчийн гаргасан дүгнэлтийн талаар түүнээс мэдүүлэг авахаар удаа дараа дуудсан боловч хүндэтгэх шалтгаангүйгээр ирэхгүй байгаа бол асуудлыг ямар журмаар шийдвэрлэх вэ?

A. Хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ.

Б. Өөрт нь мэдэгдсэн боловч ирэхгүй байгаа тохиолдолд прокурор шууд баривчилж авчирна.

B. Шаардлагатай бол цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлуулах арга хэмжээ авна.

C. Байгууллагын даргад нь мэдэгдэж албан шаардлага хүргүүлнэ.

5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын шийдвэрээр оролцож буй мэргэжилтнээс түүний гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэхүйн онцлогийн талаар тодруулж асуух хүсэлтийг оролцогчид гаргасан. Прокурорын өгсөн хариултаас хууль зүйн үндэслэлтэйг сонгоно уу

A. Мэргэжилтэн хуулийн дагуу та нарын асуултад хариулах үүрэг хүлээгээгүй.

Б. Мэргэжилтэн зөвхөн өөрөө зөвшөөрсөн тохиолдолд л та нарын тавьсан хүсэлтийг хангах боломжтой.

B. Мэргэжилтэн та нарын асуултад хариулт өгөх эсэхийг хуулиар зохицуулаагүй тул боломжгүй.

C. Мэргэжилтэн та нарын асуултад хариулах үүрэг хүлээсэн тул уулзах боломжоор хангана.

6. Ямар албан тушаалтан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй өсвөр насны хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийг тогтоох вэ?

A. Прокурор, мөрдөгч

Б. Иргэний бүртгэлийн байгууллага, прокурор, мөрдөгч

B. Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн байгууллага, мөрдөгч

C. Зөвхөн шүүх

7. Гэрч нь гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөх үү?

A. Мэдүүлэг өгөх үүрэгтэй тул заавал өгнө.

Б. Нийтийн эрх ашигт ноцтой хохирол учрахаар байгаа тохиолдолд л мэдүүлэг өгөх үүрэгтэй тул энэ тохиолдолд заавал өгнө.

B. Хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрахаас бусад тохиолдолд мэдүүлэг өгөх эрхтэй тул бусад тохиолдолд өгөхгүй байх боломжтой.

C. Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.

8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагааг явуулахад хөндлөнгийн гэрч олдохгүй боловч ажиллагааг хийх шаардлагатай тохиолдолд асуудлыг шийдвэрлэх журмыг хуульд хэрхэн тогтоосон бэ?

A. Ажиллагааг зогсоож хөндлөнгийн 2-оос доошгүй гэрчийг заавал оролцуулж явуулна.

Б. Ажиллагааг түр түдгэлзүүлж хөндлөнгийн 1 гэрчийг заавал оролцуулж явуулна.

B. Дуу-дүрсний бичлэгээр тухайн ажиллагааны явц, үр дүнг бэхжүүлнэ.

C. Хөндлөнгийн гэрч оролцуулахгүй явуулах зөвшөөрлийг прокуророос утсаар авч, ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулна.

9. Шүүгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийг нь оролцохыг хориглосон үндэслэлтэйг мэдсэн боловч оролцохыг татгалзалгүйгээр хэргийг шийдвэрлэсэн. Энэ тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

А. Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэж, шийдвэрийг хэвээр үлдээнэ.

Б. Шүүгчид ёс зүйн зөрчил гаргасан хариуцлагыг хүлээлгэж, шийдвэрийг хэвээр үлдээнэ.

В. Шийдвэрийг зохих журмын дагуу хүчингүй болгож, шүүгчийг огцруулах асуудлыг шийдвэрлэнэ.

С. Шүүгчийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүй болгоно.

10. Өмгөөлөгч ямар тохиолдолд тухайн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй вэ?

А. Тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгийн гэрчээр оролцож байсан бол

Б. Төрөл садангийн хүн нь тухайн хэрэгт гэрчээр оролцож байгаа

В. Эхнэр, нөхөр нь тухайн хэргийг шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцож байгаа Шийдвэрийг зохих журмын дагуу хүчингүй болгож, шүүгчийг огцруулах асуудлыг шийдвэрлэнэ

С. Эхнэр нь тухайн хэрэгт хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой оролцогчийн өмгөөлөгчөөр оролцож байсан

Тестийн хариу:

1	2	3	4	5	6	7	8	9	10
C	C	A	A	C	A	C	B	C	C

Багийн ажлын зааварчилгаа: Багт хуваагдсан оролцогчдод 2 кейс тэнцүү тоогоор бэлтгэн тарааж өгнө. Багууд кейсийг уншиж танилцана. Эрүүгийн хэрэг үүсгэх явцад гарсан алдаа, үүний улмаас гэрч, хохирогч бусад хүний амь насанд учирсан эрсдэл, түүнийг цаашид хэрхэн шийдвэрлэх байсан бэ гэдэгт багш багуудаас асуулт асууж хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Тараах материал 2:

Кейс 1

А.Б ЭХ-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн болох эхнэр Б.Ж-г байнга зодсон, эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан.

Шүүхийн шийдвэрйн дугаар 2019.03.05 өдөр №699

- хэрэгт авагдсан нотлох баримтуудад тулгуурлан хэргийг шийдвэрлэх боломжгүй

- хохирогчид хууль сануулж мэдүүлэг авахдаа Үндсэн хуульд заасан "өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх" эрхийг тайлбарлаж өгөөгүй нь нотлох баримтад тооцохгүй байх үндэслэл болж байгаа тул хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэсэн.

Кейс 2

Б нь 2017 оны 4 дүгээр сарын 20-ны үеэр БЗД-ийн 5 хороо Жуков хотхоны 49б байрны 32 тоотод гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай 13 нас 7 сартай Х-ийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж бэлгийн харьцаанд орж, жирэмсэн болгосон.

Анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж №18

- хэрэгт авагдсан нотлох баримтуудаар хэргийг шийдвэрлэх боломжгүй

- Х-д үр хөндөлт хийлгэсэн хүмүүсийг шалгах, түүнчлэн урагт ДНК-ийн шинжилгээ хийлгэх

- мөн хохирогч би өөр хүнтэй бэлгийн харьцаанд орж жирэмсэн болсон гэж мэдүүлсэн байх тул мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай гэж хаалттай хийсэн шүүх хурлаас буцаах шийдвэр

гаргасан

ЭХХШТ-ийн 33.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь хэсэгт заасныг үндэслэж буцаасан

-хэрэгт авагдсан баримтуудаар шийдвэрлэх боломжтой байсан ба үр хөндөлт хийлгэсэн эмч нарыг шүүх хуралд оролцуулах боломжтой байсан. Мөн ургийг шинжлэх боломжгүй гэж шүүх хурал дээр хохирогч өөр мэдүүлэг өгсөн.

Үнэлгээ:

Сургалтаа хэрхэн үр дүнтэй зохион байгуулсаныг дүгнэх зорилгоор дараах хяналтын асуултуудыг асууна.

- Яллах ажиллагаанд хохирогч төвтэй арга барил гэж юу вэ? Хохирогчийг шүүх хуралд бэлтгэхийн ач холбогдол
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг шалгах, нотлох ажиллагаанд прокуророос хяналт тавихад юуг анхаарах ёстой вэ?
- Прокурор шүүх хуралдаанд оролцож яллахад анхаарах асуудлын талаар ярина уу?

Дүгнэлт:

Оролцогчдоос хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.Сургалтын сорилын зөв хариултыг хэлж өгнө.

Сургагч багшид өгөх зөвлөмж:

- Прокурорын яллах ажиллагаанд хэрэгжүүлдэг хохирогч төвтэй хандлагын талаар судалж, мэдээлэл өгөхөд бэлтгэлтэй байх.

Шүүгчдэд зориулсан сургалтын хөтөлбөр

Сэдэв 1. ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх онцлог _____

Сэдвийн товч агуулга:

ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, нотлох баримтыг үнэлэхэд анхаарах асуудал болон гэмт хэргийг шийдвэрлэхэд шүүгч субъектив хүчин зүйлсээс сэргийлэх талаар судлахад энэ сэдвийн зорилго оршино.

Сэдвийн зорилт:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ онцлогыг нь харгалзан үзэхийг чухалчлах,
- ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримтыг үнэлэх арга зүйд суралцах

Дасгал ажлын зааварчилгаа: Өмнөх хичээл дээрх багийг дахин шинээр зохион байгуулна.

а) Оролцогчдын тоог харгалзан 5 багт хуваан, багаар ажиллах зааварчилгаа өгнө. Хэлэлцүүлгийг үр дүнтэй болгохын тулд багийн ахлагчийг томилно.

б) Багуудад ажлын хуудас болон цаас, маркер тараана. Тохиолдол (кейс)-ийг хэвлэн оролцогч нарын тоогоор хувилан өгнө. Багаараа ярилцаж, шүүхийн шийдвэрээ ажлын хуудсан дээр буулгаж, багийн ахлагч төлөөлөн багийн ажлыг танилцуулна.

Тараах материал 1:

Кейс 1: *(Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны ... дугаар шийтгэх тогтоол)*

"У нь 2018 оны 2 дугаар сарын 18-ны өдөр, 4 дүгээр сарын 21-ний өдөр, 4 дүгээр сарын 23-наас 24-нд шилжих шөнө Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын .. дугаар багийн нутаг дэвсгэрт, мөн 2018 оны 3 дугаар сард Өвөрхангай аймгийн Богд сумын .. дугаар багийн нутаг дэвсгэрт 3-г гараар болон төмөр, чулуугаар цохих, өшиглөх, үснээс нь зулгаах, чирэх зэргээр зодсон, зодсоны дараа гэр оронд нь очуулахгүй дагуулж явах, гэр бүлийнхэндээ гэмт хэргийн талаар худлаа ярихыг зааж заварлах, гэр бүлийнхэнтэй нь уулзуулахгүй байх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлээгүй, мөн 2018 оны 8 дугаар сарын 15-наас 16-нд шилжих шөнө Баянзүрх дүүргийн 27 дугаар хорооны нутаг дэвсгэр Сэлбэ голын орчимд хамтран амьдрагч 3-г түүнд хүчээр архи, согтууруулах ундааны зүйл хэрэглүүлсэн, мөн шөнө хохирогч 3-г зодож хүндэвтэр гэмтэл учруулсан, мөн шөнө хүндэвтэр гэмтэл учруулсаны дараа нойтон орчинд зориуд байлган, осгоож, хохирогч амь насаа алдсан гэмт хэрэгт холбогдож, прокуророос түүнд холбогдох хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн.

Шүүгдэгч У шүүх хуралдаанд мэдүүлэхдээ: "Би өнгөрсөн хугацаанд их зүйл ойлгосон, болж өнгөрсөн зүйлд харамсаж байна. Би гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хөнгөн хохирол учруулсан үйлдлээ хүлээн зөвшөөрч байна. Бусад хэргийг хүлээн зөвшөөрөхгүй. Гэрчийн мэдүүлэг, архи, согтууруулах ундааны зүйл хүчээр хэрэглүүлсэн гэж нэг талыг барьсан, камерийн бичлэг шалгаж өгөөгүй." гэжээ.

Мөрдөн шалгах ажиллагаанд:

Хохирогч З гэрчээр өгсөн мэдүүлэгтээ: "...2018 оны 01 дүгээр сарын сүүлээр Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд анх У гэх залуутай танилцаад үерхсэн юм. Тэгээд цагаан сарын шинийн 3-ний орой манайд У байж байгаад хашааны гадаа гудамжинд танихгүй хүн бие засаж байсныг хараад гэрт ирж намайг дагуулаад явсан. Явахдаа 1 шил "Нутгийн буян" гэх архи авч яваад жижиг 2 аяга хийж өгч уулгасан. Ихэнх архийг шилээр нь уучихаад мотоцикльтой төв рүү орж ирээд дэлгүүрээс "Нутгийн буян" гэх архи авч төвөөс урд зүгт хөдөө гарч, архиа У шилээр нь ганцаараа уучихсан. Тэгээд намайг хэн нэгэнтэй хий хардаад "хэл чи" гээд нүдсэн, тэгээд нүдээд байхаар нь зохиогоод "утасны мөнгө нэхээд хүн ирсэн юм" гээд хэлсэн. Тэгтэл "чи яасан их хуурдаг юм" гээд нүдсэн. Би нүдүүлээд ухаан алдсан. Нэг сэргэтэл "мотоциклийн араар суу" гээд байхаар нь суусан. У нь Ч гэх эгчийндээ авч очоод "мотоциклоос ойччихлоо" гээд хэвтүүлсэн. Тэр айлд 8 хоног явуулахгүй байж байгаад миний биеийг гайгүй болсны дараа хүргэж өгсөн. Хүргэж өгөхдөө "байрны доороос өвс шидэж байгаад нүд рүү юм орсон" гээд хэлчихээрэй гээд байсан. Мөн 2018 оны 04 сарын 21-ний өдөр У "Б дээр очьё" гээд намайг дагуулаад явсан, "Алтан шар зам" гэх баарны хажууд очтол Б ирж явахаар нь дуудаад бид 3 хамт бааранд орсон. Бааранд ороод 1 шил 0,500-ийн архи, 3 лаазтай "Hite" пиво авч сууж байхад анх ширээн дээр байсан пивонуудыг хамаад уучихсан. Дахиж нэг пиво захиалаад аягалтал хөөсрөөд байхаар нь үлээж газар асгасан. Түүнийг харсан үйлчлэгч нь "яагаад асгаж байгаа юм, аятайхан уучих л даа" гэтэл "танай бааараар үйлчлүүлэхгүй" гэж хэрэлдээд гарч ирсэн. У бид хоёр гэр лүүгээ явж байхад "чи дуугарахгүй намайг гутамшиг болголоо" гээд намайг нүдэж чулуугаар цохиод нүд хөхрүүлж зодсон. Тэгтэл эгч нь гарч ирээд "боль, яаж байгаа юм" гээд байсан. Тэгээд "эндээ хоно" гээд байснаа "урагшаа явна" гээд намайг сундлаад явсан. Тэгснээ чулуугаар толгой руу цохиж толгой хагалсан. Мөн миний хамар луу унагаж байгаад өшиглөсөн. Мөн толгойтой үснээс зуураад, гар өчиж "ална" хэмээн зодсон. Тэгээд манай гэрийн гадаа ирээд над руу том чулуу шидэхээр нь орилтол барьж аваад, ам дараад "дуугүй бай, алаад хаячихна шүү" гээд байсан. Би айгаад дагаад явсан. Тэгээд намайг дагуулаад байшингуудын

орцоор 2-3 хоног хонож явсан. Тэгээд 2018 оны 04 дүгээр сарын 23-наас 24-нд шилжих шөнө морь барианы хойд талд зодон, үсдэж чирч чулуугаар нүдэж, хөл гар луу олон удаа цохисон. Тэгээд намайг дагуулж яваад ээжийндээ очин хэвтэж байтал "босоодох, миний хөл хугарсан юм шиг байна, түшээдэх" гэхээр нь очтол сандал бариад далайхаар нь би очихгүй арагш ухартал хойд аав Г-хээ дээгүүр галын дэгээ төмөр авч толгой руу цохиж толгой хагалсан. Тэгээд хамт гарч алхсаар байгаад "чиний нүүрийг угааж өгье" гээд эмнэлэг дагуулж ирээд эмнэлгийн коридорт унтаад өгөхөөр нь би чимээгүй босож яваад түргэн /103/ дээр ирээд "цагдаа дуудаад өгөөч" гэж хэлж цагдаагийн байгууллагад хандсан... хий хардаж зодоод байдаг юм. Толгойг 8 удаа хагалсан, оёостой хацар дээрээс хазаж татсан, хамар сэт өшиглөж хугалсан, гар, хөл, бүх л биеэр хөхөрч хавдсан." гэжээ.

Мөрдөн шалгах ажиллагаанд:

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч Д өгсөн мэдүүлэгтээ: "...Талийгаач З нь миний төрсөн дүү Г-ийн төрсөн ганц охин, би талийгаач З-ийн авга ах нь байгаа юм. Түүний ээж Н нь Өвөрхангай аймагт амьдардаг юм. Мөн Н нь бичиг үсэг мэдэхгүй, ямар нэг зүйлийг ойлгохгүй учраас хүсэлтээр, мөн авга ахынх нь хувьд ч хохирогчоор оролцож байна. Ээж болон бусад дүү нартай нь харилцаа холбоотой байдаг. Талийгаач З-гийн хувьд хамгийн сүүлд 2017 оны хавар уулзаад түүнээс хойш уулзаагүй байсан. Бага хүүхэд байхаасаа эхлэн төлөв томоотой, хүний үгнээс гардаггүй, дуу шуу цөөтэй, элдэв ааш араншин гэзэг байх зүйлгүй хүүхэд байсан. Талийгаач нь албан ёсоор ээж Н, өөрөөс нь гарсан хүүхдийн хамт Өвөрхангай аймагт амьдарч байсан. Төрсөн хоёр эгч нь тусдаа гарчихсан. Хүүхдийнх нь эцэг гэзэг Өвөрхангай аймгийн Коллежид суралцаж байхдаа танилцсан гэзэг нэг залуу байсан. Тэгээд хүүхдийнх нь эцэг салж яваад, өөр нэг залуутай нийлээд Улаанбаатар хотод ирээд гэрийнхэнтэйгээ холбогдохгүй явж байгаад нас барсан байна... Хэдийгээр осгож нас барсан гэж байгаа боловч биед үүссэн гэмтэл шархнуудыг нь харахад зодож, цохисон У гэзэг байгаа залуугаас болж миний дүү нас барсан. Түүнээс өөрийгөө аваад явах боломжтой байсан байна. Хуулийн дагуу У гэгчид арга хэмжээ авахуулах хүсэлтэй байна. Ер нь бол талийгаач нь Н гэх айлыг цаашид авч явах хүн байсан. Ганц сургууль төгссөн, бичиг боловсролтой хүн нь байсан." гэжээ.

Мөрдөн шалгах ажиллагаанд:

Гэрч Я-гийн мэдүүлэг: "бид нар хамт ажиллаж байгаад ажил тараад 21 цаг болж явж байхад нөхөр У нь урдаас ... ирээд шууд манай нөхрийг алгадаж авсан бөгөөд тухайн үед У нь согтуу байсан. ...бид хоол идчихээд 1 цаг гаран сууж байгаад У нь "бид хоёр Өвөрхангай явлаа" гэж хэлээд эхнэрийгээ дагуулаад гарсан. Тэр хоёр гараад явахаар нь би нөхрийн хамт унтсан бөгөөд үүрээр 05 цагийн үед л байх, нэг хүн хаалга нүдээд эхэлсэн. Тэгэхээр нь манай нөхөр босоод хаалгаа тайлахад У "З ухаан алдаад уначихлаа, та очиж аваад үүрч ирээчээ" гэж хэлсэн бөгөөд У "би өөрөө даахгүй байна" гэж байсан. Тэгээд манай нөхөр У-тай хамт яваад З-г үүрээд авчирсан. Манай гэрт оруулж ирэхэд З нь тэр чигтээ нил ус болж норсон байсан болохоор нь У нь З-гийн хувцасыг тайлаад орон дээр хэвтүүлсэн. Тухайн үед нөхөр нь болох У "зүрх нь цохилж байна" гэзэг байсан, тухайн үед би З-д ойртоогүй, тэгээд байж байгаад У "эмнэлэг дуудна" гэзэг гараад явсан бөгөөд эргэж ирээгүй, өчигдөр орой манайхаас гарахдаа зүгээр байсан бөгөөд харин эргэж шөнө нөхөр нь үүрч ирэхэд ийм байдалтай болсон. Тэгэхээр өчигдөр шөнө манайхаас нөхөртэйгээ хамт гарч яваад л ийм болоод ирсэн... сэргэхгүй, хөдлөхгүй байж байгаад нас барсан. ... орж ирэхдээ куртикгүй, 2 гуталгүй, хөл нүцгэн, бусдаар бол яг өмсөж байсан хувцастайгаа орж ирсэн. Манайд орж ирэхдээ л ухаангүй байсан." гэжээ.

Гэрч Ц-ийн өгсөн: "...7 номерын өрөөнийхөн орж гараад л юм ярьж байхад нэг залуугийн дуу гараад чангараад байсан. Тэгэхээр нь би хаалгаараа харахад туранхай, саарал подволктой, намхан, жижиг халимаг үстэй, эрүүн доороо жижиг сахалтай эрэгтэй гарчихаад буцан орж байсан ба би шөнө 02 цаг хүртэл кино үзэж байхад шөнө 00 цагийн орчим миний харсан залуу байрны үүдэнд дотор зогсчихоод "З пизда минь явья л даа" гэж орилоод байсан." гэжээ.

Гэрч А-н өгсөн: "...эхнэр З-гийн хамтаар У манай гэрт хоол идчихээд 14 цагийн үед буцаагаад эхнэртэйгээ хороолол орно гээд явсан юм. Тэгээд ... 14-нөөс 15-нд шилжих шөнө ганцаараа буцаад манайд 02 цагийн үед согтуу байдалтай ирсэн. Тэгээд юу болсон талаар асуухад "эхнэртэйгээ маргалдаад зодоод Өвөрхангай руу хөөгөөд явуулчихлаа" гэж хэлж байснаа "нэг сэрсэн чинь би гол дээр унтаж байсан. З намайг хаячихаад явчихаж, хаашаа явсан байх уу" гээд 2 өөр юм яриад байсан. Тэгээд У явсны дараа эхнэр бид 2 ажил дээрээ ирэхэд З ажил дээрээ ирчихсэн байсан. З хэлэхдээ "гол дээр архи уугаад нүүр маажаад намайг зодоод байхаар нь би зугатчихсан юм" гэж хэлж байсан. ... Өөдөөс ирэнгүүтээ ямар нэг юм хэлэлгүй намайг гараараа нэг удаа шанаадсан. Тэгэхээр нь "яаж байгаа юм бэ" гэсэн чинь "бүгдийг чинь ална шүү" гээд дайраад байсан. ...араас 20 минутын дараа манай эхнэр, З, У хоёрыг дагуулаад эвлэрсэн бололтой орж ирсэн. Тэгээд хоол идчихээд З, У хоёр "хороолол явлаа" гэж 23 цаг өнгөрөөд 00 цаг болох гэж байхад гараад явсан. 2018 оны 08 дугаар сарын 15-наас 16-нд шилжих шөнө 04-05 цагийн үед манай хаалгыг хүн цохихоор нь онгойлгосон чинь У ганцаараа согтуу байсан. Тэгээд юу болсон талаар асуухад "танайхаас гараад архи аваад З-тай гол дээр архи уулаа" гэхээр нь "З архи дарс уудаггүй шүү дээ" гэсэн чинь "би архи хүчээр өгчихсөн юмаа, тэгээд их уухгүй, хурдан тасарчихлаа, тэгээд би наашаа авч ирэх гэж гол гарч байгаад бид хоёр гол дотор уначихлаа, би ганцаараа авч ирж дийлэхгүй байна, та хамт явж аваад ирээч" гэж хэлэхээр нь би хувцасаа өмсөөд цуг гараад гол орсон. Намайг гол дээр очиход дөнгөж гэгээ ороод үүр цайж байсан. Тэгээд гол дээр очиход З хажуу тийшээ харсан байдалтай, хувцас нь нойтон 2 гар нь хайрга чулуу, шавар болсон байдалтай байсан. Тэгээд би З-г сэрээх гэсэн чинь тасарчихсан хүн шиг сэрэхгүй байхаар нь өргөөд У-т үүрүүлсэн. Тэгээд хэсэг явж байгаад явган хүний зам дээр гарч ирээд би хэсэг үүрч явсан ба намайг үүрч явахад амьсгалж байсан юм. Тэгээд манай гэрт ороод "осгосон байж магадгүй" гээд У "хөнжил нөмрүүлье" гэхээр нь хөнжил гаргаж өгсөн чинь хөнжлөө нөмрөөд хамт унтсан. Тэгээд өглөө 08 цагийн үед У-г сэрээсэн ба З-г сэрээх гэсэн чинь сэрэхгүй байсан... тээр хойно нь манай жижүүр "нас барсан байна" гэж хэлсэн." гэжээ.

Мөрдөн шалгах ажиллагаанд Н-гийн гэрчээр өгсөн: "... 2017 оны 09 сард манай дүүгийн хурим болоод, би хөдөө яваад найранд яваад гэртээ иртэл манайд нэг танихгүй залуу У нь ирсэн байсан. Би тэр үед "чи юун хүн бэ, айл андуурсан юм уу яв" гэхэд "би хүнтэй уулзах гэж ирсэн юм" гэхээр нь "би чамайг танихгүй" гэхэд яваад өгсөн юм. Тэгтэл маргааш нь дахин ирээд би танай охин З-ийн найз банди нь байна гэсэн юм. Тэгээд би У гэдэг залуугийн зүс царайг харсан юм. ...Тэгээд нэг өдөр охин З, У хоёр "бид зах яваад ирье" гэхээр нь "яах гэж байгаа юм" гэхэд "машины бичиг баримт авах гэж байгаа юм" гэж хэлээд гарч яваад 8 хоног гэртээ ирээгүй. Ингээд би араас нь эрэл сураг болоод олдохгүй байтал шөнө утас дуугараад утсаа автал "танай хүүхэд эмнэлэгт түргэн дээр ирсэн байна, ээж нь мөн үү хүрээд ир" гэхээр нь би Өвөрхангай аймгийн эмнэлгийн түргэн тусламж дээр очсон. Тэр үед толгойдоо оёдол тавиулаад байж байсан. У-г толгойг нь хагалсан гэж уйлаад байж байсан. Яагаад хагалсан юм гэхэд хүүхдийнхээ мөнгийг ав гэж авахуулаад, тэгээд архи авч уугаад зодсон байсан. Нийт З удаа зодуулсан гэдгээ эмнэлэг дээр хэлсэн. Тэгээд манай охин эмнэлэгт хэвтэж байтал У нь эмнэлгээс оргуулаад авч явсан байсан. Тэрнээс хойш холбоо бариагүй байсан. Би 2018 оны 04 сараас хойш холбогдох гэвч чадахгүй байсан. Би нилээн хайж сураг гаргаж байсан. У-н ээжээс нь хүртэл асуухад "сураггүй байна" гэж байсан." гэжээ.

Шүүхийн Шинжилгээний Үндэсний Хүрээлэнгийн шинжээчийн 1828 дугаар:

"1. Талийгаач 3-гийн цогцост үхэлд нөлөөлөөгүй ходоодны амсар, кардын урагдсан шарх, булчин болон гялтан хальсан доорх давхаргын цус хуралт, бага сэмжний голомтлог цус хуралт, зулайн хуйхны дотор гадаргуу, зүүн чамархай, зулай, дагзны хуйхны дотор гадаргуун цус хуралт, зүүн 9-р хавирга бороо үүсгэсэн хуучин хугарал, зүүн 10, баруун 9-р хавирга шууд бус хугарал, орчны эдийн цус хуралт, уруулын дотор салстын цус хуралт, баруун зулай, чамархайн хуйхны язарсан шарх, дух, цох, хамрын нуруу, үзүүр, зүүн хацар, дээд уруул, хүзүү, зүүн чих, баруун, зүүн ташаа, баруун, зүүн өвдөгний зулгаралт, баруун бугалга, шуу, баруун тохой, хэвлий, зүүн өвдөг, шилбэний цус хуралт гэмтэл тогтоогдлоо. 2. Дээрх ходоодны амсар, кардын урагдсан шарх, булчин болон гялтан хальсан доорх давхаргын цус хуралт, бага сэмжний голомтлог цус хуралт гэмтэл нь хүчтэй огилт, агшилтын улмаас үүснэ. Бусад зулайн хуйхны дотор гадаргуу, зүүн чамархай, зулай, дагзны хуйхны дотор гадаргуун цус хуралт, зүүн 9-р хавирга бороо үүсгэсэн хуучин хугарал, зүүн 10, баруун 9-р хавирга шууд бус хугарал, орчны эдийн цус хуралт, уруулын дотор салстын цус хуралт, баруун зулай, чамархайн хуйханы язарсан шарх, дух, цох, хамрын нуруу, үзүүр, зүүн хацар, дээд уруул, хүзүү, зүүн чих, баруун, зүүн ташаа, баруун, зүүн өвдөгний зулгаралт, баруун бугалга, шуу, баруун тохой, хэвлий, зүүн өвдөг, шилбэний цус хуралт гэмтэл нь мохоо зүйлийн олон удаагийн үйлчлэлээр үүсгэгдэнэ. 3. Талийгаачийн ходоодны шингэнд хорт бодис болон эмийн бодис илрээгүй байна. Цусанд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох боломжгүй байна. 4. Талийгаач нь АВО системээр В(Ш) бүлгийн цустай байна. 5. Талийгаач нь 2018.08.16-ны өдрийн 14:10 минутын цогцосны гадна үзлэгээр нас бараад 6-8 цаг болсон байжээ. 6. Талийгаач нь нам хэмийн ерөнхий үйлчлэлийн улмаас осгож нас баржээ. 7. Талийгаачийн охин хальс хуучин урагдалтай байна. Хэзээ хамгийн сүүлд бэлгийн харьцаанд орсныг тогтоох боломжгүй." гэх дүгнэлт.

Шүүхийн Шинжилгээний Үндэсний Хүрээлэнгийн шинжээчийн 2018 оны .. дугаар сарын ..-ний өдрийн 1072 дугаар, хэргийн задгай материалаар хийсэн нэмэлт шинжилгээний: "... Талийгаач 3-ийн зулайн хуйхны дотор гадаргуу, зүүн чамархай, зулай, дагзны хуйхны дотор гадаргуун цус хуралт, зүүн 9 дүгээр хавирга бороо үүсгэсэн хуучин хугарал, зүүн 10, баруун 9 дүгээр хавирга шууд бус хугарал, орчны эдийн цус хуралт, уруулын дотор салстын цус хуралт, баруун зулай, чамархай хуйхны язарсан шарх, дух, цох, хамрын нуруу, үзүүр, зүүн хацар, дээд уруул, хүзүү, зүүн чих, баруун, зүүн ташаа, баруун, зүүн өвдөгний зулгаралт, баруун бугалга, шуу, баруун тохой, хэвлий, зүүн өвдөг, шилбэний цус хуралт гэмтэл нь мохоо зүйлийн олон удаагийн үйлчлэлээр үүсгэгдэнэ. Дээрх гэмтэлүүд нь бүгд талийгаачийг амьд ахуйд нь буюу нас барахаас өмнө үүссэн гэмтэл байна. Зүүн 10, баруун 9 дүгээр хавирганы хугарал гэмтэл нь дангаараа гэмтлийн зэрэг тогтоох журмын 2.3.1-д зааснаар гэмтлийн хүндэвтэр, уруулын дотор салстын цус хуралт, баруун зулай,чамархай хуйхны язарсан шарх, дух, цох, хамрын нуруу, үзүүр, зүүн хацар, дээд уруул, хүзүү, зүүн чих, баруун, зүүн ташаа, баруун, зүүн өвдөгний зулгаралт, баруун бугалга, шуу, баруун тохой, хэвлий, зүүн өвдөг, шилбэний цус хуралт гэмтэл нь гэмтлийн зэрэг тогтоох журмын 2.4.1-т зааснаар хөнгөн зэрэг, дээрх гэмтлүүд бүгд нийлээд гэмтлийн зэрэг тогтоох журмын 2.3.1-т зааснаар гэмтлийн хүндэвтэр зэрэгт хамаарна." гэх дүгнэлт.

Өвөрхангай аймгийн Шүүхийн шинжилгээний албаны шинжээчийн 2018 оны .. дүгээр сарын ..-ны өдрийн 286 дугаар:

"1. 3-ийн биед тархи доргилт, толгойн баруун ар дээд хэсэг, хамрын нуруу, зүүн хацрын төвгөр хэсэгт шарх, баруун гарын сарвуу хэсэгт зулгаралт гэмтэл тогтоогдлоо.

2. Дээрх гэмтэл нь мохоо хүчин зүйлийн олон удаагийн үйлчлэлээр үүсгэгдэх боломжтой. 3. Дээрх гэмтлүүд нь тогтоолд дурдсан 2018 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр, 2018 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр үүссэн болохыг нарийвчлан тогтоох боломжгүй. Тогтоолд дурдсан 2018 оны 02 дугаар сард зодуулсан гэх шарх, сорви гэмтэл тогтоогдсонгүй. 4. Дээрх гэмтэл нь эрүүл мэндийг түр хугацаагаар сарниулах тул Шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох журмын 2.4.1-д зааснаар гэмтлийн хөнгөн зэрэгт хамаарна" гэх. дүгнэлт.

Ажлын хуудас:

Дараах хүснэгтийг нөхөх замаар кейсийг шинжилнэ үү. ГБХ үйлдэгч Эрүүгийн хуульд заасан ямар гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг тогтоож, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх ямар нөхцөл байдал байгаа болон хуульд заасан ямар ял шийтгэл оногдуулах вэ?

Б-гийн гэм буруутай үйлдэл ЭХТА-д заасан ямар гэмт хэргийн шинжийг агуулсан	ЭХ-д заасан ямар ял оногдуулах боломжтой	Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал	Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах үндэслэл байгаа эсэх?

Мэдээлэл өгөх:

- "ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх онцлог" сэдвийн танилцуулга
- ГБХ үйлдэх гэмт хэргийг шийдвэрлэсэн статистик тоон мэдээлэл;
- ГБХ-ийн кейс (тодорхой тохиолдол);
- Шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсгийг боловсруулах ажлын хуудас;

ГБХ үйлдэх гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч субъектив хүчин зүйлсээс сэргийлэх талаар мэдээлэл өгнө.

- Субъектив хүчин зүйлс гэж юу вэ?
- Шүүгч шийдвэр гаргахад субъектив хүчин зүйлс нөлөөлөх үү?
- Субъектив хүчин зүйлсийн эх сурвалж, эрсдэлт хүчин зүйлс

Үнэлгээ:

Багш сэдвийг бататгах дараах асуултуудыг оролцогчдоос асууна.

Хяналтын асуулт:

- Эрүүгийн хуульд ГБХ үйлдэх гэмт хэргийг шинээр томъёолсны ач холбогдлыг тодорхойлно уу?
- "Ойр дотны хүн" болон "Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн" гэсэн нэр томъёо ялгаатай юу? Жишээгээр тайлбарлана уу?
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил нь гэмт хэргээс хэрхэн ялгагдах вэ?
- ГБХ үйлдэх гэмт хэргийг шийдвэрлэхэд шүүгч төвийг сахих зарчмыг алдагдуулах ямар хүчин зүйлс байж болох вэ?

Дүгнэлт:

Багаар сууж буй ширээ бүрээс хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан , (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч багшид өгөх зөвлөмж:

Дасгал ажиллуулах тохиолдол шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх тогтоол, магадлал, тогтоолтой урьдчилан танилцах. Оролцогч нарт Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль бэлдэх.

Сэдэв 2. Шүүгчээс ГБХ үйлдэгч, гэрч, хохирогчтой харилцах арга барил

Сэдвийн товч агуулга:

Шүүгчээс хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчтэй харилцах арга барил, анхаарах асуудлын талаар судлахад энэ сэдвийн зорилго оршино.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ үйлдэгч, гэрч, хохирогчийн онцлог, нийтлэг шинжийг тодорхойлох
- ГБХ үйлдэгч, гэрч, хохирогчтой харилцах арга барил, тактикийг нөхцөл байдалд тохируулан хэрэглэх чадварт суралцах

Мэдээлэл өгөх:

- "Шүүгчээс ГБХ үйлдэгч, гэрч, хохирогчтой харилцах арга барил" сэдвийн танилцуулга;
- ГБХ-ийн кейс (тодорхой тохиолдол);
- Дасгал ажиллах ажлын хуудас;

Дасгал ажлын зааварчилгаа. Цаасан дээр шүүгчээс хүчирхийлэл үйлдэгч, хохирогчоос асуух болон асууж болохгүй асуултуудыг тодорхойлно уу.

Энэ дасгал нь шүүгч ГБХ үйлдэгч болон хохирогчтой харилцах үгэн харилцаандаа анхаарахад дэмжлэг болно.

Үнэлгээ:

Багш сэдвийг бататгах дараах асуултуудыг оролцогчдоос асууна.

Хяналтын асуулт:

- Шүүгчээс ГБХ үйлдэгч болон хохирогчтой харилцах онцлогийг тодорхойлно уу?
- ГБХ үйлдэх гэмт хэргийн гэрч, хохирогч, хүчирхийлэл үйлдэгчээс асуух асуулт ямар шаардлага хангасан байх вэ?
- Хохирогчоос "Таны ямар үйлдлээс болж хүчирхийлэл гарах болсон бэ" гэж асууж болох уу?

Дүгнэлт:

Хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч багшид өгөх зөвлөмж:

Сэдэвтэй холбоотой хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх талаар судалж, хичээлийн явцад тохиромжтой үед нь сануулах.

Сэдэв 3. ГБХ үйлдэх зөрчил гаргагчид шийтгэл оногдуулах, гэмт хэрэг үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах, ял оногдуулах ажиллагааны онцлог

Сэдвийн товч агуулга:

ГБХ үйлдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээ болон бусад албадлагын арга хэмжээг авахад харгалзан үзэх хүчин зүйлсийг тооцох, ГБХ үйлдэх зөрчил гаргагчид шийтгэл ногдуулах, гэмт хэрэг үйлдэгчид ял шийтгэл оногдуулахад анхаарах хүчин зүйлсийг судална. Түүнчлэн, эдгээр ажиллагаанд шүүгчийн харилцааны элементийг анхаарч үзнэ.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно:

- ГБХ үйлдэх зөрчил гаргагчид шийтгэл ногдуулахдаа хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд харгалзан үзэх хандлагыг нэмэгдүүлэх
- ГБХ үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээг оновчтой, түргэн шуурхай авах чадварыг дээшлүүлэх
- ГБХ үйлдэгчид ял шийтгэлийг оновчтой оногдуулах, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах эрсдэлтэй үед хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид оногдуулах ял шийтгэлийг тэнсэх, хойшлуулахаас татгалзах чадвар, хандлага төлөвшүүлэх

Дасгал ажлын зааварчилгаа: Өмнөх хичээл дээрх багийг дахин шинээр зохион байгуулна.

а) Оролцогчдын тоог харгалзан 5 багт хуваан, багаар ажиллах зааварчилгаа өгнө. Хэлэлцүүлгийг үр дүнтэй болгохын тулд багийн ахлагчийг томилно.

б) Багуудад ажлын хуудас болон цаас, маркер тараана. Тохиолдол (кейс) дэлгэцэнд танилцуулна. Багаараа ярилцаж, дүгнэлтээ багийн ахлагч төлөөлөн танилцуулна.

Мэдээлэл өгөх:

- ГБХ үйлдэх зөрчил гаргагчид шийтгэл оногдуулах, гэмт хэрэг үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх ажиллагааны онцлог" сэдвийн танилцуулга
- Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг боловсруулах ажлын хуудас;
- ГБХ-ийн кейс

Үнэлгээ:

Багш сэдвийг бататгах дараах асуултуудыг оролцогчдоос асууна.

Хяналтын асуулт:

- ГБХ үйлдэх зөрчил гаргагчид оногдуулсан албадан сургалтад хамруулах шийтгэлийг хэн хэрэгжүүлэх вэ? Шийтгэвэрт хэрхэн тусгах вэ?
- ГБХ үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авахад нөлөөлөх хүчин зүйлс юу вэ?
- ГБХ үйлдэгчид ял шийтгэлийг оновчтой оногдуулах нь хохирогчийн аюулгүй байдлыг хангахад ямар ач холбогдолтой вэ?

Дүгнэлт:

Багаар сууж буй ширээ бүрээс хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан) мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч багшид өгөх зөвлөмж:

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт, түүний үр дүнгийн тараар мэдээлэлтэй байж, ТСАХ авагдсан сүүлийн үеийн тоо статистикийг авсан байх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны анхаарах асуудал

Сэдэв 1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт

Сэдвийн товч агуулга:

"Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт" сэдвийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн онцлог, тэдэнд сургалт ороход юуг анхаарах, ямар сургалт илүү үр дүнгээ өгөх болон сургалтыг зохион байгуулах мэргэжилтнүүд цаашид яаж ажиллах талаар мэдээлэл өгөх зорилготой болно.

Сэдвийн гол зорилтууд:

Энэ сэдвийн дараа та дараах ур чадварыг эзэмших болно.

- ГБХ үйлдэгчийг зан үйлийн сургалтанд хамруулах нь хүчирхийлэл дахин үйлдэгдэхээс сэргийлэх, хохирогч хамгааллын асуудал давхар яригддаг талаар мэдээлэлтэй байх
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн онцлогийг харгалзан, харилцах ур чадвараа хөгжүүлнэ.
- Тэдэнд сургалт ороход юуг анхаарах тухай ойлголтыг авна

Тоглоом тоглох. "Тархи зүрх сэр сэр"

Зааварчилгаа: Энэ тоглоомыг тоглосноор сургалтад оролцогчдыг идэвхжүүлэх, сургалтыг сонирхолтой болгох зорилготой.

Тархи тархи сэр сэр гэж тархиндаа зөөлөн хэлэх /гараараа зөөлөн хүрнэ/, зүрх зүрх сэр сэр гэж зүрхэндээ хэлэх /зүрхэндээ гараараа зөөлөн хүрэх/. Энэ үйлдлийг өөрөө дагуулж удаанаас хурдан хийлгэх. Энэ үед багшийн удирдлагад бүгд орж анхаарал төвлөрөн суралцагчид идэвхждэг.

Идэвхжүүлэх ажил: "Өөрийгөө танихуй"

Зааварчилгаа: Доорх зохиомжийг оролцогчдод хэлээд өөрөөсөө гадна 5 хүнийг аврах даалгавар өгнө. Даалгаварын өмнө /Тараах материал 1-ыг тарааж өгсөн байна./ Тоглоомын дараа ямар хүмүүсийг их аварсан, ямар хүмүүсийг бага аварсныг тоолоход нийгэмд хүчирхийлэгч нарт дургүй байдгийг ойлгуулдаг идэвхжүүлэх болон, өөрсдийгөө ойлгодог тоглоом. Суралцсан сургагч багш нар цаашид гэр бүлийн хүчирхийлэгч нараар тоглуулж болох ач холбогдолтой.

Зохиомж

- Та усан онгоцоор аялах аялал хожжээ. Далайд аялж байхад чинь гэнэт шуурга болж, усан онгоцны багийн 3 гишүүн амь үрэгдэв
- Удалгүй, усан онгоц усаар дүүрч живж эхлэв. Танд онгоцыг орхихоос өөр арга байхгүй. Амь аврах 1 завийг зөвхөн таниас өөр хүн ажиллуулж мэдэхгүй.
- Энэ завь нь таньтай нийлээд 6 хүн тээвэрлэхээр тоноглогдсон. Ийм хүнд нөхцөлд, үлдсэн 5 хүн аврагдах боломжгүй.

Тараах материал 1:

Бусад зорчигчидын жагсаалт

1. Тэтгэвэрт гарсан, 68 настай, одоогийн амьдралдаа сэтгэл хангалуун
2. 20 настай, ажилсаг Үйлдвэрийн машинист,
3. 50 настай, 4 хүүхдийн эх, сэлж чаддаггүй
4. Эхнэрээ зоддог, 40 гаран насны, орилж хашгичсан, бүдүүлэг
5. Нөхөртөө зодуулсан эхнэр, 30 гаран насны, эелдэг, айсан
6. Агаарын хүчний нисгэгч, 30 настай, саяхан гэрлэсэн
7. Тэргэнцэр дээр суудаг, 12 настай хүү

8. 3 настай охин, сэлж чадахгүй
9. Урьд хар тамхичин байсан, 2 хүүхэдтэй, гэр бүлээсээ салсан
10. 20 хүрч байгаа, эмэгтэй, их сургуульд сурдаг

Мэдээлэл өгөх:

Дэд сэдвүүд:

- ГБХ үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтийн 2019 оны мониторингийн тайлангаас
- ГБХ үйлдэгчийн онцлог шинж
- ГБХ үйлдэгчид сэдэлжүүлэх ярилцлага хийх,
- ГБХ үйлдэгчид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх- богино хэмжээний терапи
- Цаашид анхаарах асуудал

Үнэлгээ:

Багш сэдвийг бататгах дараах асуултуудыг оролцогчдоос асууна.

Хяналтын асуулт:

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн сэтгэл зүйн онцлогийн талаар тодорхойлно уу.
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын ач холбогдлыг нэрлэнэ үү.

Түүнчлэн ГБХ-ийн зөрчлийн улмаас 7 хоногийн хугацаатай ирсэн хүчирхийлэл үйлдэгчид сэдэлжүүлэх ярилцлага хийх нь илүү оновчтой бол 30 хоногоор ирсэн хүмүүст сэтгэл зүйн бусад төрлийн үйлчилгээнүүдийг тусгах нь үр дүнтэй байдаг талаар дурдана.

Дүгнэлт:

Оролцогчдоос хичээлийн үеэр яригдсан агуулгаас шинэ мэдлэг олж авсан (мэдлэгээ бататгасан), мэдлэгээ гүнзгийрүүлсэн гэсэн хэлбэрээр асууж, хичээлээ дүгнэнэ.

Хичээлийн өмнө тавьсан зорилгыг сануулна. Дурьдагдсан агуулга болон, хичээлийн турш хийсэн зүйлсийг тоочно.

Сургагч-багшид өгөх санамж:

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журмын талаар судалсан байх.

ГУРАВ СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Үнэлгээний зорилт

Үнэлгээний зорилт нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилт, биелэлт, үр дүнтэй шууд хамааралтай байна. Үнэлгээний зорилтын талаар сургагч багш болон оролцогчид нэгдсэн ойлголттой байх нь үнэлгээг хэрэгжүүлэх, шалгуурыг үнэн зөв тогтоох, үнэлгээ шударга, бодитой, үр дүнтэй байхад нөлөөлнө. Үнэлгээгээр оролцогчдын:

1. Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдлэг, ойлголтын гүнзгийрэлт;
2. Гэр бүлийн хүчирхийлэлд хандах байдлын өөрчлөлт;
3. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх мэргэжлийн ур чадварын хөгжил зэргийг үнэлэх бөгөөд энэ нь үнэлгээний зорилт болно.

Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур	Үнэлгээний жишиг хэрэглэгдэхүүн
1. Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдлэг, ойлголтын гүнзгийрэлт;	1. ГБХ-ийг жендэрт суурилсан үзэл санааны үүднээс тайлбарлаж буй байдал	Мэдлэг шалгах сорил (энэхүү хөтөлбөрийн талын сорилыг ашиглах боломжтой)
	2. ГБХ-ийг бусад төрлийн хүчирхийллээс ялгах чадвар	
2. Гэр бүлийн хүчирхийлэлд хандах байдлын өөрчлөлт;	1. ГБХ-ийн бодит байдал, хэвшмэл ойлголт төсөөллийг ялган, үндэслэж буй байдал	Өөрийгөө үнэлэх сорил (энэхүү хөтөлбөрийн сорилыг ашиглах боломжтой)
	2. Хүчирхийллийн асуудалд мэдрэмжтэй хандах, асуудалд хандах өөрийн хандлагад дүгнэлт өгч буй байдал	
3. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх мэргэжлийн ур чадварын хөгжил;	1. ГБХ-ийн зөрчил, гэмт хэргийн ялгааг тодорхойлох байдал	Кейс шинжлэх, дүгнэлт бичих
	2. ГБХ-ийн зөрчил, гэмт хэргийн нотлох баримтыг үнэлэх шалгуурыг боловсруулах түвшин	
	3. Хүчирхийлэлд өртөгчид үр дүнтэй туслалцаа үзүүлэх байдал	
	4. ГБХ-ийн хэрэг хянан шийдвэрлэх үйл явцад хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх байдал	

Үнэлэх арга, хэлбэр

а) Явцын үнэлгээ нь сургалтын үед оролцогчдын гүйцэтгэл, ахиц амжилтын талаар мэдээлэл цуглуулах үйл явц юм. Энэ үнэлгээ хийхэд дараах зүйлийг анхаарна. Үүнд:
   - Сургалтын туршид оролцогчийг өөрөө сургалтын идэвхтэй оролцогч байж, өөрийгөө илэрхийлэх, хийсэн ажлаа танилцуулах, бусдаас болон багшаас зөвлөгөө, дэмжлэг авах боломжоор хангах;
   - Оролцогч бүрт хийсэн ажлаа хэлэлцүүлэх, хийж дуусгахын тулд бусдаас санал зөвлөмж цуглуулах цаг, боломжийг гаргаж өгөх;
   - Оролцогчдод өөрийн үнэлгээ хийх боломж олгох, энэ үйл явцыг зохион байгуулах;
   - Явцад өгөх үнэлгээ нь эцсийн үр дүнд чиглэх
   - Явцын үнэлгээнд ирцийн хувийг оруулах боломжтой.

б) Эцсийн буюу үр дүнгийн үнэлгээ нь тодорхой хугацааны дараа хүрсэн үр дүнг илэрхийлнэ. Эцсийн үнэлгээ хийхэд дараах зүйлийг анхаарна. Үүнд:
   - Эцсийн үнэлгээ нь явцын үнэлгээний үр дүн байх, явцын үнэлгээг тооцох
   - Зохистой арга, хэлбэрийг ашиглах, уламжлалт сорил, тохиолдлыг шинжилж дүгнэлт бичих гэх мэт.

Сургалтын үнэлгээний бас нэг чухал зорилго бол сургалтын зохион байгуулалт, явц, сургагч багшийн ур чадвар зэргийг үнэлэх явдал байдаг. Энэ нь тухайн сургалтыг зохион байгуулж буй мэргэжлийн байгууллага болон мэргэжилтэн-сургагч багш нарын зүгээс үр дүнд чиглэсэн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрөө сайжруулах, чанартай сургалт зохион байгуулахад тусладаг.

Энэхүү сургалтын хөтөлбөрийн хөтөлбөрт оролцогчдын хандлага болон ГБХ-ийн талаарх ойлголттой холбоотой үнэлгээний жишиг хэрэглэгдэхүүнийг оруулсан бөгөөд сайжруулан хэрэгжүүлэх боломжтой юм.

Сургалтын гол хэрэглэгдэхүүн нь уг сургалтын хөтөлбөрийн дагуу боловсруулагдсан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй хохирогч төвтэй хандлагаар тэмцэх шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтны гарын авлага" байна.

Сургалтын үнэлгээнд дараах жишиг сорил, асуулгыг боловсронгуй болгон ашиглах боломжтой.

Нэг. Сургалтын өмнө ба сүүлд авч болох сорил

1. Жендэр гэж эрэгтэй, эмэгтэй хүний биологийн ялгаатай байдлыг хэлнэ.
   a) Тийм
   b) Үгүй
2. Эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгааныг нэрлэнэ үү.
   a) Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх мэдлийн тэнцвэргүй байдал
   b) Архидалт
   c) Ажилгүйдэл
   d) Боловсролын түвшин
3. ГБХ-ийн хэрэг, зөрчлийг бусад хэрэг зөрчлөөс ялгах гол онцлог шинж аль нь вэ?
   a) Далд хэлбэрээр үйлдэгддэг, давтагдах магадлал өндөр
   b) Улам даамжирч үргэлжилнэ
   c) Аль нь ч биш
   d) Аль аль нь
4. Хохирогч төвтэй хандлага гэж таны бодлоор юуг хэлэх вэ?
   a) Хохирогчийн туулсан туршлага, үзэл бодлыг харгалзан хүчирхийлэгчид хариуцлага хүлээлгэхийг хэлнэ.
   b) Хүчирхийлэл үйлдэгчийн үйлдэл, зан үйл, зорилгод анхаарлаа хандуулж, хохирогчийн аюулгүй байдлыг хангахыг хэлнэ.
   c) Хохирогчдын хүсэл, аюулгүй байдал, эрүүл мэнд зэргийг нэн тэргүүнд тавьж үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.
5. ГБХ-ийн хохирогчид аюулын зэргийн үнэлгээг ямар зорилгоор хийдэг вэ?
   a) Хохирогчийн гомдлыг барагдуулах
   b) Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлийг тооцох
   c) Шүүхэд нотлох баримт бүрдүүлэх зорилгоор
   d) Бүгд
6. Яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрөө хүсвэл өмгөөлөгчгүйгээр хэрэг хянан шийтгэх ажиллагаанд оролцуулж болох уу?
   a) Болно.
   b) Болохгүй.
   c) Өмгөөлөгч оролцуулах эсэхийг прокурор шийднэ.
   d) Хуульд зааснаас бусад тохиолдолд оролцогч өөрөө хүсэлт гаргасан бол өмгөөлөгчгүйгээр оролцуулж болно.

7. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдан ирсэн сэжигтнийг шүүхийн зөвшөөрлөөр баривчилж болох уу?
   a) Болно
   b) Болохгүй
   c) Болохгүй, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно
   d) Хуульд заасан онцгой тохиолдолд болно
8. ГБХ үйлдэгчид ял оногдуулахад харгалзан үзэх хүчин зүйлс аль нь вэ?
   a) Гэр бүлийн харилцааг цааш хэвийн үргэлжлүүлэхэд ял шийтгэл эерэгээр нөлөөлөх эсэх
   b) Зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн эсэх
   c) Хүчирхийлэл үйлдэгчийн түүх
   d) ГБХ үйлдэгчийн бие дэх гэмтэл
   e) ГБХ үйлдэгчийн нийгэм эдийн засгийн статус
   f) Бүгд
9. ГБХ-ийн үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт бол
   a) ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн мэдлэг олгох сургалт
   b) Хүчирхийлэгч зан үйлдээ хяналт тавьж, эерэг үзэл бодол хэвшүүлэхэд нөлөөлөх дасгал
   c) Хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах, эрсдэлийг бууруулах дасгал
   d) ГБХ-ийн эсрэг сайтар бэлтгэсэн презентаци, бодит жишээн дээр тулгуурласан сургалт

Хариулт: 1b; 2a; 3 d; 4c; 5b; 6d; 7c; 8b, c; 9 b, c

Хоёр. Оролцогчдын хандлагыг тандахад ашиглаж болох сорил

Бодомжийг уншаад ямар нэг байдлаар хүлээн зөвшөөрч байгаа бол "тийм", огт хүлээн зөвшөөрөхгүй бол "үгүй", эргэлзэж байвал "мэдэхгүй" хариултыг сонгоно уу.

№	Бодомж	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1.	ГБХ-д эмэгтэйчүүд ямар нэг хэлбэрээр буруутай байх нь бий. "Овоо босгоогүй бол шаазгай суухгүй"			
2.	Хүчирхийлэл архинаас л болж үйлдэгддэг			
3.	ГБХ нь хайр халамж дутсанаас гол төлөв үйлдэгддэг			
4.	Зөөлөн алгадах, цохих, хазах, айлгах, сүрдүүлэх зэрэг үйлдэл нь төдийлөн ноцтой биш.			
5.	Гэр бүлийн дотор жижиг хэмжээний маргалдах явдал байдаг учир тэр бүр анхаарах хэрэггүй.			
6.	ГБХ зөвхөн ядуу тарчиг амьдралтай айл өрхөд үйлдэгддэг			
7.	ГБХ бол гэр бүлийн дотоод асуудал			
8.	ГБХ-тэй ч гэсэн гэр бүл бүрэн бүтэн байх нь чухал			
9.	Эрэгтэй хүн тухайн агшинд уур уцаараа барьж дийлээгүйн улмаас л хүчирхийлэл үйлддэг			

Гурав. Сургалтын үнэлгээний хуудас

СЭДЭВ ДҮГНЭХ АСУУЛГА.

Сэдвийн нэр:
Багш /нар/-ын нэр:

Доорх асуултуудын дагуу харгалзах нүдийг ☒ тэмдэглэгээгээр бөглөж сургалтанд үнэлгээ өгнө үү. Үнэлгээг 1-5 хүртэл эрэмбэлсэн бөгөөд, асуулт бүрт зөвхөн нэг хариултыг сонгоно.

1. Та сургагч багшид дараах шалгуурын дагуу үнэлгээ өгнө үү.		Хамгийн Бага			Хамгийн Их	
		1	2	3	4	5
(a)	Сэдвийг бэлдсэн байдал	☐	☐	☐	☐	☐
(b)	Тухайн сэдвийн агуулгыг эзэмшсэн байдал	☐	☐	☐	☐	☐
(c)	Сэдэвтэй холбоотой асуудлуудыг оновчтой хүргэж байгаа чадвар	☐	☐	☐	☐	☐
(d)	Харилцан ярилцах аргаар сургалтыг явуулсан эсэх (сургалтанд оролцогчдын саналыг сонсох, асуултанд хариулах цаг гаргах гэх мэт)	☐	☐	☐	☐	☐
(e)	Практикт тулгуурласан аргачлал ашигласан эсэх (бодит жишээ, эрх зүйн тохиолдол шийдвэрлүүлэх гэх мэт)	☐	☐	☐	☐	☐

	Хэт бага		Яг Таарсан	Хэт их	
	☹	😐	☺	😐	☹
2. Сэдвийг заахад зарцуулсан хугацаа	☐	☐	☐	☐	☐
	Хэт энгийн		Яг Таарсан	Дэндүү Төвөгтэй	
	☹	😐	☺	😐	☹
3. Сэдвийн агуулгыг олон талаас нь авч үзсэн эсэх	☐	☐	☐	☐	☐

4. Сэдэвтэй холбоотой нэмэлт санал, хүсэлтээ бичнэ үү?

_____

_____

_____

СУРГАЛТ ДҮГНЭХ АСУУЛГА

Сургалтын нэр:
Сургалтын байр: _____ Сургалтын огноо:_____
Сургалтын менежер:

Доорх асуултуудын аль нэг харгалзах нүдэнд S ийм тэмдэглэгээ хийж, сургалтанд үнэлгээ өгнө үү. Үнэлгээг 1-5 оноогоор эрэмбэлсэн бөгөөд асуулт бүрт зөвхөн нэг хариултыг сонгоно.

I хэсэг: Сургалтын үр дүнгийн сэтгэл ханамж

		Бага			Их	
		1	2	3	4	5
1	Сургалт зорилтондоо хүрсэн гэж Та үзэж байна уу?	☐	☐	☐	☐	☐
2	Таны одоогийн ажил үүрэгт сургалтын сэдвүүд нийцэж чадсан уу?	☐	☐	☐	☐	☐
3	Сургалтын агуулга танай байгууллагын хэрэгцээнд нийцсэн үү?	☐	☐	☐	☐	☐
4.	Сургалтаар олж авсан мэдлэгээ практикт ашиглах боломжтой гэж үзэж байна уу?	☐	☐	☐	☐	☐
5.	Сургалтын материал таны хэрэгцээнд нийцэж байна уу?	☐	☐	☐	☐	☐
6.	Сургалтын материалын тоо хэмжээ хангалттай байсан уу?	☐	☐	☐	☐	☐
7.	Сургагч багш суралцахуйн үйл явцыг чиглүүлэх үүргээ хэр зэрэг гүйцэтгэсэн бэ?	☐	☐	☐	☐	☐
8.	Сургалтанд оролцогчдын бүрэлдэхүүн оновчтой байв уу?	☐	☐	☐	☐	☐
9.	Сургалтын үеэр зохион байгуулагчдаас үзүүлсэн туслалцаа хангалттай байв уу?	☐	☐	☐	☐	☐
10.	Сургалт эхлэхээс өмнө танд өгсөн мэдээлэл хангалттай байсан уу?	☐	☐	☐	☐	☐
11.	Сургалтын талаарх мэдээллийг хангалттай хугацааны өмнө авсан уу?	☐	☐	☐	☐	☐

12. Таны ажилд дор жагсаасан сэдвүүд хэр ач холбогдолтой байсан бэ?		Ач холбогдол		
		Өндөр		багатай
		1	3	5
(а)		☐	☐	☐
(б)		☐	☐	☐
(в)		☐	☐	☐

13 Таны бодлоор сургалтын агуулгад нэмж оруулах шаардлагатай сэдэв байна уу? Тийм ☐ Үгүй ☐

Хэрэв тийм бол, санал болгох 3 сэдвийг ач холбогдлоор нь эрэмбэлж бичнэ үү.

1. _____

2. _____

3. _____

14. Сургалтын сэтгэл ханамжийн талаар нэмэлт санал, хүсэлт танд байна уу?

_____

_____

_____

II хэсэг: Олж авсан мэдлэг, ур чадварын өөрийн үнэлгээ

Сургалтын өмнөх болон дараах мэдлэг, ур чадвартаа үнэлгээ өгнө үү.		Бага				Их
		1	2	3	4	5
(1)		☐	☐	☐	☐	☐
	Сургалтын өмнө	☐	☐	☐	☐	☐
	Сургалтын дараа	☐	☐	☐	☐	☐
(2)		☐	☐	☐	☐	☐
	Сургалтын өмнө	☐	☐	☐	☐	☐
	Сургалтын дараа	☐	☐	☐	☐	☐
(3)		☐	☐	☐	☐	☐
	Сургалтын өмнө	☐	☐	☐	☐	☐
	Сургалтын дараа	☐	☐	☐	☐	☐
(4)		☐	☐	☐	☐	☐
	Сургалтын өмнө	☐	☐	☐	☐	☐
	Сургалтын дараа	☐	☐	☐	☐	☐

ТӨСӨЛ 7.15.2020

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХОХИРОГЧ ТӨВТЭЙ ХАНДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ГАРЫН АВЛАГА

Хоёрдугаар хэвлэл

ТОВЧИЛСОН ҮГ

АБТ	Аюулгүй байдлын төлөвлөгөө
АЗҮ	Аюулын зэргийн үнэлгээ
ASAP	Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн сангийн эрэн сурвалжлах сан
БХГХШ	Бэлгийн хүчирхийллийн гэмтлийн хам шинж
ГДСЭ	Гэмтлийн дараах стресс эмгэг
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХТТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ЖЭТБХТХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
ЛГБТИ	Лесби, гей, бисексуал, трансжендер, интерсекс
НБҮ	Нөхцөл байдлын үнэлгээ
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ТСАХ	Таслан сэргийлэх арга хэмжээ
ХСБ	Хууль сахиулах байгууллага
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг Үндэсний Төв
ЭХ	Эрүүгийн хууль
IDLO	International Development Law Organization
ОУЭЗХБ	Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага
ЦБҮАЖ	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ГХУСТХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
ЗХТХ	Захиргааны хэргийн тухай хууль
ИХШХШТХ	Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
УДШ	Улсын Дээд Шүүх
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ЦАТХ	Цагдаагийн албаны тухай хууль
ЦБҮАЖ	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ОЙЛГОЛТ, ҮНДСЭН ШИНЖ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА 76

1.1 ЖЕНДЭР БА ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ 79

Дэд сэдэв 1. Жендэрийн тухай ойлголт 79

Дэд сэдэв 2. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын чиг хандлага, зөвлөмж 86

Дэд сэдэв 3. ГБХ-ийг тайлбарлах онолын урсгал, чиглэл 88

1.2 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАНИН МЭДЭХ НЬ 93

Дэд сэдэв 1. ГБХ-ийн ойлголт, шинж 93

Дэд сэдэв 2. ГБХ-ийн талаарх ташаа ойлголт 98

Дэд сэдэв 3. ГБХ-ийн үр дагавар 100

1.3 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ, ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧ 102

Дэд сэдэв 1. ГБХ-ийн хохирогч, түүний зан үйл 102

Дэд сэдэв 2. ГБХ үйлдэгч, түүний зан үйл 105

Дэд сэдэв 3. ГБХ ба хүүхэд 107

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН БОЛОН ШҮҮГЧИЙН НИЙТЛЭГ АНХААРАХ АСУУДАЛ 111

2.1 ГБХ-ТЭЙ ТЭМЦЭХЭД САЛБАР ХООРОНДЫН УЯЛДАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА 112

Дэд сэдэв 1. ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх цогц тогтолцоо 112

Дэд сэдэв 2. Хамтарсан багийн үйл ажиллагаа 114

Дэд сэдэв 3. Хохирогч төвтэй хандлага 118

2.2 . АЮУЛЫН ЗЭРГИЙН БОЛОН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ 121

Дэд сэдэв 1. Аюулын зэргийн үнэлгээ, түүнийг хийх аргачлал, анхаарах асуудал 121

Дэд сэдэв 2. Нөхцөл байдлын үнэлгээ 127

2.3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ 132

Дэд сэдэв 1. Гэрч, хохирогчийн хамгаалалт, түүний үндэслэл, журам 132

Дэд сэдэв 2. Гэрч, хохиргчийн хамгаалалтын арга хэмжээний хэлбэр, анхаарах зүйл 136

Дэд сэдэв 3. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтад авах 138

ГУРАВДУГААР ХЭСЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН БОЛОН ШҮҮГЧИЙН АНХААРАХ ОНЦЛОГ АСУУДАЛ 141

3.1. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДЫН АНХААРАХ АСУУДАЛ 142

3.1.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ДУУДЛАГА, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА 143

3.1.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛД ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ 152

3.1.3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ҮЙЛДЭЛД ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЖ, МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ 157

3.2 . ПРОКУРОРЫН АНХААРАХ АСУУДАЛ 168

3.2.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ 168

3.2.2.ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЖ ЯЛЛАГДАГЧААР ТАТАХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН АЖЛЫН ОНЦЛОГ 180

3.2.3.ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙГ ЯЛЛАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ 202

3.3. ШҮҮГЧИЙН АНХААРАХ АСУУДАЛ 222

3.3.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ОНЦЛОГ 223

3.3.2. ШҮҮГЧЭЭС ГБХ ҮЙЛДЭГЧ, ГЭРЧ, ХОХИРОГЧТОЙ ХАРИЛЦАХ АРГА БАРИЛ 234

3.3.3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧИЛ ГАРГАГЧИД ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ, ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧИД ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ, ЯЛ ОНОГДУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ 238

3.4. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ АНХААРАХ АСУУДАЛ 250

3.4.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТ 251

3.4.2 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧТЭЙ ХАРИЛЦАА ТОГТООХ ҮЙЛ ЯВЦ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ 256

3.4.3 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ТАЛААР СУДАЛГАА ХИЙХ 267

3.4.4 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТ 269

3.4.5 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ЗАН ҮЙЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ 272

ЭХ СУРВАЛЖ 273

ХАВСРАЛТ 277

Шинээр батлагдсан журмууд 278

Гарын авлагын эхний хэвлэл дээр ажилласан сургагч багш нар 301

I ХЭСЭГ

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ОЙЛГОЛТ, ҮНДСЭН ШИНЖ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

Удиртгал

Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтан, албан хаагчид ГБХ-ийн мөн чанар, шалтгаан нөхцөлийг ул суурьтай ойлгож, танин мэдэх нь ГБХ-тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Иймд ГБХ-ийн талаар тайлбарласан онолын урсгал чиглэлүүд, эрх зүйн гол баримт бичгүүд, жендэр болон жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний шалтгаан, нөхцөлийн талаар зөв ойлголт, мэдээлэл өгөхөд энэхүү сэдвийн зорилго оршино.

Энэ хэсэгт ГБХ, жендэрт суурилсан хүчирхийлэл, жендэрийн тухай үндсэн ойлголтуудыг багтаасан дараах 3 бүлэг сэдвийг авч үзнэ. Үүнд:

1. Жендэр, жендэрийн эрх тэгш байдал, жендэрийн хэвшмэл үзэл, жендэрийн ялгаварлан гадуурхалтын ойлголт, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь;
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын хандлага, зөвлөмж;
3. ГБХ-ийн ойлголт, үндсэн шинж, илрэх хэлбэр;

Нэр томьёо:

- Жендэр
- Жендэрийн тэгш байдал
- Жендэрийн хэвшмэл үзэл
- Жендэрийн ялгаварлан гадуурхалт
- Жендэрт суурилсан хүчирхийлэл
- Сэтгэл судлалын онол
- Социологийн онол
- Феминист онол
- Бие махбодын хүчирхийлэл
- Гэр бүлийн хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл
- Сэтгэл санааны хүчирхийлэл
- Эдийн засгийн хүчирхийлэл
- Хүчирхийллийн битүү тойрог
- ГБХ-ийн талаарх ташаа ойлголт
- Стокгольмын синдром
- Гэмтлийн дараах стресс эмгэг

1.1. ЖЕНДЭР БА ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

ДЭД СЭДЭВ 1. Жендэрийн тухай ойлголт

"Жендэр" гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ.[9]

Бодит байдалд хүмүүс жендэр болон хүйсийг адил утгаар андуу ойлгох, эсвэл жендэр нь зөвхөн эмэгтэйчүүдэд хамааралтай ойлголт мэтээр буруу тайлбарлах нь бий. Иймд гарын авлагын эхэнд дээрх хоёр ойлголтын ялгааг гаргах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс байгалиасаа харилцан адилгүй байдаг. Үүнийг хүйсийн ялгаа гэж ойлгодог. Биологийн талаасаа эрэгтэй, эмэгтэй хүн 46 хромсомтой, үүнээс 44 нь хос хромсом байдаг боловч хүйс тодорхойлогч хоёр хромсом нь эмэгтэй хүний хувьд XY, эрэгтэй хүний хувьд XX байдаг. Энэ ялгаа нь хүний хүйс биологийн хувьд үл өөрчлөгдөх шинжтэйг харуулж байгаа юм. Үүнээс гадна эрэгтэй хүмүүсийн биед тестостерон гэх биеийн нөхөн үржих, булчин, цусны улаан эсийн нөхөн төлжилтөд нэн шаардлагатай даавар ихээр ялгардаг нь эрэгтэй хүн байгалиасаа хүч чадалтай, эрэмгий болоход нөлөөлдөг бол эмэгтэй хүний биед эстроген хэмээх эмэгтэйлэг шинжийг бүрдүүлдэг даавар, түүнчлэн прогестерон хэмээх нөхөн үржихүйн үйл явцыг идэвхжүүлдэг даавар илүүтэй ялгардаг. Эндээс үзвэл хүйсийн ялгаа гэдэг нь хүний төрөлхийн шинжтэй бөгөөд биологийн буюу жам ёсны гаралтай болохыг илтгэдэг.

Харин жендэр гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс, тодорхой бүлгүүдийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, хүлээлтийг илэрхийлсэн ойлголт бөгөөд байгалийн гэхээс илүүтэй нийгмийн шинж чанартай юм.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас жендэрийг дараах байдлаар тодорхойлжээ:

> "Жендэр гэдэг нь аль нэг нийгмийн зүгээс эрэгтэй, эмэгтэй хүмүүс хийгээд охид, хөвгүүдийн хувьд гүйцэтгэх ёстой гэж үздэг үүрэг, зан байдал, үйлдэл, хандлага, боломж бололцооны агуулгыг илэрхийлсэн ойлголт юм. Жендэр нь хэдийгээр хүний биологийн хүйсийн байдлаас хамаардаг боловч агуулгын хувьд ялгаатай."

Өмнө дурдсанчлан жендэр нь тухайн нийгмийн хөгжил, үндэс угсааны онцлог зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан жендэрийн асуудал харилцан адилгүй байж болно. Жишээ нь Европ, Америк, Монголд эмэгтэй хүн юбка өмсөх нь эмэгтэйлэг шинжийг харуулдаг байхад Ойрхи Дорнод, Ази, Африк, Шотланд зэрэг газарт юбкатай төстэй богино хувцас өмссөнөөр эрэгтэйчүүд хүч чадалтай, дайчин гэж харагддаг. Нөгөө талаар жендэрийн нөхцөл байдал нь нийгмийн хөгжил хувьслыг дагаж өөрчлөгдөж байна. Жишээ нь хүүхдээ харж, өсгөн бойжуулах нь эмэгтэй хүний үүрэг гэж үздэг байсан бол өнөөдөр эцэг, эхийн аль аль нь хүүхдээ харж хандах өсгөн хүмүүжүүлэхийн ач холбогдлыг ойлгож, Финлянд зэрэг зарим оронд аавуудад хүүхэд асрах чөлөөг ээжүүдтэй адилхан хугацаагаар олгож эхэлсэн байна. Түүнчлэн УБ хотын жендэрийн асуудал алслагдсан сумынхаас ихээхэн ялгаатай байх жишээтэй. Иймд жендэр нь нийгмийн анги, давхарга, нас, арьсны өнгө, яс үндэс, шашин шүтлэг, газар зүйн байршил, эдийн засгийн байдал, улс төр, соёлын орчин зэрэг олон хүчин зүйлстэй харилцан хамааралтай байдаг.

9 ЖЭТБХТ хуулийн 4 дүгээр зүйлийн §4.1.1.

Хүснэгт 1.1. Хүйс ба жендэрийн ялгаа[10]

Хүйс	Жендэр
Биологийн ялгааг илэрхийлдэг.	Үүрэг хариуцлага, байр суурийн ялгаатай байдлыг илэрхийлдэг.
Үл өөрчлөгдөх чанар	Цаг хугацааны хувьд хувьсан өөрчлөгддөг.
Түгээмэл. Бүх улс оронд адил.	Нийгэм соёл бүрд харилцан адилгүй.
Ижил хүйсийн хүмүүсийн хувьд адил	Ижил хүйсийн хүмүүсийн дунд ч ялгаа байдаг.

Жендэр ба хүйсийн ялгааг танин мэдэхгүй, хүмүүс хүйстэй холбоотой гэж ойлгож явсан зүйл нь үнэн чанартаа жендэрийн асуудал байсныг ойлгохгүй бол өөрчлөлт хийх хүсэлгүй, хуучин, буруу чиг хандлагаар явсаар байх болно.

Жендэрийн тэгш байдал

"Жендэрийн тэгш байдал" гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг ойлгоно.[11] Өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэмд болон хувийн амьдралынхаа хүрээнд эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байхыг ойлгоно. Жишээ нь эмэгтэй хүн гэр цэвэрлэж хоол хийх ёстой гэсэн хэвшмэл хандлагаар бус, харин хэн цаг завтай нь хоол ундаа хийж гэр орноо цэвэрлэх, хүүхдээ харах шаардлагатай үед зөвхөн ээж нь гэлтгүй аль боломжтой нь ажлаасаа чөлөө авч хүүхдэдээ анхаарал халамж тавих, "эрэгтэй хүүхэд хойно болно. Харин охин хүүхдийг сургууль соёлд явуулах хэрэгтэй" гэлгүйгээр бүх хүүхдийг сурч боловсрох адил тэгш боломжоор хангах зэргээр гэр бүлийн болон хувийн амьдралын өдөр тутмын харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангаж болно. Цаг хугацааны явцад тэгш байдлын тухай ойлголт ихээхэн өөрчлөгдөж ирсэн. Тэгш байдлыг бүгдэд нэгэн адилаар хандах явдал гэж ойлгож ирсэн нь үеэ өнгөрөөж, тэгш бус нөхцөлд тэгш байдлаар хандах нь ялгаатай байдлыг улам ихэсгэдэг болохыг ойлгосон.

Иймд орчин үед жендэрийн тэгш байдлыг эрэгтэй, эмэгтэй, ЛГБТИК хүмүүст ялгаагүй хандах биш, харин тэдгээрийн ялгаанд үндэслэн ялгаатай байдлаар хандах явдал гэж үзэх болсон. Ингэснээр тэдний эдлэх боломж нь тэгш, нийгэм, гэр бүлдээ эзлэх байр суурь, эрх, үүрэг нь адил байх нөхцөл бололцоог хангах явдал чухал юм. Жендэрийн тэгш байдал нь:

- жендэрийн тэгш эрх буюу эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэдний өвөрмөц ялгаа, хэрэгцээнийх нь дагуу шударга хандах хандлага,
- жендэрийн тэгш байдал буюу эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэм болон гэр бүлдээ тэгш оролцоотой байж, хөгжилд хувь нэмрээ тэгш оруулж, түүний үр шимээс тэгш хүртэх боломж нөхцөлөөр хангагдах,
- жендэрээс үүдэлтэй аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх ойлголтуудыг багтаана.

Энд адил тэнцүү боломж олгох, боломжийг эдлэх адил нөхцөл бүрдүүлэх, үр дүн нь ижил байх нь жендэрийн тэгш байдлыг бодитоор хангах үндсэн зорилт юм.

Жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг Монгол Улсын Засгийн газраас онцгойлон анхаарч Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, 2011 онд УИХ-аар батлагдсанаар Монгол Улс жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай тусгайлсан хуультай Азийн цөөхөн орны нэг болсон юм. Энэ хуульд жендэрийн тэгш байдлыг хангах

10 "Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх" амьдрах ухааны чадвар чиглүүлэгчийн багц гарын авлага. Д.Энхжаргал, Улаанбаатар хот, 2016 он, 31 дүгээр тал.

11 ЖЭТБХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2.

үндсэн зарчим болон механизмыг тодорхой заасан. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийг хангах дараах төрлийн тусгай арга хэмжээ авахаар тогтоосон. Тухайлбал:

- эх, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр батлах;
- улс төрийн ба удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүний тэнцвэртэй төлөөллийг хангах зорилгоор суудал хадгалах зэргээр квотын хэлбэрийг хэрэгжүүлэх;
- тодорхой салбар дахь хүйсийн тэнцвэргүй байдлыг арилгах арга хэмжээ авах,
- эсхүл аль нэг ажил, мэргэжлийн хүйсийн тэгш бус төлөөллийг тэнцвэржүүлэхэд түлхэц өгөхүйц хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, эсхүл тэтгэлэг тогтоох;
- сургалтын байгууллагын элсэлтийн нөхцөл, шаардлагыг хүйсээс хамааран ялгаатай тогтоох зэрэг болно.

Жендэрийн тэгш байдлыг хангах нь үнэн хэрэгтээ зорилго биш, харин хүний хөгжил, нийгмийн хөгжлийг хангах, шударга бус байдал, ялгаварлан гадуурхалтыг арилгах үндсэн арга зам гэдгийг ойлгох шаардлагатай.

Жендэрийн хэвшмэл үзэл

"Жендэрийн хэвшмэл үзэл" гэж улс төр, нийгэм, соёл ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон, ялгаатай ойлголт, хандлагыг[12] ойлгоно.

Энэ хэвшмэл үзэл нь эмэгтэй, эрэгтэй хүний үүрэг, биеэ авч явах байдлын талаарх соёлд тулгуурласан төсөөлөл бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн ба биологийн ялгааг зааглаж өгдөг. Биологийн хүйстэй адилгүй болох жендэрийн энэ байдал нь түүхэн цаг хугацааны явцад өөрчлөгддөг бөгөөд хэрэв энэ нь хүйсүүдийн хоорондох биологийн ялгаанд үндэслэж үүссэн бол өөрчлөхөд цаг хугацаа ихээхэн шаардана. Учир нь зарим шашин, соёл уламжлалд эмэгтэй, эрэгтэйчүүдийн биеэ авч явах байдал ба үүргийг салангид авч үзэх явдал хүчтэй хадгалагдаж, үе уламжлан ирснээс жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудалд бэрхшээл тулгарах нь бий.

Ийнхүү жендэрийн хэвшмэл ойлголт гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүний шинж төрх, байр суурь, эрх, үүргийн талаарх нийгэмд тогтсон, уламжлагдан ирсэн хатуу итгэл үнэмшил, хүлээлт юм. Бүх эрэгтэй хүмүүс эрэгтэй шинж чанарыг, бүх эмэгтэйчүүд эмэгтэй шинж чанарыг бүрэн агуулах ёстой гэсэн хатуу хэвшсэн ойлголтууд байдаг. Жишээ нь, эрэгтэйчүүд эр бяртай, эрэмгий, ширүүн, эмэгтэй хүн үг дуу цөөтэй, бүрэг дорой, тэвчээртэй гэх мэт. Жендэрийн хэвшмэл ойлголт нь эерэг, сөрөг аль аль нь байж болох боловч бусдын талаар бодитой мэдээлэл болж чаддаггүй, харин түүнд шударга бус хандах, шударга бус зүйлийг зөвтгөх үндэс болдог тул ихээхэн сөрөг үр дагавартай байдаг. Хэвшмэл хандлагаас болж нийгэмд тодорхой бүлэг, хэсгийг ялгаварлан гадуурхах, тохуурхах, доромжлох, цаашлаад эрх мэдлийн тэгш бус харилцааг бий болгодог.

Жендэрийн хэвшмэл ойлголт нь хувь хүний зан чанар, илэрхийллийн нэг хэсэг болсон байх тул өөрчлөх, даван туулахад багагүй цаг хугацаа, хүч чармайлт шаарддаг. Мөн хувь хүний жендэрийн үнэлэмжийг бүрдүүлж, жендэрийн үүргээ ойлгох хүрээ хязгаарыг нь тогтоож өгдөг болохыг ойлгох учиртай.

Жендэрийн ялгаварлан гадуурхалт

"Жендэрийн ялгаварлан гадуурхалт" гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй —хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг[13] ойлгоно. Түүнчлэн жендэрийн ялгаварлан гадуурхалтад зөвхөн эрэгтэй, эмэгтэй гэсэн хүйсийн байдалд үндэслэсэн гадуурхалтаас гадна ЛГБТИК хүмүүсийг өвөрмөгц онцлогоос нь болж ялгаварлан гадуурхаж байгаа явдлыг ч хууль тогтоомжоор хориглох шаардлага байна.

12 ЖЭТБХТ хуулийн 4 дүгээр зүйлийн §4.1.3

13 ЖЭТБХТ хуулийн 4 дүгээр зүйлийн §4.1.3

Жендэрийн тэгш байдал нь амьдрал ахуйн хэв маяг, хүмүүстэй харьцах ердийн хэм хэмжээ болох ёстой. Иймээс хүн бүр ялгаварлан гадуурхалтын талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй байж энэ нь биелэгдэнэ.

Жендэрийн ялгаварлан гадуурхалт гэж хувь хүнийг түүний хүйсээс нь хамааран нийгмийн болон хувийн амьдралын аль нэг хүрээнд ялгавартай хандахыг хэлнэ. Энэ нь жендэрийн хэвшмэл уламжлалт ойлголтод суурилдаг бөгөөд хувь хүний хандлагыг тодорхойлоод зогсохгүй нийгмийн бүх хүрээнд илэрхийлэгдэж байдаг. Иймээс дээрх ялгаварлал нь хууль тогтоомжид туссан байхыг үгүйсгэхгүй бөгөөд амьдрал практик дээр бодитоор оршин байдаг. Ялгаварлан гадуурхалт нь шууд, шууд бус хэлбэртэй.

Шууд ялгаварлан гадуурхалт хүнийг хүйсийн шинжээр ялгаатай үзэж, эсрэг хүйсийн хүнээс дорд байдалд оруулах, тэгш бус хандах байдал юм. Жишээ нь сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулахдаа мэргэжил, ур чадварын хувьд илүү байсан ч хүүхэд төрүүлэх, асрах зэргээр чөлөө авдаг гэх шалтгаанаар эмэгтэй нэр дэвшигчээс татгалзаж, эрэгтэй нэр дэвшигчийг сонгон авах нь шууд ялгаварлан гадуурхалтын жишээ юм. Түүнчлэн ЛГБТИК хүмүүсийг өвөрмөц онцлогоос нь болж ажилд авахаас цааргалах, татгалзах зэрэг нь шууд ялгаварлан гадуурхалтын нэг юм.

Шууд бус ялгаварлан гадуурхалт нь хууль, журам, стандарт буюу харьцаа нь хүйсийн шинжтэй аливаа зааг ялгаа агуулаагүй атлаа хүнийг эсрэг хүйсийн хүнээс дорд байдалд оруулах, таагүй байдал үүсгэх явдал юм. Жишээ нь ажил олгогч нийт ажилтнуудаа илүү цагаар ажиллуулах шийдвэр гаргасан бөгөөд энэ шийдвэр нь бага насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг, эсхүл эхийг хөдөлмөрийн харилцаанд шууд бусаар ялгаварлан гадуурхсан шинжтэй гэж үзнэ.

Хүнийг хүйсээс нь улбаатайгаар ялгаварлахын эсрэг тэмцэх нь хүний эрхийг хамгаалах суурь нөхцөл болно гэж үздэг. Эмэгтэй, эрэгтэй хүний хууль ёсны эрхийг онцлон үзэж, хууль болон практик үйл ажиллагаанд хүйсэд тулгуурласан бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг устгахыг зорьдог. ЖЭТБХтХ-д шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалтыг тодорхойлсноос гадна жендэрийн ялгаварлалд хамаарахгүй гэж үзэх үйл ажиллагааг зааж өгсөн. Энэ нь дээр дурдсанаар ялгаатай байдлыг арилгах зорилгоор хүйсийн ялгаатай байдалд үндэслэсэн арга хэмжээ авах шаардлагаас үүдэлтэй юм. Тухайлбал, зөвхөн нэг хүйсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөрийн, боловсролын зэрэг салбарт аль нэг хүйсийн хүнийг сонгох гэх мэт.

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь жендэрийн ялгаварлан гадуурхалтад хамаарна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаанд энэ төрлийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх нь онцгой ач холбогдолтой юм. Жишээ нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг нас (жишээ нь "ийм жаахан юм байж бас найз залуутай", эсхүл "энэ хүртэл насалчихаад гэр бүлийн асуудлаа хоорондоо шийдчихэж чадахгүй" гэж хэлэх), хүйс (жишээ нь "энэ эмэгтэйчүүд өөрсдөө л эхэлдэг шүү дээ", "эр юм байж дарлуулаад байхдаа яах вэ дээ" гэж хэлэх), гарал үүсэл (жишээ нь "энэ хөдөөнийхөн дандаа ингэж хэрүүл зодоон хийдэг" гэж хэлэх), нийгэмд эзлэх байр суурь (жишээ нь "ийм нэр хүндтэй, баян чинээлэг айлынхан ингэж ч явах гэж дээ" гэж хэлэх), хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн байдал, шашин, улс төрийн үзэл бодол, санхүүгийн боломж болон бусад шалтгаанаар ялгаварлан гадуурхах нь хууль тогтоомжоор хориотой төдийгүй хохирогч итгэл алдрах, сэтгэл зүйн таагүй үр дагаврыг мэдэрч шаналахад хүргэдэг. Улмаар хэргийн талаар мэдүүлэг өгөхөөс татгалзах, худлаа мэдүүлэг өгөх, хууль сахиулах, мөрдөн шалгах, шүүхийн байгууллагад ирэхгүй зугтаах зэрэг байдал гаргаж энэ төрлийн хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаанд сөрөг үр дагавар гарах нь бий.

Браун хоёрдогч хохирогч гэсэн нэр томьёог сэтгэл санааны шаналал амссан хохирогчдод тохиолддог шударга бус явдлыг тайлбарлахад ашиглажээ. Туслалцаа үзүүлж буй мэргэжилтнүүдийн зүгээс хохирогчид дэмжлэг үзүүлэхгүй байх, тэднийг хүлээн зөвшөөрөхийн оронд хүчирхийлэлд буруутгах

тохиолдолд хоёрдогч хохирогч бий болдог. Хохирогчид хоёрдогч хохирогч болох явдал нь анх хохирогч болохоос илүү сэтгэлийн дарамт авчирдаг тухай дурджээ.[22] Иймд ялгаварлан гадуурхалтын бүхий л хэлбэрийг гаргахгүй байх, шууд санаатай биш боловч хохирогчид тийнхүү ойлгогдохоос сэргийлэх, "хоёрдогч хохирогч" болгохгүй байх, цаашлаад хууль, шүүхийн байгууллагад итгэх итгэлийг хохирогчид төрүүлэх, гаргасан хүчин чармайлт, зоригийг нь дэмжих, эерэг уур амьсгалаар харилцах нь цаашид уг хэрэг, зөрчлийг шударгаар шийдвэрлэж, зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэх гол урьдач нөхцөл болохыг анхаарах хэрэгтэй.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 14.1 дүгээр зүйлд ялгаварлан гадуурхах гэмт хэргийг зааж өгсөн бөгөөд энэ нь ялгаварлан гадуурхалтын нийгмийн хор уршиг, хөнөөлийг хууль тогтоогчийн зүгээс ухамсарлан ойлгож, гэмт хэрэгт тооцон эрүүгийн эрх зүйн хамгаалалтад оруулсны илрэл юм. Уг зүйлд ялгаварлан гадуурхах гэмт хэргийг дараах байдлаар заажээ:

1. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүнтэй тэмцэх нь

"Жендэрт суурилсан хүчирхийлэл" гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг[14] ойлгоно.

Тухайн үйлдэгдэж буй хүчирхийллийн уг шалтгаан нь тодорхой хувь хүн эсхүл бүлэг хүмүүсийн эсрэг тэдний жендэрийн талаарх нийгэмд тогтсон ойлголт, хэвшмэл хандлагатай холбоотой байдаг тул жендэрт суурилсан хүчирхийлэл гэсэн нэр томьёо үүсжээ. Хүчирхийллийн шинжтэй дээрх үйлдэл нь тухайн жендэрийн нийгэм дэх ойлголт, гүйцэтгэх үүрэгтэй холбогддог. Дайны нөхцөл байдалд жишээ авч үзвэл дайтагч тал нь ихэвчлэн нас биед хүрсэн эрэгтэйчүүд байдаг бол энгийн иргэд нь гол төлөв хүүхэд, эмэгтэйчүүд, настайчууд байдаг гэсэн хэвшмэл хандлага бий. Боснийн дайны үед буюу 1995 онд Сребреника тосгонд Босни гаралтай 8000 гаруй эрэгтэйчүүд, эрэгтэй хүүхдүүдийг дараа нь эсрэг талд элсэн дайтах магадлалтай гэж үзэн амь насыг нь хороосон[15] гашуун сургамж хүн төрөлхтөнд үлдсэн. Нөгөө талаар аливаа дайн байлдааны үед эмэгтэйчүүдийн эсрэг олон хэлбэрийн хүчирхийлэл үйлдэгддэг нь эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл юм. Жишээ нь дэлхийн 2 дугаар дайны үед Японы эзэн хааны армийн цэргүүдийн үйлдсэн бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд нийт 360,000-410,000 эмэгтэйчүүд өртөж, маш олон тооны охид, эмэгтэйчүүд амь насаа алдсан байдаг.[16]

Жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан нь эрх мэдлийн тэнцвэргүй харилцаанаас үүдэлтэй гэж үздэг. Жишээ нь өмнө авч үзсэний дагуу эрэгтэй, эмэгтэй хүмүүс байгалиасаа хүч чадлын харилцан адилгүй заяагдмал бөгөөд үүн дээр суурилсан хүчирхийлэл нь жендерт суурилсан хүчирхийлэл мөн. Ази тивд жишээ нь 15-49

14 ЖЭТБХТ хуулийн 4 дүгээр зүйлийн §4.1.4.

15 "Atrocities, Massacres, and War Crimes: An Encyclopedia2014 086 Edited by Alexander Mikaberidze Atrocities, Massacres, and War Crimes: An Encyclopedia Santa Barbara, Reference Reviews. 28 (3): 18. 2014-03-11.

16 Huang, Hua-Lun (2012). The Missing Girls and Women of China, Hong Kong and Taiwan: A Sociological Study of Infanticide, Forced Prostitution, Political Imprisonment, "Ghost Brides," Runaways and Thrownaways, 1900—2000s. McFarlanC., p.206.

насны гэрлэсэн эмэгтэйчүүдээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан эсэхийг тодруулахад Мальдивт 20, Пакистанд 26, Энэтхэгт 38, Бангладешт 53 хувь нь энэ төрлийн хүчирхийлэлд өртөж байсан гэсэн судалгаа гарсан. Түүнчлэн Энэтхэгийн бурангуй заншлийн дагуу хуримаа хийж буй хосын эмэгтэй нь эрэгтэйн талдаа үнэ цэнтэй инж өгөх ёстой бөгөөд инж нь сэтгэлд хүрээгүй, таалагдаагүй, багадсан гэх зэрэг шалтгааны улмаас 2011-2015 оны хооронд нийт 40000 гаруй эмэгтэй хүчирхийлэлд өртөн амь насаа алджээ.

Тэгвэл Монгол Улсын хувьд НҮБ-ын Хүн амын сангаас 2017 онд хийсэн судалгаагаар гэрлэсэн болон гэрлэлтийн өмнөх харилцаанд байгаа эмэгтэйчүүдийн 57.9 хувь нь ямар нэг төрлийн хүчирхийлэлд, 31.2 хувь нь бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн ноцтой тоо баримт байна.[17]

Тус сангийн мэдээлснээр нийгэм, эдийн засгийн янз бүрийн давхаргын эмэгтэй ба эрэгтэй хүмүүсийн аль аль нь жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх эрсдэл их байдаг ч жендэрийн тэгш бус байдал ихэссэнээр эмэгтэй хүн эрэгтэй хүнээс харьцангуй их хувиар хохирогч болдог ажээ. Ийнхүү жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдын дийлэнх нь охид, эмэгтэйчүүд байдгаас энэ нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэж нэрлэгдэж байна.

Монголд жендэрт суурилсан хүчирхийллийн дараах хэлбэр илүү түгээмэл байна:

- ГБХ;
- бэлгийн хүчирхийлэл;
- хүн худалдаалах гэмт хэрэг;
- ажлын байран дахь бэлгийн дарамт зэрэг болно.[18]

Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг тунхаглалын 1 дүгээр зүйлд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг дараах байдлаар тодорхойлсон байна:

"Нийгмийн болон хувийн амьдралын хүрээнд эмэгтэйчүүдийг бие махбодын, бэлгийн болон сэтгэл зүйн зовиур шаналгаа амсахад хүргэж байгаа болон хүргэж болзошгүй жендэрт суурилсан хүчирхийллийн аливаа үйлдлийг, түүний дотор үйлдэхээр заналхийлэх, эрх чөлөөг нь хасах буюу хасахаар заналхийлэх үйлдлийг хэлнэ."

Эмэгтэйчүүдийн амь нас, хувийн амьдрал, түүний дотор нөхөн үржихүйн амьдралд хяналт тавьж, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг өөгшүүлэгч зан заншил, соёл, тэгш бус байдлыг бий болгож буй тогтолцоо зэрэг нь эмэгтэйчүүдийг дорд үзэх, захирагдмал байр сууринд байх ёстой гэсэн жендэрийн хэвшмэл ойлголтод суурилж байдаг. Гэр бүлийн хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн цогц тогтолцоог бий болгох үүднээс Монгол Улс дараах хууль тогтоомжийг батлан гаргаж, эдгээр хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэж байна:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль–(2016 оны): гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, хохирогч зэрэг хуулийн үйлчлэлд хамаарах хүмүүс (3 дугаар зүйл), гэр бүлийн хүчирхийлэл, түүнд холбогдох бусад ойлголтын тодорхойлолт (5 дугаар зүйл), гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд (6 дугаар зүйл), хохирогчийн эрхийг хамгаалах

17 National Statistics Office and the UN Population Fund Ulaanbaatar, Breaking the silence for equality: 2017 National Study on Gender-based Violence in Mongolia, НҮБ-ын Хүн амын сангийн албан ёсны цахим хуудас. https://mongoliA.unfpA.org/en/publications/breaking-silence-equality-2017-national-study-gender-based-violence-mongolia

18 Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх МУЗГ-ын ээлжит 8, 9 дүгээр илтгэл, I хэсэг, 33.

(8 дугаар зүйл), гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо (9-22 дугаар зүйл), ГБХ-ийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээний зохицуулалт (23-30 дугаар зүйл), аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх үндэслэл, журам (31-32 дугаар зүйл), хохирогчид үзүүлэх үйлчилгээ (33-42 дугаар зүйл), зан үйлд нөлөөлөх сургалт (44 дүгээр зүйл).

Эрүүгийн хууль–(2015 оны) Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг алах (10.1 дүгээр зүйлийн 2.8), гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг амиа хорлоход хүргэх (10.4 дүгээр зүйл), Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх (11.7 дугаар зүйл), гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх (12.1 дүгээр зүйлийн 2.3), бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (12.2 дугаар зүйл), хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах (16.1 дүгээр зүйл) зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож, ногдуулах ял шийтгэл, албадлагын арга хэмжээ зэргийг тогтоосон.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль–(2013 оны) ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэхтэй холбоотой хамгаалалтын арга хэмжээ (6-18 дугаар зүйл), гэрч, хохирогчийг хамгаалах үндэслэл, журам (19-24 дүгээр зүйл) зэргийг хуульчилсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль–(2017 оны) ГБХ-ийн холбогдолтой гэмт хэргийн мэдээллийг хүлээн авах, хэрэг бүртгэлт явуулах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, мөрдөн шалгах, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүхэд хэргийг хянан шийдвэрлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдолтой асуудлуудыг зохицуулсан.

Зөрчлийн тухай хууль–(2017 оны) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил (5.4 дүгээр зүйл), албадлагын арга хэмжээ, зөрчилд хүлээлгэх шийтгэл зэргийг тогтоосон.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль–(2017 оны) ГБХ-ийн зөрчлийг шалган шийдвэрлэх үндэслэл, журам, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл ногдуулах, уг ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой процессын зохицуулалтыг тусгасан.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль–(2012 оны): хүн худалдаалах үйлдлийн тодорхойлолт (3 дугаар зүйл), хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зохион байгуулалт (5-8 дугаар зүйл), хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны арга хэлбэр (9-16 дугаар зүйл) зэргийг зохицуулсан бөгөөд хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаатай уялдуулахтай холбоотой чухал зохицуулалтууд бий.

Хүүхдийн эрхийн тухай хууль–(2016 оны) хүүхдийн эрхийг хамгаалах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүлээх үүрэг (5-10 дугаар зүйл), хүүхдийн эрхийг хангах талаар төр, иргэн, хуулийн этгээдийн үүрэг (11-21 дүгээр зүйл) зэргийг тусгасан.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль–(2011 оны) жендэр, жендэрийн эрх тэгш байдал, хэвшмэл үзэл, жендэрийн ялгаварлан гадуурхалт, шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт, жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг ойлголтын хууль зүйн тодорхойлолт (4 дүгээр зүйл), жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох (6 дугаар зүйл), эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийг хангах тусгай арга хэмжээ (7 дугаар зүйл), жендэрийн тэгш байдлыг улс төр, эдийн засаг, төрийн алба, хөдөлмөрийн харилцаа, соёл, боловсрол, эрүүл мэнд, гэр бүлийн харилцаанд хангах тусгай арга хэмжээ (8-14 дүгээр зүйл), жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт (15-22 дугаар зүйл), жендэрийн эрх тэгш байдлыг зөрчсөн талаарх гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх журам (23-24 дүгээр зүйл) зэргийг тусгасан.

Гэр бүлийн тухай хууль–(1999 оны) гэрлэлт, гэр бүл, гэрлэгчид, гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн зэрэг гэр бүлийн харилцаанд оролцогчдын тодорхойлолт, гэрлэгчдийн эрх, үүрэг, гэрлэлт цуцлах үндэслэл, журам, гэрлэгчдийн байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэрлэлт цуцлах, хүүхдийн

асрамжийг тогтоох, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих, эцэг, эх, хүүхдийн хоорондын эрх, үүрэг, хүүхдээ хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүдийн тэжээн тэтгэх, талаарх эцэг, эхийн эрх, үүрэг, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, хүүхэд үрчлэх, асран хамгаалах, харгалзан дэмжих зэрэг харилцааг зохицуулсан.

Цагдаагийн албаны тухай хууль-(2017 оны) ГБХ-тэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар цагдаагийн байгууллагын үүрэг (11.1.5), ГБХ-ийг таслан зогсоох зорилгоор орон байранд нэвтрэх, аюулгүй байдлыг шалгах, хүчирхийлэл үйлдэгчид шаардлага тавих, аюулын зэргийн нөхцөл байдал өндөр, түүнчлэн хүчирхийлэлд өртсөн бол хүүхдийг нийгмийн аижлтанд хүлээлгэх өгөх, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ, хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээ авах, хэрэгжүүлэх арга зэргийг нарийвчлан тусгасан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль-(2019 оны) гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлсон бөгөөд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхийг Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохицуулах зөвлөлд үүрэг болгосон.

ДЭД СЭДЭВ 2. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын чиг хандлага, зөвлөмж

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь дэлхий нийтийн хурцадмал сэдэв болсны учир НҮБ болон олон улсын бусад байгууллагаас энэ чиглэлээр цөөнгүй тооны тогтоол, зөвлөмжийг гаргаж, улс орнуудыг ГБХ-ийг устгахад уриалсан байдаг.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц-(1979)

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 34/180 тоот тогтоолоор батлагдсан тус конвенц нь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр гарсан эрх зүйн гол баримт бичиг бөгөөд энэ асуудлаар гарсан хожмын тогтоол, зөвлөмжүүдийн тулгуур баримт бичиг болсон юм. Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор Конвенцийн хорооноос 1989, 1992 онуудад зөвлөмж, тогтоолууд гаргасан байдаг.

Истанбулын конвенц-(2011)

Европын зөвлөлийн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай 2011 оны конвенц (Истанбулын конвенц) нь олон улсын болон бүс нутгийн түвшинд хамгийн өргөн хүрээг хамарсан урт хугацааны арга хэрэгсэл, стандарт болсон бөгөөд энэ чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны олон асуудлыг хамарсан, нарийвчилсан төлөвлөгөө болдог. Уг конвенцийн дагуу эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхах хэлбэр болохыг тогтоож, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хүрээнд зайлшгүй байдлын стандартыг нэгтгэн тогтоохын зэрэгцээ бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэл, мөрдөн мөшгөх, бэлгийн дарамт үзүүлэх, эм бэлэг эрхтнийг зэрэмдэглэх, албан хүчээр гэрлүүлэх, хүчээр үр хөндүүлэх, албадан үргүй болгох зэрэг болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн төрөл бүрийн хэлбэрүүдийг гэмт хэрэгт тооцохыг оролцогч улсуудад даалгасан байна.

Венийн тунхаг бичиг-(1993)

Австрийн Вена хотод 1993 оны 6 дугаар сарын 25-ны өдөр болсон Хүний эрхийн Дэлхийн бага хурлаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил болохыг тэмдэглэж, улмаар төгсгөлийн баримт бичиг болох "Венийн тунхаглал"-д нийгмийн болон гэр бүлийн харилцаанд эмэгтэйчүүдийг хүчирхийлэх бүх хэлбэрийг устгахын чухлыг онцлоод, улс гүрнүүдэд бэлгийн дарамт, мөлжлөг, жендэрийн тэгш бус байдлыг халахад чиглэсэн арга хэмжээ авахыг уриалсан байна.

Энэхүү тунхаг бичгийн уриалгын дагуу Монгол Улс олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь НҮБ-ын тогтолцооны хүрээнд батлагдсан гарсан хүний эрхийн гэрээ, конвенц, нэмэлт

протоколуудад нэгдэн орох чухал хөшүүрэг болсон юм.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал хариуцсан тусгай илтгэгч

НҮБ-ын Хүний эрхийн комисс 1994 онд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаар ажиллах тусгай илтгэгчийг томилсон бөгөөд олон улсын эмэгтэйчүүдийн байгууллагын шаардлагад үндэслэн гаргасан уг шийдвэр нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах салбарт гарсан томоохон ахиц дэвшилд тооцогддог.Тусгай илтгэгчийн гол үүрэг нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, жил бүр Женев дэх Хүний эрхийн комисст танилцуулах явдал юм.

Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг тунхаглал-(1993)

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1993 онд Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг 6 зүйл бүхий тунхаглал гаргасан. Уг тунхаглалд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэж жендэрт суурилсан хүчирхийллийн аливаа үйлдлийг, түүний дотор үйлдэхээр заналхийлэх, эрх чөлөөг нь хасах буюу хасахаар заналхийлэх үйлдлийг хамруулсан ба хүчирхийлэл үйлдэгч нь аль ч хүйсийн хүн, гэр бүлийн гишүүн, тэр ч байтугай төр байж болохыг ч заасан. Уг тунхаг бичгийн 4-р зүйлд эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг үндэсний хэмжээнд төлөвлөгөө гарган, холбогдох санхүүжилтийг шийдвэрлэн санаачилгатай ажиллахыг уриалсан байдаг.

Бээжингийн тунхаглал-(1995)

Бээжин хотноо 1995 онд зохион байгуулагдсан Эмэгтэйчүүдийн асуудлаарх Дэлхийн IY чуулга уулзалтаас баталсан Бээжингийн тунхаглалд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүний эрхийн ноцтой зөрчил мөн хэмээн онцлон тэмдэглэж, түүнийг устгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр улс орнууд хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхийг уриалж, үйл ажиллагааны хөтөлбөр гаргасан байна.

Найробигийн дээд хэмжээний уулзалт-(2019)19

Кени улсын нийслэл Найроби хотноо 2019 оны 11 дүгээр сард болсон дээд хэмжээний уулзалтаар дэлхийн 179 улсын төр засгийн төлөөлөл цуглан нийт таван асуудал хэлэлцсэний нэг нь жендэрт суурилсан хүчирхийллийг тэглэх зорилт дэвшүүлжээ. Уг уулзалтаар дэлхийн улс орнууд үүрэг амлалт авчээ. Монгол Улсын хувьд жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлээс урьдчилан сэргийлэх талаарх агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын албан ёсны хөтөлбөрт оруулах, энэ төрлийн хүчирхийлэл үйлдэгчдэд хүлээлгэх хариуцлагын оновчтой механизм бүрдүүлэх үүрэг хүлээсэн.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага нь дэлхий нийтэд тулгамдсан эрүүл мэндийн асуудлыг тодорхойлох, судалгааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, стандарт нормуудыг боловсруулах, нотолгоонд суурилсан бодлогыг санал болгох, улс орнуудад техникийн дэмжлэг үзүүлэх, хяналт үнэлгээ явуулах үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг, НҮБ-ын эрүүл мэндийн асуудал эрхэлсэн агентлаг юм. Тус байгууллагаас 1996 онд ГБХ нь нийгмийн эрүүл мэндийн салбарын нэн тулгамдсан асуудал болохыг онцлон тогтоол гаргаж, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх удирдамжийг 1997 онд баталсан билээ.[20, 21]

"Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"

Доминикан улсад 1960 оноос өрнөсөн олон нийтийн хөдөлгөөнөөс жил бүрийн 11 сарын 25-ны өдрийг эмэгтэйчүүд, охидын хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын өдөр болгох санаачилга гаргасан. Энэ өдрийг олон улс оронд тэмдэглэж ирсэн ба 1999 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор 16 хоногийн аян болгон, жил бүр тэмдэглэж байхаар батламжлан уриалсан байдаг. Энэ

19 Монгол Улсын хүлээсэн үүрэг амлалтын талаарх мэдээллийг тус дээд хэмжээний уулзалтын албан ёсны цахим хуудас /https://www.nairobisummiticpC.org/commitments/-аар нэвтэрч, Монгол улс хэсгийг сонгон үзнэ үү.

20 http://www.legalinfo.mn/law/details/1285?lawid=1285

21 http://mn-nhrB.gov.mn/hrd/ViennaDeclarationProgrammeActionBrochure.pdf

аянд дэлхийн 180 гаруй орон нэгдэж байна.

Нэгдсэн үндэстний байгууллагын 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн "2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр"-т охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийлэл, ялгаварлалын бүх хэлбэрийг хөвгүүд, эрэгтэйчүүдийн оролцоотойгоор устгана хэмээн мэдэгдсэн. Түүнчлэн жендэрийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх талаар 5 дахь зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд "Бүх эмэгтэйчүүд, охидын эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг зогсоох, олон нийт болон хувийн хэвшлийн салбарт бүх эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, тухайлбал, хууль бус наймаа, бэлгийн болон бусад мөлжлөгийг устгах"-ыг зорилт болгоод байна.

Монгол Улс дээрх олон улсын гэрээ, конвенцийн дагуу үндэсний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг шат дараатай хийж ирсэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас 1996 онд Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг, 2002 онд Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг тус тус батлан, эдгээрт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, тухайн асуудлаар бие даасан хуультай болох зорилтыг тавьсан нь чухал бодлого болсон юм. УИХ-аас 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульд "гэр бүлийн хүчирхийлэл" гэсэн нэр томьёог албан ёсоор хууль тогтоомжид оруулсан бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд батлан гаргаснаар анхны бие даасан хуультай болсон байна. Энэ хуульд гэр бүлийн харилцааны хүрээнд гарч байгаа хөнгөн хэлбэрийн хүчирхийллийг тухайн хууль болон Захиргааны хариуцлагын тухай хууль, ИХШХШТХ-иар шийдвэрлэх, хүчирхийлэл үйлдэгчийг тусгаарлах, түүнд эрх хязгаарлах арга хэмжээ авах, зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулах зэрэг цоо шинэ хариуцлагын хэлбэрүүдийг НҮБ-ын загвар хуулийн жишгээр, өөрийн орны нөхцөлд тохируулан тогтоосон нь ихээхэн онцлог болсон юм. Түүнчлэн гэр бүлийн хүрээнд гардаг хүндэвтэр, хүнд хэлбэрийн хүчирхийллийг Эрүүгийн хуулиар шийдвэрлэж ирсэн.

Дээрх хуульд заасны дагуу ГБХ-тэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн бөгөөд "Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр"-ийг гарган мөрдөж байна. Хуулийг хэрэгжүүлэх тогтоолд зааснаар хохирогчийг хамгаалах байрны зардлыг улсын төсвөөс гаргах болсон ба Цагдаагийн байгууллагад ГБХ-тэй тэмцэх тусгай нэгж ажиллах болсон нь эхний чухал алхам юм.

Түүнчлэн хамгаалах байрны тоог олшруулах, нэг цэгийн үйлчилгээний төвийг байгуулах зэрэг ажлыг санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд улсын хэмжээнд нийт түр хамгаалах 13 байр, нэг цэгийн үйлчилгээний 18 төвийг бий болгожээ. 2020 оны эхний 3 сарын байдлаар нэг цэгийн үйлчилгээний төвөөр нийт 920 хүн үйлчлүүлсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 76.6 хувиар өссөн дүн байна.[22]

Түүнчлэн төрийн зүгээс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хохирогчийг хамгаалах эрх зүйн цогц зохицуулалтыг бий болгох алхмыг хийсэн. Тухайлбал, 2016 оны 12 сарын 22-нд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан гаргаж, Эрүүгийн хууль, ЭХХШтХ, ГХЗУСтХ зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулаад байна.

ДЭД СЭДЭВ 3. ГБХ–ийг тайлбарлах онолын урсгал, чиглэл[23]

ГБХ-ийг тайлбарласан хэд хэдэн онол байх бөгөөд тэдгээрийг ерөнхийд нь 1) сэтгэл судлалын, 2) социологийн, 3) феминист онол гэсэн бүлэгт ангилж үздэг. Эдгээр онолын зарим нь эрэгтэйчүүд яагаад эхнэрээ зоддог тухай, зарим нь эмэгтэйчүүд яагаад хүчирхийлэлтэй харилцаандаа үлддэг

22 ҮСХ, ЦЕГ, Статистикийн тойм: Гэр бүлийн хүчирхийлэл, УБ, 2020, 8 дахь тал, http://1212.mn/BookLibraryDownloaC.ashx?url=GBHuchirhiilel_2020q1.pdf&ln=Mn.

23 ГБХ-ийг тайлбарлах онолын урсгал, чиглэлийн талаарх мэдээллийг А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг нарын "Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь" номноос авав.

тухай тайлбарласан байхад, зарим онол нь хүчирхийлэл үйлдэгч ба хүчирхийллийн хохирогч хоёрын аль алины нөхцөл байдлыг тайлбарлахыг оролддог.

Сэтгэл судлалын онолын зарим тайлбар

Тус онолын дагуу эхнэр, хамтран амьдрагчаа зодох нь дараах хүчин зүйлстэй холбоотой гэж тайлбарласан байна. Үүнд:

1. Хүүхэд насанд нь тохиолдсон таагүй үйл явдлууд, тухайлбал хүүхэд насандаа хүчирхийлэлд өртөж байсан түүхтэй холбоотой;
2. Хувь хүний онцлог чанартай холбоотой, тухайлбал эрх мэдэлтэй байхыг маш их хүсдэг;
3. Бусдаас зугтаах, эсвэл бусадтай үзэлцэх зэрэг зан чанарын өөрчлөлттэй;
4. Сэтгэцийн эмгэг өөрчлөлтүүд, тухайлбал, нийгмийн эсрэг гаж хандлагатай;
5. Бусад сэтгэл зүйн өөрчлөлт ба асуудалтай холбоотой, жишээ нь, гэмтлийн дараах цочрол, тархины гэмтэл, өөрийгөө хянах чадвар муу, өөрийн үнэлэмж доогуур, хорт зуршил мансууруулах бодист автсан зэрэг шалтгаантай холбосон байна.

Хүчирхийлэл үйлдэгч эрчүүдэд зориулсан хөтөлбөрт хамрагдах 840 эрэгтэйг сургалтад хамрагдахаас нь өмнө оношлох судалгаанд оруулахад 5 эрэгтэй тутмын 2 нь өөрийгөө дөвийлгөн үнэлэх дуртай, эсвэл нийгмийг эсэргүүцсэн сөрөг хандлагатай болох нь тогтоогджээ. Мөн Кампбэлл нар ГБХ үйлдэгчид нь өөрийгөө хянах чадвар муу, эсвэл зодох аргаар хяналтаа тогтоохыг хүсдэг тухай нарийвчлан судалжээ. Тэдний энэ онол нь тусдаа амьдрах ба салах нь хүчирхийллийн нөхцөл байдлыг сайжруулахаасаа илүү улам муутгадаг гэсэн санаа дэвшүүлсэн байдаг.[24]

Социологийн онолууд

ГБХ-ийг тайлбарласан социологийн онолуудад гэр бүлийн системийн онол, нийгмээс суралцахуйн онол, нөөцийн онол ба солилцооны онол тус тус багтана. Хүчирхийллийг тайлбарласан гэр бүлийн системийн онолоор гэр бүлийн бүх гишүүд хүчирхийллийг гэр бүлд бий болгох ба түүнийг тогтоон барих үйл явцад тодорхой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэр зан үйл нь нэг үеэс нөгөө үед дамждаг гэж үздэг.

Нийгмээс суралцахуйн онолоор хүмүүс бусдын хийж буй үйлдлийг харж, даган дуурайх замаар тэр шинэ зан үйлийг сурна. Хэрэв тухайн зан үйлийг дэмжсэн орчин бүрдвэл тэр зан үйл дахин давтагдана гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хүчирхийллийг харсан хүмүүс хүчирхийллийг өөрсдийн харилцаандаа хэрэглэнэ. Хэрэв сөрөг үр дагаваргүйгээр хүссэн үр дүндээ хүрвэл тэрхүү үйлдэл нь дахин давтагдах магадлал ихтэй гэж үздэг. Мөн зарим судлаачид энэ онолоор үе дамжин үйлдэгдэх гэр бүлийн хүчирхийллийг тайлбарладаг.

Нөөцийн онол нь эрх мэдэл, шийдвэр гаргах боломжийг нөөц баялагтай холбон тайлбарласан. Баялаг ихтэй, тухайлбал хөрөнгө мөнгө, орлого ихтэй, нийгмийн харилцаа холбоо сайтай, эрх мэдэлтэй хүмүүс хүч чадалтай, шийдвэр гаргах эрх мэдэл нь илүү байдаг. Нөгөө талаас, эдийн засаг болон нийгмийн нөөц баялаг багатай зарим хүмүүс хүчирхийлэл хэрэглэн бусдыг дарамтлах, хүмүүсийг өөрийн хяналтад оруулах замыг эцсийн арга болгон ашигладаг гэж үздэг[25].

Солилцооны онол. Нийгмийн солилцооны онол нь нэг талаас сэтгэл судлалын онолоос эхтэй боловч нөгөө талаас үнэ цэнэ ба үр ашгийн солилцоог тодорхойлсон социологийн онол гэж үздэг. Энэ онолыг анх социологич Жорж Хоман боловсруулсан бөгөөд нийгмийн бүхий л харилцааг тайлбарлахыг зорьж байжээ.[26] Ямар ч харилцаан дахь харилцан солилцох зарчмын дагуу амраг хосууд мөн бие биедээ үйлчлэх,

24 Campbell, J. B., Webster, C., Koziol-McLain, J., Block, B., Campbell, C., Curry, M. A., Gary, F., Glass, N., McFarlane, J., Sachs, B., Sharps, P., Ulrich, Y., Wilt, S. A., Manganello, J., Xu, X., Schollenberger, J., Frye, V., & Laughon, K. (2003). Risk factors for femicide in abusive relationships: results from a multisite case control study. American journal of public health, 93(7), 1089–1097. https://doi.org/10.2105/ajph.93.7.1089. (сүүлд үзсэн: 2020.06.28)

25 Domestic Violence Group Action Project. Domestic violence: Theories of causation. http://wost201h_domviol.tripoC.com/groupactionproject/id4.html (сүүлд үзсэн: 2020.06.24)

26 Robert. Albert R.. 'Handbook of Domestic Violence- Intervention Strategies: Policies Programms and Legal Remedies". 2002. p. 28.

эсвэл тухайн харилцаанаасаа ямар нэг үр шим хүртэх байдлаар дотно харилцаанд байдаг. Хэн нэг нь хамтран амьдрагчийнхаа хүссэн зүйлийг нь тухайлбал, хайр, секс, мөнгө зэргийг өгөхөд нөгөө нь хүссэн зүйлээ хүлээн авч талархал илэрхийлэх, хайрлах, магтах байдлаар эргэн хариу үйлдэл илэрхийлнэ. Цаг хугацаа өнгөрөх тусам хэн нэг нь магадгүй өөрийнхөө хүссэн зүйлийг хүч хэрэглэн авахыг хүсэж болох юм.

Солилцооны онол нь хүний зан үйл нь бусдын магтаал ба шийтгэлийн нөлөөнд өөрчлөгдөн өөрийн хэв маягаа олдог гэж үздэг. Хүчирхийллийн хохирогч эмэгтэй зодуулахаас эмээн хүчирхийлэл үйлдэгчид хүссэн зүйлийг нь өгөх, эсвэл магадгүй түүнийг ална гэсэн заналхийллээс айн хүчирхийлэлтэй харилцаандаа байсаар байж болох юм. Хүчирхийлэл үйлдэгч нөхөр сайхан зантай байвал хүчирхийлэхгүй юм байна, эсвэл ямар нэг сайхан бэлэг урамшуулал авах юм байна гэж найдна. Өөрөөр хэлбэл, энэхүү солилцооны онолд тайлбарласнаар, хүмүүс хүссэн зүйлээ авах хүсэгүй үр дүнгээс зайлсхийхийн тулд өөрийн биеэ авч яваа байдалдаа анхааралтай ханддаг.

Феминист онол

Хүчирхийлэл үйлдэгч гэр бүлийн харилцаанд байгаа эмэгтэйгээ хяналтдаа байлгахын тулд хүчирхийллийг хэрхэн ашигладаг талаар феминист онолыг баримтлагчид анхааран судалдаг. Хүчирхийлэл гэдэг ухагдахууны хүрээнд эмэгтэй хүний бие даасан байдлыг няцааж, гэр бүлийн хамтын амьдралд түүний эрх мэдэлтэй байх бололцоог хязгаарласан аливаа үйлдлийг, тухайлбал, бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны дарамт, бэлгийн хүчирхийлэл, нийгмээс тусгаарлалт, эдийн засгийн хавчлага зэрэг үйлдлийг багтаана. Феминист онолоор мөн нийгмийн бүтэц, зохион байгуулалт нь эрэгтэй хүний нийгэмд давамгайлах байр суурийг хөхүүлсэн нийгмийн тэгш бус байдлыг дэмждэг гэж үздэг.

Эцгийн эрхт ёс давамгайлсан нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүний эрх мэдлийн харилцаа тэнцвэртэй биш, тэдний нийгэмд гүйцэтгэх үүрэг өөр өөр, нийгмийн хүлээлт ч ялгаатай гэж ойлгодог. Энэхүү уламжлалт жендэрийн тэгш бус хандлага, нийгмийн хүлээлтийг феминистүүд мөн ГБХ-тэй холбон тайлбарладаг. Эдийн засаг ба улс төрийн эрх мэдэл хангалтгүйгээс эмэгтэйчүүд хүчирхийлэлтэй харилцааг орхиж чаддаггүй гэж энэ чиглэлийг баримтлагчид үздэг.

Социо-экологийн онол

ГБХ нь нийгмийн түвэгтэй асуудал учраас түүний олон талт хүчин зүйлсийг дан ганц онолоор тайлбарлана гэдэг учир дутагдалтай гэж үзээд олон түвшинд тайлбарлах экологийн чиг хандлагыг ашиглахыг санал болгосоор байна. Жишээ дор дүрслэн үзүүлснээр гэр бүлийн харилцаан доторх хувь хүний онцлог шинж, нийгмийн тодорхой хэсэг, бүлэг доторх гэр бүл, нийгэм дэх тодорхой хэсэг, бүлгийн зэрэг өргөн хүрээг хамаарсан, олон хүчин зүйлсээс хамаарна гэж үздэг.



Хүмүүс өөр хоорондоо болон гадаад орчинтойгоо харилцах явцад тэдэнд тулгарах хэрэгцээ, бэрхшээлтэй асуудлууд нь ил тодорхой болдог. Тухайн асуудалд нөлөөлөх хүчин зүйлс нь хувь хүний онцлог чанар, гэр бүл, орон нутаг, нийгэм, соёлын өргөн хүрээг тусгасан орчинтой холбоотой гэж тэд тайлбарлажээ. Тиймээс энэ онолыг баримтлагчид хүчирхийллийн нөхцөл байдал нь хувь хүн, орон нутаг, нийгэм, улс төр, соёлын гэх мэт хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийн дүнд бий болсон байж болох юм хэмээн үздэг. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх хүчин зүйлсийг дараах байдлаар ангилж авч үзсэн:[27]

Хувь хүний хүчин зүйлс:

- хүүхэд насандаа ГБХ-ийн хохирогч, эсхүл гэрч болсон
- бага насандаа эцэг, эх болсон, гэр бүлийн хувьд эмзэг орчин нөхцөлд өссөн
- эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхдаг, аль нэгийг дээгүүрт тавьдаг хандлагатай.

Гэр бүлийн хүчин зүйлс:

- Амьдралын орчин нөхцөл тааруу, хамааралт байдалд байдаг
- Нийгэм, сэтгэл зүй, санхүүгийн дэмжлэг тааруу
- Эцэг, эх нь сэтгэл зүй, бие махбодын болон оюун санааны бэрхшээлтэй
- Гэр бүл дэх эд хөрөнгийн болон бусад шийдвэр гаргах эрх нэг гишүүнд хэт төвлөрсөн
- Асран хамгаалах үүрэгтэй хүмүүсийн аль нэг нь согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэдэг

Нийгмийн тодорхой бүлгийн хүчин зүйлс:

- Нийгмийн үйлчилгээний хүртээмж тааруу. Хүчирхийллийн бус хэв маяг, соёлыг түгээн дэлгэрүүлэх боломж хязгаарлагдмал
- Хүчирхийлэл нь аж амьдралын хэвийн зүйл гэж үздэг хүрээлэл
- Ядуурал, соёлын ялгаатай байдал, ялгаварлах үзэл зэргийн улмаас олон нийтийн шинжтэй үйл ажиллагааны хүртээмж сул, нийгмийн гишүүд жигд оролцох боломжгүй

Нийгмийн хүчин зүйлс:

- Хүн хоорондын харилцаанд аливаа маргааныг шийдвэрлэх арга зам нь хүчирхийлэл гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрсөн байх
- Нийгэмд хүчирхийллийг уриалсан агуулгатай мэдээлэл хэт их байх
- Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг бие махбодын хүчирхийллийг хүлцэн тэвчдэг
- Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, хэрэгт хариуцлага хүлээлгэдэггүй
- Жендэрийн хувьд гүйцэтгэх үүрэг, нийгмийн хэм хэмжээ зэргийг хэт хатуу тогтоосон
- Эрэгтэйлэг чанар нь хүч чадлыг бэлгэдэл гэж үздэг
- Эмэгтэйчүүдийг өмчилдөг, эцэг, эх нь хүүхдээ "өөрийн өмч мэт ханддаг" үзэл
- Эмэгтэй хүн гэр бүлээ халамжилж, үр хүүхдээ өсгөн торинуулах ёстой гэсэн соёлын хэм хэмжээтэй
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилт дутмаг.

Чадваржуулах онол

Чадваржуулах үзэл баримтлал нь нийгмийн үйлчилгээний олон байгууллагын үйл ажиллагааны удирдах зарчим нь болдог. Ялангуяа, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувьд тэднийг чадваржуулах гэдэг нь бусадтай харилцах харилцаа холбоогоо таслахгүйгээр өөрийн амьдралдаа эзэн нь болж бие даасан байдлаа хангах чадвартай болохыг хэлдэг. Мөн чадваржуулах онол нь хүмүүс амьдралдаа тохиолдсон бэрхшээлтэй асуудлаа шийдэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох замаар өөрийн амьдралын чанараа сайжруулна гэсэн санааг дэвшүүлсэн. Энэхүү онол нь 1970-

27 H Dalzell, Issues in domestic violence: Introduction and theories (2016), in CE4less, https://ce4less.com/Tests/Materials/E098BMaterials.pdf (Сүүлд үзсэн 2020.06.24)

аад онд хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд зориулан хамгаалах байр бий болгохоор ажилласан феминистүүдийн хөдөлгөөнөөс эхтэй бөгөөд өнөөг хүртэл хамгаалах байрны үйл ажиллагааны үндсэн зарчим болсоор байна. Тухайлбал, АНУ-ын нэгэн хамгаалах байрны оршин суугч эмэгтэйчүүдэд зориулсан журамд тэднийг чадваржуулах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой дараах таван заалтыг тусгасан байдаг. Үүнд:

- Өөртөө хамгийн сайн тохирох, хэрэгтэй зүйлийг би өөрөө шийдэж чадна.
- Би хэн нэгэн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийнх нь шалтгаан биш.
- Би бол үнэ цэнтэй хүн.
- Би хүмүүсийн хүндлэлийг хүлээх эрхтэй.
- Би ганцаараа биш, хэн нэгнээс тусламж хүсч чадна гэсэн заалтууд багтана.

Гол нь чадваржуулах үйл явц хүчирхийллийн хохирогч эмэгтэй өөрийгөө буруутгалгүйгээр юу хийж чадах, юуг хянаж чадахгүй, хүчирхийлэл үйлдэгч хийсэн үйлдлийнхээ төлөө ямар хариуцлага хүлээх ёстой талаар ойлгоход нь тусална.

АСУУЛТАД ХАРИУЛНА УУ.

1. *Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж яагаад тодотгож нэрлэх болсон бэ?*
2. *Жендэр ба ГБХ-ийн талаар судлах нь таны ажил мэргэжилтэй ямар холбоотой вэ? Та энэ талаарх мэдлэг, чадвараа ажилдаа хэрхэн ашиглах вэ?*
3. *Таны бодлоор жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан нь юу вэ?*

ДАРААХ БОДОМЖУУДТАЙ САНАЛ НИЙЛЭХ УУ? ТОХИРОХ ХАРИУЛТЫГ ТЭМДЭГЛЭНЭ ҮҮ[28].

№	Өгөгдөл	Санал бүрэн нийлнэ	Санал нийлнэ	Эргэлзэж байна	Санал нийлэхгүй	Санал огт нийлэхгүй
1	Нийгэм хөгжин өөрчлөгдөж байгаа боловч эрэгтэй хүүхэд моринд эрэмгий, бөхөд хүчтэй болж өсөх ёстой.					
2	Жендэрт суурилсан хүчирхийллийн үйлдэгч нь эрэгтэй, хохирогч нь эмэгтэй байдаг.					
3	Хүйсийн ялгаа нь тухайн хүний жендэрийн байдлыг тодорхойлох үндэслэл болохгүй.					
4	Жендэрийн тэгш байдал гэдэг нь нийгмийн шинжтэй ойлголт бөгөөд хувийн амьдралын хүрээнд тэгш байдал хөндөгдөхгүй.					

28 Д.Энхжаргалын "Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх" амьдрах ухааны чадвар чиглүүлэгчийн багц гарын авлагад суурилж хийв.

1.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАНИН МЭДЭХ НЬ

ДЭД СЭДЭВ 1. ГБХ-ийн ойлголт, шинж

Жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгааныг эрх мэдлийн тэнцвэргүй байдал гэж үздэг. Эрх мэдэл нь өөртөө хамаатай асуудлаар шийдвэр гаргах, өөрийн сонголтыг хэрэгжүүлэх, эсвэл бусдын сонголтод нөлөөлөхөд эерэгээр ч, бас сөргөөр ч ашиглаж болох хүч, чадамжийг хэлнэ. Эрх мэдэл бол бидний амьдралын салшгүй хэсэг. Эрх мэдэл нь бидний шийдвэр, сонголтод байнга нөлөөлж байдаг боловч бид эрх мэдлийн тухай бараг боддоггүй. Хэн нэгэн эрх мэдлээ бусдыг хянах, эрхийг нь хязгаарлах хэлбэрээр ашиглах нь хүчирхийлэл болдог ба өөрөөр хэлбэл, эрх мэдэл, хүчирхийлэл хоёр хоорондоо холбоотой[29].

Эрх мэдлийн төрөл:[30]

- Дотоод хүч, эрх мэдэл
- Хамтын хүч, эрх мэдэл
- Бусдыг хянах, дарамтлах эрх мэдэл
- Үйл хэрэг болгох, өөрчлөлт хийх эрх мэдэл зэрэг болно.

Эдгээрээс бусдыг хянах, дарамтлах зэрэг нь өөрт байгаа эрх мэдлээ ашиглаж бусад хүний эрх, эрх чөлөө, хувийн орон зайнд сөргөөр нөлөөлж байгаа төрөл нь юм. Өөрийн ойр хамааралт хүмүүсийнхээ хувийн орон зай, эрх, эрх чөлөөг хяхан хавчих, хянах, элдэв бусаар дарамтлах зэрэг шинж түгээмэл байдаг тул гэр бүлийн хүчирхийлэл нь энэ төрлийн эрх мэдлийг сөргөөр ашигласны үр дагавар болдог.

Жендэрт суурилсан хүчирхийллийн түгээмэл хэлбэр нь ГБХ юм.

"Гэр бүлийн хүчирхийлэл" гэдэг нь гэр бүлийн харилцааны хүрээнд нөгөө хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг[31] ойлгохоор ГБХТТХ-д заасан. Уг хуулийн үйлчлэлд:

Гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгддэг хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг нь гол төлөв өөр хоорондоо бие биенээ үл таних хүмүүсийн хооронд үйлдэгдэж, хариуцлага хүлээдэг байхад ГБХ нь ойр дотно, хамт амьдардаг хүмүүсийн хооронд болж байдгаараа онцлогтой. Иймд хохирогч нэр төрөө бодон хүчирхийллийг нуун дарагдуулах, хүчирхийлэлтэй харилцааг тэвчих, хүчирхийлэл үйлдэгчийг уучлах, хамгаалах, хайрлах-хорсох- гомдох зэргээр бодол санаа нь зөрчилдөх, улмаар хүчирхийлэл давтагдах, даамжрах шалтгаан нөхцөл болдог.

ГБХ-ийн бас нэг онцлог шинж нь хүчирхийлэл давтагддаг, даамжирдаг шинж юм. Олон судлаачид ГБХ нь гурван үе шаттай өрнөж байдаг, ингэхдээ дараагийн хүчирхийлэл нь мөн тэр замналаар давтан үргэлжилж байдаг тойрог маягийн үзэгдэл болохыг тус бүрийнхээ судалгаагаар нотолсон байна. Өөрөөр хэлбэл, ГБХ нь нэг эхэлсэн бол дор өгүүлэх 3 үе шатыг дамжин өрнөж дуусаад,эргээд дараагийн хүчирхийллийнхээ эхлэл болон давтагдсаар байдаг "битүү тойрог"-ийн зүй тогтолтой[32].

29 "Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх" амьдрах ухааны чадвар чиглүүлэгчийн багц гарын авлага. Д.Энхжаргал, Улаанбаатар хот, 2016 он, 7-р тал.

30 Мөн тэнд

31 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, §5.1.1.

32 "Танд сонголт бий" 2013 он, ХЭҮТ, 10 дахь тал;

Нэгдүгээр үе: Зөрчилдөөн хуримтлагдах үе

Энэ шатанд хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг хяналтандаа байлгах зорилгоор шүүмжлэх, доромжлох, бусад байдлаар сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх үйлдэл хийх бөгөөд энэ нь гэр бүлийн харилцаанд байдаггүй, хэвшмэл бус хэлбэрээр илрэн гардаг. Хохирогч энэ шатанд нөхцөл байдлыг гол төлөв тайвнаар хүлээн авч өөрийг нь гомдоосон үйлдлийг зөвтгөх шалтгаан хайж, зөрчилдөөнийг шийдвэрлэхийг оролддог.

Энэ шат үргэлжлэх хугацаа нь нарийн товгүй ба зарим нь өдөртөө дуусаж, эсхүл 7 хоногийн хугацаанд үргэлжилж, зарим нь хэдэн жилээр ч хуримтлагдсаар явах нь бий. Чухам энэ үед ГБХ-ээс урьдчилан сэргийлэх анхны боломж үүсдэг бөгөөд зөрчилдөөнийг зохицуулахыг хүссэн хохирогч ямар нэг байдлаар тусламж зөвлөгөө хүсэх, ойр дотны хүмүүс, мэргэжлийн байгууллагаас дэмжлэг авахыг оролдох нь түгээмэл байдаг.

Хоёрдугаар үе: Хүчирхийлэл үйлдэх үе

Энэ нь хүчирхийлэл үйлдэгч хохирогчийн эсрэг аливаа хэлбэрийн хүчирхийллийг хамгийн идэвхтэй үйлдэх үе юм. Гол онцлог нь энэхүү үе эхэлж, аюултай нөхцөл байдал үүсч буйг хохирогч байнга урьдчилан мэдэрч, нөхцөл байдал улам бүр хяналтаас гарч буй нь тодорхой болж байдагт оршдог. ГБХ нь нэг л өдөр гэнэтийн халдлага, хүчирхийлллээр эхэлдэггүй. Харилцааны зөрчилдөөн хямрал өдөр өдрөөр даамжирсаар, улмаар хохирогч дарамтыг тэсвэрлэхгүйгээс сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэн тэсэрч хүчирхийллийг өдөөх, зарим тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийн байнгын дарамтыг тэсвэрлэхгүйгээс хүч хэрэглэх байдалд шилжих нь ч бий.

Энэ үе шат харьцангуй богино үргэлжлэх бөгөөд дунджаар 2 цагаас 24 цагийн хугацаанд болж өнгөрдөг хэмээн судлаачид үзсэн байна.Үүнийхээ дараа хүчирхийлэл үйлдэх явдлыг зогсоох буюу эрчим нь сулардаг. Ихэвчлэн энэхүү оргил үед хохирогч цагдаагийн байгууллага, хүчирхийллийн эсрэг төв, эрүүл мэндийн байгууллагад хандаж тусламж хүсдэг.

Гуравдугаар үе: "Бал сар"

Хүчирхийлэл үйлдэгч энэ үед ер бусын ялдам зөөлөн болж, хийсэн үйлдэлдээ гэмших, өршөөл уучлал хүсэх зэргийг ёс мэт үйлддэг байна. Гэнэт тэрээр гайхалтай эцэг, эх, хань, халамжит нэгэн, хүссэн бүхнийг биелүүлэгч болж, дахин хэзээ ч хүчирхийлэл үйлдэхгүй талаар амлалт, баталгаа өгч, өөрийгөө буруутган зүхэж эхэлдэг. Бүр зарим нь ийм байдалд хүргэсэн хэмээн хохирогчийг буруутгаад авах нь ч бий. Гэхдээ хамгийн гол нь дахин ийм зүйл "хэзээ ч болохгүй", "хайртай учир одоо шал өөрөөр амьдрах" тухай яриагаар төгсөнө. Гэтэл хүчирхийлэл үйлдэгчийн дотор бол тэрээр аль хэдийн ялалт байгуулсан, хохирогчийг айдас хүйдэст автуулсан тул одоо өөрийн амжилтаа бататгаж, энэхүү давамгай байдалтай байгаа харилцаагаа үргэлжлүүлэн даамжруулж байх бодол үүссэн байдаг. Заримдаа энэ шатандаа хүчирхийлэл үйлдэгч эдийн засгийн, эсхүл сэтгэл санааны хүчирхийллээ үргэлжлүүлэн үйлдэж, хохирогчийг дарамт хяналтандаа байлгасаар байх нь тохиолдоно.

Хохирогчийн хувьд энэ "бал сар" нь эргэлзэж тээнэгэлзэх, хамтын амьдралынхаа сайхан үеийг дурсах, хүчирхийлэл үйлдэгчийн амлалт, гуйлтад итгэл төрөх, улмаар эл байдал давтагдахгүй, эхлүүлсэн хамтын амьдрал нь хүсэж байснаар нь сайхан болно гэж дүгнэхэд хүргэдэг. Гэтэл ГБХ-ийн энэхүү "битүү тойрог" дахин эргэж, хэсэг хугацааны дараа дахиад л хүчирхийлэл үргэлжилдэг.

ГБХ–ийн хэлбэр

ГБХ-ийн бас нэг онцлог шинж нь олон хэлбэртэй байдаг буюу сэтгэл санааны,

эдийн засгийн, бие махбодын, бэлгийн хүчирхийлэл гэсэн дөрвөн үндсэн хэлбэртэй, эдгээр хэлбэрүүд нь ихэвчлэн дангаар үйлдэгдэх нь үгүй бөгөөд хүчирхийллийн аль нэг хэлбэртэйгээ хавсран үйлдэгддэг явдал юм. Өөрөөр хэлбэл ГБХ нь зөвхөн бие махбодыг өвтгөж зовоох явдал биш, эрхшээлдээ байлгахын тулд нөгөө хүнээ хэл амаар гутаан доромжилж, эд мөнгөөр хяхан хавчиж, гэрээсээ гаргахгүй хорьж цагдаж, бэлгийн төрөл бүрийн дарамт үзүүлэх зэрэг ямар ч байдлаар илэрч болдог үзэгдэл юм.Зарим судлаачид аливаа гэр бүлийн зөрчил маргаан нь даамжирч, нэгнийхээ эсрэг дээр дурдсан хэлбэрүүдийн аль нэгээр хүчирхийлж, тэр нь давтагдаад эхэлбэл ГБХ болж байгаа хэрэг гэж үздэг бол зарим нь ГБХ заавал давтагдсан байх албагүй, хэрэв хэн нэгэн гэр бүлийн харилцаандаа өөрийн эрх мэдэл, давуу байдлыг тогтоох санаагаар хүчирхийлэл үйлдсэн бол үүнийг ГБХ гэж үзэх нь зүйтэй гэж үздэг.

Хүчирхийллийн давтамж болон аюултай байдлын түвшин нь эрс ялгаатай байж болох ч үндсэн шинж нь хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийн нэг нь нөгөөдөө эрх мэдэл, хяналтаа тогтоох явдал юм.

Монгол Улсын ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг гэр бүлийн хүчирхийлэл гэж үзэхээр заасан.

Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиудад гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэргийн тодорхой үйлдлүүдийг зааглаж хуульчилсан.

Улсын Дээд Шүүхийн 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай 13 дугаар тогтоолд "байнга зодох" гэж тодорхой нэг хохирогчийн эсрэг чиглэсэн, хэвшмэл маягтай, гурав ба түүнээс дээш удаа бие махбодын хүчирхийлэл хийсэн байхыг хэлнэ гэж тайлбарласан байдаг. Эдгээрээс үзвэл ГБХ нь анхны удаа хууль сахиулах байгууллагад бүртгэгдсэн тохиолдолд зөрчлөөр шийдвэрлэгдэж, харин гурав ба түүнээс дээш удаа үйлдэгдсэн нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болж байгааг анхаарч, хууль сахиулах байгууллага ГБХ-ийн асуудлаар дагнасан бүртгэл хөтлөх шаардлагатай болж байгаа юм. ГБХТТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтад гэр бүлийн хүчирхийлэлд хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг хүчирхийллийн болзошгүй эрсдэл гэж тодорхойлсон бөгөөд нөхцөл байдлын үнэлгээгээр хүчирхийллийн болзошгүй эрсдэлт байдлыг тодорхойлох, хохирогчийн эрхийг хангах, түүнд хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зэрэг асуудлуудыг зохицуулж өгсөн.

Бие махбодын хүчирхийлэл

ГБХ-ийн хамгийн түгээмэл хэлбэр нь бие махбодын хүчирхийлэл бөгөөд хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг бие махбодын хүчирхийлэл гэнэ. Түүнчлэн өвдөж зовсон үед нь эмнэлэгийн тусламж үзүүлэхгүй тарчлаах нь ч бие махбодын хүчирхийллийн нэг хэлбэр мөн. Биемахбодын хүчирхийлэл нь зодох, цохих, чимхэх, базах, өшиглөх, хүлэх болон хутга мэс, хатуу, мохоо зүйлийн цохилт, зүсэлтээс үүсдэг хөхрөлт, няцралтууд, шарх, сорви, эд эрхтэний доргилтууд, хугаралт, түлэгдэлт гэх мэт биеийн эд эрхтний хэвийн бөгөөд бүрэн бүтэн байдал алдагдах байдлаар илэрнэ.

Энэхүү бие махбодын хүчирхийлэл олон тохиолдолд дангаараа байх нь үгүй. Бие махбодын хүчирхийллийг сэтгэл санааны, бэлгийн хүчирхийллийн хамтаар үйлдэх нь түгээмэл бөгөөд бүр зарим судалгааны үр дүнгээр эдийн засгийн хүчирхийлэл ч

дагалдан үйлдэгддэг байна.

Гэр бүл дэх бие махбодын хүчирхийллийн хамгийн түгээмэл хэлбэрийн нэг болох боомилолтын талаар онцгойлон авч үзэх нь зүйтэй. Учир нь боомилолт бол гэр бүл дэх бие махбодын хүчирхийллийн хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд хохирогчийг шууд үхэлд хүргэж болох амь насанд аюултай арга, хэлбэр юм. Боомилолт болон түүнтэй адилтгах хэргүүд нь ГБХ-ийн идэвхийг илтгэж байдаг тул уг үйлдэлтэй холбоотой аюулын шинж байдлыг ойлгож, анхаарал хандуулж байх зайлшгүй шаардлагатай.

Боомилох гэж юу вэ? Хүчирхийлэл үйлдэгч давамгай байдал, хүч чадлаа харуулах арга нь хохирогчийг боомилох юм. Боомилох үед "амь насаа алдаж байна" гэсэн бодол хохирогчид төрдөг бөгөөд хохирогч нь үүний улмаас урт хугацааны гүн хямрал, айдаст автдаг байна. Боомилохтой холбоотой аюулыг сайтар ойлгохын тулд хүний бие физиологийн үйл ажиллагааны үндсийг мэдэх нь чухал юм.

Боомилолт бол "цусны судас эсхүл хоолойгоор дамжих агаарын урсгалыг гадны даралт, шахалтын нөлөөгөөр хааснаас үүдэх амьсгал боогдолтын нэгэн хэлбэр юм. Хүзүү нь залгиур хоолой, мөгөөрсөн хоолой, хэлний доорх яс, мөгөөрсөөс бүрдэнэ. Хүзүүнд байрлах гүрээний артерийн судас нь зүрх болон уушигнаас хүчилтөрөгчөөр тэжээгдсэн цусыг тархи руу зөөвөрлөх гол судас юм. Гүрээний артерийн судсыг гадны шахалтаар хаахад тархинд хүчилтөрөгчийн дутагдал үүснэ. Хүзүүнд байрлах гүрээний венийн судас нь тархинаас ирсэн хүчилтөрөгчгүй цусыг дамжуулдаг гол судас юм. Амьсгалах нь хүнд агаарын урсгал тасалдахаас сэргийлж байдаг.Эдгээр үйл ажиллагааны аль нэг нь тасалдахад дараах үр дагаварт хүргэж болно:

- Хүний артерийн судсыг 11 паунд (4.95 кг), эсхүл түүнээс дээш даралтаар ердөө 10 секунд бооход ухаан алдуулах шалтгаан болно.
- Ойролцоогоор 33 паунд (14.85 кг)-ын даралт нь цагаан мөгөөрсөн хоолойг бүрэн хаана.
- Хэрэв боомилолт 4-5 минут үргэлжилбэл үхэлд хүргэж болно.

Боомилолтын халдлага нь хохирогчийг айдаст автуулахаас гадна бие махбодын хувьд туйлын өвдөлтийг мэдрүүлдэг. Судлаачид боомилуулсан хохирогчийн эмнэл зүйн ерөнхий дараалал нь "хүчтэй өвдөх-ухаан алдах- тархины үхжилт" хэмээн тодорхойлжээ. АНУ-д хохирогчийг боомилолтод өртсөн эсэхийг "Боомилолтын завдалтыг баримтжуулах хуудас", "Боомилолтын мэдээллийг хянах хяналтын хуудас" зэрэгт баримтжуулдаг байна.

Бэлгийн хүчирхийлэл

Гэр бүлийн хүчирхийллийн түгээмэл үйлдэгддэг хэлбэрийн нэг бөгөөд өөрийн эрхшээлдээ байгаа хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ.

Хүүхдийн эсрэг үйлдсэн хүчиндэх гэмт хэргийн 31 тохиолдлоос 14.3 хувь нь төрсөн эцэг, 57.2 хувь нь хойд эцэг, 4.7 хувь нь төрсөн ах, 23.8 хувь нь төрөл садангийн хүндээ хүчиндүүлсэн байна.[33] НҮБ-ын Хүн амын сангийн хийсэн судалгаанд хамрагдсан 15-аас дээш настай долоон эмэгтэй тутмын нэг нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд тэдгээрийн 2.6 хувь нь сүүлийн 12 сард хүчирхийлэлд өртжээ. Түүнчлэн судалгаанд

33 "Гүнж" төвийн хохирогчтой ажилласан судалгааны дүн 2012 он.

хамрагдсан 10 эмэгтэй тутмын нэг нь 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлжээ.[34]

Бэлгийн хүчирхийлэл нь байнга бэлгийн харилцаанд орохыг шаардах, хүчиндэх, бэлгийн харилцааны үед хүч хэрэглэх, хохирогчийн хүсэгүй байдлаар бэлгийн харилцаанд орох, дарамталж, сүрдүүлж бэлгийн харилцаанд орох, бусдын дэргэд бэлгийн харилцаанд орохыг хүчээр тулгах, бусадтай бэлгийн харилцаанд орохыг хүчээр тулгах зэрэг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадах байдлаар илэрнэ.

Бэлгийн хүчирхийлэл гэр бүл, ахуйн хүрээнд туйлын түгээмэл бөгөөд гэр бүл дэх бусад гишүүнийхээ эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэх нь ноцтой гэмт хэрэг атлаа нуугдмал байсаар удаж, эцэс сүүлд нь тэр хэргийг нотолж шийдвэрлэхэд төвөгтэй болдог. Хүмүүсийн дунд байдаг бас нэгэн ташаа ойлголт бол гэр бүл болсон л бол нөхрийн хүссэн тоолонгоор бэлгийн харилцаанд орж байх ёстой, энэ нь ямар нэгэн хүчирхийлэл биш гэж үзэх хандлага юм. Үүнээс болон төрөл бүрийн шалтгаанаар бэлгийн харилцаанд орохыг хүсэгүй нөхцөлд хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн тулгалтаар, хүчээр бэлгийн харилцаанд орж сэтгэл санааны ихээхэн дарамтад өртөж байдаг.

Орчин үеийн криминологийн судалгаа гэр бүлийн хүрээнд явагдахгүй, нийгмийн ноцтой, олны анхаарал татсан гэмт хэрэгт илүү чиглэдэг нь нууц биш. Хүчиндэх гэмт хэргийг судлахдаа гудамжинд танихгүй хүнийг хүчиндсэнийг л илүүтэй сонирхон судалсан байдаг. Харин энэхүү судалгааг гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бэлгийн хүчирхийлэлтэй харьцуулж үзээд ГБХ үйлдэгчийн үндсэн зорилго нь бэлгийн дур хүслээ хангах явдал биш, харин хоорондын харилцаанд өөрийн давуу байдлыг тогтоох, хохирогчийг эрхшээлдээ байлгах явдал байдгийг тогтоосон байна.

Сэтгэл санааны хүчирхийлэл

Хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гутгэх, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ.[35]

Сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх арга хэлбэр нь олон янз байж болно. Тухайлбал, хэл амаар гутаан доромжлохоос эхлээд хүүхэд болон хохирогчийн ойр дотны хүнд нь хүч хэрэглэхээр заналхийлэх, өөрийгөө гэмтээх, хохирол учруулах, "гэрийн амьтан, эд зүйлээ устгана, гэмтээнэ" гэж айлган сүрдүүлэх, хохирогчийг мөрдөж мөшгих, үг хэл, үйлдэлд байнгын хяналт тавих зэрэг үйлдлээр илрэхээс гадна үл тоомсорлох, хайхрахгүй байх зэрэг эс үйлдэхүйн хэлбэрээр илрэх боломжтой. Эдгээрээс хамгийн хүнд хэлбэр нь айлган сүрдүүлж, заналхийлэх явдал бөгөөд үүнд "алах, эд эрхтэнг хугалах, мөчлөх, орон гэрээ шатаана" гэх мэтээр сүрдүүлэн, түүнийгээ янз бүрийн аргаар баталгаажуулж, мэдрүүлэх үйлдэл хамаарна.

Сэтгэл санааны хүчирхийлэл нь хохирогчийн төрөл садан, нийгмийн хүрээлэлтэй тогтоосон холбоог нь тасалж, түүнд нь хяналт тавих замаар, үл анзаарагдах байдлаар эхэлж, хохирогчийн "тархийг угаах" байнгын нөлөөллийн аргаар хохирогчийн бусадтай тогтоосон харилцаа холбоог таслан зөвхөн

35 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, 6 дугаар зүйлийн §6.3.

өөрийн эрхшээлд, өөрийн үгээр байлгахад чиглэсэн замаар өрнөдөг байна. Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг өөрийн хүрээллээс нь тусгаарлахдаа янз бүрийн арга заль хэрэглэнэ. Тухайлбал, "ээж аав чинь надад дургүй юм аа", "найз хүүхэн чинь надтай сээтэгнээд байна" гэх мэтээр хэлэх нь хохирогчид шууд бусаар нөлөөлж байдаг. Хүчирхийллийн энэ хэлбэр нь нэлээн тархсан хэлбэр бөгөөд ГБХ-ийн бараг бүх тохиолдолд байдаг.

Аажмаар өрнөсөн энэхүү үйл явц хохирогчийн хувьд зөвхөн хүчирхийлэл үйлдэгчтэй харилцаа тогтоосон, түүний үгээр болсон тэр үеэс дараагийн шатандаа шилжиж, хохирогчийг айдас, түгшүүр, ганцаардал, сэтгэл гутрал, сэтгэцийн хямралд автуулж, заримдаа бүр хохирогч амиа хорлоход хүргэх ч үр дагавартай. Сэтгэл санааны хүчирхийлэл нь ямагт хүчирхийллийн бусад хэлбэртэйгээ хавсран үйлдэгддэг.

Сэтгэл зүйн дарамт нь хохирогчийн дотоод бодол санаа, мэдрэмжид нөлөөлж, амьдралынх нь туршид хязгаарлалт, хяналт тогтоож болохоос гадна урт хугацааны туршид нуугдмал байх боломжтой. Хохирогч орон гэртээ аюул занал, эргэн тойрондоо тогтворгүй, эмх замбараагүй байдлыг мэдэрч болно. Сэтгэл зүйн дарамт нь дотно харилцаа, найз нөхдийн харилцаа, өөрийгөө хүндэтгэх үзлийг ч устгаж болно.

Эдийн засгийн хүчирхийлэл

Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсныг эдийн засгийн хүчирхийлэл гэнэ.[36]

Тухайлбал, хүүхдэд зарцуулах зардлыг төлөхгүй байх, гэр бүлийн орлогыг үрэн таран хийх, санхүүгийн том шийдвэрийг ганцаар дур мэдэн гаргах гэх мэт нь эдийн засгийн хүчирхийллийн илрэх хэлбэр болдог.

Бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд, ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эдийн засгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байдаг. Тухайлбал, эмэгтэй хүн хүүхэд төрүүлж гэртээ сууснаас ажилгүй, орлогогүй болох үед эдийн засгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл нэмэгддэг. Ахмад настнуудын хувьд тэтгэврийн мөнгө, орон гэрийг нь ятгах, сүрдүүлэх байдлаар булаан авах, хоол хүнс, ахуйн хэрэглээний зүйлсээр гачигдуулах зэрэг хэлбэрээр үйлдэгддэг байна.

ДЭД СЭДЭВ 2. ГБХ–ийн талаарх ташаа ойлголт

Аль ч нийгэмд жендэрийн хэвшмэл, сөрөг үзэл нь ГБХ-ийн талаарх ташаа ойлголтоор илэрдэг. ГБХ-ийн талаарх ташаа ойлголт нь энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд саад тотгор болж байдаг. Ялангуяа, ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх салбарт ажилладаг хууль сахиулах, шүүх, цагдаа, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний салбарын ажилтнууд ийм ташаа ойлголт, хандлагатай байх нь ГБХ-ийг улам дэвэрэх, ноцтой үр дагаварт хүргэх аюултайг анхаарах шаардлагатай.

36 мөн хуулийн 6 дугаар зүйлийн §6.4

Ташаа ойлголт 1. Гол буруутан хохирогч өөрөө байдаг.

"Овоо босгоогүй бол шаазгай юунд суух". ГБХ-д түгээмэл өртдөг хохирогч болох хүүхэд, эмэгтэйчүүдэд энэ тайлбар түгээмэл хэрэглэгдэнэ. Эмэгтэйчүүд өөрсдөө л биеэ зөв авч яваагүйгээс, эх байх, эхнэр байх үүргээ биелүүлэхгүйгээс, хүүхдүүд дуулгаваргүй байснаас уурлуулж, шийтгүүлэхэд хүрдэг. Юун түрүүнд асуудалд ингэж хандахдаа бид хуулийн нэн чухал амин сүнс болох хүн бүрийн тэгш эрхийн тухай мартаж, гэр бүлийн харилцаанд нөхөр буюу аавын ноёлох байр суурийг гол болгож, эмэгтэйчүүд зөвхөн үүргээр ачаалагдсан, нөхрийн ая эвийг олж бүхнийг зохицуулах ёстой, гэр бүлд зөрчилдөөн үүсэхэд тэрийг тэгш эрхтэй харилцааны зарчмаар бус, эзэн ноёныхоо арга эвийг олох зарчмаар хандах ёстой гэж үздэгт оршиж байна. Гудамжинд зодуулсан хэн нэгнийг чи л биеэ буруу авч яваад хүнд зодуулсан байж таараа хэмээн буруутгахгүй атлаа нийгмийн бүхий л харилцаанд тэгш эрхтэй оролцож эн тэнцүүхэн явсан хүмүүс орон гэртээ орохоор нэг нь эзэн ноён болж, нөгөө нь ноёны аяар аятайхан байх ёстой нэгэн болж яахан болох билээ.

Хоёрдугаар анхаарах зүйл бол харилцаа нь ямагт хоёр талын оролцогчтой байдгаас үүдэн зөвхөн нэг талын буруу биш, нөгөө талын учир холбогдол заавал байх нь зүй гэдгээс үүдэлтэй төөрөгдөл юм. Өөрөөр хэлбэл, хохирогч заавал тодорхой хэмжээний буруутай байж таарна. Зөрчилдөөн гэдэг нэг нь зүв зүгээр байхад үүсдэг эд биш, тиймээс хохирогчийн энэхүү зөрчилдөөнийг өдөөсөн буруутай үйлдэл, үг яриа байсан л хэрэг гэх хандлага юм. Гэтэл бид зөрчилдөөнийг хүчирхийллийн аргаар шийдвэрлэсэн бурууг энэхүү үзэл, хандлагаар халхлан үлдээж болохгүй юм.

Ташаа ойлголт 2. ГБХ боловсролгүй, харанхуй бүдүүлэг байдлаас үүдэлтэй.

Тоо баримтаас үзэхэд ГБХ нь яс үндэс, шашин шүтлэг, боловсрол, мэргэжил, эдийн засгийн байдал, амьжиргааны түвшингээс үл хамааран нийгмийн бүхий л бүлэг давхаргад үйлдэгдсээр байна. ГБХ үйлдэгчид нь дээр дурдсан шинж байдлаараа харилцан адилгүй байх боловч гагцхүү зөрчилдөөнийг уур бухимдал, хүчирхийллийн аргаар шийддэг байдлаараа, сэтгэл зүйгээ удирдах чадваргүй, хүмүүжээгүй чанараараа адил төстэй юм.

Ташаа ойлголт 3. Хүчирхийлэл үйлдэгч бол сэтгэцийн хувьд эрүүл хүн биш.

"Сэтгэцийн хувьд эрүүл саруул хүн бол хүчирхийлэл үйлдэхгүй, өвчтэй юмнууд л тэгж галзуурч байдаг" гэж хөндлөнгөөс харах үедээ бид бодох нь бий. Гэтэл мэргэжилтнүүд үүнийг үгүйсгэж, хүчирхийлэл үйлдэгчид энгийн үедээ ямар нэгэн гаж зуршилгүй, сэтгэцийн өөрчлөлт ажиглагдахгүй, бусадтай жирийн харилцдаг, энгийн эрүүл саруул хүмүүс байдгийг баталдаг. Гагцхүү харилцааны зөрчилд орсон тэр үедээ нэгэн төрлийн "доторх араатан авир" сэрсэн мэтээр худал авирлаж эхэлдэг байна.

Ташаа ойлголт 4. Гэр бүлийн халуун харилцаа хөрч, бие биедээ хайр сэтгэлгүй болсон хүмүүс хүчирхийлэл үйлддэг.

Гэхдээ зарим нь харин ч эсрэгээрээ "хайртай бол хартай", хардаж харамлах сэтгэл хэтрэхээрээ хүчирхийлэлд хүргэдэг гэх үндэслэлийг ч хэлдэг.Аль ч тохиолдолд буюу хайргүй болсон учраас зодож байгаа юм, эсхүл маш их хайртай болохоор хардаж харамлаад ийм байдалд хүрсэн хэрэг гэх эдгээр тайлбар нь огт үндэслэлгүй юм. Аливаа асуудлыг шийдвэрлэхэд хүчирхийлэл хэрэглэх хувилбарыг сонгосон, хүнийг өөрийн өмч хөрөнгө мэт хандсан түрэмгий хандлагыг зөвтгөх учиргүй билээ.

Ташаа ойлголт 5. Архидан согтуурах нь хүчирхийллийн шалтгаан болдог.

Энэ нь хамгийн өргөн тархсан төөрөгдөл юм. Хүчирхийлэл, архидан согтуурал хоёр нь хүйн холбоотой боловч энэ нь ерөөс хүчирхийллийн шалтгаан биш юм. Удаан хугацааны судалгааны явцад хүчирхийлэл үйлдэгчид ихэвчлэн согтуугаар энэ хэргээ үйлддэг нь түгээмэл боловч үнэн хэрэгтээ эрүүлдээ ч үүнийгээ илэрхийлж тодорхой хэмжээгээр хүчирхийлж байсан байдаг. Согтуурсан үедээ ердөө л хяналтаа илүү хурдан алдаж, илүүтэй түрэмгий догшин болсон байдаг. Мөн олон тохиолдолд хүчирхийлэл үйлдэгч нь огт архи, тамхи хэрэглэдэгүй хүмүүс байдаг. Архи бол ердөө

хүчирхийллийн хурдасгагч, хүчирхийлэл үйлдэхэд шалтаг болдог зүйл юм. Мөн олон хүн архи ууж согтуурсан үедээ ямар нэг хүчирхийлэл үйлдэхгүй өнгөрдөг. ГБХ нь гэр бүлийн гишүүдийн харилцаанд эрх мэдлийн тэнцвэргүй байдал бий болсноос үүсдэг болохоос архидан согтуурснаас аяндаа хийхэд хүрдэг зүйл биш.

Ташаа ойлголт 6. ГБХ сүртэй асуудал биш.

"Ямар ч гэр бүлд маргаан байж л байдаг. Хэрэлдэх, алгадах мэт болоод өнгөрдөг жижиг асуудлуудыг сүртэй зүйл мэтээр дөвийлгэх хэрэггүй" хэмээн олон хүн боддог. Гэтэл ГБХ нь өдөр өдрөөр улам бүр хэрцгий болсоор сүүлдээ хүний амь насанд хүрэх хэмжээний харгислал болдог.

Ташаа ойлголт 7. Нэг л зодсон бол насаараа зодно.

ГБХ-ийг дагасан нэгэн парадокс бол энэ юм. Үнэхээр хүчирхийлэл үйлдэгчийг засаж өөрчлөх гэдэг асар хэцүү ажил хэрэг боловч "төрөлхийн гэмт хэрэгтэн" гэж байдаггүйн адил засрашгүй хүчирхийлэл үйлдэгч гэж байдаггүй. Хүчирхийлэл үйлдэгч асуудал, зөрчлийг хүч хэрэглэх, хянах, дарамтлах аргаар биш ,зөвшилцлөөр шийдвэрлэх аргад суралцаж, хүчирхийлэл хэрэглэхгүй байх шийдвэрийг өөрөө ухамсарлаж гаргасан цагт л хүчирхийлэл зогсоно.

Ташаа ойлголт 8. ГБХ нь гэр бүл байгаа цагт байсаар байх мөнхийн үзэгдэл, түүнтэй тэмцэх нь яг л бороо, цас орохыг болиулахтай адил бүтэхгүй зүйл.

Аливаа гэр бүлд эрт, орой, хэзээ нэгэн цагт үзэл бодол зөрөх, зөрчилдөөн үүсэх асуудал тохиолддог. Гэвч зөрчилдөөнийг хүчирхийллийн аргаар шийдвэрлэх нь зайлшгүй биш тул олон хүүхэд, эмэгтэйчүүдийг сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, нөхөн үржихүйн эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдахаас урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох боломжтойг өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас харж болно.

Ташаа ойлголт 9. ГБХ удамшдаг

"Хүчирхийлэл, хүчирхийллийг төрүүлдэг" буюу хүчирхийлэл үйлдэгчийн хүүхэд хүчирхийлэл үйлдэгч л болно гэх үзэл хандлага байдаг. Хүчирхийлэл нь өөрөө зан үйлээр илэрдэг буюу түүнд суралцах байдлаар хүчирхийлэл үйлдэгч төрдөг болохоос гениэр дамжин удамшдаг, төрөлхийн шинж биш юм. Хэдийгээр гэр бүлийн хүчирхийлэлтэй орчинд өссөн болон өсч байгаа, амьдрал нь хар бараан дурсамжаар дүүрэн байсан ч асуудал, зөрчлийг зөвшилцлийн аргаар шийдвэрлэдэг, эрүүл, хүндэтгэлтэй харилцдаг хэн нэгэн (багш, хөрш, эмээ, өвөө г.м) тухайн хүүхэдтэй учирч, үлгэрлэн нөлөөлсөн тохиолдолд хүчирхийллийн гинжин хэлхээ тасрах боломжтой.

ДЭД СЭДЭВ 3. ГБХ-ийн үр дагавар

Нэгдсэн үндэстний байгууллагын Эмэгтэйчүүдийн байгууллагын мэдээлснээр сүүлийн нэг жилийн хугацаанд 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд нөхөр, хамтран амьдрагчийнхаа зүгээс бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна.[37] Монгол Улсын хувьд гэр бүлийн хүчирхийллийн хор уршигтай холбоотой ноцтой тоо баримтууд бий. 2018 оны байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн тоо 1069 байгаа нь нийт гэмт хэргийн 3 хувийг эзэлж байна.[38] 2010-2016 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэнээр гэр бүлийн хүчирхийллийн улмаас 5411 хүн хохирч, 104 хүн амь насаа алджээ. Хамтрагчийнхаа зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртөн гэмтэл бэртэл авсан эмэгтэйчүүдийн ихэнх нь буюу 71.6 хувь нь хүнд буюу ноцтой бэртэж, таван эмэгтэй тутмын хоёр нь хөнгөн гэмтэл, 5 хувь нь дунд зэрэг гэмтэл, бэртэл авчээ.[39]ГБХ-ийн нэг

37 United Nations Entity for Gender Equality and the Empowerment of Women, COVID-19 and ending violence against women and girls, https://www.unwomen.org/-/media/headquarters/attachments/sections/library/publications/2020/issue-brief-covid-19-and-ending-violence-against-women-and-girls-en.pdf?la=en&vs=5006.

38 Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик – 2018, http://1212.mn/BookLibraryDownloaC.ashx?url=Crime_2018.pdf&ln=Mn, 8 дахь тал.

39 United Nations Entity for Gender Equality and the Empowerment of Women, COVID-19 and ending violence against women and girls, https://www.unwomen.org/-/media/headquarters/attachments/sections/library/publications/2020/issue-brief-covid-19-and-ending-violence-against-women-and-girls-en.pdf?la=en&vs=5006, p.16.

удаагийн үйлдлээс болж айл өрхөд 120.0-450.0 мян төгрөгийн үргүй зардал үүсдэг ба эмнэлэг, хууль хяналтын байгууллагуудын үйлчилгээний зардлыг тооцвол үүнээс ч өндөр тоо гарна. Тиймээс ГБХ нь зөвхөн хувь хүмүүсээс гадна нийгэм, улс орны хөгжил, эдийн засагт хор уршиг учруулсаар байдаг.[40]

ГБХ даамжирснаар хохирогч амиа хорлох, эсхүл хүчирхийлэл үйлдэгчийн амь насыг хороох тухай бодох, төлөвлөх, гүйцэлдүүлэх зэргээр гэмт зан үйлд татагдан орох, итгэл үнэмшил, шашин шүтлэг, өөрийн үнэлэмж, амьдралыг үзэх үзэл, хандлага өөрчлөгдөж буруу зан үйлд суралцах, хүмүүжил, амьдралын зам мөр нь өөрчлөгдөх зэрэг урт хугацаа өнгөрсөн ч залруулж боломгүй сөрөг үр дагаврыг дагуулдаг. ГБХ-ийн үр дагаврыг:

- шууд буюу богино хугацаанд нөлөөлөх,
- шууд бус буюу урт хугацааны гэж ангилан авч үздэг.

Шууд буюу богино хугацаанд нөлөөлөх үр дагавар нь гэр бүлийн хүрээнд нэг орчин, нөхцөлд хамт амьдарч байнгын харилцаатай байдаг дотны хүний зүгээс үзүүлж байгаа бие махбод, сэтгэл зүй, эдийн засгийн хүчирхийлэл нь хохирогч буюу хувь хүнд шууд тусч, өөртөө итгэлгүй болох, эрүүл мэнд нь муудах, нийгмийн идэвхгүй болох, амьдралд итгэл алдрах зэрэг сөрөг нөлөөллийг бий болгодог.

Шууд бус буюу урт хугацааны үр дагавар нь ГБХ-ийн улмаас гэр бүл салах, түүнээс улбаалан хүүхэд өнчрөх, хараа хяналтгүй хүүхдийн тоо олшрох, хүүхэд, эмэгтэйчүүдэд учруулж буй бие махбодын дарамт, хүчирхийлэл нь тэдний бие махбод, сэтгэл зүй, нийгмийн хөгжилд олон янзын сөрөг үр дагавар, хор нөлөө, сэтгэл зүйн гэмтэл авчирдаг.

Хүснэгт 1.2. ГБХ–ийн үр дагавар

Хохирогч	Хүчирхийлэл үйлдэгч	Гэр бүлд	Нийгэмд
• Сэтгэхүйн дарамтанд өртөх; • Өөрийн үнэлэмж буурах • Ганцаардах, ойр дотны нөхөдгүй болох • Хөдөлмөрийн бүтээмж буурах, ажилгүй болох, орлогоо алдах • Хувь хүний хөгжилд сөргөөр нөлөөлөх • Биеийн эрүүл мэнд нь муудах • Бэртэж гэмтэх, хөдөлмөрийн чадвар алдах • Сэтгэлийн хямралд орох • Сэтгэцийн өвчтэй болох (сэтгэл гутрал) • Амиа хорлох • Амиа алдах	• Архидан мансуурах • Амьдралын буруу зан үйлд орох • Гэмт хэрэг үйлдэх, ял шийтгүүлэх, он удаан жил шоронд хоригдох • Аваар осол хийх, орох • Амиа хорлох • Амь насаа алдах	• Гэр бүлийн бүх гишүүд айдас түгшүүрт автах ба энэ нь сэтгэл зүйн хямралд оруулна. • Гэр бүлийн гишүүдийн хооронд эрүүл бус харилцаатай болох. • Хүүхдийн хөгжил, сэтгэл санаанд хүчтэй нөлөөлөх. • Гэр бүлийн харилцаа нь айдас түгшүүрт автах. • Гэр бүлээс хүүхэд нь дайжих, эсхүл сургуулиас завсардах • Гэр бүлийн эдийн засгийн чадавхи буурах.	• Хүн амын хөгжил,нийгмийн эрүүл мэндийн байдалд сөргөөр нөлөөлнө. • Нийгэм эдийн засгийн чадавхид удаан хугацаагаар нөлөөлнө. • Гэр бүл төлөвлөлт, хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлнө. • Гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэгдэх явдал ихэснэ. • Гэр бүл салалт, хүн амын өвчлөлт, архидалт, ядуурал, ажилгүйдэл нэмэгдэнэ г.м.

40 ГБХ-ийн нийгэм, эдийн засгийн өртөг тооцох судалгааны тайлангаас. 2007 он

ГБХ-д өртсөн хохирогч бие махбод, сэтгэл санааны олон талтай хохирол амсаж, энэхүү хүчирхийллийн дараа бүх талаар "эмзэг" байдалтай болж хувирдаг.

АСУУЛТАД ХАРИУЛНА УУ.

1. *Та "эрх мэдэл, хяналт" гэсэн ойлголтыг ашиглан ГБХ-ийг хэрхэн тодорхойлох вэ? ГБХ-ийн онцлог шинжүүд нь юу вэ? ГБХ-ийн битүү тойрог гэж юуг хэлж байна вэ?*
2. *Гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэлд яаж хандах нь зүйтэй вэ?*
3. *ГБХ-ийн талаарх өөр ямар ташаа ойлголтуудыг та мэдэх вэ?*

ГБХ ЯМАР ҮЙЛДЭЛ, ЭС ҮЙЛДЭХҮЙГЭЭР ИЛЭРЧ БОЛОХ ВЭ? ХАРГАЛЗАХ БАГАНАД ЖАГСААН БИЧНЭ ҮҮ!

Бие махбодын	Бэлгийн хүчирхийлэл	Сэтгэл санааны хүчирхийлэл	Эдийн засгийн хүчирхийлэл

1.3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ, ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧ

ДЭД СЭДЭВ 1. ГБХ–ийн хохирогч, түүний зан үйл

"Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч" гэж ГБХ-ийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг[41] ойлгохоор ГБХТтХ-д заасан.

Сүүлийн жилүүдэд, олон улсын түвшинд "ГБХ-ийн хохирогч" хэмээх нэр томъёог "хүчирхийллийг даван туулагч" хэмээн нэрийдэх болсон. Энэ нь хүчирхийлэлд өртсөний дараах бүхий л үйл явц нь хүчирхийллийг даван туулах процесс гэж үзэх болсонтой холбоотой юм. ГБХТтХууль болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнууд "хохирогч" нэр томъог хэрэглэдэг тул энэхүү Гарын авлагад мөн тодорхойлж байна.

ГБХ-ийн хохирогч нь нэг гэр бүлийн харилцаатай байгаа, эсхүл хувийн дотно харилцаатай байсан аль ч насны, аль ч хүйсийн хүн (үүнд бэлгийн цөөнх буюу ЛГБТИК хүмүүс мөн адил хамаарна) байж болох авч, бие физиологи, нөхөн үржихүйн онцлог, нийгмийн хандлага, тогтсон уламжлал зэрэг олон олон хүчин зүйлстэй холбоотойгоор хохирогчдын 90 орчим хувь нь эмэгтэйчүүд байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэл нь бусад харгис хүчирхийллийн үйл явдал шиг хохирогчийн хувьд асар их хор хөнөөлтэй сэтгэл зүйн үр дагавартай байж болно. Дараах 2 хам шинж нь хамгийн нийтлэг илэрдэг[42]. Үүнд:

1) Гэмтлийн дараах стресс эмгэг (ГДСЭ)
2) Бэлгийн хүчирхийллийн гэмтлийн хам шинж (БХГХШ) юм. Эдгээрийн аль аль нь маш ноцтой бөгөөд харгалзах шинж тэмдгүүдийг хянаж байх шаардлагатай.

41 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл, §5.1.2.
42 http://www.hotpeachpages.net/camerica/belize/DomesticViolenceTrainingManual.pdf

Байгалийн гамшиг, автомашины осол, бэлгийн хүчирхийлэл зэрэг эрүүл мэнд, амь насанд аюултай үйл явдалд өртөж, даван туулсны дараа үүсч болох сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг ГДСЭ гэж ойлгож болно. ГДСЭ-ийн шинж тэмдгүүд нь үйл явдлын дараа аль ч үед үүсч болох бөгөөд ноцтой асуудал нь хохирогчийн нөхцөл байдлыг даван туулах чадварыг алдагдуулдаг. ГДСЭ-ийн шинж тэмдэг нь хүн бүрд харилцан адилгүй байдлаар илэрнэ[43]. Гол шинж тэмдгийг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

1) Үйл явдлыг эргэн санах (Дахин учрах шинж тэмдэг гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл хүнд, ноцтой үйл явдлын үед эргэн очсон мэт мэдрэмж төрөх)
2) Үйл явдлыг эргэн сануулах нөхцөл байдлаас зайлсхийх
3) Сөрөг итгэл үнэмшил, мэдрэмжид автах
4) Сэтгэлийн зовиуртай, тайван бус байх

ГДСЭ-т өртсөн эсэхийг тодорхойлох шалгуур нь:

- юу ч мэдрэхгүй байх, бусдаас зай барих, жишээ нь, алмайрсан байдалтай байх;
- ойлгох, ухаарах чадвар муудах
- Нойргүйдэлд хүрэх, тухайлбал хүнд, ноцтой үйл явдлын чухал хэсгийг санахгүй байх;
- хүнд, ноцтой үйл явдлыг зураглан бодох, зүүдлэх, үйл явдал байнга бодогдох, хий юм харах, хүчирхийллийн үед мэдэрсэн мэдрэмж сэргэж, сэтгэлийн зовиур хөндөх зэргээр дахин мэдрэх
- хүнд ноцтой үйл явдлын тухай дурсамжийг сэдрээдэг зүйлсээс байнга зайлсхийх
- санаа зоволт болон өдөөгч хүчин зүйлсийн шинж тэмдэг, Тухайлбал: унтаж чадахгүй байх, амархан уурлаж хилэгнэх, анхаарал сайн төвлөрөхгүй байх, хэт болгоомжлох, хэт цочимтгой болох, байнга тайван бус байх шинж илрэх[44] зэрэг болно.

БХГХШ нь ихэнх бэлгийн хүчирхийллийн хохирогчдод илэрдэг сэтгэл зүйн болон бие махбодын нийтлэг шинж тэмдэг, хариу үйлдлийн нийлбэр цогц юм. Халдлага, эсхүл бэлгийн хүчирхийлэл нь маш богино хугацаанд болоод өнгөрсөн мэт санагдаж болох авч дийлэнх тохиолдолд энэ нь саажилт үүсгэх боломжтой байдаг. Хохирогчийн болсон явдлыг даван туулахыг оролдох нөхцөл байдал нь БХГХШ-ийг үүсгэж болно. Энэ нь урт болон богино хугацааны шинж тэмдгүүдийн аль алинаар нь илэрдэг байна [45]. Үүнд:

a) Богино хугацааны (хурц) шинж тэмдэг
   - Хурц илрэл
   - Айдас, уур хилэн, түгшүүр зовнил;
   - Цурхиран уйлах, тайван бус байх, инээх (хөхрөх), төвлөрөх чадваргүй байх, тарчлахг.м
   - Хяналттай илрэл
   - Нуугдмал мэдрэмж
   - Биеэ авч явах байдлаа хянаж, тайван байх

b) Урт хугацааны (архаг) шинж тэмдэг:
   - Амьдралын хэв маягийн өөрчлөлтүүд (оршин суух газар, утасны дугаар, ажлын байр, дадал зуршлаа өөрчлөх)
   - Үйл явдлыг эргэн санах, хүчирхийлэгчтэй дүрээ солих г.м-ээр хар дарж зүүдлэх;
   - Олон зүйлээс айх айдастай байх. Тухайлбал, хүмүүст үл итгэх, ганцаараа байхаас айх г.м
   - Бэлгийн амьдралын өөрчлөлт;
   - Харилцаа холбооны өөрчлөлт (Харилцдаг найз нөхөд, гэр бүл болон бусдад итгэх итгэл буурч, өөрийгөө хүндлэх үнэлэмж буурах)[46] зэрэг болно.

ГБХ-д өртсөн хохирогч бие махбод, сэтгэл санааны олон талтай хохирол амсаж, энэхүү хүчирхийллийн дараа бүх талаар "эмзэг" байдалтай болж хувирдаг. Чухам ямар байдлаар энэхүү "эмзэг" байдлууд бий

43 https://www.ptsC.vA.gov/public/ptsd-overview/basics/what-is-ptsC.asp
44 http://www.hotpeachpages.net/camerica/belize/DomesticViolenceTrainingManual.pdf
45 http://www.hotpeachpages.net/camerica/belize/DomesticViolenceTrainingManual.pdf
46 http://www.hotpeachpages.net/camerica/belize/DomesticViolenceTrainingManual.pdf

болдог талаар авч үзье.

Стокгольмын синдром

Анх Стокгольм хотын нэгэн банкийг дээрэмдэх үед барьцаалагдсан хүмүүс хожим суллагдаад чухам ямар нөхцөл байдал мэдрэгдэж байсан талаар дэлгэрэнгүй хэлэлцэнтэй холбоотойгоор ийнхүү нэрлэх болсон гэдэг. ГБХ-ийн хохирогч яг л тэрхүү барьцаалагдсан хүн шиг нөхцөл байдалд ордог бөгөөд:

- Амьдрал үхлийн дэнсэн дээр байгаа мэт санагдаж;
- Зугтах боломжгүй гэдэгт итгэж;
- Хүчирхийлэл үйлдэгч нэгэн бодлын өөрт нь сайнаар хандаад байгаа мэт сэтгэгдэл төрж;
- Гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлагдсанаа мэдэрч байдаг ажээ.

Уг синдром хохирогчоос гадна хүчирхийллийн гэрч болсон хүүхдэд мөн ажиглагддаг.

Хамааралт харилцаатай болох

Нийгмийн хүрээллээс тусгаарлагдаж, бие даасан байдал нь үгүй болоход хохирогч гэр бүлийн харилцаанаас шууд хамааралтай болдог. Өөрөөр хэлбэл энэ үед хохирогч өөрийн үзэл бодол, хэрэгцээг үл харгалзан, зөвхөн хүчирхийлэл үйлдэгчийн үзэл бодол, хэрэгцээ, шаардлагыг чухалчилж үздэг. Хүчирхийллийн хэлбэр, хэрцгийлэл дээд цэгтээ хүрэхэд хохирогч амьдрах хүсэлгүй болж, амиа хорлох оролдлого хийх нь ч бий. Энэ тохиолдолд эмэгтэйчүүд ихэвчлэн үр хүүхдийнхээ төлөө амьд явж байдаг бол хүчирхийлэл удаан хугацаагаар үргэлжлэх тусам хүүхдээ ч хамгаалахаа больж, нөхцөл байдалтай эвлэрдэг байна.

Даван туулахыг оролдох

Хүчирхийллийг зогсоож амь гарахыг хүссэн хохирогч нөхцөл байдлыг өөрчлөх өөрийн гэсэн арга барилыг сонгох нь бий. Энэ арга барил нь зөрчилдөх, эсхүл ойлголцох гэсэн аль нэг байдлаар өрнөнө. Хохирогч энэ тохиолдолд идэвхтэй байж асуудлыг шийдвэрлэх арга зам олохыг эрмэлзэж байдаг. Заримдаа энэ хоёр хэв шинж давхар байж болох боловч хүчирхийлэл үйлдэгч хохирогчид бүрэн хяналтаа тогтоосон үед тэмцэлдэхээсээ илүүтэй бууж өгч аяар нь байх замыг сонгодог байна.

Эргэн дайрах

Эмэгтэйчүүд өөрт нь болон үр хүүхдэд нь бодитой аюул заналхийлж байна гэж үзсэн үедээ хүчирхийлэл үйлдэгч рүү эргэн дайрч, довтлон гэмтээх нь бий. Хүчирхийлэл үйлдэгч бие махбодын хохирол амссан гэж үзвэл цагдаад хандаж болох юм. Хүчирхийлэл үйлдэгчийн амь насанд хүрэх тохиолдол ч байна. Шүүхийн практикаас үзэхэд эр нөхрийнхөө амийг бүрэлгэсэн эмэгтэйчүүд удаан хугацаанд түүний хүчирхийлэл доор даван туулж байсан байдаг бөгөөд амь насаа хамгаалах гарцаагүй нөхцөл байдалд орсон эмэгтэйчүүд ийм гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байгаа юм[47].

Аажим шатах хариу үйлдэл

Гэр бүлийн хүчирхийлэлд удаан хугацааны туршид өртөн шаналж, сэтгэл санааны хүнд байдалд байсны эцэст огцом хариу үйлдэл үзүүлэх нь бий. Ийм хариу үйлдэл нь зөрчилдөөнийг улам хурцатгаж хохирогчийн амь нас эрсдэх эсхүл хүчирхийлэл үйлдэгчийн амь нас эрсдэх нөхцөл байдалд ч хүргэж болзошгүй. Линклэйтэрс байгууллагын гаргасан судалгаагаар 2012 оны хувьд гэр бүлийн харилцааны хүрээнд үйлдэгдсэн хүний амь насыг алах гэмт хэргийн хохирогчдын гуравны хоёр нь эмэгтэйчүүд байсан бөгөөд эдгээрийн 47 хувь нь нөхөр эсхүл хамтран амьдрагчийнхаа гарт амиа алдсан байна.[48]

Нөгөө талаас хохирогчийн зүгээс гаргаж буй хариу үйлдлийн улмаас хүчирхийлэл үйлдэгч амь насаа алдах тохиолдол байж болно. Энэ үйлдэл нь хүчирхийлэл үйлдэгчээс гарч болзошгүй гэсэн дараагийн илүү ноцтой хүчирхийллээс айж эмээсэн сэтгэхүйгээс болж үйлдэгддэг бөгөөд зарим улс орон эрүүгийн хууль тогтоомждоо өөрчлөлт оруулж, энэ шалтгааны улмаас үйлдэгдсэн

47 Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй тэмцэхэд анхаарах зарим асуудал. http://criminology.mn/print.php?id=143&lang=1

48 Linklaters and Penal Reform International, Women who kill in response to domestic violence: How do criminal justice systems respond?, 2016, https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2016/04/Women_who_kill_in_response_to_domestic_violence_Full_report.pdf, p.4.

гэмт хэрэгт ногдуулах эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх асуудал ч өргөн хэлэлцэгдэж байна.

Ялгаварлан гадуурхалтын олон хэлбэрт өртдөг ГБХ-ийн хохирогч

Эмэгтэйчүүдийн эрхийг зөрчсөн, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн ихэнх тохиолдолд хүйсийн ялгаатай байдал болон хувь хүнийг тодорхойлох шинжтэй бусад хүчин зүйлүүдийн хооронд ихээхэн ээдрээтэй, дам шинж бүхий хавсарсан ялгаварлал үүсдэг. Тухайлбал, арьсны өнгө, үндэс угсаа (жишээ нь "энэ казакууд эвгүй хүмүүс" гэж хэлэх), хэл (жишээ нь "хазгай хэлтэй юмнууд" гэж хэлэх), шашин шүтлэг (жишээ нь "энэ христийн шашныг дагасан юмнуудаас юу ч гарч мэднэ" гэж хэлэх), нас, эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл (жишээ нь "иймэрхүү хэлгүй, дүлий юмнууд ийм л байгаа шүү дээ" гэж хэлэх), бэлгийн чиг баримжаа (жишээ нь "энэ ижил хүйстнээ сонирхдог гаж донтой юмнууд" гэж хэлэх), хот хөдөөгийн ялгаа (жишээ нь "энэ хөдөөнийхөн олигтой байхгүй ээ" гэж хэлэх), нийгэм, санхүүгийн байдал, улс төрийн байр суурь зэрэг олон хүчин зүйлсээр хавсарсан ялгаварлан гадуурхалтад өртдөг байна. Олон төрлийн гадуурхалтад өртөх нь хохирогчийг маш эмзэг байдалд оруулдаг бөгөөд энэ нь хохирогчид сэтгэл зүйн дарамтад орох зэрэг сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй байдаг.

ДЭД СЭДЭВ 2. ГБХ үйлдэгч, түүний зан үйл

ГБХ-ийн ихэнх үйлдэл нь өдөр тутмын зөрчилдөөн, гэр бүлийн дотоод таагүй уур амьсгалаас үүдэлтэй мэт харагдавч асуудал, зөрчлийг хүч хэрэглэн шийдвэрлэх, бусдыг хяналтдаа байлгах, хамааралд оруулах гэсэн хүчирхийлэл үйлдэгчийн сэдэл тактикаас үүдэлтэй.

Хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлөх хүчин зүйлс

Хардалт, айдсаас үүдэлтэй хүчирхийлэл

Хүчирхийлэл үйлдэгч ямагт айдастай байдаг. Тухайлбал, эхнэр, найз бүсгүй нь өөрөөс нь өөр хүнийг харах вий, өөрийг нь үл ойшоох вий гэх мэт "зөвхөн минийх учраас зөвхөн над руу чиглэсэн байх ёстой" гэсэн хандлага нь эмэгтэйчүүдийг "өмч" мэт авч үзэхэд хүргэдэг. Үүнийгээ гүйцэлдүүлэхийн тулд эрх чөлөөг нь хязгаарлаж, хүслээр нь байхгүй болмогц хүчирхийлэл үйлдэж эхэлдэг.

Эрэгтэй хүмүүсийн зүгээс "Эхнэр нь хаяж явах гэж байна" гэсэн айдас нь хүчирхийллийг нэмэгдүүлдэг. Нэгэн судалгаанд гэр бүлийн хүчирхийллийн улмаас амь насаа алдсан эмэгтэйчүүдийн 85 хувь нь хүчирхийлэлт харилцааг тасалж, салахыг оролдсон байдаг тухай дурджээ.[49]

Өдөр тутмын зөрчил

Хүчирхийлэл үйлдэгч өөрийн хүссэн амьдралын хэв маягийг тогтоох гэдэгтэй холбоотой байдаг. Энэ тохиолдолд бүх зүйл хүчирхийлэл үйлдэгчийн хүсэл зоригт захирагдах ёстой бөгөөд хүчирхийлэл байнга үйлдэгдэж байдаг. Тухайлбал, хүүхдүүд дэггүйтсэнээс, эхнэр нь ээж байх, эхнэр байх үүргээ биелүүлээгүйгээс хүч хэрэглэхэд хүргэсэн гэх мэт.

Эрэгтэй хүний сул дорой зангийн хариу

Зарим тохиолдолд эхнэрийнхээ цалин мөнгөнөөс бүрэн хамааралтай юм уу, өөрөө илүү мөнгө олдог ч бай ажилдаа амжилт гаргаж байр суурь олж авч чадахгүй байгаа, эрх мэдэл, баялагт хүрч чадахгүй байгаа эрчүүд гэртээ хүчирхийлэл үйлдэж энэ бүхнээ орлуулж сэтгэл ханамж авах нь бий. Ингэхдээ эмэгтэйн эрх чөлөөг хязгаарлах, бие махбодын хүчирхийллийн хоёр хэлбэрийг хавсран хэрэглэж байдаг.

Хохирогчийг буруутгах хандлага

Энэ бол нийгэмд тун тархсан хандлага бөгөөд эмэгтэй өөрийн хийсэн үйлдлийн хариуд хүчирхийлэлд өртсөн гэж боддог. Ингэснээр эмэгтэй нь хоёр утгаар хохирогч болж байна. Үүнд:

- Хүчирхийллийн хохирогч
- Хүчирхийллийг өдөөсөн гэсэн буруушаалтын хохирогч (нөхөртөө хоол хийж өгөөгүй, хэт богино даашинз өмссөн, нөхөртөө үнэнч байгаагүй гм).

49 National Institute of Justice Journal, Intimate Partner Homicide, Issue no. 250, 2003, https://www.ncjrs.gov/pdffiles1/jr000250.pdf, p.6

Эрх мэдэл, хяналтаа тогтоох

Ихэнх хүчирхийлэл үйлдэгчид гэр бүлийн харилцаанд нөхрийн эрх мэдэл, давуу байдал тогтож байх учиртай, дэг журмыг тогтоохын тулд эхнэрийг "сургаж өгөх" хэрэгтэй гэсэн итгэл үнэмшил бат төлөвшсөн байдаг. Ер нь хүний амьдралд гэр бүлийн, нийгмийн, хувь хүмүүс хоорондын шинжтэй олон асуудал үүсэн гардаг бөгөөд үүнээс зайлсхийх аргагүй. Үүнтэй адилаар уг харилцааны явцад зөрчил гарах нь дамжиггүй. Хүн бүр харилцан адилгүй зан чанар, онцлогтой тул аливаад хандах хандлага, өнцөг харилцан адилгүй. Иймд хүний амьдрал нь санал зөрөлдөөн, зөрчилдөөнөөс ангид байх бололцоогүй. Харин энэхүү зөрчил мөргөлдөөн, санал зөрөлдөөнийг хүчирхийллийн аргаар бус, харин тайван замаар, харилцан ойлголцож эв зүйгээр шийдвэрлэх боломжтой. Гэтэл хэн нэг нь эрх мэдэл, хүч чадлаа ашиглаж, нөгөөгөө хянах, эрх чөлөөг нь хязгаарлаж хясах, дарамтлах зэргээр ашигласнаар энэ нь хүчирхийлэл болж хувирдаг. Зарим тохиолдолд хүчирхийлэл үйлдэгч нь өөрөө ч хэзээ яагаад бусдыг дарамталсан, хяналт тогтоосноо тодорхой тайлбарлаж мэдэхгүй байх нь бий. Гэр бүлийн хүчирхийллийн хувьд ч гэр бүлийн хамааралт харилцаанд байгаа хүндээ хяналтаа тогтоох зорилго, эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь ГБХ-ийн суурь шалтгаан болдог.

Хүчирхийлэл үйлдэгчийн тактик

Эрхшээлдээ оруулах

Хохирогчидтой удаан хугацаанд хамтран ажилласан мэргэжилтнүүдийн нотолж буйгаар ГБХ нь дэс дараалсан олон жижиг үйлдлээс бүрдсэн хүчирхийллийн үргэлжилсэн үйл явц ажээ. Яг л хорих ангид заналхийлж, эрүүдэн шүүхтэй, террористууд хүн барьцаалсантай адил гэж болохоор. Ялгаа нь гэвэл энэ бүхэн хаалттай хаалганы цаана, хэн ч сэрдэхээргүй жирийн нэг айлын гэрт болж байдаг. Хүчирхийллийн аль ч хэлбэрийг ашиглаад хохирогчийг эрхшээлдээ оруулж болох ба хохирогч зугтах боломж байсан ч эдийн засгийн хараат байдлаас, эсхүл ойр дотны хэн нэгэнд нь аюул, эрсдэл учрахаас айснаас, бусад ямар нэгэн аюултай үр дагавар заналхийлж буйгаас болоод хүчирхийлэл үйлдэгчийн эрхэнд орж түүний бүрэн хяналтанд байна. Энэ байдал нь хүчирхийлэл үйлдэгч, хохирогч хоёрын харилцаа тун онцгой гэдгийг харуулж байгаа бөгөөд хохирогчийн амьдралд хүчирхийлэл үйлдэгч хамгийн гол хүн нь байдаг. Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг бүрэн өөрийн эрхшээлд байлгахыг зорьдог.

Тарчлаан зовоох

Хүчирхийлэл үйлдэгчдийн дараагийн түгээмэл хийдэг үйлдэл бол хохирогчийг эрхэндээ байлгахын тулд тарчлаан зовоох юм. Үргэлжилсэн, дэс дараатайгаар хохирогчийг айдаст автуулж өөрийн эрхшээлд байлгасны үр дүнд хохирогч байнгын айдас түгшүүрт автаж, хүчирхийллийн эрхшээлээс хэзээ ч гарахгүй, түүнийг дийлэх юу ч байхгүй гэсэн итгэл үнэмшилтэй болж хүлцэн дагахаас өөр гарцыг харахаа больдог. Тодорхой хугацааны дараа бие махбодын хүчирхийлэл эхэлнэ. Өмнө нь яаж хүчирхийлж байсныг нь бодоод "ахиж тэгнэ шүү" гэж сүрдүүлээд байхад хохирогч өөрийн эрхгүй байнгын айдас түгшүүрт автдаг. Хүчирхийлэл үйлдэгч хүч хэрэглэх, уурлаж уцаарлах тохиолдол гаргахгүй байж болох бөгөөд энэ байдал нь түүнд юунд ч дийлдэшгүй, эсэргүүцээд ч нэмэргүй мэт хүчирхэг мэдрэмж төрүүлдэг байна. Үүгээр ч зогсохгүй тэрээр хохирогчийг амьд үлдээсэнд нь талархаж явахыг шаардана.

Тусгаарлах

Хохирогчийг гэр бүл, эцэг эх, найз нөхөдтэйгөө уулзахыг нь хориглох, тэдний талаарх сөрөг байр сууриа байнга илэрхийлэх зэргээр бүхий л гадаад харилцааг нь таслан тусгаарлах үйлдлээр илэрнэ. Хохирогчийн найз нөхөд, ойр дотны хүмүүстэй нь хэдэр бүдүүлэг харилцдагаас тэдгээр хүмүүс нь төвөгшөөн, хохирогчоос харилцаагаа тасалж эхэлдэг. Улмаар хохирогчийг ажил дээрээ удаан саатахад нь дургүйцэх, эсхүл байнга ажил дээр нь ирж хянаж, цагдах зэргээр үргэлжилсээр хохирогчийг нийгмийн ямар ч хүрээлэлгүй болгож, аажимдаа хүчирхийлэл үйлдэгчээс өөр харилцах, итгэж найдах, тусламж авах хүнгүй болгон нийгмийн харилцаанаас тусгаарладаг.

Бодит байдлыг ялгаж салгах чадваргүй болгох

Хүчирхийлэл үйлдэгч дандаа хүч хэрэглээд байдаггүй. Хэрцгий түрэмгий үе нь "өгөөмөр" сайхан үеэр солигдож, хохирогчид болон хөндлөнгөөс харж буй бусдад "асуудал өөр зүйлээс болсон, түүнийг нь шийдчихвэл бүх зүйл сайхан болно" гэсэн итгэл, найдварыг төрүүлж байдаг. Үүнээс шалтгаалан хохирогч хүчирхийлэл үйлдэгчээс салж чадахгүй эргэлзэх, "түүний" эелдэг, сайхан байдаг үеийг санаж, хүчирхийлэлтэй харилцааг тэвчсээр байдаг. Гэтэл хүчирхийлэл үйлдэгч энэ аргыг зөвхөн хохирогчийг өөрөөсөө явуулахгүй эрхшээлдээ байлгах арга болгон ашиглаж байдаг.

Сул дорой болгох

Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийн бие бялдар, сэтгэлийн тэнхээг барж, байнгын айдас, дарамт, эрхэндээ байлгахыг хичээдэг. Жишээлэхэд, нойр муутай олон хоног явуулах г.м.

Гүжирдэх

Байнгын гүжирдлэг, доромжлолд байгаа хүний өөртөө итгэх итгэл буурдаг. Хүчирхийлэл үйлдэгч боломж гармагц хохирогчийг ямар нэг зүйлд буруутгаж, гэм буруутай мэт сэтгэгдэл төрүүлэх замаар өөрийн эрх мэдэл, хяналтаа тогтоодог. Хохирогч үүнийг нь эрхшээлдээ оруулах арга гэж ойлгодоггүй бөгөөд өөрийгөө буруутган, өөртөө итгэх итгэлээ алддаг байна.

Хүүхэд ашиглах

Сүүлийн үед судлаачид насанд хүрсэн хохирогчийг хяналтандаа байлгахын тулд хүүхэд ашиглах гэсэн шинэ төрлийн хүчирхийллийн тактик гаараад буйг онцлох болсон. Хүүхдийг зодох, бусад хэлбэрээр хүчирхийлэх, хүчирхийлэхээр заналхийлэх, гэр бүлийн харилцаан дахь зөрчилдөө хүүхдээ хохирогчийн эсрэг турхирах, хүүхдээ хохирогчийн эсрэг хүч хэрэглэхийг хатгах, хүүхдийг барьцаалах, барьцаалахаар сүрдүүлэх, хулгайлах, авч зугтах, төөрүүлэх, хүүхдийн эрүүл мэндийг хохироох, хүүхэд дээрээ ирэх нэрээр хохирогчийн цагдан хянах, "хүүхдээ хаяад ажил хийдэг муу ээж" гэх мэт үг хэллэгээр дарамтлах зэргээр илэрнэ.

ДЭД СЭДЭВ 3. ГБХ ба хүүхэд

Хүүхэд хүмүүжлийн эхний хичээлээ гэр бүлээсээ авдаг. Гэр бүлийнх нь амьдрал, хүмүүсийн байр байдал, хоорондын харилцаа нь хүүхдэд ямар нэгэн эргэлзээгүйгээр шууд дагах мөрдлөг, амьдралын суурь зарчим болдог. ГБХ хүүхдийн эсрэг шууд чиглэж, тэдний сэтгэл санааны эрүүл саруул, амар амгалан байдлыг алдагдуулж, өмнө өгүүлсэн "эмзэг" нэгэн болгодог. Нийгмээс суралцахуйн онолын дагуу нүдээрээ харж, биеэрээ туулсан тэрхүү ГБХ нь хүүхдэд амьдралын туршлага болж өвлөгдөх аюултай.

ГБХ-ийн дунд өссөн хүүхдийн хувьд өмнө нь "ГБХ-ийн гэрч", "дуугүй гэрч" гэсэн нэр томьёог хэрэглэж ирсэн. Харин сүүлийн үед "хүчирхийлэлд дам өртөгч", "ГБХ дунд өссөн хүүхэд", "ГБХ амсаж өссөн хүүхэд" гэх нэр томьёог хэрэглэх болсон байна. Энэхүү нэр томьёоны өөрчлөлт нь хүүхдийн бодит байдлын талаарх бидний хандлага хэрхэн өөрчлөгдөж байгааг илэрхийлж байдаг. Анхлан "үйл явдлын талаар мэдэх хөндлөнгийн нэгэн, ердөө л хүчирхийллийг харсан гэрч" гэж хүүхдийг үздэг байсан нь нууц биш. Харин практик энэхүү "гэрч" өөрөө тэрхүү хүчирхийллийг ямар зовиур шаналал амсаж, хүчирхийлэлд дасал болж, өөрийгөө үнэлэх үнэлэмж нь унаж, эцэг, эхээ хүндлэн хайрлах сэтгэл үгүй болж байдгийг харуулсан учраас, мөн хүүхэд тэрхүү

хүчирхийллийн үйл явцад шууд оролцогч нь болж, зөрчилдөөнтэй асуудлыг шийдвэрлэх арга туршлагаа тэндээс олж авч байдгийг мэдсэн учраас ийнхүү өөрөөр томьёолох болсон байна. ГБХ дунд өссөн хүүхдийг дараах 3 хэв маягт хувааж болдог. Гэхдээ энэхүү 3 хэв маяг нь заавал тус тусдаа байх албагүй бөгөөд нэг хүүхдийн хувьд хэд хэдэн хэв маяг хавсран байж болохыг анхаарах нь зүйтэй.

Эхний хэв маягт шууд өөрөө хүчирхийллийн золиос болсон буюу бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийллийн хохирогч хүүхдүүд хамаарна. Хүүхдийг өөрийн эрхшээлд байлгах зорилгоор хүчирхийлэл үйлдэх нь түгээмэл үзэгдэл бөгөөд эцэг, эх нь хүүхдээ буруу зүйл хийсний төлөө шийтгэх ёстой гэсэн нэрийн доор халхавчлан өөрийн хүслээр байлгах гэсэн хүчирхийллийг зөвтгөж, гэр бүл, ахуйн хүрээний байх ёстой л харилцаа мэтээр үнэлж өнгөрөөдөг, ихээхэн нуугдмал хүчирхийллийн хэлбэр юм. Хүүхдийн эсрэг энэхүү хүчирхийлэл насанд хүрсэн хохирогчийн эсрэг хүчирхийлэлтэй хамт үйлдэгдэх нь ч түгээмэл тохиолдоно. Тэр ч бүү хэл эцэг, эх нь өөрсдийн хоорондын зөрчилдөөний золиос болгож нэг нь нөгөөдөө дам байдлаар дарамт, сүрдүүлэг үзүүлэх зорилгоор ямар ч гэмгүй хүүхдэд хүч хэрэглэх нь бий. АНУ-ын судлаачид эхнэр, хамтран амьдрагчаа хүчирхийлж буй эцэг нь хүүхдэд илүү харгисаар хүч хэрэглэдэг болохыг тогтоосон байна. Австралид нэгэн эр эхнэр нь салсны улмаас түүнээс өшөө хорслоо авах зорилгоор хоёр хүүхдээ өөрийн хамт дэлбэлж хөнөөсөн тохиолдол,[50] мөн Англид мөн адил гэр бүлийн дотоод таагүй уур амьсгалын улмаас эхнэр, охиноо өөрийн хамт буудаж хөнөөсөн тохиолдлыг нэрлэж болно[51].

Хүйсээр нь авч үзвэл гэр бүл дэх эмэгтэй хүүхдүүд хүчирхийллийн хохирогч болох нь илүүтэй бөгөөд гэр бүлдээ бие махбодын хүчирхийлэлд өртдөг охид бэлгийн хүчирхийлэлд давхар өртөх магадлал 7 дахин өсдөг нь судалгаагаар нотлогджээ.

Хоёр дахь хэв маяг эхнийхтэй нилээд төстэй боловч хүчирхийлэл үйлдэгчийн зорилго болон эцсийн объект өөр хүн байдаг онцлогтой. Олонх тохиолдолд хүчирхийлэл үйлдэгч хэн нэгнийг эрхшээлдээ оруулахын тулд хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж золиосоо болгодог. Ялангуяа, эмэгтэйчүүдийг айлгаж эрхшээлдээ байлгахын тулд хүүхдэд нь бие махбодын, сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх нь элбэг тохиолдоно. ГБХ-ийн гол шинж нь бусдыг эрхшээлдээ байлгах зорилго байдаг бөгөөд энэ удаад эрхшээлдээ байлгахыг зорьж буй хүн нь хүүхэд биш түүний эх, ойр дотны хүн нь байдаг.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн гурав дахь хэв маяг нь дам байдлаар хүчирхийлэлд өртөж буй буюу шууд өөрийх нь эсрэг чиглээгүй хүчирхийллийг хөндлөнгөөс харж, мэдэж буй нөхцөл байдал юм. Өмнө өгүүлсэнчлэн хүүхэд нь ийм төрлийн хүчирхийлэлд ердийн гэрч огтоос биш байдаг бөгөөд хайртай, дотны хүнийх нь эсрэг, чухам юу болоод буй учрыг нь тодорхой мэдэх нөхцөл байдал, өөрийнх нь хамгийн аюулгүй байх ёстой тэр орчинд үйлдэгдэж байгаа тул хүүхэд ямагт ГБХ-ийн хохирогч нь байдаг. Гурав дахь хэв маягийн хүчирхийллийн хувьд хүүхэд сэтгэл санааны хохирол илүү амсана. Ерөөс дээрх 3 хэлбэрийн алинд ч хүүхдэд сэтгэл санааны хохирол заавал учирч байдаг.

ГБХ-ийн явцад хүүхдийн хожмын өсөлт бойжилтод хортой нөлөөлөх гэмтлүүд ихээр учирдгаас гадна нас бие гүйцсэн хүнтэй харьцуулахад амь насаа алдах эрсдэл 2 дахин өндөр байдаг нь мөн л судалгаагаар нотлогдсон үнэн юм. ГБХ хүүхдийн зан төлөвт шууд атлаа хүйсийн хувьд ялгавартай байдлаар нөлөөлдөг. Хүчирхийллийн орчинд өссөн эрэгтэй хүүхэд гол төлөв түрэмгий зан авиртай болж өсдөг бол эмэгтэй хүүхдүүд өөртөө итгэлгүй, амьдралын зорилгогүй, аливаад дур сонирхолгүй нэгэн болж төлөвшдөг ажээ.

50 Daily Mail, Harrowing details emerge about how an evil dad killed his two kids by blowing them up in horrific murder-suicide to punish his wife for their marriage breakdown - as his sick final Facebook post is revealed, https://www.dailymail.co.uk/news/article-8176377/Sick-details-emerge-evil-dad-killed-two-kids-explosion.html?fbclid=IwAR22IQSr9NffV7CzfbLs1QzZxzgjXun70ttPzovEpH_pehvIcJex4MuRLgI, Сүүлд үзсэн: 2020.06.24

51 The Express, Father who killed wife and daughter then shot himself left note saying 'Karma is a b****', (Oct 27, 2016), https://www.express.co.uk/news/uk/725928/Father-killed-wife-daughter-shot-himself?fbclid=IwAR1gPzoyBr6gCuFnXQ7imPR5pCZztt5CYScdE9N2od-7Z64L0qp-wO3UdwfY, Сүүлд үзсэн 2020.06.24

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хэрхэн таних вэ?

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн шинж тэмдэг	Эрүүл мэндийн өөрчлөлт	Сэтгэл зүйн онцлог	Нийгмийн онцлог
Бие махбодын гэмтэл авсны улмаас: • бөөлжих • толгой нь эргэх, юм санахгүй байх, • бага насны хүүхдийн хувьд татаж унах • нүдний аяга улайх Бие бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд: • зан байдал тогтворгүй болж цочих • хүнээс зугтах, нуугдах, • гөлрөх, ямар ч зүйлийг сонирхохгүй байх Аажимдаа дараах шинж тэмдгүүд илэрнэ: • Өсөлт зогсох, турах • Хөлд орохгүй байх, хэлд удаан орох, инээхгүй байх • Хичээлдээ хоцрогдох • Хуруугаа хөхөх, хумсаа мэрэх, гар хангалга хийх зэрэг муу зуршилд автах • Дүйнгэ гөлөрсөн харцтай болох, эмх цэгцгүй хувцаслах, ариун цэвэр сахихгүй байх, биеэс нь таагүй үнэр үнэртэх, царай цонхигор болох г.м.	• Хөнгөн, хүндэвтэр, хүнд зэргийн гэмтлүүд учрах • Бэлгийн хүчирхийллийн улмаас бэлгийн замын халдварт өвчин тусах, бэлэг эрхтэн, бүдүүн гэдсэнд ил гэмтэл учирч, шарх сорви үүсэх • Насанд хүрээгүй охидын жирэмслэлт, түүнээс үүдсэн үр хөндөлт, төрөлт Сэтгэцийн хямралт байдал, эмгэг өөрчлөлтөд орсныг дараах шинж тэмдгүүд илтгэнэ. Үүнд: • хэт таргалалт, жин алдах, • харшилтай байх, арьс хуурайших, • хоол боловсруулах эрхтэний хямрал, гэдэсний доод хэсгээр базалж өвдөх, • өсвөр насны хүүхдийн хувьд биеийн өтгөн, шингэнээ барих чадваргүй болох	• Ямагт айдастай байх, өөрийг нь үл ойшоох, ганцаардахаас айж, “хайрлах хүн байхгүй” гэсэн сэтгэл гутралд орох • Байнга өсөрхөж хорсох, өөрөөсөө сул дорой, насаар бага хүүхдийг дээрэлхэж доромжлох, амьтан тамлах, тодорхой шалтгаангүйгээр түрэмгийлэл үзүүлэх • Үргэлж бусдын анхаарлын төвд байхыг хүсэх, энэ зорилгодоо хүрэхийн тулд санаанд багтамгүй зан үйл хийх • Бэлгийн харилцааны талаар насандаа баймгүй мэдлэгтэй байх, үүнийгээ бусадтай тоглох, харилцах үедээ илэрхийлэх • Өөрийгөө хэт доогуур үнэлэх, бүрэг ичимхий байх, ямагт буруугаа хүлээхэд бэлэн байх • Сэтгэл санааны тогтворгүй байх, ганцаардмал, нойр муутай байх, өсвөр насандаа болон насанд хүрмэгцээ амиа хорлох оролдлого хийх	• Насанд хүрэгсэдтэй харилцах дургүй, үе тэнгийнхэнтэйгээ харилцах чадваргүй байх • Хангалттай боловсрол мэдлэг эзэмшээгүй байдаг учраас хамт олныхоо дунд хүлээн зөвшөөрөгдөж, хүндлэгдэж чадахгүй байх • Бусдад уруу татагдаж, архидан согтуурах, мансуурах зуршилд амархан автамтгай, хулгай болон бусад төрлийн гэмт хэрэг үйлдэх дадал хурдан төлөвших хандлагатай байх • Биеэ үнэлэх, бэлгийн чиг баримжаагаа өөрчлөх, • Өөрийн гэр бүл, хүүхдэд хүйтэн хөндий хандах хандлагатай болон төлөвших

АСУУЛТАД ХАРИУЛНА УУ.

1. *Хохирогч яагаад хүчирхийлэлтэй харилцаанд үлддэг вэ?*
2. *Хүчирхийлэл үйлдэгч ямар арга хэлбэрээр эрх мэдэл, давамгай байдлаа тогтоодог вэ?*
3. *Хохирогч болоод хүчирхийлэл үйлдэгчтэй харилцахдаа тэдний тус бүрийн зан үйл, онцлогийг хэрхэн харгалзах нь зүйтэй вэ?*
4. *ГБХ-д байгаа хүүхдийг хэрхэн таних вэ?*

ДАРААХ ХҮСНЭГТИЙГ ГҮЙЦЭЭНЭ ҮҮ.

Хохирогч:	Хүчирхийлэл үйлдэгч:
Айдастай байдаг, айдсаас шалтгаалж хүчирхийллийн олон гэмт хэрэг дарагдсан байдаг	Зөвхөн өөрийн гэр бүл, дотны хүмүүсийг хүчирхийлдэг
Хүчирхийллийг таслан зогсоох оролдлого нь мухардалд орсон байдаг	Хэзээ, хэрхэн хүчирхийлэхээ тооцоолсон, санаатай үйлдэл байдаг

Удиртгал

ГБХ-тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллага төдийгүй хамтарсан баг, иргэдийн оролцоог хамарсан өргөн хүрээний асуудал юм. Хохирогчид шаардлагатай хамгаалалт, тусламж, үйлчилгээг хохирогч төвтэй хандлагатай цаг алдалгүй үзүүлж, тэдний амь нас, эрүүл мэндэд учрах аюулын эрсдэлийг бууруулахад хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтан, алба хаагчид холбогдох хууль тогтоомжийг хэрэглэх, хэрэгжүүлэх асуудал дээр нэгдмэл ойлголт, үзэл баримтлалтай байх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах явдал шийдвэрлэх ач холбогдолтой.

Хэдий тийм боловч хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнууд хохирогч төвтэй хандлагатай, хууль тогтоомжийг нэгдсэн мэдлэг ойлголтой хэрэгжүүлэх нь дутмаг байгаагаас ГБХ-ийн хохирогчид хуулийн хамгаалалтыг авч чадахгүй хугацаа алдах, хохирох тохиолдол гардаг. Тухайлбал, ГБХ-ийн хохирогчийн аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ, ГБХ-ийн гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах, ГБХ-тэй тэмцэх хамтарсан багийн үйл ажиллагааны талаар хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнууд нэгдсэн ойлголт мэдлэгтэй байх шаардлага үүсэж байна. Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг хуулиар цагдаагийн алба хаагч хийх үүрэгтэй боловч прокурор хяналт тавьж, шүүхийн шатанд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх болдог. Аюулын зэргийн үнэлгээг хийх журмыг ХЗДХ-ийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/83 дугаар тушаалаар шинэчилэн баталсан бөгөөд аюулын зэргийн үнэлгээг хэрхэн хийх талаар прокурор, шүүгчид ч мэдлэг ойлголттой байх шаардлагатай.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан гарын авлагын "Хууль сахиулах байгууллагын ажилтнууд, шүүгчдийн нийтлэг анхаарах асуудал" энэ хэсгийн гол зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- ГБХ-ийн хохирогчийн амь нас, эрүүл мэндийн эсрэг халдлага үйлдэж болзошгүй этгээдийн эрсдэлт зан үйл, гэрч, хохирогчийн нийгмийн орчны эрсдэлт хүчин зүйлсийг судалж, илрүүлэх, ирээдүйд үйлдэгдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бүрдүүлсэн урьдчилан сэргийлэх цогц тогтолцооны талаар мэдлэг ойлголтоо өргөжүүлэх;
- Хохирогчийг хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэхэд хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудад хамааралтай хохирогч төвтэй хандлагын талаар мэдлэг, ойлголтыг бэхжүүлэх;
- Нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхүйц үнэлгээний материалыг бүрдүүлэх талаар гүнзгийрүүлэн судлах;
- Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийхэд анхаарах зүйлсийг тодорхойлох;
- ГБХ-ийн гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа, түүний онцлог, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, мэдээллээр хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэх талаарх ойлголтоо нэгтгэх, ГБХ-ийн хохирогч хамгаалалтгүй үлдэхээс сэргийлэхийг эрмэлзэх;
- ГБХ-тэй тэмцэх хамтарсан багийн үйл ажиллагааны талаар мэдлэг, ойлголтоо өргөжүүлж, мэргэжлийн үйл ажиллагаагаа түүнтэй уялдуулах чадвараа хөгжүүлэх зэрэг болно.

Нэр томьёо

- Аюулын зэргийн үнэлгээ (АЗҮ)
- Нөхцөл байдлын үнэлгээ (НБҮ)
- Хамтарсан баг
- Хохирогч[52]
- Гэрч[53]
- Хамгаалалтын арга хэмжээ[54]
- Эрх бүхий албан тушаалтан[55]
- Хохирогч төвтэй хандлага

52 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.2-д зааснаар;
53 Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар зүйлд зааснаар;
54 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4.1.2-д зааснаар;
55 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4.1.3-д зааснаар;

II ХЭСЭГ

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН БОЛОН ШҮҮГЧИЙН НИЙТЛЭГ АНХААРАХ АСУУДАЛ



2.1. ГБХ-ТЭЙ ТЭМЦЭХЭД САЛБАР ХООРОНДЫН УЯЛДАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ДЭД СЭДЭВ 1. ГБХ–тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх цогц тогтолцоо

Урьдчилан сэргийлэх – Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бодлого боловсруулах, төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх замаар зохион байгуулна.[56]

ГБХ-тэй тэмцэх нь шууд утгаараа тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэгдэж байгаа, өргөн утгаараа нийгэм дэх олон сөрөг үзэгдэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээг цогцоор нь багтааж байдаг олон талт ажил юм.

ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн зүгээс хөндлөнгийн оролцоог зайлшгүй шаарддаг учир засаг захиргааны анхан шатны нэгжийн хүрээнд иргэд, байгууллагууд оролцсон олон нийтийн бүлгүүдийг үүсгэж, хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, сурталчлах, хүчирхийллийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх нь чухал юм.

Төрийн байгууллагуудын урьдчилан сэргийлэх чиг үүрэг, уялдаа холбоо нь Засгийн газрын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Цагдаагийн албаны тухай, Хүүхэд хамгааллын тухай, Боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдсан салбар дундын бүтэцтэй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил цогц, тогтвортой, уялдаа холбоотой байх, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээ судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан, техник, технологийн орчин үеийн ололт, амжилт, шинэ мэдлэгт үндэслэсэн байх, зардал, үр өгөөжийн хувьд үндэслэлтэй байх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн, хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн байна. Түүнчлэн төрийн байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хуульд заасны дагуу оролцох үүрэгтэй бөгөөд төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох зарчимд тулгуурлана.

ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахаасаа өмнө бид ГБХ-ийн хор уршгийг ойлгосон байх нь хамгийн чухал. Бид хохирогчид учрах хор уршгийг зөв тодорхойлж байж урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулна.

ГБХ-ээс урьдчилан сэргийлэх цогц тогтолцоог эрх зүйн зохицуулалт талаас нь

- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх;
- Хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох;
- Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах гэсэн чиглэлд хуваан авч үзэж болно.

56 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 3 дугаар зүйл, 2019 он,

Энд гурван түвшний урьдчилан сэргийлэх асуудал яригдана.

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх: Үүнийг анхдагч урьдчилан сэргийлэлт гэж хэлж болно. Энэ тогтолцоо нь хүчирхийллийг үүсгэж буй суурь шалтгааныг арилгах замаар хүчирхийллийг гаргахгүй байхад чиглэгдэнэ. ГБХ-ийг үйлдэгдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх нь эрүүл мэнд, эдийн засагт учрах удаан хугацааны өртгийг багасгадаг. Хүмүүсийн хандлага, зан үйлд боловсролын байгууллагын хөтөлбөрөөр дамжуулан нөлөөлдөг. Нэгэнт тогтсон хандлага, сэтгэлгээг өөрчлөх амаргүй. Эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь хүчирхийллийн суурь шалтгаан учраас асуудлыг тодорхойлох, зөрчлийг шийдвэрлэх, бусдын үзэл бодол, ялгаатай байдлыг хүндэтгэх зэрэг чадварт аль болох бага, өсвөр наснаас нь сургавал үр дүнтэй гэж үздэг.[57]

Бага насандаа хүчирхийлэлд өртөх нь насанд хүрсэн хойноо хохирогч болох, эсхүл хүчирхийлэл үйлдэх эрсдлийг нэмэгдүүлдэг. Энэ бүгдийг харгалзан ГБХТтХ-иар Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэх, эрсдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох агуулгыг бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах үүрэг хүлээсэн. Мөн боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих болсон.

Бүх шатны Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ ГБХ-ийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох: Үүнийг хоёрдогч урьдчилан сэргийлэлт гэж хэлж болно. Энэ тогтолцоо нь хүчирхийлэл үйлдэгдсэн тохиолдолд дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх агуулгатай. Хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн амь нас, эрүүл мэндэд учрах эрсдлийг багасгах, яаралтай хамгаалахад уг тогтолцоо чиглэдэг.

Хүчирхийллийг эрт шатанд нь илрүүлэх, цаг алдахгүй, шуурхай таслан зогсоох, хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн амь нас, эрүүл мэндийг яаралтай хамгаалах арга хэмжээ, хариу үйлдэл, үйлчилгээнүүд уг тогтолцоонд багтдаг. Үүнд:

- Эрт шатанд илрүүлэх

  ГБХ үйлдэгдсэн эсхүл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлыг аль болох эрт шатанд илрүүлэх нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад нэн чухлал. ГБХ-д хүргэж болзошгүй, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэх нөхцөл байдлыг хүчирхийллийн болзошгүй эрсдэлд тооцдог.

- Цаг алдалгүй мэдээлэх

  Үхэл, амьдралын зааг ойр, ялгаж харах боломжгүй байдгаараа ГБХ нь бусад гэмт хэргээс ялгагддаг. Тиймээс цаг алдалгүй

57 НҮБ-ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлаг, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс хамтран гаргасан "Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт" 2019 он, Гарын авлагын 81-р тал.

мэдээлснээр хүчирхийлэл үйлдэгдэх, үйлдэгдсэн тохиолдолд дахин давтагдаж, хүнд хор уршиг учрахаас урьдчилан сэргийлдэг.

Энэ онцлогийг нь харгалзан ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн оршин сууж байгаа газрын харьяаллаас үл хамааран ойр байгаа цагдаагийн байгууллагад гаргахаар хуульчилсан байдаг.

- Шуурхай таслан зогсоох.

  ГБХ үйлдэгдсэн тохиолдол болон үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлыг шуурхай таслан зогсооход цагдаагийн байгууллага, алба хаагч гол үүрэг гүйцэтгэнэ.

- Амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах

  ГБХ далд үйлдэгдэж, давтагдан даамжирдаг онцлогийг мэргэжилтнүүд анхаарлын төвдөө байлгах шаардлагатай. Мэдээллийг ямар хэлбэрээр өгснөөс үл хамааран мэдээлэл хүлээн авсан байгууллага, албан тушаалтан ГБХ-ийг хуульд заасан арга хэрэгслээр таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учирсан, эсхүл тухай орчин нь аюултай гэж үзвэл хохирогчийг хамгаалах арга хэмжээг даруй авах үүрэгтэй.

- Хариуцлага хүлээлгэх

  Хүчирхийлэл үйлдэгчийн үйлдэлд оновчтой хариуцлага хүлээлгэх нь урьдчилан сэргийлэх ажлын нэг хэсэг юм. ГБХ-ийг юугаар ч зөвтгөж болохгүй.

Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах: Үүнийг гуравдагч урьдчилан сэргийлэлт гэж хэлж болно. Энэ тогтолцоонд хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн хүчирхийлэлд өртөхөөс өмнөх байдалд буюу хэвийн амьдралд эргэн оруулахад чиглэгдсэн цогц дэмжлэг, туслалцаа, үйлчилгээ багтана.

Дээрх туслалцаа, үйлчилгээг хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрууд үзүүлэх бөгөөд ГБХТтХ-ийн 5 дугаар бүлэгт заасан үйлчилгээнээс гадна хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн бусад тусламж, дэмжлэг, үйлчилгээг үзүүлж болно.

ДЭД СЭДЭВ 2. Хамтарсан багийн үйл ажиллагаа

Хууль тогтоогчоос ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа ГБХ-тэй тэмцэх хуулийн 20 дугаар зүйлд "Хамтарсан баг"-ийн ажиллах эрх зүйн орчныг тодорхойлсон бөгөөд өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахлахаар заасан байна. Энэ хуульд зааснаар "Хамтарсан баг" дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;
2. Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;
3. Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
4. Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх,

шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

5. Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;

6. Хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх.

Зураг 2.5: Хамтарсан баг, түүний үйл ажиллагааны зарчим



Хамтарсан багийн үйл ажиллагааны дүрэм

- хамтарсан багийн хуралдаанд гишүүд идэвхтэй оролцоно;
- мэдээлэл солилцоно;
- хариуцсан ажлаа түргэн шуурхай явуулна;
- өөр өөрийн ажил үүргийн дагуу бие даасан болон багийн бусад гишүүдтэй хамтарч ажиллана;
- ажил үүргээ уялдуулсан хамтарсан шийдвэр гаргана.

Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журмыг нийгмийн хамгааллын, хууль зүйн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасан бөгөөд Хүүхэд хамгааллын тухай хуулиар нэмэлт үүрэг хүлээдэг.

Хамтарсан баг нь анхан шатанд байх төлөөллөөс бүрддэг нэгж бөгөөд урьд хэрэгжиж байсан ГБХ-тэй тэмцэх тухай хуульд заасан зарим үйл ажиллагааг явуулна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15.4-т зааснаар хамтарсан баг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид тухайн хүүхдэд шаардлагатай үйлчилгээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргаж, хуульд заасны дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хүлээдэг. Энэ хууль нь 2015 оны 9 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн юм.

Түүнчлэн хамтарсан баг нь Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолоор "Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээдэг. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг тодорхойлж, тэдгээр өрх, өрхийн гишүүдийн эрэлт, хэрэгцээ, санаачилга, боломжид тулгуурлан боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн зэрэг үйлчилгээг багцлан хүргэх замаар зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулан, амьжиргааны түвшинг тасралтгүй дээшлүүлэх явдал аж. Тус хөтөлбөрийн 6.2-т заасны дагуу аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтарсан багийг мэргэжлийн удирдлагаар

хангах ажлыг үндсэнд нь хариуцаж байна.

Цаашид Хамтарсан багийн үйл ажиллагааг чадавхижуулахын тулд тэдэнд тусгайлсан сургалт явуулах хэрэгцээ тулгамдаж байна. Өөрөөр хэлбэл, ГБХ-тэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулах сургалтууд нь хоорондоо уялдаа холбоотой, ГБХ үйлдэж болзошгүй, эрсдэлтэй зан үйлтэй хүнтэй ажиллах чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн байвал илүү үр дүнтэй байна. Мөн ГБХ-тэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд "ГБХ үйлдэх" гэсэн зөрчлийг шинээр нэмж тусгасан тул Хамтарсан багийн гишүүдэд захиргааны зөрчил, гэмт хэргийг ялган таних, урьдчилан сэргийлэх арга зүйн чиглэлээр нэмэлт ур чадварууд шаардагдана.

Хамтарсан багийн үйл ажиллагаа нь анхан шатанд ГБХ-тэй тэмцэхэд хууль сахиулах, шүүх, төрийн бусад болон иргэний нийгмийн байгууллагын хамтарсан ажил үйлчилгээний талаар боловч үүний цаана уг хамтарсан багт орж буй гишүүн бүрийг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар хангаж буй төрийн байгууллага, албан тушаалтны хамтын үйл ажиллагаагаар ГБХ-тэй тэмцэх зорилготойг илэрхийлж буй юм.

Шинэчлэн найруулсан ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 2 дугаар бүлэгт ГБХ-тэй тэмцэх үндэсний тогтолцоо хэрхэн бүрдэхийг тогтоож өгсөн бөгөөд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, хууль зүй, нийгмийн хамгаалал, боловсрол, соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, прокурор, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, бүх шатны засаг даргын чиг үүргийг хуулиар тогтоож өгсөн. Энэ нь тухайн байгууллага, албан тушаалтан, хамтарсан багийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, мэргэжлийн захиргааны удирдлагаар хангах эрх зүйн үндэс нь болж байна. Хамтарсан багийн үйл ажиллагааг дээрх байгууллага, албан тушаалтнууд санхүүжүүлэх, шаардлагатай зарим эрх зүйн хэм хэмжээний актыг батлан гаргах үүргийг мөн хүлээсэн.

Хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээ

Нийгмийн ажилтан нь хүлээн авсан кейсийн талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, кейстэй ажиллах бүхий л шатанд шийдвэр гаргах, кейст үзүүлж буй дэмжлэг, үйлчилгээг зохицуулах зэрэг ажлыг хамтарсан багийн хамтын удирдлагын хүрээнд хийдэг.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл хүлээн авах, бүртгэх

Хамтарсан багийн гишүүн нь хүүхдийн хувийн хэргийн 14 төрлийн маягтын дагуу мэдээллийг хүлээн авч, бүртгэл хөтөлдөг. Нийгмийн ажилтан бүртгэлийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэдэг. Тус мэдээллийн сан нь хамтарсан багийн гишүүн тус бүрт нээлттэй байна. Гэхдээ хувь хүний нууцлалын асуудлыг хадгалах үүргийг гишүүн бүр хүлээнэ.

Хүүхэд хамгааллын нөхцөл байдлын үнэлгээ

Хамгааллын үйлчилгээний эхний шатанд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд тулгарсан асуудлын шалтгаан, нөхцөл байдалтай холбоотой бүх мэдээллийг цуглуулж, үйлчлүүлэгчтэй хамтарч ажиллах талаар судалдаг. Энэ үе шатыг "оношлох" үе шат гэж нэрлэдэг.

Хамтарсан багийн хуралдаан

Нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан үйлчилгээний үе шатыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд хуралдаан хийнэ. Хамтарсан багийн хуралдааныг Хорооны Засаг дарга удирдах ба нийгмийн ажилтан зарлан хуралдуулах, мэдээлэл бэлтгэх, танилцуулах ажлыг хариуцдаг. Хүүхдийн асуудлаар аливаа нэг шийдвэр гаргахдаа хамтарсан багийн хуралдаанаар шийдвэрлэдэг. Хуралдааныг сард 1 удаа хийнэ. Шаардлагатай үед хугацаа харгалзахгүй хуралдаж болно. Хуралдаан нь 2 хэсгээс бүрдэнэ.

1. Үйлчилгээний үйл явц, үр дүнгийн талаар хэлэлцэх, кейс хаах тухай шийдвэр гаргах;
2. Шинээр бүртгэгдэж, зайлшгүй ажиллах шаардлагатай кейсийн асуудлыг хэлэлцэх;

Үйлчилгээг баримтжуулах

Кейс менежментийн үйлчилгээг зайлшгүй баримтжуулах хэрэгтэй. Бүртгэж эхлэхээс л "Хүүхдийн хувийн хэрэг"-ийг бүрдүүлж эхэлнэ. Хүний хувийн нууцыг хадгалах үүднээс үйлчлүүлэгч бүрт код өгч, коджуулна. Хүүхдийн хувийн хэрэгт дараах баримтуудын хувь хадгалагдана. Үүнд:

1. Бүртгэл;
2. Эрсдэлийн үнэлгээ;
3. Шүүх, цагдаагийн байгууллага хэргийн мөрөөр ажилласан бол холбогдох мэдээлэл;
4. Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой бүх мэдээлэл;
5. Нөхцөл байдлын үнэлгээ, холбогдох баримт бичгийн хуулбар;
6. Холбогдох хүмүүстэй ярилцсан тэмдэглэл;
7. Хамтарсан багийн хуралдааны тэмдэглэл;
8. Аюулгүй байдлын төлөвлөгөө;
9. Кейс төлөвлөгөө;
10. Үйлчилгээ үзүүлсэн талаарх тэмдэглэл;
11. Үйл явцын тэмдэглэл;
12. Үйлчилгээний дараах хяналтын тэмдэглэл;
13. Кейсийн зардлын бүртгэл;
14. Кейсийг хаасан тухай мэдээлэл гэх мэт зүйл багтсан байна.

Үйлчилгээг төлөвлөх үе шат

Хамтарсан багийн бүх гишүүд хамтран нөхцөл байдлын, аюулгүйн, хэрэгцээний зэрэг үнэлгээндээ тулгуурлан цаашид хүүхэд, гэр бүлтэй ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллана.Төлөвлөгөө нь хүүхдийг аюул, хөнөөлөөс хамгаалах, эргэн хэвийн байдалд ороход гол ач холбогдолтой. Мөн хүүхэд, гэр бүлийн бүрэн бүтэн байдлыг хадгалж үлдэх, хүүхэд хохирохоос урьдчилан сэргийлэх нөөц бололцоог бүрдүүлэхэд анхаарна. Төлөвлөгөө боловсруулахдаа дараах зүйлийг анхаарна.Үүнд:

1. Хамтарсан багийн төлөвлөгөөний маягтыг ашиглах (хүүхдийн хувийн хэрэгт хөтлөх 14 төрлийн маягтын 3 нь Хамтарсан багийн хөтлөх маягт юм);
2. Төлөвлөлтийн бүх шатанд хүүхэд, гэр бүлийн бүх гишүүдийн оролцоог бүрэн хангаж, тэднийг сонсож, саналыг нэг бүрчлэн тусгасан байх;
3. Хүүхдийн дээд ашиг сонирхол нь төлөвлөлтийн гол чиглүүлэгч нь байх;
4. Кейс хаах хугацааг төлөвлөх үе шатанд заавалүйлчлүүлэгчидхэлсэн байх;
5. Үйлчилгээний явцад үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд Аюулгүй байдлын бие даасан төлөвлөгөө гаргаж ажиллах;
6. Хамтарсан багийн гишүүд, ажилтнуудын аюулгүй байдлыг хангах.

Үйлчилгээг үзүүлэх буюу хэрэгжүүлэх үе шат

Үйлчилгээг хянах, өөрчлөлтийг үнэлэх үе шат

Нийгмийн ажилтан нь ахиц, өөрчлөлтийг үнэлэх үнэлгээний маягтын дагуу үйлчлүүлэгчид гарч буй эерэг болон сөрөг өөрчлөлтүүдийг үнэлж, үнэлгээнээс гарсан үр дүнг багийн гишүүддээ танилцуулан цаашид үргэлжлүүлэн ажиллах шаардлагатай эсэхээ хэлэлцэнэ.

Кейсийн зардлыг бүртгэх үйл явц

Бүртгэгдэж, хувийн хэрэг нээсэн кейс бүртээ зардлын маягтыг хөтөлнө. Тухайн хүүхдийн асуудлаар хаашаа, хэнтэй, хэзээ, хэдэн минут утсаар ярьсан, унаагаар явж очиж уулзсан, баримтжуулалтанд эрүүл мэндийн үйлчилгээ болон хоол хүнс, хувцас, хамтарсан багийн хуралдаанд зарцуулсан цай, бичиг хэргийн зардал зэрэгт хэдэн төгрөг зарцуулснаа нэг бүрчлэн бүртгэж, санхүүгийн баримтыг дугаарлан, нааж бэлтгэнэ. Кейсийг хаах үед нийт гарсан зардлын дүнг тооцон маягтын төгсгөлд бичсэн байна.

Кейсийг хаах үе шат

Кейс менежментийн үйлчилгээ дуусч, хүүхдийн байдал засарч сайжран, цаашид хамтарсан багаар үйлчлүүлэгчтэй ажиллах шаардлага бий эсэхийг хэлэлцэж, "шаардлагагүй" гэж үзсэн тохиолдолд кейсийг хаадаг.

ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх нь чухал боловч цаашид дахин давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

цагдаагийн алба хаагчаас хамтарсан багт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, прокурорын байгууллагаас гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах мэдэгдэл, шаардлага бичиж, биелэлт үр дүнг тооцох, шүүхээс хүчирхийлэл үйлдэгчид тохирсон шийтгэлийг ногдуулах замаар хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх боломжийг олгох нь чухал ач холбогдолтой. (Шүүхийн байгууллага нь хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах байрнаас гарч ирэхээс өмнө хохирогчид туслалцаа үзүүлэх цаг хугацаа олгох гэх мэт)

Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Хууль зүй, дотоод хэргийн,Эрүүл мэндийн сайд нар хамтран батална.

Баянзүрх дүүргийн нэгдүгээр хорооны нутаг дэвсгэрт 2016 оны эхний хагас жилийн байдлаар ГБХ-ийн шинжтэй нийт 20 гэмт хэрэг бүртгэгдсэнийг газар нутаг, хүн амын тоо ижил, дэд бүтэц адил хөгжсөн Чингэлтэй дүүргийн гуравдугаар хорооны нутаг дэвсгэрт тус оны эхний хагас жилд бүртгэгдсэн ГБХ-ийн шинжтэй гэмт хэрэгт харьцуулж үзэхэд даруй 38 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

1. *Дээрх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж учир шалтгааныг тайлбарлана уу.*
2. *Урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг тодорхойлж, зөв аргыг сонгоно уу.*

ДЭД СЭДЭВ 3. Хохирогч төвтэй хандлага

Хохирогч төвтэй хандлага гэдэг нь ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийг шалгах, хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ тэдний хэрэгцээ шаардлагыг нэн тэргүүнд тавих асуудал юм. ГБХ-тэй тэмцэхэд хохирогч төвтэй хандлагыг харгалзсан дараах зарчмуудыг баримтална.[58] Үүнд:

1. Хүний эрхэм чанарыг дээдлэн, хүндэтгэлтэй харилцах
2. Аюулгүй, тусалж дэмжсэн, шүүмжлэлгүй орчинд байх
3. Зохих мэдээлэлтэй байх
4. Мэдээлэлд үндэслэн сонголт хийх боломжтой байх
5. Хувь хүний нууц, өөрийн гэсэн орон зайтай байх

Дээрх зарчмуудыг хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтнууд бүгд баримталж ажиллах нь зүйтэй.

ГБХ-ийн хохирогч ойр дотныхоноо зовоох, эсвэл "амьдралаа зохицуулж чадахгүй муу эмэгтэй" гэж хэлэгдэхээс айж, хүчирхийллийг нуун дарагдуулсаар байдаг. Тэд хүчирхийлэл үйлдэгчийг "засарна, ойлгоно" гэж найдах, хүүхдээ өнчрүүлэхгүй гэх мэт шалтгаанаар олон жилийг хүчирхийллийн доор өнгөрүүлсэн байдаг. Мөн нөхрөө шүүх, цагдаад өгөхийг хүсдэггүй ба нөхцөл байдлыг тэсвэрлэхээргүй болсон үедээ хамаатан садан, найз нөхөд, хөрштэйгээ ярилцдаг байна. Ихэнх тохиолдолд эдгээр хүмүүс нь хаяад явахыг зөвлөдөг бөгөөд харин хохирогч эмэгтэйчүүд ийм том алхам хийхэд бэлэн биш байдгаас тэдний зөвлөгөөг дагахыг хүсдэггүй, улмаар хүчирхийлэл даамжирч, туйлдаа хүрсэн үед Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, хуулийн байгууллагад ханддаг байна. Хүчирхийллийг ийнхүү ил гаргах нь маш хэцүү алхам гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хохирогч төвтэй хандлагыг ойлгох, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхдээ хамгийн түрүүнд ГБХ-ийн хохирогчид учирсан хор уршиг, сэтгэл зүйн байдлын нь ойлгосон байх шаардлагатай.

58 НҮБ -ийн Эмэгтэйчүүдийн байгууллагын тодорхойлолт

Гэр бүл дэх бэлгийн хүчирхийллийн хор уршиг

ГБХ нь хүчирхийлэл үйлдэгчийн зүгээс эрх мэдэл, давуу байдал, хяналтаа тогтоох, хохирогчийг эрхшээлдээ байлгах зорилгоор үйлдэгддэгээрээ хүчиндэх гэмт хэргээс ялгаатай бөгөөд олон дахин давтагддаг, ихэвчлэн хүчирхийллийн бусад хэлбэрүүд, тухайлбал бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлтэй хавсран үйлдэгддэг. Хайртай, дотны хүн эсхүл садан төрлийнх нь хүн хүсэл зоригийнх нь эсрэг бэлгийн хүчирхийлэл байнга үйлдэхэд эмэгтэй хүн өөрийгөө сул дорой байдлаар мэдэрч, өөртөө итгэх итгэлээ алдан, сэтгэл зүйн хувьд маш их зовуурь шаналал амсдаг. Гэр бүлийн гишүүн эсхүл хамаатан саднаа буруутгах, хууль сахиулах байгууллагад гомдол гаргахаас цааргалах, сэтгэл санааны хямрал, бие махбодын зовуурь шаналалаа тэсэж үлдэх тохиолдол ч цөөнгүй. Түүнчлэн энэ төрлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүсэгүй жирэмслэлт, үр хөндөлт, бэлгийн замын халдварт өвчин зэрэг нөхөн үржихүйн эрүүл мэндээр хохирох эрсдэлтэй бөгөөд үүн дээр нийгэм эмэгтэйг нь буруутгавал байдал улам хүндэрдэг.

Сэтгэл санааны хүчирхийллийн хор уршиг

ГБХ нь хохирогчид ямагт сэтгэл санааны гүнзгий хор уршиг учруулж байдаг. Хүчирхийлэл болоод өнгөрсөн ч айдас алга болдоггүй ба хохирогч хүчирхийлэл үйлдэгчээс салсан ч айдас байсаар байдаг.

Хүчирхийлэл хэдий удаан үргэлжилж, харгисаар үйлдэгдсэн байна, төдий хэмжээгээр сэтгэл санаанд гүнзгий нөлөөлдөг бөгөөд эцэст нь хохирогч сэтгэцийн эмгэг өөрчлөлттэй болох, амиа хорлох зэрэг хүнд хор уршигтай байдаг. Сэтгэл санаанд гүнзгий нөлөөлөхүйц тодорхой үйл явдал болон урт удаан хугацааны турш хуримтлагдсан стресс, шаналалаас шалтгаалан сэтгэцийн гүн цочролд орох боломжтой. Тухайлбал:

- хүн амины хэрэг үйлдэгдэхийг харсан, өөрийг нь буюу өөр хэн нэгнийг алах, биед нь хохирол учруулахаар заналхийлэлд өртсөн, энэ үйл явдлаас айсан;
- тодорхой хугацааны туршид бие махбодын болоод сэтгэл санааны стресст орсон бол сэтгэцийн гүн цочролд орох боломжтой.

Энэхүү сэтгэл санааны цочрол нь удаан хугацаанд үргэлжилдэг бөгөөд хэдий үйл явдал болоод дууссан байвч:

- Болсон явдлыг буруу зөрүү санах;
- Хар дарж зүүдлэх;
- Хүчирхийллийг санагдуулах эд зүйлс, үг ярианаас зугтах;
- Хүчирхийллийг санагдуулах аливаа үйлдэл, үйл явдлаас зугтах;
- Цочролд оруулсан гол, том үйлдлүүдийг санахгүй байх;
- Төвлөрч чадахгүй байх;
- Нойргүйдэх;
- Хурдан уурлах, хүчтэй сэтгэл хөдлөлд хурдан автах зэрэг хямралын шинж тэмдэг удаан хугацаанд илэрч байдаг.

ГБХ-ийн хохирогч нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхүүд, түүний дотор хүүхэд, эмэгтэйчүүдийн халдашгүй эрхүүдийг эдлэхийн зэрэгцээ хуулийн тусгай хамгаалалт, нэмэлт эрхийг эдэлдэг. ГБХ-ийн хохирогчийн эрхийг хамгаалах баталгааг Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1976), Хүүхдийн эрхийн тухай конвенц (1990) зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрт тусгаж өгсөн. Манай улс эдгээр гэрээ конвенцод нэгдэн орсон учраас хохирогчийн эрхийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн.

Монгол улсад ГБХ-ийн хохирогч ЭХХШтХ (8.2 дугаар зүйл) болон ЗШШтХ (3.2 дугаар зүйл)-д заасан эрхийг эдлэхээс гадна дараах нэмэлт эрхийг эдлэнэ. Үүнд:

Нэн тэргүүнд эдлэх эрх	Дунд хугацааны үед эдлэх эрх	Урт хугацааны үед эдлэх эрх
- Цагдаагийн байгууллагаас тусламж авах - Эрүүл мэндийн шуурхай үйлчилгээ авах - Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах - Сэтгэлзүйн үйлчилгээ авах - Хүчирхийлэгчтэй уулзахгүй байх - Мэдээллийн нууцлалтай байх - Байршлаа хуулийн байгууллагаас бусдад мэдэгдэхгүй байх - Аюулгүй байдлын хамгаалалтыг сонгох	- Эрх зүйн зөвлөгөө, хууль зүйн туслалцаа авах - Хохирогчоор тогтоолгох - Нэхэмжлэгчээр тогтоолгох - Сэтгэл санааны хохирлын эрсдлийн үнэлгээ хийлгэх - Хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах - Хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэл авах - Шүүх хуралдааны танхимд сэтгэл зүйчтэй хамт байх	- Хохирол арилгуулах - Нийгмийн халамж, тэтгэмж авах

ГБХ-ийн хохирогчийн эрхийг хамгаалах, тэдний хэрэгцээ шаардлагыг мэдэх, туслалцаа, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхэд ГБХТтХ-ийг дангаар хэрэглэх нь хангалтгүй юм. Учир нь уг хууль эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан олон хуулиудтай нягт уялдаатай. Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг, Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн байгууллага, алба хаагчаас гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох зохицуулалтыг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хүчирхийлэл үйлдэгчид оногдуулсан ял шийтгэл, албадлагын арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх гэхчлэн эрх зүйн тогтолцоо бүрдсэн юм.

Өөрөөр хэлбэл хохирогч төвтэй цогц үйлчилгээ үзүүлэхэд аль нэг байгууллага, эсхүл мэргэжилтэн дан ганцаараа ажиллаад амжилт олохгүй. Харин нягт уялдаатай хамтран ажилласнаар амжилттай шийдвэрлэх боломжтой юм.

Хүчирхийллийн хохирогчид туслалцаа, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгч бүрийн нэр төр, эрхэм чанарт хүндэтгэлтэй хандаж, үйлчлүүлэгч тус бүрийн бие даасан байдал, хувийн онцлог, соёлын өвөрмөц байдал, ялгаатай хэрэгцээг харгалзана.

Хохирогчийн хувьд хүчирхийллийн талаар бусдад дэлгэж, тусламж хүсэх нь маш хэцүү алхам гэдгийг анхааралдаа авч, түүнтэй харилцахдаа итгэл төрүүлэх, нөхцөл байдлын үнэн зөвийг тогтоож, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалахад мэдээлэл ямар чухал болохыг ойлгуулж, ярилцах нь зүйтэй.

ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны бүхий л явцад хохирогчийн эрхийг нэн тэргүүнд тавьж, тэдний хэрэгцээ, шаардлагыг ойлгон мөрдөн шалгах ажиллагаа болон туслалцаа, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх үйл явцыг хуулийн хүрээнд явуулах нь хохирогч төвтэй эрхийг хамгаалах ажиллагаа гэдгийг санах хэрэгтэй.

2.2. АЮУЛЫН ЗЭРГИЙН БОЛОН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

ГБХТТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Цагдаагийн алба хаагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болзошгүй эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийнэ" гэж заасан. Цагдаагийн байгууллагын хувьд сум, хороон дээр ажиллаж буй хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нар Хамтарсан багтай хамтран нөхцөл байдлын үнэлгээ хийж байсан, харин одоо хуулийн дагуу аюулын зэргийн үнэлгээ (АЗҮ) хийх болж байна.

Хүснэгт 2.1. АЗҮ болон НБҮ-ний ялгаа.

АЗҮ	НБҮ
Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл болон хохирогчийн амь насыг хөнөөх магадлал бүхий эрсдэлийг тодорхойлно	Хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний төрлийг сонгох, ГБХ-ийн эрсдэлийг тодорхойлно.
Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад цагдаагийн алба хаагчаас ямар арга хэмжээ авахыг тодорхойлно.	ГБХ-ийн болзошгүй эрсдэлтэй байдал, хохирогчид учирч болох сөрөг үр дагавар, үзүүлэх тусламж үйлчилгээний төрлийг тодорхойлно.
Цаг хугацааны хувьд хамгийн богино хугацаанд хийх шаардлага тулгардаг.	Хамтарсан багаар ажиллаж, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх учраас хамгийн багадаа ажлын 1-2 өдрийн хугацаа шаардагдана.
Цагдаагийн алба хаагч гүйцэтгэнэ.	Хамтарсан баг, нийгмийн ажилтан гүйцэтгэнэ.

ГБХТТХ хэрэгжиж эхэлснээс хойш зарим шүүгч ГБХ-ийн зөрчлийн материал шийдвэрлүүлэхээр очсон цагдаагийн алба хаагчаас АЗҮ болон НБҮ-г хамт авч ирэхийг шаардах тохиолдлууд гарч байна. Энэ нь зөрчлийг шийдвэрлэх цаг хугацааг хойшлуулах, зөрчил үйлдэгчийг шүүхээс шийдвэр гарах хүртэл хаана байлгах нь тодорхойгүй нөхцөл байдалд хүргэж, улмаар хохирогчийн аюулгүй байдлыг алдагдуулж байгааг хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон шүүгч нар анхаарах хэрэгтэй.

Мөн гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг ихэвчлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын шатанд авсан байдаг ч хүчирхийлэл нь өөрөө нэг удаагийн шинжтэй үйлдэл байдаггүй, олон давтагдах, амь насанд аюултай шинж нь нэмэгдэх магадлалтай гинжин холбоо бүхий үйлдэл байдаг тул хамгаалалтад авах шаардлагагүй байсан гэрч, хохирогчийг хамгаалах шаардлага үүсэх боломжтой. Иймд АЗҮ-г тодорхойлох нь Цагдаагийн байгууллагын үүрэг төдийгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад прокурор, шүүхийн байгууллага ч мөн онцгойлон анхаарах шаардлагатай гэж үздэг байна.[59]

ДЭД СЭДЭВ 1. Аюулын зэргийн үнэлгээ, түүнийг хийх аргачлал, анхаарах асуудал

АЗҮ гэдэг нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учрах эрсдэлийг урьдчилан таамаглахад чиглэсэн арга хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал нь "хутганы ирэн дээр байна уу, үгүй юу" гэдгийг хамгийн богино хугацаанд тодорхойлох, хохирогчийг хамгаалах ямар арга хэмжээ авахыг тодорхойлсон баримт бичиг гэж ойлгож болно.

АЗҮ нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг шуурхай авах болон ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1,

59 AEquitas Prosecutors' Resource, Witness Intimidation as of Mar 2014

34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу хохирогч, гэр бүлийн бусад гишүүдэд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх үндэслэл болно.[60]

Цагдаагийн байгууллагад 2019 онд 620.172 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэнээс хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээлэл 57.749 бүртгэгдэж, үүнээс 12.211 дуудлага, мэдээллийг гэр бүлийн хүчирхийлэл мөн гэдгийг тогтоож аюулын зэргийн үнэлгээ хийсэн байна.

Цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг шалгах явцад АЗҮ -г хийхэд дараах хүндрэл бэрхшээл учирч байсан. Үүнд:

- "Аюулын зэргийн үнэлгээ"-ний маягт нь үндсэн 20, нэмэлт 73, нийт 93 асуулт, "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулын зэргийн үнэлгээ"-ний маягт нь үндсэн 20, нэмэлт 76, нийт 96 асуулттай бөгөөд зарим асуулт нь давхардсан, шаардлагагүй, үнэлгээнд нөлөөлдөггүй;
- Нэг тохиолдолд аюулын зэргийн үнэлгээ хийхэд ойролцоогоор 15-30 минут зарцуулж байгаа цагдаагийн алба хаагч дараагийн дуудлага, мэдээлэлд богино хугацаанд хүрэлцэн очиход саад болдог;
- Хохирогч хэт олон асуултанд хариулахаас татгалзах, ойлгохгүй байх, бухимдах зэргээр аюулын зэргийн үнэлгээг бодитой хийхэд сөргөөр нөлөөлдөг;
- Аюулын зэргийг үнэлэх аргачлал нь маягт, журмын зохицуулалттай давхацсан;
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулын зэргийн үнэлгээний маягт, аргачлал нь "Аюулын зэргийн үнэлгээ, аргачлалтай адил, тусдаа байх шаардлагагүй.

Дээрх болон бусад хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх, аюулын зэргийн үнэлгээг оновчтой асуултаар богино хугацаанд хийх, алба хаагчдад ойлгомжтой, ашиглахад хялбар байдлаар найруулах хэрэгцээ шаардлагыг үндэслэж ХЗДХ-ийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/83 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар "Аюулын зэргийн үнэлгээ хийх журам", 2 дугаар хавсралтаар "Аюулын зэргийн үнэлгээ хийсэн тэмдэглэлийн загвар"-ыг тус тус шинэчлэн баталсан.

Тус журмын дагуу АЗҮ-г цагдаагийн алба хаагч ГБХ-ийн дуудлага, мэдээллийн дагуу ГБХ үйлдэгдсэн болон үйлдэгдсэн байж болох орчинд, эсхүл хохирогчийн байгаа газар очиж хийнэ[61].

"Орчин" гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн болон үйлдэгдсэн байж болзошгүй газар, орон байр, Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв, хохирогчоос мэдүүлэг авч байгаа газрыг ойлгоно.

АЗҮ-г нотлох баримтаар тооцох, үнэлэх эсэхийг цагдаагийн алба хаагч, прокурор, шүүгч Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд өөрийн дотоод итгэлээр шийдвэрлэнэ.

Цагдаагийн алба хаагч нь гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, гомдол, мэдээллийн тохиолдол бүрт аюулын зэргийн үнэлгээг хийнэ.

АЗҮ-г хийхдээ 3 хүчин зүйлсийг харгалзана:

1. Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, учирч болзошгүй эрсдэл;
2. Хүчирхийлэл үйлдэгчийн хувийн байдал
3. Орчны эрсдлийн хүчин зүйлс юм.

"Орчны эрсдэлийн хүчин зүйлс" гэж хохирогч, түүний хамаарал бүхий этгээдийн оршин сууж, амьдарч буй газар нь төвөөс алслагдмал, дэд бүтэц хөгжөөгүй, нийтийн тээврийн үйлчилгээ байхгүй, харилцаа холбоо барих, бусдаас тусламж хүсэх боломжгүй, түр хамгаалалтад авах төрөл, садан, ойр дотны хүн байхгүй, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзах, худал мэдүүлэг өгөх нөхцөл үүссэн, түүнчлэн хохирогч нь хүүхэд эсхүл хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах боломж хязгаарлагдмал нөхцөл байдлыг ойлгоно.

60 ХЗДХС-ын 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/83 дугаар тушаалаар батлагдсан Аюулын зэргийн үнэлгээ хийх журмын §1.3, §1.4

61 ГБХТТХ-ийн §31.1, §31.2

Тэгвэл "Хүчирхийлэгчийн хувийн байдал" гэж урьд өмнө гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн үйлдэлд нь шүүхээс ял, шийтгэл оногдуулж байсан, хүчирхийлэгчтэй холбоотой гомдол, мэдээлэл, дуудлага эрх бүхий байгууллагад ирж байсан, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн, цагдаагийн байгууллага, алба хаагчийн хяналтанд авагдаж байсан, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг, архины хамааралтай, сэтгэцийн эмгэгтэй нөхцөл байдлыг ойлгоно.

Аюулын зэргийг үнэлэх аргачлал

АЗҮ нь бага, дунд, өндөр эрсдэлтэй байх ба үнэлгээг хийхдээ 11 асуулт тус бүрт тийм, үгүй гэсэн хариулт өгч, "тийм" гэсэн хариулт тус бүрт 1 оноо, "үгүй" гэсэн хариулт бүрт 0 оноо өгч, нийлбэр оноогоор аюулын зэргийг тогтооно.

АЗҮ-г хийх тэмдэглэл нь гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг тодорхойлох асуултаас бүрдэх ба цагдаагийн алба хаагч тэмдэглэлийг зөвхөн өөрөө хөтөлнө.

Хүснэгт 2.2. Аюулын зэргийн түвшинд харгалзах оноо, авах арга хэмжээ

Аюулын зэрэг	Хариу арга хэмжээ
Бага эрсдэл: (0-3 оноо) Хохирогч, хамаарал бүхий этгээдтэй үл ойлголцож маргалдсан, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тодорхой үйлдэл хийхийг хязгаарлах арга хэмжээ авсаны дараа хохирогчийн зөвшөөрөлгүй уулзах, харилцаа тогтоохыг оролдсон, сэтгэл санааны дарамт, шаналал учруулсан, эдийн засгийн хараат байдалд оруулсан үйлдэл нь хэвшмэл, байнга үйлдэгдээгүй, хохирогч, хамаарал бүхий этгээдийн бие махбод, эрүүл мэндэд хохирол учруулаагүй нөхцөл байдлыг;	Хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх эсэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгнө. Аюулын эрсдэлийн зэргийн үнэлгээ "0" бол хохирогч, холбогдогч нарт эрх зүйн зөвлөгөө өгч, хамаарал бүхий этгээдэд хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр өгнө.
Дунд эрсдэл: (4-7 оноо) Хохирогч, хамаарал бүхий этгээдийг гүтгэсэн, заналхийлсэн, гутаан доромжлох, айлган сүрдүүлсэн, дарамталсан, эдийн засгийн хүчирхийлэл нь хэвшмэл, байнга үйлдэгдээгүй, сэтгэл санааны хохирол учруулсан, хохирогч, хамаарал бүхий этгээдийн бие махбод, эрүүл мэндэд бага /хөнгөн/ хохирол учруулсан нөхцөл байдлыг;	Хохирогчийн хүсэлтийг харгалзан үзэж, гэрт нь байх, эсхүл хүчирхийлэл үйлдэгчтэй хамт байх шийдвэрийг нь хүндэтгэж үзнэ. Хохирогч өөрөө хүсвэл харьяа хорооны нийгмийн ажилтан болон хамтарсан багт нь мэдэгдэнэ. Хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдэд хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр өгнө. Хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл садан, ойр дотных нь хүний түр хамгаалалтад өгнө.
Өндөр эрсдэл: (Тэмдэглэлийн 1, 2 , 3 дахь асуултын аль нэгэнд тийм гэсэн эсхүл 8 ба түүнээс дээш оноо) • Хүчирхийлэгч нь: хохирогч, хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд бодитой заналхийлсэн, хүчирхийлэл хэвшмэл, байнга үйлдэгдсэн, хохирогч нь хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, жирэмсэн зэрэг шалтгаанаар өөрийгөө хамгаалах чадвар хязгаарлагдмал нөхцөл байдлыг;	Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалахаар нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, шаардлагатай тохиолдолд төрөл садан, ойр дотных нь хүний түр хамгаалалтад өгөх арга хэмжээг авна. Хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд мэдэгдэнэ. Хүүхдэд хийсэн аюулын эрсдэлийн зэрэг "Дунд", "Өндөр" гарсан бол эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүйгээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.1 дэх хэсэгт заасан арга хэмжээг авна.

Анхаарах асуудал: Онцгой тохиолдолд аюулын зэргийн үнэлгээ нь нийлбэр оноогоор бага, дунд гэж гарсан ч дараах тохиолдолд аюулын зэргийг "өндөр" гэж үнэлж, хохирогч, түүний хүүхэд, хамаарал бүхий этгээдийг хамгаалах арга хэмжээ авна. Үүнд:

- хүчирхийллийг хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй;
- айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, оруулж болзошгүй;
- Хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй;
- Хүүхдийн эмзэг байдлыг өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, ашиглаж болзошгүй;
- Хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэдэг, хэрэглэсэн;
- Хохирогчийг байнга зодсон, харгис хэрцгий хандсан, догшин авирласан, тохуурхан даажигнасан, тарчлаасан;
- Хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, архаг хууч өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг хүчирхийлэл үйлдсэн;
- Аюулын зэргийн үнэлгээнд журмын 2.2, 2.3, 2.4-т заасан хүчин зүйлсийг харгалзаж үнэлгээний зэргийн түвшинг нэмэгдүүлж, эсхүл багасгаж болно.

АЗҮ хийх журам, үнэлгээний тэмдэглэлийн загварыг энэхүү гарын авлагын хавсралтаас авч ашиглана уу.

Хэдийгээр хүчирхийллийн түвшинг яв цав тогтоож, хүчирхийлэл даамжрахаас сэргийлэх боломж хязгаарлагдмал боловч судлаачид хүчирхийлэл даамжрах, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учруулж болзошгүй хүчин зүйлсийг тодорхойлжээ.

Зураг 2.1. Хохирогчийн амь насыг хохироох, эрүүл мэндэд ноцтой аюул учруулж болзошгүй хүчин зүйлс

Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул учруулж болзошгүй хүчин зүйлс илэрсэн үед аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг яаралтай авах, хүчирхийлэл үйлдэгчийг эрүүлжүүлэх, саатуулах зэрэг боломжтой бүхий л арга хэмжээг авах нь зүйтэй.

АЗҮ хийх цагдаагийн алба хаагчийн анхаарах асуудал:

- АЗҮ-г хийхдээ хүчирхийлэл үйлдэгчийг хамт очсон нөгөө алба хаагчаар харгалзуулах зэргээр аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсны дараа

хохирогчтой ганцаарчлан уулзаж, тэмдэглэлд тусгагдсан 11 асуултыг эхнээс нь тодруулах байдлаар асууж, "тийм", "үгүй" гэсэн хариултын аль тохирохыг сонгож, зөвхөн өөрөө бөглөнө.

- АЗҮ хийх журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг хэрэгжүүлэхдээ ГБХ-ийн дуудлага, мэдээлэл бүрт үнэлгээ хийх ба удаа дараа дуудлага, мэдээлэл өгсөн хохирогчийн тохиолдол бүрт үнэлгээ хийж, баримтжуулна.
- Хохирогчид цагдаагийн хамгаалалтад байгааг ойлгуулах, түүний яриаг анхааралтай сонсох, хохирогчид тулгарсан асуудлыг шийдвэрлэнэ гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцах хэрэгтэй.
- Зарим хохирогч цагдаагийн алба хаагч ирсэн үед өөрийгөө хамгаалалтад орсноо ойлгож, хүчирхийлэл үйлдэгч рүү дайрах зэргээр сэтгэл санааны хүнд байдлаа янз бүрээр илэрхийлэх нөхцөл байдал үүсч болно. Энэ үед хохирогчийг тайвшруулах арга хэмжээ авч, үнэлгээ хийх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Үнэлгээний түвшин ямар гарахаас үл хамааран хүчирхийлэл үйлдэгчийг тусгаарлан эрүүлжүүлэх, эсхүл саатуулах байранд хүргэж, хуульд заасан арга хэмжээ авна.
- Хэрэв хохирогч ухаангүй буюу нэн яаралтай эмнэлэгийн тусламж үзүүлэх шаардлагатай, эсхүл учирсан гэмтэл, бусад нөхцөл байдлын улмаас асуултад хариулах чадваргүй, хүүхдийн хувьд тавьсан асуулгыг ойлгох насанд хүрээгүй, оюун ухааны хувьд хөгжөөгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тухайлбал, хэл ярианы болон сонсголын бэрхшээлтэй иргэнтэй харьцах хэлмэрч олдохгүй нөхцөл байдал үүсвэл энэ тухай ГБХ-ийг шалгасан илтгэх хуудас дээр тэмдэглэж, холбогдох материалын хамт жижүүрийн ахлах офицер, эрх бүхий албан тушаалтанд материалыг хүлээлгэж өгнө.
- Удирдах албан тушаалтнаас материалыг хүлээн авч шалгахаар томилогдсон цагдаагийн алба хаагч дээрх үндэслэл арилсан тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг хохирогчийн байгаа газарт, боломжтой бол ажлын байранд хийж болно.
- АЗҮ-ний тэмдэглэлд гэр бүлийн гишүүд, гэрч, мэдээлэгчийн хувийн мэдээллийг бичихгүй, хохирогчийн гарын үсгийг зуруулахгүй.
- Хохирогч монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар аюулын зэргийн үнэлгээг хийж, орчуулагч, хэлмэрчийн гарын үсгийг зуруулна.
- Хүүхдэд АЗҮ-г хийхдээ эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл мэргэжилтэн (сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч) байлцуулж болно. Хэрэв эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хохирогч хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй бол оролцуулахгүй бөгөөд энэ тухай тэмдэглэлд тусгана

Аюулын зэрэг өндөртэй, сэтгэл санаа нь хүчтэй цочрон давчидсан хохирогчтой харилцахад дараах арга зүйг эзэмшиж, хохирогчид анхан шатны тусламж үзүүлнэ. Үүнд:

- Амьсгалын дасгал хийлгэх нь булчин сулруулж, тайвшруулах нөлөө үзүүлдэг үр дүнтэй арга тул амьсгалын дасгалыг 3-4 удаа удирдан хийлгэх;
- Даван туулах боломж бий гэсэн итгэл төрүүлэх;
- Түгшүүр нь яагаад үүсдэгийг тайлбарлаж өгөх;
- Урьд энэ байдлаас гарахын тулд ямар арга хэрэглэдэг байсныг асуух;
- Хүний авьяас, давуу тал, бүтээлч нөөц (бичих, зурах, хийх, бүтээх, туурвих) боломжид тулгуурлах, энэхүү нөөцүүдээс ашиглан даван туулалт хийж байсан эсэхийг асуух;
- Сэтгэл зүйн нөөц-хошин шогийн мэдрэмж, утга учиржуулах, үнэт зүйлс, оюун ухаан, өөрийгөө хамгаалах чадварыг идэвхжүүлэх;
- Хүмүүс хоорондын харилцааны нөөц-дэмжин туслах хүмүүсийн хамгаалалт, туслалцааг нэмэгдүүлэх;

- Оюун санаа, бие махбодыг тамиржуулах арга хэмжээнд хамрагдах боломж, нөөцийг нэмэгдүүлэх;
- Тухайн нөхцөл, үйл явдлын болсон зүйлийг эерэгээр утга учиржуулж чаддаг байх нь чухал;
- Үнэт зүйл дээр нь хамтарч ярилцах нь үр дүнтэй;
- Тухайн хүний тэсвэр, тэвчээр хатуужил, даван туулах чадварыг харгалзах;

Зарим хохирогчийн хувьд зөвхөн түүнийг сонсож, ярилцах нь л сэтгэл заслын эмчилгээ болдог.

Хувь хүний зорилго, чиглэлтэй амьдрал даван туулахад бэрхшээлтэй хийгээд мухардалд оруулсан хориг саадтай учрахад үүсч байгаа сэтгэл зүйн байдлыг сэтгэл зүйн хямрал гэдэг.[62]Сэтгэл зүйн хямралын хамгийн хүнд байдал бол амиа хорлох төрх үйл юм. Амиа хорлох төрх үйл гэдэгт амиа хорлох бодол, амиа хорлох оролдлого болон амиа хорлох явдлыг оруулан тооцно.

Амиа хорлох буюу амиа хорлох оролдлого үйлдэх магадлалтай, сэтгэл гутралтай гэрч, хохирогчийн амиа хорлох бодолтой эсэхийг илэн далангүй яриулах хэрэгтэй. Ярилцлага бүтэмжтэй болох эсэх нь ярилцлага авах арга техникийг хэрхэн эзэмшсэнээс шууд хамаардаг.

Сэтгэл зүйн хямралтай хүнээр амиа хорлох аюултай хариу урвалыг нь үгээр тодорхойлуулан яриулах ярилцлагыг дунджаар 4-5 удаа явуулбал зохино. Нэг удаагийн ярилцлага 1 цаг ба түүнээс дээш хугацаагаар байж болно.

Аюулын зэргийн үнэлгээ хийхэд тохиолддог түгээмэл асуулт, хариулт

1. АЗҮ-г хийхэд хохирогч хариулт өгөхгүй байна, яах вэ?

"Аюулын зэргийн үнэлгээ хийх журам"-д АЗҮ-г хийхийн өмнө хохирогчийн эрх, үүргийг болон нөхцөл байдлыг үнэн зөв хариулах талаар тайлбарлан өгч, үнэлгээ хийгдсэнээр зөрчил, хэргийг шийдвэрлэх, хүчирхийлэл үйлдэгдэгчид авах арга хэмжээ, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний төрлийг сонгоход чухал ач холбогдолтойг тайлбарлан өгнө гэж заасан.

Иймд хохирогчийн айдсыг арилгах, сэтгэл зүйн онцлогийг анхаарч цагдаад итгэх итгэлийг бий болгоно.

2. Өглөө дуудлага өгсөн, АЗҮ хийсэн. Орой дахин дуудлага өгсөн АЗҮ-г давтан хийх үү?

"Аюулын зэргийн үнэлгээ хийх журам"-ын 2.1-д зааснаар дуудлага, мэдээлэл удаа дараа ирүүлсэн хохирогчид АЗҮ-г тохиолдол бүрт хийнэ гэж заасан. Тийм болохоор АЗҮ-г дахин хийнэ.

3. АЗҮ-г хохирогчоор бөглүүлж болох уу? Олон хохирогч байвал яах вэ?

АЗҮ-ний тэмдэглэлийг зөвхөн цагдаагийн алба хаагч хөтөлж, аргачлалын дагуу үнэлнэ. Хоёр ба түүнээс дээш хохирогч байвал хохирогч тус бүрт, эсхүл тухайн гэр бүл, орчинд аюулын зэргийн үнэлгээ хийж болно.

4. Хөгжлийн бэрхшээл (хэл ярианы болон сонсголын)-тэй хохирогч байна, АЗҮ -г яаж хийх вэ?

Хохирогч монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар АЗҮ-г хийж, орчуулагч, хэлмэрчийн гарын үсгийг зуруулна.

5. Хохирогч дуудлага өгөөгүй, АЗҮ хийлгэхгүй гэсэн тохиолдолд яах вэ?

АЗҮ хийх журамд АЗҮ хийхийн өмнө хохирогчийн эрх, үүргийг болон нөхцөл байдлыг үнэн зөв хариулах талаар тайлбарлан өгч, үнэлгээ хийгдсэнээр зөрчил, хэргийг шийдвэрлэх, хүчирхийлэл үйлдэгдэгчид авах арга хэмжээ, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний төрлийг сонгоход чухал ач холбогдолтойг тайлбарлан өгнө гэсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх.

Мөн гэр бүлийн бусад гишүүд, гэрч нараас нөхцөл байдлыг тодруулж АЗҮ-г хийж болно.

62 С.Бямбасүрэн "Сэтгэцийн эрүүл мэнд"

6. Хүүхдэд АЗҮ хийхдээ заавал эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг оролцуулах уу?

Хүүхдэд АЗҮ-г хийхдээ эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл мэргэжилтэн (сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч) байлцуулж болно. Хэрэв эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хохирогч хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй бол оролцуулахгүй бөгөөд энэ тухай тэмдэглэлд тусгана.

АСУУЛТАД ХАРИУЛНА УУ.

1. *АЗҮ-г хэн, хэзээ, хэрхэн хийх вэ? АЗҮ хийх нь яагаад чухал ач холбогдолтой вэ?*
2. *АЗҮ хийхэд анхаарах шаардлагатай өөр ямар асуудал, бэрхшээлтэй та тулгарч байсан бэ? Асуудал, бэрхшээлийг хэрхэн даван туулсан бэ?*
3. *Аюулын өндөр зэрэгт юуг хамааруулах вэ? Аюулын өндөр зэрэгтэй хохирогчтой хэрхэн харилцах вэ?*

ДЭД СЭДЭВ 2. Нөхцөл байдлын үнэлгээ

Нийгмийн ажлын үйлчилгээний эхний шатанд нийгмийн ажилтан үйлчлүүлэгчид тулгарч буй асуудлын шалтгаан, нөхцөл байдалтай холбоотой бүхий л мэдээллийг цуглуулж, тухайн үйлчлүүлэгчид хэрхэн тусалж болохыг судалдаг. Үйлчлүүлэгчийн асуудлыг тодотгох, шаардлагатай нөөц боломжийг судлах энэхүү судалгааг нийгмийн ажлын практикт нөхцөл байдлын үнэлгээ (НБҮ) гэдэг.

НБҮ-г ГБХ, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй байдал, хохирогчид учирсан, эсхүл учирч болзошгүй сөрөг үр дагавар болон түүнд үзүүлэх үйлчилгээг тодорхойлох зорилгоор сум, дүүрэг, баг, хороо, сургууль, халамжийн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан хийнэ.

НБҮ нь дүгнэлт хэлбэртэй байх ба хохирогчийн хэрэгцээг тодорхойлж, түүнд үзүүлэх тусламж, үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах болон хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх зэрэг шийдвэр, үйл ажиллагаа нь тус үнэлгээнд тулгуурлан хийгдэнэ. Иймд НБҮ нь шийдвэрлэх ач холбогдолтой мэдээлэл цуглуулах, үнэлгээ дүгнэлт өгөх цогц үйл явц юм.

НБҮ нь дараах хэд хэдэн онцлог шинжтэй. Үүнд:

- НБҮ нь тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд нэг талаас үйлчлүүлэгчийн орчин нөхцөлийг ойлгох, нөгөө талаас нийгмийн ажлын үйлчилгээний эх суурийг тавьж, үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулах үндсэн зорилготой.
- Ажилтан үйлчлүүлэгч хоёр хамтран ажиллаж байж сая үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг илүү сайн ойлгоно.
- НБҮ нь ажиглалтаас эхлээд оролцогч талуудын хоорондын харилцаа холбоог ойлгох хүртэл олон талт асуудлыг тандах судалгааны ажил байдаг.
- НБҮ нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны чиглэлийг тодорхойлох нэг үндэслэл болж болно.

Эдгээр онцлог байдлаас шалтгаалан НБҮ-гээр цуглуулсан аливаа мэдээлэл, дүн шинжилгээнд бодитой бөгөөд шүүмжлэлтэй хандахыг шаарддаг ба нотлох баримтын хэмжээнд бүрдүүлж өгсөн мэргэжилтний НБҮ нь асуудал шударгаар шийдвэрлэгдэхэд чухал үүрэгтэй.

Сүүлийн үед хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааг судлах НБҮ-г хохирогчийг чадваржуулах чиглэлд хөгжүүлж байна. Судлаач Коппийн тодорхойлсноор хохирогч идэвх зүтгэлээрээ өөрийн эрхэм чанар, үнэт зүйлсээ нээн илрүүлж, зорьсондоо хүрэх боломжоо бүрдүүлэх нь чадваржих үйл явц юм. НБҮ-г ашиглан хохирогчийн хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааны түүх, хүчирхийллийн үе шат, үр дагаврыг судлаад зогсохгүй хүчирхийллийн мөн чанар, нөхцөл байдлыг бодитоор харж, өөрийгөө таньж ойлгоход нь хохирогчид туслах боломжтой. ГБХ-ийн хохирогчийг НБҮ хийхэд татан оролцуулснаар өөртөө итгэх итгэл, өөрийгөө тодорхойлох чадварыг нь нэмэгдүүлэхэд нэн тустай.

Хүснэгт 2.3. ГБХ-ийн нөхцөл байдлын болон эрсдэлийн түвшинг зөв дүгнэхэд анхаарвал зохих асуудал

Хүчирхийлэлтэй харилцааны түүх	Нэгдүгээрт: ГБХ-ийн үе шат, хөдлөл зүй; Хоёрдугаарт: хүчирхийлэлтэй харилцааны онцлог, нөлөөлөх хүчин зүйлс; Гуравдугаарт: ГБХ-ийн явц, даамжралыг тандана.
Хохирогчийн аюулын эрсдэлийн түвшинг тогтоох	Нэгдүгээрт: хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлс; Хоёрдугаарт: хохирогчийн амьдрал, нийгмийн орчинтой холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийг судална.
Хохирогчийн аюулгүй байдлыг хангах	Нөхцөл байдал болон аюулын эрсдэлийн үнэлгээний явцад илэрсэн мэдээлэл, нотолгоонд тулгуурлан аюулгүй байдлын төлөвлөгөөг хохирогчтой хамтран боловсруулна.

Хохирогчийн амьдрал, нийгмийн орчинтой холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийг үнэлэхэд хохирогч нь нийгмийн байдал, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд хүчирхийлэл үйлдэгчээс ямар нэг хамааралтай эсэх; төрийн болон төрийн бус байгууллагын тусламж, үйлчилгээ түүний амьдарч буй газар хүртээмжтэй эсэх болон хохирогч тэдгээр үйлчилгээ, тусламж авах боломж, нөхцөлөөр хангагдсан эсэхийг нарийвчлан судална.

ГБХ үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдэл ба хохирогчийн амьдрал, нийгмийн орчинтой холбоотой эрсдэлүүдийн аль аль нь тухайн ГБХ-тэй харилцааны түүхтэй нягт холбоотой.

Зураг 2.2. ГБХ-тэй харилцааны түүх



Хүчирхийлэлтэй харилцаа нь хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл ба хохирогчийн нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэндийн байдалд хэрхэн нөлөөлж буйг ойлгоход тусална. Тиймээс дүн шинжилгээ хийхдээ хохирогчийн байр суурь, үзэл хандлагыг юуны түрүүнд ойлгож, ямар эрсдэл түүнд тулгарч байгаа, хүчирхийлэлтэй харилцаагаа орхих, эсхүл тэр харилцаандаа үлдэхэд ямар эрсдэл тулгарч болохыг хамтран тодорхойлно. Үүний тулд тухайн НБҮ хийж буй ажилтан нь хохирогчийг анхааралтай сонсож, түүний үзэл хандлагыг ойлгохыг эрмэлзэж, хүндэтгэлтэй харилцана.

Зураг 2.3. Нийгмийн эрсдэлүүд

Хохирогч дангаараа бие даан шийдэж, нөхцөл байдлыг нь хянаж чадахгүй нийгмийн шинжтэй олон эрсдэлүүд байдаг. Эдгээр эрсдэлүүдээс эдийн засаг, санхүүгийн хүндрэл, амьдарч буй газар орон нутгийн онцлог, эрүүл мэндийн байдал, шаардлага хангахгүй нийгмийн үйлчилгээ, нийгэмд тогтсон буруу хандлага, ялгаварлал гэх мэт нийгмийн олон эрсдэл бүхий хүчин зүйлсийг дурдаж болно.

Санхүүгийн хүндрэлтэй байдал

Өмнө өгүүлсэнчлэн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд ихэвчлэн санхүүгийн бие даасан байдлаа алдсан, хүчирхийлэл үйлдэгчээс эдийн засгийн хувьд хараат болсон байдаг. Тиймээс хохирогч хүчирхийлэлтэй харилцааг орхилоо гэхэд нийгмийн зүгээс ямар халамж хамгааллын үйлчилгээнд хамрагдаж болох, иргэдийн эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлж болох ямар хөтөлбөр, үйлчилгээ байдаг талаар судлах хэрэгтэй болно.

Амьдарч буй газар орон нутгийн онцлог

Хохирогчийн амьдарч буй байршил нь нийгмийн нэг хүчин зүйл болдог гэж үздэг. Хот суурин газар нийгмийн үйлчилгээ их төвлөрсөн, үйлчилгээ авах боломж нөхцөл их байдаг бол алслагдмал орон нутагт нийгмийн үйлчилгээ, тэр дундаа хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх мэргэжлийн үйлчилгээ хязгаарлагдмал. Зарим тохиолдолд, хэдийгээр хот суурин газар нийгмийн үйлчилгээ хангалттай ч тухайн үйлчилгээний талаар хохирогч мэдэхгүй, эсвэл үйлчилгээг хүртэх боломжийг хязгаарласан хүчин зүйлс (тээврийн хэрэгсэл, үнэ хөлс, үйлчилгээний төрөл, хэлбэр хязгаарлагдмал, боловсон хүчний хүртээмж хангалтгүй гэх мэт) байдгийг анхаарах хэрэгтэй.

Эрүүл мэндийн байдал

Хохирогчийн эрүүл мэндийн байдал нь хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй болон хохирогчийн нийгмийн орчны эрсдэлийн хүчин зүйлтэй холбоотой. Ялангуяа, хохирогч эмэгтэй архаг хүнд өвчтэй жишээ нь, хавдар, чихрийн шижин, астма, зүрх судасны өвчин гэх мэт даамжран хүндрэх төлөвтэй өвчтэй, эсвэл хөгжлийн бэрхшээлийн улмаас гадаад орчинтой харилцах боломж хязгаарлагдсан тохиолдолд тухайн хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн хяналт, эрхшээлд илүү их орох, хүчирхийлэлд өртөх, өөрийн аюулгүй байдлаа хангаж чадахгүй байх эрсдэл өндөр байдаг.

Шаардлага хангахгүй нийгмийн туслалцаа

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд туслалцаа үзүүлдэг байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмж шаардлага хангахгүй байх нь ГБХ газар авах нийгмийн гол эрсдэл болдог. Тухайлбал цагдаа, эмнэлэг, нийгмийн халамжийн үйлчилгээний ажилтнууд тогтсон буруу хандлагатай, ялгаварлан гадуурхах үзэлтэй байх нь үүнд хамаарна.

Нийгэмд тогтсон буруу хандлага ба ялгаварлан гадуурхал

Нийгэмд ГБХ-ийн талаар тогтсон буруу үзэл хандлага, эмэгтэйчүүдийг нас хүйс, гадаад байдал, ажил мэргэжлээр нь ялгаварлан гадуурхах үзэл түгээмэл байх нь ГБХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд саад болдог нийгмийн бас нэг эрсдэл юм. ГБХ-ийн талаар олон нийтийн дунд тогтсон буруу хандлага нь ГБХ-ийг эрт шатанд илрүүлэхэд саад болох, хохирогчид үзүүлэх нийгмийн туслалцааны үр дүнг сулруулах, хүчирхийлэл үйлдэгчийн буруу үйлдлийг өөгшүүлэх гээд олон сөрөг үр дагавартай.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид зориулсан аюулгүй байдлын төлөвлөгөө (АБТ)

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1985 онд "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглал" (Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power) баталж, түүний үзэл санааг 2002 он хүртэл хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосны дотор "хохирогчийн эрхийг хамгаалах албан ёсны бус механизмуудыг ашиглах"[63]-ыг зөвлөсөн байдаг.

ГБХ-ийн хохирогчид хуулийн байгууллагын тусламж авч чадалгүй амь насаа алдах, эрүүл мэндээрээ хохирох тохиолдол гардаг.

Өмнө өгүүлсэнчлэн ГБХ нь олон дахин давтагдах, гинжин холбоо бүхий үйлдэл байдаг тул ихэнх хүчирхийлэл үйлдэгч нь хүчирхийлэл эхлэхээс өмнө тодорхой зан үйл, зуршил гаргаж хэвшсэн байдаг. Хүчирхийлэл үйлдэгчийн энэхүү зуршил, зан үйлийг хохирогч хамгийн ихээр ойлгож, мэдэрдэг тул хүчирхийлэлтэй харилцааны

63 Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи (хохирогч судлал), Улаанбаатар хот, 2005 он.

үед өөрийн амь насыг хамгаалж, учрах аюул, эрсдэлийг бууруулах боломж нь хохирогчид өөрт нь байдаг гэж үздэг. Иймд хүчирхийлэлтэй харилцааг даван туулахад хохирогчийг чадваржуулах нь чухал бөгөөд үүнд аюулгүй байдлын төлөвлөгөө чухал ач холбогдолтой. Ялангуяа, хөдөө, орон нутагт, хуулийн байгууллагын тусламж авах бололцоо хязгаарлагдмал нөхцөлд байгаа хохирогчид аюулгүй байдлын төлөвлөгөө нэн чухал юм.

НБҮ-ний дүнд үндэслэн сум, хорооны нийгмийн ажилтан нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах, дахин хүчирхийлэл дарамтад өртөхөөс сэргийлж аюулгүй байдлын төлөвлөгөө (АБТ)-г хохирогчийн эсрэг хүчирхийлэл, дарамт үйлдээгүй болох нь тогтоогдсон гэр бүлийн гишүүн, хохирогч хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх заавар өгнө.[64] Хохирогч өөрийн эрсдэл нөхцөл байдлыг хамгийн сайн мэддэг тул АБТ-г хохирогчтой хамт зөвлөлдөн гаргадаг.

ГБХ-ийн хохирогчид зориулсан АБТ нь манай хууль зүйн болон нийгмийн ажлын практикт харьцангуй шинэ тутам ойлголт тул энэ талаар тодорхой ойлголт, мэдээлэл өгөх үүднээс АНУ-ын Канзас мужийн ГБХ-ийн хохирогчдод туслах хөтөлбөрийн Аюулгүй байдлын төлөвлөгөөний загвараас[65] товчлон танилцуулж байна.

Тус АБТ нь болзошгүй аюултай нөхцөл байдалд хохирогч амь нас, эрүүл мэндээ хамгаалахад зориулагдсан зөвлөмж хэлбэртэй бөгөөд хохирогч өөрийн нөхцөл байдалд тохирохыг сонгон хэрэглэнэ. АБТ-нд:

Гэнэт (огцом түргэн) өрнөсөн хэрэг явдлын үеийн аюулгүй байдал

- Гарах гарц бүхий орон зай руу оч. Угаалгын өрөө, гал тогоо зэрэг хутга мэс, хатуу гадаргуутай өрөөнд, эсхүл зэвсгийн ойролцоо байж болохгүй.
- Телефон утастай өрөөнд үлдэхийг хичээ. Хэрэв боломжтой бол цагдаагийн 102 дугаар, туслалцаа үзүүлэх боломжтой найз, эсхүл хөрш рүүгээ залга.
- Зугтаах гарцаа олж мэд. Гэрээсээ хэрхэн аюулгүй гарахыг урьдчилан бэлтгэ. Зугтаах замаа төсөөл.
- Баглаж бэлдсэн цүнхээ бэлэн байлга. Хэрэв хүчирхийлэгч гэрийг нэгждэг бол хурдан авч болох газар түүнийг нуу.
- Дохио болох нууц үг бодож ол. Хүүхдүүд, ач хүүхдүүд, хөршүүд болон харилцаа холбоо тогтоож болох хүмүүст цагдаагийн тусламж хэрэгтэй болох үед хэлэх код үгээ хэл.
- Хаана очиж болохоо тооцоол. Гэрээсээ явах тохиолдолд очиж болох газраа төлөвлө.
- Өөрийн үзэл бодол, шийдвэртээ итгэ.

Зугтахаар төлөвлөж буй үеийн аюулгүй байдал

- Үлдэж болох аюулгүй газартай бол. Энэ газар нь та болон таны хүүхдийг хамгаалж чадна гэдэгт та итгэлтэй байх хэрэгтэй.
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод туслах хөтөлбөрт ханд.
- Хэрэв танд шаардлагатай болсон бол эдгээр үйлчилгээг авах бүрэн боломжтой. Тэдгээрийн хаяг, утасны дугаарыг бүхий л цаг үед гартаа ойрхон байлга.
- Итгэж болох хэн нэгнийг ол. Мөнгө, илүү түлхүүр, чухал шаардлагатай баримт бичгийн хуулбар зэрэг хамгийн чухал

64 ГБХТТХ-ийн 32.3-т заасны дагуу НБҮ хийх журмыг нийгмийн хамгаллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.
65 http://dvack.org/safety_plan_-_for_victims_of_domestic_violence_30.html

хэрэгтэй зүйлсээ урьдчилан тэдэнд үлдээвэл хурдан зугтаж чадна.

- Хадгаламжийн данс нээ. Бие даасан байдлаа нэмэгдүүл. Орлого, зарлагын гүйлгээгээ тооцож бай.
- Мужийн ахмадын холбоотой холбоо барь. Хэрэв та 60-аас дээш настай бол нийгмийн аюулгүй байдлын, тэтгэврийн, орон сууцжуулах, тээврийн болон эмнэлгийн даатгал, нийгмийн болон хувийн дэмжлэг, үйлчилгээнд хамрагдах боломжтой.

Цагаачлалын статусын тухай асуудал

Хэрэв зугтах шаардлагатай болсон бол дараах зүйлсийг биедээ авч явахыг зөвлөдөг:

- Гэрлэлтийн болон жолоочийн гэрчилгээ, үнэмлэх
- Төрсний гэрчилгээ- таны болон гэр бүлийнхний
- Мөнгө, чек, кредит карт, АТМ карт, орон сууцны төлбөр тооцооны дэвтэр, автомашины гэрчилгээ.
- Нийгмийн даатгалын карт, ажлын үнэмлэх, ногоон карт, иргэний үнэмлэх
- Гэрлэлт цуцлуулсан, эрх хязгаарлуулсан зэрэг баримт бичиг
- Даатгалын болон эмнэлгийн хуудас
- Лизинг, түрээсийн гэрээ гэх мэт
- Сургуулийн болон эрүүл мэндийн тэмдэглэл
- Байшин, машин, оффис, найзын түлхүүр
- Эм, нүдний шил, сонсголын аппарат зэрэг танд болон таны гэр бүлд хэрэгтэй эд зүйлс
- Хувийн эд зүйлс, хаягийн дэвтэр, зураг, тоглоом гэх мэт.

Гэр доторх аюулгүй байдал (Хэрэв хүчирхийлэгч тантай хамт амьдардаггүй бол)

- Аюулгүйн систем суурилуул
- Аюулгүй байдлаа төлөвлө
- Утасны дугаараа соль
- Хөрш болон газрын эзэнтэйгээ ярилц
- Хууль зүйн зөвлөлгөө ав

Аюулгүй байдал болон сэтгэл зүйн эрүүл мэнд

- Эерэгээр бод
- Унш
- Дэмжлэг ав
- Өөрийнхөө аюулгүй байдлын төлөө бүхнийг хий

Аюулгүй байдал болон хүүхэд

- Сургууль болон хүүхэд асрах газарт хэл
- Хүүхдүүдийн аюулгүй газрыг өөрчил

Ажил дээрх аюулгүй байдал

- Хэн нэгэнд хэл
- Дуудлагаа шалга
- Аюулгүй байдлаа төлөвлө.

АСУУЛТАД ХАРИУЛНА УУ.

1. *АЗҮ болон НБҮ-ний нийтлэг болон ялгаатай шинж нь юу вэ?*
2. *НБҮ хийхэд хууль сахиулах байгууллагууд ямар, ямар чиг үүрэгтэй оролцох вэ? Юуг анхаарах шаардлагатай вэ? Яагаад?*
3. *Таны бодлоор АБТ нь хохирогчийн аюулгүй байдлыг хангахад хэр ач холбогдолтой вэ? Аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулахад юуг анхаарах шаардлагатай вэ?*

НБҮ хийж, хохирогчийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, зөвлөгөө өгнө үү.

Иргэн С нөхөр Б-тэйгээ 2012 онд танилцан гэрлэлтээ батлуулж 2 хүүхдийн эцэг, эх болсон байна. Б нь гэрлэлтээ батлуулсан үеэс эхлэн эхнэр С-ыг ажил хөдөлмөр эрхлэхэд нь дургүйцэн, хардаж зоддог болсон. Түүний зодуурын улмаас С, Б нарын анхны хүүхэд эндэж, том хүү Э төрөлхийн саажилт өвчтэй төрсөн байна. С нь нөхрийнхөө

байнгын хүчирхийлэлд өртдөг байдлаа эцэг эх, хамаатан саднаасаа байнга нууцалдаг байсан бөгөөд 2014 онд нөхөртөө зодуулсан талаараа 2 удаа цагдаагийн байгууллагад хандан дуудлага мэдээлэл өгсөн боловч Б-ийн ятгалга, дарамтаас болж өргөдлөө буцаан авсан байна.

С, Б нарын 2 хүүхэд 3-7 настай бөгөөд байнгын хүчирхийлэлд өртдөг байдлаасаа болж зарим тохиолдолд орондоо бие засах, шалтгаангүйгээр орилж уцаарлах, эсхүл удаан хугацаагаар дуугаа хураах болсон. Мөн Б нь 2 хүүхдийнхээ дэргэд байнга архидан согтуурч, согтуу үедээ хүүхдүүдээ зодож, өвлийн хүйтэнд гадаа хөл нүцгэн зогсоох, удаан хугацаагаар хоол өгөхгүй байх зэргээр тарчлаадаг байсан. 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 02 цагийн орчимд Б согтуурсан үедээ С-ыг боомилон, хутгаар гарыг нь зүсч, галын хайчаар 2 гуя, хэвлий хэсгийг нь түлж, гэрээсээ 2 хүүхдийнхээ хамт хөөсөн байна. С эмнэлгийн байгууллагаас тусламж авсныхаа дараа гэрлэлтээ цуцлуулах талаар хэлэхэд Б өөрийнхөө зүүн гарын эрхий хуруу тайрч С-д өгөөд гэрлэлтээ цуцлуулбал амиа хорлоно гэж сүрдүүлсэн.

Мөн 2019 оны 08 дугаар сард Б согтуурсан үедээ дахин С-г зодож бүгдийг нь ална гэж заналхийлэн олон ширхэг нойрны эмийг С болон 2 хүүхэддээ хүчээр уулгажээ. Энэ байдлыг сонссон хөрш айл цагдаагийн байгууллагад дуудлага өгсөн байна.

2.3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ

2016 онд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг цагдаагийн байгууллагад шилжиж ирсэн. Энэ хугацаанд цагдаагийн байгууллага нь эрүүгийн хэргийн гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий иргэдийн аюулгүй байдлыг ханган ажилласан бөгөөд хэрэгжүүлсэн хамгаалалтын арга хэмжээ, хамгаалалтад хамрагдсан иргэдийн тоон үзүүлэлтийг харуулбал:

- 2016 онд 33 хамгаалалтын арга хэмжээгээр 42,
- 2017 онд 21 хамгаалалтын арга хэмжээгээр 36,
- 2018 онд 51 хамгаалалтын арга хэмжээгээр 65,
- 2019 онд 144 хамгаалалтын арга хэмжээгээр 134,
- 2020 оны I улирлын байдлаар 41 хамгаалалтын арга хэмжээгээр 30 иргэний аюулгүй байдлыг ханган ажилласан байна.

Дээрхээс үзвэл жил ирэх тусам хамгаалалтын арга хэмжээний хэлбэр, хамгаалуулагч иргэний тоо өссөөр байгаа нь бид цагдаагийн байгууллагын алба хаагчдыг гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд мэргэшүүлэх хэрэгцээ, шаардлага зайлшгүй тулгарч байна.

ДЭД СЭДЭВ 1. Гэрч, хохирогчийн хамгаалалт, түүний үндэслэл, журам

ГБХ-ийн хэргийн онцлогтой холбоотойгоор гэрч нь ихэвчлэн хохирогч, холбогдогч нартай ойр дотно, төрсөн болон хадам эцэг, эх, үр хүүхэд, хамаатан садан байдаг.

Энэ нь хэргийн илрүүлэлт, бодит байдлыг тогтоон үнэлэхэд сөргөөр нөлөөлөх, хохирогч, холбогдогч нарын зүгээс ятгах, дарамтлах, мэдүүлэг өгөхгүй байхыг гэрчид тулган шаардах, үр хүүхэд нь гэрч болсон тохиолдолд гэр бүлээ бүрэн бүтэн авч

үлдэхийн тулд эцэг, эхийнхээ эсрэг мэдүүлэг өгөхийг хүсэхгүй байх, татгалзах шалтгаан болдгийг та бүхэн мэднэ.

Мөн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч хоёр сэтгэл зүйн болон эдийн засгийн харилцан хамааралтай байдгаас шалтгаалан хуулийн байгууллагад хандсан хохирогчийг хүчирхийлэл үйлдэгч өөрөөсөө уравсан хэмээн өш санах, дарамтлах, эдийн засгийн хувьд хүнд байдалд оруулах, гомдлоо татаж авахыг шаардан заналхийлэх үзэгдэл түгээмэл гардаг.

Иймд ГБХ-ийн гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг авах, түүний хэрэгжилтэд онцгой анхаарал хандуулан ажиллах, гэрч, хохирогчийг дахин хүчирхийлэлд өртөхөөс хамгаалахаас гадна сэтгэл зүйн хувьд гадны нөлөөнд автагдахаас давхар сэргийлэх шаардлагатай байдаг.

ГБХТтХ-ийн 34 дүгээр зүйлд ГБХ-ийн хохирогчид үзүүлэх аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээг дараах 3 хэлбэртэй байхаар тусгасан байна. Үүнд:

Гэр бүлийн орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд нь бусад төрлийн гэмт хэргээс онцлогтой тул хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн хувийн байдлыг тогтоох, хүчирхийлэгч энэ гэмт хэргийг үйлдсэн үү, эсхүл байнгын ГБХ, дарамтад байснаас сэтгэл санаа цочрон давчдаж, хохирогчийн зүгээс энэ гэмт хэргийг үйлдсэн үү гэдгийг нарийн тогтоож, хамгаалалтын арга хэмжээг сонгон хэрэглэхдээ анхаарах ёстой юм.

ГБХ-ийн гэмт хэргийн хохирогчид хамгаалалтын арга хэмжээг авахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан үзэх нь зүйтэй. Үүнд:

- Хохирогч, хүчирхийлэл үйлдэгчтэй үргэлжлүүлэн хамтран амьдарч байгаа эсэх, хамтран амьдрах боломжтой эсэх
- Хохирогчийн өмнөх салах гэсэн, эсхүл тусламж авах гэсэн оролдлогууд амжилтгүй болсон, эсхүл давтан хүчирхийлэлд өртсөн эсэх
- Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийн үйлдлийг хянадаг эсэх
- Хохирогч болон хүчирхийлэл үйлдэгч нар нь дундын хүүхэдтэй бөгөөд тухайн этгээд хүүхдүүдтэй харилцдаг эсэх, хүчирхийлэл үйлдэгчийн асрамжинд байдаг эсэх;
- Гэр бүлийнхэн болон хамаарал бүхий этгээдүүд нь хохирогчийг мэдүүлэг өгөхөөс татгалзахыг шаардаж дарамт үзүүлдэг эсэх;
- Хохирогч өмнө нь хуулийн байгууллагад хандаж итгэл алдарсан, тэдгээр байгууллагууд хүчирхийллийг зогсоож чадахгүй гэсэн хандлагатай эсэх;
- Хүчирхийлэл үйлдэгчээс санхүүгийн хувьд хараат эсэх;
- Хохирогчийн биед учирсан гэмтлийн зэрэг, хүчирхийллийн давтамж;
- Хохирогчийн амь насанд заналхийлдэг, хүчирхийлэл үйлдэхдээ зэвсэг хэрэглэдэг эсэх;
- Хүчирхийлэл үйлдэгч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэдэг эсэх, хэрэглэдэг бол давтамж;
- Хүүхдүүдтэй харгис догшин харилцдаг эсэх;
- Хүчирхийлэл үйлдэгчийн хувийн байдал, ажил эрхэлдэг эсэх, эрүүгийн хариуцлага болон захиргааны арга хэмжээ авагдсан байсан эсэх;
- Хохирогчийн аюулгүй байдалд учирч болох эрсдэл;
- Хамгаалалтад авснаар олон нийтэд учирч болох эрсдэл;
- Гэрч, хохирогчийн өгсөн, өгөхөөр зөвшөөрсөн мэдээлэл, нотлох баримтын ач холбогдол;
- Нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн түвшин;
- Хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал;
- Хамгаалах арга хэмжээ хэрэглэх эсэхийг

тодорхойлох сэтгэл зүйн сорилын үр дүн зэрэг.

Хүчирхийлэл үйлдэгдэж байх үед хохирогчийг хамгаалах шуурхай арга хэмжээ авч, түүний нөхцөл байдлыг ойлгож ажиллах хэрэгтэй. Хэрэв хүчирхийлэл үйлдэгч ял шийтгэл хүлээхгүй үлдвэл түүний эрх мэдэл, хохирогч хүчирхийлэлд өртөх эрсдэл улам ихэснэ.

Хууль сахиулах байгууллагын ажилтнууд нь ГБХ-ийн хэргийг шийдвэрлэхдээ хохирогчийн аюулгүй байдлыг тэдний итгэл үнэмшилтэй тэнцвэржүүлэх ёстой байдаг. ГБХ-ийн хэргийн хохирогчийг хамгаалахад эрх бүхий субъектүүд нь дараах онцгой үүрэгтэй ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Хохирогчийг хамгаалах шийдвэрийг эрх бүхий албан тушаалтнаар гаргуулах (шүүгч, прокурор) яаралтай хамгаалалтын арга хэмжээ авах тохиолдолд цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, гэхдээ хохирогчийг хамгаалалтад авч буй боловч хохирогч энэ шийдвэрээ чөлөөтэй гаргах боломжийг нь бүрдүүлж саналыг нь авах;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу авч байгаа хамгаалалтын зарим арга хэмжээг шүүгчийн захирамжийн дагуу авах шаардлагатай байдаг тул энэ талаарх саналаа яаралтай шүүхэд хандан гаргана. Мөн цаашид гэрч, хохирогчид хамгаалалтын арга хэмжээг авах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд хүчингүй болгох, хүчингүй болгуулахаар шүүхэд санал гаргах эрхтэй. Хамгаалалтын арга хэмжээг цуцалснаар хохирогчийг илүү аюулд учруулж болох эрсдэлийг нарийн тооцно.

ГБХ нь тодорхой нэг хохирогчийн эсрэг бус нийгмийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг бөгөөд нийгэмд бүхэлд нь хамааралтай байдаг. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хэрэгтэнд хариуцлага хүлээлгэх үүднээс хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор нь ГБХ-ийн хэргийг анхааралтай, хариуцлагатай авч үзэх үүрэгтэй. Тэд хөндлөнгөөс үр дүнтэй оролцож, хамгаалалтын арга хэмжээг оновчтой сонгосноор дахин гарч болзошгүй байсан ГБХ, түүний дотор хүн амины хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой юм.

Хамгаалуулах эрх үүсэх

ГБХ-ийн гомдол, мэдээллийг шалгахдаа ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хохирогчийн эрхийг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүснэ.

Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх үндэслэл нь гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт, эсхүл мөрдөгч, прокурорын бичгээр гаргасан санал байна.

Цагдаагийн алба хаагч ГБХ-д өртсөн хохирогчийн аюулгүй байдлыг хангахдаа доорх хүчин зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

1. Хохирогчийн аюулгүй байдалд учирч болох эрсдэл;
2. Хамгаалалтад авснаар олон нийтэд учирч болох эрсдэл;
3. Хохирогчийн өгсөн, өгөхөөр зөвшөөрсөн мэдээлэл, нотлох баримтын ач холбогдол;
4. Нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн түвшин;
5. Хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал;
6. Хамгаалах арга хэмжээ хэрэглэх эсэхийг тодорхойлох сэтгэл зүйн сорилын үр дүн;
7. Хамгаалалтын арга хэмжээний төрөл;
8. Бусад.

Мөрдөгч гэрч, хохирогчийг хамгаалуулах үндэслэл тогтоогдвол Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан урьдчилан сануулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг бие даан хэрэгжүүлнэ. Бусад хэлбэрийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ саналаа прокурорт хүргүүлэн шийдвэр гаргуулна.

Шийдвэрийг Улаанбаатар хотод Цагдаагийн төв байгууллагын Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжид, орон нутагт нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Эрүүгийн цагдаагийн тасагт хамгаалуулагчийн хамт хүргүүлнэ.

Гэрч, хохирогчийг хамгаалах нэгж нь гэрч, хохирогчийг хамгаалалтад авах ажлыг

зохион байгуулах ба түүнд холбогдох цагдаагийн байгууллага дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

Аюулгүй байдлын хамгаалалтыг цуцлах үндэслэл

Аюулгүй байдлын хамгаалалтыг дараах үндэслэлээр цуцална:

- хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн бичгээр гаргасан хүсэлт;
- аюулгүй байдлын хамгаалалт хэрэглэх шийдвэр гаргасан албан тушаалтан, эсхүл түүний дээд шатны албан тушаалтны шийдвэр.

Мөрдөгч дараах үндэслэлээр аюулгүй байдлын хамгаалалтыг цуцлах шийдвэр гаргана:

- гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нөхцөл байдал арилсан;
- хамгаалуулагч нь аюулгүй байдлын хамгаалалтын шаардлага, арга хэмжээг санаатайгаар удаа дараа зөрчсөн.

Прокурорын хяналтын ажилд болон хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагаж мөрдөх аргачилсан заавар[66]-т зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах явцад гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.3-т заасны дагуу тэдгээрийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор прокурор нь хэрэг бүртгэгч, мөрдөгчийн саналыг үндэслэн дараах тогтоол гаргана:

- Гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ авах тухай;
- Гэрч, хохирогчийг биечилсэн хамгаалалтад авах тухай;
- Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлал (овог, эцэг, эх, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь буй үл хөдлөх хөрөнгө, харилцах утас, тээврийн хэрэгслийн улсын дугаар г.м)-ыг хангах арга хэмжээ авах тухай;
- Иргэний бүртгэл, автотээврийн болон бусад байгууллагын мэдээлэл, лавлагааны сангаас гэрч, хохирогчийн хувийн мэдээллийг задруулахыг түр хугацаагаар хориглох тухай;
- Гэрч, хохирогчийг нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах; Гэрч, хохирогчийн биед болон орон байранд тусгай техник, хэрэгсэл суурилуулах тухай;
- Гэрч, хохирогчийг аюулгүй байдал хангагдсан газарт түр байрлуулах тухай.

Хэрэг бүртгэгч, мөрдөгч дээрх тогтоолыг арга хэмжээ авагдсан этгээдэд танилцуулан гарын үсэг зуруулж, хэрэгжилтэд хяналт тавина. Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол прокурор нь мөрдөгчийн хүсэлтийг үндэслэн шүүхэд дараах саналыг бичгээр гаргана:

- Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргуулах тухай;
- Гэрч, хохирогчийн иргэний бүртгэлд өөрчлөлт оруулж, баримт бичиг (иргэний болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, гадаад паспорт, гэрлэлтийн баталгаа, диплом болон бүх төрлийн зөвшөөрөл зэрэг албаны баримт бичиг, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийн гэрчилгээ, эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цэргийн бүртгэл, эдгээртэй адилтгах нийгмийн хамгаалал, халамжтай холбоотой бусад)-ийг солих шийдвэр гаргуулах тухай;
- Насанд хүрсэн гэрч, хохирогчийн гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчлөх шийдвэр гаргуулах тухай.

Нууцлалыг хамгаалах үүднээс гэрч, хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэсэн дараах шийдвэрийг хавтаст хэрэгт хавсаргахгүй:

66 http://dvack.org/safety_plan_-_for_victims_of_domestic_violence_30.html

- Сэжигтэн, яллагдагчаас гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ авах тухай прокурорын тогтоол;
- Иргэний бүртгэл, автотээврийн болон бусад байгууллагын мэдээлэл, лавлагааны сангаас хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн хувийн мэдээллийг задруулахыг түр хугацаагаар хориглох тухай прокурорын тогтоол;
- Гэрч, хохирогчийг нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах тухай прокурорын тогтоол;
- Гэрч, хохирогчийн бие болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулах тухай прокурорын тогтоол;
- Гэрч, хохирогчийг аюулгүй байдал хангагдсан газарт түр байрлуулах тухай прокурорын тогтоол;
- Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэх тухай шүүгчийн захирамж;
- Гэрч, хохирогчийн гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчлөх тухай шүүгчийн захирамж.

Хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах, прокурорын хяналтын болон шүүхийн шатанд ГБХ-ийн гэрч, хохирогчийг хамгаалах үндэслэл байгаа эсэхийг холбогдох албан тушаалтнууд харгалзан үзэж, хамгаалалтын арга хэмжээг цаг алдалгүй авч байхад анхаарах шаардлагатай.

ДЭД СЭДЭВ 2. Гэрч, хохирогчийн хамгаалалтын арга хэмжээний хэлбэр, анхаарах зүйл

Цагдаагийн байгууллагаас ГБХ-ийн гэмт хэргийн гэрч, хохирогчид Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээнд 2018-2020 оны эхний 05 сарын байдлаар мөрдөгч ГБХ-ийн 97 гэрч, хохирогч /хамаарал бүхий этгээд/-д урьдчилан сануулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг /АБХАХ/ 82, тодорхой үйлдлийг хязгаарлах АБХАХ-г 11, биечилсэн хамгаалалт АБХАХ-г 6, тусгай техник хэрэгслээр хангах АБХАХ-г 3, аюулгүй газар түр байрлуулах АБХАХ-г 3 удаа, нийт 97 хамгаалуулагчид 106 аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж ГБХ-ийн гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангасан байна.

Хүснэгт. 2.4

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гэрч, хохирогчдод гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлсэн талаарх улсын хэмжээнтй нэгдсэн тооон мэдээ /2018-2020 оны 05 сарын байдлаар/

№	ГБХ ЭХТА-11.7	Гэрч				Хохирогч				Хамаарал бүхий этгээд				Нийт хамгаалуулагч	Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ						Нийт аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ
	Он	Насанд хүрсэн		Насанд хүрээгүй		Насанд хүрсэн		Насанд хүрээгүй		Насанд хүрсэн		Насанд хүрээгүй			Урьдчилан сануулах	Тодорхой үйлдлийг хязгаарлах	Биечилсэн хамгаалалт	Мэдээллийн нууцлалыг хангах	Тусгай техник хэрэгслээр хангах	Аюулгүй газарт түр байрлуулах	
		эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм								
1	2018 он		3				21		1			1	2	22	18	3	1			1	23
2	2019 он		3				43	4	4					55	46	5	3		2	2	58
3	2020.01-05 сар						20							20	18	3	2		1		25
	Нийт		6				84	4	5			1	2	97	82	11	6		3	3	106

Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ нь аюулгүй байдлын арга хэмжээ, сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ гэсэн хоёр төрөлтэй байх[67] бөгөөд аюулгүй байдлын арга хэмжээ нь бодит орчинд хамгаалалтад байгаа субъект ямар нэг аюул занал,

67 Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 6 дугаарзүйлийн 6.1 5, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1

халдлага дайралтад өртөхөөс сэргийлэх зорилготой бол сэтгэл зүйн арга хэмжээ нь гэрч, хохирогч сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас, түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх шинжтэйгээрээ онцлог.

Зураг 2.4: Хамгаалалтын арга хэмжээний төрөл

Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болно. Хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэнэ.

Урьдчилан сануулах

Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд халдахаар заналхийлбэл тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар шүүгч, прокурор, мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

Тодорхой үйлдлийг хязгаарлах

Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна.

Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээ авсан эрх бүхий албан тушаалтан хязгаарлах арга хэмжээ авахуулсан этгээдээр гарын үсэг зуруулж, түүнд хяналт тавина.

Биечилсэн хамгаалалт

Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авна. Энэ хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно.

Мэдээллийн нууцлалыг хангах

Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэлийн талаарх мэдээлэлд өөрчлөлт оруулах, зохиомол нэр хэрэглэх, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөрчлөх зэрэг арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Мөрдөгч иргэний бүртгэлийн, автотээврийн болон бусад байгууллагын мэдээлэл, лавлагааны сангаас хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн болон хамаарал бүхий этгээдийн хувийн мэдээллийг задруулахыг түр хугацаагаар хориглох шийдвэр гаргаж болно.

Гэрч, хохирогчийн нуцалбал зохих мэдээллийг Төрийн болон албаны нуцын тухай хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд танилцуулж болно.

Хувийн хамгаалалтын хэрэгсэл болон тусгай хэрэгсэл

Техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах. Нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.

Аюулгүй газарт түр байрлуулах

Насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

Нүүлгэн шилжүүлэх

Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ. Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно.

Баримт бичгийг солих

Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн иргэний бүртгэлд өөрчлөлт оруулж, баримт бичгийг солино. Гэрч, хохирогчийн баримт бичгийг солих аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд дараах баримт бичгийн өөрчлөлт хамаарна:

- Иргэний болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, гадаад паспорт, гэрлэлтийн баталгаа, диплом болон бүх төрлийн зөвшөөрөл зэрэг албаны баримт бичиг;
- Эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цэргийн бүртгэл, эдгээртэй адилтгах нийгмийн хамгаалал, халамжтай холбоотой бусад баримт бичиг;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
- Хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийн гэрчилгээ;
- Шаардлагатай бусад баримт бичиг.

Гэрч, хохирогч овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээ өөрчлөх тохиолдолд урьд өмнө гүйцэтгээгүй байгаа үүргийнхээ талаар эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй ба ийнхүү мэдэгдээгүйгээс үүсэх үр дагаврыг Засгийн газар хариуцахгүй.

Гадаад төрхийг өөрчлөх

Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалалтын өөр арга хэмжээгээр хангах боломжгүй тохиолдолд түүний зөвшөөрснөөр гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчилж болно.Энэ аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг насанд хүрээгүй гэрч, хохирогчид хэрэглэхгүй. Гэрч, хохирогчийн гадаад төрхийг мэс заслын бус аргаар өөрчлөх (үс засалт, үс, нүдний өнгийг өөрчлөх гэх мэт) хамгаалалтын арга хэмжээ авч болно.

Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

Гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд дараах арга хэмжээ хамаарна:

- Гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах;
- Гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;
- Шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;
- Шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах;
- Шаардлагатай бусад арга хэмжээ.

ГБХ-ийн гэмт хэргийн гэрч, хохирогчид хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэг гарсан шалтгаан, нөхцөл, давтамж, учирсан гэм хор, гэрч, хохирогч болон холбогдогчийн хувийн байдалд тохируулан сонгох шаардлагатай.

ДЭД СЭДЭВ 3. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтад авах

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт,

үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах, эрхээ зөрчигдсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй байдаг.

Зураг. ГБХ-ийн улмаас гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхэд, 2017-2019 он.



ГБХ-д өртсөн хүүхдийг хамгаалах, тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ ГБХ-тэй тэмцэх тухай хууль, ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/29 дүгээр тушаалаар батлагдсан "ГБХ-д өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам", мөн сайдын 2017 оны А/39 дүгээр тушаалаар батлагдсан "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах журам"-ыг тус тус үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр бүлэгт "Хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах" талаар хуульчилсан. Тухайлбал:

- Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн, асран халамжилж байгаа этгээд хамгаалах үүрэгтэй.
- Хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, ялгаварлан гадуурхах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, заналхийлэх, хүч хэрэглэх, зодож шийтгэх, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, үл хайхрах, хүүхдийн дэргэд архидан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэхийг хориглодог.
- Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй гэж үзвэл төрийн, төрийн бус байгууллагын ажилтан, хуулийн этгээд, бусад этгээд цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, багийн Засаг даргад болон хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх утасны үйлчилгээнд мэдээлэх үүрэгтэй.
- Бүх шатны боловсролын байгууллагын багш, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, ажилтан нь хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүрэгтэй.
- Хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх утсаар хүлээн авсан мэдээллийг цагдаагийн байгууллага, эсхүл сум, багийн Засаг даргад хүргэх, хүүхдэд зөвлөгөө өгөх, шаардлагатай үйлчилгээ, туслалцаанд холбох ажиллагааг гэр бүл, хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага хэрэгжүүлнэ.
- Хүүхэд хохирсон, эрсдэлтэй нөхцөлд байгаа тухай мэдээллийг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэж, холбогдох үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдээлэл хүлээн авсан цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг дарга хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах

зорилгоор хуульд заасан үүргээс гадна дараах арга хэмжээг авна:

а) хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх;
б) хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх арга хэмжээг авах боломжгүй бол эцэг, эх, төрөл, садангийн болон бусад этгээд, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх;
в) хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх.
г) хүүхдийн байгууллага, ажилтанд мэдээлэх.

Хүүхдийг хүчирхийлэл үйлдэгчээс тусгаарлах арга хэмжээ авсан нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

Хүүхдийг хамгаалсан нөхцөлд хүчирхийлэл үйлдэгчийн тухайн хүүхэдтэй уулзах, харилцах эрх хязгаарлагдах бөгөөд хүүхдийг тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөхгүй.

ГБХ-ийг таслан зогсоох, хүүхдийн эрхийг хангахдаа дараах нөхцөл байдлыг заавал тогтооно. Үүнд:

1. Хохирогч болон гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, ГБХ-тэй тэмцэх тухай хуульд заасан журмын дагуу аюулын зэргийн үнэлгээ хийж, түүнийг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотных нь хүний хамгаалалтад өгөх;
2. Аюулын зэрэг өндөртэй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа нийгмийн ажилтанд мэдэгдэх;
3. Хохирогчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичгээр өгөх;
4. ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 8.1.1-8.1.3, 8.1.8-д заасан хохирогчийн эрхийг хамгаалах арга хэмжээ авах.

Хүүхэд өөрийн хууль ёсны төлөөлөгчийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд аюулын зэрэг дунд болон өндөр, эсхүл дараах нөхцөл тогтоогдвол хууль ёсны төлөөлөгчийн саналыг харгалзахгүйгээр хүүхдийг хамгаалах арга хэмжээг авна. Үүнд:

1. Хүчирхийллийг хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй;
2. Хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй;
3. Хүүхдийн эмзэг байдлыг далимдуулан өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, ашиглаж болзошгүй;
4. Хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, оруулж болзошгүй;
5. Хүчирхийлэл үйлдэгч соглуурсан, мансуурсан байдалтай, эсхүл байнга соглуурдаг, мансуурдаг.

!

ГБХ-ийн гэмт хэрэгт хүүхэд шууд болон шууд бус байдлаар биеийн болон сэтгэл зүйн хохирогч болдог тул хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалт авах нь чухал юм.

III ХЭСЭГ

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН БОЛОН ШҮҮГЧИЙН АНХААРАХ АСУУДАЛ

3.1. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДЫН АНХААРАХ АСУУДАЛ

Удиртгал

Сүүлийн жилүүдэд нийгэмд мэдээллийн хурд нэмэгдэж, төрийн болон ТББ-аас хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр багагүй ажлууд хийсний дүнд иргэдийн ойлголт, мэдлэг, хандлага өөрчлөгдөж байна. Энэ хэрээр цагдаагийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авах хүсэлт болон тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор ГБХ-ийн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ, холбон зуучлах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, цагдаагийн байгууллагын алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, ялангуяа, албан хаагчдын хэвшмэл үзэл, хандлагыг өөрчлөх, хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдэд чиглэсэн нийгэм, эрх зүйн үйлчилгээг цогцоор хөгжүүлэх асуудал нэн чухал байна. Бодит байдал дээр, зарим цагдаагийн байгууллагын алба хаагчдын зүгээс энэ төрлийн гэмт хэргийг гэр бүлийн дотоод асуудал, ахуйн хүрээний хэрүүл, маргаан гэж үзэх, гэр бүлийн дотоод асуудалд оролцох ёсгүй гэсэн байр сууринаас хандах байдал гаргадаг нь хүчирхийлэл үйлдэгчийг өөгшүүлэх, гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт хангалтгүй байх сөрөг үр дагавар үүсгэж байна.

ГБХ үйлдэх гэмт хэргийг бусад төрлийн гэмт хэргээс ялгах, онцлог шинжийг харгалзан мөрдөн шалгах, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа явуулах хэрэгтэй бөгөөд энэ талаар тусгайлсан мэдлэг, ойлголтгүй тохиолдолд мөрдөн шалгах, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх арга тактикаа боловсруулахад хүндрэл учирна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан гарын авлагын цагдаагийн байгууллагын ажилтанд зориулсан энэ хэсгийн гол зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- ГБХ-ийн дуудлага, мэдээллийн онцлог, шалгах ажиллагааны явцад анхаарах асуудлын талаар нэгдсэн ойлголттой болохыг чухалчлах;
- ГБХ-ийн дуудлага, мэдээллийг шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний талаар тодорхой мэдлэгтэй болох;
- ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг ялгах, нотлох баримт цуглуулах, шалгах ажиллагааны явцад анхаарах асуудлын талаар нэгдсэн ойлголттой болох;
- ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэрэг тус бүрийг шалгах ажиллагааны арга, тактикаа хөгжүүлэх;
- ГБХ-ийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчтэй харилцах ур чадвараа дээшлүүлэх;
- ГБХ-ийн гэрч, хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлэх;
- ГБХ-ээс урьдчилан сэргийлэхэд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, хамтарсан багийн үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй болж, хууль хэрэгжүүлэх мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх зэрэг болно.

Нэр томьёо:

- Дуудлага
- Мэдээлэл
- Хандлага
- Нотлох баримт
- Зөрчил шалгах ажиллагаа
- Хүчирхийлэлтэй харилцааны түүх
- Мэдүүлэг
- Мөрдөн шалгах ажиллагаа
- Шууд туслалцаа
- Нэг цэгийн үйлчилгээ
- Түр хамгаалах байр
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээ
- Урьдчилан сэргийлэх

3.1.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ДУУДЛАГА, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ДЭД СЭДЭВ 1: Дуудлага, мэдээлэл шалгах ажиллагаа

Цагдаагийн алба хаагч нь гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээллийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т заасны дагуу тэргүүн ээлжинд шалгаж шийдвэрлэнэ.

Энэ төрлийн дуудлага, мэдээллийг шалгахад алба хаагч бүр хариуцсан чиглэлээр үүрэг хүлээж, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах, нотлох баримтыг бүрэн бүрдүүлэх ажилд анхаарч ажиллана.

Цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авахдаа "Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах /код 202/ журам"-ыг баримтална.

А. Мэдээлэл хүлээн авагч, жижүүрийн цагдаагийн үүрэг:

- Дуудлага, мэдээлэл өгсөн иргэний аюулгүй байдлыг асууж, цагдаагийн ажилтан очих боломжтой хугацааны талаар мэдэгдэнэ.
- Аюулгүй байдлыг хангах үүднээс цагдаагийн ажилтан хэргийн газар дээр очтол дуудлага өгсөн иргэнийг утсан дээр байлгаж байхыг эрмэлзэнэ.
- Мэдээллийн сангаас тухайн утас, айл өрх, дуудлага өгөгч болон хүчирхийлэл үйлдэгчийн мэдээллийг шалгаж, дуудлага шалгах цагдаагийн ажилтанд өгнө.
- Дуудлага, мэдээлэл өгөгч дараагийн дуудлагаараа эхний дуудлагыг хүчингүй болгуулах хүсэлт тавьсан ч эхний дуудлагыг хүчингүй болгохгүй. Дуудлагыг үргэлжлүүлэн шалгаж, талууд аюулгүй гэдгийг баталгаажуулна.
- Хүчирхийлэл үйлдэгч гарч зугтсан эсхүл худлаа дуудлага, хаяг нь олдохгүй, дуудлага өгсөн утас нь холбогдохгүй, өөр утсаар дуудлага өгсөн зэрэг шалтгаанаар эхний дуудлагыг хүчингүй болгохгүй, үргэлжлүүлэн шалгаж, хохирогчийн аюулгүй байдлыг баталгаажуулна.
- Дуудлага, мэдээллийг цахим санд бүртгэн, дуудлагын бичлэгийг хадгална.
- Дуудлага өгсөн хүнтэй хүчирхийлэл үйлдэгчид оногдуулах хариуцлагын талаар урьдчилан ярилцах ёсгүй.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, 23.7 дахь заалтыг баримтлан дуудлага, мэдээлэл өгсөн иргэний нууцлалыг хангаж ажиллана.

Б. Жижүүрийн ахлах мөрдөгч, мөрдөгчийн үүрэг:

- Дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж байгаа цагдаагийн ажилтнуудын шалгах ажиллагааг удирдан, зааварчилж, шуурхай ажиллагааг удирдана.
- Эргүүлд ажиллах алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангуулах, ГБХ-ийн дуудлага, мэдээллийг шалгах үед аюулын зэргийн үнэлгээ хийх маягт зэрэг шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хангуулна.
- Утсаар дуудлага өгч байх явцад дуудлага тасарсан, эсхүл түүнийг үгүйсгэсэн шинжтэй мэдээллийг өөр хүн өгсөн тохиолдолд дуудлага хаанаас ирснийг тогтоох, хаягаар нь шалгуулах арга хэмжээг авна.
- Цагдаагийн ажилтны хүргэж ирсэн болон өөрөө хүрч ирсэн хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч нарын хэрэг, зөрчлийн асуудлыг шийдвэрлэнэ.
- Дуудлага өгсөн айл болон иргэний талаарх мэдээллийг сангаас шүүж, дуудлагаар очиж буй алба хаагчийг мэдээллээр хангана.
- Хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй

байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг шуурхай авна.

- ГБХ-ийн дуудлага, мэдээлэл шалгасан байдал хангалтгүй бол шалгалтын дүнг хүлээн авалгүй буцааж, зөрчил дутагдлыг арилгуулна.
- Хүчирхийлэл үйлдэгч гарч зугтсан, эсхүл худлаа дуудлага, хаяг нь олдохгүй, дуудлага өгсөн утас нь холбогдохгүй, өөр утсаар дуудлага өгсөн зэрэг шалтгаанаар эхний дуудлагыг хүчингүй болгохгүй, үргэлжлүүлэн шалгаж, хохирогчийн аюулгүй байдлыг баталгаажуулна.
- Хүчирхийлэл үйлдэгч этгээд гарч зугтсан тохиолдолд зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах үйл ажиллагааг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код/ 228-д заасны дагуу цаг алдалгүй шуурхай зохион байгуулж, хүчирхийлэл үйлдэгчийг эрж олох шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.
- Гэрч, хохирогчоос мэдүүлэг авах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн газарт хүчирхийллийн ул мөр, нотлох баримтыг илрүүлэх, баримтжуулах ажиллагааг хийлгэх, гэмт хэргийн шинжтэй тохиолдолд бүрэлдэхүүн явуулж хэргийн газрын үзлэг, бусад хойшлуулшгүй ажиллагааг хийлгэж материалжуулна.
- Бүрдүүлсэн материалыг тухайн газар, хэлтсийн даргад танилцуулан, тоо бүртгэлд авахуулж, үргэлжлүүлэн шалгах тасаг, алба хаагчид хүлээлгэн өгнө.
- ГБХ-ийн дуудлага, мэдээлэл бүрт цагдаагийн алба хаагчаар аюулын зэргийн үнэлгээг хийлгэж, "өндөр" үнэлгээ гарсан тохиолдолд эрх бүхий алба хаагчаар хохирогчийг тусгаарлах, эсхүл хүчирхийлэл үйлдэгчийг баривчлуулах, согтууруулах, мансууруулах зүйл хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх, саатуулах байранд хүргүүлэх арга хэмжээг яаралтай авахуулна.
- ГБХ-ийн дуудлага, мэдээллийг шалгасан материалд аюулын зэргийн үнэлгээг заавал хавсаргана.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, 23.7 дахь заалтыг баримтлан дуудлага, мэдээлэл өгсөн иргэний нууцлалыг хангаж ажиллахад онцгой анхаарна.

Цагдаад дуудлага өгнө гэдэг нь хохирогч хамгийн хүнд нөхцөлд орсон тохиолдолд хамгийн эхний эсхүл сүүлийн удаа хандаж байгааг анхаарах. Иймд хохирогчдын сэтгэл зүйн байдлыг ойлгож, тайвшруулж, аль болох тодорхой асуулт асууж мэдээлэл авахыг чухалчлах.

Мөн утасны цаана болж буй шуугиан, хүүхдийн дуу зэргийг соргог хүлээн авч, тэмдэглэл үйлдэх. Энэ нь дуудлагаар очиж буй эргүүлийн офицерт мэдээлэл болохоос гадна нотлох баримт болж үлдэнэ.

В. Дуудлага шалгах цагдаагийн алба хаагчийн үүрэг:

Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээллийг шалгах ажиллагаа 4 үе шатнаас бүрдэнэ. Үүнд:



1 дүгээр шат: (нэвтрэх)

- Дуудлагад хоёроос доошгүй цагдаагийн ажилтан очиж ажиллана. Боломжгүй тохиолдолд олон нийтийн цагдаа болон эргүүлийн хамт ажиллаж болно.
- Цагдаагийн ажилтнууд өөрсдийн аюулгүй байдлыг хангана.
- Аюулын зэргийн үнэлгээний тэмдэглэл, илтгэх хуудасны загвар маягтыг авч очино.
- Тухайн айл болон иргэний талаар өмнө нь дуудлага өгч байсан эсэх, түүний шийдвэрлэлтийн байдал, хүчирхийлэл үйлдэгч зэвсгийн чанартай зүйл хэрэглэдэг эсэх, ял шийтгэлтэй эсэх талаар шаардлагатай мэдээллийг сангаас шалгах, эсхүл шуурхай удирдлагын албаны нэгж, алба хаагчаас холбогдох мэдээллийг авна.
- Хүчирхийлэл үйлдэгчийг зугтахаас сэргийлж, очих хаягт ойртох үед тусгай дуут болон гэрлэн дохиог унтраана.
- Цагдаагийн автомашиныг тохиромжтой газар байрлуулна.

- Дуудлага өгсөн газар орчныг шалгана.
- Гүйцэтгэх үүргийг урьдчилан ярилцаж, ажил үүргээ хуваарилна.
- Дуудлага, мэдээлэл өгсөн айл өрхийн хаалга цоожтой, дотор талд хүчирхийлэл үйлдэгдэж буй дуу чимээ илэрхий байгаа, хохирогчийн аюулгүй байдлыг шалгах, хүчирхийллийг таслан зогсоох зайлшгүй шаардлагатай тохиолдолд—эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж нэвтрэн орно.

Цагдаагийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд цагдаагийн алба хаагч хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчил, тэдгээрийн талаарх гомдол, мэдээллийг шалгахдаа бусдын орон байр, тээврийн хэрэгсэл, ажлын байр, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, ач холбогдол бүхий баримт, мэдээллийг гаргуулан авах эрхтэй.

Цагдаагийн алба хаагч гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн хүнийг мөрдөн хөөж баривчлах, эсхүл гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдал үүссэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодит аюул байгаа, эрэн сурвалжлагдаж байгаа хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хоригдлыг мөрдөн хөөж баривчлах, сэжиг бүхий этгээд оргон зайлах, гэмт хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, үрэгдэх бодит аюул тулгарсан тохиолдолд бусдын орон байранд оршин суугч, эзэмшигчийнх нь зөвшөөрөлгүйгээр нэвтрэн орно.

Бусад тохиолдолд цагдаагийн алба хаагч бусдын орон байранд нэвтрэн орохдоо оршин суугч, эзэмшигчийн зөвшөөрлийг заавал авсан байна. Тухайн орон байранд хамтран оршин суугч, эсхүл хамтран эзэмшигч этгээдийн аль нэг нь зөвшөөрөл өгсөн бол бусдын орон байранд нэвтрэх үндэслэл болно.

Нэвтрэн ороход оршин суугч, эзэмшигч саад учруулбал эсэргүүцлээ зогсоохыг шаардах, шаардлагыг үл биелүүлбэл албадлагын арга хэмжээ хэрэглэхийг анхааруулна.

Нэвтрэн ороход эд зүйл, цоож, түгжээ, байгууламжийн хэсгийг эвдэх, дохиолол, хяналтын систем, цахилгааныг салгах, нохой, бусад амьтныг номхотгох техник, хэрэгсэл ашиглах зэргээр учрах саадыг арилгаж болно гэж заасан.

Шаардлагатай тохиолдолд нэмэлт хүч, бүрэлдэхүүнийг дуудна.

2 дугаар шат: (шалгах)

- Хойшлуулшгүй ажиллагаанаас бусад тохиолдолд өөрсдийгөө танилцуулна.
- Хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардахдаа боломжит хэлбэрээр урьдчилан сануулна.
- Хохирогч, гэр бүлийн бусад гишүүд, тодорхой шалтгаанаар гэр, орон байранд хамт амьдарч байгаа бусад хүнийг хохирсон эсэхийг шалгана.
- Хохирогчийн сэтгэл санааны байдлыг ойлгож, хүлээцтэй, итгэл төрүүлэхүйц хандана.
- Дуудлага шалгахдаа төвийг сахисан байр сууринаас харилцаж, өөрийн хувийн үзэл бодол, аливаа дүгнэлт гаргахаас зайлсхийнэ.
- Хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийг талууд бие биенээ харахгүй, сонсохгүй, тухайн орчны хүмүүс, хөршүүдээс салангид газар, орчинд байлцуулан болсон үйл явдал болон санал хүсэлтийг тодруулж, тэмдэглэнэ.
- ГБХ-ийн шинжтэй үйлдэл, эс үйлдэл мөн эсэхийг хохирогчийн биед үүссэн гэмтэл, бэртэл, хувцасны урагдал, тухайн орчны эмх цэгц, унасан, хагарсан, эвдэрсэн зэрэг хүчирхийлэл үйлдэгдсэн байж болох нөхцөл байдлыг ажиглах, гомдол мэдээлэл гаргагчтай харилцан ярилцах, хэргийн газар, орчныг шалгах зэрэг энгийн аргаар тогтооно.
- Аюулын зэргийн үнэлгээ хийнэ.
- Монгол хэл, бичиг мэдэхгүй, хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчтой орчуулагч, хэлмэрчээр дамжуулан харилцана.
- Хохирогчийн биед учирсан гэмтлийн ул мөр болон эд зүйлийн эвдрэл хэмхрэл бүрийг хуульд заасан журмын дагуу үзлэг хийж баримтжуулан, бодитойгоор үнэлж, шаардлагатай тохиолдолд бүрэлдэхүүн

дуудаж үзлэг хийлгэнэ.

- Дүрс бичлэг, дуу хураагуураар болж байгаа явдлыг давхар баримтжуулна.
- Гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хэрэглэсэн эд зүйлсийг эд мөрийн баримтаар хураан авна.
- Хүчирхийлэл үйлдэгч гарч зугтсан тохиолдолд хариуцлагатай зохицуулагчид мэдэгдэж, түүнийг зарлан мэдээлэх, очиж болох газруудаар эрэн сурвалжлах арга хэмжээг авч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг жижүүрийн ахлах офицер болон эрх бүхий албан тушаалтанд танилцуулна.
- Шаардлагатай тохиолдолд хэргийн газрын хамгаалалтыг ЦБҮАЖурмын 205-д заасны дагуу авна.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6, 23.7 дахь заалтыг баримтлан дуудлага, мэдээлэл өгсөн иргэний нууцлалыг хангаж ажиллахад онцгой анхаарна. Тухайлбал: Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг шалгахад ЦБҮАЖ-ын код-202-т заасан "дуудлага, мэдээллийн хяналтын хуудас"-ыг ашиглахгүй байх, ашигласан тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчид мэдэгдэхгүй байх бололцоотой бүх арга хэмжээг авч, хуулийг хэрэгжүүлж ажиллана.

3 дугаар шат: (туслах)

- Хохирогч, хүчирхийлэл үйлдэгчид хуульд заасан эрх, үүргийг нь тайлбарлаж, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг бичиг (Тусламжийн хуудас)-ээр өгнө.
- Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд холбоно.
- Орон байрнаасаа хувцас, эм, эмчилгээний хэрэгсэл, баримт бичиг, хүүхдийн сургалтын хэрэгсэл зэрэг нэн шаардлагатай хэрэглээний эд зүйлээ авахад нь туслалцаа үзүүлж, хүчирхийлэл үйлдэгчээс шаардан гаргуулна.

4 дүгээр шат: (шийдвэрлэх)

- Гэмт хэргийн шинжтэйгээс бусад тохиолдолд холбогдогчид эрүүгийн хариуцлага оногдуулж болох тухай сануулна.
- Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлнэ.
- Аюулын зэргийн үнэлгээг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотных нь хүний түр хамгаалалтад өгөх, шаардлагатай бол хүчирхийлэл үйлдэгчийг түр саатуулна.
- Аюулын зэргийн үнэлгээгээр эрсдэл өндөртэй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол тухайн хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа нийгмийн ажилтанд мэдэгдэнэ.
- Галт зэвсэг, хүчирхийлэл үйлдэхэд ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авна.
- Дуудлага, мэдээлэл гэмт хэргийн шинжтэй бол хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар жижүүрийн ахлах мөрдөгч, мөрдөгчид холбогдох материалын хамт хүргэнэ.
- Цагдаагийн алба хаагч нь ГБХ-тэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалгахдаа холбогдох хууль тогтоомж болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 202, 212-219, 222, 224, 228, 244, 326, 408-т заасныг баримтална.

- Дуудлага, мэдээлэл шалгасан талаар илтгэх хуудас бичнэ.
- Дуудлага, мэдээлэл шалгасан талаар санд мэдээлэл нэн даруй оруулна.
- Дуудлага, мэдээллийг хуулийн дагуу түргэн шуурхай шалгаж буй эсэхэд шууд удирдах дарга нь хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

Аюулын зэрэг, түүнийг үнэлэхтэй холбоотой мэдээлэл болон аргачлалыг тус гарын авлагын холбогдох хэсгээс дэлгэрүүлэн судлаарай.

Г. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа

- Дуудлага өгөгдсөн газар дээр хүүхэд байгаа эсэхийг тогтооно.
- Хүүхдэд тусламж шаардлагатай эсэхийг тогтооно.

- Хүүхдэд цагдаагийн байгууллагаас авах гэж байгаа арга хэмжээний талаар энгийнээр тайлбарлан, хүсэлтийг хүлээн авна.
- Шаардлагатайгаас бусад тохиолдолд цагдаагийн алба хаагчаас хүч хэрэглэсэн үйлдлийг хүүхдэд харуулахгүй байхыг хичээнэ.
- Хүүхдийг хүчирхийлэл үйлдэгчтэй нэг орчинд үлдээхгүй.

Хүүхдэд хийсэн аюулын зэргийн үнэлгээ дунд болон өндөр, эсхүл дараах нөхцөл тогтоогдвол эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүйгээр Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байр, хамгаалах байранд хүргэх, эсхүл төрөл, садангийн болон бусад этгээд, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх, асрамж, халамжийн үйлчилгээний байгууллагад хүргэх арга хэмжээг авна. Үүнд:



- хүчирхийллийг хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй;
- хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй;
- хүүхдийн эмзэг байдлыг далимдуулан өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, ашиглаж болзошгүй;
- хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, оруулж болзошгүй;
- хүчирхийлэл үйлдэгч согтуурсан, мансуурсан байдалтай, эсхүл байнга согтуурдаг, мансуурдаг бол.
- Хүүхдийг хүнд хүлээлгэн өгөх бол түүнд эрх, үүргийг сануулж, бичгээр баталгаажуулна.
- Хохирогч хүүхэд долоо, түүнээс дээш настай бол хамгаалах боломжтой хүн, гэр бүлийг сонгохдоо түүний саналыг харгалзана.

ДЭД СЭДЭВ 2: Илтгэх хуудас, тэмдэглэл үйлдэх

Цагдаагийн алба хаагчийн гэмт хэрэг, зөрчилд ач холбогдол бүхий байдал буюу бусад үйл явдлыг тоочиж мэдээлсэн тэмдэглэл, илтгэх хуудас нь эрүүгийн болон зөрчлийн хэрэгт ач холбогдолтой байвал түүнийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болно.

Цагдаагийн алба хаагч тэмдэглэл, илтгэх хуудас бичихдээ "Тэмдэглэл, илтгэх хуудас бичих /код 245/ журам"-ыг баримтална.

Тэмдэглэл гэж алба хаагчаас хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан тодорхой үйл ажиллагааг явуулсан тухай бэхжүүлэн тусгасан баримт бичгийг ойлгоно.

Тэмдэглэлд дараах зүйлсийг тухайн ажиллагааны онцлогийг харгалзан тусгасан байна:

1) уг ажиллагаа хэзээ, хаана явагдсан;
2) эхэлсэн, дууссан цаг;
3) тэмдэглэл үйлдсэн хүний албан тушаал, нэр;

   уг ажиллагаа явуулахад оролцсон буюу байлцсан хүн нэг бүрийн овог, нэр, хаяг;
4) оролцогчдын эрх, үүргийг тайлбарласан тэмдэглэл;

   уг ажиллагааны агуулга ба түүний явцад илэрсэн нөхцөл байдал;
5) уг ажиллагаа явагдсан дэс дараалал;
6) тухайн ажиллагаанд оролцогчдоос гаргасан санал, хүсэлт;
7) уг ажиллагааны үр дүн, тайлбарын агуулга;

   хураасан, битүүмжилсэн зүйлийн тоо

ширхэг, чанар, өнгө, онцлог шинж тэмдэг, ашиглалтын байдал;

нотлох баримтыг бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан соронзон болон дүрс бичлэг, гэрэл зураг, гар зураг, ул мөрнөөс хэв, хэлбэр буулгаж авах болон бусад аргыг хэрэглэсэн эсэхийг тус тус тусгасан байна.

Цагдаагийн алба хаагч ГБХ-ийн дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж тэмдэглэл үйлдэхдээ дараах зүйлсийг тусгана:



1.Нөхцөл байдал
- дуудлага, мэдээлэл аваад очсон, шалгасан хугацаа;
- хохирогчийн болон хүчирхийлэгчийн анхны байр байдал сэтгэгдэл, тухайн орчин;
- хохирогчийн болон хүчирхийлэгчийн хамаарал;
- хохирогчийн болон хүчирхийлэгчийн ил харагдах шарх, гэмтэл, бэртэл;
- эмнэлгийн тусламж авсан байдал;
- хүчирхийлэл үйлдэгдэх болсон шалтгаан;
- хүчирхийлэл үйлдсэн арга;
- хүчирхийлэгчийн заналхийлсэн байдал;
- зэвсэг хэрэглэсэн байдал, зэвсгийн төрөл;
- архи, согтууруулах ундаа хэрэглэсэн байдал;
- хохирогч болон хүчирхийлэгчийн хувийн мэдээлэл;
- хүчирхийллийн хэлбэр, үргэлжилсэн хугацаа, давтамж;

2. Давтамж
- хүчирхийлэлтэй харилцааны түүх (өмнө нь бүртгэгдсэн дуудлага мэдээлэл, гэмт хэрэг, зөрчил, эрх хязгаарлах арга хэмжээ, эрэн сурвалжлалт)

3. Авсан арга хэмжээ
- хохирогчийг хамгаалалтад авсан байдал;
- хүчирхийлэгчийн баривчилсан, саатуулсан байдал;
- хохирогчид шаардлагатай эд зүйл авч өгсөн байдал;
- хохирогчид шаардлагатай байгууллагад холбон зуучилсан байдал;
- хохирогчид эрх зүйн зөвлөгөө өгсөн байдал.

4. Шийдвэрлэлт
- аюулын зэргийн үнэлгээний түвшин;
- шийдвэрлэсэн байдал;
- тэмдэглэл /илтгэх хуудас/ хүлээлгэж өгсөн цагдаагийн ажилтан

Тэмдэглэлийн загвар

Маягт ЦБҮАЖ №245.б

_____ тухай тэмдэглэл

____оны ____сарын ____өдөр

_____/тэмдэглэл үйлдсэн хүний албан тушаал, нэр/
_____/уг ажиллагаа хэзээ, хаана явагдсан/
_____/эхэлсэн цаг/ _____ /дууссан цаг/
1. _____/ажиллагаа явуулахад оролцсон хүний овог, нэр, хаяг/
2. _____/ажиллагаа явуулахад оролцсон хүний овог, нэр, хаяг/
3. _____/ажиллагаа явуулахад байлцсан хүний овог, нэр, хаяг/
4. _____/ажиллагаа явуулахад байлцсан хүний овог, нэр, хаяг/
_____/оролцогчдын эрх, үүргийг тайлбарлаж уншиж, засвар оруулахаар санал гаргах эрхтэй болохыг тайлбарласан тэмдэглэл/
_____
_____
_____
_____/ уг ажиллагааны агуулга ба түүний явцад илэрсэн нөхцөл байдал/ _____
_____
_____ /тухайн ажиллагаанд оролцогчдоос гаргасан санал, хүсэлт/
_____
_____
_____ /уг ажиллагааны үр дүн, тайлбарын агуулга/
_____
_____ /хураасан, битүүмжилсэн зүйлийн тоо ширхэг, чанар, өнгө, онцлог шинж тэмдэг, ашиглалтын байдал/
_____
_____
_____ / нотлох баримтыг бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан соронзон болон дүрс бичлэг, гэрэл зураг, гар зураг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, хэлбэр буулгаж авах болон бусад аргыг хэрэглэсэн эсэхийг тусгах/
_____
_____
_____ /тэмдэглэлд гэрэл зураг, төлөвлөгөө, бүдүүвч зураг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, хээг хавсаргаж хийсэн тайлбар/
Жич: Ажиллагаанд оролцсон оролцогчдоос тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзах, эсхүл эрхтэй дутуу буюу бусад шалтгаанаар гарын үсэг зурах боломжгүй бол
/_____
_____/

Тэмдэглэл хөтөлсөн алба хаагч _____/нэр, гарын үсэг/
Хөндлөнгийн гэрч 1. _____/нэр, гарын үсэг/
2. _____/ нэр, гарын үсэг/

Тэмдэглэл хөтөлсөн алба хаагч _____/нэр, гарын үсэг/
Оролцсон 1. _____/нэр, гарын үсэг/
2. _____/нэр, гарын үсэг/
3. _____/нэр, гарын үсэг/
4. _____ /нэр, гарын үсэг/

ДЭД СЭДЭВ 3. ГБХ-ийн гэмт хэргийн дуудлага, мэдээллийг шалгаж шийдвэрлэхэд анхаарах асуудал

1. Хүчирхийлэл үйлдэгч, хохирогч нар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байна. Эрүүлжүүлэх тохиолдолд хүүхдийг нь яах вэ?

Цагдаагийн алба хаагч согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлж болно. Хэрэв хүчирхийлэл үйлдэгч, хохирогч нарыг албадан эрүүлжүүлэх арга хэмжээ авсан тохиолдолд хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүүхдийг Нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл Түр хамгаалах байранд хүргэх, төрөл садангийн болон бусад этгээд, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх, хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагад хүргэх арга хэмжээ авна. Ингэхдээ хэрэв хүүхэд 7 нас хүрсэн бол түүнээс саналыг нь асууж шийдвэр гаргахдаа харгалзан үзнэ.

2. Хүчирхийлэгч нь эрүүл, хохирогч нь согтуу байвал яах вэ?

Цагдаагийн алба хаагч ГБХ үйлдэгдсэн байдал, хохирогч, холбогдогч нарын өгүүлэмж, хувийн байдал, ил харагдах гэмтэл, бэртэл, шарх, харьцаа, урьд өмнөх дуудлага мэдээллийн түүх, гэрч нарын мэдээлэл зэрэг нөхцөл байдалд тулгуурлан хэн нь хүчирхийлэгч болохыг тогтооно.

Хүчирхийлэл үйлдэгдсэн тохиолдолд АЗҮ хийж, үнэлгээг үндэслэн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авна.

3. Эмэгтэй хүн хүчирхийлэл үйлдсэн ба согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, 0-3 насны хүүхэдтэй бол яах вэ?

Хүүхдэд хийсэн АЗҮ "дунд", "өндөр" гарсан эсхүл хүчирхийллийг хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй, хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй, хүүхдийн эмзэг байдлыг өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, ашиглаж болзошгүй, хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, оруулж болзошгүй, хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүйгээр хүүхдийн аюулгүй байдлыг хангана.

Дээрх тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийг албадан эрүүлжүүлж, хүүхдийг Нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх, төрөл, садангийн болон бусад этгээд, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх, хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх арга хэмжээ авч хүүхдийн байгууллага, ажилтан, сум, хорооны нийгмийн ажилтанд мэдээлнэ. Хэрэв хүүхэд 7 нас хүрсэн бол түүнээс саналыг нь асууж шийдвэр гаргахдаа харгалзан үзнэ.

4. Үзүүлэх бичиг баримтгүй бол яах вэ?

Цагдаагийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5.8 дахь заалтад зөрчлийг гарсан газарт нь шуурхай шийдвэрлэх боломжгүй, эсхүл хүний бичиг баримтыг шалгах болсон бусад үндэслэлийг тухайн газарт шалгаж тогтоох боломжгүй бол цагдаагийн байгууллагад хүргэх гэж заасан.

Мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт "Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүний

нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно" гэсэн эрх зүйн зохицуулалттай байна.

5. Гэр бүлийн гадуур харилцаатай хүнийг хамаарал бүхий этгээд гэж үзэх үү?

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд хамаарал бүхий этгээдэд хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна гэж заасан. Мөн "хамтран амьдрагч" гэж гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгаа этгээдийг ойлгохоор заасан. Энэ зохицуулалтад хамаарч байвал хамаарал бүхий этгээд гэж үзнэ.

6. ГБХ үйлдсэн этгээд эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?

Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт "Хүчирхийлэл үйлдэгч энэ хуулийн 46.1.2-т /46.1.2.хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэл үйлдэх, согтуурулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардах/ заасан шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсхүл эсэргүүцсэн бол хуульд заасны дагуу албадлагын арга хэмжээ авна" гэж заасан.

Иймд цагдаагийн алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болно.

7. Архи уудаг, агсан тавьдаггүй хүнийг хүчирхийлэл үйлдсэн гэж үзэх үү?

Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан. Цагдаагийн алба хаагч дуудлага, мэдээлэл дээр ажиллахдаа нөхцөл байдлыг үнэлэх, ингэхдээ хууль эрх зүйн мэдлэг, түүнийг хэрэглэх чадвартай байх нь маш чухал.

8. Хүчирхийлэл үйлдэгч эрүүл, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар эрүүлжүүлэх боломжгүй байвал яах вэ?

Цагдаагийн алба хаагч хохирогчид хийсэн аюулын зэргийн үнэлгээг үндэслэж хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгнө. Хохирогчийн аюулгүй байдлыг заавал хамгаална.

9. Хохирогч эсхүл өөр хэн нэгэн утсаар дуудлага, мэдээллээ буцаагаад шалгуулахгүй гэвэл яах вэ?

Цагдаагийн алба хаагч ГБХ-ийн талаарх мэдээллийг ямар хэлбэрээр өгснөөс үл хамааран гэр бүлийн хүчирхийллийг хуульд заасан арга хэрэгслээр таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учирсан, эсхүл тухайн орчин нь аюултай гэж үзвэл хохирогчийг хамгаалах арга хэмжээг даруй авах үүрэгтэй.

ГБХ-тэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн оршин сууж байгаа газрын харьяаллаас үл хамааран ойр байгаа цагдаагийн байгууллагад гаргана.

ГБХ-ийн шинжтэй мэдээллийг цагдаагийн алба хаагчид утсан харилцаагаар өгч байх явцад дуудлага тасарсан, эсхүл түүнийг үгүйсгэсэн шинжтэй мэдээллийг өөр хүн өгсөн тохиолдолд дуудлага хаанаас ирсэн болон хохирогчийн байгаа газрын байршлыг тогтоох, хаягаар нь тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчаар шалгуулах арга хэмжээг нэн даруй авна.[68]

10. Хүчирхийллийн хохирогч хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн өөрчлөлттэй байвал хаана аваачих вэ?

Хүчирхийллийн хохирогч хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл сэтгэцийн өөрчлөлтийн хувьд сэдрээгүй бол түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, төрөл, садан, ойр дотны хүний хамгаалалтад өгнө. Харин

68 Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22, А/31 дүгээр тушаалаар хамтран батлагдсан "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам"-ын 3.2 дахь хэсэг.

сэтгэцийн эрүүл мэнд нь өөрчлөлт их, хүндэрсэн үедээ байвал Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргэнэ. Улаанбаатар хотод сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв 24 цагаар дуудлага хүлээж авдаг.

11. Хүүхдийн эрхийг ноцтой зөрчих зөрчил /6.20/-ийн дуудлага, мэдээлэл ГБХ-ийн дуудлага, мэдээллийг хэрхэн ялгаж салгаж ойлгох вэ? Ихэнх тохиолдолд адилхан үйлдэгдээд байна?

Гэр бүлийн хамаарал бүхий хүн хүүхдийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлээр зүйлчилнэ. Хамаарал бүхий хүнд хамаарахгүй этгээд хүүхдийг зодсон тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлээр зүйлчилнэ. Гэхдээ Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд хүүхдийн эрхийг зөрчих зөрчлийн нилээн олон шинжийг хуульчилсан байдгыг анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл цугларсан нотлох баримтуудыг үндэслэн ямар зөрчил үйлдэгдсэн болохыг тогтооно.

12. Гэр бүлийн гишүүдээ зодож, цохихгүй ч агсам согтуу тавих, хэл амаар доромжилсон, орилж чарласан тохиолдол их гардаг. Энэ үйлдэл гэр бүлийн хүчирхийлэл мөн үү?

Гэртээ агсан тавих, хэл амаар доромжлох, айдас түгшүүр төрүүлсний улмаас гэр бүлийн хамаарал бүхий хүн нь тодорхой үйлдэл хийх, хийхээс татгалзаж байвал гэр бүлийн хүчирхийлэл болно. Тухайлбал: Агсан тавьсаны улмаас гэрээсээ гарч өөр газар очих, нойргүй хонох, хүчээр архи уулгах г.м.

Харин дээрх үйлдэл тогтоогдогдохгүй бол Зөрчлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд зааснаар хариуцлага оногдуулна.

3.1.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛД ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих

1. Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:
   - 4.1. зодсон;
   - 4.2. хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;
   - 4.3. бусадтай харилцахыг хязгаарласан;
   - 4.4. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Тайлбар: *Энэ хуулийн тусгай ангид заасан "хууль зөрчих" гэж хууль, Захиргааны ерөнхий хууль, бусад хуульд заасан журмын дагуу хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнийг ойлгоно.*

ДЭД СЭДЭВ 1. Зөрчил шалгах ажиллагаа, гомдол мэдээллийг хүлээн авах

- ГБХ-тэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн

талаарх гомдол, мэдээллийг хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн оршин сууж байгаа газрын харьяаллаас үл хамааран ойр байгаа цагдаагийн байгууллагад гаргах ба цагдаагийн байгууллага, алба хаагч харьяалал харгалзахгүй заавал хүлээн авна.

- Хохирогч ГБХ-д өртсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэл учирсан гэж үзвэл энэ талаар гомдол мэдээллийг биечлэн, эсхүл хууль ёсны төлөөлөгч болон бусдаар дамжуулан гаргаж болно.
- ГБХ-ийн шинжтэй мэдээллийг амаар болон бичгээр, утсаар, цахим хэлбэрээр өгч болно.
- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын удирдах алба хаагч ГБХ-ийн шинжтэй гомдол мэдээллийн утга, хэрэг зөрчлийн давтамж, аюулын зэргийн үнэлгээ, бусад баримт материалтай танилцсаны дараа эрх бүхий алба хаагчид шалгуулахаар шилжүүлнэ.

ГБХ-ийн зөрчлийн шинж

Зөрчлийн тухай хуулийн 5.4.дүгээр зүйлд заасан шинжийг хууль сахиулах байгууллагын ажилтан өөрийн дотоод итгэлээр үнэлж дүгнэхээс гадна доорх нөхцөл байдал байгаа эсэхийг харгалзана. Үүнд:

- гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн гэдгийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд заасныг ойлгоно.
- Зодсон гэдгийг гэр бүлийн хамаарал бүхий хүнийг цохих, өшиглөх, түлхэх, татах, алгадах, эд зүйлээр цохих, шавхуурдах зэрэг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй, бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулаагүй байх.
- хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан гэдгийг хохирогчийн хийхийг хүсээгүй үйлдлийг хүчээр хийлгэх, эсхүл хийх гэсэн үйлдлийг хийлгэхгүй байхаар заналхийлэх, айлгах, дарамтлах, шаардах, тулгах, бусдыг барьцаалах зэргээр сэтгэл санаанд нөлөөлөх, бие махбодид зовиур шаналгаа үзүүлэх, эдийн засгийн аргаар хясан боогдуулах зэрэг олон хэлбэрээр илэрч байна.

Практикт орон байрнаас хөөж тагт болон гадаа гаргах, өөр газар хонуулах, унтуулахгүй байх, хүчээр архи уулгах, бэлгийн харилцаанд орох зэрэг нийтлэг үйлдэл гарч байна.

Тухайлбал: "Г" нь 2019 оны 12 дугаар сарын 7-ны өдөр өөрийн гэртээ эхнэр "У"-ын хоолойг боож, бөгс рүү нь алгадаж зодож, нүүр лүү нь хуурай гурил цацаж, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан зөрчилд Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх: Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангийн 4.5 дүгээр зүйлийн 3, тусгай ангийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.1, 4.2 дахь заалтад зааснаар зөрчилд холбогдогч "Г"-д 40 цагийн хугацаагаар албадан сургалтад хамруулж, 20 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулж, 40 цагийн хугацаагаар албадан сургалтад хамруулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа "Баривчлах төв"-д даалгасан шийдвэр гаргасныг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хянан хэлэлцээд уг шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

- бусадтай харилцахыг хязгаарласан гэдгийг хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашиглаж бусадтай уулзах, ярилцах, холбоо мэдээллийн хэрэгсэл, нийтийн цахим сүлжээгээр харилцахыг хориглох, холбоо, мэдээллийн хэрэгслийг гэмтээж эвдэх, авах, цахим сүлжээг салгах, гэрээсээ гаргахгүй байх, зорчих эрхийг хязгаарлах зэрэг нөхцөл байдлыг ойлгож болно.
- хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэдгийг Иргэний хуулийн 127, 128 дугаар зүйлд заасан эд хөрөнгийн эрхэнд халдсаныг ойлгоно. Өөрөөр хэлбэл хуваарьт эд хөрөнгөнд гэрлэхийн өмнө олж авсан эд хөрөнгө, мөнгөн хуримтлал, эд хөрөнгийн эрх, өв, бэлэглэлийн журмаар шилжүүлэн авсан мөнгөн хуримтлал, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг худалдсан, арилжсаны үр дүнд олж авсан эд хөрөнгө, мөнгө, амин хувийн хэрэгцээг хангахад зориулсан эд хөрөнгө; оюуны өмчлөлийн

зүйлийн үнэ буюу зохиогчийн шагнал, хувийн авъяас, чадвар, ололт амжилтыг сайшаан шагнасны орлого, хуваарьт эд хөрөнгөөрөө олж авсан, мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хөрөнгө, мөнгө орно.

Тэгвэл хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон, гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгөөс бусад хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч юм. Мөн гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүн болон тэдгээрийн хамтын хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон болон бусад орлого, мөнгөн хуримтлал, шинээр бий болсон хөрөнгө, гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгийн орлогоор олж авсан үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, ноогдол хувь, үнэт цаас, гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө, гэр бүлийн гишүүн өөрийн хуваарьт хөрөнгөөс дундаа хамтран өмчлөхөд зориулж шилжүүлсэн хөрөнгө, мөнгөн хуримтлал хамтран өмчлөх дундын эд хөрөнгөнд ордог.

Анхаарах зүйл бол гэр бүлийн гишүүн хуваарьт эд хөрөнгөө өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй. Гэрлэснээс хойш гэр ахуйн ажил эрхэлсэн, хүүхэд асарсан, өвчтэй байсан болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар орлого олоогүй байсан эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн хөрөнгөө хамтран өмчлөх эрх эдэлнэ.

Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө захиран зарцуулахдаа гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна.

Тухайлбал: "Д" нь 2019 оны 12 дугаар сарын 29-ний өдөр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ эхнэр "У"-ийн гар утсыг эвдэж гэр бүлийн гишүүний хуваарьт эд хөрөнгөд халдсан зөрчлийг Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангийн 4.5 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасныг баримтлан тусгай ангийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.4 дэх заалтад зааснаар "Д"-д 10 /арав/ цагийн хугацаагаар албадан сургалтад хамруулж, 7 /долоо/ хоног баривчлах шийтгэл оногдуулж шийдвэрлэснийг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн. Ингэхдээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "... хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах ... эд хөрөнгийн хохирол учруулсныг эдийн засгийн хүчирхийлэл гэнэ." гэж тодорхойлсон байх тул зөрчилд холбогдогч "Д"-ийн гэр бүлийн гишүүдийн дундын болон хуваарьт эд хөрөнгийг эвдэж хохирол учруулсан үйлдэл нь Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.4 дэх заалтад заасан зөрчлийн шинжид бүрэн нийцсэн байна гэж дүгнэсэн байна.

Зөрчил шалгах ажиллагаа

Цагдаагийн алба хаагч ГБХ-ийн зөрчлийг шалгахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт, хэрэглэх чадвар, нотлох баримт цуглуулахад анхаарах зүйл, оролцогчдын эрх үүрэг, тодорхой ажиллагаа явуулах журам, хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчийн сэтгэл зүйн онцлог зэрэг олон талын мэдлэг, ур чадвар, мэдээлэлтэй байх шаардлагатай.

ГБХ-ийн дуудлага, мэдээлэл шалгасан илтгэх хуудас, АЗҮ, цахим сангийн мэдээлэлд үндэслэн хүчирхийлэлтэй харилцааны бодит байдалд шалгах ажиллагаа явуулна. Өөрөөр хэлбэл тухайн айл өрх, хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчийн нэр хаяг, утаснаас өмнө нь цагдаагийн байгууллагад ирж байсан дуудлага, хүчирхийлэл үйлдэгчийн гаргаж байсан зөрчил, үйлдсэн зөрчил, урьд өмнө эрүүгийн хариуцлага зөрчлийн шийтгэл хүлээж байсан эсэх, мэдээллийн сангийн бусад мэдээлэл зэргийг шалгаж тогтооно.

Зөрчлийн хэргийг шалгахдаа хөөн хэлэлцэх хугацаа, зөрчлийн хэрэг нээхгүй тохиолдол байгаа эсэхийг шалгаж тогтооно. Тухайлбал: зөрчлийн шинжгүй, хөөн хэлэлцэх хугацаа

өнгөрсөн, тухайн зөрчилд хариуцлага тооцсон хуулийн зүйл, хэсэг, заалт хүчингүй болсон эсэх, зөрчил үйлдсэн хүн нас барсан, тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтны, эсхүл шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон, зөрчил үйлдсэн этгээд 16 насанд хүрсэн эсэх гэх мэт ГБХ үйлдэх зөрчилд 7-30 хоногийн хугацаатай баривчлах шийтгэл оногдуулдаг нь зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй.

ГБХ-ийн зөрчлийг аль болох 1-3 хоногт шалгаж, шийдвэрлэх шаардлагатай.

Мөн Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэлээс чөлөөлөх үндэслэл байгаа эсэх, байвал холбогдох нотлох баримтыг бүрдүүлнэ. Тухайлбал: Сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүнийг хэрэг хариуцах чадваргүйд тооцдог тул сэтгэцийн эмгэгтэй байх шинжтэй бол зайлшгүй сэтгэцийн эрүүл мэндийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулна. ГБХ-ийн зөрчил үйлдсэн этгээд жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй эсэхийг заавал шалгаж тогтооно.

ГБХ-ийн зөрчлийн хохирогч, гэрч, тэдгээрт тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний аюулгүй байдлыг хангах зорилгоор зөрчлийн хэргийг холбогдогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчид танилцуулахдаа хохирогч, гэрчийн мэдүүлэг болон биеийн байцаалтыг нууцлах арга хэмжээг авна. Энэ хуулийн зохицуулалтыг зөрчил шалгаж байгаа алба хаагчид зайлшгүй мэдэх, хэрэгжүүлэх ёстой.

Зөрчлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлд "Хүний биед хохирол учруулахгүйгээр халдаж зодсон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан бөгөөд 5.4 дүгээр зүйлд ГБХ үйлдэх зөрчлийг зохицуулсан. Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодсон бол—Зөрчлийн тухай хуулийн 5.4-д заасан зөрчил болно.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд хуулийн 4.11 дүгээр зүйлд "Хүний биед гэмтэл учирсан эсэхийг тогтоох шаардлагатай бол" шинжилгээ хийх, 4.16 дугаар зүйл болгон "Эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, хэрэг бүртгэлтийн ажиллагаанд оролцуулахаар зөрчлийн холбогдогчийг дуудан ирүүлэх" зохицуулалтуудыг шинээр нэмсэн.

Хохирогчийн хүчирхийллийг даван туулж буй үе шатыг тодорхойлох

Хохирогч нь хүчирхийллийн давтамж, даамжралын үр дагавраас шалтгаалан эсэргүүцэх хүч нь суларч, аажим аажмаар, бага багаар өөрийнгөө хамгаалах чадвараа алдсаар байдаг. Энэ үед хохирогчид хүчирхийллийн эсрэг өөрийн төлөвлөгөөгөө боловсруулж тэмцэж байна гэж боддог боловч ихэнх тохиолдолд хохирогч хүчирхийллийн эргүүлэгт орсон байдаг. Тэд гарах гарцыг хайдаг боловч дахин давтан хүчирхийлэлд өртөх бүртээ нөхцөл байдлыг өөрчлөх боломж багассаар байдаг.

Иймд цагдаагийн ажилтан хохирогчийн хүчирхийллийг даван туулж буй үе шатыг тодорхойлох нь зөрчлийг шийдвэрлэх, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох болон цаашид авах арга хэмжээг төлөвлөхөд ач холбогдолтой.

Хохирогчийн аюулгүй байдлыг хангах

Хохирогчийн аюулгүй байдлыг хангахдаа ГБХ-тэй тэмцэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг удирдлага болгоно.

Хохирогчийн аюулгүй байдлыг хангахдаа энэхүү гарын авлагын "ГБХ-ийн гэмт үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах" сэдвээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Зөрчлийн нотлох баримт

Зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээлэл нь зөрчлийн нотлох баримт болно.

Зөрчлийн нотлох баримтад гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг, бичмэл болон эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, хэв загвар, дээж, зөрчил шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл, стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжийн мэдээлэл, бусад баримт ордог.

Хүчирхийлэл үйлдэгчийн үйлдлийг дан ганц хохирогчийн мэдүүлгээр бус бусад эх сурвалжаас тогтоох хэрэгтэй. Зөрчил шалгаж буй цагдаагийн ажилтан илтгэх хуудас, аюулын зэргийн үнэлгээ, хүчирхийлэлтэй харилцааны түүх, хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчийн тайлбар, дуудлагын бичлэг, хураагдсан эд мөрийн баримт, эмнэлгийн нотолгоо, гэмтлийн болон эд зүйлсийн фото зураг зэрэг нотлох баримтыг цуглуулна.

Нотлох баримтыг зөвхөн энэ зөвлөмжид заасан хүрээнд бус, тухай зөрчлийн шинж, давталт, үйлдэл, учирсан хор уршиг зэргийг нотолж, шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл бэрхшээл учрах эрсдэлийг тооцоолно. Хэрвээ нотлох баримт цуглуулах ажилд мэдрэмжгүй хандвал хохирогчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, хохирогчийн хүчирхийллийг илчлэх гэсэн хүсэл зоригийг мохооход хүргэдэг.

Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглох бөгөөд хуульд заасан журам зөрчиж цуглуулсан, бэхжүүлсэн нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд энэ хуульд заасан шийдвэрийн үндэслэл болохгүй.

Зөрчлийг шалгахдаа хохирогч, хүчирхийлэл үйлдэгчээс мэдүүлэг авах, асуулт, анхаарах зүйл, аргачлал, онцлог нь энэ гарын авлагын “ГБХ-ийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулах” сэдвийн хүрээнд адил ойлгоно.

Баянзүрх дүүрэгт оршин суух С өөрийг нь хамтран амьдрагч Г нь сүүлийн 1 жилийн хугацаанд 4 удаа хардалтын улмаас зодсон. Үүнд: 9 сарын өмнө 1 удаа, сарын өмнө болон 10 хоногийн өмнө хардалтын улмаас зодож байсан. Өнөөдөр 4 дэх удаагаа зодоход нь гомдол гаргаж байна гэсэн гомдлыг харьяа цагдаагийн хэлтэст гаргажээ.

1. *Иргэн С-ын гомдлыг цагдаагийн нийтийн хэв журам, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн аль нь хүлээн авч шалгах нь зөв бэ?*

- *Хохирогчийн гомдол, мэдээлэл, тайлбарыг үндэслэн бусад албанд шилжүүлэх гэж яарахгүй байх*
- *Зөрчлийг тал бүрээс нь бүрэн нотлох*
- *Хүчирхийлэл дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх*
- *Хүчирхийлэл үйлдэгчийг ял завшуулахгүй байх*

3.1.3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ҮЙЛДЭЛД ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЖ, МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2017 онд 1286, 2018 онд 1070, 2019 онд 985, 2020 оны эхний 03 сард 279 буюу нийт 3620 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт хэргийн 3.2 хувийг эзэлж байна.

Зураг 3.1._Бүртгэгдсэн нийт гэмт хэргийг гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэгтэй харьцуулсан үзүүлэлт. /2017-2019 он, 2020.3 сар/



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2017 онд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 4.0 хувийг эзэлж байсан бол 2018 онд 3.0, 2019 онд 2.8 хувь болж тус тус буурсан бол 2020 оны эхний 3 сард 3.5 хувь болж өссөн байна. 2017-2019 онд 3341, 2020 оны эхний 3 сард 279, нийтдээ 3620 гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн 1975 буюу 54.6 хувь нь Улаанбаатар хотод, 1643 буюу 45.4 хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдсэн байна.

Зураг 2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг бүртгэгдсэн газар. /2017-2019 он, 2020.3 сар/



- Зөрчлийн гомдол, мэдээллийг хүлээн авч шалгахтай нэгэн адил журмаар хүлээн авч шалгана.
- Хохирогч ихэвчлэн өнгөрсөн хойно нь өргөдөл, гомдлыг бичгээр гаргаж цагдаагийн байгууллагад биеэр, эсхүл бусад ойр дотны хүнээр дамжуулж ханддаг онцлогтой. Энэ тохиолдолд харьяалал харгалзахгүй хүлээн авч шалгана. Өнгөрсөн асуудал, тухайн үедээ хандахгүй яасан юм бэ гэсэн байдлаар хэрхэвч хандаж болохгүй.
- Хохирогчийн бичгээр ирүүлсэн өргөдлийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга нар хүлээн авч, шалгах алба хаагчид цохолт хийж, бүртгэлд авахуулан шалгуулна.

ГБХ үйлдэх гэмт үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах цагдаагийн алба хаагчид зөвхөн хууль эрх зүйн төдийгүй ГБХ-ийн

талаар мэдлэг сайтай байх шаардлагатай. Тухайлбал, дараах зүйлд анхаарлаа илүү хандуулах хэрэгтэй. Үүнд:



- Гэр бүл, ураг төрөл, сэтгэл зүй болон эдийн засгийн хамаарал бүхий хүмүүсийн дунд далд үйлдэгддэг,
- Хүний хувийн амьдрал, нэр төртэй холбоотой эмзэг асуудал,
- Гэр бүлийн хүчирхийлэл нь санаатай үйлдэгддэг, байнгын тогтвортой үргэлжилдэг тэгш бус харилцаанаас улбаатай,
- Илрэхгүй далд үйлдэгдэх хирээр давтагдан үргэлжилж, удаан хугацааны турш үргэлжлэн улам даамжирсаар байдаг,
- Хүчирхийлэл нэг удаагийн үйлдэл бус үргэлжилсэн довтолгоо байдаг,
- Давтагдах үйлдэлүүд нь гүтгэх, тарчлаах, гэмтэл учруулах, танхайрах гэх мэт олон үйлдэл ээлжлэн гардаг,
- Асуудлыг хүчирхийллийн аргаар шийдэж сурсан зан үйлээ өөрчлөхийг хүчирхийлэл үйлдэгч хүсээгүй цагт гэр бүл дэх хүчирхийлэл байнга давтагдаж байдаг
- Хүчирхийлэл бол хосуудын харилцааны доголдолтой асуудал биш, тухайн хүчирхийлэгч өөр хүнтэй суусан ч хүчирхийлэл үйлдэгч хэвээрээ байдаг
- ГБХ нь салсны дараа ч үргэлжилдэг,
- Хохирогч, хүчирхийлэл үйлдэгч хоёр хоёулаа төөрөгдөлд орсон байдаг.
- Жижиг танхайн зөрчлүүд давтан үйлдэгдсээр ноцтой гэмт хэрэг болдог.

ГБХ-ийн талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг гарын авлагын нэгдүгээр хэсгээс судлаарай.

ДЭД СЭДЭВ 1. Мөрдөн шалгах ажиллагаа гомдол, мэдээллийг хүлээн авах

Мөрдөн шалгах ажиллагаа

Мөрдөгч эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр шалгах гомдол, мэдээллийг хүлээн авсаны дараа ЭХХШТХ-нд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй үндэслэл байгаа эсэхийг нягтална.

Мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулашгүй явуулах тохиолдол байгаа эсэхийг тогтооно.

Хэргийн оролцогчдын статусыг тогтооно. Тухайлбал: Хохирогч нь Гэр бүлийн хамаарал бүхий этгээд мөн эсэх, насанд хүрээгүй хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоох хүн, холбогдуулан шалгах этгээд г.м.

Зөрчлийн тухай хуулийн 1.5 /2. Энэ хуулийн тусгай ангид баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй/, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл /1.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн, 1.2. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн/-д заасан хөөн хэлэлцэх хугацааг анхаарна.

Тухайлбал: *Улсын Дээд шүүх "О"-д холбогдох хэргийг 2019 оны 12 дугаар сард хянаж хэлэлцсэн бөгөөд шүүгдэгч "О" нь 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдөр, 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр, 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдөр тус тус үйлдсэн Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдийн хувьд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.1-д заасан хөөн хэлэлцэх 1 жилийн хугацаа нь 2019 оны 4 дүгээр сарын 14-нөөс 15-нд шилжих шөнө Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мал хулгайлах*

гэмт хэрэг үйлдсэнээр тасарч, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гэмт хэрэг тус бүрд шинээр тоологдож эхэлсэн тул шүүгдэгч "О"-д холбогдох хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх үед түүний үйлдсэн Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй гэж шийдвэрлэсэн.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь зөрчлөөс "байнга" шинжээр ялгардаг. Практикт байнга шинжийг Улсын Дээд Шүүхийн 2010 оны "Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 13 дугаар тогтоолд заасан "тодорхой нэг хохирогчийн эсрэг чиглэсэн, хэвшмэл маягтай, гурав ба түүнээс дээш удаа"-гийн үйлдлийг ойлгож байгаа. Тухайлбал:

А) Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим "П"-д холбогдох хэргийг 2020 оны 04 дүгээр сард хянан хэлэлцээд "гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объектив талын үндсэн шинж нь гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодсон гэх үйлдэл байнга буюу гурав ба түүнээс дээш давтамжтай үйлдэгдсэн идэвхтэй үйлдлүүд байхаас гадна тэдгээр үйлдлүүдийн хооронд Зөрчлийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй байхыг шаарддаг. Харин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинж хангагдсан сүүлчийн үйлдлээс хойш уг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолно" гэж шийдвэрлэсэн.

Б) Улсын дээд шүүхийн хяналтын Эрүүгийн хэргийн танхим "Г"-д холбогдох хэргийг 2020 оны 04 дүгээр сард хянан хэлэлцээд дараах шийдвэрийг гаргасан.

Анхан шатны шүүх шүүгдэгч "Г" нь 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 769, 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 1700 дугаартай шийтгэврээр тус тус зөрчлийн шийтгэл хүлээсэн бөгөөд хамгийн сүүлд оногдуулсан шийтгэлээс Зөрчлийн тухай хуульд заасан 6 сарын хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан үйлдлийн "байнга" гэх шинж хангагдахгүй байна гэж дүгнэн шүүгдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгаж шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүх прокурорын бичсэн эсэргүүцлийг үндэслэн хэргийг хянан хэлэлцээд анхан шатны шүүх гэм буруу, хөөн хэлэлцэх хугацаа, эрүүгийн хариуцлагын талаарх дүгнэлтийг хийгээгүй атлаа хөөн хэлэлцэх хугацааны талаар дүгнэсэн, шүүгдэгчийн өмнөх 2 үйлдлийг сүүлийн буюу 2019 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн үйлдэлтэй холбож "гэр бүлийн хүчирхийллийг байнга үйлдсэн" гэж дүгнэх хууль зүйн боломжгүй, энэ нь "Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна" гэсэн шударга ёсны зарчимтай харшилна хэмээн нэмж дүгнэлт хийгээд цагаатгах тогтоолыг хэвээр үлдээжээ.

Харин хяналтын шатны шүүхээс: шүүгдэгч "Г" нь 2018 оны 05 дугаар сарын 9, мөн оны 11 дүгээр сарын 09, 2019 оны 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд эхнэр "А"-г зодсон үйлдэл тогтоогдсон бөгөөд тооны хувьд байнга гэсэн шинжийг хангасан байна.

Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлүүдийн сэдэлт, зорилгыг тодорхойлсон боловч уг үйлдлүүдийн хоорондох хугацааны хамаарлыг нарийвчлан тодорхойлоогүйгээс энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн маргаан үүссэн байх тул энэхүү эргэлзээ, маргааныг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтай байх зарчмыг баримтлан дараах тайлбар, хууль хэрэглээний жишиг тогтоох үндэслэлтэй гэж үзэв.

Энэхүү гэмт хэргийн үндсэн шинжийг бүрдүүлэгч "Байнга" гэх ойлголт нь тооны давтамжаас хууль зүйн ойлголт руу шилжихдээ хууль зүйн алдаагүй байх ёстой бөгөөд гэмт хэргийн шинжийг хангаж буй гурав ба түүнээс дээш удаагийн үйлдлийн хооронд зөрчилд хариуцлага хүлээлгэх хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх шаардлага нь тухайн гурван үйлдлийг нэгтгэн дүгнэх хууль зүйн үндэслэл /легитим/ болно.

Зөрчлийн тухай хуулийн хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх үндэслэл нь гурав, түүнээс дээш удаагийн гэр бүлийн хүчирхийллийн үйлдэл болон зөрчлүүдийн нэг нь дангаараа гэмт хэргийн шинжийг хангахгүй тул Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэргийн

хөөн хэлэлцэх хугацааг ашиглах боломжгүй, харин үйлдэл болон зөрчлүүдийн нийлбэр Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэрэгт шилжиж байгаагаас үүдэлтэй юм.

Үүнээс үндэслэн "Г"-ийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зөрчлийн шинжтэй үйлдлийн давтамж нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн "Байнга" гэсэн шинжийн тооны давтамжийг агуулж байгаа боловч хоёр болон гурав дахь үйлдлийн хооронд нь зургаан сарын хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн нь Эрүүгийн хуулиар тодорхойлсон гэмт хэрэг гэж үзэх, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль зүйн үндэслэлээ алдсан тухай тайлбар хийж, анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг хууль зүйн үндэслэлтэй гарсан гэж үзлээ.

Харин давж заалдах шатны шүүх "Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна" гэсэн зарчим зөрчигдсөн гэж нэмж дүгнэсэн нь үндэслэлгүй байна.

Ямар ч хүнийг үйлдсэн гэмт хэрэгт нь шүүхээс хуулийн дагуу эцэслэн шийтгэсэн буюу цагаатгасан тохиолдолд тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэхийг хориглодог Double jeopardy /Ne bis in idem/ гэсэн Эрүүгийн эрх зүйн онолын зарчмыг НҮБ-аас баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, Ромын дүрмийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр тогтоож, нийтээр хүлээн зөвшөөрч хэм хэмжээ тогтоосон бөгөөд Монгол Улс уг зарчмыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангидаа тухайлан хуульчилж, тусгажээ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд "Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна" гэж тусгасан нь Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэрэгт шүүхээс шийтгүүлсэн эсхүл цагаатгагдсан тохиолдолд шүүхээс, эсхүл өөр шүүхээс дахин ял оногдуулахыг хориглосон агуулгыг илэрхийлсэн бөгөөд Зөрчлийн хуулиар шийтгэл оногдуулсан эсхүл оногдуулж болох зөрчил давтагдах зүй тогтлоороо нийгэмд аюултай үзэгдлийг гэмт хэрэгт шилжүүлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй энэхүү гэмт хэргийн тохиолдол дээрх зарчимд хамааралгүй гэж үзнэ.

Зөрчилд шийтгүүлсэн нь нэг удаагийн тохиолдол бөгөөд тэрхүү зөрчлийн үйлдэл дангаараа гэмт хэргийн шинжийг хангаж чадахгүй ч өөр бусад ижил тохиолдлуудтай нэгдэж гэмт хэргийн шинжийг хангаж байгаа тохиолдолд зөрчилдөө шийтгүүлсэн нь хууль бус үйлдлийн цаана хамгаалагдаж буй харилцааг Эрүүгийн хуулиар хамгаалах зорилгыг хязгаарлах үндэслэл болохгүй.

Хамгаалагдаж буй харилцааны агуулга нь "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийн "гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх"-д оршино гэсэн зорилгоор тодорхойлох бөгөөд уг хуулийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн эсхүл Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх асуудлыг хууль тогтоогч үйлдлийн давтамжийг харгалзан шат дараалж хүндрүүлсэн нь хууль тогтоогчийн үзэл санаа юм.

Эрх зүй нь зүй бус, хууль бус үзэгдлийг ямагт хүлээн зөвшөөрч болохгүй бөгөөд түүнд хариуцлага хүлээлгэх асуудлыг эрэмбэлж, илэрч буй аюултай түвшин, зүй тогтлоос нь шалтгаалан эрүүжүүлэх, хариуцлагыг хүндрүүлэх зарчим, бодлого цөөнгүй бөгөөд энэхүү ойлголт, ухагдахууныг хууль тогтоогч тооцож, хуульчилсан байна.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэг болон Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан шинжүүдийн давхардаж буй хэсгүүд нь гэмт хэргийн шинжийг тодорхойлох үндэслэл болох бөгөөд аль нэг үйлдлийг гурав, түүнээс дээш удаа, эсхүл нийтдээ гурав, түүнээс дээш удаа байх аль ч тохиолдол гэмт хэргийн шинжийг хангана.

Иймд прокурорын бичсэн эсэргүүцлийн давж заалдах шатны шүүхийн "Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна" гэсэн зарчмыг шийдвэрийнхээ үндэслэл болгосон нь буруу гэсэн хэсгийг хүлээн авч бусад хэсгийг хэрэгсэхгүй болгож, цагаатгах тогтоол, магадлалыг хэвээр үлдээжээ.

Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах санал гаргахдаа ямар гэмт хэрэг хэзээ, хаана

үйлдэгдсэн, сэжигтний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэгт буруутгаж байгаа тухай тодорхой бичнэ. Ялангуяа зүйлчлэлийн талаар анхаарна. Тухайлбал:

А) Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар "Г"-д холбогдох хэргийг 2019 оны 3 дугаар сард хянан хэлэлцэж, дараах шийдвэрийг гаргасан.

Шүүгдэгч "Г" нь 2018 онд хүнсний дэлгүүрт "О"-г утсаар ярьж хардлаа гэж уурлан түүний нүүрэн тус газарт гараараа нэг удаа алгадаж унагаан эрүүл мэндэд нь хүнд хохирол санаатай учруулсан үйлдэлд шүүх "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах" буюу Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2.1-т зааснаар хүндрүүлэн зүйлчилж шийдвэрлэсэн нь хэргийн жинхэнэ байдалд нийцээгүй, шүүх Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн гэж үзсэн.

Шүүгдэгч "Г"-ийн үйлдэлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэх нөхцөл байдал тогтоогдоогүй бөгөөд эр, эмийн хардлагаас үүссэн хувийн таарамжгүй харьцааны улмаас өөрийн эхнэр "О"-ийн эрх чөлөөнд халдсан үйлдлийн сэдэлт, тухайн хэрэг гарахад хохирогчийн хувьд зохих буруутай талаар хохирогчийн өгсөн удаа дараагийн мэдүүлэг, хохирогч, шүүгдэгч нарын хувийн байдал, тэдгээрийн харилцааны түүхийг үл харгалзан зөвхөн "Гэр бүлийн хамаарал бүхий хүн"-ий эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан гэх шинжээр "Г"-д холбогдох хэргийг Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2.1-т зааснаар хүндрүүлэн зүйлчилсэн нь үндэслэлгүй гэж дүгнэсэн.

Б) Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар "П"-д холбогдох хэргийг 2020 оны 04 дүгээр сард хэлэлцэж, дараах шийдвэрийг гарсан.

"П" нь эхнэр "М"-тай харгис хэрцгий харьцаж, 2013, 2015, 2018 онуудад гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болох нь шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар тогтоогдсон хэдий ч дээрх идэвхтэй үйлдлүүдийн хоорондд дээр дурдсан хөөн хэлэлцэх хугацаанууд дуусан байх тул гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангахгүй байгаа талаар давж заалдах шатны шүүх зөв дүгнэлт хийсэн байна.

Харин хоёр шатны шүүх шүүгдэгч "П"-ийг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг үргэлжилсэн үйлдлээр хүчиндсэн гэмт хэргийг үйлдсэн гэж дүгнэсэн нь Эрүүгийн хуулийн заалтын зорилго, агуулгыг буруу ойлгож хэрэглэсэн байна гэж шүүх бүрэлдэхүүн үзсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хуульд заасан гэр бүлийн хамаарал бүхий этгээдүүдэд эхнэр, нөхөр хамаарах боловч Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүчиндэх гэмт хэргийг хүндрүүлэхээр заасан хохирогч гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн байх шинж нь шүүгдэгчийн эхнэр, нөхрийн хэн алинд нь ч хамаарахгүй.

Гэр бүлийн хамааралт этгээдийг хүчиндэх үйлдлийг нийгмийн хор аюулаар энгийн бүрэлдэхүүнтэй хүчиндэх гэмт хэргээс илүүд тооцсон шалтгаан нь эхнэр, нөхрөөс бусад гэр бүлийн хамааралтай буюу садан төрлийн хүмүүсийн хоорондд дахь бэлгийн харилцаа нь нийгэмд тогтсон ёс суртахуун, зан заншлын хэм хэмжээнд харш атал түүнийг хүч хэрэглэн эсвэл заналхийлэн үйлдэх нь хохирогчийн сэтгэл зүй, бие махбодод илүү хүнд тусаж улмаар нийгмийн гишүүдийн нийтлэг үнэт зүйлс дээр суурилсан иргэний ёс зүйн үндсэн зарчмуудад ноцтой хор уршиг учруулах шинж чанарыг хууль тогтоогч харгалзан үзсэн хэрэг юм.

Тодорхой нэг төрөлд хамаарах хэд, хэдэн гэмт хэргийн улмаас учирсан хор уршиг адил атал хохирогчийн гэр бүлийн гарал үүсэл бусад хувийн шинж байдлын шалтгаанаар шүүгдэгчид оногдуулах ялыг хүндрүүлэн тогтоох нь эрүүгийн хууль тогтоомж нийгмийн гишүүдийг тэгш хамгаалах шударга ёсны зарчим алдагдах бөгөөд гэмт хэрэгт оногдуулах ял нь гагцхүү уг гэмт хэргийн нийгмийн хор аюул, шүүгдэгчийн гэмт санаа буюу гэм бурууд тохирсон байх нь дээр өгүүлсэн шударга ёсны зарчмын нэг шаардлага билээ.

Жишээлэн үзвэл шүүгдэгч эхнэр эсвэл нөхрөө хүчиндсэн үйлдэл нь энгийн бүрэлдэхүүнтэй

хүчингийн гэмт хэрэгт хамаарах бол бусад гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн тухайлбал, эгч, дүү, үр хүүхдээ хүчиндэх нь заавал хүндрүүлэн үзэх шинж гарцаагүй мөн.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлд заасан хүчиндэх гэмт хэргийн "гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх" гэсэн хүндрүүлэх шинжид эхнэр, нөхрийг хамааруулан ойлгож болохгүй бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргүүдийн "гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг" гэсэн хүндрүүлэх шинжид эхнэр, нөхрийн хэн аль нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай этгээдэд хамаарах онцлогтой болохыг анхаарах нь зүйтэй гэжээ.

Иймд мөрдөн байцаалтын шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан хэргийн талаар нотолбол зохих байдлыг хангалттай шалгаж тодруулсан, мөрдөн байцаалт болон шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх явцад оролцогчийн хуулиар хамгаалагдсан эрхийг хассан, хязгаарласан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг зөрчсөн гэх ноцтой зөрчил гаргахгүй байхад онцгой анхаарах шаардлагатай.

- ГБХ-ийн дуудлага, мэдээлэл шалгасан илтгэх хуудас, аюулын зэргийн үнэлгээ, цахим сангийн мэдээлэлд үндэслэн хүчирхийлэлтэй харилцааны бодит байдалд мөрдөн шалгах ажиллагаа явуулна.
- Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, гэрч, хохирогчид нөлөөлөх үндэслэлтэй бол Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээ буюу үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг шийдвэрлэнэ.
- Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, эрхийн хязгаарлалтыг тогтоож болно.
- Шүүх дараах гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх. үүргийг хүлээлгэнэ.
- Шүүх тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох хязгаарлалтыг тогтооно.
- Мөрдөгч, прокурор, шүүгч нь сэжигтэн яллагдагч, шүүгдэгчид албадлагын арга хэмжээг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг урьдчилан танилцуулна.
- Хүчирхийлэгчийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ аваагүй гадуур шалгаж байгаа тохиолдолд хохирогч, хүчирхийлэгч 2 байнга хамт байхыг анхаарч аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчийг түр хамгаалах байранд байлгах бүхий л боломжит хувилбарыг авч хэрэгжүүлнэ.
- Мөрдөн шалгах ажиллагаагаар энэ төрлийн гэмт хэрэгт заавал тогтоох ёстой дараах нөхцөл байдлууд байна. Үүнд:
- хүчирхийлэлтэй харилцааны түүх
- хохирогчийн хүчирхийллийг даван туулж буй үе шат

Мөрдөн шалгах ажиллагааны нотлох баримт

ГБХ-ийн гэмт хэргийг бусад төрлийн гэмт хэрэгтэй харьцуулахад илүү түгээмэл үйлддэг ч ураг төрөл, сэтгэл зүйн болон эдийн засгийн хамаарал бүхий хоорондын харилцааг хөнддөг, хувь хүний болон гэр бүлийн нэр төртэй холбоотой асуудал учраас түүнийг нотолж, шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл бэрхшээл учирдгаас түүнийг илрүүлэх, нотлох үйл явц нь мэргэжилтнээс нарийн ур чадварыг шаардана.

Цагдаагийн ажилтан нүдэнд үл үзэгдэвч алхмын төдий зайд байж болзошгүй хүчирхийллийн эрсдэлээс өрсөж хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахын тулд мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн байх шаардлагатай. Мөн дуудлага, мэдээлэл өгсөн

иргэнийг нууцлах бүх талын арга хэмжээг авч ажиллана.

Хүчирхийлэл үйлдэгчийн үйлдлийг дан ганц хохирогчийн мэдүүлгээр бус, бусад эх сурвалжаас тогтоох хэрэгтэй. ГБХ-ийн гэмт хэргийн онцлогоос шалтгаалан энэ гэмт хэргийн гэрч нь хохирогч өөрөө болон гэр бүлийнх нь бусад гишүүд байдаг. Тэд гэмт хэргийг гэрчлэхийг хүсдэггүй. Учир нь хохирогч нь заргалдаж буй хүнтэйгээ хэрэг шийдвэрлэгдтэл нэг орчинд амьдардаг. Хэрвээ нотлох баримт цуглуулах ажилд мэдрэмжгүй хандвал хохирогчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, хохирогчийн хүчирхийллийг илчлэх гэсэн хүсэл зоригийг мохооход хүргэдэг. Энэ төрлийн гэмт хэргийг шалгаж буй цагдаагийн ажилтан хэргийг шалгах явцдаа дараах нотлох баримтыг цуглуулсан байна. Үүнд:

- цагдаагийн ажилтны тэмдэглэл /илтгэх хуудас/;
- аюулын зэргийн үнэлгээ;
- хүчирхийлэлтэй харилцааны түүх;
- хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчийн мэдүүлэг;
- дуудлагын бичлэг;
- хураагдсан эд мөрийн баримт;
- эмнэлэгийн нотолгоо;
- гэмтлийн болон эд зүйлсийн фото зураг;
- шинжилгээ хийлгэх.

Нотлох баримт цуглуулахад анхаарах зүйл:

Хэрэг бүртгэлтийн шатанд шинжээч томилоход гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхой байхад гэрчийн мэдүүлэг авсан байдаг нь цаашид хэрэг шүүхээр шийдвэрлэх үед ЭХХШТХ-ийн 27.2 дугаар зүйлд заасан шинжээчийг татгалзан гаргах хүсэлт гаргах, шинжээчид нэмэлт асуулт тавих, шинжээчид нэмэлт баримт бичиг өгөх, тайлбар гаргах, мөрдөгч, прокурорын зөвшөөрлөөр шинжилгээ хийхэд байлцах, шинжээчийн дүгнэлттэй танилцах зэрэг оролцогчийн эрхийг эдлүүлээгүй гэсэн маргаан гарч байна. Иймд тодорхой хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсаны дараа шинжээч томилж, дүгнэлт гаргуулах нь зүйтэй.

Мөн хэргийн оролцогчдын сэтгэцийн эрүүл мэндэд шинжилгээ хийлгэх асуудалд мөрдөгч нар мэдрэмжтэй байх ёстой. Тухайлбал: Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим "В"-д холбогдох хэргийг 2018 онд хэлэлцэхэд мөрдөн байцаалтын шатанд хохирогч, гэрч нарын сэтгэцийн эрүүл мэнд эргэлзээтэй байхад шинжээч томилж, дүгнэлт гаргуулаагүйн улмаас хэргийг шүүхээр шийдвэрлэх боломжгүй болсон гэж дүгнэсэн.

Насанд хүрээгүй гэрч, хохирогчоос мэдүүлэг авахдаа хууль ёсны төлөөлөгч, бусад оролцогч байлцуулах, шаардлагатай тохиолдолд мэдүүлэг өгөх чадвартай эсэхийг шинжээч томилж, дүгнэлт гаргуулах шаардлагатай. Тухайлбал: Улсын Дээд Шүүхэд гаргасан гомдолд эрүүгийн хэрэгт бага насны буюу 3 нас 10 сартай гэрч нь мөрдөн байцаалтын шатанд "...Би унтаад босоод ирсэн чинь ээжийн нүүр "баба" болсон байсан. Ээж шээнэ гээд байхад нь аав шээлгэхгүй зодоод дараад байсан. Намайг дүүтэйгээ зурагт үзэж байхад аав 2 гараа атгаж байгаад ээжийн толгой хэсэгт цохисон. ...Аав "Г" манай ээжийн араас түлхээд шатнаас унагаасан. Тэгээд ээж газар унаад "ёо ёо" гээд уйлахад аав ээжийн толгой руу 1 удаа гараараа цохисон..." гэх мэдүүлэг, "...Төмөр шанагаар зодсон, гараараа зодсон. ... аав шатнаас түлхсэн. Ээж уйлсан, эндээс нь цус гарсан (баруун гараараа баруун талынхаа хөмсөг хэсэгт заасан)..." гэх мэдүүлэг өгсөн бөгөөд түүнийг ийнхүү өөрийн харсан зүйлийн талаар мэдүүлэг өгөхөд түүнд хэн нэгэн хөндлөнгөөс хууль бусаар нөлөөлсөн, эсхүл мөрдөгч тухайн нотлох баримтыг хууль бусаар бэхжүүлсэн гэж үзэх нөхцөл байгаа эсэхийг шалгуулахаар гомдол гарсан.

Улсын Дээд Шүүхээс дээрх хэрэгт бага насны гэрчээс өөр хэргийн үйл баримтыг шууд харсан гэрч байхгүй бөгөөд гэрчийн мэдүүлэг авахыг хууль ёсны төлөөлөгч "Т" хүлээн зөвшөөрснөөс гадна Шүүх сэтгэц эмгэг судлалын төвийн шинжээчийн дүгнэлтээр насанд хүрээгүй гэрч нь хэргийн талаар өөрийн нас, оюун ухааны түвшинд тусган ойлгож болсон хэргийн талаар өөрийн нас, оюун ухааны түвшинд мэдүүлэг өгөх чадвартай..." гэж дүгнэсэн, мөн энэ хэргийн улмаас түүний төрсөн эхийн амь нас хохирсон зэргийг тус тус харгалзан мөрдөгч

нь бага насны гэрчээс мэдүүлэг авахдаа хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, сурган хүмүүжүүлэгч, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн нарыг байлцуулж, мэдүүлгийг камерын бичлэгээр баталгаажуулсан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах" журмыг зөрчөөгүй гэж үзсэн байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага болон хохирогч төвтэй хандлага

Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны харъяа Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх" гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн шинжилгээний мэргэжилтэн, шинжээчээр оролцож хэрэгт ач холбогдол бүхий ул мөр, эд баримтыг илрүүлж бэхжүүлэн улмаар хохирогчийн эрхийг хамгаалахад чухал ач холбогдол бүхий шинжээчийн дүгнэлт, магадлагаа гаргадаг байгууллага юм. Иймээс шүүх, прокурор, хууль сахиулах чиг үүрэг бүхий албадуудаас гадна шүүхийн шинжилгээний байгууллага ч мөн адил үйл ажиллагаандаа хохирогч төвтэй байх зарчмыг баримтлах нь чухал юм. Шинжээчийн дүгнэлт нь хэргийн талаарх нотлох баримтыг баталгаажуулах боломжийг олгодог тул хэрэг хянан шийдвэрлэх бүхий л шатуудад хохирогч төвтэй арга барилыг ашиглах нь гэр бүлийн хүчирхийлэлтэй хохирогч төвтэй хандлагаар тэмцэхэд үр дүнтэй.

Үзлэг, шинжилгээ явуулахаас өмнө хохирогчид дараах нөхцөл байдлыг хууль, журмын дагуу тодорхой тайлбарлаж өгвөл зохино. Үүнд:

- Хэрэгт ач холбогдол бүхий ямар нөхцөл байдлыг тогтоолгохоор шүүхийн шинжилгээний байгууллагад хандаж байгаа болох,
- Хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээллийг шинжилгээнд ашиглуулах,
- Шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийн өөрт хамааралтай хэсэгтэй танилцах,
- Үзлэг, шинжилгээний явцад хохирогчийн талаар олж авсан мэдээ, мэдээллийг шинжээчийн дүгнэлт гаргахаас өөрөөр шинжээч ашиглахыг хуулиар хориглосон болохыг,
- Хохирогчийн биед үзлэг хийхдээ эмнэлгийн практикт хэрэглэгдээгүй болон хэрэглэхийг хориглосон арга хэрэглэхийг хориглох,
- Шүүний шинжилгээний байгууллагын шинжээчийн үзлэг, шинжилгээний явцад үүсч болзошгүй өвдөлт, сөрөг нөлөөний талаар урьдчилан тайлбарлах,
- Хохирогчид биеийн болон дотуур үзлэгийн үе шат, түүний хэрэгцээ шаардлага, мөн тухайн үзлэгийн үеэр гуравдагч этгээдийг байлцуулах эрхтэй байдаг талаар бүрэн мэдээлэл өгсөн байх.

Гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч шүүхийн шинжилгээний байгууллагад үзлэг шинжилгээнд орох явцад дараах үйлчилгээг нэн тэргүүнд үзүүлэх шаардлагатай. Үүнд:

- Дээрх гэмт хэргийн хохирогчид нэн тэргүүнд шаардлагатай эмнэлгийн тусламжийг гэмт хэргийн ул мөрийг арилгахгүйгээр үзүүлэх,
- Тухайн хохирогчийн овог нэр, нас, гэрийн хаяг бусад мэдээллийг нийтэд ил болгохгүй нууцлах,
- Үзлэг шинжилгээг хохирогчид аль болох тааламжтай байдлаар хуульд заасан журмын дагуу хийх,
- Хохирогчийн шашин шүтлэг, зан үйлийг хүндэтгэх тодорхой гадны нөлөөнөөс ангид байлгах,
- Шинжилгээ томилох эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр үзлэг, шинжилгээний явцад хохирогчийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч, шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах,
- Шинжилгээний явцад хохирогчийн зүгээс тавьсан шинжээч, мэргэжилтэнтэй холбоотой шинжилгээ хийж байгаа хүний хүйстэй холбоотой хүсэлтийг харгалзан үзэх,
- Үзлэг шинжилгээг чухам ямар зорилгоор хийж байгаа болох, ямар үе шаттай

хийх талаар урьдчилан хохирогчид тайлбарлах,

- Хохирогчийн аюулгүй байдлыг хангах,
- Үзлэг, шинжилгээний эцсийн үр дүнг шинжилгээ томилсон эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр холбогдох материалтай танилцах,
- Мэдээллийг өгөхдөө үйлчлүүлэгч ойлгоход хялбар, энгийн байхад анхаарах,
- Хохирогч үзлэг, шинжилгээ явуулахаас бүрэн татгалзах эсхүл үзлэг, шинжилгээний аль нэг үе шатаас татгалзсан тохиолдолд үүний улмаас ямар үр дагавар гарч болох, тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд гарч болох хүндрэл бэрхшээлийн талаарх мэдээлэл өгөх, татгалзсан шалтгааныг баримтжуулах

ДЭД СЭДЭВ 2. Мэдүүлэг авах ажиллагаа

Цагдаагийн газар мэдүүлэг авахдаа хохирогчид хамааралтай асуудлыг гаргаж ирэх шаардлагатай. Хохирогч цагдаагийн байгууллагад хүрэлцэн ирэхдээ өөрийн болон хүүхдүүдийнхээ аюулгүй байдлыг хангах шаардлагатай болно. Иймээс Түр хамгаалах байр, НЦҮТ-дээр мэдүүлэг авах нь хохирогчид ээлтэй байдаг.

А. Хохирогчоос мэдүүлэг авах

- Өөрийгөө танилцуулна.
- Хохирогчид эрх үүргийг нь тайлбарлан өгнө.
- Хохирогчийг хүчирхийлэлд өртсөн даруйд мэдүүлэг авна.
- Хохирогчоос мэдүүлэг авахын өмнө сэтгэл санааг нь тайвшруулна.
- Хохирогчоос мэдүүлгийг ганцаарчилсан тайван нөхцөлд авна.
- Шаардлагатай хохирогчоос мэдүүлэг авахдаа сэтгэл зүйч байлцуулж болно.
- Шаардлагатай гэж үзвэл хохирогчийн ойр дотны нэг хүнийг хамт байлцуулж болно.
- Шаардлагатай хохирогчоос мэдүүлгийг эмэгтэй цагдаагийн ажилтан авна.
- Хохирогчийн мэдүүлгийг дахин авах тохиолдолд анх мэдүүлэг авсан цагдаагийн ажилтан, эсхүл мэргэшсэн цагдаагийн ажилтан авна.
- Хохирогчоос мэдүүлэг авахдаа хүчирхийллийн талаарх санаж байгаа үйл явдлын дараалыг тасалдуулахгүй чөлөөтэй яриулна.
- Мэдүүлгийг утгаар биш, үг бүрээр тэмдэглэн авна.
- Мэдүүлэг авах явцад зарим нэг таагүй асуулт асууж байгаа учрыг тайлбарлаж, тодруулж буй асуудлын учир холбогдлыг ойлгуулна.
- Урт хугацаанд мэдүүлэг авах тохиолдолд завсарлага авна.
- Хохирогчийг цагдаагийн байгууллагад олон дахин дуудахгүй байхад анхаарна.
- Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчийн өмнө дуудахгүй, нүүрэлдүүлэхгүй.
- Хохирогчийг гэмт хэргийг нотлох үүрэгтэй оролцохыг шаардахгүй.

Б. Хүчирхийлэл үйлдэгчээс мэдүүлэг авах

- Мэдүүлгийг цагдаагийн байгууллага дээр авна.
- Хүчирхийллийн шалтгаан, хэлбэр, давтамжийг тодорхой асууна.
- Хүчирхийлэл үйлдэгчид гаргасан үйлдэлд хохирогч бус, цагдаагийн байгууллага эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татан шалгаж байгааг ойлгуулна.
- Хүчирхийлэл үйлдэгчид өөрийнх нь хүчирхийллийн үйлдэлд хуулийн хариуцлага, шийтгэл хүлээлгэх тухай ойлгуулна.
- Хүчирхийлэл үйлдэгчид хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний газруудад ойртохыг хориглодог талаар сануулна.
- Хохирогч эмэгтэй орон гэрээ орхиж явсан бол хүчирхийлэл үйлдэгчид түүнийг хаана байгаа талаар мэдээлэл өгөхгүй.
- Хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийллийн хор уршгийг тайлбарлан ойлгуулна.

Хохирогчтой ярилцлагыг хэрхэн эхлүүлэх вэ?

Ярилцлагыг дараах байдлаар эхлүүлэх нь зүйтэй. “Ирсэнд их баярлалаа. Болсон явдалд харамсаж байна. Та хэцүү зүйлийг даван туулсан гэдгийг би мэднэ, танд туслахын тулд боломжтой бүх зүйлийг хийнэ. Цагдаад мэдэгдсэнээр та үнэхээр их зориг гаргаж зөв зүйл хийсэн байна. Одоо би танаас хэдэн

асуулт асуух хэрэгтэй байна. Танд үүний тухай ярихад хэцүү байгаа, гэхдээ би тодорхой мэдэх шаардлагатай байна. Учир нь бид хүчирхийлэл үйлдэгч этгээдэд хариуцлага тооцох ёстой. Танд их хэцүү байвал, эсхүл завсарламаар байвал хэлээрэй...” гэх мэт

Мэдүүлэг авах аргачлал

- Таныг энд буруутгах буюу шүүх гэж биш, харин танд туслах гэж байгааг хэлэх,
- Хохирогч хүчирхийлэлд өртсөн нь түүний буруу биш, харин хүчирхийлэл үйлдэгчийн буруу, хүчирхийллийг ямар ч тохиолдолд өмгөөлж болохгүй гэдгийг хохирогчид сайтар ойлгуулах,
- Юу тохиолдсоныг надад аль болох дэлгэрэнгүй яривал би таныг төдий чинээ ойлгох болно.
- Хохирогчийг тайван ярих боломж олгож, болсон явдлыг дараалаар нь ярихыг хүсэх. Ярилцлагыг хүчирхийлэл болохоос өмнөх байдлаас эхлүүлэх.
- Хэрэв би таны хэлж буйг буруу ойлгосон бол надад хэлнэ үү, би энэ тухай мэдэж зөвөөр ойлгуулахыг хүснэ.
- Хэрэв та миний хэлж буйг ойлгоогүй бол надад хэлнэ үү, би дахин ойлгуулъя.
- Хэрэв та хариултандаа итгэлгүй байгаа бол битгий тааж хэлээрэй, хариулахаасаа өмнө энэ тухайгаа надад хэлээрэй.
- Хохирогчоос асуулт асуусан тохиолдолд лавлаж болох боловч, хариулахаас нь өмнө бодох хугацаа өгөх.

Хандлага

- Хохирогчтой илэн далангүй ярилцаж, нэг талыг барихгүй байх;
- Уух юм санал болгох;
- Хохирогчоос нээлттэй асуулт асууж, мэдүүлгийг чөлөөтэй яриулах байдлаар авч, хэрэгт хамааралтай асуултыг тодорхой тавина.
- Чөлөөт ярилцлага нь хохирогч хамгийн дэлгэрэнгүй мэдээллээ илчилдэг, мэдүүлгийг тодорхой болгодог чухал хэсэг юм.
- Нээлттэй асуултууд нь нэг үйл явдлын талаар илүү мэдээлэл олж авах, төрөл бүрийн мэдээлэлд хяналт тавих боломж олгохын зэрэгцээ цагдаагийн ажилтан болсон явдалд өөрийн хувийн бодол санааг илэрхийлэх эрсдэлийг багасгана.
- Мэдүүлэг авахаас өмнө цагдаагийн ажилтан хүчирхийллийн гол асуултуудыг төлөвлөх хэрэгтэй (хор уршиг, давтамж, даамжрал, эрсдэл гэх мэт).
- Хохирогчийн хувьд цагдаагийн ажилтны асуулт хүчирхийлэлтэй ямар ч хамааралгүй мэт санагдаж болох учир тодруулж буй асуултын учрыг тайлбарлавал хохирогч илүү дэлгэрэнгүй хариулт өгнө.
- Хохирогчоос урт хугацаанд мэдүүлэг авахад анхаарал төвлөрөл сулардаг тул шаардлагатай үед богино завсарлагуудыг авах хэрэгтэй.
- Хохирогч эмэгтэй хүнд илүү итгэж, илүү дэлгэрэнгүй ярьдаг тул эмэгтэй цагдаагийн ажилтан мэдүүлгийг авах нь үр дүнтэй.
- Хохирогчоос мэдүүлэг авахдаа түүнийг яаруулахгүй, анхааралтай сонсоно.
- Хохирогчид итгэж буйгаа итгүүлээрэй. ГБХ-ийн үед хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг буруутгаж “Чамд хэн ч итгэхгүй” гэж итгүүлсэн байдаг.

Асуулт

- “Нөхөр чинь таныг зодсон уу?” гэсэн хаалттай асуултын оронд “нөхөр чинь ажлаасаа ирээд яасан бэ? таныг яаж цохисон бэ? гэх мэт нээлттэй асуулт асуугаарай.
- “Таныг яагаад цохисон/хүчиндсэн бэ?” гэсэн асуултнаас татгалзах хэрэгтэй. Учир нь эмэгтэй хүн хүчирхийлэл үйлдэгчийн үйлдлийн төлөө хариуцлага хүлээхгүй, ийм асуултыг хүчирхийлэл үйлдэгчид тавина.
- Хохирогчийн бэртэл гэмтлийг ямар байдлаар, хэрхэн үүссэн талаар тодорхой асууна. “Таныг яаж цохисон бэ? хаана нь? Таныг цохихдоо зангидсан гараар уу, хөлөөр үү, эсхүл ямарваа нэгэн зүйлээр үү”?
- Зөвхөн бие махбодын хүчирхийлэл дээр битгий төвлөрөөрэй, хүчирхийллийн бусад хэлбэрийн талаар асуугаарай. Жишээ нь, сүрдүүлэг, дарамт шахалт, эвдсэн зүйл, бэлгийн, эдийн засгийн

хүчирхийллийн талаар гэх мэт.

Мэдүүлгийн онцлог

- Хохирогч хүчирхийллийг давтан ярихад дахин хүчирхийлэлд өртөж байгаа мэт сэтгэл зүйн байдалд ордог тул хохирогчийн сэтгэл зүйн байдлыг ойлгож, хүлээцтэй хандана.
- Хохирогчийн яриаг гэнэт тасалж, өөр зүйл асуувал хохирогч ярьж байсан зүйлийнхээ дараалаасаа гарч, хүчирхийллийн өөр нэг үе, элемент рүү орох болдог. Энэ байдал давтагдах тохиолдолд "зөвхөн богино хариулт хэрэгтэй юм байна" гэсэн буруу ойлголт хохирогчид төрж, эцэстээ нарийвчилсан мэдүүлэг өгөхөө больж эхэлдэг.
- Хохирогчоос цагдаагийн өөр өөр ажилтан, олон удаа байцаалт авахаас зайлсхийх хэрэгтэй. Учир нь хохирогч өөрийнх нь хэргийг тоохгүй байна гэсэн ойлголт авдаг.
- ГБХ-ийн гэмт хэрэгт худал мэдээлэл өгч, гомдол гаргах тохиолдол тун ховор байдаг. Тиймээс хохирогчдын мэдээлэл бусад гэмт хэргийн хохирогчийг бодвол үнэн зөв байх магадлал өндөр байдаг.
- Хохирогчийн сэтгэл хөдлөлөөр хэлсэн үг, үйлдлийг сайтар тэмдэглэж, боломжтой бол аудио, видеогоор давхар баримтжуулах хэрэгтэй. Энэ нь дараа нь хохирогч мэдүүлгээсээ татгалзсан үед ач холбогдолтой байдаг.
- Гэрч, хохирогчийн мэдүүлгийг аль болох эрт авах нь чухал ач холбогдолтой. Учир нь хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн дарамтад орж гомдлоосоо татгалзах, хүчирхийллийг бууруулж ярих тохиолдол их байдаг.
- Хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэй ойр дотно харилцаатай, түүний гомдлоо буцааж тат гэсэн дарамтан дор байдаг, шийтгүүлэхийг хүсэх боловч, сайжрах болов уу, дордох болов уу гэх зэрэг олон эргэлзээтэй, сэтгэл зүйн хувьд хүндрэлтэй байдаг.
- Эрүүгийн хэрэг үүсгэхгүй шийдвэр гарсан ч хохирогчид мэдэгдэж, баримтуудыг хадгалах хэрэгтэй. ГБХ гэнэт зогсдоггүй, өмнөх баримтууд дараа хэрэг болж, хүчирхийлэл давтагдсан тохиолдолд нотлох баримтаар ашиглах боломжтой байдаг.
- Хохирогч гомдол гаргасны төлөө хүчирхийлэл даамжрах нь бий.
- Нөхцөл байдлаас хамаарч, хохирогчид болон гэрчүүдийг гэрт нь мэдүүлэг авбал цагдаагийн газарт авснаас илүү мэдээлэл өгч болох юм. Зарим эмэгтэйчүүд гэртээ ярихдаа илүү айдастай байдаг бол зарим нь эмнэлэгт, эсвэл түр хамгаалах байранд мэдүүлгээ өгч болно.
- Хохирогчийг шууд бусаар буруутгаж буй мэт асуултыг тавьж болохгүй.

ХОРИГЛОХ АСУУЛТ:

- *Та юунаас болж энэ хүнтэй амьдарч байгаа вэ?*
- *Та хүчирхийлэлтэй харилцаагаа таслахгүй яасан юм?*
- *Таны ямар үйлдлээс болж таныг цохисон бэ?*
- *Түүнийг тайвшруулахын тулд та юу хийж чадах вэ?*

3.2. ПРОКУРОРЫН АНХААРАХ АСУУДАЛ

Удиртгал

Прокурор нь Монгол улсын Үндсэн хууль болон Прокурорын тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад заасан үндсэн чиг үүргийнхээ хүрээнд зөрчлийн хэрэг бүртгэлт болон гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгах, шийдвэрлэх ажиллагаанд эхнээс нь дуустал тасралтгүйгээр хяналт тавьж, удирдан чиглүүлж оролцох үүрэгтэй субъект юм.

ГБХ-ийн улмаас хүний амь нас хохирсон, эсхүл хүний эрүүл мэндэд хохирол учирсан хэргийг прокурор хянан шийдвэрлэхдээ жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний нэг хэлбэр болох ГБХ-ийн мөн чанар, онцлогийг харгалзан хууль зүйн дүгнэлт хийх шаардлага тулгардаг.

Дотоодын болон олон улсын байгууллагын хийсэн хэд хэдэн судалгаанд прокурор, шүүгч, хууль сахиулагч нарт ГБХ-ийн талаарх ташаа ойлголт хэвээр, хохирогч төвтэй арга барилд суралцахгүй байгааг дурьдсан байна. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх хууль, эрх зүйн орчин өөрчлөгдөж, ГБХ агуулсан гэмт хэрэг, зөрчлийг шүүхээр хянан шийдвэрлэхэд хууль хэрэглээний нэгдсэн практик хэдийнээ тогтсон боловч мөрдөн байцаалт, прокурорын хяналтын явцад ГБХ-ийн талаарх зөрүүтэй байр суурь, хууль хэрэглээний маргаанаас болоод хэрэг шийдвэрлэгдэхгүй удаашрах, улмаар хохирогчийг дахин хохироход хүргэх эрсдэлүүд хэвээр байна.

Гарын авлагын прокурорт зориулсан энэхүү хэсэгт ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийн онцлог шинж, түүнийг зөв ялган зүйлчлэх, гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоох, учирч болох эрсдэлийг тооцоолох, гэрч, хохирогчийн болон хүчирхийлэл үйлдэгч этгээдийн зан үйл, сэтгэл зүйн өвөрмөц онцлог байдалтай уялдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, прокурорын хяналтын явцад анхаарах асуудлыг практикт тулгуурлан тусгахыг зорьсон болно.Тухайлбал:

- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалган шийдвэрлэх ажиллагааны онцлог;
- ГБХ үйлдэх гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчтой харилцах, хамгаалалтад авах, яллагдагчид авах таслан сэргийлэх арга хэмжээ;
- ГБХ ийн гэмт хэрэг, зөрчлийн шүүх хуралдаанд прокурор, улсын яллагч бэлтгэл хангаж оролцох,

3.2.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

ДЭД СЭДЭВ 1. ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн бусад төрлийн гомдол, мэдээллээс ялгагдах онцлог.

Гэр бүлийн хүчирхийлэл нь цагдаагийн байгууллагад хандсан гомдол, мэдээлэл, дуудлагын эхний 4-д орж байна. Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан, Статистикийн үндэсний хороо жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгаагаар Монгол Улсад ойр дотно хамтрагч болон бусдын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийн түвшин хэт өндөр байгааг тогтоосон болов[69] тэдгээрээс цагдаагийн байгууллагад хандаж байгаа албан ёсны тоо хол зөрүүтэй байдаг.

69 https://mongoliA.unfpA.org/mn/publications

Цагдаагийн байгууллагад хандсан ГБХ-ийн шинжтэй дуудлага мэдээлэл 2017-2018 онд 2 дахин нэмэгдсэн нь ГБХ-ийн талаарх мэдээллийг иргэд цагдаагийн байгууллагад шуурхай дамжуулдаг болж иргэний үүргээ биелүүлэхээс гадна цагдаагийн байгууллагын зүгээс дээрх дуудлага, мэдээллийг нэн тэргүүнд шалгаж хүчирхийлэл үйлдэгчийн үйлдэл бүрт хуулийн хариуцлага тооцож байгаатай холбоотой гэж үзжээ.[70] Гэхдээ энэхүү дүгнэлт нь Улаанбаатар хотын хэмжээнд хамааралтай бөгөөд орон нутагт эсрэгээрээ хохирогчоос гомдол, мэдээлэл гаргаж шийдвэрлүүлэх эрмэлзлэл бага байна.

Нийт гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг авч үзвэл 33.8 хувийг бүрэн шийдвэрлэж, 66.2 хувийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад заасан гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй үндэслэлээр татгалзаж шийдвэрлэсэн буюу ямар нэгэн арга хэмжээ аваагүй, үр дүн гараагүй байна.[71]

ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг:

- гэр бүлийн дотно харилцаа, хамаарал бүхий хүмүүсийн хооронд үүссэн,
- аюулын өндөр эрсдэл, хор уршгийг дагуулсан,
- даамжирсан, давтамжтай, /нэг бус удаагийн/
- нуугдмал шинжтэй
- нэн даруй, шуурхай арга хэмжээ авах шаардлагатай,
- гэрчгүй үйлдэгддэг,
- хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчээс хамааралтай буюу ихэнх хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэй байнга хамт байдаг зэрэг байдлаар нь бусад төрлийн гомдол, мэдээллээс ялгаж болно.

Хууль хэрэгжүүлэх явцад ГБХ-ийн дуудлагаар цагдаагийн ажилтан очиход дуудлагаа буцаах, хаягаа буруу өгөх, хаягаа өгсөн айл эзэнгүй байх, очиход зугтаасан байх, хүчирхийлэл үйлдэгчийг саатуулсны дараа гомдолгүй хэмээн өргөдлөө буцаах явдал их байна гэж[72] зарим судалгаанд иш баримттай дүгнэжээ. Иймд гомдол мэдээллийн шийдвэрлэлтэд хяналт тавьж буй прокурор нь хянаж буй ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн ялгагдах онцлогийг тодорхойлж чаддаг байх явдал чухал.

ГБХ-ийн гомдол, мэдээлэл дараах онцлог шинжтэй байна. Үүнд:

1. Гэр бүлийн дотно харилцаа, хамаарал бүхий хүмүүсийн хооронд үүссэн харилцаа байх. (хамаарал бүхий харилцаатай хүн гэдгийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3.1.1-д заасан)-аар ойлгох.
2. Хохирогчид хүчирхийллийн улмаас эрүүл мэнд, бие махбодь болон сэтгэл санаа, эд хөрөнгөд нь бодитой хохирол учирсан байх. Мөн цаашилбал аюулын өндөр эрсдэл буюу амь нас эрсдэх, бие махбодид нь хүнд хор уршиг учрах нөхцөл бий болсон байх
3. Холбогдогч нь өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд аль нэг давуу талаа ашиглан хохирогчийн эрх ашиг сонирхлыг хохироох үйлдлийг давтамжтайгаар, даамжруулсан, удаашруулсан байх,
4. Хууль сахиулах байгууллага болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн алба хаагч, ажилтнууд нь ГБХ-ийн талаар мэдсэн, мэдээлэл хүлээн авсан даруйд нэн даруй арга хэмжээг авах шаардлагатай, шуурхай ажиллагааг шаардсан байх,
5. ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчил нь гол төлөв гэрчгүй, зөвхөн хохирогч, холбогдогч хоёрын хооронд үйлдэгддэг, ямар нэгэн байдлаар хөндлөнгөөс нотлох баримт үлдээдэггүй,
6. Хохирогч нь холбогдогчоос санхүүгийн болоод бусад байдлаараа бүрэн хамааралтай, хараат болсон, өөртөө итгэх итгэлгүй, сул дорой байдалд орсон байдаг зэргээрээ бусад төрлийн гомдол,

70 "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт" мониторонгийн тайлан. 2018. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв.

71 "Гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал" судалгааны тайлан. Монголын криминологичдын холбоо. 2020 он

72 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхтэй холбоотой хуулийн хэрэгжилтийн талаар УИХ гишүүн З.Нарантуяагаас МУ-ын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариу file:///C:/Users/H!/Downloads/narantuya%20gishuun%20hariu.pdf

мэдээллээс ялгагдана.

Мөн ГБХ нь:

- Үл ялих зүйлээр шалтагласан,
- Тодорхой нэг шалтаг, шалтгаангүй,
- Эрхшээлд буюу тухайн гэр бүлийн хүчирхийллийн орчинд байгаа хүн эрх мэдлийн ялгаатай байдалд байх гэсэн онцлог шинжүүдийг агуулна.

Харин Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн байсан хэдий ч ГБХ-ийн шинж болох даамжирсан, давтамжтай, байнга үйлдэгдэх, үл ялих зүйлээр шалтагласан, шалтаг шалтгаангүй, эрхшээлд байх гэсэн шинжийг агуулаагүй бол гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс хоорондоо бодит хардалт, харилцааны шинжтэй зөрчилдөөний улмаас хэн нэгнээ зодож, гэмтэл учруулсан тохиолдол бүр нь ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчил болохгүй бөгөөд үүнийг ялгаж ойлгох нь чухал.

Гудамж талбай, олон нийтийн газар үйлдэгддэг хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчил нь гол төлөв өөр хоорондоо бие биенээ үл таних хүмүүсийн хооронд үйлдэгдэж, хариуцлага хүлээдэг байхад ГБХ нь ойр дотно, хамт амьдардаг хүмүүсийн хооронд болж байдгаараа онцлог юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн хоорондын ялгаа.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйл. "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх" гэмт хэрэг	Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл. "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих" зөрчил
1.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга: 1.1.зодсон; 1.2.харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; 1.3.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан, 2.Энэ гэмт хэргийг: 2.1. хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн; 2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн; 2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн	4. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: 4.1. зодсон, 4.2. хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, 4.3. бусадтай харилцахыг хязгаарласан, 4.4. хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан,

Зөрчлийн тухай хуульд зодсон, тодорхой үйлдэл хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хөрөнгө эзэмших, захиран зарцуулах эрхэд халдах гэсэн шинжийг тусгасан ба үүнээс хөрөнгө эзэмших, захиран зарцуулах эрхэд халдах, зодохоос бусад шинж гэмт хэргийн шинжид хамаарахгүй юм.

Тухайлбал гомдол мэдээллийг шалгах явцад хүчирхийлэл үйлдэгч гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг өөрийн эрхшээлд байлгаж, бие махбодид нь халддаг, доромжилдог, үг яриагаараа сэтгэл санааны дарамтад оруулдаг зэрэг нөхцөл байдал тогтоогдвол энэ зөрчилд заасан хэд хэдэн үйлдлийн шинжийг хангаж байна. Амьдралд гарч байгаа зөрчлийн шинж болгон адилгүй байх ба зарим тохиолдолд зөвхөн нэг үйлдэл, эс үйлдэхгүйн шинжийг хангаж байхад зарим тохиолдолд гэр бүлийн хоёроос дээш гишүүний нэгийг зодож, нөгөөг нь сэтгэл санааны дарамтад байлгасан, албадсан байж болдог. Энэ тохиолдолд аль аль нь зөрчлийн шинжийг хангах ба зөвхөн аль нэг хэлбэр нь байна гэж үзэж болохгүй.

Зарим хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокуроос гомдол, мэдээлийг шалгах явцад хэргийг хаахад дараах нөхцөл байдал нөлөөлдөг гэж дүгнэсэн. Үүнд: хохирогчоос гэр бүлийн нэр хүнд болон өөрийн нэр хүндэд нөлөөлөх эрсдэл, гэр бүл салалт, мөн тухайн хүчирхийлэл дахин үргэлжилж, цагдаагийн

байгууллагаас шийдвэрлэж өгөхгүй байх гэсэн айдас нөлөөлдөг, мөн цагдаагийн алба хаагчийн анхан шатны дуудлагад хайхрамжгүй хандах явдал ихээр нөлөөлдөг, мөн дуудлага, мэдээлэл хэн өгснийг ямар нэг байдлаар илчилдэг зэрэг нь дахин энэ талаар гомдол гаргах явдлыг нуугдмал түвшинд хүргэдэг гэж дүгнэн ярьжээ.[73] Гэр бүлийн хүчирхийллийг эрт шатанд илрүүлэх шинэлэг арга, хувилбар, дуудлаганд очих цагдаагийн алба хаагчийн ур чадварыг ахиулах шаардлага байгаа нь үүнээс харагдаж байна.

Кейс: Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдэн гарсан эрүүгийн .....047 дугаар Б.Л... холбогдох хэрэгт авагдсан нөхцөл байдлыг дүгнэж үзвэл 2016-2017 онд хохирогч О нь Цагдаагийн байгууллагад 10 гаруй удаа дуудлага өгч байснаас гадна 2017 оны 3 дугаар сард хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэхээр хамтарсан багийн хурлаар хэлэлцэж байсан хэдий ч асуудлыг шийдвэрлэхгүй хугацаа алдсанаас 2017 оны 8 дугаар сард хохирогчийг алсан байна.

Гомдол, мэдээлэлд хяналт тавьж байгаа прокурор нь тухайн гомдол мэдээлэл нь гэмт хэрэг, зөрчлийн алинд хамаарахыг шийдвэрлэх үүрэгтэй ба цагдаагийн байгууллага ихэвчлэн гомдол, мэдээллийг анх хүлээн авахдаа удирдах албан тушаалтны шийдвэрээр алинд хамаарахыг урьдчилан шийдвэрлэдэг. Иймээс зөрчлийн хэрэг нээхээс татгалзах, зөрчлийн хэрэг нээх, эсхүл гомдол мэдээллийг шалгах явцад хэргийг татаж хянах зэргээр тухайн үйл баримт нь гэмт хэрэг, эсхүл зөрчлийн шинжтэй эсэхийг шийдвэрлэх боломжтой.

Гэмт хэрэг, зөрчил дараах шинжээр ялгагдана. Үүнд:

1. Зөрчлийн тухай хуульд заасан 4 шинжээс "зодох, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан"- гэсэн 2 үйлдлийг "байнга "үйлдсэн нь Эрүүгийн хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг болно.
2. Зөрчлийн тухай хуульд заасан "зодох" үйлдлийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт "...Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд /нөхөр, хамтран амьдрагч/ энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг бие махбодын хүчирхийлэл гэнэ." хэмээн Улсын Дээд шүүх тодорхой зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ дэлгэрүүлэн тайлбарласан.
3. ГБХ үйлдэх гэмт хэрэг нь "байнга" гэсэн шинжээр зөрчлөөс ялгагдах бөгөөд зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад 3 ба түүнээс дээш удаа ГБХ үйлдсэн бол гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэлд хамаарна.
4. Гэмт хэрэгт байхгүй зөрчлийн шинжээр байнга гэж үзэж гэмт хэрэгт тооцох нь хууль зүйн үндэслэлгүй талаар шүүхийн практик тогтсон ба гомдол мэдээллийг хүлээн авах эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг бүртгэгчид хууль зүйн тодорхой практик, жишгийг ойлгуулах шаардлагатай. Эрүүгийн хуульд тусгагдаагүй, зөрчлийн тухай хуульд тусгагдсан гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдлийг байнга үйлдсэн нь гэмт хэрэг болохгүй.
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "... хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах ... эд хөрөнгийн хохирол учруулсныг эдийн засгийн хүчирхийлэл гэнэ." гэж тодорхойлсон байх тул зөрчил үйлдэгч гэр бүлийн гишүүдийн дундын болон хуваарьт эд хөрөнгийг эвдэж хохирол учруулсан үйлдэл нь Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4.4 дэх заалтад заасан зөрчлийн шинжид бүрэн нийцнэ гэж шүүх дүгнэн шийдвэрлэж байна. Зөрчлийн шинжийг нэг мөр, зөв ойлгох нь эрх бүхий албан тушаалтан, алба хаагч зөрчлийн тухай гомдол мэдээллийг шалгахад ач холбогдолтойг анхаарах.

73 Гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал" судалгааны тайлан. Монголын криминологичдын холбоо. 2020 он

"Г" нь "А" тай 2018 онд гэр бүл болсноос хойш тэдний гэр бүлд ямар нэгэн байдлаар маргаан, хэн нэгнээ цохиж, зодох асуудал гарч байгаагүй. Гэтэл 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр "байрны төлбөр төлсөнгүй" гэх шалтгаанаар хоорондоо маргалдан улмаар "А" "Г"-ийн хацар руу нэг удаа алгадсан. Энэ асуудлаас болж "Г" цагдаагийн байгууллагад "нөхөр намайг зодлоо" гэх гомдлыг гаргасан.

Цагдаагийн байгууллагаас уг гомдлыг ГБХ-ийн дуудлага, мэдээллээр хүлээн авч, "Г"-ээс мэдүүлэг авахад:

-Аюулын зэргийн үнэлгээ 2 буюу бага гарсан.

-Дуудлага, мэдээлэлд очиж ажилласан эргүүлийн офицерийн илтгэх хуудаст "... нөхөр намайг зодлоо" гэх дуудлагын дагуу очиход эхнэр, нөхөр 2 маргасан, гэрт эмх замбараагүй байдал бий болоогүй хэвийн, гомдол гаргагч "Г"-ийн биед ил харагдах гэмтэл шархгүй, аюулын зэргийн үнэлгээ хийхэд "2 буюу бага гарсан. Гомдол гаргагч "Г" хамгаалах байранд очихгүй, гомдолгүй, цагдаагийн байгууллагаар шалгуулахгүй гэв" гэжээ.

-"Г" мэдүүлэгтээ:

"... манай нөхөр "А" урьд өмнө нь намайг цохиж, зодож байгаагүй. 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр анх удаагаа гар хүрч байна. Иймд надад гомдол, санал нэхэмжлэх зүйл байхгүй. Шүүх эмнэлэгт үзүүлэхгүй" гэсэн байна.

1. *Сэдвийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн бусад төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс ялгагдах гол онцлогыг тодорхойлж бичнэ үү?*
   А).....
   Б).....
   В).....
   Г).....

ДЭД СЭДЭВ 2. ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын онцлог.

Цагдаагийн байгууллага нь хохирогч, "бүх шатны боловсролын байгууллагын багш, сургуулийн нийгмийн ажилтан, бусад ажилтан"[74], "эрүүл мэндийн, нийгмийн, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан"[75], "сум, дүүрэг, баг хорооны холбогдох албан тушаалтан"[76], "төрийн албан хаагч, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын ажилтан"[77], "этгээд, хуулийн этгээд"[78]-ээс амаар, бичгээр, утсаар, цахим хэлбэрээр ирүүлсэн ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяалал харгалзахгүйгээр хүлээн авч, нэн даруй хойшлуулашгүй ажиллагааг явуулдаг.

Мөн "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуульд ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага, сум, дүүргийн Засаг дарга хүлээн авахаар тусгагдсан тул сум, дүүргийн Засаг даргад ирүүлсэн гомдол, мэдээллийг нэн даруй цагдаагийн байгууллагад шилжүүлэн авч, ажиллагааг эхлүүлэн ГБХ-ийг хуульд заасан арга хэрэгслээр таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учирсан, эсхүл тухайн орчин нь аюултай гэж үзэн хохирогчийг хамгаалах арга хэмжээг нэн даруй авах үүргээ хэрэгжүүлэн ажилласан эсэхэд прокурор хяналт тавина.

Прокурорын байгууллага нь ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллагаас гадна төрөл бүрийн эх сурвалжаас шууд хүлээн авч болно.

Эдгээрт хохирогч, хувь хүмүүс болон эмэгтэйчүүдийн нийгэмлэг, төрийн бус байгууллага болон "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн 23 дугаар зүйлд заагдсан "бүх шатны боловсролын байгууллагын багш, сургуулийн нийгмийн ажилтан, бусад ажилтан"[1], "эрүүл мэндийн, нийгмийн, хүүхэд, гэр бүлийн

74 ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1
75 ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2
76 ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 23дугаар зүйлийн 23.1.3
77 ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.4
78 ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2

асуудал хариуцсан ажилтан"[2], "сум, дүүрэг, баг, хорооны холбогдох албан тушаалтан"[3], "төрийн албан хаагч, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын ажилтан"[4], "этгээд, хуулийн этгээд"[5]-үүд хамаарна.

Энэ тохиолдол бүрт прокурор хүлээн авсан бүх гомдол, мэдээллээ харьяа цагдаагийн байгууллагад нэн даруй шилжүүлэх арга хэмжээг авч, тэргүүн ээлжинд хийгдвэл зохих ажиллагааны талаар амаар чиглэл өгөх болон бичгээр даалгавар өгнө.

ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад ирэхэд дуудлага, мэдээллийн дагуу нэн тэргүүнд дуудлага, мэдээлэлд газар дээр нь эргүүлийн офицер, хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа гэх мэт эрх бүхий албан тушаалтнууд очиж ажиллаж байгаа бөгөөд хуульд заасан тодорхой ажиллагааг хийж бүртгэлд авснаар прокурорын байгууллагын нэгдсэн бүртгэлд орж прокурорын хяналтанд орно.

Прокурор нь ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан эсэхэд хяналт тавих бөгөөд дараах асуудлыг анхаарч хянавал зохино. Үүнд:

- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл ямар байдлаар цагдаагийн байгууллагад ирсэн, гомдол гаргагч нь биеэр болон холбоо мэдээллийн хэрэгслээр гаргасан бол дуудлага, мэдээлэл хүлээн авагч нь үүргээ бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх.
- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл гаргагчид цагдаагийн байгууллагад хуурамч дуудлага мэдээлэл өгсөн бол хүлээлгэх хариуцлагын талаар сануулж, "Гэмт хэрэг, зөрчлийн талаар амаар болон холбоо, мэдээллийн хэрэгслээр гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авсан тухай тэмдэглэл" үйлдэж танилцуулсан эсэх.
- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн гомдол гаргагч, хохирогч нь "ГБХ-тэй тэмцэх тухай"[1] хуулийн 3 дугаар зүйлд заасан гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн мөн эсэхийг шалгаж тогтоосон эсэх.
- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн дуудлагыг шалгах цагдаагийн ажилтан хүлээх үүргээ бүрэн хэрэгжүүлсэн эсэх. Дэлгэрэнгүйг дуудлага шалгах цагдаагийн ажилтны үүрэг хэсгээс харна уу.
- Тухайн айл болон иргэний талаар өмнө нь цагдаагийн байгууллагад дуудлага өгч байсан эсэх, түүний шийдвэрлэлтийн байдал зэргийг шалгаж тогтоосон эсэх.
- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээллийн хохирогч, гэрч нарыг тусгаарлан, хохирогч, гэрч нарт хамгаалуулах эрхтэй болохыг нь танилцуулж, хамгаалах байранд хандах, хамгаалуулах эсэхийг нь лавлаж, тодруулж, хамгаалуулах эрхээр нь хангасан эсэх;
- ГБХ-ийн орчны нөхцөл байдал, хүчирхийлэл үйлдэгдсэн байдал зэргийг нь шалгах, тогтоох, хэргийн газрын үзлэг хийсэн эсэх,
- ГБХ үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйлийг эд мөрийн баримтаар хураан авах, бэхжүүлэх хойшлуулшгүй ажиллагааг хийсэн эсэх.
- Хэргийн газарт хийсэн үзлэгээр гэмт хэрэг, зөрчлийн улмаас үүссэн ул мөрийг (цус, үс, шүлс, биологийн болон бусад) бэхжүүлэн авч, шинжилгээнд хүргүүлсэн эсэх,
- Монгол хэл, бичиг мэдэхгүй, хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчийг орчуулагч, хэлмэрч байлцуулж, эрхийг нь хангасан эсэх.
- Дүрс бичлэг, дуу хураагуураар болж байгаа явдлыг давхар баримтжуулсан эсэх.
- Хохирогч тус бүрт Аюулын зэргийн үнэлгээг хийсэн эсэх, хэрвээ Аюулын зэргийн үнэлгээ "Өндөр" гарсан тохиолдолд хамтарсан багаар хэлэлцүүлж, нөхцөл байдлын үнэлгээ хийлгэх асуудлыг шуурхай шийдсэн эсэх,
- ГБХ-д хүүхэд өртсөн эсэхийг шалгасан эсэх, хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрсдэлийн үнэлгээг хийсэн эсэх,
- Хүүхдийг хамгаалах арга хэмжээг авсан эсэх,

- Хохирогч урьд нь ГБХ-ийн улмаас эмнэлэг, сэтгэл зүйн болон хууль зүйн тусламж авч байсан эсэхийг шалгасан эсэх;
- Хохирогчийн сэтгэцэд өөрчлөлт орсон эсэх, өөрчлөлт орсон бол хөдөлмөрийн чадварыг ямар хугацаагаар алдагдуулсан буюу энэ нь гэмтлийн ямар зэрэгт хамаарч байгааг шинжээчийн дүгнэлтээр тогтоолгосон эсэх;
- Насанд хүрээгүй, бага насны хүүхэд, өндөр настанд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоосон эсэх;
- Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг эрхшээлдээ байлгахдаа хэрэглэдэг арга хэлбэрийг тогтоосон эсэх,
- Хүчирхийлэхдээ аюултай үйлдэл буюу хоолойг боох, амьсгалыг боогдуулах үйлдэл хийдэг эсэхийг тогтоосон эсэх,
- Ямар аргаар тарчлаах, зодох үйлдэл хийсэн, мөн дээрх үйлдлүүдийн цаг хугацааны давтамжийг нарийн тогтоосон эсэх,
- Хүчирхийлэл үйлдэгч согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, согтуудаа дарамталж, хүчирхийлэл үйлддэг эсэхийг тогтоосон эсэх,
- Урьд энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдэж байсан эсэх, хувийн байдлыг шалгасан эсэх,
- Хүчирхийлэл үйлдэгчийн дарамтаас болж хохирогч нь эсрэг үйлдэл үзүүлж, гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцөлийг тогтоосон эсэх,
- Нийлмэл гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, ойролцоо төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс ялгагдах онцлогийг тогтоосон эсэх,
- Дээрх ажиллагаануд хуульд заасан журмын дагуу явагдсан эсэх зэргийг хянавал зохино.

Мөн хохирогчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал ямар түвшинд байгааг шинжээчийн дүгнэлтээр заавал тогтоолгодог байх. Хэрвээ хохирогчийн сэтгэцэд ямар нэг өөрчлөлт орсон бол түүнийг ямар зардлаар, ямар хугацаанд эмчлүүлэх, эдгэрэх боломжтой эсэх талаар эмнэлгийн байгууллагын, шинжээчийн дүгнэлтээр тогтоолгох зайлшгүй шаардлагатай. Хэдийгээр практикт сэтгэл зүйн хохирлыг бодитой тогтоох боломжгүй байгаа боловч үүнийг мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнууд хойшлуулашгүй ажиллагааны явцад тогтоох нь зайлшгүй чухал гэдгийг прокурор анхаарвал зохино.

Аюулын зэргийн үнэлгээгээр хохирогч, хүчирхийлэл үйлдэгчтэй нэг орчинд байх нь аюултай эсэхийг тогтоодог тул үнэлгээг хүчирхийллийн тохиолдол бүрт богино хугацаанд гүйцэтгэж, улмаар "хохирогчийн аюулгүй байдлыг хангах" шийдвэрийг яаралтай гаргах үндэслэл болгон ашиглах ёстой. Цагдаагийн алба хаагчид гомдол, мэдээллийн дагуу тохиолдол бүрт аюулын зэргийн үнэлгээ заавал хийж хэвшсэн боловч энэ нь нотолгооны хэрэгсэл болон хувирч, улмаар хэргийг шүүхээс буцаах нэг шалтгаан болж хувирсан аж. ХЭҮТ-өөс 2018 онд хийсэн "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт" мониторингийн судалгааны дүн үүнийг нотолж байна.

Анхаарах зүйл: Аюулын зэргийн үнэлгээг гомдол, мэдээллийг шалгах явцад заавал хийхгүй тохиолдол байх бөгөөд энэ нь гэмт хэрэг гарсан нь илэрхий, хүний амь нас эрүүл мэндэд шууд хохирол учирсан, тусгаарлах шаардлагатай зэрэг хэрэг учрал болсон газарт хүрэлцэн ирэх тохиолдлууд юм. Энэ тохиолдолд дээрх үнэлгээг хийхгүйгээр шууд хэрэг нээн шалгаж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг. Энэ үед гомдол мэдээлэлд мөрдөгч энэ тухай тэмдэглэл үйлдэж тусгах боломжтой. Өөрөөр хэлбэл үнэлгээ хийх ач холбогдол хэдийнээ алдагдаж гэмт хэрэг гарсан нөхцөл байдал үүссэн онцлогийг мөрдөгч, прокурор аль аль нь ойлголцох нь чухал.

Хүүхэдтэй холбоотой асуудал:

ГБХ-ийн хохирогч нь эмэгтэйчүүд, өндөр настай ахмадууд, хүүхдүүд байх нь нийтлэг бөгөөд ялангуяа насанд хүрээгүй хүүхдүүд, тэр тундаа бага насны хүүхдүүд байна.

Зураг 2. "Хүчирхийлэл үйлдэгчийн хүүхэд хүчирхийлэл үйлдэгч" гэдэгтэй та санал нийлэх үү? /Эргэцүүлэл/

Хүчирхийлэл нь бага насны хүүхдийн сэтгэц, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, өндөр эрсдэл, хор уршиг дагуулдаг болохыг прокурор анхаарах нь чухал. Жишээлбэл: эхнэр, нөхөр хоёр нэг тал нь давамгайлсан шинжгүй хэрүүл маргаан, зодоон хийдэг тохиолдолд үүнийг ГБХ гэж үзэх боломжгүй мэт боловч хажууд нь байгаа хүүхэд, өндөр настан хүчирхийлэлд өртөж, хохирогч болж байдаг..

ГБХ үйлдэгч нь хэдийгээр хүүхэд рүү яг чиглэсэн үйлдэл гаргахгүй байгаа ч хүүхдийн дэргэд эхийг нь болон өвөө, эмээ, ах, эгч нарыг нь хүчирхийлж байгаа тохиолдолд бага насны хүүхэд давхар хүчирхийлэлд өртөж байдаг. Үүнд прокурор анхаарч, тухайн ГБХ-ийн орчинд хүүхэд байсан эсэх, хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн байдал бий болсон эсэхийг сайтар хянаж, хүүхдийн зөрчигдөж байгаа эрх ашгийг хамгаалахад чиглэсэн ажиллагааг хийлгэдэг байх хэрэгтэй.

Хэдийгээр эцэг эх нь үр хүүхдээ зодож хашраахыг хүмүүжүүлэх арга гэж үздэг уламжлалт үзэл, үүнийг хэвийн үзэгдэл мэтээр ойлгож ирсэн зэрэг байдал байх хэдий ч насанд хүрээгүй буюу ялангуяа бага насны хүүхэд нь төрсөн эцэг, эх, ах, эгч, өвөө, эмээгээсээ илт хүч дутуу, тэдэнтэй ямар нэгэн эрх тэгш байдлаар хандах боломжгүй, хувийн таарамжгүй харьцаа үүсгэх боломжгүй бөгөөд хэрвээ хүүхдэд бие махбодид нь хүч хэрэглэн халдаж зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан зөрчлийг гаргасан тохиолдлыг онцгой тохиолдолд авч үзэн хүүхдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг шуурхай авахуулж байх. (Үүнд: хүүхдийн асран хамгааллын асуудлыг хөндөх, сэтгэл зүйд учирсан хүнд дарамт бий болж байгаа эсэхийг тогтоолгох, мэргэжлийн эмч, сэтгэл зүйчид хандах зэрэг).

"Э" нь 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, Хилчиний 5-63 тоотод байх гэртээ төрсөн охин 10 настай "А"-г "хичээл хийсэнгүй" гэх шалтгаанаар 2 гарыг нь өргүүлэн, галын шилээвэр төмрөөр гуя, бөгс хэсэгт нь 2-3 удаа цохиж,

Мөн 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдөр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ хамтран амьдрагч "О"-той "архи уулаа" гэх шалтгаанаас болж маргалдан улмаар толгой руу нь гараараа 4-5 удаа цохиж, хоолойг нь боож, 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдөр "шөнө хүүхдүүдээ авч явна" гэж маргалдан хоолойг нь боон, сандлаар толгой руу нь 1 удаа цохин тус тус зоджээ.

Гомдолд: хохирогч "О", насанд хүрээгүй хохирогч "А" нар мэдүүлэг өгсөн, Аюулын зэргийн үнэлгээ "дунд" гарсан.

"Э" нь урьд нь 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдөр СХД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хамтран амьдрагч "О"-г зодсон гэх зөрчилд 40 цагийн албадан сургалтанд хамрагдаж, 30 хоногийн баривчлах шийтгэлээр шийтгүүлж байсан болох нь тогтоогдсон.

1.Дээрх тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн аль нь болохыг тодорхойлж, зүйлчлэлийг хийнэ үү?

2. Шалгавал зохих ажиллагаа тодорхойлно уу?

Мөн прокурор нь ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийг шалгах ажиллагааны явцад

хүчирхийлэлд хүүхэд өртсөн тохиолдолд дараах нөхцөл байдлыг тогтоосон эсэхэд хяналт тавина. Үүнд:

- Хүүхдэд тусламж шаардлагатай эсэхийг тогтоосон эсэх,
- Хүүхдэд цагдаагийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний талаар энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарлан, хүсэлтийг хүлээн авсан эсэх,
- Хэрэв хүүхэд өөрийн эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд аюулын зэрэг дунд болон өндөр, эсхүл дор дурьдсан нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчийн саналыг харгалзахгүйгээр хамгаалах боломжтой иргэн, гэр бүлд хүлээлгэн өгөх, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр, эсхүл асрамж, халамжийн үйлчилгээний байгууллагад хүргэх зэрэг хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлсэн эсэх,
- ГБХ үйлдэх гэмт хэргийн хохирогч байж болох нөхцөл тогтоогдвол тухайн нутаг дэвсгэрийн орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага, хүүхдийн эрхийн ажилтан, хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд мэдэгдсэн эсэх,
- ГБХ-д өртсөн хүүхдэд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхдээ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/39 дүгээр тушаалаар батлагдсан "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам"-ыг баримталсан эсэх.

ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчил нь цагдаагийн байгууллагад дуудлага өгснөөр, аль эсхүл сум, багийн Засаг дарга, хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагчид мэдэгдснээр төгсдөг, тухайн үед л гарсан ердийн тохиолдол биш гэдгийг анхаарах

Дараах асуумжийг мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан прокурор хохирогчтой харилцахдаа товч асуумж байдлаар авч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлоход ашиглах боломжтой гэж үзлээ. Ашиглаад үзээрэй.

№	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Асуулт
1.				Тэр түрэмгий, эсхүл аюултай болдог уу?
2.				Таныг эмнэлгийн тусламж авахад хүргэсэн бие махбодын бэртэл гэмтэл биед тань учруулж байсан уу?
3.				Таныг багалзуурдаж байсан тохиолдол байгаа юу?
4.				Тэр танд ер нь бие махбодын гэмтэл, эсхүл тэжээвэр амьтан алах гэх мэт хохирол учруулж байсан уу?
5.				Таныг ална гэж сүрдүүлж байсан уу?
6.				Бэлгийн дарамтад орж байсан уу?
7.				Зэвсэг хэрэглэж, эсхүл хэрэглэнэ гэж сүрдүүлж байсан уу? Хэрвээ тийм бол ямар зэвсэг вэ?
8.				Таныг мөшгөж байсан уу? Таны байгаа газрыг шалгаж, хардалтын эмгэг илэрч байсан уу?
9.				Таны эсрэг үйлдсэн хүчирхийллийн тоо өссөн үү?
10.				Амиа хорлоно гэж сүрдүүлж байсан уу? Түүний зүгээс амиа хорлох оролдлого хийж байсан уу?
11.				Жирэмсэн байхдаа хүчирхийлэлд өртөж байсан уу?
12.				Сүүлийн жилд түүнээс явж, эсхүл салах оролдлого хийж байсан уу?
13.				Та гаднаас тусламж авч байсан уу (цагдаа, хорогдох байр, г.м)?
14.				Тусламж авах боломжтой газруудаас тусгаарлагдсан гэсэн мэдрэмж төрдөг үү (машин, утас, гэр бүл, найз нөхөд, г.м)?
15.				Хүчирхийлэл үйлдэгч сүүлийн жилд стресс/сэтгэл санааны хямралд байсан уу? (ажилгүйдэл, ойр дотны хүний үхэл, санхүүгийн хямрал)?
16.				Хүчирхийлэл үйлдэгч нь архи хэрэглэдэг эсэх?
17.				Архи/мансуурах бодисын хамааралтай юу?
18.				Хүчирхийлэл үйлдэгч зэвсэг олох боломжтой юу?
19.				Тэр танд ноцтой хохирол учруулж чадна гэж та бодож байна уу?
20.				Та түүнийг хариуцлагаас хамгаалж байсан удаатай юу (цагдаагийн газраас гомдлоо татан авах, батлан даалтанд гаргах)?
21.				Тэр хүүхэд байхдаа харгислалд өртөж байсан уу?

22.				Хүчирхийлэл үйлдэгч нь түүний ээжийн эсрэг хүчирхийлэл үйлдэхэд гэрч байсан уу/харж байсан уу?
23.				Хүчирхийлэл хийснийхээ дараа тэр гэмшдэг үү?
24.				Хүчирхийлэлтэй холбоогүй гэмт хэрэг үйлддэг үү?
25.				Гэр бүлийн гишүүн хүмүүсийн эсрэг хүчирхийлэл үйлдэж байсан уу?
26.				Тэр мансууруулах бодис хэрэглэдэг үү?

- *ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах ажиллагаанд хохирогчийг мэдэрч, түүнд үзүүлэх тусламж, дэмжлэг бодитой байх ёстой гэдгийг прокурор ямагт санах.*

Дэд сэдэв 3. ГБХ үйлдэх зөрчилд зөрчлийн хэрэг нээх, шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт

ГБХ үйлдэх зөрчлийн талаарх дуудлага, мэдээллийн дагуу эрх бүхий албан тушаалтан хэргийн газарт очиж ажиллахдаа хохирогчийн биед илтэд гэмтэл учраагүй, хүнд хор уршиг учраагүй, хүний амь нас эрсдэлгүй тохиолдолд уг дуудлага мэдээллийг ГБХ үйлдэх зөрчлийн талаарх гомдол, мэдээллээр бүртгэн авч, улмаар Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтанд ордог.

Эрх бүхий албан тушаалтнаас ГБХ үйлдэх зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шалгаад Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, эсхүл зөрчлийн шинжтэй гэж үзвэл Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн холбогдох хэсгээр зөрчлийн хэрэг нээхээр прокурорын хяналтанд ирүүлнэ.

Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш хуулийн хэрэгжилтийн талаар хийсэн судалгаанаас үзвэл өргөдөл, гомдлыг шалгахдаа хуучин арга барилаар буюу хохирогч гомдлоо татсан, хаана байгаа нь олдоогүй гэх шалтгаанаар, эсхүл илэрхий гэмт хэргийн шинжтэй буюу гэмтлийн зэрэг тогтоогдсон атал, эсхүл тодорхой ажиллагааг гүйцэд хийлгүйгээр, эргэлзээтэй байж болох үндэслэлээр хаасан тохиолдол нийт судалсан 60 хэргийн 50 орчим хувийг эзэлж байжээ.[79]

Кейс : 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр ... дүүргийн 03 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах .. дугаар байрны .. тоотод оршин суух Ж.Б нь салсан эхнэр С-ийг согтуурсан үедээ хэл амаар доромжлон биед нь халдан зодсон талаарх гомдол, мэдээллийг хохирогч гаргасан. Аюулын зэргийн үнэлгээ хийгдээгүй, холбогдогчоос мэдүүлэг аваагүй. Хүчирхийлэл үйлдэгч нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан зөрчил гаргаж 4 удаа эрүүлжүүлэгдэж, 1 удаа 15 хоногоор баривчлагдаж байсан. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа дуусан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож хаасан ба тогтоолуудийн он сар засвартай байв.

Гэмт хэргийг эрт шатанд илрүүлэх мөрдөгчийн ур чадвар хангалтгүй, эсхүл хуучин үйлчилж байсан хуулийн хандлагаар "эвлэрсэн бол хааж болно" гэсэн итгэл үнэмшлийг өөрчилж, хэрэгт хяналт тавьж байгаа прокуророос гэр бүлийн хүчирхийллийн шинж агуулсан эсэхийг үргэлжлүүлэн шалгах, зарим ажиллагааг гүйцэд хийх талаар нэмж даалгавар өгөх шаардлагатай.

Прокурор нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн шинжийг агуулж байгаа эсэхийг дараах байдлаар хянана. Үүнд:

- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн дуудлагыг шалгах цагдаагийн ажилтан хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн эсэх. Гарын авлагын дуудлага шалгах цагдаагийн ажилтны үүрэг хэсгээс харна уу.
- Тухайн айл болон иргэний талаар өмнө нь цагдаагийн байгууллагад дуудлага өгч байсан эсэх, түүний шийдвэрлэлтийн

79 Гэр бүлийн хүчирхийллийг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал" судалгааны тайлан. Монголын криминологичдын холбоо. 2020 он. Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан материалд хийсэн судалгааны хавсралт хэсгээс

байдал зэргийг шалгаж тогтоосон эсэх.

- ГБХ үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээллийн хохирогч, гэрч нарыг тусгаарлан, хохирогч, гэрч нарт хамгаалуулах эрхтэй болохыг нь танилцуулж, хамгаалах байранд хандах, хамгаалуулах эсэхийг нь тодруулж, хамгаалуулах эрхээр нь хангасан эсэх;
- ГБХ-ийн орчны нөхцөл байдал, хүчирхийлэл үйлдэгдсэн байдал зэргийг нь шалгаж тогтоох, хэргийн газрын үзлэг хийсэн эсэх,
- ГБХ үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйлийг эд мөрийн баримтаар хураан авах, бэхжүүлэх хойшлуулашгүй ажиллагааг хийсэн эсэх.
- Хэргийн газарт хийсэн үзлэгээр гэмт хэрэг, зөрчлийн улмаас үүссэн ул мөрийг (цус, үс, шүлс, биологийн болон бусад) бэхжүүлэн авч, шинжилгээнд хүргүүлсэн эсэх,
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээчийн дүгнэлтээр гэмтлийн зэрэг тогтоогдсон эсэх,
- Монгол хэл, бичиг мэдэхгүй, хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчийг орчуулагч, хэлмэрч байлцуулж, эрхийг нь хангасан эсэх.
- Дүрс бичлэг, дуу хураагуураар болж байгаа үйл явдлыг давхар баримтжуулсан эсэх.
- Хохирогч тус бүрт Аюулын зэргийн үнэлгээг хийсэн эсэх, хэрвээ Аюулын зэргийн үнэлгээ "Өндөр" гарсан тохиолдолд хамтарсан багаар хэлэлцүүлж, нөхцөл байдлын үнэлгээ хийлгэх асуудлыг шуурхай шийдсэн эсэх,
- ГБХ–д хүүхэд өртсөн эсэхийг шалгасан эсэх, хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрсдэлийн үнэлгээг хийсэн эсэх,
- Хүүхдийг хамгаалах арга хэмжээг авсан эсэх,
- Хохирогч урьд нь ГБХ-ийн улмаас эмнэлэг, сэтгэл зүйн болон хууль зүйн тусламж авч байсан эсэхийг шалгасан эсэх;
- Хохирогчийн сэтгэцэд өөрчлөлт орсон эсэх, өөрчлөлт орсон бол хөдөлмөрийн чадварыг ямар хугацаагаар алдагдуулсан буюу энэ нь гэмтлийн ямар зэрэгт хамаарч байгааг шинжээчийн дүгнэлтээр тогтоолгосон эсэх;
- Насанд хүрээгүй, бага насны хүүхэд, өндөр настанд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоосон эсэх
- Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг эрхшээлдээ байлгахдаа хэрэглэдэг арга хэлбэрийг тогтоосон эсэх,
- Хүчирхийлэхдээ аюултай үйлдэл буюу хоолойг боох, амьсгалыг боогдуулах үйлдэл хийдэг эсэхийг тогтоосон эсэх,
- Ямар аргаар тарчлаах, зодох үйлдэл хийсэн, мөн дээрх үйлдлүүдийн цаг хугацааны давтамжийг нарийн тогтоосон эсэх,
- Хүчирхийлэл үйлдэгч согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, согтуудаа дарамталж, хүчирхийлэл үйлддэг эсэхийг тогтоосон эсэх,
- Урьд энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдэж байсан эсэх, хувийн байдлыг шалгасан эсэх,
- Хүчирхийлэл үйлдэгчийн дарамтаас болж хохирогч нь эсрэг үйлдэл үзүүлж, гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцөлийг тогтоосон эсэх,
- Нийлмэл гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, ойролцоо төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс ялгагдах онцлогийг тогтоосон эсэх,
- Гомдол, мэдээлэл хүлээн авсан албан хаагч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөрчил шалгах ажиллагааг явуулсан эсэх зэргийг хянаад материалд авагдсан баримтуудаар ГБХ үйлдэх зөрчил үйлдэгдсэн болох нь хангалттай тогтоогдсон гэж үзвэл зөрчлийн хэрэг нээж дугаар олгоно.

Прокурор дугаар олгохдоо дараах зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

а) Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4.1-т заасан шинжийг тогтоохдоо нэн тэргүүнд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн мөн эсэхийг тогтоосон эсэхийг үзэх, үл ялих зүйлээр шалтаглан, танхайн сэдэлтээр, тодорхой шалтаг, шалтгаангүйгээр гэр бүлийн

хүчирхийллийн шинжийг агуулж зодсон үйлдэл байгаа эсэхийг анхаарах.

Эхнэр, нөхөр, ах дүү, эцэг, эх, үр хүүхдийн хоорондох зүй ёсны харилцааны талаар нийгэмд тогтсон зан заншил, ёс суртахууны нийтлэг хэм хэмжээг бүдүүлгээр зөрчсөн хохирогчийн ёс бус үйлдэл, зан үйл, хэв шинж, зуршил зэргээс үүдэлтэйгээр гэнэт үүссэн, нэг удаагийн тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас зөрчил үйлдэгдсэн нь хэргийн материалд авагдсан баримтаар тогтоогдож байвал "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх" зөрчилд хамааруулж үзэхгүй, харин Зөрчлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйл буюу "Хүний эрүүл мэндэд хохирол учруулахгүйгээр халдаж зодсон" зөрчил гэж үзэхийг анхаарах нь чухал.

б) Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4.2-т заасан "хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан" гэх хэсгээр хэргийг зүйлчлэхдээ холбогдогч нь хохирогчийг яг ямар тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадаж байгааг тодорхой шалгаж тогтоосон эсэхийг анхаарч үзвэл зохино. Үүнд дараах үйлдлийг хамруулж үзэж болно (шөнийн цагаар хоол хийж өгөхийг албадах, шаардах, унтуулахгүй хөөж босгох, албадах үйлдлээ бодитоор үйлдсэн байх, мөнгө нэхэх, гэрээс хөөж гаргах, биелүүлэх боломжгүй зүйлийг шаардах гэх мэт)

в) Бусадтай харилцахыг хязгаарлах гэх хэсгээр хэргийг зүйлчлэхдээ хэрхэн, ямар байдлаар бусадтай харилцахыг нь хязгаарлаад байгааг тогтоосон эсэх. Үүнд: хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашиглаж бусадтай уулзах, ярилцах, холбоо мэдээллийн хэрэгслээр харилцахыг хориглох, холбоо, мэдээллийн хэрэгслийг гэмтээж эвдэх, авах, цахим сүлжээг салгах гэх мэт/

г) хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэх хэсгээр хэргийг зүйлчлэхдээ уг эд хөрөнгө нь хуваарьт болон дундын эзэмшлийн эд хөрөнгө болохыг хангалттай нотлон тогтоож, учирсан хохирлыг бодитой тогтоох зорилгоор эрх бүхий байгууллагаар үнэлгээ хийлгүүлж, бодит хохирлыг тогтоосон эсэх, мөн тухайн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхдээ хохирол учруулсан эсэхийг сайтар шалган тогтоосныг анхаарах. Зарим тохиолдолд уг асуудлыг шалгаж тогтоогоогүй нөхцөлд Зөрчлийн тухай хуулийн 8.8 дугаар зүйлд заасан "Эд хөрөнгө устгах, гэмтээх" зөрчил болохыг үгүйсгэхгүй.

Иймд прокурор гомдол, мэдээллийг хянаж шийдвэр гаргахдаа материалд Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хуульд заасан үндэслэл журмын дагуу бэхжүүлэгдэн авсан нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн дүүрэн шинжлэн судалж, хохирогч, холбогдогч болон хэрэгт авагдсан бусад гэрчийн мэдүүлгийг харьцуулан, зөрчлийн шинжийг хангаж байгаа эсэхэд дүгнэлт хийж, хэргийн зүйлчлэлийг зөв тогтоох шаардлагатай.

Аливаа зөрчлийн шинж байдлаас үл хамааран хохирогч эмэгтэй, ахмад настан, хүүхэд хэн боловч бие махбодын болон сэтгэл санааны хувьд ямар нэгэн байдлаар хохирол хүлээж байдгийг чухалчлан санаж, аль болох тэдний эсрэг үг, үйлдэл гаргахгүй, тэдний эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, хамгаалах талаар арга хэмжээг авах хэрэгтэй бөгөөд жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэж байгаа гэдгийг ямагт санах нь чухал юм.

- *Хэрэгт цугларсан нотлох баримтад бодитой дүгнэлт хийх.*

1. ГБХ үйлдэх зөрчлийн хэрэгт тавих прокурорын хяналтын онцлогийг тодорхойлно уу?
А).....
Б).....
В).....
Г).....

"М" нь Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороо, Орбитын 8-3 тоотод байх гэртээ 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ хамтран амьдрагч "Г"-тэй "амтгүй хоол хийлээ" гэх шалтгаанаар маргалдан, хэл амаар доромжилж, гараараа нүүр рүү 2-3 удаа цохиж,

Мөн 2020 оны 03 дугаар сарын 05-ны орой мөн л согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ "хаалга тайлж өгсөнгүй" гэх шалтгаанаар гаднаас монгол гэрийнхээ хаалгыг өшиглөн, эвдэн орж "Г"-ийн толгой руу нь гараараа 2 удаа, галын шилээвэр төмөр авч гуя руу нь 4 удаа цохиж, улмаар үснээс нь зулгаан чирж, гэрээсээ хөөж гарган хаалгаа түгжээд оруулахгүй байна" гэх гомдол цагдаагийн байгууллагад ирсэн.

Эрх бүхий албан тушаалтан гомдлыг хүлээн авч шалгаад ГБХ үйлдэх зөрчлийн шинжтэй гэж зөрчлийн хэрэг нээн, дугаар авахаар прокурорын хяналтанд ирүүлсэн байна.

1. *"М"-ийн үйлдэл нь Зөрчлийн тухай хуульд заасан ГБХ үйлдэх зөрчлийн аль шинжийг агуулж байгаа? Тохирох хэсгээр үйлчилнэ үү?*
2. *Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаагаар хийгдвэл зохих ажиллагаануудыг тодорхойлно уу?*

3.2.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЖ ЯЛЛАГДАГЧААР ТАТАХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН АЖЛЫН ОНЦЛОГ

Дэд сэдэв 1. ГБХ-ийн үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэх, яллагдагчаар татах ажиллагаа, гэмт хэргийн зүйлчлэл



ГБХ үйлдсэн гэж үзэж эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахдаа хууль хэрэглээний практикийг харгалзан үзэх, тухайн үйлдэл эс үйлдэхүйн Эрүүгийн хуульд заасан шинжийг хангалттай нотолж, яллаж чадах эсэхийг урьдчилан дүгнэх нь прокурорын анхаарах асуудал юм. Учир нь энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд хууль хэрэглээ, зүйлчлэлийн маргаан удаа дараа гарч байсан бөгөөд нотолгооны хувьд хэргийн үргэлжилсэн, удааширсан байдал, үйлдэл хоорондох давтамжийг хэрхэн үнэлэх зэргээс хамаарч зарим үйлдэл холбогдлыг шүүхээс цагаатгаж, зарим зүйлчлэл хэргийн нөхцөл байдалд бүрэн тохирсон гэж үзэж шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэж байна. Нөгөө талаар энэ төрлийн хэргийг шийдвэрлэх шүүхийн практик харьцангуй тогтсон гэж үзэж болох боловч мөрдөгчдөд энэ талаарх мэдээлэл дутмаг, хууль хэрэглээний хувьд өөрсдийн урьд олж авсан хууль эрх зүйн мэдлэгт тулгуурлан хэргийг зүйлчилж, шалгаж байгаа

тул прокуророос зөвтгөл хийж мөрдөн байцаалтыг эхнээс зөв чиглүүлэн ажиллах ёстой.

доорх хүснэгтэд гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэргийг харуулсан ба эдгээрийн заримыг давхар болон дангаар зүйлчлэх байдлаар эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналыг прокурорт хүргүүлдэг.

Гэмт хэргийн төрөл	Зүйл, хэсэг, заалт
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх
Хүн алах гэмт хэрэг	Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.8 дах хэсэг буюу гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүнийг алсан бол
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг	Эрүүгийн 11.6-ийн дугаар зүйлийн 2 дах хэсэг 8 /10.1-ийн 2.8 дах хэсэгт заасан аргаар үйлдсэн/
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах гэмт хэрэг	Эрүүгийн хуулийн 11.4-ийн дүгээр зүйлийн 2 дах хэсэг /10.1-ийн 2.8 дах хэсэгт заасан аргаар үйлдсэн/
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах	Эрүүгийн хуулийн 11.1-ийн дугаар зүйлийн 2 дах хэсэг /10.1-ийн 2.8 дах хэсэгт заасан аргаар үйлдсэн/
Хүчиндэх гэмт хэрэг	Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.3 дах хэсэг /гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх/ Мөн зүйлийн 3 дах хэсэг /гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай 16 насанд хүрээгүй хүнийг хүчиндэх/
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг	Эрүүгийн хуулийн 10.4 дүгээр зүйл. Эд хөрөнгө, албан тушаал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаа, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа хүнийг байнга хүчирхийлсэн, доромжилсон, зодсон, тамлан зовоосон, айлган сүрдүүлсний улмаас амиа хорлоход гарцаагүй хүргэсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч амиа хорлоход хүрсэн хэргийн жишээ:

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.2.7-ны 233 дугаар шийтгэх тогтоолоор хянан шийдвэрлэсэн Т.Э холбогдох хэрэг.

Т.Э нь амь хохирогч эхнэр С.Б эсрэг чиглэсэн, сэтгэл санааны дарамтыг удаан хугацаанд хэвшмэл шинжтэйгээр, их хэмжээгээр учруулж, бие махбодод нь зарим тохиолдолд халдаж гэмтэл учруулах зэргээр шаналгасан, түүнийг болон ойр дотных нь хүнийг ална, эрүүл мэндэд нь хохирол учруулна, өөрийнхөө амийг хорлоно гэх зэргээр заналхийлж, тамлан зовоож, айлган сүрдүүлсний улмаас хохирогч С.Б нь сэтгэл санааны дарамтад орж, амиа хорлосон.

Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах гэдэг нь мөрдөгчөөс гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэлд мөрдөн байцаалт явуулахаар ирүүлсэн саналыг үндэслэн гаргаж буй прокурорын шийдвэр юм. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол гарснаар мөрдөн байцаалтын ажиллагаа эхлэх ба ГБХ-ээс үүдэлтэй дээр дурьдсан тодорхой хэргүүдийг гомдол мэдээллийг шалгах 5-14 хоногийн хугацаанд болон хэрэг бүртгэлтийн нийт 30 хоногийн хугацаанд цугларсан нотлох баримтад тулгуурлан зүйлчлэл хийж, тогтоолдоо тусгадаг.

Прокуророос хэрэг бүртгэлтийн явцад цугларсан нотлох баримтыг үнэлж ГБХ-ийн шинжтэй үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах шийдвэрийг түргэн шуурхай гаргах нь тухайн хүчирхийллийн үйлдлийг шалгаж тогтоох, хохирогч, гэрчийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг асуудлыг шуурхай шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хэрэг бүртгэлтийн явцад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол үүсээгүй, тухайн хүн, хуулийн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх нөхцөл байдал тогтоогдсон, яллагдагчаар татах хүн, хуулийн этгээд хаана байгаа нь тодорхой бол мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналыг прокурорт хүргүүлнэ.



Яллагдагчаар татах хүн, хуулийн этгээд хаана байгаа нь тодорхой, хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй гэж үзвэл прокурор өөрийн санаачилгаар, эсхүл мөрдөгчийн саналаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэж, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодож ГБХ-г байнга буюу өөрөөр хэлбэл 3 буюу түүнээс дээш удаа үйлдсэн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх" гэсэн зүйл хэсгээр шалгаж, шийдвэрлэж байна. Монгол Улсын Дээд шүүхээс зөрчил гэмт хэргийг хооронд нь ялгах "байнга" гэсэн шинжийг "3 ба түүнээс дээш удаагийн давтамжтай гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл хамаарна" гэсэн практик тогтоосон[80].

80 УДШ-ийн 2020 оны 01 дүгэр сарын 08-ны өдрийн №25 тогтоол

Прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол гаргахдаа мөрдөгчөөс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх "байнга" гэсэн шинжийг хэрхэн нотолсныг дүгнэж дараах нөхцөл байдлыг анхаарч үзнэ. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дүгээр зүйлд заасан ГБХ-ийн шинжтэй үйлдлийг 3, эсхүл түүнээс дээш удаа үйлдсэнээс гадна тэдгээр үйлдлийн хооронд Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх 6 сарын хугацаа болон сүүлийн үйлдлээс хойш Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.1-д заасан 1 жилийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөөгүй бол "Гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдсэн" гэж үзэн эрүүгийн хэрэг үүсгэж,-яллагдагчаар татах. Өөрөөр хэлбэл ГБХ-ийн шинжтэй Эрүүгийн хуульд заасан бэлгийн, эдийн засгийн, бие махбодын , сэтгэл санааны хүчирхийллийн шинжтэй аль нэг болон ижил үйлдэл эс үйлдэхүйн хооронд хөөн хэлэлцэх хугацаа тасарсан эсэхийг анхаарах.
2. ГБХ-ийн шинжтэй үйлдэл эс үйлдэхүйн давтамж нь зөвхөн нэг хэлбэр байхыг шаардахгүй ба бэлгийн, эдийн засгийн, бие махбодын , сэтгэл санааны хүчирхийллийн шинжтэй үйлдэл эс үйлдэхүйн аль хэлбэр дангаар болон давхардан үйлдэгдсэн байж болно.
3. Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих" зөрчлийн бүрэлдэхүүний объектив талын үндсэн шинж нь "Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн"-ийг зодсон; хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; бусадтай харилцахыг хязгаарласан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэсэн 4 шинжийн аль нэг нь, эсхүл хэд хэд нь тогтоогдож байгаа тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр хуульчилжээ.

   Тэгвэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх" гэмт хэргийн объектив талын үндсэн шинж нь "Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн"-ийг байнга: зодсон; харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэсэн 3 шинжийн аль нэгийг, эсхүл хэд хэдэн шинжийг тус бүр байнга үйлдсэн байхыг шаардсан байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний байнга гэсэн шинжийг хангахад дээрх хоёр хуулийн ижил шинжүүдээс давтагдаж буй шинжүүдээр дүгнэлт хийх хүрээгээ тогтоож байх нь зөрчил ямар тохиолдолд гэмт хэрэгт шилжиж байгааг тодорхойлох хууль зүйн үндэслэл болно.
4. Зөрчлийн үйлдэлд хариуцлага хүлээсэн бол түүнээс хойш давтан үйлдсэн байдлыг мөн дээр дурьдсаны дагуу тогтоосон эсэх зэрэг болно. Иймд хүчирхийлэл үйлдэгчийн түүхийг судалж, үйлдэл хоорондын давтамжийг нотолсон эсэх нь эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол гаргахад чухал ач холбогдолтой.
5. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүсийн хооронд гарсан бие махбодын хүчирхийллийн шинжтэй үйлдэл болгон ГБХ-д хамаарахгүйг анхаарах. Тухайлбал, тодорхой тохиолдолд эр, эмийн хардлагаас үүссэн хувийн таарамжгүй харьцааны улмаас эхнэр, нөхрийн аль нэг нь нөгөөгийнхөө эрх чөлөөнд халдсан үйлдлийн сэдэлт, тухайн хэрэг гарахад хохирогчийн хувьд зохих буруутай үйлдэл нөлөөлсөн, өмнө нь хүчирхийллийн түүх байхгүй нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдож байвал энэ нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргийн үндсэн шинж болно.
6. Урьд нь зөрчлийн хэрэгт баривчлах шийтгэл хүлээснийг оролцуулан нийт 3 удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хэрэг үүсгэхэд нөлөөлөхгүй гэдгийг Double Jeopardy буюу нэг хэрэгт нэг удаа ял оногдуулах зарчимд үндэслэн УДШ-ээс тайлбарласныг анхаарах зэрэг болно.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолын бүтэц, агуулга, мөн чанарыг хуульд тусгайлан заасан нь аливаа гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа хүн, хуулийн

этгээдийг үндэслэл баримтгүйгээр хууль ёсны эрх ашиг, сонирхлыг нь зөрчигдөхөөс хамгаалах нөхцлийг бүрдүүлсэн гэдгийг анхаарч гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл тус бүрийг хэзээ, ямар байдлаар үйлдсэн гэдгийг тогтоолд тодорхой зааж болно.

Мөрдөн байцаалт явуулах эрх зүйн үндэслэл болсон эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэгдмэгц прокурор нь дараах ажиллагаа явуулахыг мөрдөгчид даалгана. Үүнд:

1. Сэжигтнийг прокурорын мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлэх;
2. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрлөөр баривчлах;
3. ЭХХШТ хуульд заасны дагуу хойшлуулшгүй тохиолдолд баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах.

ЭХХШТ хуульд "сэжигтэн" гэж энэ хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг ойлгоно гэж тодорхойлсон ба гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэж сэрдэгдэж байгаа хүн нь ихэвчлэн хэн болох нь тодорхой, тухайн үед газар дээрээ баригдсан эсхүл эрүүлжүүлэгдсэн байдаг онцлогтой.

Мөрдөгч дараах тохиолдолд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилж болно. Үүнд:

- гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь барьсан;
- ЭХХШТ хуульд заасан хойшлуулшгүй тохиолдолд;
- гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан;
- тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд гэмт хэргийн ул мөр илэрсэн.

Мөрдөгч сэжигтнийг баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор шийдвэрийг шүүхэд даруй хүргүүлж 24 цагийн дотор шүүх шийдвэрлэнэ. Мөрдөгч шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилснаас хойш прокурорт даруй хүргүүлнэ.

Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд мөрдөгчөөс саналын хамт хүргүүлж байгаа ГБХ- ийн талаарх гомдол, мэдээллийг шалгасан нотлох баримт, хойшлуулшгүй үндэслэлээр авсан ажиллагааны үр дүн бусад нотлох баримтын хамтаар хүргүүлдэг ба энэ гэмт хэргийн "байнга" гэсэн шинжийг бүрэн эсхүл анхдагч байдлаар нотлох баримтыг цуглуулж чадсан эсэхийг хянан үзэх шаардлагатай.

ЭХХШТ хуулийн 31.4 дүгээр зүйлд шүүхийн зөвшөөрлөөр баривчлах үндэслэлийг тодорхой зааж прокурор нь сэжигтнийг баривчлах саналыг шүүхэд гаргаж, баривчлах ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага баривчлан 48 цагийн хугацаагаар тусгаарлана. Үүнд:

- Хуульд заасан үндэслэл, журмын дагуу сэжигтнийг дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, эсхүл мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан бол;
- оргон зайлсан, эсхүл мэдэгдэх хуудсаар дуудахад оргон зайлах үндэслэл байгаа бол;
- мөрдөгч, прокурор, шүүгч, хохирогч, гэрч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнийг дарамтлах, сүрдүүлэх, амь нас, эрүүл мэндэд нь халдах үндэслэл байгаа бол;
- гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл байгаа, түүнчлэн дахин гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл байгаа бол;
- нотлох баримтыг устгах, өөрчлөх, хуурамчаар үйлдэх, эсхүл гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл илэрсэн бол.

Прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа сэжигтнийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж уг тогтоолыг танилцуулахыг мөрдөгчид даалгана. Тогтоол танилцуулахаар сэжигтнийг дуудан ирүүлэхдээ ЭХХШТ хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан журмыг баримталж мэдэгдэх хуудсыг гардуулан өгөх журмыг хэрэгжүүлж

ажиллах шаардлагатай ба энэ журмыг баримтлаагүйгээс цаашид таслан сэргийлэх арга хэмжээг хүчирхийлэл үйлдэгчид үр дүнтэй хэрэглэх боломж багасдаг гэдгийг мөрдөгчид ойлгуулвал зохино.

Хүндэтгэн үзэх шалтгаанаар ирэх боломжгүй тухайгаа мэдэгдэх хуудас хүлээн авсан сэжигтэн мөрдөгчид даруй мэдэгдэж, энэ тухай баримтаа ирүүлсэн бол яллагдагчаар татах тогтоол танилцуулах хугацааг прокурор 24 цаг хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

Харин эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудсан сэжигтэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан нь түүнийг шүүхийн зөвшөөрлөөр баривчлах үндэслэл болно. Шөнийн цагт тогтоол танилцуулахаар сэжигтнийг дуудан ирүүлэхийг хориглоно.

2.1 Сэжигтний эрх

Мөрдөгч баривчлагдсан сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэр танилцуулахаас өмнө, шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан бол баривчилсан даруй дараах эрхийг танилцуулна:

- ямар гэмт хэрэгт сэжиглэж байгаа;
- хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох;
- түүний хийсэн үйлдэл, хэлсэн үг өөрийнх нь эсрэг шүүхэд нотлох баримт болохыг анхааруулах;
- хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй бол холбогдох хуульд заасны дагуу албадлага хэрэглэхийг сануулах.

Шүүхийн зөвшөөрлөөр баривчлах тохиолдолд мөрдөгч дээрх эрхийг танилцуулсны дараа сэжигтэнд баривчлах тухай шүүхийн зөвшөөрөл, үндэслэлийг танилцуулна.

Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед, эсхүл баривчилсны дараа сэжигтний биед үзлэг хийж, дараах эд зүйлийг хураан авна:

- хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах эд зүйл;
- оргон зайлахад ашиглаж болох эд зүйл, баримт бичиг;
- гэмт хэрэг үйлдэж олж авсан, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан байж болзошгүй эд зүйл, баримт бичиг;
- хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой эд зүйл, баримт бичиг;
- хүн, хуулийн этгээд эзэмших, ашиглах, хадгалах, авч явахыг хуулиар хориглосон эд зүйл, баримт бичиг.

Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор түүний хувийн байдлыг тогтоох, мэдүүлэг авах ажиллагааг явуулна. Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор тухайн сэжигтнийг баривчилсан талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ. Мөрдөгч баривчлах ажиллагааны үед холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болох гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг баривчилсан нөхцөл байдлыг тухайн хэрэгт тодорхой тусгах шаардлагатай.

Сэжигтэн дараах эрхтэй. Үүнд:

- баривчилсан үндэслэлтэй танилцах;
- шүүхийн зөвшөөрөлгүй баривчилснаас бусад тохиолдолд баривчлах тухай, шүүхийн зөвшөөрөлтэй хуульд заасан хугацаанд танилцах, хуулбарыг авах;
- өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, өмгөөлөгч, гэр бүлийн гишүүнтэй холбогдох боломжоор хангагдах;
- баривчлах шийдвэр, ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах;
- өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;
- эмнэлгийн тусламж авах;
- хууль бусаар баривчилсны улмаас учирсан хохирлоо арилгуулахаар гомдол гаргах;
- хууль зөрчсөн эрх бүхий албан тушаалтан, мөрдөгч, прокурорын үйл ажиллагаанд гомдол гаргах.

Мөрдөгч сэжигтнийг баривчлахдаа тэмдэглэл үйлдэж бэхжүүлэхдээ дараах зүйлийг тусгана. Үүнд:

- баривчилсан мөрдөгчийн овог, нэр, албан тушаал;
- баривчлах ажиллагаа эхэлсэн огноо, газар;
- баривчлагдаж байгаа сэжигтэнд эрхийг

нь танилцуулсан цаг, минут;

- баривчлах газарт хүргэсэн цаг, минут;
- баривчлагдсан сэжигтний гаргасан санал хүсэлт, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн;
- сэжигтнийг баривчилсныг хаана, хэнд мэдэгдсэн тухай болон мэдэгдсэн цаг, минут.

Тэмдэглэлийг баривчлах ажиллагааны үед үйлдэх боломжгүй байсан бол тухайн ажиллагааг дуусгаанаас хойш нэн даруй нөхөн үйлдэнэ.

Дасгал 1.

Энэхүү дасгалаар ГБХ-ийн гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэх онцлогийг тодорхойлно.

Тохиолдол: Гэмтлийн эмнэлэгт шокийн байдалтай хүргэгдсэн Н ухаан орсон үедээ дараах байдлаар мэдүүлэг өгчээ.

Би өөрийн нөхөр Г-д зодуулж яаж эмнэлэгт ирснээ санахгүй байна. Надтай анх танилцаж үерхэж эхэлсэн цагаасаа зодож дарамталдаг, удаа дараа хэл амаар доромжлон айлган сүрүүлдэг байсан. 2004 оны 06 дугаар сарын 25-ны өдөр намайг 4 сартай жирэмсэн байхад зодож гэмтээснээс болж би цочролд орж, миний хоёр чих шуугин өвдөж сонсгол маань муудсан. Салаад эргэж нийлснээс хойш энэ байдал давтагдаж 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдөр намайг гэртээ ирэхэд гараараа миний мөр болон нуруу хэсэг рүү цохиж зодсон. 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр намайг гэртээ байхад дахин мөр, гар, гуя, хавирга зэрэг газар руу гараараа удаа дараа цохиж, зодож, өргөж аваад байрны паар, ор, буйдан шал зэрэг газрууд руу шидэж байсан. 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс 02-нд шилжих шөнө үүрийн 04 цаг хүртэл сөхөр гэзэг гараас зуураад, үснээс зулгааж, айлгаж хэл амаар дорожилж байсан. 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14 цагаас 16 цагийн хооронд миний мөр рүү гараараа цохиж, зүүн хавирга, бөөр, хэвлий хэсэг рүү хуванцар нарийн хоолойгоор цохиж, хувцас хатаагчны төмрөөр толгой болон дух хэсэг рүү цохисон. Заримдаа ажлаа тараад гэр рүүгээ явж байхад утсаар яриад яагаад алга болчихоо вэ, автобуснаасаа буугаад гүйгээд яв гэж дарамталдаг байсан. Би Г-г орилж, доромжлох болгонд нь айж гар чичирдэг байсан. Хүүхдүүддээ хэдүүлээ ааваасаа тусдаа амьдарья гэхэд хүүхдүүд маань аав хаана байгаа газар маань олоод ирнэ шүү дээ гэзэг байдаг байсан. Мөн миний гар утсыг ус буцалгагчинд хийгээд буцалгаж байсан. Эхлээд дандаа түлхэх маягтай гар хүрдэг байсан бол тэр нь даамжирсаар байгаад сүүлдээ цохиж, зоддог болсон. Би маш их гомдолтой байна. Энэ хүнийг дахин надтай уулзуулахгүй байх арга хэмжээ авч өгнө үү.

- *Дээрх мэдээллийг үндэслэн нэн даруй ямар, ямар ажиллагаа явуулах вэ?*
- *Ингэхдээ ямар асуудалд онцгойлон анхаарах вэ? Яагаад?*

Баримт дээр ажиллахад анхаарах зүйл:

- Мэдээллийн дагуу нэн даруй эрүүгийн хэрэг үүсгэн, хохирогчийн амь нас, эрүүл мэндийн байдалд учрах эрсдэлийг үнэлж, хэрвээ хохирогчийн амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хохирогчийн мэдүүлгийг яаралтай бэхжүүлж (дуу, дүрс бичлэг, тэмдэглэл зэргээр) авна.
- Хэргийн зүйлчлэлийг зөв сонгоход анхаарна. Хэргийн зүйлчлэлийн асуудал нь тухайн гэмт хэргийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны чиглэл, цар хүрээг тодорхойлдог.
- Нэн даруй эрүүгийн хэрэг үүсгэснээр гэмт хэргийн улмаас хохирсон хүнийг хохирогчоор тогтоон байцаах, мөн хэргийн талаар мэдэх хүнээс гэрчийн мэдүүлэг авч, тухайн болж өнгөрсөн үйл явдлын талаар тодорхой төсөөлөлтэй болох, илүү бодитой мэдээллийг шуурхай авах боломжтой.
- Хэргийн зүйлчлэлийг зөв сонгох нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээний ямар төрлийг сонгон хэрэглэх асуудлыг шийдвэрлэхэд чухал ач

холбогдолтой.

- Хэргийн нөхцөл байдлыг баталсан, эсвэл үгүйсгэсэн, хуульд заасан журмын дагуу цуглуулж бэхжүүлж авсан нотлох баримт л нотлох баримт болдог гэдэгт анхаарах хэрэгтэй.
- ГБХ нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн гэсэн шинжүүдээр илэрдэг бөгөөд тухайн хүчирхийлэл ямар шинжээр илэрч байгаад анхаарлаа хандуулах нь чухал.

ГБХ-ийн гэмт үйлдэлд прокуророос эрүүгийн хэрэг үүсгэхдээ дараах нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд:

- хүчирхийллийн түвшин,
- учруулсан хохирол, хор уршиг,
- хүчирхийлэгчийн хүчирхийлэл үйлдсэн арга хэлбэр.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хэрэг үүсгэхдээ тухайн ГБХ-ийн гэмт үйлдэлд тохирсон зүйлчлэлийг сонгох нь чухал. Ингэснээр цаашид хохирогч, гэрчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээний төрлийг сонгох, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны чиглэлийг тодорхойлох зэрэгт ач холбогдолтой юм.

-Хохирогч болон түүний гэр бүлийн гишүүд, найз нөхөд, хамт ажилладаг хүмүүс, хөршийнхнөөс мэдээлэл ирэх.

-Хохирогч үйлдэгдсэн гэмт хэргийн талаар мэдээлэх нь цөөн байдаг. ГБХ-тэй холбоотой гэмт хэргийн 70 гаруй хувь нь хохирогчийн гомдлоор бус үүссэн байдаг. Хохирогч зодуулсны улмаас хүнд гэмтэл авсан байхдаа ч энэ талаар нуух тохиолдол байдаг.

-Эмнэлгийн байгууллагад хандсан мэдээлэл, баримт

-ГБХ-ийн явцад хохирогч гэмтэл авч, эмнэлгийн байгууллагад хандсан байж болно. Гэмт хэргийн улмаас гэмтэл авсан байж болох шинж тэмдэгтэй үйлчлүүлэгч ирсэн тохиолдолд эмнэлгийн байгууллагын ажилтан хуулийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

-ГБХ-тэй тэмцэх байгууллага болон хүүхдийн, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах байгууллагууд, хүчирхийллийн хохирогчид тусламж дэмжлэг үзүүлсэн болон хамгаалах байраар үйлчилсэн төрийн болон иргэний нийгмийн байгууллагаас мэдээлэл ирэх.

-Дээр нэр дурьдсан байгууллагуудаас ГБХ-ийн гэмт үйлдлийн шинжтэй нөхцөл байдлыг мэдээлж байх талаар тухайн байгууллагуудад мэдээлэл өгч, хамтран ажиллах шаардлагатай.

-Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах үед ГБХ-тэй холбоотой гэмт хэргийн шинж тэмдгийг илрүүлэх.

-Насанд хүрсэн хүмүүс гэмт хэрэгт уруу татсан эсэх, эцэг, эх, ах дүү нь байнга архи ууж зодож тарчлаадаг, хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийлгэсэн байж болно.

-Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад ГБХ-тэй холбоотой гэмт хэргийн шинж тогтоогдвол эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах шийдвэрийг гаргахдаа цаг хугацаа алдахгүй байх

-Хүчирхийлэгч байнга хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд цагдаагийн албан хаагчийн бүрдүүлсэн материалыг үндэслэн эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах шийдвэрийг гаргах нь тухайн үйлдэл даамжирч, ноцтой хохирол учрахаас урьдчилан сэргийлэх нэг арга зам байж болох талтай.

ДЭД СЭДЭВ 2. ГБХ-ийн гэмт хэргийн нотлох баримтыг шалгаж, үнэлэх ажиллагааны онцлог

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал нь эрүүгийн хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааны олон төрлийн арга барилыг нэвтрүүлэхэд чиглэсэн бөгөөд прокурор, мөрдөгчөөс эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, тактик, арга барил зэрэг нэр томьёог илүүтэй хэрэглэх нь зүйтэй. Мөрдөн байцаалт эхэлснээс хойш ГБХ-ийн хохирогч, гэрч мэдүүлгээсээ буцах, мэдүүлгээ өөрчлөх зэрэг хүндрэлүүд гардаг. Энэ нь хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаанд саад учруулж, эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилготой байдаг хүчирхийлэгчийн идэвхтэй оролдлого байдаг тул прокуророос мөрдөгч бие даан хийх мөрдөн шалгах ажиллагааг чиглүүлэх, прокурорын зөвшөөрөлтэй хийгдэх мөрдөн шалгах ажиллагааг зөвшөөрөл өгөх үедээ хянах болон хойшлуулашгүй хийгдсэн ажиллагааг хүчинтэйд тооцох үедээ цаашид хийх ажиллагаа, нотлох баримтыг нэмж цуглуулах боломж, бусад зүйлийн талаар мөрдөгчтэй ярилцаж, арга замыг эрэлхийлэх нь зүйтэй.

> Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг нотлоход шинжээч томилсон тогтоолыг холбогдогч болон шинжээч эмчид танилцуулж гарын үсэг зуруулаагүйгээс нотолгооны чадвараа алдах, шаардлагатай гэрчүүдийг бүрэн асуухгүй байх, дуудлагаар очсон боловч хэргийн газрын үзлэг хийж болсон асуудлыг бэхжүүлдэггүй, хохирогчийн биед үзлэг хийж гэмтэл, бэртлийн талаарх зургийг авдаггүй зэрэг нийтлэг алдаа гардаг. Мөрдөгч, прокуророос энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа ойлголцож ажиллах шаардлагатай ба тодорхой ямар үйл баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд хэрхэн бэхжүүлж авснаар тухайн хэргийг үр дүнтэй шийдвэрлэх вэ гэдгийг тодорхойлно.

Мөрдөн байцаалт эхлэх үед ГБХ-ийн шинжтэй үйл явдал болоод өнгөрсөн байдаг тул түүнийг судлан шинжилж, танин мэдсэнээр өнгөрсөн үйл явдлыг сэргээн тогтооход мөрдөн шалгах ажиллагаа бүхэлдээ чиглэгдэнэ. ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийг шалгахдаа тухайн үйлдэгдсэн гэмт хэргийн онцлог, мэдээллийг хүлээн авсан цаг хугацаа, хэргийг шалгаж эхлэх үеийн нөхцөл байдал зэргийг харгалзан мөрдөн шалгах ажиллагааны тактикийг тодорхойлно.

ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн онцлог нь гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхой байдгаас мөрдөн шалгах ажиллагааны зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн мэдүүлэг бодит байдалтай тохирч байгаа эсэх, тухайн гэр бүлийн харилцааны түүх, өөрөөр хэлбэл, тухайн гэр бүлд өмнө нь ГБХ-ийн хэлбэрүүд гарч, үйлдэгдэж байсан эсэх, давтамж, гэмт хэргийн сэдэлт, гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан, нөхцөлийг тогтооход чиглэгдэнэ.

Энэ төрлийн гэмт хэргийг гэрчлэх хүн нь хохирогч өөрөө байдаг тул мөрдөн шалгах ажиллагаа хохирогчоос мэдүүлэг авахаас эхлэх нь үр дүнтэй. Үйлдэгдсэн гэмт хэрэг нь нэг удаагийн үйлдэл биш, хэд хэдэн бие даасан үйлдлийг шалгах шаардлагатай байдаг тул хэрэгт цугларсан материалыг дүгнэн үзэх нь дараах ач холбогдолтой:

- Цугларсан мэдээлэл, баримтын аль нь нотлох баримт болох,
- Эд мөрийн баримтаар үйл явдлын аль хэсэг тогтоогдож болох,
- Гэмт хэргийн буюу гэмт үйлдлийн аль хэсгийг гүйцээж нотлох,
- Нотлох баримтыг ашиглан шинээр ямар нотлох баримт гаргаж болох,
- Маргаантай асуудлыг хэдийд, яаж шийдвэрлэх зэргийг тодорхойлж, тодорхой төлөвлөгөө боловсруулан шалгах хэрэгтэй.
- Зөвхөн зодохоос гадна бусад хүчирхийллийн шинжтэй тухайлбал эдийн засгийн, сэтгэл санааны хүчирхийллийн хэлбэрүүд байсан эсэхэд анхаарах

ГБХ-тэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах явцдаа (мөрдөн шалгах ажиллагаандаа мөрдөн байцаах нь орох) нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлж, үнэлэхэд дараах зүйлийг анхаарна. Үүнд:

1. Прокурорын зөвшөөрөлтэй хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа нь

а. Прокурорын зөвшөөрөлтэй хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа;

б. хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа гэсэн хэлбэртэй байх тул аль аль тохиолдолд зөвшөөрөл олгох, тогтоол үйлдэх, хүчинтэйд тооцохдоо ГБХ-д хамаарах ямар үйлдэл, давтамж, тогтоож болох боломжит хугацаа тухайн мөрдөн шалгах ажиллагаа нь хүчирхийллийн шинжтэй үйлдлийг шууд болон шууд бусаар хэрхэн нотлож, шалтгаант холбоо, үр дагаврыг хэрхэн тодруулж байгааг урьдчилан үнэлэлт өгөх хэрэгтэй.



Прокурорын зөвшөөрөлтэй хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа нь дараах төрөлтэй:

- үзлэгийг нуцаар хийх;
- нэгжлэг хийх;
- эд зүйл, баримт бичиг хураан авах;
- хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох;
- харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч хяналт тогтоох;
- харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах;
- хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах;
- оршуулсан цогцсыг гарган шинжлэх;
- мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах;
- хяналттай хүргэлт;
- хяналтын худалдан авалт;
- мөрдөн шалгах нууц туршилт;
- нууц ажиглалт;
- таньж олуулах ажиллагааг нуцаар хийх.

2. Мөрдөгч бие даан явуулах мөрдөн шалгах ажиллагаатай танилцах эсхүл тодорхой хэргийг татаж хянаж даалгавар бичих явцдаа дээрх ажиллагааны үр дүн, нотлогдвол зохих байдал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой журмыг зөрчсөн эсэх, албан бичгийн техникийн шаардлага хангасан эсэх, оролцогчдод танилцуулсан эсэх зэргийг харгалзан үзнэ. Ихэнх тохиолдолд мөрдөгчөөс мөрдөн шалгах ажиллагаа явуулж хэргийг нотлохдоо хийх шаардлагагүй буюу илэрхий нотлогдсон үйл баримтыг дахин нотлох зорилгоор мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.

Прокурор нь хууль зүйн ямар үйл баримт, фактыг үндэслэж, ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг хэрхэн нотолсноор тухайн яллагдагчийг цаашид шүүхийн шатанд яллах боломжтой талаар мөрдөгчдөд ойлгуулаагүйгээс хэргийн шийдвэрлэлтэд саад учруулсан эсхүл шаардлагагүй мөрдөн шалгах ажиллагаа хийлгэсэн гэх мэт харилцан адилгүй сөрөг уур амьсгал үүсдэг гэдгийг мэдэж байх ёстой.

Зарим мөрдөн шалгах ажиллагаа явуулахад прокуророос анхаарах зүйл:

Үзлэг гэдэг нь гэмт хэргийн ул мөр, эд мөрийн баримтыг олох, гэмт хэрэг гарсан байдал

ба гэмт хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тодруулах зорилгоор хэрэг учрал болсон газар, тодорхой газар орон, орон байр, эд зүйл, бичиг баримт зэргийг судлан үзэж байгаа мөрдөн шалгах бие даасан ажиллагаа мөн. Үзлэг нь нотлох баримт цуглуулах үндсэн арга болдог. Иймд үзлэгийг явуулахдаа иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай эсвэл тэдний нэр төрийг гутаасан ажиллагаа явуулах, хүнлэг бус хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, тайлбар дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж болохгүй.

1. гэмт хэрэг гарсан байдал (гэмт хэргийг хэдийд, хаана, хэрхэн яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг тодорхойлох бусад байдал);
2. гэмт хэргийг хэн үйлдсэн байж болох таамаг, үндэслэл бүхий сэжиг;
3. гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэрийг нотлох нөхцөл байдал;
4. гэмт хэргийн ул мөр, түүний байж болзошгүй нөхцөл байдал;
5. гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;
6. гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөл, түүнд хамаарах үйл баримт бүхий нөхцөл байдал;

Сэжигтнийг баривчлах, нэгжлэг хийх, эд зүйл хураан авах, хөрөнгө битүүмжлэх, туршилт явуулах зэрэг ажиллагааны хүрээнд эдгээр аль нэг ажиллагааны тодорхой хэсэг болгож үзлэгийг явуулж болно.

Үзлэгийн төрөл. Ямар объектод явуулж байгаагаар нь үзлэгийг:

1. Хэргийн газрын үзлэг
2. Тодорхой орон байранд хийх үзлэг
3. Орон байранд хийх үзлэг
4. Эд зүйлд хийх үзлэг
5. Бичиг баримтад хийх үзлэг
6. Шуудан цахилгаанаар явуулсан зүйлд хийх үзлэг
7. Хүүрэнд хийх үзлэг
8. Хүний биед хийх үзлэг гэж ангилдаг.

Хэргийн газрын үзлэг.

Мөрдөгч үйлдэгдсэн гэмт хэргийн талаар мэдээлэл авмагц хэргийн газрын үзлэг явуулж, шаардлагатай мэдээлэл, нотлох баримтыг цуглуулна. Гэмт хэргийг түргэн хугацаанд үнэн зөв, тал бүрээс нь мөрдөн шийдвэрлэх ажлын эцсийн үр дүн нь хэргийн газрын анхны үзлэгийн чанараас ихээхэн шалтгаалдаг.

Үзлэгийн явцад мөрдөгч нөхцөл байдлыг судалж, гэмт хэрэг үйлдэгдсэн газарт эмх замбараагүй байдал (сав суулга, сандал, ширээ унасан, хагарсан, хугарсан байх, эд зүйлийг урсан, эмх цэгцгүй хаясан байх), биологийн гаралтай ул мөр, цус, бөөлжис, үрийн шингэн, үс, гэмт хэрэг үйлдсэн зэвсэг, хэрэгсэл, бичил мөр (хувцасны тасархай утас г.м), хохирогчийн хувцсанд гэмтэл учирсан байх (урагдсан, зүсэгдсэн, ханзарсан), хохирогчийн биед хүч хэрэглэсний ул мөр (улайсан, хөхөрсөн, хавдсан, зулгарсан, цус гарсан, хугарсан, маажсан, боосон г.м), тэмцэлдсэн ул мөр, биед гэмтэл учруулсан зэвсэг, хэрэгсэл зэрэг байдлыг илрүүлж болно.

ГБХ-тэй гэмт хэргийн хэргийн газрын үзлэг нь дараах зорилгыг агуулдаг. Үүнд:

- Хохирогчид яаралтай туслалцаа, дэмжлэг үзүүлэх,
- Гэр бүлийн амьдралын хэв маягийг тодорхойлох,
- Гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг судлах,
- Хэрэгт ач холбогдол бүхий ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, хураан авах,
- Хохирогчийг хамгаалах хэлбэрийг сонгох,
- Эрсдэлтэй байдлыг тодорхойлж, хүчирхийлэгчийг тусгаарлах арга хэмжээ авах эсэх асуудлыг шийдвэрлэх.

Энэ төрлийн хэрэгт хэргийн газарт бүхэлд нь үзлэг хийх нь илүү үр дүнтэй байдаг. Тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан үзлэг явуулах аргыг зөв тодорхойлох нь чухал юм. ГБХ үйлдэх үеийн нөхцөл байдал, тухайн орчинд эвдэрч сүйдсэн, эд хөрөнгө устгах гэмтээсэн байдал, хохирогчийн бие эрхтэнд учирсан гэмтлийн улмаас гарсан цус бусад

зүйл, үргэлжилсэн явц гэх мэт нөхцлийг үзлэгээр тогтоож чадсан эсэх, үзлэгийн явцад илрүүлсэн эд мөрийн баримт, бусад шинжилгээнд хүргүүлсэн эд зүйл гэх мэт нэмэлт нотлох баримтыг хэрхэн бэхжүүлсэн зэргийг прокурор хянан үзсэнээр шүүхийн шатанд нотлох баримтыг шинжлэн судлах, тодорхой бичлэг гэрэл зураг үзүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн үйлдсэн гэмт хэргийн нөхцлийг тодорхой харуулахад ач холбогдолтой гэдгийг анхаарна.

Хохирогч, гэрч, яллагдагчаас мэдүүлэг авах явцад өөр хоорондоо зөрүүтэй, бодитой бус мэдээлэл цугларах боломжтой. Харин хэргийн газрын үзлэгийн үед багахан хугацааны дотор үнэтэй мэдээллийг тэмдэглэл, гэрэл зураг, видео бичлэг ашиглан бэхжүүлж авч болно. Видео бичлэг нь гэмт хэрэг гарсан нөхцөл байдал, хохирогч тухайн үед ямархуу байдалтай байсан зэргийг бэхжүүлж үлдээх чухал нотлох баримт бөгөөд мөрдөн байцаалтын үед болон шүүх хуралд нөхцөл байдлыг сэргээн харуулах бололцоог олгодог.

Үзлэгийг хийхдээ тухайн орчинд байгаа болон үзлэг хийлгүүлж байгаа хүний үйлдэл, хөдөлгөөн, орчныг анхааралтай ажиглаж хяналтандаа байлгана. Хоёр ба түүнээс дээш мөрдөгч, алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд үзлэгийг нэг нь явуулж, бусад нь үзлэг хийж байгаа алба хаагчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. Үзлэг хийх явцад гэмт хэргийн ул мөр, хэрэгт ач холбогдол бүхий бусад мэдээллийг агуулсан эд зүйл, хутга мэс, галт зэвсэг, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, бусад зүйлс байгаа тухай мэдээлэл, илэрхий шинж тэмдэг бий болсон тохиолдолд явц, үр дүнг бэхжүүлнэ. Энэ тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24.1, 24.2 дугаар зүйлд заасан ажиллагааг явуулна.

Үзлэгийн явцад мөрдөгч болон бусад хүний эрүүл мэнд, амь насанд аюул учрах нөхцөл байдал илэрвэл үзлэгийг зогсоож, энэ талаар тэмдэглэлд тусгана. Үзлэгийг зогсоосон үндэслэл арилбал үзлэгийг дахин, эсхүл үргэлжлүүлэн хийж болно. Мөн тухайн хүчирхийлэл үйлдэгдсэн орчны гаднах болон доторх нөхцөл байдлыг харуулсан камерын бичлэгийг шүүж үзэж болно. ГБХ үйлдэгдсэн орчинд орохоос өмнө хэрэлдэж маргалдаж байгаа, хохирогчийг цохиж, зодож байгаа нь бичлэгт үлдсэн байж болно. Камерын бичлэгийг цаг тухайд нь бэхжүүлж авах, хэрэв устсан бол холбогдох мэргэжилтнийг оролцуулан сэргээх бололцоотой байдаг.

Хэргийн газрын үзлэгийн явцад криминалистикийн техник ашиглаж, нотлох баримтыг цаг алдалгүй илрүүлж, зөв бэхжүүлж авах, зөв хадгалах нь чухал. Хэргийн газрын үзлэгийг аль болох шуурхай явуулах шаардлагатай. Практикт гардаг түгээмэл бэрхшээл бол хэргийн газрын үзлэгийг нөхөн хийх боломжгүй, үзлэгийн явцад бусад сэтгэл зүйч, мэргэжилтэн, шүүх шинжээч эмчийг оролцуулахгүй хийдэг явдал.

Прокуророос мөрдөгч хэргийн газрын үзлэг хийхдээ үзлэгийн явц, үр дүнг тэмдэглэлээр бэхжүүлэхийн зэрэгцээ дуу дүрсний бичлэг хийх, тухайн үйл явцыг тухайн үед нь буюу авах аль болох хойшлуулахгүйгээр явуулж, үзлэгээр илрүүлж, бэхжүүлж авсан ул мөр, эд мөрийн баримтын нотлох баримтын ач холбогдолтой эсэхийг хянан үзнэ. Хэргийн газрын үзлэг нь илэрсэн ул мөр, тэдгээрийг цаашид ямар мөрдөн шалгах ажиллагаагаар нотлох тактикийг боловсруулах, яллах дүгнэлт үйлдэхэд нотлох баримтын жагсаалт болгож хавсаргах зэрэг ач холбогдолтой.

Хүний биед үзлэг хийх

Хүний биед хэргийн ул мөр, онцлог шинж тэмдэг байгаа, эсхүл хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичгийг тухайн хүн биедээ авч яваа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа бол түүнийг илрүүлэх зорилгоор хүний биед үзлэг хийнэ. Үзлэг хийх хүн нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч байж болно. Хүний биед үзлэг хийхэд өмссөн хувцас, биедээ авч яваа эд зүйл, шаардлагатай бол тээврийн хэрэгсэл, уналгыг хамтад нь үзнэ. Нүцгэлж, эсхүл гараар тэмтрэх байдлаар хийх үзлэгийг ижил хүйсийн албан тушаалтан хийнэ. Шаардлагатай бол хүний эмч, сувилагчийг оролцуулж болно. Түүнчлэн хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нэр төр, алдар хүнд, хувь хүний нууцыг хамгаалах шаардлага хангасан, бусдаас тусгаарлагдсан орчинд явуулахаар хуульчилсан.

Гэмт хэргийн ул мөр гэдэг нь тухайн гэмт

үйлдлийн улмаас бий болсон шарх, сорви, эсвэл үүссэн—гэмтэл (түлэнхий, хазсан, маажсан мөр) цус, өтгөн шингэний үлдэц, бусад зүйл юм. Харин биед байгаа онцлог тэмдэг мэнгэ, эрхтэн дутуу байдал, биеийн гаж хөгжил шивээс, сорви, хагалгааны онцлог мөр зэргийг багтааж ойлгож болно.

ГБХ-ийн гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан гэмтэл нь богино хугацаанд арилж үгүй болох улайлт, хөхрөлт, боомилолт үүссэн байдаг. Тиймээс эдгээр ул мөрийг илрүүлэх, бэхжүүлэн авахын тулд хохирогчийн биед үзлэг хийх зайлшгүй шаардлагатай. Хүний биед үзлэг хийх нь хүчирхийллийн улмаас хохирогчийн биед хүч хэрэглэсэн эсэх болон гэмтэл учирсан эсэхийг тогтоох, нөгөө талаас шүүх эмнэлгийн шинжилгээ хийлгэх үндэслэлийг тодорхойлох урьдчилсан нөхцөл болдог.

ГБХ-ийн шинжтэй гэмт хэргийг шалгах явцад хүний биед үзлэг хийх нь тухайн хэрэгт ач холбогдол бүхий баримтыг илрүүлж тогтоох ач холбогдолтой. Тухайлбал, хохирогчийн биед үзлэг хийснээр урьд нь учирсан гэмтлийн улмаас үлдсэн сорви, шархыг илрүүлэн, тухайн хүчирхийлэл нэг удаагийн үйлдэл биш гэдгийг тогтоох боломжийг бүрдүүлнэ. Хохирогч нь эмэгтэй хүн байгаа тохиолдолд бие махбодын онцлогоос шалтгаалан ул мөр илүү их байх магадлал өндөр байдаг.

Харин хүчирхийлэл үйлдэгчийн биед үзлэг хийснээр хохирогчийн биеэ хамгаалж тэмцэлдсэний ул мөрийг илрүүлэх боломжтой юм. Тийм учраас үзлэг хийж байгаа мөрдөгч нь үзлэг хийж байгаа хүний бие дээрх шарх, сорвийг шинэ, хуучин гэж ялгалгүйгээр биеийн аль хэсэгт байгаа, хоорондын зай, хэмжээ, хэлбэр, тоо, ширхэг, шинжийг тэмдэглэлд нэг бүрчлэн тодорхой тусгаж, боломжтой бол гэрэл зургаар бэхжүүлж авах шаардлагатай.

Шинжээч томилж, дүгнэлт гаргуулахад анхаарах асуудал

Аливаа эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх (хянан шийдвэрлэх дотроо мөрдөн шалгах ажиллагаа орно) явцад эрх зүйн мэдлэгээс гадна тусгай мэдлэгийн салбарын онол, арга зүйд тулгуурлах шаардлага гардаг. Энэ үүднээс хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор тусгай мэдлэгийн салбарын туслалцааг шинжилгээ хийлгэх тухай шийдвэр гаргах замаар гүйцэлдүүлдэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан дараах тохиолдолд заавал шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулна:

1. гадны нөлөөтэй, эсхүл сэжигтэй, тодорхойгүй байдлаар хүн нас барсан, цогцос, түүний эд эрхтэн олдсон, хүч хэрэглэж амь насыг нь хохироосон байж болзошгүйг гэрчлэх ул мөр, баримт илэрвэл үхлийн шалтгааныг тогтоолгохоор;
2. гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэнд, бие махбодид гэмтэл учирсан тохиолдолд хохирлын шинж байдал, гэмтлийн зэрэг, эрүүл мэнд болон хөдөлмөрийн чадварт хэрхэн нөлөөлж буйг тогтоолгохоор;
3. сэжигтэн, яллагдагчийн өөрийнх нь мэдүүлэг, үйлдсэн гэмт үйлдлийн байдлаас сэтгэцийн хувьд эрүүл эсэхэд эргэлзээ төрвөл сэтгэцийн байдлыг тогтоолгохоор;
4. гэрч, хохирогч нь хэрэгт ач холбогдолтой нөхцөл байдлыг бодитойгоор үнэн зөв мэдүүлэх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл сэтгэцийн байдлыг тогтоолгохоор;
5. Эрүүгийн хуулийн тусгай ангид бүх насаар нь хорих ял оногдуулж болох гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүний сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадвартай эсэх, сэтгэцийн эмгэг, сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай эсэхийг тогтоолгохоор;
6. сэжигтэн, яллагдагч, хохирогчийн насны байдлыг баталсан төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх зэрэг баримт байхгүй, насыг тогтоох нь хэрэгт ач холбогдолтой, зайлшгүй шаардлагатай байвал насны байдлыг тогтоолгохоор;

Шинжээч томилсон шийдвэрт шинжилгээ хийлгэх үндэслэл, төрөл, шинжилгээний байгууллагын нэр, шинжээчид тавих асуулт, шинжилгээ хийж дүгнэлт гаргах хугацаа, шинжээчийн мэдэлд шилжүүлэн өгсөн эд зүйл, хэв загвар, дээжийн талаарх мэдээллийг тусгана. Мөрдөгч нь шинжилгээ хийлгэх тухай шийдвэрийг шинжилгээний байгууллагад хүргүүлэхээс өмнө эрүүгийн

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдод даруй танилцуулж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхийг тайлбарлаж өгнө.

Оролцогчоос шинжээч томилсон шийдвэртэй танилцаад, хүсэлт гаргасан тохиолдолд шинжээч томилсон тогтоолыг шинжилгээний байгууллагад хүргүүлэхээс өмнө хүсэлтийг шалгаж бүрэн, хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргаж, оролцогчид танилцуулан, гарын үсэг зуруулна. Хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн тохиолдолд шинжээч томилсон тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдод танилцуулсны дараа шинжилгээний байгууллагад хүргүүлнэ.

ГБХ-ийн улмаас хүний эрүүл мэндэд учирсан хохирлын шинж байдлыг шүүхийн шинжилгээний байгууллагаар тогтоолгохоор шинжээч томилсон шийдвэрийг шинжлүүлэгчид өөрт нь өгч явуулахгүй байхад анхаарна. Мөрдөгч нь тогтоол, шинжилгээний объектыг шинжилгээний байгууллагад өөрийн биеэр, эрх бүхий ажилтнаар, эсхүл мөрдөн шалгах байгууллагын тусгай шуудангаар хүргүүлнэ.

Шинжлүүлэгч шинжилгээ хийлгэхээс татгалзсан нь шинжээч томилж, шинжилгээ хийлгүүлэхгүй байх үндэслэл болохгүй. Шинжилгээ хийх хугацааг шинжилгээнд хамрагдах объектын хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан тогтоох бөгөөд хугацааг шинжилгээний байгууллагад тогтоол хүлээлгэн өгсөн өдрөөс эхэлж тоолно.

Мөрдөгч нь шинжээчийн шинжилгээ хийх хугацааг сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авч, шинжилгээний явц байдал, хугацаа сунгуулах үндэслэл, шинжилгээний цар хүрээтэй танилцаж, хугацааг сунгах тухай тогтоол үйлдэн, хувийг шинжээч, шинжилгээний байгууллагад даруй хүргүүлнэ. Мөрдөн шалгах ажиллагааны явцад тухайн хэрэгт мэргэжилтнээр оролцсон хүнийг шинжээчээр томилж, дүгнэлт гаргуулахыг хориглоно.

ГБХ-ийн шинжтэй гэмт хэрэгт ямар төрлийн шинжилгээ хийлгэх шаардлагатай байгаагаас шалтгаалж, шинжээчид тавих асуулт өөр өөр онцлогтой байх боловч уг асуултууд нь товч, тодорхой, ойлгомжтой нэмэлт болон бүрэлдэхүүнтэй шинжээч томилох шаардлагагүй байх ёстой. Практикт мөрдөгч шинжээч томилж дүгнэлт гаргуулсны дараа прокурор ихэвчлэн танилцдаг ба мөрдөгчийн тавьсан асуулт ойлгомжгүй тохиолдолд тухайн шинжээчээс мэдүүлэг авахыг даалгадаг. Улмаар оролцогч талуудаас хүсэлт тавьснаар тухайн хэргийг шуурхай шийдвэрлэхийн тулд нэмэлт болон дахин хийлгэх нөхцөл байдал үүсдэг.

Шинжээчийн дүгнэлт тодорхойгүй, шинжилгээ бүрэн биш хийгдсэн гэж мөрдөгч, прокурор дүгнэсэн, эсхүл шинжилгээ хийх явцад шинэ нөхцөл байдал бий болсон тохиолдолд мөрдөгч нь дараах хэлбэрээр нэмэлт шинжилгээг хийлгэнэ:

а) шинжилгээтэй холбоотой нэмэлт асуудлаар тухайн шинжээчээр;
б) тухайн шинжилгээтэй холбоотой бусад шинжлэх ухааны мэдлэг шаардлагатай бол өөр шинжээчээр;

Нэмэлт шинжилгээг шинжилгээний явцад болон шинжээчийн дүгнэлт гарснаас хойш аль ч үед хийлгэж болно. Мөрдөн шалгах ажиллагааны явцад дахин шинжилгээг прокурорын шийдвэрээр хийлгэх бөгөөд мөрдөгч нь дахин шинжилгээ хийлгэх тухай прокурорын тогтоол, шинжилгээний объектыг шинжилгээний байгууллага, шинжээчид хүргэнэ.

Прокуророос шинжээч томилох, шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд дараах нөхцлийг харгалзан үзнэ. Үүнд:

- Эрх зүйн дүгнэлт гаргах, хууль тайлбарлуулахаар асуулт тавьж дүгнэлт гаргуулахгүй байх. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хүүхэд мөн үү гэх мэт хуулиар тодорхойлсон асуулт тавихгүй байх харин сэтгэц, нас бие эрхтэний хөгжлийн байдал зэргийг тогтоолгож болох ба хууль зүйн ойлголтыг прокурор өөрөө дүгнэх шаардлагатай. Энэ төрлийн хэрэгт мөрдөгч шинжээч томилох тогтоолыг үйлдэхээсээ өмнө нь заавал танилцаж байх нь зүйтэй.
- ГБХ-н хэрэгт хохирогчид учирсан сэтгэл зүйн асуудал, сэтгэцийн

өөрчлөлт, тодорхой айдас, стрессийг тодорхойлохоор сэтгэцийн шинжилгээ хийлгэж хэвших. Эрүүгийн хуульд заасан "эрүүл мэндийн хохирол"-д сэтгэл зүйн болон бие махбодын гэмтэл хамаарах тул хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох айдас түгшүүрт автах эмгэг, олон улсын сэтгэцийн эрүүл мэндийн өвчний жагсаалтын аль хэсэгт хамаарах, сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал зэргийг тогтоолгох. Энэ нь цаашид сэтгэл санааны хүчирхийллийн шинж байдлыг нотлох, сэтгэл зүйн хохирол, хор уршгийг тогтооход ач холбогдолтойг анхаарах,

- Шинжээч томилох тогтоолыг хохирогч, яллагдагчид танилцуулж баталгаажуулж хэвших, гэмтлийн зэрэг тогтоогдоогүй боловч боомилолт бусад шинж байгааг үнэлэх, гэмтлийн зэрэг нь эрүүл мэндийн аль хохиролд хамаарч байгааг хууль зүйн дүгнэлт хийж тодорхойлж байх.
- Насанд хүрээгүй хүнээс гэрчээр болон хохирогчийн мэдүүлэг авахын өмнө эргэлзээ бүхий нөхцөл байдал үүссэн, тухайлбал бага насны хүүхдийн сэтгэцийн байдал, юмс үзэгдлийг ойлгож таних, тайлбарлах чадвар хэвийн эсэх талаар шинжээч томилж дүгнэлт гаргуулж байх. Улсын Дээд шүүхээс шийдвэрлэсэн тодорхой хэрэгт ГБХ үйлдэж эхнэрийнхээ амь насыг хохироосон хэргийн цорын ганц гэрч 5 настай хүүхдийн мэдүүлэгт эргэлзээ төрөхүйц нөхцөл байдал үүссэн, шүүгдэгчийн өмгөөлөгчийн зүгээс бусдын нөлөөгөөр мэдүүлэг өгсөн гэх гомдлыг шийдвэрлэхдээ шинжээчийн дүгнэлтийг үндэслэж шийдвэрлэсэн практик байгааг анхаарах.
- Шинжээчийн гаргасан дүгнэлтэнд ойлгомжгүй, хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий бусад байдлыг тодруулах шаардлага гарвал тодорхой асуултыг мөрдөгчид тайлбарлаж шинжээч эмчээс мэдүүлэг авч болно.

Яллагдагчаас мэдүүлэг авах

Дээр дурьдсанчлан ГБХ-ийн гэмт хэргийн нэг онцлог нь гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхой байдаг бөгөөд гэмт хэрэг үйлдэгдсэний дараа тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээд зугтах магадлал харьцангуй бага, харин хариуцлагаас зайлсхийх, хариуцлагыг хөнгөрүүлэх зэрэг арга замыг хайдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар яллагдагч гэм буруугаа нотлох үүрэг хүлээдэггүй боловч яллагдагч өөрийн гэм бурууг хүлээсэн нь хэрэгт байгаа бусад нотлох баримтаар батлагдвал яллах үндэслэл болдог. Иймд мөрдөгч нь яллагдагчийн мэдүүлэгт ач холбогдол өгч бодит байдлыг үнэн зөв, бүрэн дүүрэн илэрхийлэх мэдүүлгийг авах арга, тактикаа боловсруулах шаардлагатай.

Мөрдөгч мэдүүлэг авахын өмнө тухайн яллагдагчийн хувийн байдлыг тогтоох нь мэдүүлгийн арга, чиглэлийг тодорхойлоход ач холбогдолтой юм. Хувийн байдлыг хохирогч, гэрчүүдийн мэдүүлэг, ажлын газрын тодорхойлолт, өмнө нь шалгагдаж байсан эрүүгийн хэрэг байгаа бол тухайн гэмт хэрэгт оролцсон байдлыг судлах, ял эдэлж байсан эсэх, зөрчил гаргаж байсан эсэх, давтамж, төрөл гэх мэт байдлаар судалж болох юм. Мөн мэдүүлэг авах явцад тухайн хүний асуудалд хандаж байгаа хандлага, сэтгэл хөдлөл зэргээс үндэслэн байцаалтын арга, чиглэлийг тодорхойлж болно.

Яллагдагчаас мэдүүлэг авахын өмнө дараах нөхцөл байдлыг урьдчилан судалж, дүгнэлт хийсний эцэст мэдүүлэг авах ажиллагааг эхлүүлнэ:

1) мэдүүлэг өгөх хүн монгол хэлээр мэдүүлэг өгөх эсэх;
2) өмгөөлөгч авах эсэх;
3) Үндсэн хуульд заасан мэдүүлэг өгөхгүй байх эрхийг нь тайлбарлах шаардлага байгаа эсэх;
4) мэдүүлэг өгөх гэж буй хүн насанд хүрсэн эсэх;
5) сурган хүмүүжүүлэгч, хууль ёсны төлөөлөгч оролцуулах шаардлагатай эсэх;
6) мэдүүлэг өгч байгаа хүн сэтгэцийн хувьд эрүүл эсэх, өвчтэй бол энэ талаарх шүүхийн сэтгэц эмгэг судлалын шинжилгээ, дүгнэлтэд хэрхэн тусгагдсан болох;
7) мэдүүлэг өгч байгаа хүн хэлгүй, дүлий бол албан ёсны дохионы хэл мэддэг эсэх;

8) дуу, дүрс бичлэг хийх шаардлагатай эсэх;

Баривчлагдсан сэжигтнээс мэдүүлэг авахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.11 дүгээр зүйлд заасан журмын дагуу хянан шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнээс бусад тохиолдолд сэжигтнээр мэдүүлэг авахгүй. Хэрэв мэдүүлэг өгсөн хүн гарын үсэг зурахаас татгалзвал тайлбар бичиж, тэмдэглэлд хавсаргана. Энэ талаар дуу, дүрсний бичлэг хийж болно. Мэдүүлгийн тэмдэглэлийг мөрдөгч уншиж өгсөн тохиолдолд энэ талаар тэмдэглэлд тусгана.

Яллагдагчийн мэдүүлгийг хэд хэдэн удаа шалгаж болох бөгөөд зохиомол буюу худал мэдүүлэг өгсөн тохиолдолд өмнө ярьсан зүйлийг дахин давтан ярих нь хүндрэлтэй, боломжгүй байдаг. Зарим тохиолдолд яллагдагч мөрдөгчийн асуултаас зайлсхийхийн тулд гэмт хэрэг үйлдэгдэх үед согтуу байсан гэж мэдүүлдэг. Энэ тохиолдолд хэдийгээр тухайн этгээд гэмт хэрэг үйлдэгдэх үеийн нөхцөл байдлыг санахгүй байх боловч гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнөх нөхцөл байдал, маргалдсан шалтгаан зэргийг санаж байдаг. Иймд яллагдагчаас мэдүүлэг авахдаа гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө болсон үйл явдал, хохирогчийн зан байдал, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан зэргийн талаар тодруулан мэдүүлэг авах нь ач холбогдолтой. Яллагдагч илэрхий худал мэдүүлэг өгч гэм буруугаа хүлээхгүй байгаа тохиолдолд дараах байцаалтын аргыг хэрэглэж болно. Үүнд:

- Нотлох баримтуудыг багаас нь дэс дараалалтай гарган ирж тавьснаар шинэ нотлох баримт гарч ирэх бүрт байцаагдаж буй этгээдийн хувьд сэтгэл зүйн дарамт болж, гэм буруугаа хүлээхгүй үгүйсгэх санаа бодол орхигдож, үнэн зөв мэдүүлэг өгөх боломжтой.
- Хэргийн талаарх гол нотлох баримтыг гаргаж тавих нь үнэн зөв мэдүүлэг өгөхгүй байгаа этгээдийн сэтгэл зүйд нөлөөлөх ач холбогдолтой.
- Хэргийн талаарх нотлох баримтууд гэм бурууг нотлоход хангалттай бол бүгдийг зэрэг гаргаж тавьснаар гэмт хэрэг үйлдсэн этгээд мэдүүлэг өгөхгүй байх, эсвэл худал мэдүүлэг өгөх нь ач холбогдолгүй гэдгийг ойлгосны үндсэн дээр үнэн зөв мэдүүлэг өгч болно.

ДЭД СЭДЭВ 3. ГБХ-ийн гэрч, хохирогчоос мэдүүлэг авахад анхаарах асуудал, тусгай журмын талаар

ГБХ-ийн хохирогчоос мэдүүлэг авах онцлог

ГБХ-ийн хохирогч нь ихэвчлэн сэтгэл зүйн хувьд цочролд орсон байдаг тул тэд мэдүүлэг өгөхөөс татгалзах хандлагатай байдаг. Мэдүүлэг өгөхгүй байгаа шалтгааныг ойлгож, тэднээс хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой мэдүүлэг авахын тулд хохирогчийн аюулгүй байдлыг хангаж чадна хэмээн ойлгуулж, дэмжиж ажиллах ёстой. Энэ нь тухайн мөрдөгч, прокуроос нилээд ур чадвар шаардах юм. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч дараах шалтгаанаар мэдүүлэг өгөхөөс татгалзах эсхүл анхны мэдүүлгээ өөрчилдгийг сайтар ойлгох хэрэгтэй. Үүнд:

- хүчирхийлэл үйлдсэн хүний өшөө авалтаас айх,
- тухайн хүнтэй шүүх хурал дээр дахин уулзах хүсэлгүй,
- ичих, нэр төрөө эрхэмлэх
- өнгөрснөө мартах хүсэл гэх мэт.

Ихэнх тохиолдолд дараах хүчин зүйлс дээрх шалтгааныг даамжруулдгийг мөн анхаарах хэрэгтэй. Үүнд:

- хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэй үргэлжлүүлэн амьдардаг,
- давтан хүчирхийлэлд өртсөн,
- хүчирхийлэл үйлдэгч хохирогчийн үйлдлийг хянадаг,
- хохирогч хүчирхийлэл үйлдэгчийн

асрамжинд байдаг,

- гэр бүлийнхэн нь мэдүүлэг өгөхөөс татгалзахыг шаардаж, дарамт үзүүлдэг,
- хохирогч хууль хяналтын байгууллагад итгэлгүй болсон гэх мэт.

Хүчирхийлэлтэй шууд тулгарсан хохирогч нь гэрчийг бодвол илүү бүрэн дүүрэн, болж өнгөрсөн үйл явдал, учруулсан хохирол, хор уршгийн талаар хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдүүлэг өгөх боломжтой байдаг. Иймд сэтгэл зүйн холбоо (хоорондоо харилцаж байгаа хүмүүс бие биеэ зөв ойлгож, нэгэнт бий болсон харилцаагаа дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн үйл явц) тогтоож, хэргийг үнэн зөв шуурхай шийдвэрлэж, түүний болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хангана гэдгийг ойлгуулах нь чухал бөгөөд ингэснээр болсон явдлын талаар үнэн зөв мэдээлэл авах боломжтой болно.

Прокуророос хохирогчийн мэдүүлгийг дүгнэх болон гэрч, хохирогчийг хамгаалах шаардлага үүссэн эсэхийг хянахгүйгээр хэргийг шүүхэд шилжүүлсэн хойно шүүх хурал дээр анх удаа харах байдал түгээмэл байна. Прокуророос аль болох хохирогчтой биечлэн уулзаж хохирогчийн сэтгэл зүйг судалж, мэдүүлгийг үр дүнтэй явуулах талаар мөрдөгчтэй хамтран ажиллах шаардлагатай. Прокурор нь хохирогчтой уулзалт хийхдээ юуны түрүүнд өөрийгөө танилцуулж, эрхийг нь тайлбарлаж, нээлттэй ярилцана. Гэхдээ хэт нэг талыг барихгүй байх, мөн түүнд хүчирхийллийн талаар ярих нь хэцүү гэдгийг санах хэрэгтэй.

Үндсэн хуульд өөрийнхөө болон төрөл төрөгсдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг заасан учир хохирогч мэдүүлэг өгөх үүрэггүй. Гэхдээ үүнийг даван туулах арга нь хохирогчийг итгүүлэн үнэмшүүлэх арга юм. Хохирогчид цаашид хүчирхийлэл үйлдэгч хариуцлага хүлээхгүй үлдсэнээр өөрт нь болон хүүхдэд нь, гэр бүлийн бусад гишүүнд илүү ноцтой гэм хор учруулж болзошгүй гэдгийг тайлбарлаж өгч болно. Мөн шаардлагатай нөхцөлд хохирогчийн аюулгүй байдлыг хэрхэн хангах боломжтой байдаг, хохирогчийн аюулгүй байдлыг хангах газарт байрлахад туслах бололцоотойг хэлж болно. Хохирогчоос мэдүүлэг авах нь дараах зорилгыг хангах юм. Үүнд:

- хэрэгт хамаарал бүхий мэдээ баримтыг олж авах,
- цугларсан баримтыг шалгах,
- мэдүүлгийн зөрүүг гаргах,
- нэмэлт тодруулга, тайлбар гаргах.

Хохирогчоос анхны мэдүүлэг авах нь бодитой мэдээлэл олж авах боломжийг олгодог бол харин дараа дараагийн мэдүүлэг авах үед хохирогчийн мэдүүлэг нь янз бүрийн хүчин зүйлийн нөлөөлөлд автагдан, хүчирхийлэл үйлдэгдсэнийг хохирогч өөрөө үгүйсгэдэг. Иймд мэдүүлгийг үр дүнтэй болгохын тулд тухайн хүний талаар тодорхой хэмжээгээр судалсан байх шаардлагатай. Энэ нь тухайн хүнтэй сэтгэл зүйн холбоо тогтоох, харилцах чиглэлээ тодорхойлох, асуултаа тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Хохирогчоос мэдүүлэг авахдаа сэдвийн хүрээг тогтоохгүйгээр чөлөөтэй ярих боломжийг олгодог ерөнхий асуултаар мэдүүлгийг эхлэх, хохирогчид гүйцэд ярих боломж олгож, анхааралтай, тэвчээртэй сонсох нь чухал бөгөөд мэдүүлэх явцад дэмжих үг хэлэхээс бус түүний яриаг таслах, зөвхөн өөрийн сонирхсон асуулт тавих, утсаар ярих зэргээс аль болох зайлсхийх хэрэгтэй. Хохирогчоос мэдүүлэг авахдаа тухайн нөхцөл байдлаас шалтгаалан хохирогчийн сэтгэл санаа хөөрлийн, эсвэл хямралын байдалтай байдгийг харгалзан хохирогчийг тайвшруулж байж явуулах нь оновчтой байдаг.

ГБХ-ийн хохирогчоос мэдүүлэг авахдаа дараах асуултад заавал хариулт авсан байх шаардлагатай. Үүнд:

- гэр бүлийн ямар харилцаа хамааралтай болох,
- хохирогчийн биеийн байдал ямар байгаа,архаг хууч өвчтэй эсэх,
- бие махбодод гэмтэл учирсан, өөрчлөлт орсон эсэх,
- хүчирхийлэл үйлдэгч гэмт хэрэг үйлдэхдээ мансуурсан, согтуурсан байсан эсэх,
- хүчирхийлэл үйлдэгч байнга согтуурч, мансуурдаг эсэх,
- хүчирхийлэл хэдий үеэс эхэлсэн, үргэлжилсэн хугацаа,

- хүчирхийллийн давтамж, хоорондын хугацаа,
- хүчирхийллийн арга хэлбэр,
- урьд нь эмнэлгийн болон хуулийн байгууллагад хандаж байсан эсэх,
- хэрвээ хуулийн байгууллагад хандаж байсан бол хүчирхийлэл үйлдэгчид ямар арга хэмжээ авсан,
- арга хэмжээ авагдсаны дараа хүчирхийлэл үйлдэгчийн зан төлөвт өөрчлөлт гарсан эсэх,
- хүчирхийлэлд байдаг тухай гэрчлэх хүмүүс байгаа эсэх,
- гэр бүлийн бусад гишүүдийг хүчирхийлдэг эсэх,
- хүчирхийлэл үйлдэгч заналхийлж сүрдүүлдэг эсэх,
- заналхийлэл сүрдүүлэг бодитой эсэх,
- хүчирхийлэл үйлдэгчээс тусдаа амьдрах боломжтой эсэх,
- хамгаалалт хүсэх эсэх.

Зарим тохиолдолд хохирогчийн мэдүүлж байгаа зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй байж болох ч түүнийг буруутгасан болон шүүмжлэлтэй хандахаас аль болох зайлсхийх нь чухал. Урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй учраас хохирогчийн мэдүүлгийг бүх талаас нь шалгах шаардлагатай. Харин ГБХ-тэй гэмт хэргийн хохирогчийн мэдүүлгийг богино хугацаанд шалгах шаардлагатай бөгөөд хэрэв цаг алдвал хүний амь нас, эрүүл мэнд хохирох аюул дагуулах эрсдэлтэй гэдэгт прокуророос хяналтаа чиглүүлэн ажиллах шаардлагатай.

ГБХ-ийн гэрчээс мэдүүлэг авах

Хохирогч нь эцэг, эх, ах, дүүдээ болон дотны найз нөхдөдөө ГБХ-д өртсөн тухайгаа ярих, утсаар мэдэгдэх, төрсөн гэр рүүгээ очих, зарим тохиолдолд хүчирхийллээс зугтан айл хөршийндөө орж тусламж эрэх, нуугдах, гэр орондоо орилж хашгирах, уйлах гэх мэт чимээ нь хөршийнхөнд сонсогддог зэргээс шалтгаалан энэ гэмт хэргийн гэрч нь ихэвчлэн хохирогчийн гэр бүлийн гишүүд, найз, хүчирхийлэгчийн гэр бүлийн гишүүд, тухайн гэр бүлийн хөршүүд байдаг. Дээрх гэрчүүдээс өөр илүү бодит мэдээлэлтэй хүмүүс ховор байдаг.

Гэрчээс мэдүүлэг авснаар болж өнгөрсөн үйл явдлын талаар мэдээлэлтэй болохоос гадна тухайн үйл явдал болохоос өмнө, болсны дараах үйл явдал, гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, тухайн гэр бүлийн амьдралын хэв маяг, гэрлэгсдийн болон хамтран амьдрагчийн хоорондын харилцаа, тэдгээрийн төлөв байдлын талаар мэдээлэл, нотлох баримтыг олж авах, мэдүүлгүүдийн зөрүүг арилгах, худал гэрчлэгчийг илрүүлэх зэргээр хэрэгт цугласан материалыг шалгах боломжийг олгодог.

ГБХ-ийн гэмт хэргийн гэрчүүд нь хохирогч холбогдогчийн гэр бүлийн гишүүд байдагтай холбоотойгоор тухайн хэрэгт хувийн сонирхлоор буюу ихэвчлэн өөр өөрийн төрөл садны хүнээ өмгөөлөх мэдүүлэг өгдөг. Мөн жендэрийн хэвшмэл ойлголтоос шалтгаалан мэдүүлэг өгч буй гэрчүүд эрэгтэй нь эрэгтэйгээ өмөөрсөн, хаацайлсан мэдүүлэг өгөх магадлалтай байдгаас гадна эмэгтэй хүн илүү нарийн зүйлсийг анзаарсан байдаг.

Иймд энэ төрлийн гэмт хэрэгт нэгдүгээрт, насанд хүрээгүй хүүхдийг, дараа нь хөршийнхнийг, нэг гэрт хамтран амьдардаг насанд хүрсэн гэр бүлийн гишүүд, тэдгээрийн дараа тусдаа амьдардаг гэр бүлийн гишүүд, найз нөхөд, ажлын газрынхныг гэрчээс мэдүүлэг авах нь бодит байдлыг зөвөөр танин мэдэхэд ач холбогдолтой. Гэрч нь:

- хэрэгт ач холбогдол бүхий мэдлэг агуулж буй, тухайн хэрэгт хувийн сонирхолгүй, мэдэж буй зүйлээ бүрэн бодитой мэдүүлж чадах хүнийг,
- хэргийн талаар тодорхой мэдэх гэрчийг.

Харин болж өнгөрсөн үйл явдлын зөвхөн нэг хэсгийн талаар хэд хэдэн гэрчээс мэдүүлэг авах бол үзсэн, харсан, мэдсэн зүйлээ зөвөөр хүлээн авч, бүрэн мэдүүлж чадах, ажил амьдралын туршлагатай хүнээс мэдүүлэг авах нь ашигтай[81] хэмээн үздэг. Хүчирхийлэгчийн гэр бүлийн гишүүд, хамаатан, төрөл садны хүмүүс хүчирхийлэгч этгээд эрүүгийн хариуцлага хүлээхээс болгоомжилж, цөөнгүй

81 мөн тэнд

тохиолдолд болсон үйл явдлын талаар худал мэдүүлэх, эсвэл огт хүчирхийлэл үйлдэгдээгүй гэж мэдүүлэх тохиолдол байна.

Энэ төрлийн гэмт хэргийн ямар гэрчийг, хэзээ мэдүүлэг авах дараалыг тогтоох нь чухал бөгөөд хэдийгээр гэрч нь хуульд зааснаар үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй боловч, гэрчийн хувийн байдлыг судалж үзсэнээр мэдүүлгийг амжилттай авах суурь тавигдана. Гэрчээс мэдүүлэг авахдаа тухайн хүний боломжит цагийг харгалзан байцаалтад дуудах нь оновчтой бөгөөд товлосон цагт ирсэн гэрч хэргийн талаар бүрэн дүүрэн мэдүүлэг өгөх боломжтой байдаг байна. Харин мөрдөгчийн зүгээс өөрийн боломжит цагт мэдүүлэг авахаар дуудаагүйгээс гэрч залхах, дахин дуудагдахгүйн тулд мэдсэн, сонссон, харсан зүйлээ мэдээгүй, сонсоогүй, хараагүй гэх эрсдэлийг дагуулна.

Мөн гэрчийг хэзээ мэдүүлэг авахаар дуудахаа урьдчилан төлөвлөх нь гэрчүүд хоорондоо уулзаж, болсон үйл явдлын талаар ярилцан, өөрийн харсан, сонссон зүйлдээ эргэлзэх, өөрийн харсан, сонссон, мэдсэн зүйлийг биш,бусад гэрчийн ярьсан зүйлийг өөрийн харсан, сонссон, мэдсэн зүйл гэж ярьж, хэргийг шийдвэрлэхэд хүндрэл учруулж болох юм. Иймд гэрчээс мэдүүлэг авахдаа мэдүүлэг авахаар дуудахаас эхлэн хэргийн онцлогоос шалтгаалан тодорхой төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай.

Мөрдөгчийн зүгээс ГБХ-ийн гэмт хэргийн хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа насанд хүрээгүй хохирогч, гэрчийн тухайд насны онцлогтой холбоотой сэтгэхүйн мөн чанарыг судалж, ойлголт авсан байхаас гадна тухайн хохирогч, гэрчийн хувь хүний мөн чанар, онцлогийг олж мэдсэн байх шаардлагатай. Мэдүүлэг өгөх хүнийхээ онцлог шинж, зан чанар, онцлогийг мэдэх нь мэдүүлгээр сэтгэл зүйн байдлыг харгалзах, асуултын чиглэлийг тодорхойлох зэрэгт ач холбогдолтой юм. Гэрчээс мэдүүлэг авахад:

- Гэмт хэргийн гэрч, хохирогч өөрөө хүсэлт гаргаагүй ч тухайн этгээдийг айлган сүрдүүлж, хууль бусаар нөлөөлж байгаа талаарх баримт сэлт мэдээлэл байгаа эсэх
- Гэр бүлийн хамаарал бүхий хүн, ойр дотны хүний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн гэрч, тухайн хэргийн хохирогчийн мэдүүлэг хэргийг шийдвэрлэхэд голлох нөлөө үзүүлэх эсэх;
- Гэрчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 6 дахь заалтыг тайлбарлаж өгөх ба гэрчийг өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авахгүй байх
- Хөгжлийн бэрхшээлтэй, хэлгүй, дүлий хүн нь албан ёсны дохионы хэл мэдэхгүй тохиолдолд хэлмэрчээс гадна түүнтэй дохио зангаагаар сайн ойлголцдог гэр бүлийн гишүүн, эсхүл ойрын хүнийг оролцуулах
- Мэдүүлгийг тухайн хүний байгаа газарт очиж авсан тохиолдолд аюулгүй байдлыг хангах.
- Мөрдөгч, прокурор нь гэмт хэргийн гэрч, хохирогч аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлт гаргасан бол тухайн шаардлага байгаа эсэхийг шалгаж, аюулын эрсдэлийн үнэлгээг хийлгэсний дараа гэрч хохирогчийг хамгаалах арга хэмжээг тогтоол үйлдэж, түүнийг гүйцэтгэхийг даалгах
- Прокурортэрүүгийнхэргийгшилжүүлсэний дараа болон прокурорын хяналтын явцад гэмт хэргийн мэдээлэгч, гэрч, хохирогч аюулгүй байдлаа хамгаалуулахаар прокурорт хүсэлт гаргасан бол тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурор тухайн нэгжийн ерөнхий прокуророор албан бичгээр хүсэлт гаргаж, үнэлгээ хийлгэх
- ГБХ үйлдэгч таслан сэргийлэх арга хэмжээг зөрчиж гэрч, хохирогчид нөлөөлсөн, заналхийлсэн үйл баримт, сэлт нь цагдан хорих үндэслэл болохоос гадна Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйлд заасан "Заналхийлэх", мөн хуулийн 21.5 дугаар зүйлд заасан "Гэрч, хохирогч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх" гэмт хэргийн шинжтэй эсэхийг заавал шалгах
- Хүүхэд гэмт хэргийн гэрч, хохирогч болох нөхцөл байдал илэрхий тогтоогдвол хүүхдийн эрхийн улсын байцаагчид заавал мэдэгдэж Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд мөн эсэх, тухайн хуульд заасан тусламж үйлчилгээ шаардлагатай

эсэхийг тогтоолгох

Гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээчээс авсан мэдүүлгийн тэмдэглэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 28.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.5, 1.6-д зааснаас гадна дараах мэдээллийг тусгана:

a) шинжээчээс мэдүүлэг авсан тэмдэглэлд түүний мэргэжил, боловсрол, туршлага, эрхэлж буй ажлын талаарх мэдээлэл;
b) иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчаас мэдүүлэг авсан тэмдэглэлд мэргэжил, боловсрол, эрхэлж буй ажил, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар томилсон тушаал, шийдвэрийн талаарх мэдээлэл.
c) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчоос дахин мэдүүлэг авч байгаа тохиолдолд түүний биеийн байцаалтыг тэмдэглэлд тусгах шаардлагагүй. Хэд дэхь удаа мэдүүлэг авч байгааг болохыг тусгана.

Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.3 дугаар зүйл, энэ журмын 19.1 дүгээр зүйлд заасан нийтлэг журмыг баримтална.

a) Мэдүүлэг авахдаа тухайн хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, гэмт хэргийн нөхцөл байдалд тохирсон байдлаар явуулах ба болсон нөхцөл байдлын талаар ярихгүй бол асуулт асуух байдлаар мэдүүлэг авч болно.
b) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлд Хүүхдийн эрх, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнийг оролцуулж болно.
c) Бага насны хүүхдэд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тохиолдолд тогтоолыг хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулах боловч мэдүүлэг авахгүй.

Мэдүүлэг авахад анхаарах асуудал, тусгай журмын талаар

Гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу цугларсан нотлох баримтад үндэслэн гэм буруутай хүний үйлдлийг сэргээн тогтоох тогтоох зорилгоор хийгдэж буй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний суурь эрхийг хамгаалж, гэмт хэрэгт буруутгагдаж буй хүнд хэрхэн хандаж байгаагаар тухайн улс орны ардчиллын үзүүлэлт, хүний эрхэд хандах хандлагыг тодорхойлж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөнөөс хойш хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэрчээр асуухтай холбоотой дараах нийтлэг зөрчил гарч байгааг анхаарч, ажиллана. Мөрдөгч, түүний үйл ажиллагаанд хяналт тавьж буй прокурор нь гэмт хэргийн талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлыг зөвхөн хуулиар зөвшөөрсөн арга хэрэгслээр шалгаж тогтоох үүрэгтэй бөгөөд мөрдөн шалгах ажиллагаанд оролцогчийн хуулиар олгогдсон эрхийг хязгаарлах, хуульд заасан журмыг зөрчих замаар цуглуулж бэхжүүлсэн баримтыг нотлох баримтаар тооцож боломжгүй тул холбогдох шийдвэрийг хүчингүйд тооцох, хууль зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6 дугаар зүйлд тодорхой заажээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэгт холбогдуулан хүнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, <u>өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх</u> эрхийг мөрдөгч заавал сануулахаас гадна мөн хуулийн 16.3 дугаар зүйлийн 4.6-д заасны дагуу өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан гэрч, хохирогчоос гэрчийн мэдүүлэг албадан авч болохгүй.

Учир нь мөрдөгч хэн нэгэн хүнийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах үндэслэл бүхий гомдол, мэдээлэл, баримт сэлтийг хүлээн авсан үед тухайн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүнд худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэхийг урьдчилан сануулж, түүнээс гэрчийн мэдүүлэг авах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн

14 дэх хэсэгт заасан "... өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно..." гэсэн заалтыг ноцтой зөрчих тул шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.11 дүгээр зүйлд зааснаар тухайн мэдүүлгийг нотлох баримтаар тооцож, шүүхийн шийдвэрийн үндэслэл болгох боломжгүй юм.

Өөрөөр хэлбэл, мөрдөгч нь гэмт хэрэгт холбогдуулан шууд нэр заасан, эсхүл хамаарал бүхий нотолгоо бий болсон хүнд худал мэдүүлэг өгвөл хуулийн хариуцлага хүлээлгэхийг сануулж түүнээс өөрийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг авах нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй", мөн хуулийн 31.8 дугаар зүйлийн 1.5, 31.11 дүгээр зүйлийн 1.1-д "Баривчлагдсан сэжигтэн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй", мөн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Яллагдагч өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруугүйгээ, эсхүл хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээхгүй", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Яллагдагчийг өөрийнх нь эсрэг мэдүүлэг авахаар албадахыг хориглоно." гэсэн заалтыг тус тус ноцтой зөрчих бөгөөд ийнхүү гэмт хэрэгт сэрдэгдэж буй хүнээс хууль сануулж өөрийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг авахыг сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлсэнд тооцно.

Харин мөрдөгч гэмт хэрэг үйлдсэн байж болох хүн, хуулийн этгээд тодорхойгүй байгаа үед тухайн хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа гэж үзсэн хүнээс гэрчийн мэдүүлэг авч болох бөгөөд энэ тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан "Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй." болохыг мэдүүлэг авахаас өмнө тусгайлан тайлбарлах учиртай.

Иймд тодорхой нэр бүхий хүнийг гэмт хэрэг үйлдсэн талаар гомдол мэдээлэл гарсан, эсхүл гэрчийн мэдүүлэг авах явцад тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл бүхий нөхцөл байдал тогтоогдсон, эсхүл хүнийг гэмт үйлдэл дээр нь баривчилсан нөхцөлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 31.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 31.11 дүгээр зүйлд тус тус заасны дагуу сэжигтнээр мэдүүлэг авах, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.3 дугаар зүйлд заасны дагуу гэмт хэрэгт сэрдэгдэж буй хүнд эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татах тогтоол танилцуулж, улмаар яллагдагчаар мэдүүлэг авах нь зүйтэй.

Гэтэл Шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдсөнөөс хойш гэмт хэрэгт сэрдэгдэж буй хүнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлд "Гэрч шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй. Гэрч дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ. Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэснийг сануулж, өөрийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг албадаж авах, хууль эрх зүйн мэдлэггүй хүнээс гэрчийн мэдүүлэг авахдаа өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өмгөөлөгчөөс хууль туслалцаа авах, өмгөөлөгчийн хамт мэдүүлэг өгөх эрхийг нь сайтар тайлбарлаж өгөхгүй байх, ийнхүү мөрдөгч гэмт хэрэгт сэрдэгдэж буй хүнээс өөрийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг авахыг хэрэг илрүүлэх арга болгон ашиглах зөрчил гарч байгааг таслан зогсоох хэрэгтэй.

Прокурор яллагдагчийн өөрийнхөө эсрэг өгсөн гэрчийн мэдүүлгийг яллах талын нотлох баримтад тооцон яллах дүгнэлтдээ тусгаж, уг мэдүүлгийг үндэслэн шүүгдэгчийг яллах, улмаар шүүх тухайн нотлох баримтыг шүүгдэгчийн гэм буруутайд тооцсон шийдвэрийнхээ үндэслэл болгохыг зөвшөөрч болохгүй.

Иймд дээр дурдсан зөрчил цаашид гарахаас

урьдчилан сэргийлж, гэмт хэрэгт яллагдагчаар татагдах үндэслэл тогтоогдсон хүнд Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэхийг сануулж өөрийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг албадаж авахыг хориглох, тухайн гэрчийн мэдүүлгийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.11 дүгээр зүйлд заасан үндэслэлээр нотлох баримтаар тооцохгүй байхад анхаарч ажиллана.

Дасгал 2.

Энэхүү дасгал нь ГБХ-ийн гэмт мөрдөн шалгах ажиллагааны онцлогт анхаарлаа хандуулахад чиглэнэ.

Тохиолдол: Н.Э нь 2018 оны 7 дугаар сарын 14-нөөс 2018 оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай жирэмсэн эмэгтэй А.Г-ийг байнга зодож ГБХ үйлдсэн гэдгийг хохирогчийн найз Б цагдаагийн байгууллагад мэдэгджээ. А-г хамтран амьдрагч Н.Э-д удаа дараа зодож, гэмтэл учруулж байсныг түүний найз Б мэддэг бөгөөд А.Г-г гэртээ цоожилж явсан үед нь түүн рүү утсаар ярьж энэ тухай хэлдэг байсан байна. Н.Э нь "миний хүүхдийг хүнд өгч харуулах гэлээ, салах гэлээ" гэсэн шалтгаанаар А.Г-г удаа дараа зодож, хутгаар гар, хөлийг нь зүсч, боомилон ухаан алдуулдаг байсан бөгөөд хамгийн сүүлд боомилуулж, зодуулсны улмаас бие муу байгаагаа тухайгаа утсаар найздаа болон ээждээ хэлж амжсан байна. Н.Э нь найз болон ээжийг утсаар сүрдүүлсэн бөгөөд энэ тухай цагдаад хэлбэл ална хэмээн айлгажээ. Хохирогч эмнэлэгт хүргэгдсэн ба жирэмсний үеийн хямрал, хүчирхийллийн айдсын улмаас түр хугацаанд мэдүүлэг өгөх чадваргүй.

?

1. *Хохирогч мэдүүлэг өгөх чадваргүй үед ямар ажиллагааг зайлшгүй, нэн даруй хийж гүйцэтгэх вэ?*
2. *Хохирогчоос мэдүүлэг аваагүй байхад хохирогч нас барсан тохиолдолд хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөс авах байцаалтын асуултуудыг төлөвлөнө үү.*
3. *Гэрчээр ямар хүмүүсийг байцааж болох вэ?*
4. *Гэрч Б-г мэдүүлэг авах асуултуудыг төлөвлөнө үү.*
5. *Яллагдагчид тавих байцаалтын асуултуудыг төлөвлөнө үү.*
6. *Ямар, ямар шинжилгээний байгууллагад шинжээч томилох вэ?*
7. *Хохирогчийн бие махбодод учирсан гэмтлийн зэрэг, үхлийн шалтгааныг тогтоолгохоор шинжээч томилох үед шинжээчид тавих асуултуудыг төлөвлөнө үү.*

3.2.3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙГ ЯЛЛАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

ДЭД СЭДЭВ 1. Мэтгэлцээний талаарх ойлголт

"Хараат бус хөндлөнгийн шүүгчийн өмнө шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг талууд өрсөлдөх хэлбэрээр нотолдог, маргаан шийдвэрлэх ажиллагааны нэгэн төрлийг мэтгэлцээн гэдэг. Мэтгэлцээн гэдэг энэ нэр томьёог Монгол улсад анх 1993 оны Шүүхийн тухай хуульд " шүүн таслах ажиллагаа мэтгэлцэх зарчмаар явагдана" гэж тусгаж өгсөн. 1994 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 201 дүгээр зүйлийг шинээр оруулж "Эрүүгийн хэргийг анхан шатны болон давж заалдах шатны журмаар хянан хэлэлцэх шүүх хуралдаан мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явагдана" гэж заасан байна[82].

Англо-саксоны эрх зүйн системтэй улс орнуудад шүүх хуралдааныг мэтгэлцээнээр явуулдаг, харин Ром-Германы эрх зүйн системтэй улс орнуудад байцаан шүүдэг тогтолцоотой байдаг. Мэтгэлцүүлэн шүүх, байцаан шүүх гэсэн үндсэн ойлголтын ялгааг доорх харьцуулалтаас харж болно.

Мэтгэлцүүлэн шүүдэг тогтолцоо

- Хэргийг нотлох үүргийг талууд хүлээдэг.
- Шүүгч төвийг сахисан, хөндлөнгийн байр суурьтай байдаг.
- Зарим оронд хавтаст хэргийн материалыг урьдчилан уншдаггүй.
- Ямар нэг эргэлзээ төрвөл, нөгөө талд хожил ирнэ. Энэ нь зарим талаараа гэмт этгээдэд ял завшуулах боломж олгодог гэсэн шүүмжлэлийг дагуулдаг[83].

Байцаан шүүдэг тогтолцоо

- Шүүн таслах ажиллагааны явцад шүүгч идэвхтэй байр суурьтай байдаг.
- Шүүгч хавтаст хэргийн материалыг шүүх хуралдааны өмнө уншиж танилцана.
- Хэргийн бодит үнэнийг олох, тогтоох зорилготой.

Асуултуудаа урьдчилан бэлтгэх: Асуултыг урьдчилан бэлтгэлгүйгээр шүүх хуралдаанд гэнэт асуух нь заримдаа логикгүй, үр дүнгүй, хүсэгүй хариултаа авахад хүргэдэг. Бэлтгэгдээгүй асуулт тавих нь хуульчийн ур чадвар, авхаалж самбаа, түргэн сэтгэх ур чадвар зэргээс ихээхэн шалтгаалдаг бөгөөд бүх хүнд ийм авьяас тэр болгон заяадаггүй тул шүүх хуралдаанд тавих асуултаа урьдчилан бэлдэж орох нь үргэлж зөв байдаг. Нэгэнт бэлдсэн асуултуудыг шүүх хуралдаанд хэрэглэхгүй байх ч тохиолдол гарна. Гэхдээ урьдчилан бэлтгэж байгаа нь асуудлыг олон талаас нь, цаг хугацаанд баригдалгүйгээр нягтлах, зөв шийдвэр гаргахад ямагт тус дөхөм үзүүлдэг.

Шүүмжлэлийн үг бэлтгэх: Шүүх хуралдааны хамгийн оргил үе шат бол шүүмжлэл хэлэх үе шат. Тиймээс ялалтад хүрэхийн тулд дээр дурдсанчлан асуултуудаа урьдаас бэлтгэхийн нэгэн адил шүүмжлэлийн үгээ урьдаас бэлтгэх нь мөн л амжилтын үндэс болно. Магадгүй шүүх хуралдаан дээр таны бодсоноос өөрөөр шүүмжлэл хэлэх шаардлага ч гарч ирж болох юм. Гэхдээ та өөр нэг хувилбарын талаар аль хэдийнээ бодсон тул дахиж цаг алдахгүйгээр өөрөөр сэтгэхэд тус болох нь лавтай. Бэлдэж өөрийн болгосон үгээ сандарч тэвдэлгүйгээр шийдвэр гаргагчид хэрхэн хүргэх нь хэр бэлтгэснээс шалтгаалдаг гэдгийг анхаарах нь зүйтэй.

Илтгэх ур чадвар: Яллагч шүүмжлэл хэлэхдээ илтгэх ур чадварыг эзэмшсэн байх хэрэгтэй. Сонгодог мэтгэлцээнээр шүүх хуралдаан хийдэг улс орнуудад өмгөөлөгч, яллагч нарт зайлшгүй тавигдах шаардлагын нэг нь илтгэх ур чадвар байдаг. Иймээс тэдэнд тусгайлан энэ чиглэлээр сургалт явуулдаг. Харин манайд энэ талаар тодорхой программын дагуу сургалт явуулдаггүй гэж хэлэхэд болно. Яллагчийн шүүмжлэл нь үнэмшилтэй, нотлох баримтад тулгуурласан, логиктой, хууль зүйн үндэслэлтэй байх ёстой бөгөөд дараах бүтэцтэй байвал зохино.

Удиртгал: Эхлэл сайн байх нь танхимд

82 УЕПГ Прокурорын мэдээлэл, Х.Батчимэг, 2009 он, 58 тал

83 УЕПГ, Прокурорын мэдээлэл, Х.Батчимэг, 2009 он, 58 тал

байгаа хүмүүст өөрийнхөө үгийг бүрэн дүүрэн сонсгоход чухал ач холбогдолтой байдаг. Энэ хэсэгт хэн гэдэг прокурор, хэнд холбогдох ямар гэмт үйлдлийг яллах гэж байгаа зэргийг ярина.

Хэргийн байдал: Энэ хэрэг юунаас болж гарсан, гэмт үйлдлийн талаар, учруулсан хор уршиг болон гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулсан байдал гэх зэргийг хэлэх бөгөөд хэргийн онол буюу яллах дүгнэлтдээ нийцүүлж ярина.

Нотолгоо: Дээрх байдлууд нь хавтаст хэрэгт цугласан нотлох баримтууд болон шүүхийн хэлэлцүүлгийн үед хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар нотлогдож байгаа байдлын талаар ярина.

Яллах хэсэг: Эцэст нь шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн ямар зүйл хэсэгт зааснаар, ямар төрлийн ял шийтгэлийг, ямар байдлаар (хэмжээтэйгээр) оногдуулах нь тухайн шүүгдэгчид тохиромжтой гэж үзсэнийхээ хэмжээнд, өөрийн дотоод итгэлийг удирдлага болгон ялын талаарх дүгнэлтээ хэлнэ. Түүнчлэн энэ хэсэгт хорих ял эдлүүлэх дэглэм, хохирлын асуудал, ял хүндрүүлэх нөхцөл байдлын талаар ярина.

Нэмэлт тайлбарын хэсэг: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35.24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүх хуралдаан даргалагч шүүхийн хэлэлцүүлэг дуусаныг зарласны дараа улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт гаргана", 3 дахь хэсэгт "Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт хэлж дуусаны дараа дүгнэлтэд заасан зүйлийн талаар харилцан тус бүр нэг удаа тайлбар хэлж болно" гэх зэрэг заалтуудыг тусгаж өгсөн байна. Үүний гол зорилго нь өмгөөллийн үг болон өмгөөлөгчийн хэргийн онолыг няцаах явдал юм.

Шүүмжлэлийн үг бол зөвхөн мэдээлэл дамжуулж байгаа явдал биш бөгөөд бүх агуулгаараа ятгалга байдаг онцлогтой тул хэргийн онолоо итгүүлэхийн тулд оролцогчдыг өөрийнхөө ярианд анхааруулах бүх аргыг эзэмшсэн байх нь чухал байдаг. Шүүмжлэл явуулахдаа дараах зүйлсийг анхаарсан байвал зохино.

Биеэ авч явах байдал: үг хэлэхдээ эсрэг талтайгаа соёлтой, ёс зүйтэй харилцах, сандарсан, тэвдсэн байдал гаргахгүй байх гэх мэт.

Дууны өнгө, хэлбэлзэл: илтгэх урлагт нэг өнгийн дуу хоолойгоор ярих нь хүмүүсийн анхаарлыг төдийлөн татдаггүй гэж үздэг төдийгүй үгний үнэ цэнийг бууруулдаг учраас чанга, зөөлөн ярихыг хослуулах гэх мэт.

Ярианы хурд: хэт хурдан дуржигнуулах, хэт удаан ярих зэрэг нь сонсогчдыг ойлгохгүй болон залхаахад хүргэдэг тул ярианы хурдыг тохируулан ярьж сурах, зарим тохиолдолд түр зогсосхийх, анхаарал хандуулах шаардлагатай зарим үгийг дахин давтах гэх мэт.

Үг хэллэг: Үг хэллэг нь яллагчийн хувьд хурц, хууль зүйн хэллэгтэй, оновчтойгоор илэрхийлэгдэх нь ач холбогдолтой байдаг. Тэр ч байтугай хүмүүсийн хэлсэн үгнээс ишлэл хийх, зүйр цэцэн үгийг тохируулан хэрэглэх зэрэг нь үр дүнд хүргэдгийг анхаарна.

Хөдөлгөөн, дохио зангаа: Илтгэх урлагт зөвхөн үг хэллэг биш, дохио зангаа, хөдөлгөөний хуваарилалтыг тохируулан хэрэглэх нь мөн л үр дүнтэй байдаг. Шаардлагатай гэж үзвэл үзүүлэн хэрэглэх (хэргийн газрын үзлэгийн зургаар гэх мэт), босож явах зэрэг нь бусдын анхаарлыг татахад чухал байдаг. Гэхдээ нэг ижил төрлийн дохио зангааг байнга давтах, танхимд чөлөөтэй босож явах зэргээс зайлсхийвэл зохино.

Харааны хуваарилалт: Яллаж байхдаа зөвхөн нэг тийшээ харах буюу доошоо хараад байх нь өөртөө итгэлгүй, сул дорой шинж тул хараагаа зөв хуваарилах нь ач холбогдолтой байдаг. Тухайлбал, шүүгдэгчийн гэмт үйлдлийн талаар ярьж байхдаа шүүгдэгч рүү харах, шүүгчид хандаж байгаа бол шүүгч рүү харах гэх мэт.

Анхаарал хандуулахыг зориуд хүсэх: Жишээ нь, одоо миний хэлэх гэж байгаа энэ үгэнд та бүхэн анхаарлаа хандуулна уу гэх мэт.

Гэнэтийн асуулт тавих: Жишээ нь, хохирогч хэрвээ өөрийгөө хамгаалах бүх оролдлогыг хийсэн байсан бол өдийд амь насаа алдах байсан болов уу, яасан бол, хэрвээ хамгаалах гэж оролдсон бол өдийд эсрэг тал

шүүгдэгчийг аргагүй хамгаалалт хийсэн гэж хэлэх байсан байх даа гэх мэт.

Сэдвээ өөрчлөн өөр асуудал руу шилжих: Жишээ нь, шүүгдэгчийн талаар сая ярилаа. Одоо тэр үед хохирогч ямар байдалтай байсан талаар яръя гэх зэргээр анхаарал суларч байсныг дахин сэргээх гэх мэт[84].

Прокурор мэтгэлцээнд оролцохдоо эрх зүйн хэм хэмжээнд тулгуурласан байхаас гадна, илтгэх, өөртөө итгүүлэн үнэмшүүлэх ур чадварыг сайтар эзэмшсэн байх нь шүүх хуралдааны мэтгэлцээний үед зайлшгүй ач холбогдолтой.

ДЭД СЭДЭВ 2. ГБХ-ийн хэргийг яллахад прокуророос анхаарах асуудал

Мөрдөн шалгах ажиллагаагаар яллагдагчийн гэм бурууг шүүхээр шийдвэрлүүлэх хангалттай нотлох баримт хэрэгт цугларсан гэж прокурор үзвэл яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлнэ. Хэргийн бүрдэл дутуу хэргийг шүүхэд шилжүүлсэн нь шүүхээс тухайн хэргийг прокурорт буцаах, эсхүл хэргийг нотлогдоогүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, шүүгдэгчийг цагаатгах үндэслэл болдог. Тиймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан ажиллагаа хэрэгт бүрэн хийгдсэн эсэхийг прокурор заавал хянана. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг гарсан байдал хангалттай тогтоогдсон эсэх;
- Гэмт хэргийг хэн үйлдсэнийг илрүүлсэн эсэх;
- Гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэрийг зөв тогтоосон эсэх;
- Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл, яллагдагчийн хувийн байдлыг тогтоох ажиллагаа бүрэн хийгдсэн эсэх;
- Эрүүгийн хүлээлгэх хариуцлагын хэр хэмжээ, шинж чанарт нөлөөлөх нөхцлүүдийг тогтоосон болох;
- Хохирлын хэр хэмжээг зөв тогтоосон эсэхийг нарийвчлан хянах ёстой.

ГБХ үйлдэх гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг цаг хугацааны байдлаар тогтоохоос гадна гэр бүлийн харилцааны түүхчилсэн байдлыг шалгаж, хүчирхийлэл хэдийд эхэлснийг тогтооно.

Шүүгдэгчийн хөрөнгө орлого, боловсрол, мэргэжил, ажил эрхлэлтийн байдлыг шалгаснаар түүний гэм буруу, хувийн байдалд тохирсон эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдэнэ.

Үүнээс гадна мөрдөгч нь хэргийн оролцогчийг хавтаст хэргийг материалтай танилцах боломжоор хангасан эсэх, хэргийн материалтай танилцаад гаргасан гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн эсэх, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхдээ хууль зөрчсөн эсэхийг хянаж үзнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн аливаа зөрчлийг мөрдөгч гаргасан эсэхийг хянах:

Мөрдөгч хэргийг шалгах үедээ процессын, техникийн шинжтэй зөрчлүүд гаргах нь түгээмэл байдаг. Энэ тохиолдолд зөрчлийг засуулалгүйгээр хэргийг шүүхэд шилжүүлэх нь шүүхээс хэргийг прокурорт буцаах үндэслэл болно. Иймээс ямар ч тохиолдолд хэргийг хянаад хууль зөрчсөн аливаа зөрчил илэрвэл прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд зөрчлийг засуулах, засагдах боломжгүй тохиолдолд нотлох баримтаас хасах шийдвэр гаргах, мөрдөгчид хариуцлага тооцуулах зэрэг ажиллагааг хийсний үндсэн дээрээс хэргийг шүүхэд шилжүүлэх нь зүйтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд прокурор хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих талаар "хэрэг бүртгэлт, мөрдөн шалгалтын явцыг хянах, бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шалгах, шаардлагатай бол хавтаст хэргийг татаж хянах, уг ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгуулах талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын удирдлагад шаардлага тавих, зөрчлийг арилгуулах", "Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн шалгалтын явцад мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан энэ хуулийг хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, хууль зөрчсөн шийдвэрийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүй

84 УЕПГ, Прокурорын мэдээлэл, Х.Батчимэг, 2009 он, 75 тал

болгож, хариуцлага тооцуулна", "Хэрэг бүртгэлт, мөрдөн шалгалтын явцад гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, мөрдөн шалгах ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж прокурор үзвэл оролцогчийн гаргасан гомдлоор, эсхүл өөрийн санаачилгаар гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчаас биечлэн мэдүүлэг авах, шинжээч дахин томилж дүгнэлт гаргуулах, үзлэг, нэгжлэг, туршилтыг давтан хийх, мөрдөн шалгах нууц ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан эсэхийг хянан шалгах ажиллагаа явуулж болно" гэх зэргээр тусгаж өгчээ.

Практикт мөрдөгч нар хуулийн нэр томьёог зөв хэрэглэхгүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулах журам зөрчих тохиолдол гардаг. Тухайлбал: 14-18 насны яллагдагчаас мэдүүлэг авахдаа "өсвөр насны" гэсэн нэр томьёогоор хэрэглэж хэвшүүлэх, нотлох баримтанд тооцуулах журам зөрчсөн зөрчлийг их гаргаж байгаа тул уг зөрчлийг засуулж хэргийг шүүхэд шилжүүлэх нь зүйтэй.

Мөрдөгч гэрч, хохирогч, яллагдагчаас мэдүүлэг авахдаа хөтөлсөн, тулгасан хууль бус асуулт асуух нь элбэг бөгөөд энэ зөрчлийг прокуророууд төдийлөн анхаарахгүй байдаг нь буруу юм. Өөрөөр хэлбэл хуульд заасныг зөрчиж цуглуулсан нотлох баримт нь нотлох чадвараа алдах тул зөрчлийг засуулсны дараа хэргийг шүүхэд шилжүүлнэ.

Зөрчилтэй нотлох баримтыг нотлох баримтаас хасуулж, мөрдөгчид хариуцлага тооцох, шүүх хуралдаанд зөрчилтэй баримтыг нотлох баримтаар хэлэлцүүлэхгүйгээр нотлох баримтаас хасуулах тухай хүсэлт гаргах замаар прокурор хуулийг нэг мөр хангуулах чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой.

ГБХ үйлдэх гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн Улсын Дээд шүүхийн зарим шийдвэрээс:

2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 119 дугаартай тогтоолоор:

"Бусдын эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан үйлдэлд гэр бүлийн хүчирхийллийн шинж хангалттай тогтоогдоогүй тохиолдолд тухайн хэргийн хохирогч нь гэр бүлийн хамаарал бүхий хүн байсан гэх агуулгаар хэргийг 2015 оны Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хүндрүүлэн зүйлчлэхгүй болно" гэж,

2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 34 дугаартай тогтоолоор:

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинжийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд тодорхойлсон агуулгаар ойлгох ёстой бөгөөд уг зүйлд заасан аль нэг үйлдлийг байнга хийсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор хууль тогтоогч тодорхойлсон байна.

Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлд заасан "Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэргийг "гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн" гэх шинжээр хүндрүүлэн зүйлчлэхдээ хэдийгээр энэ нь нэг удаагийн шинжтэй үйлдэл байж болох боловч тухайн үйлдэл нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинжийг хангаж байгаа эсэхэд хууль зүйн дүгнэлт хийж, хэргийн зүйлчлэлийг зөв тогтоож байх шаардлагатай.

Шүүгдэгч Ц.Н нь төрсөн дүүгээ гэр бүлийн байнгын харилцан хамааралтай байдлыг нь далимдуулан байнга зодож байсан, эсхүл байнга харгис хэрцгий харьцаж, догшин авирлаж тарчлаасан гэх нөхцөл байдал тогтоогдоогүй, харин хүмүүс хоорондын харилцаа, ах дүүгийн ёсны талаарх нийгэмд тогтсон зан заншил, ёс суртахууны нийтлэг хэм хэмжээг бүдүүлгээр зөрчсөн хохирогчийн зүй бус үйлдэл гэмт хэрэг гарах шалтгаан болсон, түүнчлэн хохирогчийн амьдралын буруу зан үйл, хэв шинж, зуршлыг засах үүднээс ах хүний хувиар зүй ёсны шаардлага тавихад хохирогч хэл амаар доромжилсноос шалтгаалж гэнэт үүссэн буюу тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдэгдсэн байх тул гэр бүлийн хүчирхийллийн шинж үгүйсгэгдэж байна гэж дүгнэн хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн зүйлчилсэн,

2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 251 дугаартай тогтоолоор:

2015 оны Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний эрүүл мэндэд

хөнгөн хохирол учруулсан үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хүндрүүлэн зүйлчлэхээр хуульчилсан бөгөөд гэр бүлийн хүчирхийллийг байнга үйлдсэн үндэслэлээр хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд зааснаар давхар зүйлчлэх тохиолдолд тухайн үйлдлийг хэзээ, хаана, ямар хэлбэрээр, 3 ба түүнээс дээш удаа үйлдсэнийг хөдөлбөргүй тогтоосон байвал зохино гэж тус тус дурдсан байна.

Иймд эдгээр шийдвэрүүдээс дүгнэлт хийн, хэргийн зүйлчлэлд онцгой анхааран, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг нотолбол зохих бүхий л асуудлаар тал бүрээс нь бүрэн дүүрэн шалгуулж, тогтоолгож байх.

Жишээ :

Б нь ... аймгийн ... байранд 2019 оны 03 дугаар сарын 28, 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрүүдэд гэр бүлийн хамаарал бүхий, хамтран амьдрагч С.И-г зодож, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, мөн Ч. 2019 оны 05 дугаар сарын 11-ний өдөр гэр бүлийн хамаарал бүхий хохирогч И-д гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгч Б-г хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн, мөн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодож гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгт тус тус гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1.1-д зааснаар 10 сар хорих ял, ~~Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2.8 дахь хэсэгт заасныг журамлан~~ мөн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 320 цагийн нийтэд тустай ажил хийлгэх ял тус тус шийтгэж, ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүх дээрх үйл баримтуудад эрх зүйн дүгнэлт өгөхдөө Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ойлголт, шинжийг төсөөтэй тайлбарлан гэмт хэргийг шинжийг хангаагүй үйлдэлд шүүгдэгчийг гэм буруутайд тооцож шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй байх ба Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн байна.

Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн нэг онцлог шинж нь тухайн зүйлд заасан үйлдлийг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний эсрэг байнга үйлдсэн тохиолдолд хамаарахаар хуульчилсан болно. Эрүүгийн эрх зүйн онол болон практикт тодорхой үйлдэл, эс үйлдэхүйн давтамжийн шинжийг тодорхойлоход давтан, байнга гэсэн ойлголт хэрэглэдэг бөгөөд байнга гэдэг нь тоон илэрхийллийн хувьд гурав болон түүнээс дээш удаа үйлдэгдсэн байхыг авч үздэг хууль хэрэглээний ойлголт юм.

Иймээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бие даасан шинж болох гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодсон гэх үйлдэл нь байнга буюу гурав ба түүнээс дээш давтамжтай үйлдэгдсэн үйлдэл байхыг шаардах ба Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан өөр гэмт хэргийн шинжийг агуулаагүй, хохирол, хор уршиг учраагүй, эсхүл өөр салбар эрх зүйд тодорхойлсон хэм хэмжээгээр хариуцлага хүлээгээгүй байхыг багтаан ойлгоно.

Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нэг харилцаа буюу хүний эрүүл мэндийн халдашгүй байдалд халдаж хохирол учруулсан нэг үйлдлийг тухайн харилцааны доторх өөр зүйл, хэсгээр давхар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна гэсэн шударга ёсны зарчимд нийцэхгүй тул нэг үйлдлийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж бусдын биед гэмтэл учруулсан, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэг гэж салгаж зүйлчлэх боломжгүй юм.

Өөрөөр хэлбэл, хохирогчийн эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр болон хүнд хохирол учруулсан шинжээр Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсгээр тусдаа зүйлчлэгдээгүй, түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтад заасны дагуу хариуцлага хүлээгээгүй, гэр бүлийн хамааралтай байдлыг нь далимдуулан зодсон гурав ба түүнээс дээш удаагийн бие даасан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай

ангийн 11.7 дугаар зүйлд заасан шинжийг хангана.

Гэтэл Б өөрийн хамтран амьдрагч И-г 2019 оны 03 болон 04 дүгээр сард зодсон гэх 2 удаагийн үйлдлийг анхан шатны шүүх гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэж, түүнчлэн давж заалдах шатны шүүхийн хувьд уг 2 үйлдэл дээр хохирогчид хөнгөн гэмтэл учруулсан шинжээр тусдаа зүйлчлэгдсэн үйлдлийг давхардуулан дүгнэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргийн шинжид тооцож шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заагаагүй үйлдлийн шинжийг төсөөтэй хэрэглэж болохгүй талаарх Эрүүгийн хуулийн 2.1 зүйлийн шаардлага, мөн Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх талаарх Эрүүгийн хуулийн 1.2 зүйлд заасан хууль ёсны зарчимд нийцээгүй, үндэслэлгүй шийдвэр болжээ.

Иймд шийтгэх тогтоол, магадлалын шүүгдэгч Б-д гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгт гэм буруутайд тооцож, ял оногдуулсан заалтыг хүчингүй болгож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар зүйлчилж шийдвэрлэсэн.

Прокурорын яллах дүгнэлт үйлдэх аргачлал:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын хуульд прокурорын яллах дүгнэлт хэрхэн бичих аргачлалыг тодорхой заагаагүй боловч прокурорын аргачилсан зааврааар яллах дүгнэлтийг хэрхэн бичих талаар дурьдсан байдаг. Прокурор нь мөрдөгчийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж ирүүлсэн хэрэгт хяналт тавьж, улмаар мөрдөн байцаалтыг дуусган ирүүлсэн хэргийг гэмт хэргийн гэмт хэргийн шинжийг бүрэн агуулсан эсэхийн хянаад шүүхээр гэм бурууг тогтоолгох нь зүйтэй гэж үзвэл мөрдөн байцаалт явуулсан хэрэгт прокурорын яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлнэ.

Прокурорын яллах дүгнэлт:

Мөрдөн шалгах ажиллагааг дуусгаж ирүүлсэн хэргийг прокурор хянаж үзээд хэргийг шүүхэд шилжүүлэх шаардлагатай гэж үзвэл яллах дүгнэлт үйлдэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.9 дүгээр зүйлийн 1-д "прокурор яллах дүгнэлт үйлдэх үед яллагдагчийг буруутгаж байгаа Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалтыг өөрчлөх, нэмэлт оруулах бол яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, яллагдагчаар татах тогтоолд оруулсан өөрчлөлтийг яллагдагчид танилцуулахыг мөрдөгчид даалгана" гэж заасан.

Мөрдөгч прокурорын даалгасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоолд өөрчлөлт, эсхүл нэмэлт оруулсан тогтоолыг яллагдагчид танилцуулан, эрхийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд гарын үсэг зуруулна. Яллагдагч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоолд өөрчлөлт, эсхүл нэмэлт оруулсан тогтоолтой танилцахаас татгалзвал түүнд тогтоолыг уншиж энэ талаар тэмдэглэл хөтөлж шаардлагатай бол дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ. Яллагдагч нь сонсгосон ялын талаар бичгээр болон амаар тайлбар гаргах, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй тул түүнд урьд нь яллагдагчаар татсан тогтоолд өөрчлөлт эсхүл нэмэлт оруулсан тогтоолыг танилцуулаад мэдүүлэг өгөх эсэхийг тодруулна. Яллагдагч мэдүүлэг өгөхийг зөвшөөрсөн бол мөрдөгч мэдүүлэг авч болно.

Прокурорын яллах дүгнэлт нь шүүхийн тогтоолын нэгэн адил хууль ёсны бөгөөд үндэслэлтэй байх ёстой.

Хууль ёсны байх: Прокурорын яллах дүгнэлт нь хуулийн бүх шаардлагад нийцсэн байх ёстой. Прокурорын хэрэглэж байгаа хууль нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа, Үндсэн хуульд нийцсэн байх нь дамжиггүй юм. Түүнчлэн эрх зүйн зарчмуудад нийцсэн байх ёстой. Тухайлбал шударга ёсны, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд хариуцлага хүлээлгэх зарчим зэрэг болно.

Үндэслэлтэй байх: Прокуроос хэргийг хянах явцдаа мөрдөн шалгах ажиллагаагаар цугларсан нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн бодитой шинжилсний үндсэн дээр гэмт хэргийн шинжтэй гэсэн дотоод итгэл төрж улмаар энэ дотоод итгэлийн үндсэн дээрээс яллах дүгнэлт үйлдэх нөхцөл бүрддэг. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэнийг нотолж байгаа үндэслэлтэй нотлох баримтуудад дүгнэлт хийж яллах дотоод итгэл төрж байгаа

нь яллах дүгнэлтийг үндэслэлтэй болгодог байна.

Хэргийг хянахдаа нотлох баримтуудыг тал бүрээс нь авч үздэг хэдий ч нэгэнт дотоод итгэл нь яллах нь зүйтэй гэж үзсэн бол прокурорын яллах дүгнэлт нь зөвхөн яллах талын нотлох баримтуудаас бүрдэх ёстой болдог.

Хэдийгээр хуульд зөвхөн яллах талын баримтуудыг оруулсан байхаар зохицуулаагүй боловч энэ нь шүүх хуралдаанд прокурор нь улсын яллагчаар оролцож шүүгдэгчийг яллах ажлын үндсэн чиг үүргээс нь урган гарч байгааг анхаарах нь зүйтэй.

Прокурорын яллах дүгнэлтийн бүтэц: Яллах дүгнэлт нь тэмдэглэх, тогтоох хэсэг, хавсралтаас бүрдэнэ.

Тэмдэглэх хэсэгт: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "яллагдагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, биеийн байцаалттай холбоотой бусад мэдээлэл"-ийг тэмдэглэх хэсэгт бичнэ гэжээ. Үүнд яллагдагчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, биеийн байцаалттай холбоотой бусад мэдээлэл буюу нас, хүйс, регистрийн дугаар, иргэний харъяалал, эзэмшсэн боловсрол мэргэжил, эрхэлсэн ажил, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээдийн албан ёсны нэр, хаяг үйл ажиллагаа явуулж байгаа байршил, бүртгэлийн дугаар, ял шийтгүүлсэн байдал зэргийг бичих нь зүйтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "яллаж байгаа гэмт хэргийн товч агуулга, гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа, учруулсан хохирол, зайлшгүй шаардлагатай нотлох баримт" гэж тэмдэглэх хэсэгт оруулах зүйлүүдийг заажээ.

"Хэргийн товч агуулга" гэдэгт гэмт хэргийн үндсэн шинжид тусгаж өгсөн хэлбэрийн дагуу бичих бөгөөд тухайн гэм буруутай этгээд Эрүүгийн хуульд заасан ямар гэмт хэргийг хэзээ, хаана үйлдсэн, гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа, уг гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн тохирох зүйл, хэсгийг журамлах нөхцөл байдал бий болсон тохиолдолд агуулгыг нь оруулах, тухайлбал хэрэгт хамтран оролцогчоор оролцсон бол хамтран оролцсон гэх, уг гэмт хэргийг үйлдэхээр завдсан бол завдсан гэх маягаар бичих, гэмт хэргийн улмаас ямар хохирол, хор уршиг учирсан болох зэргийг хамруулсан байвал зохино.

Харин тухайн гэмт хэргийн шинжид нь сэдэлт, санаа зорилгыг тогтоосон байхыг шаардсан бол сэдэлт, санаа зорилгыг нь хэргийн товч агуулгадаа дурьдаж байх нь зүйтэй.

"Зайлшгүй шаардлагатай зарим нотлох баримт" гэдэгт яллагдагчийн гэм бурууг нотолж байгаа зайлшгүй шаардлагатай нотлох баримтуудын товчлолыг ойлгоно. Өөрөөр хэлбэл тухайн прокурор хэрэгт авагдсан ямар нотлох баримтуудаар хэргийн онолоо баталж байгаа тэр баримтаа дурьдана. Энд нэг анхаарах зүйл бол үйлдэл тус бүрийг нотолж байгаа нотлох баримтуудаас оруулсан байх ёстой.

Яллах дүгнэлт бол прокурорын гол шийдвэр тул хуульчийн ур чадварыг харуулсан, хууль хэрэглэж үндэслэлээ гаргадаг, нотлох баримтуудаа дүгнэж бичдэг байх нь зүйтэй. Үүнд нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, хуулийн дагуу цуглуулж бэхжүүлж авсан, хэргийг шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлдэг болох, харилцан зөрүүтэй нотлох баримтуудын алийг нь үнэн зөв гэж үзсэн үндэслэлээ дүгнэх, буруу гэж үзсэнээ үгүйсгэх байдлаар бичих шаардлагатай бөгөөд яллах дүгнэлт нь товчхондоо яллаж байгаа баримтуудыг дүгнэж байгаа прокурорын шийдвэр юм.

Нотлох баримтуудыг жагсаан бичсэний дараа дээрх нотлох баримтуудаар гэм буруутай нь тогтоогдож байх тул гэж дүгнэх явдал нийтлэг байдаг. Энэ нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно", Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлд "гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ", Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйлийн 13.1-д "Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй" гэсэн хуулийн заалтуудтай зөрчилдөж байна. Иймд

гэмт хэргийг үйлдсэн гэх үзэх үндэслэлтэй байх тул гэх маягаар бичиж байх нь зүйтэй.

Яллах дүгнэлтийн тогтоох хэсэг нь: бүтцийн хувьд ямар байх, юу юу агуулагдаж байхыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт нэг бүрчлэн заасан байдаг. Үүнд:

1. яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж нь Эрүүгийн хуульд заасан ямар зүйл, хэсэг, заалтаар зүйлчлэгдэх;
2. эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал;
3. яллах дүгнэлт үйлдсэн прокурорын нэр, албан тушаал, он, сар, өдөр.

Тогтоох хэсэгт яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн хэд хэдэн яллагдагчтай бөгөөд яллагдагч нарын үйлдсэн гэмт хэргүүд нь өөр өөр гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулж байгаа бол Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг нэг бүрийг нэг бүрчлэн бичсэн байх ёстойг анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл эндээс ямар хэрэг үйлдсэн, энэ нь Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсгээр зүйлчлэгдэж байгаа нь тодорхой харагдах ёстой. Түүнчлэн яллах дүгнэлтийн доод хэсэгт үйлдсэн прокурорын нэр, албан тушаал, зэрэг дэвийг тодорхой тусгах ёстой. Дээрх жишээн дээр авч үзвэл тогтоох хэсгийн 1 дэх заалтыг "Б овгийн С.Н нь бусдыг тодорхой үйлдэл хийхийг шаардаж түүнд хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлснийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр зүйлчлэхээр тогтоосугай" гэж бичих нь зүйтэй.

Яллах дүгнэлтийн хавсралт хэсэгт юу хамаарахыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйл болон мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан зааврын 16.5 дугаар зүйлд заасан байдаг.

Хавсралт хэсэгт шүүх хуралдаанд шинжлэн судлах нотлох баримт, шүүх хуралдаанд мэдүүлэг авахаар дуудах оролцогч, бусад оролцогчийн нэр, яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, хугацаа, холбогдох мэдээлэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн хэмжээ, нөхөн төлөгдсөн байдал, яллагдагч тус бүрийн хариуцах хохирлын хэмжээ, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал, хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, битүүмжилсэн эд хөрөнгө, эд мөрийн баримт, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байгаа бол яллагдагчид хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээний талаарх санал зэргийг тусгасан байвал зохино.

Прокурор нь шүүх хуралдаанд шинжлэн судлах нотлох баримтыг яллах дүгнэлтийн хавсралт хэсэгт нэг бүрчлэн тусгаж өгөх хэрэгтэй. Энд тусгаагүй нотлох баримтыг шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлахгүйг анхаарвал зохино.

Шүүх хуралдаанд мэдүүлэг авахаар дуудах, оролцогч, бусад оролцогчийг шүүх хуралдаанд оролцуулахдаа прокурор өөрт ашигтай мэдүүлэг өгөх эсвэл ашигтай хариулт авах асуултуудыг тавьж чаддаг байх хэрэгтэй.

Эд мөрийн баримт, битүүмжилсэн хөрөнгийн талаарх тодорхойлолт гэдэг нь тухайн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан ямар ямар эд зүйлсийг хэргийн хамт шилжүүлж байгаа, хэрвээ хэргийн хамт шилжүүлэх боломжгүй байгаа бол хаана хадгалж байгааг, битүүмжилсэн ямар ямар эд хөрөнгө хаана, ямар байдалтай байгаа болохыг тодорхой тусгасан байвал зохино. Мөн барьцааны мөнгийг байршуулсан дансны мэдээллийг яллах дүгнэлтийн хавсралтанд тусгана. Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, эд мөрийн баримтын шинж чанар, тоо ширхэг, овор хэмжээ, онцлог шинж тэмдэг, хэв загвар, сери дугаар, сорьц, үнэлгээг тодорхой тусгах бөгөөд хэрэв тэдгээрийг хэргийн хамт шилжүүлэх боломжгүй бол хадгалж байгаа газрыг тодорхой заана.

"Иргэний нэхэмжлэл, түүнийг хангах талаар авсан арга хэмжээ" гэдгийг гэмт хэргийн улмаас хохирогч, иргэний нэхэмжлэгчид ямар хэмжээний хохирол учирсан, яллагдагч төлсөн эсэх, хэдий хэмжээний төлбөр төлвөл зохих зэргийг тусгах ёстой.

"Шүүх хуралдаанд зүйлшгүй оролцуулбал зохих гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч болон бусад оролцогчдын талаарх санал" гэдэг нь улсын яллагчаас шүүх хуралдаанд ямар арга

тактиктай оролцох гэж байгаа арга зам нь бөгөөд мэтгэлцээнд өөртөө давуу тал олж авах боломж тул эдгээрийг оролцуулах талаар шүүхэд хүсэлт гаргаж байгааг ойлгоно. Улсын яллагч шүүх хуралдаанд зайлшгүй оролцуулвал зохих оролцогчдын талаар саналаа гаргахдаа эдгээр оролцогчид нь шүүх хуралдаанд оролцсоноороо яллах талд ашигтай, давуу байдлыг бий болгох талаас нь харгалзан үзнэ.

Яллах дүгнэлт үйлдэх үед шүүхийн харьяалал тодорхойгүй бөгөөд дээд шатны шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдолд "Улсын дээд шүүхийн харьяалал тогтоож өгсөн газрын шүүхэд шилжүүлсүгэй" гэж бичвэл зохино.

Яллах дүгнэлт шаардлага хангаагүйгээс гарсан үр дагавар

Жишээ:

<u>Хэргийн утга:</u> В нь өөрийгөө хамгаалах чадваргүй, сэтгэцийн өөрчлөлттэй, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүдэд удаа дараа хүч хэрэглэж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэх гэмт хэрэгт холбогдсон бөгөөд УДШ-ээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хууль ёсны ба үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүйгээс гадна прокурорын яллах дүгнэлт хуульд заасан шаардлага хангаагүй гэж дүгнэн, хэргийг анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн байна.

<u>Яллах дүгнэлтэд гаргасан алдааны агуулга:</u> *..... аймгийн прокурорын газрын хяналтын прокурор .... бичсэн эсэргүүцлийг үндэслэн шүүгдэгч В-д холбогдох хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг хянаж үзэхэд мөрдөн байцаалтын шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан хэргийн талаар нотолбол зохих байдлыг дутуу шалгасан, прокурорын яллах дүгнэлт болон шүүхийн шийтгэх тогтоол, магадлал хуульд заасан шаардлагыг хангаагүй байна. Үүнд:*

1. *Прокурор яллах дүгнэлт үйлдэхдээ яллагдагчийн холбогдсон хэргийн агуулгыг хэт ерөнхий байдлаар товч бичиж, яллах нотлох баримтын агуулгыг огт дурьдахгүйгээр, нотлох баримтын зөвхөн эх сурвалжийг жагсаан бичиж агуулгыг нууцалсан нь яллагдагчийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйлд заасан "Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх" эрхийг зөрчсөнөөс гадна өөрийг нь буруутгаж буй нотлох баримттай танилцсанаар өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ бодитой хэрэгжүүлж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасны дагуу шинээр баримт сэлт гаргаж өгөх, өөрийг нь буруутгаж буй нотлох баримтыг шалгуулах, нэмж тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, яллах талын баримтыг няцаан үгүйсгэж мэтгэлцэх, эсхүл энэ хуулийн 17 дугаар бүлэгт заасан журмын дагуу гэм буруугаа хүлээн зөвшөөрч, өөрийн эрхзүйн байдлыг дээрдүүлсэн шийдвэр гаргуулах зэрэг яллагдагчид хуулиар олгогдсон эрхийг хязгаарлах үр дагавартай бөгөөд шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7, 34.14, 35.8 дүгээр зүйлд заасны дагуу прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд, яллах болон өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр шүүгдэгчийн гэм буруу хянан хэлэлцэж хэргийн бодит байдлыг тогтоох зарчимд сөргөөр нөлөөлөх болно.*

Иймд .... аймгийн прокурорын газрын хяналтын прокурор ..... бичсэн 2017 оны ..дугаар сарын ...-ний өдрийн .... дугаартай яллах дүгнэлт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй гэж үзэв.

2. *Прокурор яллах дүгнэлтдээ яллагдагч В-г "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн" гэж дүгнэн хэргийг 2015 оны Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт зааснаар зүйлчлэхдээ В нь хэзээ, хаана, хэний эсрэг, хэдэн удаа, ямар арга, хэлбэрээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, бусдад ямар хохирол учирсан, уг хэргийг хүндрүүлэх ямар шинж тогтоогдсон талаар огт дурьдаагүй байна. Иймд уг*

яллах дүгнэлтийг үндэслэн шүүгдэгч В-г гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэх хэргийг хянан хэлэлцэж хэргийн бодит байдлыг тогтоох боломжтой эсэхийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэж шийдвэрлэх нь зүйтэй.

3. *Давж заалдах шатны шүүх нь В-ийн гаргасан гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдлүүд нь цаг хугацааны хувьд 2011 оноос 2016 оны 8 дугаар сарын хооронд үйлдэгдсэн" гэж хэрэг үйлдэгдсэн хугацааны талаар анхан шатны шүүхээс өөр дүгнэлт хийсэн атлаа түүний үндэслэл болсон нотлох баримтын агуулга, уг баримтыг үнэн зөв гэж үзсэн үндэслэл болон няцаан үгүйсгэсэн эсрэг баримтын талаар ямар ч дүгнэлт хийгээгүй байх тул магадлалыг хууль ёсны ба үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй гэж үзэв.*

4. *Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан үйлдлийг 2015 оны Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хүндрүүлэн зүйлчлэхээр хуульчилсныг анхаарч В-ийн 2017 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өөрийн төрсөн дүү Ө-г хутгалж, эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан үйлдэл нь гэр бүлийн хүчирхийллийн шинжийг агуулсан эсэх, прокуророос уг хэргийг 2015 оны Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зүйлчилсэн нь зөв эсэх, түүнчлэн В нь гэр бүлийн хамаарал бүхий хэн хэний эсрэг, хэзээ, хаана, ямар хугацаанд, ямар хэлбэрээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хэнд ямар хохирол учруулсан, хэргийг хүндрүүлэн зүйлчлэх ямар шинж тогтоогдсон талаар прокурорын яллах дүгнэлтэд дурьдаагүй байхад энэ талаар шүүх дүгнэлт хийх боломжтой эсэхийг анхан шатны шүүх дахин хэлэлцэж, хууль зүйн дүгнэлт хийх шаардлагатай гэж дүгнэв.*

5. *Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 6966 тоот дүгнэлтэд "Ө-н биед чихэнд хатгагдсан шарх, сарвуунд зүсэгдсэн шарх гэмтэл тогтоогдлоо" гэсэн /хх-67/ байхад прокурорын яллах дүгнэлт болон анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдахшатны шүүхийн магадлалд "Шүүгдэгч В нь 2017 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өөрийн төрсөн дүү Ө-н хүзүүний баруун талд хутгалж эрүүл мэндэд нь хөнгөн хохирол санаатай учруулсан" гэж шинжээчийн дүгнэлтээс өөрөөр дүгнэсэн нь ойлгомжгүй, энэ талаар шүүх үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй.*

6. *Прокурорын яллах дүгнэлтийн тэмдэглэх хэсэгт яллагдагч В-г "ял шийтгэлгүй" гэж бичсэн боловч хавтаст хэргийн 93 дугаар хуудсанд авагдсан ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудсанд В-г "Баянгол дүүргийн шүүхийн 2000 оны .. шийтгэх тогтоолоор 3 жил хорих ял шийтгүүлж, уг ялыг тэнсэж, 2 жилийн хугацаагаар хянан харгалзсан, Баянгол дүүргийн шүүхийн 2010 оны .... шийтгэх тогтоолоор 2 жил хорих ял шийтгүүлж, уг ялыг тэнсэж, 1 жил 6 сарын хугацаагаар хянан харгалзаж байсан" гэж тэмдэглэжээ. Гэтэл Б.В-г дээр дурьдсан гэмт хэргүүдэд гэм буруутайд тооцож, ял оногдуулсан гэх шүүхийн шийдвэрүүд хавтаст хэрэгт байхгүй байна.*

Иймд Б.В нь урьд ял шийтгүүлсэн эсэхийг дахин шалгаж, холбогдох шүүхийн шийдвэрийг хэрэгт хавсарган, хувийн байдлыг сайтар шалгаж тогтоох нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан хэргийн талаар зайлшгүй нотолбол зохих асуудалд хамаарахаас гадна шүүдэгчийн гэм бурууд тохирсон эрүүгийн хариуцлага хүлээлгэж, албадлагын арга хэмжээ хэрэглэх асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой гэж үзнэ.

7. *Прокурорын яллах дүгнэлтийн тэмдэглэх хэсэгт яллагдагч В-г "хэрэг хариуцах чадвартай" гэж бичсэн байх боловч прокурор ямар баримтыг үндэслэн ийнхүү яллагдагчийн хувийн байдлыг тодорхойлсон нь ойлгомжгүй байна. Иймд яллагдагчийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлын талаар нэр бүхий гэрчүүдийн өгсөн мэдүүлэг болон яллагдагчийн төрсөн эгч Р нь сэтгэцийн хувьд хөнгөвтөр хэлбэрийн оюун ухааны хомсдол өвчтэй /хх-71/, дүү О нь сэтгэцийн хувьд хүндэвтэр хэлбэрийн оюун ухааны хомсдол, зан төрхийн өөрчлөлт өвчтэй /хх-69/, дүү Ө нь төрөлхийн оюун ухааны хөнгөн хомсдол, зан төрхийн өөрчлөлт өвчтэй /*

хх-73/ болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон ба энэ талаар тэдний төрсөн эх Ч "Ө, О, Р нар нь бүгд сэтгэцийн өвчтэй, өөрт тохиолдож буй явдлыг бусдад ойлгуулах ямар ч чадваргүй" гэж мэдүүлсэн /хх-31/ байдлыг харгалзан Б.В-ийн сэтгэцийн байдалд шинжилгээ хийлгэж, хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоолгох тухай асуудлыг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй.

Мөн .... нарыг хохирогчоор, мөн тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлж хамгаалах хүнийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогоогүй байна.

Шүүхийн шийдвэрт сөргөөр нөлөөлж болох дээр дурьдсан мөрдөн байцаалтын дутуу ажиллагааг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжтой эсэх, уг мөрдөн шалгах ажиллагааны үр дүн нь хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, хэргийн зүйлчлэлд ноцтойгоор нөлөөлөх эсэх асуудлыг анхан шатны шүүх хуульд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлээгүй, энэ талаар давж заалдах шатны шүүх хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд үндэслэл бүхий дүгнэлт хийхгүйгээр хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь буруу байх тул шийтгэх тогтоол болон магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатнаас дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Улсын яллагчийн дүгнэлтийн хэлбэр, гэм буруутайг дүгнэж байгаа улсын яллагчийн дүгнэлтийн бүтэц

Улсын яллагчийн дүгнэлт нь гэм буруугийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн 2 хэлбэртэй байна. Энэ хүрээнд бид бүхэн улсын яллагчийн гэм буруугийн дүгнэлтийн талаар үзэх бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх дүгнэлтийг хойно үзэх болно.

Гэм буруутайг дүгнэж байгаа улсын яллагчийн дүгнэлт үнэмшилтэй, нотлох баримтанд тулгуурласан, логиктой, хууль зүйн үндэслэлтэй байх ёстой бөгөөд бичгэн хэлбэрээрээ удиртгал, хэргийн байдал, нотолгоо, хууль зүйн үндэслэл гэсэн бүтэцтэй байх ба эдгээрт дор дурдсан агуулгыг тусгана. Үүнд:

1. Удиртгал хэсэгт: хэнд холбогдох ямар гэмт хэргийг яллахаар ямар хуулийн аль зүйл, хэсгийг баримтлан улсын яллагчаар оролцож байгаа талаар дурдана. Ингэхдээ эхлэл сайн байх нь танхимд байгаа хүмүүст өөрийнхөө үгийг бүрэн дүүрэн сонсгоход чухал ач холбогдолтой гэдгийг санах хэрэгтэй.
2. Хэргийн байдалд: шүүгдэгч нь хаана, хэдийд, ямар гэмт хэргийг хэрхэн үйлдсэн, гэмт хэргийн шинж, гэм буруугийн хэлбэр, сэдэлт, санаа, зорилго, шалтгаан нөхцөл, учруулсан хохирол, хор уршиг, шүүгдэгч, хохирогчийн хувийн байдлын талаар бичнэ.
3. Нотолгоо хэсэгт: үйлдсэн гэмт хэрэг нь хэрэг цугларсан болон шүүхийн хэлэлцүүлгийн үед шинжлэн судлагдсан ямар нотлох баримтуудаар хэрхэн нотлогдож байгаа талаар тодорхойлон бичнэ.
4. Хэргийн онол буюу яллах дүгнэлтэндээ нийцүүлж хэргийг зүйлчлэх болсон хууль зүйн үндэслэлийг хууль тогтоомжуудыг удирдлага болгон дэлгэрэнгүй дүгнэх, бусад ойролцоо төрлийн гэмт хэргүүдээс ялгагдах шинжүүд, онцлогийн талаар дүгнэлт өгөх.

Нэмэлт тайлбарын хэсэг: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт хэлж дуусаны дараа дүгнэлтэд заасан зүйлийн талаар харилцан тус бүр нэг удаа тайлбар хэлж болно." гэж заасны дагуу улсын яллагчийн дүгнэлтийн талаар өмгөөлөгч гэм буруугийн асуудалд саналын зөрөөтэй дүгнэлт танилцуулсны дараа өмгөөлөгчийн дүгнэлт, хэргийн онолыг няцаах явдал маш чухал юм.

ДЭД СЭДЭВ 3. Шүүх хуралдааны өмнө хохирогчийг бэлтгэх

Шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд гэрч, хохирогч нарын гүйцэтгэх үүрэг улс бүрт харилцан адилгүй байдаг. Зарим улсад тэд зөвхөн мэдээллийн эх сурвалж болдог бол зарим оронд гэрч, хохирогч нь шүүхээр хэрэг хянан хэлэлцэх ажиллагааны нэг тал болж, биечлэн, эсхүл өмгөөлөгчөөрөө төлөөлүүлэн оролцдогийн хувьд шүүн таслах ажиллагааны бүх үе шатанд идэвхтэй оролцдог. Мөрдөн байцаах, яллах болон шүүхийн шатанд гэрч,

хохирогчийн хамтран ажиллах хүсэл нь тэдэнд тулгарсан шаардлага, хэрэгцээ, хохирлоо нөхөн төлүүлж, дэмжлэг авах баталгааг хангаж чадахуйц эрх зүйн тогтолцооноос ихээхэн шалтгаалдаг байна.[85]

Жендэрт суурилсан хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчтой ажиллахад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд онцгойлон анхаарах шаардлагатай. Бусдад байтугай өөртөө ч итгэх итгэлгүй болсон хохирогчийн үзэл бодол, хэрэгцээ шаардлагыг прокурорын зүгээс ойлгож дэмжин, хүндэтгэлтэй харилцаж, тэдэнд аюулгүй нөхцөл, хамгаалалтад байгаа итгэл, хуулийн байгууллагатай хамтран ажиллах сэдлийг төрүүлэх нь хохирогч төвтэй яллах ажиллагааны гол стратеги байх учиртай.[86]

Сонгодог мэтгэлцээний тогтолцоо бүхий АНУ, Англи зэрэг улс орнуудад хохирогч нь процесс ажиллагааны оролцогч талд тооцогддоггүй буюу шүүх хуралдаанд гэрчээр дуудагддаг, прокурор нь хохирогчийг төлөөлсөн маягаар биш Төрийн нэрийн өмнөөс ажилладаг онцлогтой.[87] Мөн дээрх орнуудын шүүх нь "цуглуулсан цаас"-нд анхаарахаасаа илүү, тангараг өргөсөн амьд гэрчийн мэдүүлэг, хөдөлбөргүй баримтад тулгуурласан мэтгэлцээний явцад аль илүү итгэл үнэмшил төрүүлж, ятган сэнхрүүлж байгаа талд нь итгэж, өчүүхэн төдий эргэлзээ төрсөн бол "хэрэгтнийг" гэм буруугүйд тооцох шийдвэрийг гаргадаг. Тиймээс тухайн орнуудад зөвхөн гэр бүлийн хэргийн хохирогч төдийгүй хүн худалдаалах, хүчиндэх зэрэг хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчтой прокурор нь шүүх хуралдаан эхлэхээс өмнө тусгайлан уулзаж, хохирогчийг шүүх хуралдаанд биечлэн мэдүүлэг өгөхөд тусламж, мэдээлэл өгч, сэтгэл зүйн хувьд бэлтгэж, шүүх хуралдааны үед түүний аюулгүй байдлыг хангах арга зам болон хэргийг яллах ажиллагааны арга тактикаа тодорхойлдог байна.

Монгол улс ч мөн шүүх хуралдааныг мэтгэлцэх зарчмаар явуулахыг хуулиар баталгаажуулсан[88] орны хувьд прокурор нь шүүх хуралдааны өмнө энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг бэлтгэх ажиллагааг зайлшгүй хийх нь практик ач холбогдолтой. Хохирогч хүндэтгэн үзэх шалтгаанаар үнэхээр шүүх хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд техникийн дэвшлийг ашиглан видео мэдүүлэг авах зэрэг арга хэрэгслийг ашиглахаас гадна бусад нотлох баримтад тулгуурлан яллах ажиллагааг явуулах нь зүйн хэрэг.

3.2.3.1 Зураг. Прокурор нь хохирогчийг шүүх хуралдаанд оролцохоос өмнө сэтгэл зүйн хувьд бэлтгэх шаардлагатай.

Прокурор ГБХ-ийн хэргийн хохирогчийг шүүх хуралдааны өмнө сэтгэл зүйн хувьд бэлтгэх нь хохирогчийн зүгээс итгэлтэй, тайван байж шүүх хуралдаанд оролцох, хэргийг үнэн зөв шийдвэрлэх, хохирогчийн эрх ашгийг хамгаалах, нөхөн сэргээхэд чухал ач холбогдолтой.

ГБХ-ийн гэмт хэрэг нь ихэвчлэн гэр бүлийн орчинд үйлдэгддэг, гэр бүлийн аль нэг гишүүн нь хохирогч болж байдаг, мөн хохирогч нь шууд болон шууд бусаар хүчирхийлэгчийн эдийн засгийн хараат байдал, элдэв нөлөө, дарамт, шахалтын дор удаан хугацаагаар байснаас сэтгэл гутрал, депресстэй болсон байдаг ба хохирогч хуулийн байгууллагад хандвал хүчирхийлэгч этгээдийн зүгээс үзүүлэх түрэмгийлэл, доромжлол улам ихсэх байх, хуулийн байгууллага туслалцаа үзүүлж шударгаар ажиллаж чадахгүй буюу хүчирхийлэгч этгээд хариуцлагаас мултраад гарна гэсэн айдас түгшүүрт автсан байдаг

85 "Гэмт хэргийн хохирогч", Олон улсын прокуроруудын холбоо, 2007, хуудас 2.

86 Criminal justice handbook series: "Handbook on effective prosecution responses to violence against women and girls", Part Two. Effective responses in cases involving violence against women and girls: the role of prosecutor, p41, UN, New York, 2014, http://www.unodB.org/documents/justice-and-prison-reform/Handbook_on_effective_prosecution_responses_to_violence_against_women_and_girls.pdf

87 See above, p47.

88 Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, http://www.legalinfo.mn/law/details/59

зэрэг нь бусад төрлийн гэмт хэргийн хохирогчоос ялгагдах шинжийн нэг юм.[89] Түүнчлэн хохирогч мөрдөгчид дахин дахин дуудагдах, шүүх эмнэлэгт үзүүлэх, шүүх хуралдаанд мэдүүлэг өгөх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урт удаан процесс ажиллагаанаас хүртэл айх айдастай, хүүхдүүдийнхээ аюулгүй байдалд түгшсэн зэрэг байдалтай байдаг.

Хохирогчийн энэхүү онцлог шинж нь түүнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед эдлэх эрх, үүргээ хуульд заасны дагуу хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээгээр саад тотгор болж байдаг тул прокурорын зүгээс хохирогчийг цаг алдалгүй хамгаалж, шаардлагатай эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж байгаа эсэх, тухайн хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ямар ажиллагаа хийгдээд байгаа, ямар үе шатандаа явж байгаа зэрэг мэдээллийг тухай бүр өгч хохирогчийг мэдээлэлтэй байлгахад хяналт тавьж, яллагдагчийг цагдан хориулах, хэргийн шийдвэрлэлтийг түргэсгэхэд анхаарах нь зүйтэй. Зарим оронд ГБХ-ийн холбогдогч этгээдэд цагдан хорих арга хэмжээг зайлшгүй авахыг (mandatory arrest) хуульчилсан байдаг[90]боловч тийнхүү цагдан хорих нь хохирогчийн аюулгүй байдал, мөн хүчирхийлэгч этгээдийн цаашдын амьдрал, нэр хүндэд хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг сайтар харгалзан үзэх хэрэгтэй.

> "Эмэгтэйг хаалгаар дөнгөж оронгуут л нөхөр нь түүнийг хаалга мөргөж унатал алгадсан. Өөрийгөө хамгаалж чадахгүй болтол нь гурав, дөрвөн удаа тийрсэн. Дараа нь цаасны хутгаар хувцсыг нь зүсэж, "хувцасгүй хаачих юм бэ, чи одоо хаашаа ч явж чадахгүй." гэж хэлсэн. Эмэгтэй юу ч хийж чадахгүй болсон. Мөрдөн шалгах явцад найз нөхдөөс нь асуухад бүгд л ГБХ өмнө нь байсан талаар ярьсан....эмэгтэй биднийг дуудсан үед ирж мэдүүлэг өгч байсан. Удалгүй хэрэг шүүхэд шилжсэн" гэж цагдаагийн ажилтан ярьсан. "Хохирогч эмэгтэй одоо хүчирхийлэлгүй, тайван сайхан амьдарч байгаа" гэж цагдаагийн ажилтан нэмж хэлсэн ."Хэрвээ хохирогч мэдүүлэг өгөхгүй л бол хангалттай баримт байхгүй учраас хэргийг шүүхээр шийдвэрлэх боломжгүй" гэж прокурор хэлсэн. "Хохирогч заавал мэдүүлэг өгөх ёстой, үгүй бол хэргийг шийдэхэд хэцүү болно" гэж тэрээр тодруулга хийсэн.[91]

Хэдийгээр хавтаст хэрэгт мэдүүлэг нь авагдсан хэдий ч хохирогч биечлэн шүүх хуралдаанд оролцох нь хэргийг амжилттай яллах, тодруулбал, хэргийг шүүх шийдвэрлэснээр хүчирхийлэл үйлдэгч этгээдийг ял завшихаас сэргийлэх, дахин давтан үйлдэгдэж ирсэн хүчирхийллийг таслан зогсоох ач холбогдолтой. Тиймээс хохирогчийн сэтгэл санаа, эрүүл мэнд хэвийн байдалд орж, амар амгалан, эрүүл саруул амьдрах, тийнхүү амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд хууль, шүүхийн байгууллага туслалцаа үзүүлэх хууль зүйн боломжтой болохыг хохирогчид сайтар ойлгуулах, үүнд хохирогчийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчтэй хамтран ажиллах нь чухал.

ГБХ-ийн гэмт хэргийн онцлог шинж байдалтай уг гэмт хэргийн яллах ажиллагаа салшгүй уялдаатай болохыг өмнө дурдсан. Энэ төрлийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлүүлэхийн тулд улсын яллагч зохих бэлтгэл ажиллагааг сайтар хангасан байвал зохино. Тодруулбал, ГБХ үйлдэх гэмт хэргийн

89 Criminal justice handbook series: "Handbook on effective prosecution responses to violence against women and girls", Part Two. Effective responses in cases involving violence against women and girls: the role of prosecutor, p43, UN, New York, 2014, http://www.unodB.org/documents/justice-and-prison-reform/Handbook_on_effective_prosecution_responses_to_violence_against_women_and_girls.pdf

90 https://opsvaw.as.uky.edu/sites/default/files/05_Mandatory_Arrest.pdf

91 "ГБХ-тэй тэмцэх хууль, Монгол улс", Хүний эрхийн тайлан, 2014, хуудас 57, http://www.stopvaw.org/uploads/dv_law_monitoring_report_-_mongolian_version.pdf

талаар дуудлага, гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага хүлээн авч, шалгах үеэс прокурорын хяналтыг тасралтгүй, шуурхай тавьж, улсын яллагчийн хувьд хохирогчийн, цаашилбал нийтийн эрх ашиг, сонирхлыг шүүхэд хууль ёсоор төлөөлөх, хамгаалах эрх бүхий субъект гэдгээ мэдүүлэг авах үеэс эхлэн хохирогчид ойлгуулах, түүнд хуулийн байгууллагаас айх айдсыг бус, итгэл найдварыг төрүүлж, болсон хэрэг, нөхцөл байдлын талаар бүрэн төгс судалж мэдэрсэн, бэлтгэгдсэн байх шаардлагатай.

Олон улсын прокуроруудын холбооноос АНУ-ын Муж улсуудын Шүүхийн үндэсний төвтэй хамтран гэмт хэргийн хохирогчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр 22 орны прокурорын байгууллагыг хамруулсан судалгааг хийжээ. Уг судалгаагаар, 22 орны 19 нь буюу дийлэнх прокурорын газар гэрч, хохирогчийг эрүүгийн хэрэг шалгах процедуртай танилцуулдаг байна. Тухайлбал, Норвегид үүнийг өмгөөлөгчөөр нь дамжуулан хийдэг, Умард Ирландын прокуроруд хохирогчийг эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоотой цахим хэлбэрээр танилцуулдаг. Ингэхдээ Гэмт хэргийн хохирогчдыг дэмжих байгууллага, Хүүхдийн хүчирхийллийг таслан зогсоох үндэсний нийгэмлэг зэрэг мэргэжлийн байгууллагатай хамтран шүүх дээр очиж, шүүх орчинтой танилцах байдлаар хохирогчийг шүүх хуралд оролцоход урьдчилан бэлтгэдэг байна.

Бусад ихэнх оронд шүүх хуралдаан эхлэхийн өмнө гэрч, хохирогчид процедурын талаар, мөн эдлэх эрх, статусын талаар прокурор нь тайлбарлаж өгөх үүрэгтэй байдаг бөгөөд тийнхүү танилцуулсан эсэхийг шүүгч шүүх хурлын үед мөн хянаж үздэг байна.[92] Өөрөөр хэлбэл, улсын яллагч яллах талын гэрч, хохирогч, шинжээч нартай шүүх хуралдааны өмнө ганцаарчлан уулзах, ялангуяа, анх удаа шүүх хуралдаанд оролцох гэж буй хохирогчид шүүн таслах ажиллагаа ямар процедураар явагддаг, хэн хэн оролцдог, шүүх хуралдааны уур амьсгалын талаар, шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн талаас ямар асуулт, дайралтууд ирж болох, түүнд хохирогч бэлэн байж, өөрийн сэтгэл зүйг хэрхэн удирдах, шүүх хуралдааны үед хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах ямар арга, боломжууд байдаг талаар мэдээлэл, зөвлөгөө өгдөг байх нь хохирогчийг ямар нэг айдас, дарамтгүйгээр хуулийн байгууллагад итгэж, шүүх хуралдааны үед өөртөө итгэлтэй, тайван байхад тустай байдаг байна.

Иймд ГБХ-ийн хэргийг нотлох ажиллагааг дан ганц хохирогчийн байцаалтад тулгуурлах бус, хохирогчийн хохирсон байдлыг нотлох эд мөрийн баримт, шинжээчийн дүгнэлт, бусад гэрчийн мэдүүлэг зэрэг бусад нотлох баримтуудыг цуглуулахад чиглүүлэх, шүүх хуралдаанд оролцож мэдүүлэг өгөхөд хохирогчийг эрүүл мэнд, сэтгэл зүйн хувьд болон аюулгүй байдал зэрэг бусад талаар бэлтгэгдсэн эсэхийг прокурор заавал нягтлах хэрэгтэй.

Хохирогч нас барсан тохиолдолд ч түүнийг төлөөлөн хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдсон этгээдийг шүүх хуралдааны өмнө сэтгэл зүйн хувьд сайтар бэлтгэх нь чухал. Ялангуяа, ГБХ-ийн улмаас хохирсон этгээдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх болон аюулын зэргийн түвшин тогтоох, хохирогчийн сэтгэцэд ямар нэг өөрчлөлт орсон эсэх талаар шинжээчийн дүгнэлтийг заавал гаргуулсан байх шаардлагатай. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь бие махбодын болон сэтгэл санааны зовлон шаналалд давхар автагдсан байдгаас хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэргэжлийн сэтгэл зүйчийг байнга оролцуулж, хохирогчийн сэтгэл зүйг тогтворжуулж, хэвийн байдалд оруулах талаас нь анхааран эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэхэд хохирол, гэм хорын асуудлыг шүүхээр нэг мөр давхар шийдвэрлүүлэхэд анхаарвал зохино.

1985 онд батлагдсан НҮБ-ын "Гэмт хэргийн хохирогч нарт зориулсан шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмуудын тунхаглал"[93]-д гэрч, хохирогч нарын эрх, эрх ашгийг хамгаалахаас гадна тэдэнд хуулийн байгууллагатай хамтран ажиллахад нь

92 "Гэмт хэргийн хохирогч", Олон улсын прокуроруудын холбоо, 2007, 7 тал

93 Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power, UN, General Assemby, A/RES/40/34, 29 November 1985, http://www.un.org/documents/ga/res/40/a40r034.htm

дарамт, шахалт үзүүлэхгүй байхыг хангаж өгсөн 21 зарчмыг тодорхойлсон. 2005 онд НҮБ-аас баталсан "Гэмт хэргийн хохирогч, гэрч болсон хүүхэдтэй ажиллах удирдамж"[94]-нд эрүүгийн шүүн таслах ажиллагааны явцад гэрч, хохирогч болсон хүүхдийг, ялангуяа, жендэрт суурилсан хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болсон охидыг хамгаалж, шаардлагатай туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах талаар заасан.

Прокурор нь хохирогчтой хийх уулзалтын үеэр болсон хэргийн талаар дахин давтан яриулах, тодруулах, хуульд заасан эрх үүргийг сануулах зэргээр хэт албаны, хөндий байдлаар харилцахаас зайлсхийж, харин түүний эрүүл мэнд, аюулгүй байдал болон шүүх хуралдаанд оролцох эсэх, оролцсон тохиолдолд шүүх хуралдааны уур амьсгал, үе шат ямар байдаг, ямар байж болох талаар энгийн байдлаар ярилцаж, ярилцлагын үеэр сэтгэл зүйн эерэг харилцааг үүсгэн, хохирогчийн өөртөө болон хуулийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд анхаарна.

Түүнчлэн шүүх хуралдааны үед хохирогчийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хамгаалах асуудал онцгой чухал байна. Тухайлбал, хохирогч шүүх хуралдаанд биечлэн оролцож, мэдүүлэг өгч байгаа нөхцөлд шүүгдэгчийн шууд өөдөөс аль болох харах боломжгүй газраас мэдүүлэг өгөх, боломжтой бол видеогоор, эсхүл хамгаалалтын хаалтны цаанаас мэдүүлэг өгүүлэх, дуу дүрсийг шүүгдэгчид танигдах бололцоогүйгээр өөрчлөх зэргээр техникийн дэвшлийг түлхүү ашиглах боломжтой.

Мөн гэмт хэргийн үргэлжилсэн цаг хугацаа, давтамж, үйлдэгдсэн газар орон бүрэн шалгагдаж тогтоогдсон эсэх, хэргийн улмаас хохирогчоор тогтоогдсон этгээдээс гадна хүүхэд, гэр бүлийн бусад гишүүд, ах дүү, хамаатан садан, өөр бусад этгээд давхар хохирсон эсэх, хохирогчид учирсан хохирол нь амь бие, эрүүл мэнд, сэтгэл санаа, эд хөрөнгийн ямар төрөл, хэмжээтэй хохирол учирсан болох, учирсан хохирлыг арилгах, эмчлэх, нөхөн төлөх талаар ямар арга хэмжээ авсан, эрүүл мэнд, нийгэм хамгааллын ямар байгууллагуудтай хэрхэн хамтран ажилласан, ямар үр дүнд хүрсэн, гэрч, хохирогчийн болон хүчирхийлэгч этгээдийн хэн, алины хуулиар хамгаалагдсан, эрх, үүрэг нь мөрдөн байцаалтын шатанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүрэн хэрэгжсэн эсэх, тухайлбал, яллах талын гэрч, хохирогчийн аюулгүй байдал цаг тухайдаа найдвартай хамгаалагдсан эсэх, хэрэв хамгаалагдаж чадаагүй бол гэрч, хохирогч бусдын нөлөөнд автсан, дарамт шахалтанд орсон эсэх зэргийг прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө сайтар нягталсан байх нь зүйтэй.

Хохирогчийн эрх, үүрэг, хариуцлага.[95]

Эрх:
- өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах,
- баримт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах,
- шүүхийн хэлэлцүүлэгт оролцох,
- шүүх, прокурор, мөрдөгчийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах,
- гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах, аюулгүй байдлаа хамгаалуулах туслалцаа авах, мэдээллээр хангуулах эрхтэй

Үүрэг:
- шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирэх,
- хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх,
- өөрт илэрхий болсон хэргийн талаарх мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй

Хариуцлага:
Мэдүүлэг өгөхөөс санаатайгаар татгалзсан, зайлсхийсэн, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг.

Тухайлбал, 2018 онд шүүхээс хохирогчийн мэдүүлэгтэй холбоотойгоор 3 хэрэг буцсан байх ба үндэслэл нь анхан шатны шүүх хурлын явцад хохирогч "намайг зодож, бэлгийн хүчирхийлэл үйлдээгүй, огт тийм зүйл болоогүй" гэж мэдүүлсэн ба "яллагдагчийн нөлөөнд орсоноос шүүх

94 UN guidelines on Justice in Matters involving Child victims and Witnesses of Crime , UN Resolution 2005/20,https://www.unodB.org/pdf/criminal_justice/Guidelines_on_Justice_in_Matters_involving_Child_Victims_and_Witnesses_of_Crime.pdf

95 Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 42 дугаар зүйл, http://www.legalinfo.mn/law/details/59

дээр мэдүүлгээс буцсан" гэж сүүлд нь тайлбарласан байна. Гэтэл дээрх хэргүүдэд хохирогчийг хамгаалах талаар ямар нэг арга хэмжээ аваагүй, мөрдөгч, прокуроос хохирогч аюул заналд өртсөн байж болох нөхцөл байдлыг ойшоолгүйгээр зөвхөн хэргийн шийдвэрлэлтэнд анхаарчээ. Мөн прокурор нь шүүх хурал дээр хохирогчийг анх удаа харсан, түүнд учирсан эрдсэл бүхий нөхцөл байдлын талаар мэдээгүй байжээ.

Т.У-д холбогдох №180600..... дугаартай, ЭХ-ийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7, 2.8 дах заалтаар зүйлчилсэн эрүүгийн хэргийг анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар буцаахдаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алсан гэх зүйлчлэл эргэлзээтэй, хохирогч өөрөө гэр бүлийн хүчирхийлэлд байсан, нотолбол зохих байдлыг бүрэн гүйцэд тогтоогоогүй гэсэн үндэслэлээр буцаасныг хүлээн авч шийдвэрлэжээ.

Дасгал 1.

Дараах нөхцөл байдалд прокурор хохирогчийг шүүх хуралдаанд мэдүүлэг өгөхөд хэрхэн бэлтгэхийг тодорхойлно уу. Хохирогч ямар нөхцөл байдалд мэдүүлгээ үнэн зөв, бодитой өгөх боломжтойг тооцоолоорой.

1. *Хохирогч шүүх хуралдаанд оролцохгүй гэдгээ илэрхийлсэн. Прокурорын хувьд та яах вэ?*
2. *Хохирогч шүүх хуралдаанд ирсэн боловч хүчирхийлэгч этгээдтэй эргэн амьдрах болсон, хариуцлагаас чөлөөлөхийг хүсч байгаа, шүүх хуралдаанд мэдүүлэг өгөхгүй гэсэн. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?*
3. *Хохирогч шүүх хуралдаанд ирсэн боловч тэр өдөр юу болсон талаар юу ч санахгүй байна гэсэн.*

ДЭД СЭДЭВ 4. Шүүх хуралдааны үед тавигдах асуултыг урьдчилан бэлтгэх

Улсын яллагч шүүх хуралд орохын өмнө ГБХ үйлдэгч, өөрөөр хэлбэл шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн тавигдах боломжтой асуулт, хариултуудыг урьдчилан төсөөлж, тэдгээрийг няцаах хариултыг бэлтгэсэн байх шаардлагатай. Улсын яллагчийн зүгээс асуултуудаа бэлтгэхдээ дараах зүйлсийг анхаарвал зохино. Үүнд:

- хохирогчийн сэтгэл зүйн онцлогт тохируулсан, хүссэн хариултуудыг авах боломжтой асуулт асуух,
- хүчирхийлэгч этгээдийн үйлдэл болон хохирогчид учирсан эрүүл мэнд, бие махбод, сэтгэлийн шаналалын хоорондох шалтгаант холбоог нарийвчлан гаргахад түлхүү анхааран асуух,
- шинжээч болон сэтгэл зүйчээс хүчирхийллийн улмаас хохирогчийн сэтгэцэд орсон өөрчлөлт, шинж тэмдгүүд нь хохирогч цаашид хэвийн ажиллаж, амьдрахад нь хэрхэн нөлөөлөх, эдгэрэх боломжтой эсэх, ямар хугацаанд эдгэрэх буюу хөдөлмөрийн чадварт нь хэрхэн нөлөөлсөн талаар шинжээчийн дүгнэлтэд үндэслэж, гэм хорын асуудлыг хэрхэн ямар арга замаар шийдвэрлэж болохыг тодруулж асуух зэрэгт бэлтгэсэн байна.

Прокурор ГБХ-ийн хэргийн шүүх хуралдаанд шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчээс асуух асуулт, тэдгээрийн мэдүүлэгт өгөх няцаалтыг урьдчилан бэлтгэх нь яллах ажиллагаа амжилттай явагдах нөхцөл болно.

ГБХ-д суурилсан гэмт хэргийн шүүх хуралдааны үед тавигдах асуултыг урьдчилан бэлтгэх үйл ажиллагааны нэг хэсэг нь гэрч, хохирогчийг мөн шүүгдэгчийн талын асуултад хариулахад бэлтгэх явдал юм. Ингэхдээ мөн шүүгдэгчийн талаас тавигдах асуултыг төсөөлж, хохирогчид дараах байдлаар тайлбарлаж өгөх боломжтой:

- шүүгдэгчийн өмгөөлөгчийн зүгээс хөтөлсөн, тулгасан асуулт хэрхэн тавих боломжтой,
- түүнд хариулахдаа асуулт бүрийг анхааралтай сонсож, үнэнээр хариулах, шаардлагатай бол тодруулахыг хүсэх хэрэгтэй,
- асуулт нь бодит байдалд тохироогүй буюу үнэн зөв биш байвал шүүгдэгчийн өмгөөлөгчтэй санал нийлэхгүй байгаагаа

илэрхийлэх боломжтой,

- нэмэлт өөр мэдээлэл өгөхгүйгээр зөвхөн тавигдсан асуултад хариулах хэрэгтэй гэх мэт.

?

- *Асуултыг бэлтгэх: яллах болон цагаатгах талын, хэрэгт ач холбогдол бүхий асуултыг гэрч, хохирогч, шинжээчид тавих*
- *Асуултын хариултыг урьдчилан төсөөлж бэлтгэх: тусгай мэдлэгийн хүрээнд хариулагдах боломжтой буюу танин мэдэхүйн шинжтэй асуултыг шүүх хуралдааны үеэр асуух эсэхээ төлөвлөх*
- *Асуултын төрлүүд: энгийн, мэргэжлийн, зорилготой, зорилгогүй, нээлттэй, хаалттай, няцаасан, лавласан гэх мэт.*
- *Шүүх хуралдааны үед тавигдах боломжгүй асуултууд: өмгөөлөх талаас тулгасан, хөтөлсөн, хэрэгт хамааралгүй, хууль бус зэрэг асуулт тавигдсан нөхцөлд улсын яллагч эсэргүүцэл илэрхийлж таслан зогсоох*
- *Асуултын үр дүн, хариултаас хамааран санал гаргах: хуралдаанд оролцогчоос шүүхэд шинээр гаргаж өгсөн баримтыг үнэлж дүгнэх, шинжилгээ хийлгэх, эд мөрийн баримтад үзлэг хийх, туршилт хийлгэх, шүүх хуралдааныг хойшлуулах, үргэлжлүүлэх, нээлттэй, хаалттай явуулах зэрэг.*

Дасгал 3.

Тохиолдол

А хар багаасаа ганцаараа хоцорсон ч угийн ухаан сэргэлэн, зүс царай сайтай охин тул их сургуульд элсэн суралцаж, төгссөн. Их сургуулийн нөгөө ангийн Ж-тэй танилцаад удалгүй хуримаа нижгэр тэмдэглэн, сургуулиа төгссөн жилээ өрх тусгаарлажээ. Дараа жил нь буюу 2017 оны намар нэгэн хөөрхөн хүүтэй болсон. Ж нь ээж аавынхаа буянаар дээд боловсрол эзэмшиж, гадаад дотоодод ч их явсан. Гэр бүлээрээ эхлүүлсэн хувийн бизнесээ өргөжүүлэхээр. А-г татан оролцуулж, менежерээ болгожээ. А өөрийн мэргэжлээр ажиллах сонирхолтой гэдгээ хэлэхийг хүссэн боловч Ж болон хадам ээж нар нь А-г хамт ажиллах нь гэр бүлдээ тустай гэсэн тул нэг их цааргалсангүй. Компанийн ажил ихтэй тул А-г ар гэрийн ажил, бяцхан хүүгээ асрахад түүний хүү 7 настай Б тун их тус дэмтэй. Ж харин гадаад явах нь ихэсч, гэрийнхэндээ анхаарал тавих нь багасчээ. Хааяа архи уудаг нь ч нэмэгдэж, уухаараа танигдахын аргагүй аашлахад А, Б хоёрын арга тасардаг боллоо.

2018 оны 5 дугаар сарын 5-6-нд шилжих шөнө 03.00 цагийн орчим Гэмтэл согог сэргээх үндэсний төвд 7 настай эрэгтэй Б ухаан алдсан байдалтай хүргэгдэн ирсэн талаарх мэдээлэл цагдаагийн байгууллагад ирсэн. Улмаар эмчилгээ хийлгэж ухаан оролгүй байсаар 2018 оны 5 дугаар сарын 6-ны өглөө 07.00 цагт нас барсан байна.

Хэргийн газар цагдаагийн ажилтнууд очих үед А нь 8 сартай хүүгийн хамт уйлсан, маш их айж сандарсан байдалтай байсан. Хэргийн газрын үзлэгийн тэмдэглэлд, гэр доторх байдал нь эмх цэгцтэй, ямар нэгэн хэрүүл зодоон болсон гэх шинж тэмдэг байхгүй, харин хогийн савнаас цус мэт зүйлээр бохирлогдсон ариун цэврийн цаас 4 ширхэг гарч ирсэн.

Талийгаачийн цогцсонд үзлэг, задлан шинжилгээ бүрэн хийгдсэн. Цогцосны үзлэгээр талийгаачийн биед 20 гаруй хөхрөлт, няцралт, хоолойнд боолт орсон оромтой, нүдэнд нь цэгчилсэн харвалт үүссэн байсан. Задлан шинжилгээгээр, 9 хавирга хугарсан, элгэнд хавирганы оромнууд үүссэн, тархинд цус харвалттай гэмтлүүд үүссэн. Талийгаачийн үхлийн шалтгаан нь тархины цус харвалт, гэмтлийн шокын улмаас нас барсан болох талаар шинжээчийн дүгнэлт гарсан.

?

1. *Шүүх хуралдаан болохоос өмнө буюу прокурорын хяналтын шатанд хохирогчтой хийх уулзалтад юуг, яагаад анхаарах талаар прокурорт зориулсан санамж гаргана уу.*
2. *Шүүх хуралдааны үед улсын яллагчийн зүгээс хохирогч, гэрч, шинжээч, шүүгдэгчид тавих тус бүр 2-3 асуулт гаргана уу.*
3. *Тавьсан асуулт тань оновчтой эсэхийг ямар шалгуураар үнэлэх вэ?*

ДЭД СЭДЭВ 5. ГБХ–ийн хэрэгт улсын яллагчийн дүгнэлт хэлэхэд анхаарах асуудал

Шүүх хуралдааны улсын яллагчийн дүгнэлт танилцуулах үе шат нь шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахаас өмнө буюу шүүгч зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө талууд шүүх хуралдаанд хэлэлцсэн нотлох баримтуудыг дүгнэж, яллах ба цагаатгах нотлох баримтын талаар шүүхийн өмнө мэтгэлцэн, хэргийн байдлыг тал бүрээс нь тодруулж шүүгчийг ятгуулан үнэмшүүлж өөрийн шийдвэр, байр суурийг баталгаажуулах ач холбогдолтой байдаг. Өөрөөр хэлбэл дүгнэлт танилцуулах үед хэлэх үг нь хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор логик, дэс дараалалтайгаар гаргаж тавих, нотлох, итгүүлэн үнэмшүүлэх, сэтгэл зүйн нөлөө үзүүлэх гэсэн үндсэн чиг үүргүүдтэй бөгөөд энэ үед хэлэх үг нь агуулга, чиглэлээрээ нотолгооны хүчтэй хэрэгсэл болдог.

!

ГБХ-ийн хэргийн шүүх хуралдаанд тавих улсын яллагчийн дүгнэлт нь энэ төрлийн хэргийг амжилттай яллахад түлхэц болох чухал үе шат байдаг.

ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааны үед улсын яллагчийн дүгнэлт хэлэхэд анхаарах зүйл нь бусад хэргийн үед тавигдах шаардлагаас төдийлөн ялгагдах зүйлгүй. Улсын яллагчийн дүгнэлтийг эсрэг тал буюу шүүгдэгчийн өмгөөлөгч няцаасан тохиолдолд улсын яллагч нотлох баримтад тулгуурлан үндэслэл бүхий тайлбар хийх нь энэ төрлийн хэргийг амжилттай яллахад түлхэц болох чухал үе шат байдаг. Тийнхүү тайлбар хийх үед ГБХ-ийн хэргийн талаар хэрэгт тулгуурлан, оновчтой байдлаар шүүх бүрэлдэхүүнээс гадна хуралдааны танхимд сууж байгаа нийт оролцогч, хүмүүст хандан үг хэлэх, уг хэргийн нийгэмд учруулж байгаа хор уршгийг тайлбарлан таниулах боломжтой юм.

Хохирогч сэтгэцийн өвчин туссан талаар улсын яллагчийн дүгнэлтийн үед хэрхэн ярих вэ?

- Хохирогч хэрэв ГБХ-ийн хэргийн улмаас сэтгэцийн өвчин туссан, сэтгэцэд нь тодорхой хэмжээний өөрчлөлт орсон бол ямар нөхцөл байдлын улмаас тийм өвчтэй болсныг шүүх бүрэлдэхүүнд дахин нэг сануулна.
- Хохирогч сэтгэцийн өвчтэй болсон нь шүүх эмнэлгийн дүгнэлтээр хэрхэн баталгаажин нотлогдож байгаа болохыг шүүх танхимд ойлгуулна.
- Хохирогч тийнхүү сэтгэцийн өвчтэй болсноор түүнд өөрт нь болон үр хүүхдэд нь ямар их хор уршиг, үр дагавар учирч байгааг тодорхойлон хэлнэ. Жишээлбэл, хохирогч насанд хүрээгүй хүүхдээ асран тэтгэх боломж, чадвар нь хязгаарлагдсанаас хүүхдүүд нь хэрхэн хохирч байгаа талаар дурдана.
- Хохирогчийг сэтгэцийн өвчтэй болгоход хүргэсэн хүчирхийллийн шинжтэй урьд өмнө үйлдэгдэж байсан үйлдлүүдийг товчоор давтан сануулна.
- Шүүгдэгч шүүх хуралдааны үеэр худал хуурмагаар мэдүүлсэн үгүүдийг дурдаж, энэ нь хэрэгт авагдсан ямар нотлох баримтуудаар няцаагдаж байгаа болохыг хэлнэ.

Дасгал 4.

1. ГБХ үйлдэх гэмт хэргийн анхан шатны шүүх хуралдаанд тавих улсын яллагчийн дүгнэлт нь:
   a) Бусад төрлийн хэргийн шүүх хуралдаанд тавих шүүмжээс ямар онцлогтой байж болох вэ?
   b) Улсын яллагчийн дүгнэлт, тайлбарын ялгаа, онцлог юу вэ?

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

болон Улсын Ерөнхий прокурорын тушаалаар батлагдсан "Прокурор шүүх хуралдаанд төрийг төлөөлөх ажлын аргачилсан заавар"-т шүүхийн хэлэлцүүлэг дуусаны дараах үе шат буюу дүгнэлт танилцуулах талаар журмыг ерөнхий байдлаар зохицуулсан байна.

Харин улсын яллагч нь дүгнэлтээ өөрийн байр суурь, хэргийн онолын хүрээнд шүүх хуралдаанд хэрхэн үр дүнтэй танилцуулах нь тухайн хуульчийн мэргэжлийн ур чадвартай шууд холбоотой.

Улсын яллагч шүүх хуралдаанд дүгнэлтээ танилцуулахдаа дараах зүйлүүдийг анхаарвал зохино. Үүнд:

2. "Дүгнэлтэд шүүх хуралдаанаар хэлэлцэгдээгүй шинэ нотлох баримтыг ашиглахгүй" гэж хуулиар зохицуулсан. Учир нь дүгнэлт танилцуулахаас өмнө шүүхийн хэлэлцүүлэг явагдаж, шүүх нотлох баримтыг шинжлэн судалсан байдаг бөгөөд энэ үед шүүгчийн дотоод итгэл бүрэлдэж байдаг тул дүгнэлт танилцуулахад зөвхөн шүүхэд хэлэлцэгдсэн нотлох баримтад тулгуурлан, иш татаж, хэрэгт холбогдолтой зүйлсийг ярих ёстой. Улсын яллагчийн зүгээс энэ үе шатанд дээрх нотлох баримтуудыг хэрхэн үнэлж, шүүхээс юу хүсэж байгаагаа ойлгомжтой тодорхойлох үүрэгтэй.
3. Дүгнэлт танилцуулахдаа шүүгдэгчийн зан төлөв, гэмт хэргийн нөхцөл байдал, үйл явдлын талаарх өөрийн тайлбарт шүүхийн анхаарлыг хандуулах зорилгоор хэлэх үгэндээ шүүхийн хэлэлцүүлгийн үр дүнг юу гэж дүгнэж байгаагаа тусгаж байх.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар "Шүүх нь ... улсын яллагч, өмгөөлөгчийн дүгнэлт, тэдгээрийн тайлбар гаргах хугацааг талуудын санал, хүсэлтийг харгалзан урьдчилан тогтооно" гэж зохицуулсан. Ингэж дүгнэлт танилцуулах, тайлбар гаргах хугацааг хуульчилсан нь гэмт хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилттой холбоотой бөгөөд шүүх хуралдааныг эмх цэгц, дэг журамтайгаар талуудын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явуулах нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм. Нөгөө талаар ямарваа нэг амжилтыг хурдаар хэмжих болсон үсрэнгүй хөгжиж буй орчин үеийн нийгэмд хүмүүс цаг хугацааны үнэ цэнийг мэдэрч, цаг хугацааг зөв зүйтэй, үр дүнтэй ашиглах шаардлага тулгарсаар байна.

Дээрх хугацааг талуудын санал, хүсэлтийг харгалзан шүүх урьдчилан тогтоохоор заасан нь энэ үе шатыг ямар хугацаатайгаар үргэлжлүүлэхийг шүүх дангаар шийдвэрлэхгүй гэсэн үг. Иймд тухайн эрүүгийн хэрэгт улсын яллагч нь цаг хугацааг зөв мэдэрч, дүгнэлтээ хэдий хугацаанд бүрэн дүүрэн оновчтой танилцуулах боломжтой талаар урьдчилан бэлтгэсэн байх шаардлага урган гарч байна.

5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд "Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт хэлэхийн өмнө шүүхэд хандан завсарлага авч болно. Завсарлах хугацааг шүүх тогтооно" гэж шинэ зохицуулалт орсон бөгөөд улсын яллагч дараах тохиолдолд үүнийг хэрэгжүүлнэ. Үүнд:
   а. Шүүх хуралдааны явцад төлөөлөн мэтгэлцэж байгаа улсын яллагч бусад яллагчтай зөвлөлдөх шаардлагатай болсон;
   б. ажлын цаг дуусан;
   в. бусад үндэслэл.

Яагаад "бусад үндэслэл" гэж тодорхойлоогүй орхисон бэ гэвэл "улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт хэлэхийн өмнө шүүхэд хандан завсарлага авах" талаар хуулийн дээрх зохицуулалтанд завсарлага авах үндэслэлийн талаар тодорхойлоогүй байна. Гэхдээ бид бүхэн мөн хуулийн 34.15 дугаар зүйлд заасан "Шүүх хуралдаан завсарлах" тухай зохицуулалтуудын хүрээнд завсарлага авч болохоор байгаа тул мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад заасан "хүндэтгэн үзэх шалтгаан байгаа бол" гэсэн үндэслэлийг "бусад үндэслэл" гэдэгт хамааруулан ойлгохоор байна.

Иймд "хүндэтгэн үзэх шалтгаан" гэдгийг өмнө бэлтгэсэн байсан дүгнэлтээ илүү сайжруулан танилцуулах шаардлагатай нөхцөл байдал шүүх хуралдааны хэлэлцүүлгийн явцад тогтоогдсон, эсхүл тухайн үеийн нөхцөл байдалд талуудад хувийн, албаны болон эрүүл мэндийн гэнэтийн тулгамдсан асуудал

тохиолдсон зэргийг ойлгож болно.

Дээрх хуулийн зохицуулалтаас харахад: талууд дүгнэлт хэлэхийн өмнө шүүхэд хандан завсарлага авах эрхийг шүүх эдлүүлэхгүй байх, энэ талаарх хүсэлтийг нь хангахаас татгалзах ямар нэгэн хязгаарлалт байхгүй боловч шүүхээс тогтоож завсарлуулсан хугацаанд л талууд амжиж дүгнэлтээ бэлэн болгох шаардлагатай байхаар хуульчилсныг анхаарвал зохино.

Мөн улсын яллагчийн хэргийн зүйлчлэлээс шүүх хэргийг өөрөөр зүйлчилсэн тохиолдолд улсын яллагч завсарлага авч цаашид ямар ял, эрүүгийн хариуцлага оногдуулах талаар бэлтгэх шаардлагатай болох тул энэ талаар хүсэлт гаргаж завсарлага авдаг байх нь зүйтэй.

6. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Хэрэг ээдрээ төвөгтэй буюу олон шүүгдэгчтэй бол шүүх хуралдаанд хэд хэдэн улсын яллагч оролцож болно" гэж зохицуулсан байсан. Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Шүүх хуралдаанд хэд хэдэн улсын яллагч оролцож байгаа бол шүүх хуралдаанд тодорхой асуудлаар мэтгэлцэхэд нэг улсын яллагч нь бусдыгаа төлөөлнө" гэж өөрчлөгдсөн бөгөөд улсын яллагч үүнийг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хэн нь ямар үүрэгтэй оролцохоо урьдчилан хуваарилах /жишээ нь: хэн нь яллах дүгнэлт уншиж танилцуулах, хэн нь оролцогчдоос асуулт тавьж мэдүүлэг авах, хэн нь нотлох баримт шинжлэн судлах, хэн нь улсын яллагчийн дүгнэлт танилцуулах гэх зэргээ урьдчилан шийдвэрлэсэн байх/;
- Дээд шатны прокурор ахалж оролцох прокурорыг урьдчилан томилсон байхаар зааварт зохицуулсан билээ. Гэхдээ ахалж оролцох прокурор нь дээр дурьдсан шүүх хуралдааны үе шатуудад хэн хэн нь ямар үүрэг оролцоотой оролцох талаар зохион байгуулалтын хувьд бусдыгаа чиглүүлэх үүрэгтэй бөгөөд харин бусдаасаа давуу эрх эдэлж, албан тушаалаар ахлахгүй гэж ойлгоно. Өөрөөр хэлбэл шүүх хуралдаанд хэд хэдэн улсын яллагчийг ахалж оролцлоо гэвэл түүнийг тодорхой үүрэг хариуцлага болон гардан хэрэгжүүлэх ажлаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- Илтгэх ур чадварыг бусдаасаа илүү эзэмшсэн гэж үзэж байгаагаа дотроо зөвлөлдсөний дагуу шүүх хуралдааны дүгнэлт танилцуулах үе шатанд төлөөлүүлэхээр урьдчилан сонгосон байх.
- Ялангуяа ээдрээ төвөгтэй, олны анхаарал татсан, олон холбогдогч, үйлдэлтэй, гэм буруугийн талаар болон нотолгооны хувьд маргаантай хэргийн шүүх хуралдаанд дүгнэлт танилцуулах, дүгнэлттэй холбогдуулж тайлбар хэлэхээс өмнө улсын яллагч нь шүүхээс шүүх хуралдааныг завсарлуулахыг хүсэх эрхээ эдэлж, бусад улсын яллагчтай зөвлөлдөж байх.

7. Дүгнэлтэд заасан зүйлийн талаар тус бүр нэг удаа тайлбар гаргах эрхтэй талаар хуульд тусгайлан тогтоосон нь талууд эсрэг талынхаа гаргасан үндэслэлийг няцаах боломжийг олгож буй хэрэг юм. Энэ нь мөн шүүх хуралдаанд хэлэлцэгдсэн буюу шинжлэн судлагдсан нотлох баримтад үндэслэх ёстой. Тайлбар хэлэхээс татгалзсаныг тухайн этгээд нөгөө талынхаа хэлсэн үгийг зөвшөөрсөн мэтээр ойлгож болохгүй боловч улсын яллагч өөрийн байр суурь, хэргийн онолын талаар шүүгчийн дотоод итгэлийг бүрэлдүүлэх зорилгыг хангах үүднээс өмгөөлөгч улсын яллагчийн дүгнэлтээс зарчмын эсрэг байр суурийг илэрхийлсэн бол хариу няцаалт, тайлбарыг хууль зүйн үндэслэлтэйгээр хэлэх нь зүйтэй.

8. Дүгнэлт танилцуулах үе шат нь мөн шүүх хуралдаанд байлцсан иргэдэд хүмүүжлийн үр нөлөө үзүүлэх ач холбогдолтой бөгөөд иргэд хэргийн мөн чанар, үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, хор аюул, үр дагаврыг ойлгоход дөхөм болдгийг анхаарч хүмүүжүүлэх чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай.

3.3. ШҮҮГЧИЙН АНХААРАХ АСУУДАЛ

Удиртгал

Дэлхийн аль ч улс оронд ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүч хэрэглэсэн бусад төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс илүү төвөгтэй, өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой гэж үздэг байна. Учир нь энэ төрлийн зөрчлийг хянан шалгах, гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, яллах, шүүхэд хянан шийдвэрлэх зэрэг ажиллагаанд ГБХ-ийн мөн чанараас шалтгаалсан цөөнгүй хүндрэл бэрхшээл гардаг. Юуны өмнө ГБХ-ийн хохирогч нь зөрчилд холбогдогч болон шүүгдэгчтэй ойр дотны харилцаатай, түүнээс хамааралтай, сэтгэл зүйн холбоотой байдаг нь гэм буруутай этгээдийн үйлдлийг бүрэн зөв тогтоож, тохирох хариуцлага хүлээлгэхэд хүндрэл учруулдаг. Өөрөөр хэлбэл, хохирогч нь хүчирхийлэл даамжирсан тухайн агшинд л үйлдлийг таслан зогсоож, амь аврагдахын тулд цагдаагийн байгууллагад ханддаг. Харин хохирогчид гэм буруутай этгээдийг шийтгэж, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлоо барагдуулах, хохирогчоор тогтоогдож зөрчлийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох ямар нэг сонирхол байдаггүй. Энэ нь ГБХ-ийн хохирогч зөрчил шалгах ажиллагаа болон мөрдөн байцаалт, шүүхийн шатанд мэдүүлгээсээ буцах, худал мэдүүлэх, мэдүүлэг өгөхгүй байх, зөрчилд холбогдогч, шүүгдэгчийг өмөөрөх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэдэг.

ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгчид юуны өмнө дараах асуултууд тулгарч болно. Хэргийн ачаалал ихтэй нөхцөлд эрх зүйн мэдлэг багатай ГБХ-ийн хохирогч, гэрчтэй шүүгч хэрхэн харилцаж, шийдвэр гаргах үйл явцыг хэрхэн үр дүнтэй удирдах вэ? Ялангуяа, өмгөөлөгчгүйгээр шүүх хуралдаанд оролцож буй хэргийн оролцогч шүүх хуралдааны дэг, үйл явц, шүүхийн шийдвэрийг ойлгож байгаа эсэхийг яаж мэдэх вэ? Энэ бүхэн шүүгчийн харилцааны ур чадвараас шалтгаалдаг. ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэрэг нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, нэр төрд ноцтой хохирол учруулах өндөр магадлалтай байдаг тул шүүгчээс шүүх хуралдааны танхимд хохирогч, гэрчтэй харилцахад онцгой анхааралтай хандахыг шаарддаг. Ийм ч учраас шүүгчийн өөрийн харилцааны хэв маяг, арга барил, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж буй байдал зэргээс шалтгаалан шүүгч, ГБХ-ийн хохирогчийн хооронд итгэлцэл бий болдог. Шүүгч хэргийн оролцогч болон бусад хүмүүстэй харилцахад хууль, дүрмээр тогтоосон шүүгчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах зайлшгүй шаардлага тулгарна. Нөгөө талаас, өөрийн гэсэн онцлогтой ГБХ-ийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд хэргийн оролцогчидтой нягт хамтран ажиллаж байж хэргийг үнэн зөв, шуурхай, шударгаар шийдвэрлэх боломжтой юм.

ГБХ үйлдэх гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд шүүгчийн гаргасан шийдвэр хохирогч, шүүгдэгч, хүүхдүүд, гэр бүлийн бусад бүх гишүүдийн амьдралд нөлөөлдөг. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар жендэрт суурилсан хүчирхийллийг шүүгчид тэвчихгүй гэсэн тодорхой ойлголтыг олон нийтэд хүргэдэг. Дэлхий дахины судалгаанаас үзэхэд ГБХ-ийг зогсооход шүүхийн байгууллага чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд шүүхээс ГБХ үйлдэгчид тохирсон эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь ГБХ-ийг зогсооход том түлхэц өгдгийг хэд хэдэн судалгаа харуулсан[96].

Дээрх нөхцөл байдлыг харгалзан энэ хэсгийн зорилт нь шүүгчийн дараах мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэхэд оршино. Үүнд:

- ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийн шинж, онцлог, ялгааг танин мэдэх, жендэрийн хэвшмэл үзлийн нөлөө, жендэрт суурилсан хүчирхийллийн онцлогийг танин мэдэх, үйл ажиллагаандаа тусгах;
- ГБХ үйлдэх зөрчил болон гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхдээ онцлогийг нь харгалзан үзэхийг чухалчлах;

96 "Вьетнам улсын хууль хэрэгжүүлэх, шүүх байгууллагын чадварыг нэмэгдүүлснээр ГБХ-ийн эсрэг авах аргахэмжээ, урьдчилан сэргийлэх үр дүнг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд гаргасан сургагч багшийн гарын авлага, 2010

- ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийн нотлох баримт, түүний онцлог, нотолгооны хэлбэрүүдийг танин мэдэх, нотлох баримтыг үнэлэх арга зүйд суралцах;
- ГБХ–үйлдэгч, гэрч, хохирогчийн нийтлэг шинж, онцлогийг харгалзан үзэхийг чухалчлах;
- Шүүх хуралдааны үеэр ГБХ—үйлдэгч, хохирогч, гэрчтэй харилцах арга барилаа хөгжүүлэх;
- ГБХ-ийн хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах эрсдэлтэй үед хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг оновчтой тодорхойлох;
- ГБХ үйлдэх зөрчил гаргагчид шийтгэл ногдуулах, гэмт хэрэг үйлдэгчид ял шийтгэлийг оновчтой оногдуулах мэдлэг чадвараа дээшлүүлэх;
- ГБХ үйлдэгчид ял оногдуулахгүйгээр тэнсэхээс татгалзах хандлагыг чухалчлах.

Дээрх зорилтыг хангах хүрээнд ГБХ-ийн зөрчлийг шалган шийдвэрлэх, зөрчил гаргагчид шийтгэл оногдуулах, ГБХ-ийн гэмт хэрэг үйлдсэн яллагдагчийг шүүхэд шилжүүлэх болон хэргийг хянан шийдвэрлэж ял оногдуулах, эрүүгийн хэрэгт нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаах талаарх асуудлыг дэлгэрүүлэн авч үзнэ. Мөн шүүгчээс хэргийн оролцогчидтой харилцах харилцаа, хандлагын талаарх нийтлэг асуудлаас илүүтэй ГБХ-ийн зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэх явц дахь шүүгч болон хэргийн оролцогчдын хоорондын харилцаа, түүнд шүүгчийн зүгээс анхаарвал зохих асуудлыг авч үзэх болно. Эцэст нь ГБХ үйлдэх зөрчил гаргагчид шийтгэл оногдуулах, гэмт хэрэг үйлдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээ, ял шийтгэл оногдуулах ажиллагааны онцлогийн талаар авч үзнэ.

3.3.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ОНЦЛОГ

ДЭД СЭДЭВ 1. ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал

Энэ дасгал ГБХ үйлдэх зөрчил болон гэмт хэргийн онцлогийг танин мэдэхэд туслах болно.

Дараах тохиолдолтой танилцаж, асуултад хариулна уу.

А, Б нар 2011 онд гэр бүл болжээ. Нөхөр А нь гадаадад сурч төгссөн, төрийн албанд удирдах албан тушаал хашдаг. Тэд хоёр хүүхэдтэй ба бусдад тэдний гэр бүл эвтэй найртай, хангалуун амьдралтай, аз жаргалтай харагддаг. А эхнэртээ үе үе үнэтэй бэлэг өгдөг бөгөөд хамгийн сүүлд төрсөн өдрөөр нь Wolkswagen Touareg маркийн автомашин бэлэглэжээ. Тэрээр эхнэрээ гэртээ байгаа эсэхийг шалгаж үе үе утсаар ярьж, найз нөхөдтэйгээ уулзахыг нь хориглох болсон бөгөөд хүүхдээ асрах, гэр орноо цэвэр цэмцгэр байлгах ёстой гэж шаардах болсон байна. Сүүлийн үед нөхрийн хөдөө томилолтоор ажиллах нь ихсэж, гэртээ ирээд эхнэрээ хардах, улмаар гар хүрэх болжээ.

Нөхрийн үйлдэл ГБХ үйлдэх зөрчил болох уу, гэмт хэрэг болох уу? Яагаад?

ГБХ-ийг танин мэдэх, ГБХ-ийн үйлдэл, онцлог шинжийг анхаарч үзэх хэрэгтэй.

ГБХ үйлдэх зөрчлийг хянан шийдвэрлэх: Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан,

бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдан "ГБХ-тэй тэмцэх тухай хууль зөрчих" зөрчил гаргасан бол шүүх Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан шийтгэл оногдуулж, албадан сургалтад хамруулна[97]. ГБХ үйлдэх зөрчлийг хянан шийдвэрлэхдээ ГБХ үйлдэх гэмт хэргийн адил зөрчлийн шинж, хүчирхийллийн хэлбэрийг харгалзан үзнэ. Шүүх зөрчлийг шийдвэрлэхдээ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасны дагуу зөрчилд холбогдогчид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцох, зөрчлийн хэрэгтэй танилцах, хохирогчийн гомдолтой танилцаж хариу тайлбар гаргах, хууль зүйн туслалцаа авах эрхийг нь танилцуулж, хангасан эсэхийг анхаарах нь зүйтэй.

Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх: Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан этгээдийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан "ГБХ үйлдэх" гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шатанд шүүгч ГБХ нь хүчирхийллийн бусад хэлбэрээс ялгаатай, онцлог гэдгийг анхаарах ёстой. Тухайлбал, ГБХ үйлдэгч хохирогчид хяналтаа тогтоосон байдгийг анхаарахгүй бол хэргийг шударгаар шийдвэрлэхэд хүндрэлтэй. Бусад төрлийн хүчирхийллийн хохирогч нь хууль сахиулах болон шүүхийн байгууллагатай хамтран ажиллах хандлагатай байдаг бол ГБХ-ийн хохирогч хууль сахиулах, шүүхийн байгууллагаас аль болох дөлөх, зугтаах, нуугдах, хүчирхийллийн нөхцөл байдлыг бууруулах мэдүүлэг өгөх хандлагатай байдгийг анхаарах хэрэгтэй.

Хэргийг прокурорт буцаах: ГБХ үйлдэх гэмт хэргийг бүх талаас нь бүрэн шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримт хэрэгт авагдаагүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн, мөрдөн шалгах ажиллагааг бүрэн биш хийсэн, түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй тохиолдолд шүүгч хэргийг нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаана. Өөрөөр хэлбэл, шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй илэрхий алдаа дутагдал байгааг мэдсээр байж яллагдагчийг шүүхэд шилжүүлж, шүүх хуралдаанаас хэргийг прокурорт буцаавал буруу практик болох бөгөөд цаг хугацааны хувьд ч шүүгдэгч, хохирогч, тэдний ар гэрийнхэн, зарим тохиолдолд гэрч, шинжээчдийг чирэгдүүлж байгаа явдал юм.

Шүүгч хэргийг хүлээн авч яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх үндэслэл байна гэж үзвэл өөрийн санаачилгаар шүүхийн урьдчилан хэлэлцүүлэг зарлаж явуулна. Ингэхдээ оролцогч нарт урьдчилсан хэлэлцүүлгийн товыг мэдэгдэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

ГБХ үйлдэх гэмт хэргийн хувьд бусад хэргийн адилаар шүүгч тухайн хэргийг шийдвэрлэхэд ямар нотлох баримт дутуу, ямар процессын зөрчил гарсан гэдгийг маш тодорхой бөгөөд үндэслэлтэй тайлбарлах ёстой. ГБХ-ийн хэргийн онцлог нь цаг алдалгүй хурдан шийдвэрлэгдэх ёстой байдаг. Иймд нэг хэргийг нэгээс илүү удаа буцааж сунжруулах нь хэрэг шударгаар шийдвэрлэгдэх боломжгүй болох сөрөг үр дагаварт хүргэж болно. Энэ ажиллагааг оновчтой, бүрэн дүүрэн хийх нь шүүгчийн ур чадвар, хэрэгтэйгээ танилцсан байдал зэргээс шууд хамааралтай байна.

Дэд сэдэв 2. ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийн нотлох баримтыг үнэлэхэд анхаарах асуудал

Шүүгч нь аливаа зөрчил, гэмт хэргийг шийдвэрлэхдээ тухайн зөрчил, гэмт хэрэгт хамааралтай, хуулийн дагуу цуглуулж, бэхжүүлж авсан бүх нотлох баримт нь зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлдэг. Түүнчлэн хэргийг хянан шийдвэрлэхдээ хэрэгт авагдсан нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, бусад нотлох баримттай харьцуулах, нотлох

97 Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 2017

баримтын эх сурвалжийг магадлах аргаар шалгадаг бөгөөд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй.

"ГБХ-тэй тэмцэх тухай хууль зөрчих" зөрчлийг хянан шийдвэрлэхдээ шүүгч дараах нөхцөл байдлыг тогтооно. Үүнд:

1) зөрчил нь тухайн байгууллага, албан тушаалтны эрх хэмжээ, харьяаллын асуудал мөн эсэх;
2) хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсний дараа зөрчил шалгах шийдвэрлэх ажиллагаа явуулсан эсэх
3) зөрчлийн тухай тэмдэглэл, нотлох баримтыг үнэн зөв бүрдүүлсэн эсэх;
4) нэмэгдэл баримт сэлт зайлшгүй шаардлагатай эсэх;
5) зөрчилд холбогдсон этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ямар нэг хүсэлт гаргасан эсэх;
6) холбогдох этгээдэд зөрчлийг хянан хэлэлцэх өдөр, цаг, газрыг мэдэгдсэн эсэх.

ГБХ-ийн хэргийн нотлох баримтыг зөв үнэлэх нь тухайн хэргийг цаг алдалгүй шуурхай хянан шийдвэрлэж, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд зохих ял шийтгэлийг шударгаар оногдуулах, шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэслэлтэй гарах нэг үндсэн нөхцөл болдог. ГБХ-ийн хэргийн онцлог нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, нэр төрийг шуурхай хамгаалах, хэргийн нотлох баримт бүдгэрч устаж үгүй болохоос өмнө бүрэн дүүрэн, цаг алдалгүй шуурхай шийдвэрлэх шаардлагатай байдагт оршино. Нөгөө талаар шүүх хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн, бодитой нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч шүүгдэгчид ял шийтгэх, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй.

ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэхэд хэргийг бүх талаас нь бүрэн бодитой, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангасан хэмжээнд шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримт цугласан эсэхийг тогтоох, үгүй бол түүнийг залруулах боломжтой субъект нь шүүгч юм. Жишээ нь, энэ төрлийн хэргийг нотлох хамгийн чухал баримт болсон хохирогчийн мэдүүлэг олон дахин өөрчлөгдөх тохиолдол байдаг. Иймд хохирогч, гэрчийн мэдүүлэг нь тэдний сэтгэл зүйн өөрчлөлт, хүчирхийлэгч болон бусдын нөлөөлөлтэй салшгүй холбоотой байдгийг анхаарч, бусад нотлох баримт, хэргийн нөхцөл байдалтай нарийн уялдаатайгаар дүгнэлт хийж, хүчирхийллийн түвшинг бодитой тогтоохын тулд бусад хамааралтай нотлох баримт, шүүгдэгчийн хувийн байдал, өмнө нь ГБХ үйлдэх зөрчил гаргасан болон хүчирхийллийн хэрэгт холбогдсон, шийтгүүлсэн эсэхийг нотлох баримтууд зэргийг давхар шалгах ёстой.

ГБХ-ийн хэргийн нотлох баримтад шүүгдэгч, хохирогчийн мэдүүлгээс гадна дараах бусад нотлох баримтыг анхаарч үзэх нь зүйтэй. Үүнд:

- Бусад эх сурвалж: найз нөхөд, хөрш, хүүхэд зэрэг хүчирхийллийг шууд үзсэн харсан, сонссон гэрчүүд;
- Шүүгдэгчийн өмнөх зүй бус, хүчирхийллийн үйлдлүүд, зөрчлийн талаарх нотлох баримтууд;
- Хамгаалах байр, эмнэлэг болон бусад байгууллагаас гаргасан нотлох баримтын шинжтэй эх сурвалж;
- Хэргийн газар дуудлагаар очсон цагдаагийн алба хаагчдын хэлсэн, мэдүүлсэн тайлбар гэх мэт.

ГБХ-ийн хэргийн нотлох баримт нь бусад төрлийн гэмт хэргийн нотлох баримтаас хэд хэдэн зүйлээр ялгаатайг хэрэг хянан шийдвэрлэх явцад анхаарах нь зүйтэй. Тухайлбал:

Нэгдүгээрт, энэ төрлийн хэрэг нь ихэвчлэн "цоожтой хаалганы цаана" буюу гэр бүлийн дотоод орчинд үйлдэгддэг. Бусад хүч хэрэглэсэн гэмт хэргийн хувьд гол төлөв гадаа гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгддэг, гэмт үйлдлийг харсан, үзсэн гэрчийн этгээд олонтой байхад ГБХ-ийн хувьд зөвхөн шүүгдэгч, хохирогч, зарим тохиолдолд насанд хүрээгүй гэрч гэсэн хүмүүсийг хамарсан байдаг.

Хоёрдугаарт, энэ төрлийн хэргийг нотлоход хамгийн чухал шууд эх сурвалж нь хохирогч, гэрчийн мэдүүлэг байдаг. Шууд бус эх

сурвалжийн хувьд шинжээчийн дүгнэлт, хөршийн мэдүүлэг, шүүгдэгчийн хувийн байдлыг тодорхойлсон баримт зэрэг байж болно.

Гуравдугаарт, хэргийг нотлох шууд эх сурвалж болж байгаа хохирогч, гэрч зэрэг нь шүүгдэгчтэй ямар нэг байдлаар хувийн дотно харилцаатай хүмүүс байдаг. Энэ тохиолдолд тэд шүүгдэгчийг өмгөөлөх, эсхүл түүний хожмын үйлдлээс айж эмээсэндээ мэдүүлэг өгөхгүй байх, өгсөн мэдүүлгээсээ буцах, эсрэг мэдүүлэг өгөхөөс царгалах, хүчирхийллийн үйлдлийг "зөөлрүүлж" мэдүүлэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл бэрхшээл учруулж болно. Ийм үед шүүх гэрч, хохирогчийг ямар нэг сэтгэл зүйн дарамт шахалт, айдасгүйгээр шүүх хуралдаанд мэдүүлэг авах, үнэн шударгаар мэдүүлэх боломжийг хангах ёстой болдог.

ГБХ-ийн хэргийн нийтлэг нотлох баримт болох гэрч, хохирогч, шүүгдэгчийн мэдүүлэг, нөхцөл байдлын болон аюулын зэргийн үнэлгээ, шинжээчийн дүгнэлт, тэдгээрийг үнэлэхэд анхаарах асуудлыг дараах байдлаар танилцуулъя.

Гэрч, хохирогчийн мэдүүлгийн ач холбогдол, түүнийг үнэлэхэд анхаарах асуудал

ГБХ-ийн хохирогчтой тулгарах бүхий л харилцаанд тэднийг хүчирхийлэлд өртсөн тул эелдэг, хүнлэг, хүндэтгэл, мэдрэмжтэй байдлаар харьцах шаардлагатай байдаг. Ихэнх тохиолдолд хохирогчид шүүх хуралдаанд оролцохын өмнө хэд хэдэн удаа хүчирхийллийн хэргийн талаар мэдүүлэг өгсөн байдаг ба энэ үйл явц тэдний хувьд шархыг сэдрээх, ичгүүр, бухимдлыг дагуулдаг. Түүнчлэн тэд цаг хугацааны эрхээр нөхцөл байдлын нарийн ширийн зүйлийг мартсан байж болно.

Шүүх эрх мэдлийн салбарын оролцогчид тэвчээртэй байж, мөн адил хохирогчид болсон үйл явдлыг өөрийн үгээр илэрхийлэх хугацааг олгох хэрэгтэй. Түүнийг хүчирхийлэлд буруутгагдаагүй гэдгийг сануулах, мэдүүлэг өгөх, гэрчээр мэдүүлэг өгч оролцох нь хэргийг тогтоох чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг тайлбарлах шаардлагатай байдаг. Шүүгчийн зүгээс хохирогчтой хүчирхийллийн ноцтой байдлын түвшин улам бүр нэмэгддэгтэй холбоотойгоор ГБХ-ийн динамик өсөлтийн талаар ярилцах нь хохирогчид нөхцөл байдал хэр их ноцтой болохыг ойлгуулах, хууль эрх зүйн тогтолцоо нь энэ төрлийн хүчирхийллийг цаашид хэвээр үргэлжлэхгүй зогсоохын тулд бий болсон гэдгийг ойлгуулахад ач холбогдолтой юм.[98]

ГБХ-ийн хувьд гэрчээс үнэн зөв мэдүүлэг авах нь хамгийн чухал бөгөөд үүний тулд шүүх хуралдаанд тавих асуулт аль болох шууд чиглэсэн, тодорхой байх нь чухал. Ийм асуулт тавихын тулд шүүгч хэргийн нөхцөл байдалтай сайтар танилцсан байх хэрэгтэй. Асуулт нь гол төлөв "тийм", "үгүй" гэж хариулагдах, тодорхой өдөр, цаг хугацаа, минут, тоо, хэмжээ зэрэг тодорхой зүйл байвал зохино.

Мөн шүүх хуралдаанд гэрч нь шүүгдэгч эсхүл хохирогчоос айж эмээсэн, сандарсан, түгшсэн, зэвүүцсэн зэрэг сэтгэл зүйн хурц байдалтай байгаа эсэхийг тогтмол ажиглах, тийм нөхцөл байдал илэрвэл нөхцөл байдлыг хэвийн болгох, гэрч үнэн зөв мэдүүлэг өгөх бусад нөхцөл байдал, орчинг бүрдүүлэх хэрэгтэй.

Хохирогч нь хуульд[99] зааснаар шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэгтэй бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Гэвч ГБХ-ийн хохирогчийн хувьд аргагүй нөхцөл байдлын улмаас худал мэдүүлэг өгөх, мэдүүлгээсээ буцах зэрэг байдал нийтлэг ажиглагддаг. Хохирогчийн мэдүүлгээс хүчирхийллийн аль хэлбэр, түүний онцлог шинжүүд байгааг тодорхойлж сурах нь чухал.

ГБХ үйлдэх гэмт хэрэг нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний эсрэг үйлдэгддэг учраас хүчирхийлэл үйлдэгчийн

98 Анна Костанза Балдри болон Элизабет Дубан. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон ГБХ-тэй тэмцэхэд хууль сахиулах болон шүүхийн байгууллагын ажилтнуудын үр нөлөөг сайжруулах явдал, 201

99 ЭХХШтХ-ийн 8.2 дугаар зүйл, 2017

зүгээс хохирогчид бие махбодын, эдийн засгийн, сэтгэл зүйн дарамт учруулах, ятгах, айлган сүрдүүлэх зэргээр мэдүүлгээсээ буцахаас аргагүй нөхцөл байдалд оруулах тохиолдол их. Тухайлбал, Хохирогчийн эрхийг хамгаалах төвөөс 2010 онд хийсэн судалгаагаар гэрч, хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, ятгах, заналхийлэх явдал гарсаар байгааг тогтоосон байна. Үүний үр дагаварт мэдүүлэг өгөхгүй байх, худал мэдүүлэг өгөх, сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох зэрэг үйлдэл гарсан байдаг.

Хохирогчийн яриа: Намайг маш их хардаж зоддог байсан. Сүүлдээ намайг зодох нь хэр хэмжээнээс их хэтэрсэн. Миний хувьд намайг гэх төрөл садан, найз нөхөд гэж байхгүй учир намайг Л-д зодуулсныг мэдэх, өмгөөлж хамгаалах хүн байхгүй байсан. Сүүлд нь 2 хүүхдээ Дэлхийн зөнд явуулж эхэлснээр би ганц нэг найзтай болсон. Намайг байнга зодож тарчлаадаг байсан.

ГБХ-ийн хувьд хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд нь гол төлөв нийгмээс тусгаарлагдсан байдаг онцлогтой. Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг байнга тарчлаан зовоох, хардах, дарамтлах зэргээр бусадтай харилцах харилцааг нь тасалсан, өөртөө итгэх итгэлийг нь алдагдуулсан байдаг. Хохирогч зөвхөн нөхцөл байдлыг тэсэхээ больсон, эсхүл хүүхдэд нь аюул занал учирсан зэрэг аминд тулсан нөхцөлд л бусдаас тусламж хүсдэг ба юуны түрүүнд хамаатан садан, найз нөхөд, хөрштэйгээ ярилцдаг байна. Тэд нар нь ихэнхдээ салахыг зөвлөдөг. Эмэгтэйчүүд харин ийм тодорхой алхам хийхэд бэлэн биш байдаг бөгөөд тэдний зөвлөгөөг дагахыг хүсэхгүй, эсвэл хүчирхийлэл бүр ихэссэн үед Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, хамгаалах байр зэрэг тусламж авах, түр хоргодох байгууллагуудад ханддаг. Хүчирхийллийг ил гаргах, мэдээлэх, хуулийн байгууллагад хандах нь хохирогчийн хувьд маш хэцүү алхам байдаг. ГБХ үйлдэх гэмт хэргийг шийдвэрлэхэд хохирогчийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг энэ бүлгийн эцэст байгаа "Тусгайлан авч үзэх нь" зөвлөмжөөс үзнэ үү.

Хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагын туршлагатай ажилтан хохирогч шүүх хүртэл ямар хүнд, хэцүү сорилтыг даван туулсныг мэддэг. Тиймээс хохирогчийн мэдүүлгээс гадна найз нөхөд, хамаатан садан, ойр дотны хүмүүс, хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагын ажилтан зэрэг бусад этгээдийн мэдүүлэг нь хохирогчийн мэдүүлгийг шалгах, шууд бусаар хэргийг нотлох баримт болохыг үгүйсгэхгүй.

Нөгөө талаар, хохирогч гэмт хэргийн улмаас тодорхой хохирол хүлээсэн учраас яллагдагч, шүүгдэгчийг жигшсэн болон сэтгэл зүйн тааламжгүй байдал хэргийн бодит байдлыг тогтооход сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайлбал, хохирогч нь хэргийн материалтай бүрэн танилцдаг тул шүүхийн хэлэлцүүлгийн үед мэдүүлгээ бусад нотлох баримтад уялдуулан зохицуулж өөрчилж магадгүй. Мөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсвэл түүний гэр бүл, эцэг эх, үр хүүхэд, төрөл садангийн хүний хэн нэг нь, ямар нэгэн байдлаар хохирогчид нөлөөлж болзошгүй тул хохирогчийн мэдүүлэгт "сохроор" итгэхгүйгээр, бусад нотлох баримтуудтай харьцуулан шалгах шаардлагатай.

ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэхэд гардаг нэг том бэрхшээл нь хохирогч мэдүүлгээсээ буцах явдал юм. Энэ тохиолдолд хэргийг хангалттай нотлох баримт хэргийн үйл баримтыг тогтооход дутагдах, хэргийн нөхцөл байдал огт эсрэгээр эргэх зэрэг сөрөг үр дагавартай. Иймд хамгийн түрүүнд хохирогчийн мэдүүлгээсээ буцсан шалтгааныг зөв тогтоох нь чухал. Нөгөө талаар, ГБХ-ийн хохирогч эмэгтэйчүүд шүүх хуралдаанд мэдүүлэг өгөхөөс татгалзах нь түгээмэл байдаг. Шүүх үүнийг байнга санаж, тэдний итгэлийг хүлээхийн тулд мэдүүлэг өгөхийг хүсэхгүй байгаа шалтгааныг нь ойлгож, хохирогчид хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэлийг төрүүлэх хэрэгтэй. Хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзах нь дараах шалтгаантай байж болно. Үүнд:

- ГБХ үйлдэгчийн зүгээс өшөө авалт, сүрдүүлэг байгаа;
- ГБХ үйлдэгчтэй шүүх хурал дээр дахин уулзах хүсэлгүй байгаа;
- Ичиж эмээсэн;
- Өнгөрснөө мартах хүсэл;

- Дуугаа хураах, сэтгэл хөдлөл эрс өөрчлөгдөх, бэртлийн бусад шинжүүд г.м.;

Хохирогчид нөлөөлж буй дээрх шалтгаануудыг дараах хүчин зүйлс ихэнх тохиолдолд даамжруулдаг гэдгийг шүүх давхар анхаарч байх ёстой. Өөрөөр хэлбэл, өмнө дурдсан шалтгаан дээр дор дурдсан хүчин зүйлс нэмэгдвэл, хохирогч мэдүүлгээсээ дарамт, арга залинд орж буцах магадлал туйлын өндөр гэсэн үг юм. Үүнд:

- Хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэй үргэлжлүүлэн амьдарч байгаа бол;
- Хохирогчийн өмнөх салах гэсэн, эсхүл тусламж авах гэсэн оролдлогууд амжилтгүй болсон, давтан хүчирхийлэлд өртсөн;
- Хүчирхийлэл үйлдэгч хохирогчийн үйлдлийг хянадаг;
- Хохирогч, хүчирхийлэл үйлдэгч нар дундаасаа хүүхэдтэй бөгөөд тухайн этгээд хүүхэдтэйгээ харилцдаг, хохирогч хүүхдүүдийнхээ аюулгүй байдалд санаа зовдог бол;
- Хохирогч өөрөө болон хүүхдүүд нь хүчирхийлэл үйлдэгчийн асрамжид байдаг;
- Гэр бүлийнхэн болон орчныхон мэдүүлэг өгөхөөс татгалзахыг шаардаж дарамт үзүүлдэг бол;
- Хохирогч хууль хяналтын байгууллага болон шүүхэд итгэл алдарсан, эдгээр байгууллагууд хүчирхийллийг зогсоож чадахгүй гэж боддог бол.

Мэдүүлэг өгөхөөс татгалзсан хохирогчийг мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн хохирогчоос ялгах нь чухал. ГБХ-ийн хохирогч мэдүүлэг өгөх хүсэлгүй, эсхүл татгалзаж буй шалтгааныг, мөн хохирогч сүрдүүлэгт автагдсан, албадлагад өртсөн эсэхийг тогтоох нь чухал. Үүнийг тогтооход дараах асуултуудыг тавьж болохыг мэргэжилтнүүд зөвлөсөн байдаг.[100] Үүнд:

- Та яагаад мэдүүлэг өгөх хүсэлгүй байгаа вэ?
- Та мэдүүлэг өгөхөөс татгалзах шийдвэрийг хэзээ гаргасан бэ?
- Та түүнтэй одоо амьдарч байгаа юу?
- (Хамт амьдрахгүй байгаа бол) Таны хаана амьдарч байгааг мэддэг үү?
- Хүчирхийлэл үйлдэгчээс санхүүгийн хувьд хараат байдаг уу?
- Та хоёр дундаасаа хүүхэдтэй юу?
- Та түүнтэй шүүх, шүүх хуралдааны талаар ярилцаж байсан уу?
- Таныг мэдүүлэг өгвөл танд ямарваа нэгэн зүйл хийнэ гэж хэлж байсан уу?
- Та энэ амлалтаас нь болж мэдүүлэг өгөхөөс татгалзаж байна уу?
- Таныг мэдүүлэг өгөхөөс татгалзуулах гэж хүчирхийлэл үйлдэгч, эсхүл хэн нэгэн таныг болон танай гэр бүл, хүүхдүүдийг сүрдүүлсэн үү?
- Хүчирхийлэл үйлдэгчээс айх ямар нэгэн шалтгаан байна уу?
- (Хэрвээ бие махбодод нь ил гэмтэл байвал) Та энэ бэртэл гэмтлийг яаж авсан бэ? (мөн цагдаагийн тэмдэглэл, эмнэлгийн тодорхойлолт, зураг, нүдэнд харагдах гэмтлүүдэд үндэслэх).

Хүчирхийлэл үйлдэгчийн стратегиас болж хохирогч ихэвчлэн мэдүүлэг өгөхөөс татгалздаг. Иймд бид хүчирхийлэл үйлдэгчийн хувийн байдлыг тогтоох нь чухал. Хохирогч эхлээд мэдүүлэг өгөхөөс зайлсхийж байгаад, зохих дэмжлэг үзүүлсний дараа, мөн аюулгүй байдал нь хангагдсан тохиолдолд шийдвэрээ өөрчилдөг. Хохирогчийг дахин сэтгэл санааны хүнд байдалд оруулахаас зайлсхийхийн тулд дараах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.

Сэтгэл зүйн дэмжлэг болон хууль зүйн туслалцаа

Хүчирхийлэл үйлдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох талаар мэдэгдэж, түүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар тайлбарлах нь зүйтэй. Мөн хохирогч хууль зүйн туслалцаа авах, өмгөөлөгчөө сонгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үнэ төлбөргүй сэтгэл зүйн туслалцаа авах, хүчирхийлэл үйлдэгчээс хохирлоо

100 "Вьетнам улсын хууль хэрэгжүүлэх, шүүх байгууллагын чадварыг нэмэгдүүлснээр "ГБХ-ийн эсрэг авах арга хэмжээ,урьдчилсан сэргийлэх үр дүнг нь нэмэгдүүлэх" төслийн хүрээнд гаргасан сургагч багшийн гарын авлага, 2010

нэхэмжлэх, хэргийн материалтай танилцах, нотлох баримт гаргуулах, шүүх хуралдааны явцад асуулт асуух эрхтэйг тайлбарлаж, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзаж буй бол шалтгааныг тодруулах зэрэг дэмжлэг туслалцаагаар хангах хэрэгтэй. Шүүхээс дээрх шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлснээр хохирогч шүүхэд мэдүүлэг өгөх магадлал өндөр болдог.

Аюулгүй байдал

Шүүх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангах нь зүйтэй. Хохирогчийг хүчирхийллийн тухай давтан ярьж шархлах нөхцөлийг аль болох багасгах зорилгоор нэг удаа мэдүүлэг авах нь зүйтэй. Хохирогчид хүчирхийлэл үйлдэгчтэй тааралдахгүй, түүний дэргэд мэдүүлэг өгөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Хохирогчийг зөвхөн гэрч, эсхүл "үнэнийг илрүүлэх хэрэгсэл" гэж үзэхээс илүүтэй, түүний аюулгүй байдлыг хангах, шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх нь шүүн таслах ажиллагааны нэг зорилго байх ёстой.

ГБХ-ийн нөхцөл байдлын болон аюулын зэргийн үнэлгээний ач холбогдол, түүнийг нотлох баримтаар үнэлэхэд анхаарах асуудал

ГБХ-ийн нөхцөл байдлын үнэлгээ болон аюулын зэргийн түвшинг[101]оновчтой тодорхойлох нь хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюулын эрсдэлийг бууруулах, тэдэнд шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх, аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулахад болон ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд шаардлагатай нотлох баримт болох чухал ач холбогдолтой.

Нөхцөл байдлын үнэлгээгээр[102] санхүүгийн хүндрэлтэй байдал, амьдарч буй газар нутгийн онцлог, эрүүл мэндийн байдал, шаардлага хангахгүй нийгмийн туслалцаа, нийгэмд тогтсон буруу хандлага, ялгаварлан гадуурхал гэх мэт нийгмийн олон эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох боломжтой байдаг. Нийгмийн ажилтан ГБХ, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй байдлыг, хохирогчид учирсан, эсхүл учирч болзошгүй сөрөг үр дагаврыг, хохирогчид үзүүлэх үйлчилгээг тодорхойлох зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийдэг.[103] Нөхцөл байдлын үнэлгээг хорооны нийгмийн ажилтан нийгмийн хамгаллын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу хийдэг.

Аюулын зэргийн үнэлгээг[104] ГБХ-ийн дуудлага, мэдээллийн дагуу цагдаагийн алба хаагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд ГБХ үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдсэн байж болох орчинд, эсхүл хохирогчийн байгаа газарт очиж хийнэ. Аюулын зэргийн үнэлгээгээр хохирогчийн эрсдэлийг бага, дунд, өндөр гэсэн ангиллаар тогтоож, шаардлагатай арга хэмжээг авна.

Аюулын зэргийн түвшинг тодорхойлох нь цагдаагийн албаны үүрэг төдийгүй шүүн таслах ажиллагааны явцад прокурор, шүүхийн байгууллага ч мөн онцгойлон анхаарах шаардлагатай гэж үздэг байна[105]. ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхэд хууль, журмын дагуу хийгдсэн нөхцөл байдлын үнэлгээ болон аюулын зэргийн үнэлгээг нотлох баримтын хэмжээнд үнэлж, зарим тохиолдолд зайлшгүй аль алиныг нь шаардаж цаг алдах бус, хохирогчийн аюулгүй байдал, эрсдэл, хүчирхийллийн түвшинг харгалзан, бусад нотлох баримтыг үндэслэн гэм буруутай этгээдэд тохирсон хариуцлага, ял шийтгэлийг оногдуулах шаардлагатай.

Шинжээчийн дүгнэлт, түүнийг үнэлэхэд анхаарах асуудал

ГБХ-д өртсөн хохирогч шинжээчийн дүгнэлт гаргуулахын тулд эхлээд цагдаагийн байгууллагад гомдол гаргасан байх ёстой.

101 Дэлгэрэнгүйг гарын авлагын Хоёрдугаар хэсгийн 2.1-т "Нөхцөл байдлын болон аюулын зэргийн үнэлгээ" сэдвээс үзнэ үү.

102 мөн тэнд.

103 ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1

104 Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Аюулын зэргийн үнэлгээ хийх журам, хоёрдугаар хавсралтаар Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээний маягт, үнэлэх аргачлал, гуравдугаар хавсралтаар Хүүхдийн аюулын зэргийн үнэлгээний маягт тус тус батлагдсан.?

105 AEquitas Prosecutors' Resource, Witness Intimidation as of Mar 2014.

Дараа нь хохирогч шинжилгээ хийлгэх тухай тогтоолыг авч шүүхийн шинжилгээний байгууллагад үзүүлж дүгнэлтээ гаргуулна.

ГБХ-д өртсөн хохирогч ГБХ-ийн улмаас бие махбодод учирсан бэртэл, гэмтэл, сэтгэл санааны зовиур шаналал, сэтгэцийн байдлыг шинжээчийн дүгнэлтээр баталгаажуулж, уг дүгнэлт, нотлох баримтаар хэрэгт авагдсан тохиолдолд хүчирхийлэл үйлдсэн этгээдэд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх, гэм буруутай этгээдэд ял шийтгэх, хохирогчид учирсан гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэхэд голлох нотлох баримт болдог. Гэвч ГБХ-ийн тохиолдол бүрт хохирогч бэртэл, гэмтэл, сэтгэл санааны зовиур, шаналал, сэтгэцийн байдлаа баримтжуулах гэж шүүхийн шинжилгээний байгууллагад ханддаггүй.

Шинжээчийн дүгнэлтээс гадна бие махбодын хүчирхийлэл үйлдэгдсэн нь хохирогчийн биед учирсан дараах шинжүүдээр илэрдэг. Үүнд: хөхрөлт, биеийн гэмтлүүд (түлэгдэл, зүсэлт, хазалтын ул мөр, толгой дээрх шарх), эмтэрсэн шүд, хугархай хавирга, хамар, бусад эрүүний, эсхүл мөрний мултрал, сонсголын асуудал, бэлэг эрхтэний асуудал, гавлын гэмтэл гэх мэт. Эдгээр гэмтлүүдийг шүүгч шүүх хуралдааны үеэр ажиглан мэдэх боломжтой. Мөн бие махбодод учирсан гэмтлийн талаар шинжээчийн дүгнэлтээс гадна хэрэгт авагдсан гэрэл зургийн үзүүлэлт, эмчид үзүүлсэн магадлагаа, өвчний түүх зэргийг сайтар анхааран, нотлох баримтаар үнэлэх, үнэлсэн тохиолдолд энэ талаараа шүүгч шийдвэртээ тусгах шаардлагатай.

ГБХ–ийн гэмт хэргийн бусад нотлох баримт, түүнийг үнэлэхэд анхаарах асуудал

ГБХ-ийн бие махбодын хүчирхийллийг таних, гэрчлэх, нотлох баримт бүрдүүлэх, хор хохирлыг тооцоход сэтгэл зүйн хүчирхийлэлтэй харьцуулахад илүү хялбар байдаг. Сэтгэл санааны болон бэлгийн хүчирхийлэл нь хохирогчийн мэдүүлгээр ихэвчлэн тогтоогддог онцлогтой тул хүчирхийллийн хэлбэрээс хамаарч нотлох баримтууд өөр өөр байдгийг анхаарах нь зүйтэй.

ГБХ-ээс үүдэн гарсан сэтгэл санааны хохирол, нийгэм соёлын үр дагавар нь ГБХ-ийн бүх хэлбэрт тодорхой түвшинд оршин байдаг. ГБХ-ийн хэлбэрүүд цаг хугацааны хувьд дараалсан, нэг нь нөгөө дээрээ суурилан гарсан байж болно. Хохирогч сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн бол түүнийг шинжээчийн дүгнэлтээр тогтооход бэрхшээлтэй. Хэрэв хүчирхийллээс үүдэн сэтгэцийн өвчтэй болсон бол түүнийг шинжээчийн дүгнэлтээр тогтоож болно.

Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хохирогчид дараах шинж тэмдэг илэрдэг. Үүнд:

Айдсын шинж тэмдэг: Зүрх дэлсэх, амьсгал бачуурах, чичиргээ, хөлрөх, толгой эргэх, хэвлийгээр өвдөх, зүрхний өвдөлт, амьсгалын асуудал, нойргүйдэл, зүрхний цохилт түргэсэх гэх мэт.

Хүчгүйдлийн шинж тэмдэг: Сульдах, сэтгэл гутрал, сэтгэлийн дарамт, ядрах гэх мэт.

Хурцадмал байдлын шинж тэмдэг: Толгой өвдөх, нойргүйдэл, хэвлийн өвдөлт, сарын тэмдгийн тасалдал гэх мэт.

Зан үйлийн шинж тэмдгүүд: Сэтгэлээр унасан, эсхүл хүлцэнгүй байдал, илэрхий бухимдал, уулзалт болзоог байнга цуцлах, хүчирхийлэл үйлдэгчтэй тогтмол, ойр дотно байх, “Миний нөхөр надад зөвшөөрөхгүй...” гэх мэт үг хэлэх. Хохирогчийг сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн талаар дүгнэхдээ хохирогчид илэрсэн дээрх шинж тэмдгийг харгалзан үзэж болно.

Эдийн засгийн боломж, эрх мэдлийг нь хязгаарлан барих, ажил хийлгэхгүй байх, цалин орлогыг нь өөртөө зарцуулах боломж өгөхгүй байх, хоол унд, мөнгөөр хавчин боож, эрхшээлдээ байлгах, өдөр тутмын зайлшгүй хэрэглээг нь хянах, гэр орныхоо эд зүйлийг эвдэх, зарах, зөвхөн өөрийнхөө эрхшээлдээ байлгах зорилгоор эдийн засгийн боломжийг нь хязгаарлах, хамааралдаа оруулах гэх мэт шинж тэмдгээр эдийн засгийн хүчирхийллийг таньж, тогтоох боломжтой бөгөөд энэ талаар шийдвэртээ тусгах нь зүйтэй.

Энэ дасгал ажил ГБХ үйлдэх гэмт хэргийн нотлох баримт, түүнийг үнэлэх талаар нэгдсэн ойлголтод хүрэхэд туслах болно.

Гэрч, хохирогчийн мэдүүлгээр ГБХ үйлдэх гэмт хэрэг үйлдсэнийг тогтоох боломжтой юу? Тийм бол дараах хохирогчийн мэдүүлэгт үндэслэн шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсгийг боловсруулна уу. Хохирогчийн мэдүүлгээс:

"Би өдөр бүр айдастай байдаг. Дөнгөж уржигдар тэр манай гэрт ирээд хаалга нүдээд байсан ч би хаалгаа нээгээгүй. Тэр миний гар утас руу залгаад л байсан, би бас л хариу өгөөгүй, намайг заавал олж авна гэж мессэж ирүүлсээр байсан. Дараа нь биднийг цагдаа дуудсан байх гэж бодоод тэр яваад өгсөн. Өнөөдөр, эсвэл маргааш юу болох бол гэж би үргэлж айдаг. Сэтгэл санааны хувьд байнга түгшүүртэй байснаас эм их хэрэглэдэг болсон. Үүнээс болж миний толгой байнга өвдөж, их турсан. Одоо би хуулийн сургуулийн магистрийн ангид сурч байгаа ч, сургууль руугаа явахаас айдаг. Ажил дээрээ байсан ч миний бодол санаа ажил дээрээ төвлөрч чаддаггүй, учир нь тэр байнга "Би чамайг алах болно, би чиний хаана байгааг мэдэж байгаа, алах болно" гэж мессэж бичиж дарамталдаг. Ажлаас гэр хүрэхэд ганцхан зам байдаг учир орой харихдаа байнга айж түгшдэг, явган явдаггүй. Магадгүй тэр машинтай ирээд намайг аваад явчих байх, бас тэр намайг алчих байх гэж байнга айдаг"

ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэрэгт гэрч, хохирогчийн мэдүүлэг нотлох баримтын гол эх сурвалж байдгийг анхаарах хэрэгтэй.

Дэд сэдэв 3. ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг шийдвэрлэхэд шүүгч субъектив хүчин зүйлсээс сэргийлэх нь

ГБХ үйлдэх хэргийн хувьд шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөтлөн явуулах, шийдвэр гаргах мэдлэг, ур чадвар нь хохирогч, түүний хүүхдүүд, гэр бүлийн бусад гишүүд, гэрч төдийгүй хүчирхийлэл үйлдэгчийн амь нас, эрүүл мэндэд шууд бусаар нөлөөлдөг.

Хэдийгээр ГБХ-ийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь зөвхөн гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхээс гадна нийгэмд ГБХ-ийг үл тэвчих хандлага төлөвшүүлэх, хохирогчийг буруутгах хандлага болон ГБХ-ийн талаарх төөрөгдөлд нөлөөлөхөд эерэг нөлөө үзүүлж байдаг онцлогтой хэдий ч шүүгч тухайн хэргийг шийдвэрлэхдээ төвийг сахих, гэм буруугийн урьдчилсан төсөөлөл, шүүгдэгчийн үйлдэл, хувийн байдлыг "жигших" аливаа хувийн шинжтэй хандлагаас ангижирсан байх шаардлагатай. Ялангуяа, ГБХ нь жендэрт суурилсан хүчирхийлэл байдаг учир хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүгч хүйсийн хувьд ялгаварлахгүй байх, аль нэг талд илүү хандахгүй байх, өөрийн хувийн сэтгэл зүйн бэлтгэлийг хангасан байх ёстой. Энэхүү сэдвийн хүрээнд шүүгчийн хувийн субъектив хүчин зүйлс ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэхэд хэрхэн нөлөөлөх, түүнээс хэрхэн сэргийлэх тухай авч үзнэ.

Субъектив хүчин зүйлс гэж юу вэ?

Нийгмийн шинжлэх ухаанд хүн аливаа шийдвэрийг рациональ ухамсрын түвшинд, сэтгэл хөдлөөс ангид байж гаргадаг гэж үздэг. Хууль, эдийн засаг зэрэг нийгмийн

аль ч шинжлэх ухаанд энэ хандлага хүчтэй оршсон хэвээр байна. Шүүхийн шийдвэр гаргах ажиллагаа ч энэ хандлагыг тойроогүй бөгөөд шүүгч хүн тухайн хэрэгт цугларсан баримтад тулгуурлан хууль зүйн дүгнэлт хийж шийдвэрээ гаргадаг гэж үздэг.

Гэвч сүүлийн үеийн зарим судалгаанд, ялангуяа когнитив шинжлэх ухааны үүднээс хүний тархи, оюун санааны үйл ажиллагаанд тулгуурлан арай өөр өнцгөөс тайлбарлах болжээ. Тухайлбал, сэтгэл судлаач Энди Кларкийн хийсэн судалгаагаар хүний тархи нь мэдрэлийн асар олон тооны эсээс бүрдэх бөгөөд маш хурдан хугацаанд олон талын шууд бус нөлөөлөлтэйгээр шийдвэр гаргадаг тухай авч үзжээ. Мөн Фредрик Хаекын үзсэнээр "Хүний ухамсар бол тодорхой объектыг таньж, тайлбарлаж, түүнийг ангилсны үр дүн юм. Хүний тархи төрөлхийн үзэгдэл, үйл явцыг ангилж хадгалах, түүн дээрээ тулгуурлан шийдвэр гаргах, үнэлэмж өгөх функцтэй. Энэ ангилал ямагт объектив байх боломжгүй бөгөөд тархин дахь мэдрэлийн эсүүд хэрхэн хуваарилснаас хамаарч байдаг" гэжээ. Жишээ нь, боолын нийгэмд хүний хөдөлмөрийг мөлжих явдлыг хүн байж болох хэвийн үзэгдэл гэж хүлээн авдаг. Учир нь хүний тархи, сэтгэн бодох үйл явцад боолчлох ёс нийгмийн амьдралын "хэвийн зүйл"-д ангилагдсан байх бөгөөд түүнийг шударга бус гэж үзэхгүй. Харин орчин цагт боолчлолын тухай бодоход хүмүүсийн ухамсарт шударга бус, хууль бус, тэвчишгүй гэсэн төсөөлөл шууд бууна.

Ийм субъектив хүчин зүйлс хүний амьдралд өдөр тутам тохиолдох бөгөөд цагдаа нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эсэх, эмч цус алдсан өвчтөнд тохирох ямар эмчилгээ хийх, шүүгч хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэж, гэм буруутай эсэхийг тогтоох гэсэн мэргэжлийн үйл ажиллагаанд ч хүртэл тодорхой хэлбэрээр нөлөөлж байдаг

Шүүгч шийдвэр гаргахад субъектив хүчин зүйлс нөлөөлөх үү?

Уламжлалт хандлагаар шүүгч зөвхөн үйл баримтад тулгуурлаж, хуульд захирагдан шийдвэр гаргадаг гэж үздэг. Ингэхдээ шүүгч аливаа шийдвэрийг өөрийн дотоод итгэл үнэмшлээр гаргах ёстой.[106] Субъектив хүчин зүйлс шүүгч шийдвэрээ гаргахад нөлөөлөх боломжтой гэж үзэх гол үндэслэл нь энэ дотоод итгэл үнэмшил гэх ойлголттой холбоотой. Шүүгчийн дотоод итгэл үнэмшил бол шүүх судлалын хүрээнд хамгийн бага судлагдсан, ээдрээтэй сэдэв мөн. Шүүгчийн итгэл үнэмшил хууль болон үйл баримтын хүрээнд тогтож, шийдвэр гардаг гэж ихэнх хүмүүс итгэдэг. Ингэхдээ шүүгч хуулийн зүйл заалтыг тайлбарлан хэрэглэх замаар дотоод итгэл үнэмшлээ үндэслэлтэйгээр зөвтгөх ёстой.

Гэвч эдгээр нь шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны зөвхөн хэлбэрийн талыг харуулах бөгөөд далд, нууц хүчин зүйлсийг тайлбарлаж огт чаддаггүй. Өмнө дурдсанаар хүн юмс, үзэгдлийг ангилж, "шошголох" төрөлхийн функцтэй бөгөөд шүүгч ч мөн адил хүн учир ийм итгэл үнэмшлийн системтэй.

Шүүхийн шийдвэр гаргах ажиллагаанд шүүгчийн хувийн итгэл үнэмшил, туршлага, амьдралыг үзэх хандлагын талаарх судалгаанд шүүгчийн хувийн үзэл, хандлага, төсөөлөл зэргийг субъектив хүчин зүйлс гэж нэрлэдэг. АНУ-ын Дээд шүүхийн шүүгч агсан Оливер Вендел Холмэс "Эрх зүйг хэрэглэх, хэрэгжүүлэх ажил нь зөвхөн тархины логик сэтгэлгээний үр дүн биш. Харин амьдралын туршлага юм." гэж хэлсэн нь шүүхийн шийдвэр гаргах ажиллагаа зөвхөн объектив хууль зүйн дүгнэлт гаргах ажиллагаа биш, амьдралдаа цуглуулсан мэдлэг, чадвар, хандлагаар нөхцөлдөж байдаг гэсэн санаа юм. Жишээ нь, шүүгч Б бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг шийдвэрлэх шүүх хуралдааныг даргалахаар болсон бөгөөд хуралдаан эхэлж, шүүгдэгчид эрх, үүрэг танилцуулсны дараа "Чи ёстой ясны хулгайч юм аа" хэмээн шүүгдэгчийг загнасан. Энэ хэргийн шүүгдэгч өмнө нь хулгайн гэмт хэрэг давтан үйлдсэн байсан. Дээрх жишээнээс үзвэл шүүгч тухайн хэргийг зөвлөлдөх тасалгаанд орж шийдвэрлэхээс өмнө буюу гэм бурууг эцэслэн тогтоохоос өмнө "давтан хулгайн хэрэг үйлдсэн учир дахиад үйлдсэн" гэсэн нэгэнт тогтсон итгэл үнэмшилтэй,

106 John N.Drobak, Douglass B.North, Understanding Judicial Decision-Making: The Importance of Constraints on Non-RationalDeliberations, Washington University, Journal of Law and Policy, 131 (2008), p.132

гэм буруугийн урьдчилсан төсөөлөлтэй болсон байна. Ийм тохиолдолд хэдийгээр шүүгдэгчийн гэм бурууг тогтоогоогүй боловч шүүгчийн дотоод итгэл үнэмшилд аль хэдийнээ "шүүгдэгч хулгайн гэмт хэрэг үйлдсэн, муу хүн" гэсэн төсөөлөл бий болсон байх бөгөөд үүнээс урьдчилан сэргийлж байх ёстой.

Субъектив хүчин зүйлсийн эх сурвалж, эрсдэлт хүчин зүйлс

Шүүхийн шийдвэр гаргах ажиллагаан дахь субъектив хүчин зүйлсийн эх сурвалжийг дараах зүйлстэй холбон тайлбарладаг:

Хувийн туршлага: Боловсрол, уламжлал, нийгмийн хүчин зүйлс, мэдээллийн солилцоо;

Нөлөөт хүчин зүйлс: Хувь хүнд тохиолдсон үйл явдлаас улбаатай айдас, бусад сөрөг үнэлэмж болон сэтгэл зүйн тогтворгүй байдал;

Соёлын ялгаа: Нийгмийн тодорхой хүрээнд төрөл бүрийн соёлын түвшин бий бөгөөд энэ нь хүсээгүй байхад ч субъектив хүчин зүйлс, шууд бус ялгаварлалыг үүсгэж болно.

Бие хүний хүчин зүйлс: Хувь хүний тодорхой юмс, үзэгдэлд хандах хандлага, зарчим, байр суурь.

Эдгээр эх сурвалжууд нь шийдвэр гаргах ажиллагаанд дараах эрсдэлт хүчин зүйлсээр өдөөгддөг: тухайн үеийн сэтгэл зүйн байдал, хууль тогтоомж, үйл баримтын эргэлзээтэй байдал, шийдвэр гаргах чадвар, чадамж дутмаг байх, ажлын ачаалал, стресс, нийгмийн хүчин зүйлс, асуудлыг өөр өнцгөөс харах, тайлбарлах чадвар дутмаг байх зэрэг болно.

ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэрэг ба субъектив хүчин зүйлс

ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэрэгт шүүгч төвийг сахих, субъектив далд хүчин зүйлсээс ангижирсан байх онцгой шаардлага бий. Энэ онцгой шаардлага нь ГБХ-ийн өөрийнх нь онцлогтой холбоотой. Иймд шүүгч субъектив хүчин зүйлсээс сэргийлж, дараах асуудлыг анхаарах хэрэгтэй.

Хэн нэгнийг буруутгах аливаа урьдчилсан төсөөллөөс ангижрах: Шүүгч тухайн гэр бүлийн дотоод уур амьсгал, гэр бүлийн гишүүдийн хувийн байдал, харилцааг мэдсэн байдаг. Иймд хувь хүний үүднээс аль нэг талыг буруутгасан төсөөлөл бий болсон даруйд түүнийг тэвчих хэрэгтэй. Жишээ нь, эхнэрийн хувийн амьдрал, бусадтай харилцаа холбоотой байдал зэргээр нь хохирогчийг буруутгасан хандлага гаргаж хэрхэвч болохгүй.

Стрессийн хүчин зүйлсийг бууруулах: Ажлын болон орчны стресс нь хүний шийдвэр гаргах чадварыг ямагт бууруулж байдаг. Шийдвэр гаргах, анхаарал хандуулах чадвар буурснаар ГБХ-ийг цогцоор нь харах, дүгнэлт хийх боломжгүй болдог.

Цагийн хуваарилалт, ажил ба амралт: Хэт их ачаалал авсан, сэтгэл зүйн хувьд тогтворгүй байгаа тохиолдолд түр чөлөө авах, өөр зүйлд анхаарлаа хандуулах, түр хугацаанд ажлаасаа хөндийрөх, магадгүй 30 минут унтаж амрах нь энэ төрлийн субъектив хүчин зүйлсээс салах арга болно.

Сэтгэл зүйн тогтвортой байдал: Сэтгэл зүйн тогтворгүй байдал нь хүнийг рациональ бус шийдвэр гаргахад хүргэх бөгөөд сэтгэл догдолсон, эсхүл гутарсан аль аль үед шийдвэр гаргах ажиллагаа буруугаар эргэх хандлагатай байдаг.

ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг шийдвэрлэхдээ шүүгч хүчирхийллийн үйлдлүүдийг цогцоор нь дүгнэх, хүчирхийллийн динамик, тэдгээрийн хохирогчид үзүүлэх нөлөөллийг тогтоосон байх нь чухал. Жишээ нь, хохирогчид цаашид энэ хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд ямар нэг хүндрэл бэрхшээл, төвөг саад, аюул занал учрахгүй гэсэн итгэлийг бүрдүүлэх хэрэгтэй.

Энэ дасгал ажил хүний сэтгэн бодох үйл явцад рефлексив буюу субъектив хүчин зүйлс хэрхэн нөлөөлдөг болохыг мэдэж, таних чадвартай болоход туслах болно.

Дараах өнгийг хараад шууд нэрлэж үзнэ үү.

ХӨХ ЯГААН ШАР

ХАР УЛААН

ЦАГААН НОГООН

ЦЭНХЭР

Жишээлбэл, "ягаан" гэснийг уншсан хүний сэтгэхүйд автоматаар ягаан өнгө дүрслэгдэх боловч бодит байдалд ягаан өнгөний оронд цэнхэр өнгө дүрслэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, хүн тодорхой нэг ойлголтыг тархиндаа хүлээн авахдаа аль хэдийн ямар нэг байдлаар өөрийн үнэлэмж, төсөөллийг бий болгосон байдгийн жишээ юм.

Дараах бодомжийг уншаад ямар нэг байдлаар хүлээн зөвшөөрч байгаа бол "тийм", огт хүлээн зөвшөөрөхгүй бол "үгүй", эргэлзэж байвал "мэдэхгүй" гэсэн хариултыг сонгоно уу.

ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч өөрийн хувийн үзэл бодолдоо хөтлөгдөх магадлалтай байдгийг анхаарах хэрэгтэй.

3.3.2. ШҮҮГЧЭЭС ГБХ ҮЙЛДЭГЧ, ГЭРЧ, ХОХИРОГЧТОЙ ХАРИЛЦАХ АРГА БАРИЛ

Шүүгчээс хэргийн оролцогчид (хохирогч, шүүгдэгч, гэрч)-той тогтоож буй харилцаанд хамгийн чухал байр суурь эзэлдэг нь шүүх хуралдааны танхим дахь харилцаа юм. Манай улсын шүүх судлалын практикт шүүгчийн харилцаа, хандлагатай холбоотой хийсэн судалгаа, шинжилгээ цөөн байх бөгөөд Нээлттэй нийгэм форумаас 2010, 2015 онд явуулсан "Шүүхийн ажиглалтын тайлан"-д дүн шинжилгээ хийж үзвэл шүүгчийн биеэ авч явах байдал, харилцаа холбоонд анхаарах дараах нийтлэг асуудлууд байгааг тэмдэглэжээ:

- Шүүх хуралдаан товлосон цагаасаа хоцрох, энэ талаар хэргийн оролцогчдод үндэслэл бүхий мэдээлэл өгөхгүй (зарим тохиолдолд уучлалт гуйхгүй) байх;
- Хавтаст хэрэгтэйгээ сайтар танилцаагүй нь шүүгчийн ярианаас мэдэгдэх;
- Хэргийн оролцогчидтой ярилцахдаа тэдэнд олгосон цаг нь харилцан адилгүй байх;
- Хэргийн оролцогчдыг үл хүндэтгэх, яриаг таслах, үл ойшоосон байдалтай сонсох;
- Хувцаслалт, биеэ авч явах байдалд анхаарахгүй байх (хэт задгай, эсхүл богино хувцас өмсөх, хиртэй, индүүдлэггүй үрчгэр хувцас өмсөх гэх мэт).

Шүүгчээр олон жил ажилласан туршлагатай О.Нарангэрэл шүүгч "Иргэд шүүхийн шийдвэрт биш, шүүгчид гомдох тохиолдол их байна. Энэ нь шүүгчийн дотоод итгэлд гомдохоос өөр асуудал юм. Тэдний бусадтай харилцах зан харилцаа (дээрэлхүү зан, тоомжиргүй байдал, өөрийг нь сонсохгүй, үл хүндэтгэсэн байх гэх мэт), эсхүл ажил мэргэжилдээ хандах хандлагад (ажилдаа цагтаа ирэхгүй хүлээлгэх, хурлаа цагт нь эхлэхгүй байх, ярилцаж байх үедээ бусадтай утсаар ярих, хурал дээрээ утсаар ярих, өөр хэрэг унших г.м) гомдож байна[107] гэжээ.

Шүүгчээс хохирогчтой харилцах арга

107 О.Нарангэрэл, "Харилцааны соёлын тухай бодрол" эссэг бүрэн эхээр нь дараах холбоосоор уншина уу. Холбоос: http://www.jud-council.mn/main/1242--.html

барил, анхаарах асуудал

Шүүгчийн хохирогчтой харьцах харилцаа бол ихэвчлэн шүүх дээр (урьдчилсан хэлэлцүүлэг эсхүл шүүх хуралдааны үеэр) өгөх мэдүүлгээр хязгаарлагддаг. Шүүгчийн зүгээс асуулт асуух боломжтой бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд тавих асуултын төрөлд хяналт тавих эрхтэй. Хохирогч урьд нь шүүхтэй харилцаа тогтоож байсан болзошгүй (жишээ нь, таслан сэргийлэх арга хэмжээ өөрчлөх шүүх хуралдаан болон эрүүгийн хэрэгтэй хамт иргэний хэргийн шүүх хуралдаанд оролцож байсан) гэдгийг шүүгч анхаарахын зэрэгцээ одоо болж байгаа шүүх хуралдааны процесс ажиллагаа, гарч болох үр дүн болон хохирогчийн хувьд гарах үр дагавар зэргийг тодорхой тайлбарлахад бэлтгэлтэй байна.[108]

Хуралдаан болохоос өмнө (урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаан болон шүүхийн танхимд) шүүгч дараах байдлаар бэлтгэлийг хангах, хохирогчтой хэрхэн харьцах, ямар төрлийн мэдээлэл өгөх зэргийг авч үзэх шаардлагатай байна.

Шүүхийн танхимд аюулгүй байдал болон үр дүнтэй байдлыг хангах:

- Шүүхийн танхимд мөрдөгдөж буй аюулгүй ажиллагааны журам (үүнд, аюулгүй байдал хангахтай холбоотой асуудлууд, шүүгч болон шүүхийн бүх ажилтнуудын хувьд ГБХ-ийн хэрэгт зохих хариу арга хэмжээ авах чадвартай байх зэрэг асуудал багтана)-ыг тогтмол үнэлж дүгнэх.
- Хохирогчоос аюулгүй байдал, дэмжлэг үзүүлэх үйлчилгээний талаар асууж тодруулахад бэлэн байх.
- Хамт шийдвэрлэгдэж буй хэргүүдийн талаар лавлаж, боломжтой бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (ялангуяа эрүүгийн болон иргэний хэргийг хамт шийдвэрлэх ажиллагаа)-г зохицуулах арга хэмжээ авах.

Хохирогчтой харилцах:

- Хохирогчийг анхааралтай сонсох. Мөн зарим зүйлийг тодруулах үүднээс асуултыг идэвхтэй тавих. Хохирогч шүүх хуралдааны танхимд хэнэггүй хандах, өөрөө санал нийлэхгүй хэдий ч хүчирхийллийн төлөө хариуцлага хүлээх зэрэг үйлдэл гаргаж болно.
- Хэт их хөндлөнгөөс оролцсон, ичгүүртэй байдал төрүүлсэн, хэт олон давтагдсан асуултыг асуухгүй байх.

Шүүхийн танхимд бие авч явах байдал:

- Хохирогчийн зүгээс хамтран ажиллахыг хүсэхгүй байгаа тохиолдолд ундуулцал бухимдлаа гаргахгүй байх. Хэлж байгаа зүйл болон биеийн харилцааны хэлээр илэрхийлж буй зүйлийг ямагт санаж байх.
- Шийдвэр гаргахад хэрэглэж буй үг хэллэг болон илэрхийлж буй санаа тань хохирогчид болон хүчирхийлэл үйлдэгчдэд хэрхэн хүрч байгаад мэдрэмжтэй хандах.
- Шүүхийн индрээс хэлэх үг болон шүүхийн танхимд биеэ авч явах байдал (аман бус харилцаа) зэрэг нь шүүхээс ГБХ-ийн хэргийг нухацтай авч үзэж байгааг илэрхийлэх.

Шаардлагатай мэдээллийг өгөх:

- Хохирогчийн эрх, үүргийг тайлбарлах.
- Тухайн хуралдааны зорилго болон процесс ажиллагааны талаар тайлбарлах.
- Шүүх хуралдааныг дуусгавар болоход хохирогчийн зүгээс шүүхийн танхимаас гарахад аюулгүй байдлыг хангах зорилгоор харуул хамгаалалт шаардлагатай эсэхийг лавлах.

Хохирогчийн эрх, үүргийг уншиж танилцуулах нь хангалтгүй болохыг зөвлөдөг. Хохирогчтой холбогдох эрүүгийн процесс ажиллагаа, түүний эрх, үүргийн талаар ярилцах нь илүү үр дүнтэй бөгөөд ингэснээр түүнд асуулт тавих боломжийг олгоно.

ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийг хянан

108 Анна Костанза Балдри болон Элизабет Дубан.Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон ГБХ-тэй тэмцэхэд хууль сахиулах болон шүүхийн байгууллагын ажилтнуудын үр нөлөөг сайжруулах явдал, 2016

шийдвэрлэх явцад шүүгчээс хохирогчтой харилцах харилцаанд онцгой анхааралтай хандах учиртай байдаг нь ГБХ-ийн хохирогчийн хувьд хүчирхийллийг "тэвчих хандлага"-тай байдаг үеэ нэгэнт туулж, хүчирхийлэл үйлдэгчээс холдох, түүний эрхшээлээс гарах зорилготой байдгаас шалтгаалдаг. Энэ үед шүүх, шүүгч түүний асуудлыг шийдвэрлэхэд хайхрамжгүй, удаан, бусад хөнгөн гэмт хэрэгтэй адилтган авч үзэх нь хохирогчийн шүүхэд итгэх итгэлийг бууруулаад зогсохгүй, мэдүүлгээсээ буцахад хүргэж болох юм. Энэ тохиолдолд хүчирхийлэл үйлдэгч ял завших, хүчирхийлэл улам даамжирч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах магадлал нэмэгдэх болно.

Шүүгч шүүх хуралдааны явцад хохирогчоос мэдүүлэг авах үйл явцыг төлөвлөх, мэдүүлэг авах үеийн уур амьсгал, байр, танхимыг бэлтгэх, мэдүүлэг авахдаа дараах зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд:

- Хохирогчтой хаана, ямар байдлаар мэдүүлэг өгвөл дээр байх талаар ярилцах;
- Аюулгүй, тухтай байрыг бэлтгэхийг шүүхийн тамгын газарт даалгах (хохирогчийг шүүх хуралдааны танхимаас тусгаарлаж мэдүүлэг авах, тусдаа өрөө, уух ус, нулимс арчих цаас гэх мэт);
- Хохирогчид мэдүүлэг өгөхөөр ирэх, явахдаа аюулгүй, хүчирхийлэл үйлдэгчтэй болон бусад уулзахыг хүсэхгүй байгаа хүмүүстэйгээ тааралдахгүй гэдэгт итгэлтэй байх хэрэгтэйг зөвлөх, тийм боломжийг бүрдүүлэх;
- Хохирогч хамгаалах байр, эсхүл ижил төстэй байгууллагаас дэмжлэг авч буй эсэхийг нягтлах хэрэгтэй.

Шүүгчийн харилцаа зөвхөн мэдүүлэг авахаар хязгаарлагдахгүй бөгөөд шүүх хуралдааныг удирдах явцад хохирогч, хүчирхийлэл үйлдэгч, гэрчтэй үгэн болон үгэн бус харилцааны элементүүдийг ашиглан харилцаа тогтоож байдаг. Шүүгчийн үгэн болон үгэн бус харилцаанд анхаарах зөвлөмжийг нэмэлт мэдээллээс үзнэ үү.

Шүүгчээс хүчирхийлэл үйлдэгчтэй харилцах арга барил, анхаарах асуудал

ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийн хувьд яллагдагч, шүүгдэгч нь ямагт хуулийн зохих хариуцлагаас бултах, ийнхүү бултахдаа хохирогч, гэрчийг дарамтлах арга замыг эрэлхийлж байдгийг санах хэрэгтэй. Шүүгч ГБХ үйлдсэн шүүгдэгчээс мэдүүлэг авахдаа дараах зүйлсийг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Хүчирхийллийн ноцтой байдлыг сааруулсан (жишээ нь, хэрүүл, зөрчилдөөн гэх зэргээр шүүгч нөхцөл байдлыг зөөлрүүлж огт болохгүй) үг хэллэгийг хэрэглэхээс аль болох татгалзах хэрэгтэй. Энэ нь шүүгдэгч Таны хэлсэн үгэнд дөрөөлж, хохирогчтой жижиг маргаан, хэрүүл үүсгэсэн гэсэн тайлбар мэдүүлэг өгч, шүүх хуралдааны танхимын уур амьсгалыг өөрчлөх магадлалтай.
- Өөрийгөө болон өөрийнхөө үйлдлийг зөвтгөсөн, үүнийхээ тулд хохирогчийг буруутгах, шүүмжлэх зэргээр шүүх хуралдааны уур амьсгалыг өөрийн талд бүрдүүлэх гэсэн бүх оролдлогыг нь эрүүгийн процессын хуульд заасан боломжит аргаар няцаах хэрэгтэй.
- Хэргийг бүрэн дүүрэн нотлоход дөхөм болох үүднээс хүчирхийллийн улмаас хүүхэд, эмэгтэйчүүдэд учирсан бие махбод, сэтгэл санааны болон хууль зүйн үр дагаврын талаар асуулт асуух хэрэгтэй.

Хийсэн үйлдлийнхээ талаар ярьж байгаа хүчирхийлэл үйлдэгч гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй, нотлох баримтыг үгүйсгэх магадлалтай тул түүнээс мэдүүлэг авахдаа асуулт аль болох тодорхой, товч, шууд чиглэсэн байх нь оновчтой. Дараах асуултууд байж болохыг олон улсад зөвлөмж болгосон байна. Үүнд:

- Та эхнэрээ хэдэн удаа зодсон бэ?
- Та эхнэрээ яаж зодсон бэ?
- Танд өөрт чинь ямар санагдаж байсан бэ?
- Эхнэр чинь хариуд нь яасан бэ?
- Зодуураас ямар ул мөр үлдсэн бэ?

Мөн хүчирхийлэл үйлдэгчээс мэдүүлэг авахад гардаг нэг бэрхшээлтэй зүйл бол хүчирхийлэл үйлдэгчийг "ойлгож байгаа буюу эмпати" байдлаар асуултуудыг тавих явдал байдаг.

Энэ үед хүчирхийлэл үйлдэгчийн хувь хүн дээр биш, хүчирхийллийн үйлдэл дээр төвлөрөх хэрэгтэй.

- Хүчирхийлэл үйлдэгчийн өөрийн биеэ барьж чадах хязгаар нь хаана вэ гэдгийг ойлгоход нь туслах. Олон эрчүүд хүчирхийллийг "биеэ барьж чадаагүй" гэдгээр тайлбарладаг. Хүчирхийллийн зорилго юу вэ гэдэгт төвлөрч "хүчирхийлэл үйлдлээ гээд эрэгтэйд ямар үр ашиг байна вэ" гэдэг асуултад хариулт авахаа мартаж болохгүй.
- Сэтгэл санааны хүчирхийллийн хэлбэрт онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Жишээ нь, доромжлол, бусдаас болон нийгмээс хохирогчийг тусгаарлах, орлогогүй гэр бүлийн гишүүнээ мөнгө хөрөнгөөр хавчих зэрэг нь сэтгэл зүйн ноцтой гэм хорыг дагуулдаг. Ийм хүчирхийллийн хор уршгийг хүчирхийлэл үйлдэгчид хэлж өгөх хэрэгтэй.

Шүүгчээс гэрчтэй харилцах арга барил, анхаарах асуудал

ГБХ үйлдэх зөрчил, гэмт хэргийн нотлох баримт бусад төрлийн хэргээс ялгагдах онцлогтой талаар өмнө авч үзсэн. ГБХ үйлдэх гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд гэрчийн мэдүүлэг, түүнийг үнэлэх асуудалд онцгойлон анхаарах шаардлагатай. Гэрчийн талаарх нийтлэг ойлголтыг гарын авлагын ерөнхий сэдвээс үзэх боломжтой бөгөөд шүүгч түүнээс мэдүүлэг авахдаа дараах асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй.

Юуны өмнө гэрч хүчирхийлэл үйлдэгчтэй ойр дотны болон садан төрлийн холбоотой байх, эхнэр, нөхрүүд дандаа муудалцаж байдаг, байдаг л зүйл гэх олон нийтийн ташаа ойлголт, гэрчийг хамгаалах бүтэц, тогтолцоо, механизм сул зэрэг олон төрлийн шалтгааны улмаас гэрчийн мэдүүлэг өгөхөд саад болдог хүчин зүйлс байдгийг тооцоолоорой.

Шүүгч гэрчтэй харилцахад дараах нөхцөл байдлууд илэрч байгаа бол түүний хэр хэмжээ, давтамжийг анхааралтай ажиглах хэрэгтэй. Үүнд:

- Гэрч мэдүүлэг өгөхдөө чөлөөтэй, тайван байсан, түүний мэдүүлэг нь ихээхэн нарийвчлалтай байгаа бол энэ нь хэргийг шийдвэрлэхэд чухал нөлөөлөх хүчин зүйл мөн. Үүнээс гадна мэдүүлэг өгч байхдаа гэрч ямар байдалтай байсныг бодолцох хэрэгтэй.
- Хэрэв гэрч асуултад түгдэрсэн, зарим зүйлийг мэдэхгүй байсан, түүнчлэн зөвхөн хамгийн чухал зүйлийг хэлээд дэлгэрүүлэхгүй байгаа бөгөөд шүүх тодруулах үүднээс байнга нэмэлт асуулт тавих шаардлагатай болж байгаа бол энэ мэдүүлгийг үнэн зөв гэж үзэхэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл байж болох юм. Гэрч нь мэдүүлэг өгч байхдаа аль нэг талруу байнга харсан, гараа атгаж нуусан байдал үзүүлээд байгаа бол энэ мөн л сөргөөр нөлөөлөх хүчин зүйл мөн.
- Мөн эргэлзээтэй мэдүүлэг өгсөн гэрчийн (түүний дотор анх хэргийн газарт очсон цагдаа) урьд өгсөн мэдүүлгийг уншиж сонсгоод "Та үүнийгээ баталж байна уу" гэхэд ихэнх нь "тийм" гэж хариулдаг.
- ГБХ-ийн хувьд гэрч нь гол төлөв тухайн гэр бүлийн гишүүн, эсхүл шүүгдэгч, хохирогчтой ойр дотны харилцаатай хүн байдаг. Тэгэхээр гэрчээс үнэн зөв мэдүүлэг авах нь хамгийн чухал бөгөөд үүний тулд шүүх хуралдаанд Таны тавих асуулт аль болох шууд чиглэсэн, тодорхой байх нь чухал. Ийм асуулт тавихын тулд шүүгч хэргийн нөхцөл байдалтай сайтар танилцсан байх хэрэгтэй. Асуулт нь гол төлөв "тийм", "үгүй" гэж хариулагдах, тодорхой өдөр, цаг хугацаа, минут, тоо, хэмжээ зэрэг тодорхой зүйлийг асуусан байвал зохино.
- Мөн шүүх хуралдаанд гэрч шүүгдэгч, эсхүл хохирогчоос айж эмээсэн, сандарсан, түгшсэн, зэвүүцсэн зэрэг сэтгэл зүйн хурц байдалтай байгаа эсэхийг тогтмол ажиглах, тийм нөхцөл байдал илэрвэл нөхцөл байдлыг хэвийн болгох, гэрч үнэн зөв мэдүүлэг өгөх бусад нөхцөл байдал, орчинг бүрдүүлэх хэрэгтэй.

Энэ дасгал шүүгч ГБХ үйлдэгч болон хохирогчтой харилцах үгэн харилцаандаа анхаарахад дэмжлэг болно.

Дараах талбарт шүүгчээс хүчирхийлэл үйлдэгч, хохирогчоос асуух болон асууж болохгүй асуултуудыг тодорхойлно уу.

	Асуух асуулт	Асууж болохгүй асуулт
Хүчирхийлэл үйлдэгч		
Хохирогч		

3.3.3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗӨРЧИЛ ГАРГАГЧИД ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ, ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧИД ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ, ЯЛ ОНОГДУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

ДЭД СЭДЭВ 1. ГБХ үйлдэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээ авахад харгалзан үзэх хүчин зүйлс, албадлагын бусад арга хэмжээ

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээд уг гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан бол түүнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан, шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол цагдан хорьж болно.[109]

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ[110] нь таслан сэргийлэх арга хэмжээний хамгийн хүнд төрөл бөгөөд бусад таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх боломжгүй тохиолдолд хэрэглэнэ. Шүүх ГБХ үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээг оновчтой авч, уг ажиллагаанд үр дүнтэй оролцох нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Хохирогчийг цаашид ГБХ-д өртөхөөс хамгаална;
- Хүүхэд болон бусад гэр бүлийн гишүүдийг хүчирхийлэлд өртөхөөс хамгаална;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангана;
- Хүчирхийлэгчийн хийсэн үйлдэлд ял оногдуулна;
- Нийгэмд ГБХ-ийг ахин гарахаас урьдчилан сэргийлнэ;
- Хүчирхийлэл үйлдэгчийг засан

109 ЭХХШтХ-ийн 14.9 дүгээр зүйлийн 1

110 Монгол Улсын ЭБШХ-ийн тайлбар, Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр, 2003 он, УБ

хүмүүжүүлнэ гэх мэт.

Түүнчлэн ГБХ-ийн хэргийн хохирогчийг хамгаалах шуурхай арга хэмжээ авч, хохирогчийн нөхцөл байдлыг мэдэж ойлгох нь ГБХ-тэй тэмцэхэд чухал ач холбогдолтой. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад болон хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх хүртэл хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор, шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчид цагдан хорих, хязгаарлалт тогтоох ТСАХ авч болно.

Шүүх яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авна.

ГБХ үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авахад нөлөөлөх хүчин зүйлс:

- Хүчирхийлэл даамжрах хандлагатай бол
- Хүчирхийллийн хэрэг болжээ гэсэн бодит баримт сэлт, ул мөр байгаа бол
- Цагдаагийн ажилтны нүдэн дээр хэрэг үйлдэгдсэн бол
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүн таслах ажиллагаанд хүчирхийлэл үйлдэгч саад болох магадлал бий бол
- Урьд өмнө хүчирхийлэл үйлдэж байсан бол
- Хохирогч цаашид дахин хүчирхийлэл үйлдэгдэнэ гэсэн бодит айдастай байгаа бол
- Хүчирхийлэл үйлдэгч архи, хар тамхи хэрэглэдэг, сэтгэцийн өвчтэй бол
- Өмнө нь давтамжтай хугацаанд ГБХ үйлдэж, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээж байсан, цагдаагийн гомдол, мэдээллийн сүлжээнд бүртгэлтэй бол
- Урьд өмнө нь авч байсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчиж байсан бол
- Аюулын зэргийн үнэлгээ
- Мөрдөн байцаагч, прокурорын хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаарх санал

ГБХ үйлдэгчид ТСАХ авахад нөлөөлөхгүй хүчин зүйлс:

- Гэр бүлийн байдал
- Гэр бүлийн өмчийн харилцаа, өмчлөлийн байдал
- Амаараа дахиж хүчирхийлэхгүй гэж амлаж итгүүлэх гэж оролдож байгаа байдал
- Хохирогч өөрөө энэ бүхэнд хүргэсэн гэсэн итгэл үнэмшил төрүүлсэн
- ГБХ үйлдэгчийн биед ямар нэг гэмтэл байгаа
- Аль аль тал нь цаашид хүчирхийлэл гаргахгүй гэж тухайн агшинд тохирсон байгаа
- Тусгаарласны улмаас гэр бүлд санхүүгийн ямар нэг гарз учирна
- ГБХ үйлдэгч, хохирогчийн нийгэм, эдийн засгийн статус

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгч ямагт хохирогчийг өөрийн эрхшээлд оруулах гэсэн сонирхолтой байдаг бөгөөд шүүх хуралдааны өмнө энэ байдал илүүтэй ажиглагддаг. Иймд таслан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч байх нь зүйтэй бөгөөд ингэснээр хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалаад зогсохгүй хэргийг бүрэн бодитой шийдвэрлэхэд дөхөм болно.

Таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа ямар ч үедээ хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд авч үзэх ёстойг анхаарах хэрэгтэй. Мөн таслан сэргийлэх арга хэмжээ авсан, цуцалсан, татгалзсан тухай бүрт хохирогчид мэдэгдэж байх нь түүний амь насыг хамгаалах нэг арга болдгийг анхаарах нь чухал.

Прокуророос шүүхэд ирүүлсэн ГБХ-ийн хэргийг хүлээн авч, шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтоосон журмын дагуу шүүгчид хуваарилахдаа ГБХ-ийн талаарх мэдээллээр сайн хангагдсан, ГБХ-ийн хэргүүдийг яаж шийдвэрлэх талаар бэлтгэгдсэн зэргийг харгалзан үзэх боломжтой.

Хэрэг хүлээн авсан шүүгч хэрэгтэй танилцаад яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, хэргийг нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаах, хэргийг түдгэлзүүлэх, харьяалах шүүхэд нь шилжүүлэх шийдвэрийн аль нэгийг гаргана. Эдгээр шийдвэрийг гаргахад ГБХ-ийн нарийн төвөгтэй байдал болон цар хүрээ, хохирогчид үзүүлэх

нөлөөллүүд, тэдний зүгээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хандаж буй байдал зэргийг ойлгох нь чухал байдаг.

Энэ дасгал ГБХ-ийн хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн ээлжинд хангахад хүчирхийлэгчид авах таслан сэргийлэх арга хэмжээг оновчтой тодорхойлох ур чадварт суралцахад туслах болно.

Дараах тохиолдолтой танилцаж, асуултад хариулна уу.

А нь инженер мэргэжилтэй, нэгэн компанид менежер ажилтай, эхнэр О нь 3 хүүхдийн хамт амьдардаг. 2016 оны 8 дугаар сарын 5-6-нд шилжих шөнө эхнэртэйгээ хувийн таарамжгүй харилцааны улмаас маргалдан муудалцах явцдаа тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодон эхнэр О-г дайрч санаатай алахыг завдсан. Өмнө нь 2013 онд 3 удаа, 2014 онд 4 удаа, 2015 онд нэг удаа байнга зодож, тарчлаах гэмт хэрэг үйлдэж байсан. Тэрбээр мөрдөн байцаалтын шатанд "Эхнэр О бид хоёр архи хэтрүүлэн хэрэглэсэн үедээ машин жолоодож яваад санаандгүй осол гаргасан" гэж мэдүүлсэн бол хохирогч А нь их хартай, тааралдсан эрэгтэй болгонтой харддаг, ална гэж сүрдүүлсэн" гэж мэдүүлсэн байна. Мөрдөн байцаалтын болон прокурорын шатанд гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ аваагүй.

Хүчирхийлэл үйлдэгчид ямар таслан сэргийлэх арга хэмжээ авах нь хохирогчийг хамгаалахад хэр тохиромжтой вэ?

ГБХ-ийн хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн ээлжинд хангалзан үзэж, шаардлагатай арга хэмжээг нэн тэргүүнд авах хэрэгтэй.

Албадлагын арга хэмжээ

Шүүх Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.[111]

Албадлагын арга хэмжээний төрөл:

- үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;
- эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;
- хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.

Эрүүгийн хуульд[112] зааснаар шүүх ГБХ үйлдэх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, эрхийн хязгаарлалтыг тогтоож болно. Дараах үүргийг хүлээлгэнэ:

- гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах;
- зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах;
- тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх;
- оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх.

Мөн дараах хязгаарлалт тогтооно:

- тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах;
- галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох;
- согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох;
- тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох.

Хэрэв ГБХ үйлдэгч шүүхээс хүлээлгэсэн дээрх үүргийг биелүүлээгүй, мөн хязгаарлалтыг зөрчсөн бол шүүх уг шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулна.

111 Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйл

112 Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйл

Энэ дасгал нь ГБХ үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа ГБХ-ийн онцлогийг харгалзах, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэгчийн тактикт тулгуурлан шийдвэрлэх хандлага, мэдлэг, чадвараа хөгжүүлэхэд туслана.

ГБХ үйлдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авахад нөлөөлөх болон нөлөөлөхгүй хүчин зүйлсийг тоочно уу.

Таслан сэргийлэх арга хэмжээ авахад нөлөөлөх хүчин зүйлс	Таслан сэргийлэх арга хэмжээ авахад нөлөөлөхгүй хүчин зүйлс

ДЭД СЭДЭВ 2. ГБХ үйлдэх зөрчил гаргагчид шийтгэл ногдуулах, гэмт хэрэг үйлдэгчид ял шийтгэл оногдуулах, анхаарах хүчин зүйлс

ГБХ, түүний хохирогчийн онцлог шинж, чанарыг таньж мэдэх нь ГБХ-тэй тэмцэхэд чухал ач холбогдолтой. ГБХ нь давтагдах, даамжрах шинжтэй тул энэ үед хохирогчийн нөхцөл байдлыг ойлгож, түүнийг хамгаалах шуурхай арга хэмжээ авах хэрэгтэй. Хэрэв хүчирхийлэл үйлдэгч ял шийтгэлгүй үлдвэл түүний эрх мэдэл, гэр бүлийн харилцаан дахь ноёрхол улам даамжирч, хүчирхийлэл давтагдах, хор уршиг нэмэгдэх эрсдэл өндөртэй.

ГБХ-ийн хэрэгт эрүүгийн хэргийн шүүхийн гүйцэтгэх үүргийн талаар Америкийн нэгэн мөрдөгч тэмдэглэхдээ "Жинхэнэ амжилт алуурчныг яллахдаа биш, аллагаас урьдчилан сэргийлэх явдал гэдгийг бид олж харах хэрэгтэй. Энэ нь хэрэгтнүүдийг олон арван жилээр цоожны цаана суулгахдаа биш, харин ГБХ-ийн хүнд хэлбэрийг багасган, улмаар хүчирхийллийг зогсооно гэсэн үг юм. Хүний бие махбодод бага ч гэсэн гэмтэл учруулсан бол үүнийг нухацтай авч үзэх хэрэгтэй" гэжээ.

"ГБХ–тэй тэмцэх тухай хууль зөрчих" зөрчил гаргагчид шийтгэл оногдуулах

Шинэчлэн найруулсан Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд зааснаар "ГБХ-тэй тэмцэх тухай хууль зөрчих" зөрчлийг "Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон; хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; бусадтай харилцахыг хязгаарласан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан" үйлдлийг ГБХ үйлдэх зөрчил гэж үзнэ.

Түүнчлэн энэ зүйлд ГБХ үйлдэх зөрчлөөс гадна "Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй", "Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн", "Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан" үйлдлийг ГБХ-тэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчилд хамааруулахаар тодорхойлсон.

Энд дурьдсан "Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн" гэдэгт ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг, "хууль зөрчих" гэдэгт хууль, Захиргааны ерөнхий хууль, бусад хуульд заасан журмын дагуу хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнийг[113] ойлгоно.

ГБХ үйлдэх зөрчил гаргасан этгээдэд шүүх Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд зааснаар 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулж, албадан сургалтад заавал хамруулах бөгөөд шийтгэврийн тогтоох хэсэгт албадан сургалтын хугацааг дурьдана. Шүүх зөрчил гаргагчид 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулахдаа түүний хувийн байдал, зөрчлийн шинж чанар, ГБХ-ийн түвшин, хохирогчийн аюулгүй байдал зэргийг харгалзан үзнэ.

Албадан сургалтад хамруулах шийтгэл нь 15-50 цаг хүртэл хугацаатай байх ба уг шийтгэлийг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд хэрэгжүүлнэ.

Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх[114]

Дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол эрх бүхий албан тушаалтан зөрчлийг газар

113 Зөрчлийн тухай хууль, УБ, 2017, Төрийн мэдээлэл №24

114 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйл

дээр нь, эсхүл хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэнэ:

- зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол;
- зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол;
- зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон бол.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн, эсхүл зөрчил үйлдсэн нь тогтоогдож байгаа бол эрх бүхий албан тушаалтан хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авна.

Эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж, шийтгэл оногдуулахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

Эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

Прокурор эрх бүхий албан тушаалтны зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлтэй гэж үзвэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу дүгнэлт бичиж шүүхэд хүргүүлнэ.

ГБХ үйлдэх гэмт хэрэг үйлдэгчид шийтгэл ногдуулах

Шүүх ГБХ-ийн хэргийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох шударга ёс, тэгш байдлын зарчим болон дараах зарчмуудыг удирдлага болгож хянан шийдвэрлэнэ. Үүнд:

- Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх;
- Шударга ёсны;
- Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх;
- Хохирогчийн аюулгүй байдлыг хангах;

Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хуульд заасан тэгш эрхийн зарчмын дагуу гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил,

албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзана.

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлага нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна. Мөн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага заавал хүлээлгэнэ.

Хэрэгт цугласан нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн, бодитой шинжилсний үндсэн дээр хуулийн бүх шаардлагад нийцүүлэн, хуульд үндэслэн шийдвэрийг гаргах нь шүүхийн шийдвэр дээд шатны шүүхээс хүчингүй болох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаан үргэлжлэхгүй байх зэрэг ач холбогдолтой.

Эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг явуулахдаа хохирогчийг хамгаалах, хүндэтгэхийн зэрэгцээ шүүгчдэгчийн гэм бурууг тогтоон, буруутай этгээдэд тохирсон ялыг оногдуулна. Ял шийтгэлийг оногдуулахдаа хэргийн харгис хэрцгий байдлыг шууд харгалзан үзэх хэрэгтэй. Шүүх хуралдаанд хүчирхийлэлтэй харилцааны түүх, динамик зэргийг заавал нягтлах хэрэгтэй.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй.

- ГБХ үйлдэх зөрчил үү?
- Гэр бүлийн харилцааг цааш нь хэвийн болгоход ял шийтгэл үнэхээр эерэгээр нөлөөлж чадах уу?
- Хүчирхийлэл үйлдэгчийн үйлдлийн түүх, өмнөх зөрчлийн хэргийн жагсаалт;
- Зэвсэг, зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн эсэх;
- Насанд хүрээгүй этгээд хүчирхийлэл үйлдэгдэж байхад хажууд нь байсан эсэх;
- Гэмших хандлага ажиглагдаж буй байдал;
- Тухайн үед биеэ авч явах хэвийн байдалтай байсан эсэх (архи, хар тамхи, эмийн хэт хэрэглээ гэх мэт).

ГБХ-ийн хэлбэрүүдээс байнга гардаг сэтгэл санааны болон санхүүгийн хүчирхийлэл нь нуугдмал байдалд удаан хугацаанд илрэхгүй байдаг. ГБХ-ийн хэргийг үр дүнтэй шийдвэрлэх нь ГБХ-ийг эцэс болгох нийтийн хүчин чармайлтад оруулж буй чухал хувь нэмэр юм. Үйлдсэн гэмт хэргийнх нь үр дагаварт тохирсон ял шийтгэл нь хүмүүжүүлэх нэг арга хэрэгсэл болно. Ингэснээр ГБХ-ийн шинж бүхий үйлдлүүд зөрчил, гэмт хэрэг бөгөөд хүлээн зөвшөөрч болохгүй, тэвчиж болохгүй гэдэг сэтгэлгээг нийгэмд авчирна. Зарим тохиолдолд эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь хохирогч эмэгтэйгээс хариугаа авах, хүчирхийлэл илүү хурцдах үр дүнд хүргэж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд нь аюул занал учрах эрсдэлтэй үед эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны турш хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх ял шийтгэлийг хойшлуулах, түдгэлзүүлэхээс аль болох татгалзаж, ГБХ үйлдсэний улмаас ноцтой үр дагавар авчирсан хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд хорих ял оногдуулах нь зүйтэй.

Түүнчлэн шүүхийн шийдвэрүүд түргэн шуурхай гарах ёстой. Үүнийг удаашруулах нь хохирогчийн эрсдэлийг ихэсгэх бөгөөд нэн ялангуяа, шүүгдэгч шүүх хуралдаанаас хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн үед эрсдэл ихэснэ. Ямар ч тохиолдолд ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгч нь хүчирхийллийн хохирогчийн сэтгэл зүйн байдал, онцлогийг онцгой анхаарч авч үзэх шаардлагатай бөгөөд ингэснээр хүчирхийллийг дахин даамжруулахгүй байх, хохирогчийг хамгаалах чухал ач холбогдолтой юм.

Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд ГБХ-ийг бие даасан гэмт хэрэг гэж хуульчилж өгсөн. Энэ зүйлд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах,

захиран зарцуулах эрхэд халдвал ГБХ үйлдэх гэмт хэрэгт тооцохоор тодорхойлж өгсөн.

ГБХ үйлдэх гэмт хэрэг нь байнга үйлдэгдэх шинжээрээ ГБХ үйлдэх захиргааны зөрчлөөс ялгагдана. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт үйлдлийн байнгын шинж гэдэгт эрх зүйн эсрэг үйлдлийг гурав ба түүнээс дээш удаа үйлдэхийг ойлгоно. Мөн Монгол Улсын Дээд шүүхийн 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 13 дугаар тогтоолоор Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйлийн 100.1-д заасан "байнга зодох" гэж тодорхой нэг хохирогчийн эсрэг чиглэсэн, хэвшмэл маягтай, гурав ба түүнээс дээш удаа бие махбодын хүчирхийлэл хийсэн байхыг хэлнэ гэж тайлбарласан байна. "ГБХ үйлдэх" гэмт хэргийн "тарчлаах" шинжтэй үйлдэл нь хохирогчид ямар нэг бэртэл гэмтэл учруулахгүй ч байнга буюу олон удаа үйлдэгддэг үйлдлүүд юм. Тухайлбал, шөнө бүр хохирогчийг байнга чимхэх, зулгаах гэх мэт.

ГБХ-ийн тарчлаан зовоосон хэргүүдэд хохирогч өнгөрсөн түүхээ ярьдаг. Жишээ нь, тэр намайг чимхдэг, хараадаг. Иймд хэргийг нотлоход хэцүү. Тун ховор тохиолдолд, тухайлбал, тарчлаан зовоосон нотлох баримт хангалттай үед уг хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд шүүх ял оногдуулдаг байна.[115]

Кэйс: Нөхөр нь эхнэрээ хамт амьдрах хугацаандаа байнга бие махбодын хүчирхийлэлд байлгасан. Хохирогч цагдаагийн байгууллагад хандан, эрүүгийн хэрэг үүсгэж, шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлт гаргасан. Мөн тусдаа амьдрах болсон ч нөхрийн хүчирхийлэл дахин давтагдсан. Хохирогч "Тэр намайг байнга зоддог байсан. Өөрөө байнга л гэртээ байдаг, намайг бас ажил хийлгэдэггүй байсан. Бид тусдаа амьдарснаас хойш олон удаа зодсон. Тусдаа амьдрах хугацаанд байнга дагаж мөшгидөг, зүсээ хувиргадаг байсан. Он, сар, өдрийг нь санахгүй байна. Намайг ярилцъя гээд голын эрэг дээр очсон. Гэнэт чамайг хүчиндэнэ гээд байсан. Тухайн үед хүмүүс голын эрэг дээр ирсэн болохоор бид тэндээс явсан. Тэгээд явж байгаад зогсоход нь би зугтаасан боловч намайг барьж аваад машиндаа суулгаад явсан ч би айгаад машинаас үсэрсэн". Шүүхээс хохирогч, шүүгдэгчийн мэдүүлэг, шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн хүчирхийлэл үйлдэгчид 1 жил хорих ял оногдуулсан. Шүүхээс хохирогч, шүүгдэгчийн мэдүүлэг, шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн хүчирхийлэл үйлдэгчид 1 жил хорих ял оногдуулсан.

Ийнхүү ГБХ үйлдэх гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг болгож, үйлдлүүдийг тодорхой хуульчилж өгснөөр зайлшгүй хохирогчоос хүчирхийллийг нотлохыг шаардахгүй байх, байнгын дарамт, мөрдлөг, сэтгэл санааны дарамтыг хүчирхийлэлд тооцох, мэдүүлэгт үндэслэн гэмт хэргийг нотлох, хүчирхийлэл үйлдэгчийг шийтгэх, цаашлаад далд үйлдэгддэг ГБХ-ийг багасгахад онцгой хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

ГБХ үйлдэгчийн гэм буруутай үйлдэлд тохирсон ял шийтгэлийг оновчтой оногдуулах нь ГБХ-ийг таслан зогсоох, хохирогчийг дахин ГБХ-д өртөхгүй байх хамгаалалт болохыг харгалзан авч үзэх хэрэгтэй.

ДЭД СЭДЭВ 3. ГБХ үйлдэгчид оногдуулсан хорих ялыг хугацаанаас өмнө суллах асуудлыг шүүх шийдвэрлэхэд анхаарах асуудал

Хорих ял эдэлж буй хоригдлыг хорих ялаа бүрэн эдэлж дуусахаас өмнө хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд хугацаанаас өмнө суллаж байгаа нь хоригдлыг засрал

115 "ГБХ-тэй тэмцэх тухай хууль, Монгол улс",Хүний эрхийн тайлан., АНУ, Миннесота., Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, УБ, 2014

хүмүүжлийн бодит байдлаар нь урамшуулах, бусад хоригдлуудад хүмүүжлийн эерэг нөлөө үзүүлэх зорилгоор ялаас тодорхой болзол тавьж суллаж байгаа урамшууллын шинжтэй үйл ажиллагаа байдаг.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах гэдэг нь шүүх гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлэн уг ялаа эдэлж байгаа, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулсан, ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялын зохих хувийг биеэр эдэлсэн хоригдлыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.12 дугаар зүйлд заасан үндэслэлээр эдлээгүй үлдсэн хорих ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтоон өгч, хяналтын хугацаанд дахин шинээр гэмт хэрэг үйлдээгүй, шүүхээс хүлээлгэсэн үүргийг зөрчсөн, зөрчил үйлдэж захиргааны шийтгэлийн арга хэмжээ авгдаагүй тохиолдолд эдлээгүй үлдсэн ялыг биечлэн эдлүүлэхгүй байх гэсэн урьдчилсан нөхцөлтэйгээр хорих байгууллагаас хугацааны өмнө суллаж буй үйл ажиллагааг хэлнэ.[116]

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай асуудлыг хорих байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу хорих байгууллагын оршин байгаа газрын шүүх шийдвэрлэх бөгөөд хорих ялаас хугацаанаас өмнө суллахдаа ялтны эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтооно.

Хоригдол нь хорих ял эдлэх хугацаандаа үлгэр жишээ зан төлөвтэй болж, үнэнч шударга хөдөлмөрлөж, хорих ангийн дотоод журам, дэглэмийн шаардлагыг сахин биелүүлж, гэм буруугаа ухамсарлаж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх итгэл үнэмшилтэй болсон, ял эдлэж байх хугацаандаа сахилгын арга хэмжээ авгдаж байгаагүй, хорих байгууллага болон бусад төрийн бус байгууллагаас зохиож байгаа сургалт, хүмүүжлийн ажилд идэвхтэй оролцдог, мэргэжил, боловсролоо дээшлүүлэх талаар биеэ дайчлан ажилладаг, бусад хоригдолтой зөв боловсон харьцдаг, тэдний хүмүүжилд сайн нөлөө үзүүлдэг, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх, гэм хорыг арилгах талаар санаачилга гаргах зэргээр засарч хүмүүжин зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулсан тохиолдолд түүний эдлээгүй үлдсэн хорих ялыг хугацааны өмнө суллах асуудлыг прокурорын гаргасан дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Шүүх хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох асуудлыг шийдвэрлэж буй практикт ГБХ үйлдэх болон бага насны хүүхэд болон гэр бүлийн хамаарал бүхий 16 насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлсөн, ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялын зохих хувийг биеэр эдэлсэн үндэслэлээр эдлээгүй үлдсэн хорих ялаас хугацааны өмнө суллахаар хорих байгууллагын тодорхойлолтоор прокурор дүгнэлт үйлдэн ирүүлэх явдал цөөнгүй гарч байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эдлээгүй үлдсэн хорих ялыг хугацааны өмнө суллах асуудлыг шүүх шийдвэрлэхдээ төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох "Эрүүгийн хариуцлага нь тухайн хүний үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна." гэсэн шударга ёсны зарчимд нийцүүлэн шийдвэрлэж байх нь зүйтэй бөгөөд хуульд заасан нэг чухал үндэслэл болох "хоригдол зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулсан" нь нотлогдож байгааг зайлшгүй шалган тодруулж, үндэслэл тогтоогдохгүй бол хугацаанаас өмнө суллахгүй байж болно. Ингэж шийдвэрлэх нь шүүхийн үүрэг бус эрх гэдгийг анхаарах хэрэгтэй.

Мөн хяналт тавьж буй прокурор шүүхэд дүгнэлт үйлдэн ирүүлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.3 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих ялаас хугацааны өмнө суллах асуудлыг шийдвэрлэх хуралдааны товыг 3-аас доошгүй хоногийн өмнө хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй бөгөөд ингэж мэдэгдэх

116 Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан, 2010 он, УБ.

нь хохирогчийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэдгийг анхаарах нь зүйтэй.

Шүүх хорих ялаас хугацааны өмнө суллах прокурорын дүгнэлтээр тухайн асуудлыг мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хоригдол, түүний өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргавал оролцуулна.

Харин шүүхийн шийдвэрийн хохирол, хор уршиг нөхөн төлүүлэхтэй холбоотой хэсэгт гарсан тодорхой биш асуудлыг шийдвэрлэх шүүх хуралдаанд хохирогчийг оролцуулж болно.

нэмэлт МЭДЭЭЛЭЛ

ШҮҮГЧИЙН ХАРИЛЦААНЫ ЭЛЕМЕНТ

Харилцаа нь үгэн ба үгэн бус элементүүдээс бүрдэх бөгөөд шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны хувьд үүнээс гадна идэвхтэй сонсох нь чухал нөлөөтэй. Тийм учраас шүүгчийн харилцааны бүрдлийг үгэн ба үгэн бус, идэвхтэй сонсох гэсэн үндсэн гурван элементтэй гэж үздэг.

Үгэн харилцаанд бичгийн болон ярианы харилцаанд хэрэглэгдэж буй үгс, хэллэг хамаарна. Үгэн бус харилцаа гэдэгт үгс, хэллэг хэрэглээгүй бусад харилцааг ойлгоно. Үүнд гарч буй дуу авианы нэгтгэлээс гадна нийтлэг нэрлэгддэг биеийн хэлэмж орно. Үгэн ба үгэн бус харилцааг багтаасан харилцааны бас нэг суурь элемент бол сонсох (идэвхтэй) юм.



Шүүгч болон хэргийн оролцогчдын хоорондын харилцаанд шүүх хуралдааны танхимд хэрэглэгдэж буй бичгийн болон ярианы үгс хэллэгээс гадна тэдгээр үгс хэллэгийг илэрхийлж буй бодит байдал, сонсох болон унших чадварыг хамруулж ойлгоно.

Шүүх хуралдааны танхимд хэрэглэгдэж буй үгсийн агуулга ерөнхий ба мэргэжлийн (хуулийн нэр томьёо) эсэх, албан болон албан бус хэллэгийн хэмжээ, оролцогчдын бичиг үсгийн боловсролын түвшин, үг хэллэгийг илэрхийлж буй байдлаас шалтгаалж шүүх хуралдааны үйл явцын талаарх хэргийн оролцогчдын ойлголтын түвшин өсч, буурч байдаг.

- Үг - 8 хувь
- Дуу хоолойны өнгө - 34 хувь
- Биеийн хөдөлгөөн, дохио, зангаа, харц - 58 хувь

буюу харилцаанд үгэн харилцаа 8 хувь, үгэн бус харилцаа 92 хувийг эзэлдэг байна.

Kelly Tait, Kathleen SikorA. "Communication tools for cases involving self-represented litigants" training manual, 2006

Шүүгч дараах нийтлэг үгэн бус арга замаар дамжуулан бусдад мэдээлэл өгч бусдаас мэдээлэл мөн хүлээн авдаг.

Үгэн бус харилцааны хэлбэр

Шүүгч таны хийж буй үйлдэл чинь хэлсэнтэйгээ, мөн хэлсэн чинь хийсэнтэйгээ яг таардаг байх хэрэгтэй. Хэрвээ үгэн болон үгэн бус харилцааны илэрхийлэл хоорондоо тохирохгүй бол хүмүүс ихэвчилэн үгэн бус

харилцаанд итгэдэг байна.[117] Шүүгчээс ГБХ-ийн хэргийн оролцогчидтой харилцах үгэн бус харилцааны зорилго, анхаарвал зохих зүйлсийг доорх хүснэгтээс үзнэ үү.

Шүүгчийн үгэн бус харилцаанд анхаарах зүйлс

	Шүүгчээс:	
	Хүчирхийлэл үйлдэгчтэй харилцах	Гэрч/ хохирогчтой харилцах
Нүдээрээ холбоо тогтоох	▪ Хүн бүр хүний эрхэм чанартай бөгөөд түүнийг хүндэтгэх нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах үүрэг юм. Тийм учраас шүүгдэгч, хохирогч гэлгүйгээр харилцаж хандах бөгөөд хүчирхийлэл үйлдсэн этгээд болохоор муухай харах, буруутгасан өнгө аястайгаар ширтэх зэрэг үйлдэл гаргаж болохгүй. Ингэх нь таныг шүүгчийн төвийг сахих зарчим, хүний эрхэм чанарыг хүндэтгэх мэргэжлийн үүргээ умартахад хүргэх аюултай.	▪ Хохирогчтой харилцахдаа түүний нүд рүү эгцэлж харах нь түүнд итгэл үнэмшил төрүүлэхэд чухал бөгөөд харин хохирогч тань руу эгцэлж харж чадахгүй байгаад дургүйцэх хэрэггүй. Эрх мэдлийн ялгаа үүгээр илэрдгийг санахад илүүдэхгүй. Хохирогч, гэрчтэй нүдээрээ холбоо тогтоосноор түүний биеийн хэлэмжийг ойлгохоос гадна харилцааг илүү зохион байгуулалттай болгож өгдөг.
Дуу хоолойны өнгө	▪ Шүүгдэгчээс мэдүүлэг авах үед дуу хоолойны өнгийг хэтэрхий өндөрсгөх эсхүл намсгах хэрэггүй. Шүүгдэгчтэй аядуу зөөлөн дуугаар харилцах нь зарим тохиолдолд түүн дээр дөрөөлж, хүчирхийллийн үйлдлийн хор уршиг, эрсдэлийн түвшинг бууруулах мэдрэмж төрүүлэх эрсдэлтэйг санах хэрэгтэй.	▪ Ихэнх тохиолдолд ГБХ-ийн хохирогч айдастай, түгшсэн, ярихдаа хоолой нь чичрэх, аяархан ярих зэрэг үйлдэл гаргадаг тул шүүгч асуулт асуух болон бусад үед зандрах, чанга ярихыг шаардах дээрэнгүй өнгө аястайгаар үг хэлэх зэрэг үйлдлийг гаргаж болохгүй.
Нүүрний хувирал	Шүүгдэгч, хохирогч, гэрчтэй харилцахдаа инээх, тэдний өгсөн мэдүүлэгтэй холбож шоолох, ярьж буй зүйлийг илтэд үгүйсгэх байдал үзүүлэхээс сэргийлэх хэрэгтэй. Түүнчлэн өөр асуудлаас шалтгаалсан таагүй сэтгэл зүйн байдлаа ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаан дээр гаргах, тийм нүүрний хувирал үзүүлэхээс болгоомжлох нь зүйтэй. Ялангуяа хохирогч, гэрчтэй харилцах явцдаа иймэрхүү таагүй сэтгэл хөдлөлийн дүр төрхийг үзүүлэх нь таныг шүүгдэгчийн талд ажиллаж байна гэх хардлагыг төрүүлэх эрсдэлтэй.	
Дохио зангаа	▪ Шүүгдэгчийн хийсэн хүчирхийллийн үйлдэлтэй холбоотойгоор өөрийн дохио зангааг эмх замбараагүй байлгахаас сэргийлэх хэрэгтэй.	▪ Хохирогч гэрчийг буруутгасан өнгө аястайгаар хуруугаараа чичих, шанаагаа тулах, гар хуруугаа оролдох зэрэг үйлдэл гаргахаас зайлсхийх хэрэгтэй.
Биеэ авч явах байдал, үйл хөдлөл	▪ Шүүгдэгч, хохирогчтой харилцах харилцааны орон зай чухал бөгөөд тухайлбал, шүүгдэгчтэй хохирогчийг бодвол арай хол зайнаас харилцаж болох юм. Гэхдээ шүүгч хэргийн нөхцөл байдал болон гэм буруугийн талаар урьдчилсан төсөөлөлтэй байж болохгүйг санаарай.	▪ Шүүгч хохирогч гэрчтэй харилцахдаа түүн рүү өөрийн биеийг чиглүүлэн харж, цэх суух, эсвэл бага зэрэг урагш суух нь зохимжтой. Ингэх нь таныг хохирогчтой харилцаж байгааг бататгах төдийгүй идэвхтэй сонсоход чухал нөлөө үзүүлнэ.
Гадаад төрх	▪ Хэргийн оролцогчдын хувьд шүүгчийн үйлдэл, биеэ авч яваа байдал зэргээс гадна түүний гадаад төрхийг ч анхааралтай ажиглаж байдаг. Практикт шүүгчийн унаж яваа машин, хувцаслалт, гоёл чимэглэл зэргийг ажиглаж байдаг тул та ноён нуруутай, голч, төвийг сахисан байр суурийг илэрхийлэхүйц, хэргийн оролцогчдод итгэл төрүүлэхүйц байдлаар биеэ авч явах нь зүйтэй юм.	

Идэвхтэй сонсох

Идэвхтэй сонсох нь Та үгэн болон үгэн бус хэлбэрээр өөрийгөө илэрхийлж буй хүний хэлж буй гол агуулга санааг бүрэн ойлгох явдал юм. "Ярих гэдэг тарианыхаа үрийг суулгаж байна гэсэн үг, харин сонсох бол ургац хурааж буйтай адил" юм гэх зүйр үг хүртэл байдаг. Идэвхтэй сонсохын гол зорилго нь мэдээллийг цуглуулан, баталгаажуулахад чиглэх бөгөөд 4 үе шаттай. Үүнийг шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбон авч үзье.

А. Хэргийн оролцогчийн мэдээлэлд (мэдүүлэг, тайлбар гэх мэт) анхаарлаа

117 Kelly Tait, Kathleen SikorA. "Communication tools for cases involving self-represented litigants" training manual, 2006

төвлөрүүлэх: Энэ нь сонсож буй болон ярьж буй талууд анхааралтайгаар харилцан оролцож байгааг харуулах бөгөөд үүнийг үгэн бус харьцаагаар илэрхийлж болно. Жишээ нь: Толгой дохих, нүдээрээ холбоо тогтоох, эерэг өнгө аястай дуу хоолойгоор ярих, цэх эсвэл бага зэрэг урагшлан сууж "За ойлголоо", "ммхмм", "Та цааш нь үргэлжүүлнэ үү" гэх мэт үгэн хэллэгээр хэргийн оролцогчдыг дэмжих;

Б. Шаардлагатай мэдээллийг цуглуулах: Хэргийн оролцогчоос бүрэн дүүрэн хариулт авахын тулд шүүгч өөрөө харилцан яриаг эхэлж болно. Үүнийг хийх хамгийн сайн аргуудын нэг бол асуулт асуух явдал юм. Ямар асуулт асуух нь хариултад шууд нөлөөлнө.

- Дүгнэсэн буюу төгссөн асуулт - богинохон, шууд хариулт авдаг; эдгээр нь ихэвчлэн "байна, ...сан байна, ... х болно,.....хэзээ" гэж эхэлдэг. Энэ нь шүүгч маш тодорхой мэдээлэл шаардлагатай тохиолдолд хэлэлцэж буй асуудлыг өөрийн хяналтад байлгахад үр дүнтэй байдаг.
- Төгсөөгүй буюу нээлттэй асуулт - өргөн хүрээ бүхий хариулт авдаг; эдгээр нь ихэвчлэн "юу, хэрхэн, яагаад, тодорхойлох, тайлбарлах, өгүүлэх жишээ авахад ..." гэх зэргээр эхэлдэг. Шүүгчид арай өргөн цар хүрээний мэдээллийг хэргийн оролцогчдоос авах шаардлагатай байгаа тохиолдолд энэ хэлбэрийн асуултыг тавьдаг. Жишээ нь, "Ямар учраас", "Надад энэ талаар арай илүү мэдээлэл өгөхгүй юу" "Надад ойлгуулж өгнө үү" "Энэ талаар дэлгэрэнгүй хэлж өгнө үү" "Надад төсөөлж үзүүлээч" гэх мэт

В. Хүлээн авсан мэдээллийн талаарх ойлголтоо харилцан солилцох: Ихэвчлэн мэдээ солилцох хэд хэдэн хэлбэр байдаг.

- Агуулга: баримт, мэдээлэл

  Мэдээллийн агуулгыг хэрхэн ойлгосныг шалгах хамгийн үр дүнтэй аргуудын нэг нь парафраз буюу өөр үгээр илэрхийлэх юм. "Би таны хэлснийг зөв ойлгосон байна уу?" "Би таны хэлснийг ..... гэж ойлголоо. Зөв үү? "Та ..... гэж хэлсэн нь ..... гэсэн үг мөн үү?"

- Сэтгэл хөдлөл: мэдрэмж, харилцан үйчлэл

  Мэдээлэл өгөх явцад сэтгэл хөдлөл чухал үүрэг гүйцтгэж байгаа тохиолдолд сэтгэл хөдлөлийг анхааралдаа авч үзэх нь маш их үр дүнтэй байдаг. Шүүгч шийдвэр гаргахад хэргийн оролцогчийн сэтгэл хөдлөл хамааралгүй байлаа ч сэтгэл хөдлөлийг нь хүлээн авч ойлгосноор ярилцагч (мэдүүлэг өгж буй хэргийн оролцогч)-д сэтгэл хөдлөлөө даван туулж танд хэрэгтэй мэдээллийг өгөхөд үр нөлөөтэй байдаг. "Таны урам их хугарсан юм шиг байна, намайг шийдвэр гаргахад тус болох мэдээллийг одоо танаас авах хэрэгтэй байна л даа...." гэх мэт.

- Санаа, зорилго:

  Хэргийн оролцогчид яагаад Танд энэ мэдээллийг өгч байна, үүгээр тэд юунд хүрэхийг зорьж байна, энэ мэдээлэл нь шүүн таслах ажиллагаатай ерөнхийдөө ямар хамааралтай байна. "Таны хэлж буй ..... энэ мэдээлэл .....-ыг батлах болно гэдэгт та итгэлтэй байна уу?"

Г. Хэргийн оролцогчийн хэлсэн мэдээллийн утгыг зөв ойлгосноо дахин лавлах, тодруулах замаар асуух:

- Мэдээллийг зөв ойлгосноо бататгахын тулд шүүгч хэргийн оролцогчийн ялангуяа, өмгөөлөгчгүйгээр оролцож буй шүүх хуралдааны хэргийн оролцогчид хэлсэнээ дахин бататгах, тодруулах боломж олгох ёстой: "Тийм, миний хэлэх гэзд байгаа зүйл мөн", "Үгүй ээ шүүгчээ, би юу гэж хэлэх гэзд байна вэ гэвэл...."
- Бодитойгоор идэвхтэй сонсох үүднээс мэдээллийн агуулгыг харгалзан үзсэний дагуу тодруулгыг хийгээрэй. Сэтгэл хөдлөлийн хувьд шүүгч хэргийн оролцогчдын сэтгэл хөдлөлд гол анхаарал төвлөрүүлэх эсэхээ өөрөө шийдэзд, тодруулгыг хийж болно. Үүнийг "Ойсон сонсох ур чадвар" гэдэг ба тухайн хэрэг, хэргийн оролцогчид, хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан хэрэглэхэд зохистой эсэхийг нь тогтооно.

ШҮҮГЧИЙН ҮР ДҮНТЭЙ ХАРИУ ҮЙЛДЭЛ

Шүүгч хэргийн оролцогчидтой харилцах харилцаанд дараах хариу үйлдлүүдийг хийж болохгүй бөгөөд эдгээр хариу үйлдлүүд нь шүүгчийн төвийг сахих, хараат бус байдалд

нь ноцтой үр дагавар учруулж болохуйц байж болно.

- Мэтгэлцэх
- Магтах
- Тайлбарлах
- Дүгнэх
- Бусдаас өмөөрөх, эсхүл шүүмжлэх гэх мэт.

Үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэхэд хэрэг болох зөвлөмжүүд:

Мэдүүлэг өгөгч (ярилцагч)-ийн хувьд шүүгчийн зүгээс хариу үйлдэл үзүүлэх нь чухал байгаа тохиолдолд, дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр мэдүүлэг өгөгчийг өөрийгөө хамгаалсан байдалд оруулж, мэдээллийг авах боломжийг хязгаарлахаас сэргийлнэ.

- Эерэг мэдэгдэл тайлбараар өгүүлбэрээ эхлэх
- Тодорхой байх- Таны юу хэлж буй мөн энэ талаар гаргах гэж буй шийдвэр маш тодорхой байх ёстой
- Шулуун шударга бөгөөд ая зантай байдлыг хослуулах- (маш чухал чадвар)
- Өөрийн үзэл бодлоо хэлж буй үгээ хүн рүү төвлөрсөн болгох

Байнга "Та, чи" гэдгийн оронд "Би надад" зэргийг заримдаа хэрэглэснээр мэдүүлэг өгөгчийг өөрийгөө хамгаалуулсан байдалд оруулахгүйгээр мэдэгдлийг- авахад дэмтэй.

- Эерэг нөхцөл байдал бий болгох - Мэдүүлэг өгөгчийн зөв хэлсэн үг үйлдлийг сайшаахаа мартуузай
- Хэргийн оролцогчийн талд ..... гэснээр ямар ашигтайг тайлбарлах
- Сөрөг байдалд асуудлыг шийдвэрлэх арга замаар хандах
- Эерэг мэдэгдлээр өгүүлбэрээ дуусгах. Эерэг сөргийг хослуулах нь таатай уур амьсгал үүсгэх магадлалтай

ГБХ-ИЙН ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД ХОХИРОГЧИЙГ ТУСГАЙЛАН АВЧ ҮЗЭХ ЗӨВЛӨМЖ

1) Хэргийн материалтай сайтар танилцах, шүүх хуралдааны явцад өгсөн мэдүүлгийг анхааралтай сонсож, хохирогчийг зөв тогтоосон эсэхийг анхаарах. Гэр бүлийн нэг гишүүнийг хохирогчоор тогтоосон боловч таагүй үйлдлийн улмаас хохирсон бусад гишүүн байхыг үгүйсгэхгүй тул сайтар нягталж шалгах нь хэргийг бүх талаас нь бүрэн бодитой шийдвэрлэхэд ач холбогдолтой.
2) ГБХ үргэлжилсээр байгаа эсэхийг тогтоох нь чухал. Хохирогч гомдлоосоо татгалзах, өмнө өгсөн мэдүүлгээс буцах, үйлдлийн шинжийг "зөөлрүүлж" ярих нь түүнийг одоог хүртэл хүчирхийлэлд өртөж байж болзошгүйг харуулдаг. Иймд хохирогчид хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг цаг алдалгүй авахуулах хэрэгтэй.
3) Хэргийг үнэн зөвөөр, шударгаар шийдвэрлэнэ гэдэг итгэлийг хохирогчид шүүгч төрүүлэх ёстой. Хохирогч хэргийн хууль зүйн үр дагаврыг ойлгож байгаа боловч сэтгэл санааны байнгын тогтворгүй байдалд байдаг шүүхийн шийдвэрт гаргасан өчүүхэн жижиг алдаа нь ч хохирогчийн цаашдын хувь заяа, амь амьдралыг шийддэг гэдгийг анхаарах шаардлагатай.
4) Шүүх хуралдааны явцад хохирогч хувийн амьдралаа ярихаас эмээх, шүүгдэгчийн дэргэд мэдүүлэг өгөхөөс айх зэрэг сэтгэл санааны дарамтад байдаг тул мэдүүлгийг үнэн зөв авах үүднээс хугацааг боломжийн хэмжээнд төлөвлөх, техник технологийн арга хэрэгслийг ашиглаж, зайнаас мэдүүлэг авах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй.
5) Шүүх хуралдааны танхимд шүүгдэгч хохирогчид нөлөөлөх, дарамтлах уур амьсгалыг бүрдүүлэхээс сэргийлэх хэрэгтэй. Шүүгдэгчийн ар гэр, найз нөхөд нь олноороо хуралдааны танхимд суувал хохирогчид таагүй сэтгэгдэл төрүүлж болзошгүй. Мөн шүүгдэгч мэдүүлэг өгөхдөө хохирогчийг дайрч доромжилсон, тохуурхсан, заналхийлсэн агуулгатай үг, үйлдэл гарахаас сэргийлэх, тухай бүр таслан зогсоож байх хэрэгтэй.

3.4. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ АНХААРАХ АСУУДАЛ

Удиртгал

ГБХ-тэй тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-д гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь албадан болон сайн дурын хэлбэртэй байх, мөн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамрагдах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага хариуцан зохион байгуулах зохицуулалтыг тусгасан.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг дараах 2 төрөлд хуваан гарын авлагад оруулаа. Үүнд:

1. ГБХ-ийн гэмт хэрэг үйлдээд хорих ял эдэлж байгаа хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан урт хугацааны (илүү сэтгэл засал, нийгэмшүүлэхэд чиглэгдсэн)
2. ГБХ үйлдэх зөрчлийн улмаас баривчлах шийтгэл авсан хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан богино хугацааны /зан үйлээ өөрчлөх сэдэл төрүүлэхэд чиглэгдсэн/

2020 оны эхний хагас жилийн байдлаар Зөрчлийн тухай хуульд баривчлах шийтгэл оногдуулахаар заасан 6 зөрчилд холбогдон Нийслэлийн 9 дүүргийн шүүхээс 7-30 хоногийн хугацаагаар баривчлагдан ирсэн 3750 этгээд байгаагаас насанд хүрсэн эрэгтэй 3624, насанд хүрсэн эмэгтэй 108 байгаа бол гадаад улсын харьяат 3/эр/ иргэн /БНХАУ-ын ӨМӨЗО- 2, ОХУ-ын 1/, насанд хүрээгүй этгээд 18 /эр-16, эм-2/ байгааг зөрчлийн төрлөөр нь ангилбал:

Хүснэгт 1.

№	Зөрчлийн хуулийн холбогдох зүйл, заалтын нэр	2020 оны эхний хагас жилийн тоон мэдээ /3750 этгээдэд баривчлах шийтгэл оногдуулснаас/
1.	ЗТХ-ийн 5.1.3 / мансуурах зөрчил/	51 баривчлагдсан этгээд буюу 1.36%-ийг;
2.	ЗТХ-ийн 5.2.1 / танхайрах зөрчил/	211 баривчлагдсан этгээд буюу 5.6%-ийг;
3.	ЗТХ-ийн 5.4.4 /гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/	2742 баривчлагдсан этгээд буюу 73.12%-ийг;
4.	ЗТХ-ийн 8.6.1 / хулгайлах зөрчил/	269 баривчлагдсан этгээд буюу 7.02%-ийг
5.	ЗТХ-ийн 8.7.1 / хөрөнгө завших зөрчил/	2 баривчлагдсан этгээд буюу 0.05%-ийг;
6.	ЗТХ-ийн 14.7.5 / согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон/	475 баривчлагдсан этгээд буюу 12.22%-ийг эзлэж байна.

(ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвөөс авсан тоо баримт)

Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтэд 2019 онд хийсэн мониторингийн тайлангаас тусгасан нь сургагч багш нарт цаашид үйл ажиллагаандаа анхаарахад ахиц гарна гэж итгэж байна.

2009-2012 онд ГБХ үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан "Албадан сургалт зохион байгуулах журам, сургалтын хөтөлбөр батлах тухай" 2009 оны 69/55 дугаар тушаалаар Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв хамтран туршилтын журмаар явуулж эхэлсэн байдаг.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах нь бодит байдлыг судлахаас эхлээд сургалт зохион байгуулах, түүнийхээ үр дүнг үнэлэх хүртэлх уялдаа холбоо бүхий нарийн үйл явц бөгөөд энэхүү сургалтыг явуулахын тулд хорих анги, баривчлах төвийн нийгмийн

ажилтан, сэтгэл зүйч (цаашид "сургалтын ажилтан" гэх) нь дараах мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх шаардлага гарч байна. Үүнд:

- Албадан сургалтын зарчим, зорилгыг тодорхойлох
- хүчирхийлэл үйлддэг зан үйлээ орхиход чиглэсэн өөрчлөлтийн үе шатууд
- хүчирхийлэл үйлдэгчтэй сэдлийг дэмжих ярилцлага хийх
- ГБХ үйлдэгчийн талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх;
- харилцах ур чадвараа дээшлүүлэх;
- зан үйлд нөлөөлөх албадан сургалтын төрлүүдийг танин мэдэх;
- албадан сургалтын төлөвлөгөө боловсруулах арга зүйд суралцах;
- зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулах;
- сургалтын үр дүнг тодорхойлох, үнэлэх зэрэг болно.

Гарын авлагын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтанд зориулсан энэхүү хэсэгт дээр тэмдэглэсэн мэдлэг,чадварыг хөгжүүлэхэд илүү анхаарсан болно.

Нэр томьёо:

- Амлалтын хуудас
- Зан үйлийн өөрчлөлтийн үе шат
- Сэтгэл зүйн судалгаа
- Албадан сургалтын төлөвлөгөө
- Сургалт
- Мониторинг
- Үнэлгээ

3.4.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТ

Сургалтыг зохион байгуулах мэргэжилтэн нь юуны түрүүнд зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үзэл баримтлал, зорилго, зарчмын талаар мэдлэг ойлголттой байж, түүнийгээ хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион явуулахад энэхүү гарын авлагыг ашиглах юм.

Сургалтын зорилго:

Хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах, эрсдлийг бууруулах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлээ өөрчлөх сэдлийг төрүүлэх, өөрчлөхөд нь дэмжлэг үзүүлэх, хүчирхийлэл үйлдэх зан үйлдээ хяналт тавьж, эерэг үзэл бодол, зан үйлийг хэвшүүлэхэд нөлөөлөх зорилготой.

Олон улсын түвшинд зан үйлд нөлөөлөх сургалтыг явуулахдаа нэг талаас тухайн хүчирхийлэл үйлдэгч өөрт тулгарсан асуудлаа хэр хүлээн зөвшөөрч байгаад ач холбогдол өгдөг. Өөрийнхөө зан үйлийг асуудалтай гэж хараагүй, хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд өөрчлөлт гарахгүй.

Хөтөлбөрийн үзэл баримтлал

- Гэр бүлийн хүчирхийллийн суурь шалтгаан нь эрх мэдлийн тэнцвэргүй байдал, бусдыг хяналт, хамааралдаа байлгахыг эрмэлзсэн санаатай үйлдэл, эс үйлдэл юм.
- Хүчирхийлэл үйлдэгч нь асуудал, зөрчлийг шийдвэрлэхдээ хүч хэрэглэх, дарамт үзүүлэх аргыг сонгон авсныхаа хариуцлагыг заавал хүлээж, ухамсартайгаар сонгон хүчирхийллийг үйлдэж байгаа учир мөн ухамсартайгаар сурсан зан үйлээ орхих ёстой.
- Тэд үйлдлээ зогсооход цаг хугацаа, дэмжлэг шаардана.
- Хүчирхийлэл үйлдэгч зан үйлээ өөрчилхөд бэлэн биш байж болох ч, өөрчлөлт хийх бодол санаа төрөх боломжийг олгох нь чухал юм.
- Тэд өөрчлөгдөж чадах бөгөөд бусдыгаа өөрчлөгдөхөд ч мөн тусалж чадна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим[118]

Аюулгүй байдлыг хангахын тулд эрхэд суурилсан, хохирогч төвтэй зарчмуудыг баримтлан ажиллана. Эдгээр зарчим нь газар нутаг, орчин нөхцөл, арга барилаас үл хамааран хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүхий л үе шат, цаг хугацааны турш зайлшгүй даган мөрдөгдөх учиртай.

1. Аюулгүй байдлыг хангах

Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь "хохирогч" төвтэй байх ба хохирогч аюулгүй байгаа эсэхийг хөтөлбөр хэрэгжих хугацаанд тогтмол магадлаж, ажилтнуудын аюулгүй байдлыг давхар анхаарна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүхий л хугацаанд хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг анхаарлынхаа төвд байлгаж, тэргүүн ээлжинд авч үзнэ. Хүчирхийлэл үйлдэгчид тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлыг шийдэх, нуугцлалыг хангах болон түүнийг нөхөн сэргээх нь хохирогчийн аюулгүй байдлын дараа тавигдах ёстой.

2. Хохирогчийг чадавхижуулах

Хохирогчийг чадавхижуулах нь түүнийг амьдралаа хянах чадвартай болгож, ГБХ-ийг таслан зогсоох нь хохирогчийг чадавхижуулах ажлын гол цэг нь байна.

Өөртэй нь хамаатай шийдвэр гаргахад оролцуулах нь аюулгүй байдлыг хангахын суурь болж, ГБХ-д буруугүйг нь ойлгуулах, шийдвэр, сонголтыг нь хүндэтгэх, өөрийнхөө болон хүүхдийнхээ аюулгүй байдлыг хангахад нь зоригжуулах замаар хохирогчийг чадавхижуулна.

3. Хариуцлага хүлээх

Хариуцлага нь 2 түвшинд тавигдана. Эхнийх нь хүчирхийлэл үйлдэгчийн, удаах нь хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч ажилтнуудын хүлээх хариуцлага юм.

Хүчирхийлэл үйлдэгчийн хүлээх хариуцлага

Хувь хүнээс хараат бус байх, халдашгүй, эрх чөлөөтэй, аюулгүй амьдрах жам ёсны эрхэд халдсан, хууль зөрчсөн гэм буруутай үйлдлийнхээ төлөө хүчирхийлэл үйлдэгч хариуцлага хүлээх ёстой. Хүчирхийллийн хүлээн зөвшөөрөгдөх ямар ч түвшин байх учиргүй. Хүчирхийллийг юугаар ч зөвтгөж болохгүй. Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь хариуцлагын нэг төрөл гэдгийг мартаж болохгүй.

Хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэгч ажилтнуудын хүлээх хариуцлага

Хөтөлбөрт хамрагдагсдын өмнөөс гэрч, өмгөөлөгчийн үүрэг гүйцэтгэхгүй байхад онцгойлон анхаарч, хөтөлбөрт хамрагдсан хүчирхийлэл үйлдэгчийн хариуцлагын асуудалд онцгой анхаарлаа хандуулна. Бүлгийн цугларалт нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол аргачлал байна.

4. Хүндэтгэж харилцах

Хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн хүний эрх, бие даасан байдал, хувийн онцлог, соёлын өвөрмөц байдлыг хүндэтгэнэ. Тэдний шийдвэр гаргах, сонголт хийх эрхтэйг хүлээн зөвшөөрч, өөрт нь хамааралтай аливаа үйлдэл болон шийдвэр гаргах үйл явцад оролцоог нь хангана. Энэ нь хохирогчтой ганцаарчилсан ярилцлага өрнүүлэх, зөвхөн хамааралтай асуултууд асуух, удаа дараагийн ярилцлагаар түүхийг нь давтан яриулахаас зайлсхийх зэрэг зарчмын үүднээс хандана гэсэн үг. Хохирогчдод хөтөлбөрийн явц, үр дүнгийн талаар байнга мэдээлж байх ёстой бөгөөд тэд хөтөлбөрийг үнэлэхэд заавал оролцоно.

5. Түншлэл хангах

ГБХ-ийн шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлс, нуугдмал шинж, аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол, эдийн засагт учрах үр дагаврууд, тэдгээрийн харилцан хамааралтай байдал зэрэг нь олон талт хариу үйлдэл, хамтын ажиллагааг шаардаг. Иймээс гэр бүлийн гишүүдэд учирч буй асуудлыг тус тусад нь авч үзэлгүйгээр, эрэгтэй, эмэгтэй, хүүхэд, ахмад настан зэрэг бүлгээр ангилан салангид үйлчилгээ үзүүлэхгүйгээр "аюулгүй байдлыг

118 Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төв, Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх хөтөлбөр, Д.Энхжаргал, 2016 он

хангах" нэгдсэн бодлогын дор, харилцан уялдаа холбоо, нэгдмэл үйл ажиллагаа бүхий зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хөгжүүлэх шаардлагатай. ГБХ-ийг таслан зогсооход бүх салбар дундын цогц, иж бүрэн, нарийн зохицуулалттай, тасралтгүй хүчин чармайлт шаардагдана. Эмэгтэйчүүд, эрчүүд, хүүхэд, ахмад настанд зориулагдсан үйлчилгээнүүд болон холбогдох бусад байгууллагатай нягт хамтран ажиллах шаардлагатай.

6. Нууцлал хангах

Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хэрэгжүүлэхэд оролцогч салбар бүрийн холбогдох ажилтнууд дагаж мөрдөх ёс зүйн бодлоготой байж, түүндээ нууц хадгалах талаар гарын үсэг зурж баталгаажуулна. Нууц задруулсан тохиолдолд хариуцлага хүлээх механизмыг хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбон зуучлах журамд тодорхой тусгасан байх шаардлагатай. Хохирогч, гэр бүлийн гишүүд болон зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсан хүмүүсийн нэр, хаягийг нууцална. Амь насыг нь яаралтай аврах шаардлага гарснаас бусад үед хохирогчид урьдчилан мэдэгдэлгүйгээр, түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр тэрхүү мэдээллийг хүлээн авах эрх болон хэрэгцээ нь батлагдсан хүнээс бусад хэнд ч хувийн мэдээллийг нь задруулах ёсгүй.

Хохирогч бичгээр хувийн мэдээллээ задлах талаар зөвшөөрсөн тохиолдолд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хөтөлбөрийг хэрэгжүүлж буй ажилтнууд, эсхүл хохирогчийн эрх ашгийг хамгаалах байгууллага эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай. Хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчийн зүгээс ирэх дарамтаас айсандаа ийм алхам хийсэн байж болох эсэхийг анхааралдаа авч байх нь зүйтэй. Бүх маягт, карт, бичмэл мэдээлэл байнгын хамгаалал, нууцлалд байх ёстой. Бусдад нээлттэй баримт бичигт нэргүйгээр код ашиглана. Нийтэд ил гаргах тайлан, статистик мэдээнд боломжит бүх танигдахуйц мэдээллийг арилгана.

7. Тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхахгүй байх

Хүйс, үндэс угсаа, гарал үүсэл, нас, шашин шүтлэг, нийгмийн бүлэг, давхарга болон бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл, итгэл үнэмшил зэргээс үл шалтгаалан хүн бүр тэгш үнэлэгдэх ёстой. Ялгаварлан гадуурхахгүй байх нь хүн бүр нас, хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, итгэл үнэмшил зэргээс шалтгаалан өөр өөр байх боломжтойг хүлээн зөвшөөрөхөөс эхэлнэ.

ГБХ-тэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн хэрэгжилт

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн А/73 дугаар тушаалаар батлагдсан "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам"-ын хэрэгжилтыг хангах ажлын хүрээнд "Монгол өрх" сэтгэл зүйн хүрээлэнгээс НҮБ-ийн Хүн амын сантай хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Цагдаагийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сэтгэл зүйч нарт 2018 онд "Зан үйлийн албадан сургалтын сургагч багш бэлтгэх" 5 өдрийн сургалтыг зохион байгуулж сертификат олгож, "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт" гарын авлагыг эрхлэн гаргаж хууль сахиулах байгууллагын сэтгэл зүйчдийг гарын авлагаар хангасан. Энэхүү сургагч багш бэлтгэх сургалтын "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт"-ын сэдэв, бүтэцийг танилцуулж байна.

Сургалтын хугацаа, давтамж:

Долоо хоногт 1 удаа, 90 минут үргэлжлэх ба нийт 20 цуврал хичээлийг бүлгээр зохион байгуулна.

Сургалтын үнэлгээ, сахилга бат:

Бүлгийн дүрмийг чанд баримтлана. Эхний хичээлээс эхэлж тавьсан зорилгодоо хэр зэрэг хүрч буй дэвшлийг 7, 14, 20 дугаар хичээлээр эргэн дүгнэнэ. Хичээл тасалбал холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх газарт мэдэгдэж, давтан оролцох эсэхийг шийдвэрлэнэ.

Бүлгийн сургалтын үе шат:

1. Сэтгэл зүйн боловсрол
2. Харилцааны тодорхой ур чадварт суралцах
3. Өөрийгөө ойлгох, үйлдлээ ухамсарлах

4. Амьдралаа шинээр бүтээх
5. Давталтаас сэргийлэх

Хичээлийн агуулга:

Хичээл №	Сэдэв
Хичээл 1	Бүлгийн дүрэм ба зорилго
Хичээл 2	Гэр бүлийн хүчирхийллийн харилцааны динамик, илрэх хэлбэрүүд
Хичээл 3	Эрх мэдэл ба хяналт
Хичээл 4	Хүчирхийллийн давтамжийг таслах – Завсарлага авах
Хичээл 5	Хүчирхийлэлтэй харилцаа ба Эерэг харилцаа
Хичээл 6	Бодол – Мэдрэмж – Үйлдэл
Хичээл 7	Эргэн дүгнэх ярилцлага
Хичээл 8	Таны үнэт зүйлс ба хүчирхийлэл
Хичээл 9	Хүчирхийлэл үйлддэг, эс үйлддэг эрэгтэйн зургийн шилжүүлэлт
Хичээл 10-11	Эцгийн эрхт ёс ба Жендерийн үүрэг, үнэлэмж
Хичээл 12	Сөрөг бодол, нөхөр, дайсан
Хичээл 13	Мэдрэмжийн далд уул, мөсөн оргил
Хичээл 14	Эргэн дүгнэх ярилцлага
Хичээл 15	Дахилтаас сэргийлэх нь
Хичээл 16-17	Хүчирхийлэл хүүхдэд нөлөөлөх нь
Хичээл 18	Харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх нь
Хичээл 19	"Хүчирхийлэлгүй амьдрал" Эрчүүд эрчүүддээ нөлөөлж чадна.
Хичээл 20	Бүлгийн сургалтын дүүргэлт ба Үр дүнг үнэлэх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5 хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/73 тоот тушаалийн хавсралтаар батлагдсан "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр", "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам"-ын хүрээнд Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн албадан сургалтыг зохион байгуулж байна.

Архины шалтгаант зан үйлд нөлөөлөх" сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийг 2020 онд НҮБ-ын Хүн амын сангийн "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл"-ийн санхүүжилтээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, ШШГЕГ-ын харьяа Баривчлах төв, МУБИС-ын Сэтгэл зүйн тэнхимтэй хамтран боловсруулсан байна. Энэхүү хөтөлбөрийг доорх 12 сэдвийн дагуу ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнууд /албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар/ баривчлах шийтгэл оногдуулсан этгээдүүдийг хамруулан зохион байгуулж байна.

Хичээлийн агуулга:

Сэдэв 1. Өөрийн нөхцөл байдлыг таньж мэдэх
Сэдэв 2. Тулгамдсан асуудал, түүний үр дагаврыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх
Сэдэв 3. Архины хэрэглээний талаарх ойлголт, хандлага
Сэдэв 4. Архины шалтгаант сэтгэц, бие махбодын хамаарал
Сэдэв 5. Шийдвэр гаргах чадвараа үнэлж, хөгжүүлэх нь
Сэдэв 6. Зан үйлээ өөрчлөх төлөвлөгөө боловсруулах
Сэдэв 7. Амьдралын зорилго чиглэлдээ дүн шинжилгээ хийж, ~~амьралаа~~ амьдралаа дахин төлөвлөх нь
Сэдэв 8. Суурь итгэл үнэмшил, үнэт зүйлээ тодорхойлж, үнэлэх
Сэдэв 9. Холбоо харилцаагаа үнэлж, хөгжүүлэх ба дэмжих харилцаа бүрдүүлэх
Сэдэв 10. Эрсдэлийг тодорхойлох, түүнээс сэргийлэх
Сэдэв 11. Тэвчээр алдалт, түүнээс сэргийлэх
Сэдэв 12. Эерэг зан үйлээ бэхжүүлэх

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зан үйлд нөлөөлөх" сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийг 2020 онд НҮБ-ын Хүн амын сангийн "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл"-ийн санхүүжилтээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, ШШГЕГ-ын харьяа Баривчлах

төв, МУБИС-ын Сэтгэл зүйн тэнхимтэй хамтран боловсруулсан байна. Энэхүү хөтөлбөрийг бүлгийн сургалтын хэлбэрээр доорх 8 сэдвийн хүрээнд ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнууд Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийг зөрчсөн этгээдүүдийг хамруулан зохион байгуулж байна.

Хичээлийн агуулга:

Бүлгийн сургалт 1.	Гэр бүл гэж юу вэ?
Бүлгийн сургалт 2.	Гэр бүлийн хэвийн харилцаа
Бүлгийн сургалт 3.	Гэр бүлийн хэвийн бус харилцаа
Бүлгийн сургалт 4.	Хүчирхийлэл, түүний үр дагавар
Бүлгийн сургалт 5.	Гэр бүл дэхь нийтлэг асуудал /хардалт, донтолт, хөндлөнгийн оролцоо/, шийдвэрлэх арга зам
Бүлгийн сургалт 6.	Эхнэр/нөхөртэйгөө харилцах эерэг аргад суралцах нь
Бүлгийн сургалт 7.	Хүүхэдтэйгээ харилцах эерэг аргад суралцах нь
Бүлгийн сургалт 8.	Үр дүнг үнэлэх хэлэлцүүлэг

Зөрчлийн тухай хууль зөрчиж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах, 10-50 цагийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдах шийтгэл оногдуулсан иргэдэд ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвөөс албадан сургалтыг зохион байгуулахдаа зөрчил тус бүрийн агуулга, зорилго, чиглэлд тохирсон тусгай хөтөлбөрийг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглах нь илүү үр дүнтэй гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байна.

Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтэд 2019 онд хийсэн мониторингийн тайлангаас

(Хүчирхийллийн эсрэг үндэсний төв)

НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-аас "Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтэд 2019 онд хийсэн мониторингийн тайлан"-ийн Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөртэй холбоотой дүгнэлт, зөвлөмжөөс хүргэе.

Дүгнэлт 1: Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр нь үр дүнд суурилсан сургалтын нэгдсэн бодлогын баримт бичгийн түвшинд боловсруулагдаж гарсан байх шаардлагыг хангахгүй байна. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, сэдэвчилсэн болон календарьчилсан төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын материал болон гарын авлага, хэрэглэгдэхүүн, арга зүй, үнэлгээ, сургалтын орчин зэрэг хамаарал бүхий бүтцийг алдагдуулахгүйгээр тэдгээрийн нарийн уялдаа холбоог тодорхойлсон нэгдмэл баримт бичгийн түвшинд боловсруулах хэрэгтэй байна.

Дүгнэлт 2: Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай байна. Гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэж баривчлагдсан этгээдэд өмнө нь явуулсан хөтөлбөрөөр сургалтыг явуулж байгаа нь үр дүнгүй байна.

Дүгнэлт 3: Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулах, нэгдсэн хөтөлбөрт шилжүүлэх, сургалтыг төрийн бус байгууллагатай гэрээлэн гүйцэтгүүлж болохоор хууль, журамд заасан ч энэ чиглэлээр мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хандаж бодитой ажлыг зохион байгуулж буй төрийн бус байгууллагууд болон мэргэжилтэн, алба хаагчдад дэмжлэг үзүүлэх, ажил дүгнэх нэг үзүүлэлтэд нь тусгаж үнэлэх, урамшуулал, нэмэлт цалин хөлс олгох гэх мэт хөшүүрэг байхгүй байна.

Зөвлөмж 1: Албадан сургалт явуулах чиг үүрэгт хамаарах төрийн албан хаагч буюу сургалт хариуцсан сэтгэл зүйч, эмч, мэргэжилтэн зэрэг алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтод сургалт явуулахтай холбоотой чиг үүргийг тодорхой тусгах, сургалт явуулах багш нарыг нэгдсэн сургалтад хамруулах, мэргэшүүлэх, тогтвортой ажиллаж байгаа сургагч багш нарт урамшуулал,

дэмжлэг үзүүлэх, тогтвортой ажиллуулах, сургалтын хэрэглэгдэхүүн, материаллаг баазаар хангах

Зөвлөмж 2: Зорилтод бүлэгт чиглэсэн зан үйлээ засах, зан үйлд нөлөөлөх сургалтын төлөвлөгөөг ялгамжтай байдлаар боловсруулж дагаж мөрдөх:

Зөвлөмж 3: Сургагч багш нарыг нэгдсэн журмаар бэлтгэх, сургагч багш бэлтгэх сургалтын агуулгад заах арга зүйн болон боловсрол судлалын ерөнхий мэдээлэл олгох асуудлыг тусгахад анхаарч сургалт хариуцсан ажилтны орон тоог нэмэгдүүлэх.

3.4.2 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧТЭЙ ХАРИЛЦАА ТОГТООХ ҮЙЛ ЯВЦ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

ДЭД СЭДЭВ 1. ГБХ үйлдэгчтэй уулзалт хийх, итгэлтэй харилцаа тогтоох нь

Үйлчлүүлэгчид зан үйлд нөлөөлөх албадан сургалтын ач холбогдлыг ойлгуулахын тулд түүнтэй уулзалт хийж, харилцан итгэлцэл бүхий харилцаа тогтоох нь чухал байдаг.

Зарим үйлчлүүлэгч сургалтын ажилтантай уулзаж, өөрт нь зан үйлд нөлөөлөх албадан сургалт шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрдөг бол зарим нь түүнийг огт зөвшөөрдөггүй. Тиймээс зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үйлчлүүлэгч болж буй этгээдтэй харилцаа холбоо тогтоох нь амаргүй байх болно.

Сургалтын ажилтан нь үйлчлүүлэгчтэй шүүмжилсэн, буруутгасан өнгө аясаар харилцаж болохгүй. Харин ойлгож, хүндэтгэн, хэрэгцээг нь мэдэрч харилцсанаар үйлчлүүлэгч өөрийн асуудал, санаа бодлоо хуваалцах болно. Энэ шатанд үйлчлүүлэгч болон сургалтын ажилтны хооронд нээлттэй, харилцан итгэлцэл бүхий харилцаа бий болсон байх ёстой.

Сургалтын ажилтан үйлчлүүлэгчид нэн түрүүнд шийдвэрлэвэл зохих ямар асуудал тулгараад байгаа, үйлчлүүлэгч хүчирхийлэл үйлдэх зан үйлийн өөрчлөлтийн аль үе шатанд байгааг уулзалтын явцад тодорхойлно.

> *Уулзалтыг үр дүнд хүргэхийн тулд үйлчлүүлэгчийг тулгамдаад байгаа асуудлаа нээлттэй, чөлөөтэй илэрхийлж, ярилцах боломжоор ханган аль болохоор дэлгэрэнгүй үнэн зөв мэдээлэл олж авах нь чухал. Мөн асуудлыг улам хурцатгаж, дэвэргэж болохгүйг анхаарч, ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллана.*

Уулзалт зохион байгуулахад тав тухтай (дуу чимээ багатай), нээлттэй, чөлөөтэй уур амьсгал бүхий орчин бүрдүүлсэн байхаас гадна:

- Тухайн үйлчлүүлэгчид тулгамдсан асуудалтай холбоотой мэдээллийг тоо бүртгэлийн ажилтан болон бусад хүмүүс, алба хаагчдаас боломжийн хэрээр авч судалсан байх;
- Үйлчлүүлэгчийн хувийн хэрэгтэй танилцсан байх;
- Амлалтын хуудас, хүчирхийлэх зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг тодорхойлох асуулгыг бэлтгэсэн байх;
- Бусад шаардлагатай материалуудыг бэлтгэсэн байх шаардлагатай.

Уулзалт, ярилцлагын үеэр сургалтын ажилтан, үйлчлүүлэгч хоёр ямар дүрэм журмыг баримтлах талаар ярилцаж, зөвшилцөх нь уулзалтын үр дүнд чухал нөлөөтэй болохыг үйлчлүүлэгчид заавал сануулах нь зүйтэй. Тухайн үйлчлүүлэгчид итгэл төрүүлэн нээлттэй ярилцах боломжийг олгоход уулзалтын дүрэм бүхий амлалтын хуудас ач холбогдолтой.

Сургалтын ажилтан нь үйлчлүүлэгчид уулзалт, ярилцлагыг хийх болсон шалтгаан, энэхүү үйлчилгээний зорилго, ач холбогдол, хүрэх үр дүн зэргийг тодорхой танилцуулж, энэ талаар ямар санал бодолтой байгаа талаар ярилцан, хүчирхийлэл үйлдэх зан үйлээ өөрчилж, эерэг, шинэ зан үйлд суралцахтай холбогдуулан ухаалаг шийдвэр гаргах, буруу зан үйл хандлагынх нь хор уршгийг ойлгуулахад нь туслах хэрэгтэй.

Хүчирхийлэх зан үйлийн өөрчлөлтийн үе шат

Зан үйлийг өөрчлөх Хосолмол-Онолын

Загвар[119] боловсруулагчид эрсдэлийг бууруулах зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээний үр дүнтэй аргыг санал болгодог. Тэдний үзэж байгаагаар хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийн өөрчлөлт нь тус бүрдээ өөрийн гэсэн онцлогтой хэд хэдэн үе шатыг дамждаг.

Бодолгүй байх үе

Хүчирхийлэл үйлдэх зан үйлээ өөрчлөх бодолгүй байх буюу зан үйлээ өөрчлөх шалтгаан байхгүй гэж үзнэ. Эдгээр хүмүүс хүчирхийлэх зан үйлийн асуудлын талаар тодорхой ойлголт мэдлэггүй байх, эсвэл тухайн зан үйлийн зэргийн талаар мэдэж байвч түүнийг өөр дээрээ авч үзэхээрээ зэргийн зэрэглэлийг бууруулж ойлгодог. Энэ шатанд байгаа хүмүүс тухайн асуудлыг нухацтайгаар авч үздэггүй учраас түүнийг өөрчлөхийг хичээдэггүй, эсхүл өмнөх оролдлого нь бүтэлгүйтэж байснаас үүдэн өөрчлөлт хийж чадна гэдэгтээ итгэдэггүй, энэ талаар бодохыг ч хүсдэггүй болсон байх талтай. Тэдэнд хүчирхийлэл үйлдэх зан үйл, түүний үр дагаврын талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай ба тухайн зан үйлийн улмаас үүсэх эрсдэлүүдийг өөр дээрээ дүгнэн үзэж эхлэх, буруу зан үйл хандлагынх нь хор уршгийг ойлгуулахад нь туслах үүднээс энэ шатны зөвлөгөө өгөх үйлчилгээний зорилго, үйл ажиллагаа чиглэдэг.

Бодож эргэцүүлэх үе

Өөрчлөлтийн энэ үед байгаа хүмүүс өөрийн зан үйлд асуудал байгааг ойлгож, өөрчлөх талаар бодож эхэлдэг бөгөөд магадгүй, ойрын 6 сарын дотор өөрчлөлт хийхээр төлөвлөж байдаг. Тэд өөрсдийн зан үйлээ өөрчлөхийн давуу ба сул талыг цэгнэн үзэхийн зэрэгцээ олон зөрчил, бэрхшээлтэй тулгардаг. Учир нь зарим тохиолдолд тэд өөрсдийн хүчирхийлэл үйлдэх зан үйлийнхээ сул талыг олж харсан ч, түүнийг өөрчлөхийн ашиг тусыг хараахан ойлгож ухаарч чадаагүй байдаг. Тиймээс хүчирхийлэл үйлдэхгүйгээр бусад хүмүүстэй харилцахыг хүсэж байгаа ч бодит хэрэг дээрээ тодорхой алхам хийдэггүй. Өөрөөр хэлбэл, энэ үе шатанд байгаа хүмүүс өөрчлөлт хийхийн чухлыг хүлээн зөвшөөрдөг ч харин өөрчлөлт хийх шийдвэрийг гаргаагүй, энэ тал дээр хараахан бэлэн биш байдаг. Энэхүү шийдвэрийг гаргахад гучаас доошгүй хоног шаардагдана.

Бэлтгэл үе

Энэ үед үйлчлүүлэгч тун удахгүй буюу ойрын нэг сарын дотор өөрийн хүчирхийлэх зан үйлдээ өөрчлөлт хийж эхлэхээр хатуу шийдсэн байдаг. Тэд зан үйлээ өөрчлөхийг хүсэж байгаагаа сайтар ухаарсан байх ба өөрчлөлт хийхээр зарим нэгэн оролдлогуудыг хийж эхэлсэн байдаг. Тухайлбал, хараалын үг хэрэглэхгүй байх аргуудыг тогтмол биш ч, ганц нэг удаа хэрэглэж, туршсан гэх мэт. Мөн тэд өөртөө хэвшүүлэхээр зорьж буй шинэ зан үйлийн талаар төдийгүй өөрчлөлт хийх өөрийн чадавхи боломжийн талаар эргэцүүлэн бодно. Улмаар шинэ зан үйлд суралцах болон саад бэрхшээлийг даван гарах өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх эхний оролдлого, алхмуудыг хийхийг хичээдэг. Тэдэнд эрсдэл бүхий хүчирхийлэх зан үйлээ өөрчилж, эерэг харилцааны шинэ чадвар дадал эзэмшихийн давуу тал, ашиг тусыг ойлгон, тэрхүү өөрчлөлтийг хийх хүсэл эрмэлзэл хүчтэй төрж эхэлдэг. Тиймээс энэ үе шатанд байгаа хүмүүс өөрчлөлтийн ашиг тусыг мэдэрснээр эерэг шинэ зан үйлд суралцаж, хэвшүүлэхэд бэлэн болсон байдаг.

Үйлдэл хийх үе

Энэ үе шатанд байгаа хүмүүсийн хувьд зан үйлээ тасралтгүй буюу наад зах нь бүтэн өдрөөс аваад, цаашилбал зургаан сар хүртэлх хугацаанд төлөвлөсний дагуу өөрчлөлт хийх ба хүчирхийлэл үйлдэхгүйгээр бусадтай харилцах эерэг, шинэ дадал, чадваруудыг эзэмших үйлдэл, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Үйлчлүүлэгч өөрчлөлт хийхээр санаа шулуудаж, зорилгодоо хүрэхийн төлөөх тодорхой алхам бүхий үйлдлүүдийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Жишээлбэл, гэр бүлийнхэн болон ойр дотныхоо хүмүүстэй хүч хэрэглэхгүйгээр харилцах, уурлаж бухимдахгүйгээр өөрийгөө илэрхийлэх, бусдыг хүлээцтэй сонсох, хараалын үг хэрэглэхгүй байх зэргээр өдөр бүр тасралтгүй

119 Эрдэмтэн Прочаска, Диклемент болон Норкросс нарын 1992 онд боловсруулсан онол

хийж хэрэгжүүлэхийг хичээдэг. Энэ үеийн нэг чухал анхаарах асуудал нь янз бүрийн шалтгаан, өдөөгч хүчин зүйлсийн нөлөөгөөр тэвчээр алдаж, хүчирхийлэл бүхий эрсдэлт зан үйлээ дахин үйлдэх магадлалтай. Хэвшил болсон эрсдэлт зан үйлээ өөрчлөх үйл явц нь маш их стресс дагуулахын хамт хэт их чармайж хичээснээс болж ачааллаа дааж чадахгүйд хүргэж ч болно. Тиймээс эдгээр хүмүүст өөрчлөлтийг амжилттай хийж, шинэ, эерэг зан үйлийг хэвшүүлэхийн тулд ихээхэн хичээл чармайлт, тэвчээр шаардлагатай гэдгийг ойлгуулах нь чухал. Нөгөөтэйгүүр, өөрчлөлтөд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг багасгаж, орчны дэмжлэгийг сайжруулж, урамшуулан дэмжих замаар үйлчлүүлэгчийг тэвчээр алдаж, эргэж буцахаас сэргийлэхэд энэ шатанд үзүүлэх үйлчилгээний зорилго оршино.

Хэвших үе

Зургаа буюу түүнээс дээш сарын хугацаагаар шинэ зан үйлийг тасралтгүй хэвшүүлнэ. Энэ шатанд байгаа хүмүүс дээр дурдсанчлан харилцааны эерэг чадвар, дадал бүхий шинэ зан үйлээ өдөр тутмын амьдралдаа идэвхтэй хэрэглэж хэвшүүлсэн, тэвчээр алдахаас сэргийлэх арга хэмжээг ч авч эхэлсэн байдаг. Зан үйл нь дадал болсон байх бөгөөд хувь хүний ахуй амьдралын нэг хэсэг болж эхэлсэн байдаг. Гэхдээ энэ үе шатанд байгаа хүмүүсийн хувьд ч тэвчээр алдаж, эргэж буцах нь сэтгэл зовоосон асуудал хэвээр байна. Жишээлбэл, 7- 8 сарын турш бусдыг хүндлэн зөв, сайхан харилцаатай байсан хүн гэнэт нэг өдөр хуучин зан авир, өвчин нь сэдэрч, бусдыг хүчирхийлэн, түрэмгийлэх тохиолдол амьдрал дээр гарч байдаг. Мэдээж өмнөх үе шатуудыг бодвол энэ хүртэл өөрчлөгдөж чадсан хүмүүсийн хувьд шинэ зан үйлийг дадал хэвшил болгоход харьцангуй хялбар байдаг. Тиймээс шинэ зан үйлээ өдөр тутмын амьдрал, үйл ажиллагааныхаа салшгүй хэсэг болгож тогтмол хэвшүүлэхийн тулд тодорхой хэмжээний шахалт хэрэгтэй. Үүнээс үзвэл өмнөх үе шатуудад хийгдэж байсан өдөөгч буюу сэдрээх зүйлийг хянах, дэмжих харилцааг бэхжүүлэх, урамшуулан бататгах үйл явц цаашид ч үргэлжлэн явагдсаар байдаг.

Хүмүүс хүчирхийлэл үйлдэх зан үйлээ өөрчлөхдөө дээрх үе шатыг дамжин өнгөрөх ба эхний үе шатад гарсан ахиц өөрчлөлт нь дараагийн үе шатад шилжих нөхцөлийг бүрдүүлж байдаг. Аль ч үе шатнаас эргэж буцах буюу тэвчээр алдаж болох бөгөөд энэ нь өөрчлөлтийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Эхний буюу бодолгүй байх үеэс хэвших үед шууд орох боломжгүй байдгийг судлаачид сануулдаг.

Сургалтын ажилтан үйлчлүүлэгчийнхээ зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг оновчтой тодорхойлж, тухайн үе шатанд ямар сургалт үр дүнтэй вэ гэдгийг сонгон, түүний онцлогт тохирсон сургалтыг явуулна.

Үйлчлүүлэгч асуултад хариулахдаа бодох ч юмуу, эсвэл нэмэлт янз бүрийн тайлбар өгч болох юм. Тиймээс тэдгээрийг нь сайтар ажиглах хэрэгтэй ба түүний хариулттай нь харьцуулж, бодитой эсэхийг нь шалгаж үзээрэй.

Үйлчлүүлэгч бүр хүчирхийлэл үйлдэх зан үйлийн өөрчлөлтийн хувьд адилхан байх албагүй. Тиймээс сургалтын ажилтан тухайн үйлчлүүлэгчийн өөрчлөлтийн үе шатыг оновчтой тодорхойлж, гол нь түүний санаа бодлыг сонсож, ямар дэмжлэг, үйлчилгээ авах хүсэлтэй байгаа, зан үйлээ өөрчлөх талаар ямар бодолтой байгааг асууж ярилцах хэрэгтэй.

ДЭД СЭДЭВ 2. ГБХ үйлдэгчтэй харилцахад анхаарах зүйлс

Анхаарах: Амиа хорлох эрсдэлтэй сэтгэл гутрал, психоз, психопаттай үйлчлүүлэгчийг (хүчирхийлэгчийг) хохирогчид аюул учруулах өндөр эрсдэлтэй гэж үзэх ба сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад холбон зуучилж, тодорхой эмчилгээ, үйлчилгээ, оношилгоонд хамруулсны дараа зан үйлийг өөрчлөх албадан сургалтад хамруулна.

Эдгээр тохиолдлуудаас бусад үед үйлчлүүлэгчийн (хүчирхийлэгч) итгэлийг олох, өөрийн зан байдлын талаар тунгаан бодох (эргэцүүлэх) боломжийг олгох сэдлийг дэмжих ярилцлагыг эн түрүүнд хийх нь чухал.

Үйлчлүүлэгчтэй нээлттэй, итгэлцэл бүхий

харилцаа холбоо тогтоохын тулд сургалт зохион байгуулж буй мэргэжилтэн та идэвхтэй сонсох, бусдын сэтгэл санааг ойлгох, улмаар ойлгож мэдэрч байгаагаа оновчтой илэрхийлж, тохирсон хариу үйлдэл үзүүлэх зэрэг харилцааны ур чадваруудыг сайтар эзэмшсэн байх шаардлагатай. Үүнд:

Ярилцлагыг хөтлөн явуулах

Ярилцлага нь асуудлаа ухаарч ойлгох, одоогийн үзэл бодол, итгэл үнэмшилд нөлөөлөх, түүнийг шийдвэрлэх арга зам, хувилбаруудыг боловсруулж хэлэлцэх, сонголт хийх, тэдгээрийг амьдрал,ахуйдаа хэрэглэж туршихад дэмжлэг үзүүлэх өвөрмөц арга юм.

Ярилцлагын үргэлжлэх хугацаа харилцан адилгүй байдаг боловч үйлчлүүлэгчтэй хийх нэг удаагийн уулзалт,ярилцлагын үргэлжлэх хугацаа нь ойролцоогоор нэг цаг орчим байх нь тохиромжтой бөгөөд дараах дараалаар явуулах нь тохиромжтой. Үүнд:

- Ярилцлагыг эхлэх;
- Мэдээлэл цуглуулах;
- Шийдвэрлэх асуудлыг тодруулах;
- Ярилцлагыг дуусгах.

Ярилцах таатай уур амьсгал бүрдүүлэхэд сэтгэл зүйн харилцаа чухал үүрэгтэй. Сэтгэл зүйн харилцаа тогтооход харилцааны үгэн ба үгэн биш хэрэгслүүд чухал нөлөө үзүүлдэг. Сэтгэл зүйн харилцаа тогтоож, ярилцлагыг эхлэх бэлтгэл хангахад дараах арга,техникүүдийг хэрэглэх боломжтой.

- Үйлчлүүлэгчийн нэрээр дуудаж ярилцах;
- Байгаа чигээр нь хүлээн авах;
- Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх боломж олгох;
- Дэмжсэн үг хэллэг хэрэглэж, сэтгэлээ илэрхийлэх;
- Энгийн үг хэллэг хэрэглэх;
- Нүдээрээ харилцаа тогтоох;
- Нүүр царайны хувирал, хөдөлгөөнөө тохируулж илэрхийлэх;
- Биеийн хөдөлгөөн, байрлалаа тохируулах;
- Орон зайн байрлалаа зөв сонгох;
- Дуу хоолойн өнгө, чанга, сулаа тохируулах;
- Ярилцлагын цаг хугацааг зөв сонгох.

Ажиглах техник

Энэ үед үйлчлүүлэгчийн хүйсийн ялгаа тод илэрдэг. Эрэгтэй үйлчлүүлэгч яриагаа юунаас эхлэхээ мэдэхгүй дуугүй суух, дэлгэрэнгүй ярихаас зайлсхийх зэрэг байдалтай байдаг тул түүний хувийн онцлогт тохируулан харилцахад анхаарах хэрэгтэй. Зарим тохиолдолд хэлж байгаа үг, яриа болон илэрхийлж буй үйлдэл хөдөлгөөн зөрөх нь цөөнгүй. Жишээлбэл, ажил амьдрал сайхан байна, болж байна гэж ярьж байгаа боловч цаанаа л сэтгэл зовж, шаналсан дуу хоолой илэрч байвал далд, нуугдмал зөрчил байна гэсэн үг.

Үйлчлүүлэгчийн үг яриа, нүүр царай, биеийн хөдөлгөөний өөрчлөлт хувирал, түр зогсолт зэргийг сайтар анхааралтай ажиглаж чадвал түүнд чухам ямар асуудал байгааг тодруулах боломжтой. Хэрвээ үйлчлүүлэгч өөрт тохиолдсон бодит асуудлаа хэлэхээс зайлсхийх байдал ажиглагдвал "та сая хөрөнгө бэлтэй болж, амьдрал сайн сайхан байгаа тухайгаа ярилаа, гэхдээ таныг ажиглаж байхад нэг л гутарсан, гунигтай байдал илрээд байх юм" гэж эргэлзээтэй санаа бодлоо хэлж, асуудлыг тодруулж болно. Ярилцлагын явцад илрэх үгэн бус харилцааг ойлгох мэдрэмжтэй, ажигч гярхай байж чадвал нуугдмал далд мэдээллийг тодруулж чадна.

Сонсох техник

Зарим үйлчлүүлэгчид ямар нэгэн шахалтгүйгээр өөрт тохиолдсон асуудлаа ярьж эхэлдэг. Үйлчлүүлэгчид тохиолдсон үйл явдлын талаар мэдээлэл цуглуулахад сонсох чадвар чухал үүрэгтэй. Сонсож байж тохиолдсон бэрхшээл, зөрчил, таагүй байдлыг мэднэ.

Үйлчлүүлэгчид анхаарал тавьж, түүнд тохиолдсон асуудлыг тэвчээртэй сонсож чадвал үйлчлүүлэгчийн үзэл бодол, сэтгэл санаанд эргэлт гарахад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг. Сонсох нь:

- Үйлчлүүлэгчид тохиолдож байгаа үйл явдлыг ойлгож байна гэсэн итгэл төрүүлдэг;

- Үйлчлүүлэгчийг хүндэтгэж, асуудлыг сонирхож байна гэсэн сэтгэгдэл төрүүлдэг;
- Үйлчлүүлэгч мэдээллээ бүрэн дүүрэн ярихыг эрмэлзэж хичээж эхэлдэг.

Үйлчлүүлэгчтэй ярилцах явцдаа үйлчлүүлэгчийнхээ яриаг анхааралтай, зорилго чиглэлтэйгээр, дэмжсэн байдлаар сонсохыг идэвхтэй сонсох техник гэдэг.

Үйлчлүүлэгчийн хэлсэн зарим үг, сүүлчийн өгүүлбэрийг тэр чигээр нь давтан хэлж болно. Үүнийг "эхо" буюу цуурай техник гэж нэрлэдэг. Үйлчлүүлэгчид тохиолдсон үйл явдал, мэдрэмж, сэтгэл хөдлөлийг танин мэдэхэд энэ техникийг голлон хэрэглэдэг. (Шүүгчдэд зориулсан "Шүүгчээс ГБХ үйлдэгч гэрч, хохирогчтой харилцах" сэдвээс тодруулан харна уу)

Үүний зэрэгцээ сэтгэл хуваалцан сонсох арга техникийг өргөн хэрэглэдэг. Үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөлийн байдал, дуу хоолойны өнгө, хурд, хэмнэл, дохио зангаа, ярьж байгаа зүйлийн агуулгад аль болохоор ойртуулж, ижил төстэйгээр илэрхийлэх чадварыг "сэтгэл хуваалцан" сонсож байна гэж үздэг. Энэ техник нь дэмжих нөлөө үзүүлдэг. Үйлчлүүлэгчийн яриаг чин сэтгэлээсээ "сэтгэл хуваалцан" сонсож чадвал тэрээр өөрт тохиолдсон асуудлаа нээлттэй, чөлөөтэй ярьж эхэлдэг. Жишээлбэл, "тийм тийм, тэгэлгүй яахав, өө тийм, үргэлжлүүл, үргэлжлүүл" гэх мэтийн үг хэрэглэж, толгойгоо дохин инээмсэглэж, дэмжлэгээ илэрхийлж болно.

Асуух техник

Зарим үйлчлүүлэгч яриагаа юунаас, яаж эхлэхээ мэдэхгүй учраа олохгүй, дуугүй суух тохиолдол цөөнгүй гардаг. Иймээс:

- Таны ярихыг сонсъё.
- Танд тусламж хэрэгтэй байна уу?
- Хоёулаа яриагаа юунаас эхлэх вэ?
- Энэ өөрчлөлтийг хэдий үеэс анзаарах болов?
- Та жаахан бухимдсан байх шиг байна. Энэ юутай холбоотой юм бол?
- Би таныг анхааралтай сонсож байна гэх мэт дэмжих асуулт тавьж, ярьж эхлэхэд нь туслах боломжтой.

Үйлчлүүлэгчид тохиолдсон асуудлын талаар тодорхой мэдээлэлтэй болох, ярилцлагыг логик дэс дараалалтай хөтлөн явуулахад асуух техникийг ашигладаг. Асуулт нь тухайн хүний дотоод ертөнцөд болж байгаа үйл явдлын далд хөшгийг нээх түлхүүр болдог. Ийм учраас асуух зүйлээ аль болохоор урьдчилан төлөвлөж, эрэгцүүлэн бодож, бүтээлчээр хандах нь чухал.

Оновчтой, тодорхой тавьсан асуулт нь:

- Санаа бодлоо бүрэн дүүрэн илэрхийлж ярих, мэдээллийг тодотгох;
- Ярилцах цаг хугацааг хэмнэх;
- Ойлголцлыг дэмжиж, ярилцлагыг цаашид үргэлжлүүлэх;
- Ойр тойрны хүмүүстээ хандах хандлагын талаар аль болохоор үнэн бодитой мэдээлэл авах;
- Үйл явдлыг дотроо эрэгцүүлж тунгаах, ухаарч бодоход чухал нөлөө үзүүлдэг.

Асуулт нь олон янз байх бөгөөд тухайн нөхцөл байдал, сургалтын зорилгодоо тохируулан сонгож сурах хэрэгтэй болно.

a) Дор үзүүлсэн уулзалтын дүрэм бүхий амлалтын хуудасны загвартай танилцаж, амлалтын хуудас бичээрэй.

b) Амлалтын хуудсын ач холбогдлыг тодорхойлно уу.

"УУЛЗАЛТЫН ҮЕД БАРИМТЛАХ ДҮРМҮҮД"
"АМЛАЛТЫН ХУУДАС"-ны загвар

Миний бие дараах зүйлсийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж амлалт өгч байна.

Нууцыг хадгалах - Уулзалтын үеэр яригдсан болон хувийн шинж чанартай аливаа мэдээллийн талаар найз нөхөд, гэр бүлийнхэн, хамт хоригдогсод гэх мэт хэн нэгэн хүнд ярихгүй байх. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд харилцан зөвшилцсөний үндсэн дээр өөр хэн нэгэнд мэдээлнэ.

Хүндэтгэх - Нэг нэгнийхээ үзэл бодлыг хүндэтгэж, хүлээцтэй сонсоно. Бие биенээ доромжилсон үг хэллэг хэрэглэхгүй, бие биенээ буруутгах, шүүмжлэхээс зайлсхийж, хүндэтгэж харилцана.

Нээлттэй, чөлөөтэй байх - Аль болох нээлттэй чөлөөтэй байж, уулзалт ярилцлагад идэвхтэй оролцоно.

Асуулт асуух эрхтэй байх - Ямар нэгэн зүйлийг ойлгохгүй, эсхүл нэмэлт мэдээлэл авахыг хүссэн үедээ чөлөөтэй асууна.

Хариуцлагатай байх - Өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь хийж гүйцэтгэнэ. Өөрчлөлтийн төлөө идэвх чармайлт гаргана.

Үйлчлүүлэгч:	Сургалтын ажилтан:
Нэр:	Нэр:
Гарын үсэг: _____	Гарын үсэг: _____
Огноо:	Огноо:

a) Дараах тохиолдлыг уншиж, хүчирхийлэл үйлдэгчийн өмнөөс хүчирхийлэх зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг тодорхойлно уу. Ингэхдээ тохиолдлын дор өгөгдсөн "Хүчирхийлэх зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг тодорхойлох асуулт"-ыг ашиглаарай.

b) Үйлчлүүлэгчийг тодорхойлсон үе шатын онцлог юу вэ?

Тохиолдол:

Иргэн Д.Баатар эхнэр, 4 хүүхэдтэй. Д.Баатар нь эхнэр Б.Цэцэгээтэй гэр бүл болоод 11 жил болсон, 2015 оны 5 сард гэр бүлээ цуцлуулсан. 2015 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Б.Цэцэгээг зодож, хүндэвтэр гэмтэл учруулсан.

Шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсгээс: "... шүүгдэгч Д.Баатар нь архи ууж, согтуурсан байхдаа 2010 оноос 2015 оны 11 сарын 23-ны өдөр хүртэл хугацаанд өөрийн эхнэр байсан, сүүлдээ гэр бүлээ цуцлуулаад тусдаа амьдарч байсан Б.Цэцэгээг байнга зодож, тарчлаах шинжтэй үйлдлийг удаа дараа хийж, бусдыг тарчлаасан гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдож байна".

Шийтгэх тогтоолын тогтоох хэсгээс: "...3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэгт зааснаар шүүгчдэгч Д.Баатарыг 2 (хоёр) жилийн хугацаагаар хорих ял шийтгэсүгэй."

"Хүчирхийлэх зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг тодорхойлох асуулт"



Заавар: Та "тийм", "үгүй" гэсэн хариултаас сонгож, хэрхэн хариулснаас шалтгаалан хариулт бүхий сумны дагуух дараа дараачийн асуултуудыг хариулах байдлаар зан үйлийн өөрчлөлтийн аль үе шатанд байгааг тодорхойлно уу.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг сэдэлжүүлэхдээ бодуулах асуулт асуух, ярилцлагын төгсгөлд, юмуу сургалтын төгсгөл хэсэгт байнга бодох болон асуултын хариулт олох даалгавар өгч дуусгах нь ач холбогдолтой байдаг.

ДЭД СЭДЭВ 3. Сэдлийг дэмжих ярилцлага

Сэдлийг дэмжих ярилцлага өөрөө өөрийгөө өөрчлөх боломжийг олгодог. Өөрчлөлтийг хийхэд яг өөрчлөх ёстой зүйлээ олох нь чухал байдаг. Хувь хүн гэдгийг нь хүндэлж харьцах, мөн зөвхөн шүүмжилж хандахын оронд үйлчлүүлэгчид хүнд хэцүү байсан тэр зүйлийг нь зөвөөр хандаж гаргаж ирэх нь чухал юм. Хүндрэл бэрхшээлүүдийг даван туулах чадвар, бололцоог сэдэлжүүлэх нь гол байна. Хамтын ажиллагаанд (эмчилгээ) үйлчлүүлэгчийн сэтгэл санааны байдал, хандлага гол нөлөө үзүүлдэг. Энд хамтын ажиллагааг бий болгож чадах нь чухал юм. Үйлчлүүлэгчид өөрчлөгдөх шалтгааныг нь өгөх хэрэгтэй.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсан 47 хүний 24 хүн нь баривчлагдсан байх хугацаандаа 5-аас дээш удаа, 8 хүн нь 3-5 удаа, 15 хүн нь 1-2 удаа сургалтад хамрагджээ. /Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтэд 2019 онд хийсэн мониторингийн тайлангаас/

Энэ тохиолдолд 7-10 хоног баривчлах шийтгэл хүлээлгэсэн хүчирхийлэл үйлдэгчтэй ганцаарчлан уулзаж сэдлийг дэмжих ярилцлага хийх нь үр дүнтэй юм.

Сэдлийг дэмжих богино хугацааны ярилцлагын арга нь анхан шатны зөвлөгөө, тусламжийн хүрээнд хүчирхийлэл үйлдэгчид зан үйлээ өөрчлөх сэдлийг төрүүлэх, өөрчлөгдөх сэдлийг дэмжих ач холбогдолтой.

Тухайн үйлчлүүлэгч:

Өөрчлөгдөх шаардлагатай тал (шалтгаан)

- Гадаад үзэмж, гоо сайхны байдлаа алдана
- Бие нь өвдөх,
- Нэр хүнд унах
- Ажилгүй болох магадлал

Өөрчлөгдөх шаардлагагүй тал

- Би хүчирхийлэгч биш, гэж бодсон ч сэтгэлийнхээ мухарт би хайртаа хүндээ гар хүрэхээ зогсоох хэрэгтэй гэдгээ ойлгож байдаг.

Хувь хүний дотор эргэлзэх тээнэгэлзэх байдал үүсэж, хоорондоо тэмцэлдэж байдаг. Сэдлийг дэмжих ярилцлага нь тухайн үйлчлүүлэгч "Юу гэж бодож байна" гэдэг дээр төвлөрөх нь гол юм. Өөрчлөгдөхгүй байх шалтгаан нь өөрийн дуртай таашаал төрүүлдэг зүйлээ хийж чадахаа болино гэж бодсоноос өөрчлөгдөх хүсэлгүй байх. Тухайн үйлчлүүлэгч өөрийн байдлыг өөрчлөх сэдлийг бий болгох талаар харилцан ярилцах арга юм. /харилцаа холбоо - өөрчлөлтөд бэлтгэх/

- Үйлчлүүлэгч дээр төвлөрч, түүнийг чиглүүлэх.
- Үйлчлүүлэгч сэтгэл зүйч намайг анхааралтай сонсож байгаа гэсэн мэдрэмж төрүүлэх, анхааралтай сонсож өөрчлөгдөх шалтгааныг тодруулах, лавлаж, зөв ойлгосон эсэхээ бататгах, асуух.

- Хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх
- Тээнэгэлзлэлийг таньж түүнийг шийдвэрлэх нь тухайн үйлчлүүлэгчийн өөрчлөгдмөөр байгаа хүсэл эрмэлзлэлийг чиглүүлэхэд нэг ач холбогдол нь оршино. Энэ хүсэл эрмэлзлэлийг үйлчлүүлэгчээр өөрөөр нь хэлүүлэх хэрэгтэй.

Сэдлийг дэмжих ярилцлага нь үндсэн 3 зарчимтай байна.

1. Сэдлийг дэмжих ярилцлага нь бие даасан байдлыг харгалзаж үзнэ. Тухайн үйлчлүүлэгч өөрөө шийдвэр гаргах ёстой гэдгийг хэлнэ. Өөрийнх нь асуудал учир өөрөө тэр асуудлаа гаргаж ирнэ. Үйлчлүүлэгчээр өөрөөр нь хэлүүлнэ.
2. Сэтгэл зүйч үйлчлүүлэгчийн яриан дундаас өөрчлөгдөх шалтгааныг нь олж мэдэх ёстой.
3. Үйлчлүүлэгч сэтгэл зүйч хоёр сэдлийг дэмжих ярилцлагад эрх тэгш оролцож байж, сэдлийг дэмжих ярилцлага амжилттай болох ёстой.

Сэдлийг дэмжих ярилцлага ямар зорилготой вэ?

1. Бие биедээ итгэсэн харилцааг бүрдүүлэх

Няцаалтыг эсэргүүцэхгүйгээр алгуур шийдэх зорилготой байдаг.

2. Үйлчлүүлэгчээс өөрчлөлт хүлээж байгаа, өөрчлөгдөж магадгүй гэж хүлээж сэдлийг дэмжих ярилцлагыг явуулдаг. Тухайн хүнийг сонсоод ойлгож байна гэдгээ харуулах.

Сэдлийг дэмжих ярилцлагын ач холбогдол

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний үед 8 өвчтөнтэй сэдлийг дэмжих ярилцлага хийж, зөвлөгөө өгснөөр нэгийг эмчлэх магадлалтай гэж үздэг. Тамхинаас гаргах эмчилгээний үед 20 өвчтөнд зөвлөгөө өгч, сэдлийг дэмжин ярилцсанаар нэгийг эмчлэх магадлалтай бөгөөд хэрвээ эмийн эмчилгээг хавсарч хийсэн тохиолдолд эмчлэгдэх хүний тоо 10 хүртэл өсөх магадлалтай. Сэдлийг дэмжих богино хугацааны ярилцлага нь урт хугацааны ярилцлагаас илүү үр дүнтэй байна. Үр дүн нь дараагийн нэг жил, бүр дөрвөн жил хүртэл хадгалагддаг.

Сэдлийг дэмжих ярилцлагыг анхан шатны эрүүл мэндийн тусламжийн хүрээнд архи согтууруулах ундааны аюултай хэрэглээг багасгах зорилгоор, архины хараат байдалд ороогүй өвчтөнүүдтэй хийх нь илүү үр дүнтэй. Найман өвчтөнтэй ярилцахад нэг хүнд нь нөлөө үзүүлэх магадлалтай.

Сэдлийг дэмжих ярилцлагыг хэрэгжүүлснээр үхлийн тоо хэмжээ буурахад нөлөөлнө. Энэ нь 282 өвчтөнтэй ярилцаж байж жилд 1 хүнийг үхлээс аврах магадлалтай.

Сэдлийг дэмжих богино хугацааны ярилцлага нь эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу хүмүүст ижилхэн үр дүнтэй байдаг. Гэвч асуудал нь арай хөнгөн хүн дээр үр дүн нь илүү харагдана.

Хуваалцах гэдэг нь: Адилхан гуниглаж, хэцүү байдлыг нь нимгэлнэ гэсэн үг биш юм.

Ярилцаж байгаа байдлаас үр дүн гарах хэрэгтэй. Зарим тохиолдолд сэтгэл зүйчийн зүгээс тулгасан, зөвлөсөн, хурдан маягаар (яарсан) хийх нь үйлчлүүлэгчийн эсэргүүцэлтэй тулгарна.

- Асуудлыг олон талаас нь харж үзэх, олон нөхцөл байдал.
- Өөрчлөлт хийнэ гэсэн өөртөө итгэх итгэлээ алдсан байдаг учраас үр дүн гаргаж байна гэсэн мэдрэмжийг төрүүлэх. Хэрвээ тухайн үйлчлүүлэгч өөрчлөгдөхөөр шийдвэр гаргаж чадвал зоригжуулж, урамшуулж, зөв эерэг нөлөөлөл үзүүлж болно.

Сэдлийг дэмжих ярилцлагыг ямар аргаар явуулж болох вэ?

- Нээлттэй асуулт: тэр талаараа ярих хүсэл төрүүлж байгаа тэр асуултыг хэлнэ.

Ядаж эхэн үедээ аль болох нээлттэй асуултаар эхлэх нь зүйтэй юм. Уулзалтуудынхаа талаар та юу гэж бодож байна? Яагаад?

Яагаад? Гэдэг асуултыг нэг хүнтэй ярилцахад 1 юм уу, 2 удаа хэрэглэх хэрэгтэй.

Олон удаа яагаад? гэж асуухаар үйлчлүүлэгчдэд ядаргаатай, яагаад заавал хариулах ёстой гэсэн саад үүсдэг.

Нэг дор олон удаа "үгүй" гэсэн хариулт авбал бас саад үүсчихдэг. Аль болох "үгүй" гэсэн

хариултаас зайлсхийх хэрэгтэй.

- Та яагаад энд хүрч ирсэн бэ?
- Таньд миний тусламж хэрэгтэй гэж үзэж байна уу?
- Тэр талаар сайн ойлгосонгүй. Үүнийхээ талаар тодруулж өгөөч.

Ярилцлага нь хүчирхийлэл үйлдэгчид байцаалт өгч, шүүмжлүүлж байгаа сэтгэгдэл төрөх ёсгүй.

Сэдлийг дэмжих ярилцлагын үеэр биеэ авч явах тухай

Үйлчлүүлэгчийн сайн талыг харуулах гэдэг нь өөрийнх нь сайн талыг гаргана гэсэн үг. Өөрийн сайн талыг мэдэрсэнээр өөртөө итгэх итгэл нь нэмэгдэнэ.

- Та өөрийн багш мэргэжилдээ их дуртай юм байна.
- Өөртөө санаа тавиад сэтгэл зүйчид хандаж байгаа нь их сайшаалтай явдал байна.

Тухайн үйлчлүүлэгчийн ярьсан зүйл дээр дүгнэлт хийх нь ярьсан зүйлийг нь сайн ойлгосон гэдгээ харуулж буй хэрэг юм. Ярилцлагын дунд юм уу сүүлд нь хийж болно. Лавшруулж асуух, зөв ойлгосон эсэхээ асуух, цуурай маягаар ярих нь мөн тэр хүндээ тухайн асуудлынхаа талаар бодож эргэцүүлэх завшаан болдог. Эргэлзэж тээнэгэлзэн яахаа мэдэхгүй байгаа хүнд дүгнэлт хийх нь бодол санаагаа цэгцлэхэд нь тус дөхөм үзүүлдэг.

Сэдлийг дэмжих ярилцлагаа дуусгахад яагаад өөрчлөгдөх ёстой вэ? гэсэн тэр зүйл дээр нь ярьж дуусгана. Дүгнэж ярилцах нь тухайн хүндээ таатай мэдрэмж төрүүлдэг. Богино, товчхон байдаг. Олон цэцэгнээс баглаа бэлддэг шиг ярилцлагаас чухал гэсэн зүйлүүдийг шилж түүж дүгнэлт хийх хэрэгтэй. Сэдлийг дэмжих ярилцлагын явцад хэрхэн цуурай хийх талаа дасгал хийх. Ярилцлагыг хийх үед хурдан бодож сэтгэх, асуух асуултаа бодож олоод асуух хэрэгтэй байдаг.

Тухайн үйлчлүүлэгчийн эсрэг зүйл хэлэх, шүүмжлэхээс зайлсхийх. Үйлчлүүлэгчийн зүгээс эсэргүүцэл үзүүлэх тийм утга бүхий асуулт асуухаас зайлсхийх хэрэгтэй.

Сэтгэл зүйч, Үйлчлүүлэгч, Ажиглагч

Үйлчлүүлэгч ер нь юу яриад байна? Гэдгийг сайн ойлгоно. Үйлчлүүлэгч муухай зантай биш, үйлчлүүлэгчдийн нийтлэг ярьдаг зүйл ярина . 10-15 минут үргэлжилнэ.

1. Нээлттэй асуулт
2. Сайн талыг харуулах
3. Цуурай
4. Дүгнэлт хийх

Энэ 4 арга барилыг хэрэглэх нь чухал.

Ямар түүх өгүүлж байгаа нь гол биш. Ямар арга барилаар ямар хариулт, яриа өрнүүлж байна гэдэг нь гол.

Үйлчлүүлэгчийн эсэргүүцэлтэй тулгарвал энэхүү харилцаа болохгүй байна гэсэн дохио юм. Тиймээс ярилцлагыг эерэгжүүлэх үүднээс сэтгэл зүйч, дээрх арга техникүүдийг хэрэглэх нь зүйтэй юм.

Эсэргүүцэл:

- Чив чимээгүй, ярихгүй байх
- Эсвэл суудлаа сэлгэх, сандлаа холдуулж суух
- Өөрийгөө хамгаалсан байр суурьтай байх

Сэтгэл зүйч үйчлүүлэгчдэд emphaty үзүүлэх нь чухал юм. Сэтгэл зүйчийн зүгээс харилцаа эерэг байвал үйлчлүүлэгч сандалаа ойртуулах эсвэл арай ойр сандал дээр сэлгэж суух байдал гаргаж болно.

Үйлчлүүлэгчээс зөвшөөрөл аваад сэтгэл зүйн сорил, асуулга, тестыг бөглүүлэх, мөн сэдлийг дэмжих ярилцлагын үед сэтгэл зүйн судалгааны үр дүнгээр анхаарал татсан асуулт, үр дүн, нэмж тодруулах зүйлсийн талаар үнэлж дүгнэж ярилцаж болно.

Анхны уулзалт эсвэл үргэлжилсэн уулзалт гэдгээс хамаараад сэдлийг дэмжих ярилцлагын үед үйлчлүүлэгчийн ярьсан зүйлд тэмдэглэл хийх эсэхээ шийддэг.

Анхны уулзалтаар сэдлийг дэмжих ярилцлага хийдэг. Уулзалтын төгсгөлд гэр бүлийн харилцаа болон сэтгэл гутрал, стресс, түгшүүр, зан байдлыг тодорхойлох сэтгэл зүйн сорил, асуулга, тест бөглүүлж болно. Хаалттай асуултуудаар ярилцлагаа төгсгөдөг.

Үйлчлүүлэгчийн түүх дээр тэмдэглэх зүйл байвал ярилцлагын төгсгөлд сонирхсон хаалттай асуултаа асууж тэмдэглэдэг. 2 дахь уулзалтанд ирэх эсэхийг хэлэлцэж тохирох, дараагийн уулзалтад ирэх хэрэгтэй гэдгийг тайлбарладаг. 2 дахь уулзалтад бэлтгэх, сэтгэл зүйн судалгааны үр дүнг танилцуулах гэх мэт. Сэтгэл зүйч юу бичсэн бэ ? гэдгээ үйлчлүүлэгчдэд хэлдэг. Ингэснээр үйлчлүүлэгч сэтгэл зүйч надад анхааралтай хандаж, дараагийн сэдлийг дэмжих ярилцлагад бэлтгэж байна гэж бодоод өөрөө ч гэсэн бэлтгэлтэй ирэх хэрэгтэй юм байна гэж боддог. Өөр сэтгэл зүйчид шилжүүлэх захиагаа үйлчлүүлэгчдэд уншиж өгдөг. Үйлчлүүлэгч бичүүлэхийг хүсэхгүй зүйл байж болно. Ярьж байхад нь аль болох бичихгүй байхыг хичээх хэрэгтэй. Ярьж байхад нь бичихээр үйлчлүүлэгч сэжиглэх эсвэл намайг сонсохгүй байна гэх хандлагатай байдаг.

Сэдлийг дэмжих ярилцлага: Өөрчлөлт хийхэд хэрхэн туслах вэ?

Үйлчлүүлэгчдэд өөрийн байдлыг өөрчлөх сэдлийг бий болгох талаар харилцан ярилцах.

Ярилцлагыг танилцуулах төлөвлөгөө:

- Үйлчлүүлэгчдэд өөрийн байдлыг өөрчлөх сэдлийг бий болгох талаар харилцан ярилцах: Зарчим ба арга
- Донтолт болон архаг хууч өвчтэй, хүчирхийлэгч зан үйлтэй хүмүүсийг хянахад үйлчлүүлэгчид өөрийн байдлыг өөрчлөх сэдлийг бий болгох талаар харилцан ярилцах нь үр дүнтэй байдаг.

Үйлчлүүлэгчдэд өөрийн байдлыг өөрчлөх сэдлийг бий болгох талаар харилцан ярилцах арга барил.

- .....харилцаа холбоо
- .....өөрчлөлтөнд бэлтгэх
- Үйлчлүүлэгч дээр төвлөрч, мөн түүнийг чиглүүлсэн байх
- Хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх
- Тээнэгэлзэлийг таньж түүнийг шийдвэрлэх нь

Үйлчлүүлэгчдэд өөрийн байдлыг өөрчлөх сэдлийг бий болгох талаар харилцан яриа өрнөх уур амьсгал.

- Өөрчлөлт хийх санаачлага сэтгэл зүйчээс биш харин үйлчлүүлэгчээс гарах ёстой.
- Өөрчлөлт хийхэд үргэлж гардаг тээнэгэлзэлийг сэтгэл зүйч биш харин үйлчлүүлэгч өөрөө шийдвэрлэх ёстой.
- Үйлчлүүлэгчийн тээнэгэлзэлийг таньж түүнийг шийдвэрлэхэд туслахдаа сэтгэл зүйч чиглүүлэх үүрэг гүйцэтгэнэ.

Үйлчлүүлэгчдэд өөрийн байдлыг өөрчлөх сэдлийг бий болгох талаар харилцан яриа явуулах уур амьсгал:

- Ярилцлага нээлттэй уур амьсгалд өрнөх ёстой ба үйлчлүүлэгчийг ярилцлагад идэвхитэй оролцуулах хэрэгтэй ба үйлчлүүлэгчтэй маргалдах хэрэггүй.
- Өөрчлөлт хийх хандлага үйлчлүүлэгчийн хувь хүний шинжээс биш харин харилцаа холбооноос гарах үр дүн байх ёстой.
- Эмчилгээ, жор солилцож байгаа биш харин хамтрагч, туслагч гэсэн харилцаан дээр тогтох ёстой.

Үйлчлүүлэгч өөрийн байдлыг өөрчлөх сэдлийг бий болгох талаар харилцан ярианы уур амьсгал:

- Асуудлыг мэдэх хоёр экспертын хамтын ажиллагаа шиг (ижил тэнцүү харилцааны уур амьсгалыг бүрдүүлэх)
- Үйлчлүүлэгч өөрийн асуудлыг дэлгэрэнгүй хэлж шийдэх арга замыг боловсруулна.
- Үйлчлүүлэгчийн бие даасан байдлыг хүндэтгэж түүнчлэн бусдаас хараат бус байхад нь зоригжуулах.

Тээнэгэлзээ	
Зан үйлийг өөрчлөх албадан сургалтад (ЗҮӨАС) хамрагдахгүй байх таатай тал	Зан үйлийг өөрчлөх албадан сургалтад (ЗҮӨАС) хамрагдахын давуу тал



Өөрчлөлт хийхэд шаардлагатай үе шат

- Өөрчлөлт хийх шаардлага
- Өөрчлөлт хийж чадна гэсэн итгэл

Бэлэн болох → Өөрчлөлт хийнэ

Үйлчлүүлэгч өөрийн байдлыг өөрчлөх сэдлийг бий болгох талаар харилцан ярианы үеэр тавигдах зорилго:

- Өөрчлөлт хийхийн чухлыг илүүтэй мэдрүүлэх: Эргэлзээ тээнэгэлзэлийн талаар ярилцах
- Өөрчлөлт хийж чадна гэсэн итгэлийг бэхжүүлэх: Саадыг давах
- Шийдвэр гарсан тохиолдолд өөрчлөлт хийх төлөвлөгөөг сонгох

Няцаалт гэдэг нь

- Биеэ авч явах байдлаар илэрдэг
- Хүмүүсийн харилцаанд гарч ирдэг
- Ярилцлага үр дүнгүй байгаагийн тэмдэг
- Өөрчлөлт гарахгүйн шинж
- Сэтгэл зүйч хандлагаа өөрчлөхийг сануулсан тэмдэг.

Үйлчлүүлэгч өөрийн байдлыг өөрчлөх сэдлийг бий болгох талаар харилцан ярианы зарчим

- Нээлттэй байх
- Асуудлыг олон талаас нь авч үзэх
- Няцаалтыг эрс эсэргүүцэхгүйгээр алгуур шийдэх
- Үр дүн гаргаж байна гэх мэдрэмжийг нэмэгдүүлэх

1. Нээлттэй байх

- Үйлчлүүлэгч тээнэгэлзэх нь байдаг зүйл
- Үйлчлүүлэгч ярилцахыг зөвшөөрөх нь өөрчлөлт хийхэд хялбар болгодог.
- Нээлттэй байна гэдэг нь үйлчлүүлэгчийн хэлснийг зөвшөөрөх, түүнтэй найзын харьцаа тогтоох, хамт зовох гэсэн үг биш юм....

2. Асуудлыг олон талаас нь авч үзэх

- Үйлчлүүлэгчийн одоогийн байдал, түүнд тавигдах зорилго болон түүний үнэлэмжийн хооронд орших зөрчлийг

ойлгосноор өөрчлөлт хийхэд дөхөмтэй болно.

- Өөрчлөлт хийх санаачлага үйлчлүүлэгчийн зүгээс гарах ёстой.

3.4.3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ТАЛААР СУДАЛГАА ХИЙХ

ДЭД СЭДЭВ 1. ГБХ үйлдэгчийн талаар мэдээлэл цуглуулах

Үйлчлүүлэгчийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбоотойгоор ямар мэдээлэл цуглуулах шаардлагатайг тодорхойлох нь чухал. Тулгамдаж буй асуудлын мөн чанар, түүнд үзүүлэх үйлчлүүлэгчийн хариу үйлдэл, орчны нөлөө, асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой хувь хүний чадвар, боломж, нөөц сурвалжууд зэрэг мэдээллийг цуглуулна.

Мэдээллийн эх сурвалж нь үйлчлүүлэгч өөрөө байхаас гадна түүний гэр бүл, найз нөхөд, хамт ажиллагсад, эмчлэгч эмч, сэтгэл зүйч, харуул хамгаалалтын ажилтнууд, сургуулийн багш, хорооны нийгмийн ажилтан байж болно.

Сэтгэл зүйн судалгааны олон төрлийн арга байдаг ба сургалтын ажилтан үйлчлүүлэгчээс дараах аргуудаар шаардлагатай мэдээлэл цуглуулах, судалгаа хийх боломжтой. Үүнд:

1) Сорил ашиглах

Тухайн этгээдийн зан үйлийн онцлогоос хамаарч сорилыг сонгон авч ашиглах хэрэгтэй болдог. ГБХ үйлдэгч нь хаалттай, үгүйсгэсэн зан төлөвтэй байдаг тул анкетийн арга тохиромжгүй, алдаатай гарах тохиолдол их байдаг. Сэтгэл зүйчид шинжлэх ухаанд өргөн хэрэглэж байгаа проектив сорилоор[120] судлах хандлагатай байна. Проектив сорил нь хүний сэтгэл зүйн байдал, дотоод ухамсаргүйд шахан түрэгдсэн асуудлыг судалгаанд оролцогчийн идэвх чармайлтыг төдийлөн шаардахгүйгээр илрүүлж чаддаг давуу талтай арга юм. Гэхдээ сорилыг ажиглалт болон тандалтын аргатай хослуулж хэрэглэвэл нэн тохиромжтой.

Анхны проектив шалгуур нь К.Г. Юнгийн чөлөөт дүрслэлийн арга байсан гэж олон хүн үздэг. Бүх проектив аргын үндэс болдог, туршилтын үйл ажиллагаанд "хариу" үүсгэх хүний үйлдэл ба сэтгэл хөдлөлийн ач холбогдолтой салбарт дам нөлөө үзүүлэх замаар боломжийн гоц чанарыг нээж, баталсан нь Юнгтэй холбоотой юм. Түүний бодлоор, өвөрмөцөөр сэтгэхэд хүргэдэг ач холбогдолтой байж мэдэх үгэн цочруулагчийг Юнг өөрийн үндэслэсэн шинжлэх ухааны дэг сургуулийн зарчимд тохируулан сонгон аваад, туршилтад оролцогчийн хариуг эргэх холбооны талаас нь задлан шинжилснээр барахгүй дараа нь бас хариуны хэлбэр талыг тайлбарлажээ.

2) Бодит болон хийсвэр нөхцөлд ажиглах

Бодит болон хийсвэр нөхцөлд ажиглах гэдэг нь тухайлбал, ямар нэгэн бодит болон хийсвэр тохиолдол ярихад, үзүүлэхэд үйлчлүүлэгчийн гаргаж буй биеийн хэлэмжийг унших аргыг ойлгож болно. Жишээлбэл, урьд өмнө ярьдаг байсан зүйлээ өөрчилж ярих болон жүжигчилсэн тоглолт хийн, түүний байр суурийг ажиглах гэх мэт.

3) Асуулга бөглүүлэх

Сургалтын ажилтан, асуулгыг дараах чиглэлээр боловсруулж, үйлчлүүлэгчээс авч болно. Үүнд:

- үйлчлүүлэгч болон эцэг эх, тэдний хоорондын харилцаа;
- үйлчлүүлэгчийн бусадтай харилцах харилцаа болон биеэ авч явах байдал;
- үйлчлүүлэгчийн давуу болон сул талын талаар;
- үйлчлүүлэгч гэр бүлийн гишүүн бүртэй хэрхэн яаж харилцдаг талаар;
- үйлчлүүлэгч хорт зуршил хэрэглэдэг эсэх;
- хорт зуршил хэрэглэсэн үедээ ямар зан үйл, авир гаргадаг талаар гэх мэт.

4) Холбогдох бичиг баримтуудыг уншиж, судлах

ДЭД СЭДЭВ 2. ГБХ үйлдэгчийн талаар цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх

120 Проектив буюу тусгалын сорил. Проекц-тусгал, хуулбар гэсэн латин үгийг анх 1984 онд сэтгэл зүйн зүйн нэр томьёонд оруулж ирсэн.

Энэ үе шатанд үйлчлүүлэгчид тулгамдаад байгаа асуудалтай холбоотой цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ. Ингэснээр тухайн үйлчлүүлэгчид чухам ямар үйлчилгээ тохиромжтой болох нь тодорхой болно. Өөрөөр хэлбэл, сургалтын зорилго, чиглэл тодорхойлогдсон байдаг.

Дүн шинжилгээ нь:
- шаардлагатай мэдээллийг,
- холбогдох эх сурвалжаас,
- тодорхой аргыг ашиглан цуглуулж,
- түүндээ дүн шинжилгээ, дүгнэлт хийснээр төгс утгаараа хийгдэнэ.

Дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийн жагсаалт

а) Үйлчлүүлэгчийн талаарх ерөнхий мэдээлэл
- овог, нэр, нас, төрсөн он, сар, өдөр болон хүйс;
- гэрлэлтийн байдал;
- гарал угсаа, яс үндэс;
- гэрийн хаяг;
- иргэний бичиг баримтууд, түүний дугаар;
- үйлчлүүлэгч өөрийнхөө асуудлыг тодорхойлж буй байдал;

б) Бусад мэдээлэл
- гэр бүлийн талаарх мэдээлэл;
- боловсролын талаарх мэдээлэл;
- хөдөлмөр эрхлэлт ба мэргэжлийн ур чадвар;
- шашин шүтлэг;
- эрүүл мэндийн байдал;
- сэтгэл зүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал;
- авьяас, хүсэл эрмэлзлэл;
- хувь хүний давуу тал нөөц боломжууд;
- ял шийтгэл ба гэмт хэргийн талаарх мэдээлэл;

в) Үйлчлүүлэгчийн одоогийн байдлын талаарх мэдээлэл
- дасан зохицох байдлын түвшин;
- өөртөө итгэх итгэлийн түвшин;
- хорт зуршлын хэрэглээний түвшин;
- нийгмийн эсрэг зан үйл;
- амиа хорлох зэргийн түвшин;
- стрессийг даван туулах чадвар.

Дасгал 3

Амьдралын тор

Сэтгэл зүйн судалгааны энэхүү арга нь үйлчлүүлэгчийн байдлыг энгийнээр томьёолох, гэр бүлийн хүчирхийлэгч болох үндэс суурь амьдралынх нь аль үед үүсэн бий болсон, мөн зан үйлийн өөрчлөлт хийх үйл явцад ач холбогдолтой мэдээллийг илрүүлдэг байна.

Ерөнхий дүрслэл нь төрсөн цагаасаа хойш санаж байгаа, амьдралд нь голлох үйл явдлуудыг он дараалаар нь яриулах юм. Жишээлбэл:

Он	№	Амьдарч байсан газар	Ам бүл	Биеийн байдал	Тэмдэглэл
1989	1	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ам бүл 7, ээж, аав, 3 ах, 1 эгч	Эрүүл	
1990	2	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ам бүл 7, ээж, аав, 3 ах, 1 эгч	Эрүүл	Талбайд зураг авахуулахдаа бамбаруушнаас айж зураг авахуулсан. (айдсын мэдрэмж)
1991	3	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ам бүл 7, ээж, аав, 3 ах, 1 эгч	Эрүүл	
1992	4	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ам бүл 7, ээж, аав, 3 ах, 1 эгч	Эрүүл	
1993	5	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ам бүл 7, ээж, аав, 3 ах, 1 эгч	Эрүүл	
1994	6	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ам бүл 7, ээж, аав, 3 ах, 1 эгч	Эрүүл	Бөөрөлзгөнө хулгайлж иддэг байсан. Анх удаа охин үнсэж үзсэн.
1995	7	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ам бүл 7, ээж, аав, 3 ах, 1 эгч	Эрүүл	Ангид цүнхнээс жоом гарсан. Маш их ичиж байсан. (ичгүүр)
1996	8	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Эгч Солонгос явсан	Эрүүл	Зурагтад 1 жил амьдарсан. Байр засварт орсон. (эцэг,эхийн хяналт суларч,тэнэж эхэлсэн)
1997	9	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ээж, аав, 3 ах	Эрүүл	

1998	10	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ээж, аав, 3 ах	Эрүүл	Минжинсор гэж хөөрхөн охинтой үерхэж эхэлсэн.
1999	11	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ээж, аав, 3 ах	Эрүүл	Хожимын гэгээнтнүүд сүмд явж эхэлсэн.
2000	12	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ээж, аав, 3 ах	Эрүүл	Минжинсороос салсан.
2001	13	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ээж, аав, 3 ах	Эрүүл	
2002	14	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ээж, аав, 3 ах	Эрүүл	Болороотой үерхэж эхэлсэн.
2003	15	Талбайн хажуу талын Тагнуулын 50 айл	Ээж, аав, 3 ах	Эрүүл	

Дээрх "амьдралын тор"-оос харахад эцэг эхийн хяналт суларч, тэнэж эхэлсэн нь ГБХ үйлдэгч өөрөө эмэгтэй хүнийг хайрлах орчинд өсөөгүй, гэр бүлийн нэгдмэл байдал алдарсан байдлаас болсон байх гэх мэт зүйлийг ажиглаж болно.

3.4.4. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТ

ДЭД СЭДЭВ 1. Албадан сургалтын төлөвлөгөө гаргах

Сургалтын төлөвлөгөө боловсруулахдаа тухайн үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн онцлог, зөрчлийн шинж байдалд тохируулан, түүнд байгаа нөөц боломжуудыг ашиглан, зорилгодоо хүрэх хамгийн оновчтой, үр дүнтэй арга замыг сонгох нь чухал. Мөн зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанаас хүлээж буй тодорхой үр дүнгээс гадна, өөр гарч болох бусад үр дүнг тооцоолж, төлөвлөгөөндөө тусгах хэрэгтэй.

Сургалтын ажилтан нь сургалтын төлөвлөгөөг дараах байдлаар боловсруулна:

- Сургалтын сэдэв, агуулгыг тодорхой гаргах;
- Зорилгодоо хүрэх арга замуудыг тодорхойлох;
- Хэн, юу хийхийг тодорхой болгох;
- Тэдгээр зүйлийг ямар хугацаанд хийж гүйцэтгэхийг тодорхойлох;
- Шаардлагатай нөөц, эх сурвалжуудыг тодорхойлох;
- Үйлчилгээг хэзээ дуусгавар болгохыг тодорхойлох;

Сургалтын төлөвлөгөө нь үйлчлүүлэгчид үр дүнтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тодорхой үүрэг хариуцлага хүлээлгэх, түүндээ эзэн болоход тустай байх болно.

Сургалтын ажилтан үйлчлүүлэгчид тохирох интервенцийг[121] сонгож, хэрэгжүүлэх хэрэгтэй. Энэ үйл ажиллагаа нь сургалтын зорилгоос хамааран янз бүр байна. Тухайлбал, үйлчлүүлэгчийн зан үйлийг өөрчлөх буюу сөрөг зан үйлийг бууруулах, эсвэл өөрийнх нь эерэг зан үйлийг улам батжуулж, хөгжүүлэх, шинэ зан үйлийг хэвшүүлэх, уур бухимдлаа зохицуулж сурах сургалтад хамруулах, асуудлыг даван туулах чадварт сургах гэх мэт үйл ажиллагаа байж болно.

ДЭД СЭДЭВ 2. ГБХ үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь дараах 2 төрөлд хуваагдаж байна. Үүнд:

1. ГБХ-ийн гэмт хэрэг үйлдээд хорих ял эдэлж байгаа хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан урт хугацааны /илүү сэтгэл засал, нийгэмшүүлэхэд чиглэгдсэн/

2. ГБХ үйлдэх зөрчлийн улмаас баривчлах шийтгэл авсан хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан богино хугацааны /зан үйлээ өөрчлөх сэдэл төрүүлэхэд чиглэгдсэн/ гэсэн 2 төрлөөр албадан сургалтын зорилго, зарчим, үйл явцыг ойлгож болно.

Сэдэлжүүлэх ярилцлагыг дээд хэсэгт үзсэн тул одоо урт хугацааны сэтгэл зүй, нийгэмшүүлэхэд чиглэсэн албадан сургалтын төрлүүдтэй танилцъя.

1) Сэтгэл зүйн сургалт:

- Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн

121 Интервенц гэдэг нь аливаа үйлчилгээний хүрээнд тавьсан зорилгоо биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

зохицуулах;
- Уур бухимдлаа хэрхэн зохицуулах, стрессийг даван туулах;
- Харилцах ур чадвараа дээшлүүлэх;
- Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх;
- Архинд донтолт болон түүний хор уршиг;
- Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх;
- Хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүйн асуудал, сөрөг үр дагавар;
- Гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх.

2) Дотоод хүчийг бэхжүүлдэг уламжлалт дасгалууд:

- Йог
- Бясалгал

3) Хууль, эрх зүйн сургалт: Сургалтыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно:

- Ганцаарчилсан;
- Бүлгийн;
- Хосолмол байдлаар;

Сургалтыг ганцаарчилсан болон бүлгийн, эсхүл хослуулан хэрэглэх тохиолдол цөөнгүй байдаг. Жишээ нь, үйлчлүүлэгч ганцаарчилсан зөвлөгөө авахын зэрэгцээ бүлгийн сургалтад давхар хамрагдах шаардлага цөөнгүй тулгардаг. Энэ нь бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулж буй сургалтын хосолмол хэлбэр юм.

Дээрх сургалтууд нь нийгэм, сэтгэл зүйн гэсэн хоёр том шинжлэх ухаан байдаг ба энэхүү гарын авлагад бүгдийг нь оруулах боломжгүй юм. Иймд практик туршлагад өргөн хэрэглэгддэг, ГБХ үйлдэгчид маш өндөр үр нөлөө үзүүлж байгаа хэдэн аргын талаар авч үзье.

1) Хөгжмийн засал

Сэтгэл заслын орчин нөхцөлд хөгжим ашиглан сэтгэл засал хийх арга. Хөгжим нь хүний бие организмд эмчилгээний нөлөө үзүүлдэг бөгөөд XYII зуунд хөгжмийн засалд шинжлэх ухааны тайлбар хийх анхны оролдлого хийгдсэн бол, XIX зуунд туршилтын судалгаа хийгдсэн байна. Хөгжмийн заслын нөлөөллийг 4 чиглэлд хуваах үздэг. Үүнд:

- Сэтгэл заслын явц дахь сэтгэл хөдлөлийг идэвхжүүлэх;
- Бие хүмүүсийн хоорондын харилцааны (харилцааны үүрэг ба хэрэгцээ) дадлыг хөгжүүлэх;
- Психовегетатив (сэтгэц, оюун ухаанаас үл шалтгаалах дотоод эрхтэний мэдрэлжүүлэлт) үйл явцын нөлөөллийг зохицуулах;
- Гоо зүйн хэрэгцээг дээшлүүлэх;

Хөгжмийн засал нь идэвхтэй ба жорын гэсэн 2 үндсэн хэлбэртэй. Идэвхтэй хөгжмийн засал гэдэг нь хөгжмийн зэмсэг тоглож сурах буюу эзэмших, хөгжим зохиох, уран сэтгэмжлэх, бүтээх зэрэг хөгжмийн идэвхтэй үйл ажиллагаанд орох заслын чиглэл юм.

Жорын гэдэг нь зорилготойгоор хөгжмийг ухамсарлан ойлгох үйл явц юм. Энэ нь 3 хэлбэртэй:

- харилцааны (итгэлцэл, харилцан ойлголцол бий болгож, хамтдаа хөгжим сонсох хэлбэр);
- хариу үйлдлийн (катарсист хүрэхэд чиглэсэн хэлбэр, өөрөөр хэлбэл, сэтгэл хөдлөлийн тэнцвэрт байдалд оруулах);
- зохицуулалтын (сэтгэл санааны хямралтай байдлыг багасгах хэлбэр);

а) Үйлчлүүлэгчийг биедээ эвтэйхэн байдлаар тайван суухыг хүснэ. (нүдээ хөнгөн аньж, 2 гараа өвдөг дээрээ дээш харуулсан байрлалтай суулгах)

б) Бэлдэх байдал: Гүнзгий амьсгал аван, гаргах (3 секунд авах, 3 секунд түгжих, 3 секунд гаргах) 2 удаа хийх.Энэ үед үйлчлүүлэгчийн бие нь аливааг шинээр хүлээж авахад бэлэн болсон байна. Сургалтын ажилтны хэлсэн үгийг дотроо бодохыг зөвлөнө. Эхийг болгоомжтой сонгох ёстой.

в) Хэлэх үгийг сургалтын ажилтан өөрийн мэдрэмжээр сонгоно. Жишээлбэл, та маш сайхан уулан дээр сууж байна. Энэ ууланд дүүрэн шар цэцэг, маш их мод харагдаж байна, уулын доогуур гол урсаж байна, нар таатай ээж байна, надад маш сайхан байна, би хайр энэрэлээр дүүрэн байна. Би бусдыг маш их хайрладаг, бусад хүмүүс намайг маш их хайрладаг гэх мэт.

г) Сайн төвлөрсний дараа хөгжмийг сонгож тавина, эмзэг сэдвээр шууд хөгжим сонсгож болохгүй. Тухайлбал,

эхнэр нь салаад удаагүй байхад ханийн тухай дуу, нас барсан хүнтэй холбоотой дууг сонсговол та үйлчлүүлэгчийнхээ итгэлийг алдах болно. Эхний 2 уулзалтад нийтлэг "Орчлонг хайрлаарай", "Эр хүн" гэх мэт дууг сонговол тохиромжтой. Мөн үйлчлүүлэгчийн хүйснээс хамаарч дууг сонгох хэрэгтэй.

Бүлгийн хөгжмийн засал

Практикт жорын заслыг ихээхэн хэрэглэдэг. Бүлэг дэх үйлчлүүлэгчид хөгжмийн бүтээлийг сонсох явцдаа уран сэтгэмж, харилцаа холбоо, өөрийн бэрхшээлтэй хүнд асуудал, үзэл бодол зэрэгтээ задлан шинжилгээ хийдэг. Нэг удаагийн хичээлийн үед хөгжмийн гурван бүтээлийг сонсох нь тохиромжтой байдаг. Хөгжмийн бүтээлийг бүлгийн гишүүдийн сэтгэл хөдлөлийн ачаалал, сэтгэл санааны өөрчлөлт, хөдөлгөөн, хурд зэргийн ялгаатай байдлыг харгалзан сонгодог.

Эхний бүтээл нь хөгжмийн бүх хичээлийн ач холбогдлыг мэдрүүлэх, үйлчлүүлэгч сэтгэл санаагаа илэрхийлэх, харилцааг бий болгох, цаашид сонсох бэлтгэлийг хангах зэрэг нөхцөлийг бүрдүүлэхүйц байх ёстой.

Хоёрдугаар бүтээл нь шилжилт, дүрийн тоглолт гэх мэтийг агуулсан, хамгийн их ачаалалтай бүтээл байна. Энэхүү бүтээлийн үүрэг нь үйлчлүүлэгч өөрийн амьдралаас харилцаа холбоо, бодол санаа, төсөөллөө олж харахад тусалж, сэтгэл хөдлөлөө эрчимжүүлэх сэдлийг бий болгоход оршино.

2) Номын засал

Номын засал гэдэг нь хүнд ном уншуулах замаар эмчилгээний нөлөө үзүүлэх арга юм. Номын засал нь сэтгэл заслын төрөлд багтдаг бөгөөд сэтгэл судлал, сэтгэц заслын өвөрмөц арга техниктэй хослуулах нарийн төвөгтэй арга гэж В.Н.Мясищев тодорхойлсон. Эмчилгээний зорилгоор 1836 онд И.Е.Дядьковский энэ аргыг анх хэрэглэсэн. АНУ-ын Эмнэлэгийн номын сангийн нийгэмлэгээс "Номын засал гэдэг нь эмнэлэг болон сэтгэц заслын хүрээнд үйлчлүүлэгчийн хувийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор уншуулах материалыг мэргэжлийн түвшинд сонгож ашиглах явдал юм" гэж тодорхойлсон.

Номыг сонгохдоо хүний амьдралын зорилго, өөрийгөө танин мэдэх, хөгжүүлэх, зөв амьдралын хэвшилд суралцах, ёс суртахуун, бодол сэтгэлийн боловсрол эзэмших чиглэлийн сэдэвтэй байвал үр дүнтэй байх бөгөөд тухайн хүний унших чадварыг анхаарах ёстой. Тухайлбал,

- Богино хэмжээний, сонирхолтой, сургамжит өгүүллэг байж болно.
- Номын агуулга нь номын баатар шиг болоход чадал хүрэх мэт сэтгэгдэл төрүүлэхүйц байхад анхаарна.
- Тухайн үйлчлүүлэгчийн эмзэг сэдвийг хөндөхгүй боловч амьдралын бодит нөхцөл байдалтай төстэй агуулга бүхий ном сонгоход анхаарна.

Номын засал нь эрэгтэй ГБХ үйлдэгчид нэн тохиромжтой заслын хэлбэр юм. Учир нь эрэгтэй хүн сайн уншдаг, хүнтэй харилцах, ярилцах дургүй онцлогтой холбоотой. Иймд номыг мэргэжлийн түвшинд, дэс дараалалтайгаар сонгож уншуулах нь хурдан хугацаанд зан үйлд нь өөрчлөлт оруулах магадлал өндөр байдаг.

Бүлгийн номын засал

Бүлгийн номын засалд унших чадвар болон уншигчийн сонирхлыг харгалзан гишүүдийг сонгон авахыг шаарддаг. Бүлгийн номын заслыг 5-8 үйлчлүүлэгчтэй гүйцэтгэх нь тохиромжтой. Бүлгийн хичээлийн үед номыг бүхэлд нь уншаад хэлэлцүүлэг эхэлдэг. Хэлэлцүүлгийн үр дүнд бүлэг дэх хүмүүсийн харилцааны бүтэц тодорхой болдог. Хэлэлцүүлгийн үеийн ярианд бичлэг хийж, сэтгэл засалч задлан шинжилгээ хийдэг.

3) Байгалийн засал

Байгаль бол эмчилгээний нөлөө үзүүлдэг, сэтгэл заслын бие даасан арга гэдгийг зүй ёсоор хүлээн зөвшөөрдөг. Ихэнх эрдэмтэд байгаль хүний сэтгэл санааны байдалд эерэгээр нөлөөлдөг гэдгийг үгүйсгэдэггүй бөгөөд сэтгэл заслын орчин болдог гэж үздэг. Сэтгэл засалч үйлчлүүлэгчийн сэтгэц болон сэтгэл зүйн байдалд дан ганц үгээр нөлөөлөөд үр дүн нь төдийлөн гарахгүй тул өөр бусад аргуудыг хэрэглэдэг. Үүнд хөгжим, ном, байгаль, хөдөлмөр гэх мэт багтдаг.

4) Ярианы засал

Боммерт "ярианы засал нь тодорхой тооны хүмүүс болон сэтгэл засалч үйлчлүүлэгч хоёрын хоорондын нийгмийн харилцаа, аман ба аман бус харилцааны төлөвлөсөн,

системчилсэн сонгон сайжруулсан хэлбэр юм" гэж тодорхойлсон. Зорилго нь хүнд нөхцөлд байгаа үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн зөрчилдөөнийг багасгах, өөрийн өвөрмөц "Би"-гийн дүр төрхийг тодорхойлох, шинэ хандлагыг бий болгоход туслах явдал юм.

Дээрх сэтгэц заслын аргууд нь хүнийг хамгийн хурдан хугацаанд харилцааны эерэг, шинэ дадал чадвартай болгодог. Хуучин зан үйлийг сэдрээх зүйлсийг оновчтой тодорхойлж, тэдгээрийг хяналтандаа байлгахын сацуу эрсдэл багатай эерэг дадал чадваруудад суралцсанаар өөрчлөлтийг амжилттай хийх үндэс бүрдэнэ. Бэлтгэл үе шатнаас эхлээд үйлдэл хийх, хэвших үе шатны аль алинд нь хүчирхийлэх зан үйлийг дахин сэдрээхээс сэргийлж, орлох шинэ дадал, чадваруудыг эзэмшихэд нь үйлчлүүлэгчдэд дэмжлэг үзүүлэхэд зан үйлд нөлөөлөх сургалтын нэн чухал зорилт оршино. Үүнийг зан үйлийг өөрчлөх хосолмол онолын загварт (орлох зүйлийг сонгох) үйл явц гэж тодорхойлдог.

5) Бясалгал

Бясалгал нь өөрийгөө удирдан жолоодож тайвшруулах, амьдралын эерэг хандлага, зөв дадал, сэтгэлгээ, чадвар суулгахад оршино. Бясалгалыг зөвхөн мэргэжлийн багш хөтлөн явуулах шаардлагатай. Зан үйл, хандлагыг өөрчлөх зорилгоор бясалгалыг сэтгэл заслын сургалттай хосолж явуулах нь өндөр үр дүнтэй.

Бясалгалыг зөвхөн тайвшруулах төвлөрүүлэх, бодол хоослох зорилгоор буюу сэтгэл заслын аргаар ашиглах, шашны зориулалтаар ашиглахгүй байхыг анхааараарай

3.4.5. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН ЗАН ҮЙЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын явцад мониторингийг хэд хэдэн удаа хийж болох бөгөөд энэ нь сургалтыг өөрчлөх шаардлагатай эсэхийг тодорхойлох ба эцсийн үнэлгээ нь сургалтын үр дүнг тооцохоос гадна, дараагийн удаа ижил төстэй асуудалтай өөр үйлчлүүлэгчид тус сургалтыг явуулахад юуг анхаарах, цаашид хэрхэн сайжруулах зэргийг тодорхойлох ач холбогдолтой. Ихэнх тохиолдолд сургалтын ерөнхий хугацаанаас хамааран, сургалтыг тогтвортой явуулж эхэлснээс хойш 1-2 долоо хоногийн дараа эхний мониторинг хийх боломжтой.

Мониторинг хийхэд хэрэглэдэг ерөнхий аргуудын зэрэгцээ явуулж буй сургалттай уялдуулан өөрмөц аргуудыг ашиглаж болно. Тухайлбал, үйлчлүүлэгчийн харилцааны ур чадварыг сайжруулах интервенцийг хэрэгжүүлсэн бол тухайн үйлчлүүлэгч бусадтай хэрхэн харилцаж байгааг бодит нөхцөлд ажиглаж, тэмдэглэл хөтлөх, харилцааны ур чадвараа хэрхэн ашиглаж, тэмдэглэл хөтлөх, харилцааны ур чадвараа хэрхэн ашиглаж, дадал хэвшил болгож байгаа талаар асуулга бөглүүлж, өөрийн үнэлгээ хийлгэх гэх мэт аргыг хэрэглэж болно. Мөн үйлчилгээг үнэлэхэд тоон болон чанарын объектив, субъектив аргууд, стандартчилагдсан сорил, өөрийн үнэлгээ, эргэцүүлэл гэх мэт олон төрлийн аргыг ашиглаж болно. Тухайлбал, анхны уулзалт, зөвлөгөөн дээр хэрэглэж байсан зан үйлийн өөрчлөлтийн үе шатыг тодорхойлох асуулт болон харилцааны чадвар тодорхойлох бусад сорилыг ашиглан үнэлгээ хийх, сургалтын үр дүнгийн талаар ярилцаж, санаа бодлоо солилцож болно.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт дуусаны дараа сургалтын үр дүнг тодорхойлно. Албадан сургалтыг төгсгөх талаар эртнээс бэлтгэлтэй байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, сургалт дуусахад хэр хугацаа үлдэж байгааг сургалтын явцад үйлчлүүлэгчид сануулж байх нь зүйтэй.

Албадан сургалтыг төгсгөхдөө сургалтын үр дүн, үйлчлүүлэгчид гарсан ахиц дэвшлийн талаар үйлчлүүлэгчтэйгээ ярилцахын зэрэгцээ талархлын үг хэлэх, дурсгалын зүйл өгөх зэрэг арга хэмжээг явуулж болно. Тухайлбал, хичээл зүтгэл, цаг, заваа зориулан эрсдэлт зан үйлээ өөрчлөхийн тулд сургалтад хамрагдсанд нь хүн бүрт талархал илэрхийлнэ. Түүнчлэн өөртөө төдийгүй, гэр бүл, найз нөхдөдөө тустай сайн шийдвэр гаргасан явдал нь эерэг зан үйлийг хэвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байсныг дурдана.

Хамгийн чухал нь хэвшүүлж дадсан, хийж бүтээсэн бүхнээ өдөр тутмынхаа амьдралд тогтмол хэрэгжүүлж байх нь эрүүл саруул, сэтгэл хангалуун, аз жаргалтай ажиллаж, амьдарч, бусдын хайр хүндлэлээр дүүрэн явахад тань чухал түлхэц болно гэдгийг зөвлөнө.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Гэр Бүлийн тухай хууль, 1999
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2005, 2017
4. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 2014
5. Хувь хүний нууцын тухай хууль, 1995
6. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016
7. Хүүхэд хамгаалах тухай хууль 2016
8. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1990
9. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2016
11. Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга), 2015
12. Эрүүгийн хуулийн тайлбар, Улсын дээд шүүх, 2010
13. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, 1981
14. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх, насанд хүрээгүй гэрч, хохирогчтой харилцах НҮБ-ын стандарт, 2015
15. УДШ-ийн 2007 оны "Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зөвлөмж"
16. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн Нэг Цэгийн үйлчилгээний түр удирдамж (ХНХ, ХЗДХ-ийн сайдын 2009 оны 188/128 хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт)
17. ГБХ-ийн зэргийн нөхцөл байдлыг тодорхойлох үнэлгээний маягт (ХНХ, ХЗДХ-ийн сайдын 2009 оны 188/128 хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт)
18. Нөхцөл байдлын үнэлгээг хэрхэн хийх, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох үнэлгээг хийх заавар (ХНХ, ХЗДХ-ийн сайдын 2009 оны 188/128 хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт)
19. Сэтгэл зүйч, нийгмийн ажилтны ажлын заавар (ШШГЕГ-ын даргын 2010 оны А/69 дүгээр тушаал)
20. УЕП-ын 2015оны А/88 дугаар тушаалаар батлагдсан "Прокурорын хяналтын ажил болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд эрүүгийн байцаан шийтгэх хуулийг дагаж мөрдөх аргачилсан заавар"
21. ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/25 дугаар тушаалаар батлагдсан "Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам"
22. Мөн тушаалаар батлагдсан "Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл слилцох журөм"
23. ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/29 дүгээр тушаалаар батлагдсан " Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам"
24. ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан "Аюулын зэргийн үнэлгээ хийх журам"
25. УЕП, ХЗДХ-ийн сайдын хамтарсан 2017 оны А/22, А/31 дүгээр тушаалаар батлагдсан "ГБХ-ийн хохирогчийн аюулын байдлыг хангах журам"
26. ХЗДХ-ийн сайдын 2017 оны А/38 дугаар тушааалаар батлагдсан "Нэг Цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам"
27. ХЗДХ-ийн сайдын 2017 оын А/39 дүгээр тушаалаар батлагдсан "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам"

Судалгаа

1. "Гэр бүрийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар цагдаагийн байгууллагаас хүлээсэн үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд хийсэн үр дүн шинжилгээний тайлбар" ЦЕГ, УБ, 2015
2. "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль", Монгол улс. Хүний эрхийн тайлан., АНУ, Миннесота., Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, УБ, 2014
3. Монгол Улсын Үндэсний Статистикийн хорооноос НҮБ-ийн Хүн амын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр үндэсний хэмжээнд хийсэн "нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа", 2009
4. "Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн мониторингийн тайлан" Хүчирхийллийн Эсрэг Үндсэний Төв, УБ, 2008
5. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа, 2007
6. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтйин талаарх МУЗГ-ын ээлжит 8, 9 дүгээр илтгэл
7. Strangulation Laws. Compiled by the National Center for Prosecution of Child Abuse (July, 2009)

Ном, гарын авлага

1. С.Баасанбат, Л.Бадамцэцэг "Ураг төрлийн хүчин" (хохирогч, ээж нарт зориулсан зөвлөмж)
2. С.Баасанбат, С.Хишигтогтох "Онцгой, эрсдэлтэй нөхцөлд хүүхдэд үзүүлэх нийгэм сэтгэл зүйн дэмжлэг" УБ, 2012
3. А.Батхишиг "Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь", УБ, 2010
4. А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг "Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь", УБ, 2011
5. Д.Баярсайхан "Ялын бодлого ба сэтгэлгээний шинэтгэл: Эрүүгийн эрх зүйн үзэл баримтлалын тухайд", Шүүх эрх мэдэл, УБ, 2015, °3
6. С.Бямбасүрэн "Сэтгэцийн эрүүл мэнд"
7. А.Гэрэл "Өөртөө болон бусдад тусла", Дэлхийн Зөн Монгол ОУБ, УБ хот, 2014
8. Ц.Мандах "Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдолтой хэргийг хянан шийвдэрлэхэд хохирогчийг анхаарах нь", Шүүх эрх мэдэл, УБ, 2014, °3
9. М.Мөнхсаруул " Танд сонголт би...", Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, УБ хот, 2013
10. С.Нарангэрэл "Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс", УБ, 1988
11. Г.Оюунболд "Олон улсын эрүүгийн эрх зүйн зарчим Гэмт хэргийн тутай хуулийн төсөлд", Шүүх эрх мэдэл, УБ, 2014, °3
12. Г.Оюунболд "Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай", Хууль дээдлэх ёс, УБ, 2016 °1
13. Т.Оюунчимэг "Мөрдөн байцаалтын үзлэгийн тактик" лекцүүд, УБ, 2006
14. Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь" УБ, 1966
15. Д.Энхжаргал, Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх, амьдрах ухааны чадвар чиглүүлэгчийн багц гарын авлага, УБ, 2016
16. Д.Энхжаргал Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх хөтөлбөр, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, УБ, 2016
17. Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбүлган Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал. УБ, 204
18. Ж.Эрдэнэбулган "Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зарчмын агуулга ерөнхий ба тусгай ангид бүрэн тусгагдсан уу?", хууль дээдлэх ёс, УБ, 2016 °1
19. Г.Эрдэнэбат "Эрүүгийн эрх зүй дэх хууль ёсны зарчим-гэмт хэргийн бүрэлдэхүүний онол-хууль зүйн техник", Хууль дээдлэх ёс, УБ, 2015 °4
20. Д.Эрдэнэчулуун "Сэтгэл зүйн зөвөлгөөний арга техник", 2010
21. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд шүүгчдийн оролцоо (Шүүгчдэд зориулсан гарын авлага), 2010

22. Монгол Улсын шүүхийн тайлан 2014, 2015
23. "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам", Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Нээлттэй нийгэм форум, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс хамтран гаргасан гарын авлага, 2003
24. IDLO ОУБ, ГБХ-тэй тэмцэх чиглэлээр шүүх болон хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудын чадаввхийг бэхжүүлжх сургалтын хөтөлбөр – туршлаг, загвар, УБ хот, 2016
25. "Focus on the family" ОУБ "Мэргэшсэн сэтгэл зүйчдийн семинар" УБ хот, 2015
26. Гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхэдтэй холбоотой асуудлаарх шүүн таслах ажиллагаа. (Загвар хууль, холбогдох тайлбар) НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC), НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF), 2009
27. Гэмт хэрэг илрүүлэхүй, сурах бичиг, ХСИС, хамтын бүтээл, УБ, 2015
28. ЦЕГ "Цагдаагийн мэргэжилийн сургалт, 2 дугаар дэвтэр", УБ 2003
29. "Вьетнам улсын хууль хэрэгжүүлэх, шүүх байгууллагын чадварыг нэмэгдүүлснээр ГБХ-ийн эсрэг авах арга хэмжээ, урьдчилан сэргийлэх үр дүнг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд гаргасан сургагч багшийн гарын авлага, 2010
30. ОХУ-ын эмэгтэйчүүдийн хүчирхийлэл: Мэргэжилтэнд зориулсан сургалтын хөтөлбөр, 2010
31. Хорих байгууллага дахь нийгмийн ажил, 2015 он (Гэр бүлийн генограмм зурах аргачлал)
32. Хүний эрхийн үндэсний комисс "Танд сонголт бий", 2013
33. Aequitas Prosecutors Resource, Witness Intimidation as of Mar 2014
34. Kelly Tait, Kathleen SikorA. "Communication tools for cases involving self-represented litigants" training manual, 2006
35. Ч.Нямсүрэн "Гэмт хэргийн виктимологи (хохирогч судлал)", УБ, 2005

Цахим эх сурвалж

1. https://www.who.int/health-topics/gender
2. https://mongoliA.unfpA.org/en/publications/breaking-silence-equality-2017-national-study-gender-based-violence-mongolia
3. /https://www.nairobisummiticpC.org/commitments
4. http://mn-nhrB.gov.mn/hrd/ViennaDeclarationProgrammeActionBrochure.pdf
5. http://1212.mn/BookLibraryDownloaC.ashx?url=GBHuchirhiilel_2020q1.pdf&ln=Mn
6. https://doi.org/10.2105/ajph.93.7.1089
7. http://wost201h_domviol.tripoC.com/groupactionproject/id4.html
8. https://ce4less.com/Tests/Materials/E098BMaterials.pdf
9. https://www.facebook.com/205899389429585/photos/pcБ.1816848748334633/1816847141668127/?type=3&theater
10. https://www.facebook.com/205899389429585/photos/pcБ.1816848748334633/1816847141668127/?type=3&theater
11. http://1212.mn/BookLibraryDownloaC.ashx?url=Crime_2018.pdf&ln=Mn,
12. http://www.hotpeachpages.net/camerica/belize/DomesticViolenceTrainingManual.pdf
13. https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2016/04/Women_who_kill_in_response_to_domestic_violence_Full_report.pdf,
14. http://www.legalinfo.mn/law/details/1285?-lawid=1285
15. http://criminology.mn/print.php?id=143&-lang=1
16. https://www.legalinfo.mn/law/details/59
17. http://www6stopvaw.org/uploads/dv_law_monitoring_report_-_mongolian_version.pdf
18. http://www.judcouncil.mn/main/1242--.html

ХАВСРАЛТ

- Шинээр батлагдсан журмууд

1. АЗУХ-ийн журам
2. "Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
3. Сургалт зохион байгуулах журам
4. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам

- Гарын авлагын эхний хэвлэл дээр ажилласан сургагч багш нар

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 18 өдөр Дугаар А/83 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.“Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”-ыг 1 дүгээр, “Аюулын зэргийн үнэлгээ хийсэн тэмдэглэлийн загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /бригадын генерал С.Баатаржав/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Э.Энхтуяа/-д тус тус даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Ц.НЯМДОРЖ

1119287523 ШТТ6740 9131817

Doc\tushaal Said. 2020 он

151600301

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн
A/183 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

1119287523 ШТТ6740 9131817

АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учирсан аюулын зэргийг тогтоох, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Аюулын зэргийн үнэлгээ хийхэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг баримтална.

1.3.Аюулын зэргийн үнэлгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт заасан орчин, газарт хийнэ.

1.4.Аюулын зэргийн үнэлгээ нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг шуурхай авах болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу хохирогч, гэр бүлийн бусад гишүүдэд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэхэд харгалзах нөхцөл болно.

1.5.Аюулын зэргийн үнэлгээг нотлох баримтаар тооцох, үнэлэх эсэхийг эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

1.6.“Хүүхэд” гэж арван найман насанд хүрээгүй хүнийг ойлгоно.

1.7.“Хамаарал бүхий этгээд” гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд заасныг ойлгоно.

1.8.“Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” /цаашид “хохирогч” гэх/ гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.2-д заасныг ойлгоно.

Хоёр.Аюулын зэргийн үнэлгээ хийх, авах арга хэмжээ

2.1.Цагдаагийн алба хаагч нь гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, гомдол, мэдээллийн тохиолдол бүрт аюулын зэргийн үнэлгээг хийнэ.

2.2.Аюулын зэргийн үнэлгээг хийхдээ хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол, учирч болзошгүй эрсдэл, хүчирхийлэл үйлдэгчийн хувийн байдал болон орчны эрсдэлийн хүчин зүйлсийг харгалзана.

2.3.Аюулын эрсдэлийг “Бага”, “Дунд”, “Өндөр” гэсэн ангиллаар үнэлнэ.

2.4.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн дараах үйлдэл нь аюулын эрсдэлийн “Бага” зэрэгт хамаарна:

2.4.1.хохирогч, хамаарал бүхий этгээдтэй үл ойлголцож маргалдсан;

2.4.2.эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тодорхой үйлдэл хийхийг хязгаарлах арга хэмжээ авсаны дараа хохирогчийн зөвшөөрөлгүй уулзах, харилцаа тогтоохыг оролдсон;

2.4.3.хохирогчид сэтгэл санааны дарамт, шаналал учруулсан;

2.4.4.хохирогчийг эдийн засгийн хараат байдалд оруулсан үйлдэл нь хэвшмэл, байнга үйлдэгдээгүй;

2.4.5.хохирогч, хамаарал бүхий этгээдийн бие махбод, эрүүл мэндэд хохирол учруулаагүй.

2.5.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн дараах үйлдэл нь аюулын эрсдэлийн "Дунд" зэрэгт хамаарна:

2.5.1.хохирогч, хамаарал бүхий этгээдийг гүтгэсэн, заналхийлсэн;

2.5.2.хохирогчийг гутаан доромжилсон;

2.5.3.хохирогчийг айлган сүрдүүлсэн, дарамталсан;

2.5.4.эдийн засгийн хүчирхийлэл нь хэвшмэл, байнга үйлдэгдээгүй;

2.5.5.хохирогчид сэтгэл санааны хохирол учруулсан;

2.5.6.хохирогч, хамаарал бүхий этгээдийн бие махбод, эрүүл мэндэд бага хэмжээний хохирол учруулсан.

2.6.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн дараах үйлдэл нь аюулын эрсдэлийн "Өндөр" зэрэгт хамаарна:

2.6.1.хохирогч, хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд бодитой заналхийлсэн;

2.6.2.хүчирхийлэл хэвшмэл, байнга үйлдэгдсэн;

2.6.3.хохирогч нь хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, жирэмсэн зэрэг шалтгаанаар өөрийгөө хамгаалах чадвар нь хязгаарлагдмал.

2.7.Аюулын зэргийн үнэлгээг учирч болох эрсдэлийг таслан зогсоож, аюулгүй байдлыг хангаж, хүчирхийлэл үйлдэгчийг хохирогч, хамаарал бүхий этгээдээс тусгаарласны дараа хийнэ.

2.8.Дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж буй цагдаагийн алба хаагч нь аюулын зэргийн үнэлгээг хүчирхийлэл үйлдэгдсэн орчинд хийнэ.

2.9."Орчин" гэдэгт гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн болон үйлдэгдсэн байж болзошгүй газар, орон байр, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хохирогчоос мэдүүлэг авч байгаа газрыг ойлгоно.

2.10.Аюулын зэргийн үнэлгээг хохирогчтой харилцан ярилцах хэлбэрээр хийх ба хохирогчийг буруутгах, нэг талыг баримтлах, тулгах, хөтлөх байдлаар асуулт тавихыг хориглоно.

2.11.Цагдаагийн алба хаагч нь хүүхэдтэй ярилцахдаа айдас, түгшүүр төрүүлэхээс зайлсхийсэн нөхцөлийг бүрдүүлэх ба хүүхдийг буруутгах, загнах, тулгах, хөтлөх байдлаар асуулт тавихгүй.

2.12.Цагдаагийн алба хаагч нь үнэлгээ хийхдээ хүчирхийлэгчтэй холбоотой гомдол, мэдээлэл, дуудлага цагдаагийн мэдээллийн санд бүртгэгдсэн эсэх, тэрбээр цагдаагийн байгууллага, алба хаагчийн хяналтад авагдаж байсан эсэх зэрэг түүний хувийн байдал болон орчны эрсдэлийн хүчин зүйлсийн талаар гэр бүлийн гишүүд, гэрчээс асууж болно.

2.13.Хохирогч, түүний хамаарал бүхий этгээдийн оршин болон амьдарч буй газар нь төвөөс алслагдмал, дэд бүтэц хөгжөөгүй, нийтийн тээврийн үйлчилгээ байхгүй, харилцаа холбоо барих, бусдаас тусламж хүсэх боломжгүй, түр хамгаалалтад авах төрөл садан, ойр дотны хүн байхгүй, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзах, худал мэдүүлэг өгөх нөхцөл үүссэн, түүнчлэн хохирогч нь хүүхэд эсхүл хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах боломж хязгаарлагдмал зэрэг нөхцөл байдлыг “Орчны эрсдэлийн хүчин зүйлс” гэнэ.

2.14.Гэр бүлийн хүчирхийллийн гомдол, мэдээлэл, дуудлагын дагуу ажилласан цагдаагийн алба хаагч аюулын зэргийн үнэлгээг холбогдох материалын хамт эрх бүхий албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр хүлээлгэж өгнө.

2.15.Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан энэ журмын 2.14-т заасны дагуу аюулын зэргийн үнэлгээг хүлээн авч Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээг даруй авна.

2.16.Аюулын эрсдэл “Бага”, “Дунд”, “Өндөр” гэсэн үнэлгээтэй гарсан бол хохирогчийн саналыг харгалзан нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, эсхүл төрөл садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгнө.

2.17.Хүүхдэд учирсан эрсдэл “Дунд”, “Өндөр” гэсэн үнэлгээтэй гарсан, эсхүл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.4-т заасан нөхцөл байдал тогтоогдвол эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүйгээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30.1 дэх хэсэгт заасан арга хэмжээг авна.

2.18.Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гарцаагүй эрсдэл үүсвэл нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, эсхүл төрөл садан, ойр дотных нь хүний түр хамгаалалтад өгөх арга хэмжээг авч, хамтарсан баг болон сум, баг, хорооны нийгмийн ажилтанд даруй мэдэгдэнэ.

Гурав. Аюулын зэргийн үнэлгээний тэмдэглэл

3.1.Аюулын зэргийн үнэлгээг хийхдээ тэмдэглэл /цаашид “тэмдэглэл” гэх/ хөтөлнө.

3.2.Тэмдэглэл нь гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг тодорхойлох асуултаас бүрдэх ба цагдаагийн алба хаагч тэмдэглэлийг зөвхөн өөрөө хөтөлнө.

3.3.Аюулын зэргийн үнэлгээг хийхдээ тэмдэглэлийн 11 асуулт тус бүрд “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн баганад оноо тавих ба “Тийм” гэсэн хариултад “1” оноо, “Үгүй” гэсэн хариултад “0” оноо тавина.

3.4.Энэ журмын 3.1-3.3-т заасан ажиллагааг хийж дууссаны дараа “Тийм” гэсэн хариултын нийлбэр 0-3 оноог “Бага”, 4-7 оноог “Дунд”, 8-11 оноог “Өндөр” гэж үнэлэх ба нийлбэр оноо гэсэн хэсэгт нийт тэмдэглэлийн оноог бичиж, тохирох үнэлгээг зурж баталгаажуулна.

3.5.Хүчирхийллийн аюулын эрсдэлийн зэргийг тодруулах асуултын 1, 2, 3 дугаарын аль нэгэнд “Тийм” гэж хариулсан бол аюулын зэрэг шууд “Өндөр” гэж үнэлэгдэх ба бусад асуултыг асуухгүй.

3.6.Аюулын зэргийн үнэлгээнд энэ журмын 2.2, 2.4, 2.5, 2.6-д заасан хүчин зүйлс, хүчирхийлэл үйлдэгчийн үйлдлийг харгалзан үнэлгээний зэргийн түвшинг нэмэгдүүлж, эсхүл багасгаж болно.

3.7.Цагдаагийн алба хаагч нь аюулын зэргийн үнэлгээ хийхдээ орчин, хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн нөхцөл байдлыг боломжит бүх хэлбэрээр /дуу-дүрсний бичлэг, гэрэл зураг г.м/ баримтжуулна.

3.8.Цагдаагийн алба хаагч аюулын зэргийн үнэлгээ хийсэн тохиолдол бүрт холбогдох мэдээллийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд оруулна.

3.9.Аюулын зэргийн үнэлгээг зөвхөн цагдаагийн алба хаагч хийнэ.

3.10.Тэмдэглэлд гэр бүлийн гишүүд, гэрч, мэдээлэгчийн хувийн мэдээллийг бичихгүй, хохирогчийн гарын үсгийг зуруулахгүй.

3.11.Цагдаагийн алба хаагч аюулын зэргийн үнэлгээ хийсний дараа үнэлгээг хохирогчид танилцуулсан болон тэмдэглэлийг үнэн зөв хөтөлснөө баталгаажуулж, өөрийн гарын үсгээ зурна.

3.12.Хохирогч монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар аюулын зэргийн үнэлгээг хийж, гарын үсгийг нь зуруулна.

3.13.Хүүхдэд учирсан аюулын зэргийн үнэлгээг хийхдээ эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг байлцуулж болно. Хэрэв эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хохирогч хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй бол оролцуулахгүй бөгөөд энэ тухай тэмдэглэлд тусгана.

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн
A/183 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

Аюулын зэргийн үнэлгээ нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгчид авах арга хэмжээг тодорхойлох, хохирогч, хамаарал бүхий этгээдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний төрлийг сонгоход ач холбогдолтой тул асуултанд үнэн зөв хариулах талаар болон эрх, үүргийг нь хохирогч, хамаарал бүхий этгээд, гэрч нарт тайлбарлан өгнө.

АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭ		
Үнэлгээ хийсэн	Байгууллага	..... цагдаагийн газар, хэлтсийн ..... албан тушаалтай .... цолтой .....
	Огноо	.....он..... сар ..... өдөр
Хохирогчийн талаарх мэдээлэл		Ургийн овог: ..... Эцэг/эхийн нэр: ..... Нэр: ..... Регистр: ..... Хүйс: .....
Холбогдогчийн талаарх мэдээлэл		Ургийн овог: ..... Эцэг/эхийн нэр: ..... Нэр: ..... Регистр: ..... Хүйс: .....
Гэр бүлийн талаарх мэдээлэл		Гэр бүлийн байдал: ☐ гэр бүл, ☐ хамтран амьдрагч, ☐хамаарал бүхий этгээд. Дундаасаа хүүхэдтэй эсэх: ☐тийм, ☐ үгүй, хүүхдийн тоо: ..... Хэрэг, зөрчил гарахад хүүхэд байсан эсэх:☐ тийм, ☐ үгүй

Асуултын өмнөх “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн баганад оноо тавих ба “Тийм” гэсэн хариултад “1” оноо, “Үгүй” гэсэн хариултад “0” оноо тавина.

Хүчирхийллийн аюулын зэргийг тодруулах асуулт		тийм	үгүй
Асуулт № 1-3-ын аль нэгэнд “Тийм” гэж хариулсан бол “Өндөр” гэж үнэлнэ			
1	Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэх.		
2	Хохирогч, хамаарал бүхий этгээд хүчирхийлэлд өртсөний улмаас амь нас нь хохирсон, эрүүл мэндэд нь хүнд хохирол		

	учирсан, эмнэлгийн байгууллагад хэвтэн эмчлүүлж байгаа, хүчирхийлэл үйлдэгч галт зэвсэг, хутга, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэсэн, хэрэглэхээр заналхийлдэг эсэх.		
3	Хохирогч, хамаарал бүхий этгээд гэр бүлийн хүчирхийллийн улмаас амиа егүүтгэх сэдэл төрсөн, эсхүл оролдлого хийж байсан эсэх.		
Асуулт № 4-11			
4	Хүчирхийллийг хохирогч, хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй, хүндэвтэр, хохирол учирсан, эсхүл хүчирхийлэл үйлдэгч нь "өөрийнхөө амь насыг хохирооно, хамаарал бүхий этгээдийг ална" гэж сүрдүүлдэг, эсхүл хоолойг боох, багалзуурдах, амь насыг бодитой хохироох бусад оролдлого хийж байсан эсэх.		
5	Хүчирхийлэл үйлдэхдээ хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй, эсхүл хүүхдийн эмзэг байдлыг далимдуулан айдас, сэтгэл санааны дарамтад оруулах, өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олох, хамаарал бүхий этгээдийг дарамтлах хэрэгсэл болгон ашигладаг эсэх.		
6	Хүчирхийлэл үйлдэгч нь согтууруулах ундааны зүйл хэвшмэл, байнга, эсхүл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг эсэх.		
7	Хохирогч, хамаарал бүхий этгээдийг бэлгийн дарамтад оруулах, эсхүл биеийг нь үнэлүүлэх, гуйлга гуйлгах, хүнд хөдөлмөр хийлгэдэг эсэх.		
8	Хохирогч, хамаарал бүхий этгээдийг нийгмийн харилцаанаас тусгаарладаг, мөрдөн мөшгидөг эсэх. /Эцэг эх, төрөл садантайгаа харилцахыг хязгаарладаг, араас нь дагадаг, гадаад орчинтой хүчирхийлэл үйлдэгчээр дамжуулан харилцдаг эсэх, гэрийн хорионд байлгадаг, хүүхдийг хичээл сургуулиас завсардуулдаг эсэх/		
9	Хохирогч, хамаарал бүхий этгээдийг эдийн засгийн хараат байдалд оруулдаг эсэх. /Гэр бүлийн эд хогшлийг эвдэж устгадаг, барьцаанд тавьдаг, өр зээлэнд оруулдаг, цалин хөлсийг хурааж, захиран зарцуулах эрхийг хязгаарладаг, үл хайхардаг, хоол хүнс, дулаан орон байр, хувцас, хичээлийн хэрэгслээр гачигдуулдаг эсэх/		
10	Хүчирхийлэл үйлдэгч урьд өмнө гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шүүхээс эрүүгийн хэрэгт 1 буюу түүнээс дээш удаа ял, зөрчлийн хэрэгт 2 буюу түүнээс олон удаа шийтгэл хүлээж байсан эсэх.		
11	Хохирогч, хамаарал бүхий этгээдийг хэл амаар хорио цээртэй үгээр байнга гутаан доромжилдог эсэх. /Агсам тавих, хараах, зүхэх, хашгичих г.м/		

"Тийм" гэсэн хариултын нийлбэр оноог гаргаж, үнэлгээг зурж баталгаажуулах.
Нийлбэр оноо: ..... , ☐ Бага /0-3/, ☐ Дунд /4-7/, ☐ Өндөр /8-11/

Нөхцөл байдал /дуудлага, мэдээллийн газар, орчны нөхцөл байдал, хүчирхийлэл үйлдэгч болон хохирогч, хамаарал бүхий этгээдийн зан төлөв, сэтгэл санааны байдал, өгүүлэмж, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирол, орчны эд зүйлийн эвдрэл гэмтэл, хүүхдийн эрсдэлт нөхцөл байдал, нотлох баримт, хэдэн хүнээс асууж аюулын зэргийн үнэлгээний тэмдэглэл хөтөлсөн тоо г.м/ ямар байгааг тодорхойлж, хохирогч,

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 30 өдөр Дугаар А/243 Улаанбаатар хот

“Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам”-ын Хоёрт доор дурдсан агуулгатай 2.5, 2.6 дахь заалт нэмсүгэй:

“2.5.Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.2.2-т заасан хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийн талаарх мэдээлэл, хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх статистик мэдээллийг харьяа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад сар бүр бичгээр өгнө.

2.6.Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр “Нэг цэгийн үйлчилгээний төв” болон түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээнд хамруулсан иргэд, тэдэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг энэ журмын 2.4-т заасан цагдаагийн байгууллагын мэдээллийн санд оруулна.”

2.“Журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам”-ын 2.4 дэх заалтын а) дэд заалтын “талаарх” гэсний дараа “дуудлага,” гэж, г) дэд заалтын “гэмт хэрэг,” гэсний дараа “зөрчил,” гэж тус тус нэмсүгэй.

3.“Журам батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/25 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл

151300633

хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам”-ын дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1.1 дэх заалт:

“1.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 11.1.4-т заасны дагуу гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээллийг цуглуулж бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.”

2/3.1 дэх заалт:

“3.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл энэ журмын дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн хохирогчид үзүүлсэн үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллийн талаарх тоон үзүүлэлт, статистик мэдээллийг хагас, бүтэн жилээр нэгтгэн боловсруулж, хүчирхийллийн шалтгаан нөхцөл, гарч байгаа үр дагаварт дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.”

3/3.2.3 дахь заалт:

“3.2.3.шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллага хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийн хүрээнд энэ журмыг үндэслэн гэр бүлийн хүчирхийллийн талаарх тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хяналт тавьж ажиллах журмыг батлан хэрэгжүүлж болно.”

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/-т даалгасугай.

Х.НЯМБААТАР

1119287523 ШТТ6740 9131817

Doc\tushaal Said. 2020

хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдэд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээг хэрхэн үзүүлсэн болон үзүүлэх шаардлагатай талаарх санал, хүчирхийлэл үйлдэгчид авсан арга хэмжээг дэлгэрэнгүй бичнэ. ....
Дүгнэлт /нийлбэр оноо, хохирогч, хамаарал бүхий этгээдэд учирч болох эрсдэл, хохирогч, холбогдогч, хамаарал бүхий этгээд, гэрч нарын өгүүлэмж, харьцаа, зан байдал, хохирогчийн эрүүл мэнд, эд хөрөнгийн хохиролд ерөнхий дүгнэлт хийж бичнэ. Мөн үнэлгээнд тусгагдаагүй эрсдэлт хүчин зүйлсийг тэмдэглэнэ/. ....
Цаашид авах арга хэмжээ /хохирогч, хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах талаар анхаарах асуудал, нэн тэргүүнд үзүүлэх үйлчилгээг санал болгож бичнэ/. ....
Аюулын зэргийн үнэлгээ хийсэн: Цагдаагийн алба хаагч ..... /..... /
Аюулын зэргийн үнэлгээ хийхэд байлцсан орчуулагч, хэлмэрч: ...../..... /

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 26 өдөр Дугаар А/149 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, Хүүхэд хамгаллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгаллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажилтанд сургалт зохион байгуулах журмыг нэгдүгээр, давтан сургах хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолтод Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан чиг үүргийг тусган, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Т.Бадрахбаяр/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /М.Энх-Амар/-т тус тус үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус даалгасугай.

САЙД С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын сайдын
2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн
А/149 тушаалын нэгдүгээр хавсралт

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нийгмийн ажилтанд зориулсан /цаашид ажилтан/ гэх сургалт зохион байгуулахад энэхүү журмыг баримтална.

Хоёр. Сургалтын зорилго, зорилт

2.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий бүх шатанд ажиллаж буй ажилтны гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид нийгмийн үйлчилгээг шуурхай, цогц, хүртээмжтэй, чанартай хүргэх эрхзүй, онолын болон практик мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангах ажлын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. сургалтад оролцогчдод холбогдох хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх ур чадварыг эзэмшүүлэх;

2.2.2. сургалтыг тус журмын хоёрдугаар хавсралтад заасан давтан сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд чанартай зохион байгуулах;

2.2.3. сургалтын явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

Гурав. Удирдлага зохион байгуулалт

3.1. Сургалтын удирдамж, хөтөлбөр, сургалт зохион байгуулах хугацааг Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон Хамтарсан багаас захиалга, санал авч, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын жилийн бүрийн төлөвлөгөө, төсөвт тусгана.

3.2. Сургалтын захиалгыг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сургалт, судалгаа мэдээллийн төвд хүргүүлнэ.

3.3. Урьдчилан захиалга өгч төлөвлөгөөнд ороогүй сургалтын зардлыг захиалга өгсөн байгууллага хариуцана.

3.4. Сургалтыг захиалга, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон судалгааны үндсэн дээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын баталсан удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Сургалт, судалгаа мэдээллийн төв зохион байгуулна.

3.2. Сургалтыг үндэсний, бүсийн, орон нутгийн түвшинд танхимын болон зайны сургалт хэлбэрээр зохион байгуулж болно.

3.3. Мэргэшүүлэх буюу ахисан түвшний сургалтыг мэргэжлийн байгууллага, нийгмийн ажлын их, дээд сургуулиудтай хамтран зохион байгуулж болно.

3.4. Сургалт, судалгаа, мэдээллийн төв нь мэргэжлийн байгууллагатай хамтран мэргэшсэн үндэсний сургагч багш нарыг шаталсан хэлбэрээр бэлтгэж, гэрчилгээ олгоно.

3.5. Сургалтыг тодорхой сэдвийн хүрээнд бэлтгэгдэж, гэрчилгээ авсан эрх бүхий үндэсний сургагч багш нар болон мэргэжлийн багш нар заах эрхтэй бөгөөд сургалтыг зөвхөн батлагдсан хөтөлбөрийн дагуу явуулна.

Дөрөв. Сургагч багшид тавигдах шаардлага

4.1. Үндэсний сургагч багшаар бэлтгэгдэх ажилтныг мэдлэг, боловсрол, ажлын туршлага, өмнө хамрагдсан сургалт, туршлага дээр үндэслэн сонгож бэлтгэнэ.

4.2. Үндэсний сургагч багш нь хүмүүнлэгийн болон нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн магистр болон түүнээс дээш зэрэгтэй, хууль эрх зүй, нийгмийн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил төрийн болон төрийн бус байгууллагад ажилласан туршлагатай, насанд хүрэгчдэд зориулсан сургалтын арга зүй, техникийг эзэмшсэн байна

4.3. Үндэсний сургагч багшаар ажиллах гэрчилгээ авсан сургагч багш нарыг Сургалт, судалгаа мэдээллийн төвд бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

Тав. Суралцагчид тавигдах шаардлага

5.1. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалд анх томилогдсон албан хаагч /цаашид суралцагч гэх/ чиглүүлэх сургалтад заавал хамрагдаж гэрчилгээ авна.

5.2. Чиглүүлэх багц сургалтад хамрагдаж тухайн албан тушаалд 1-2 жил ажилласан албан хаагч мэргэшүүлэх дунд шатны сургалтад хамрагдаж гэрчилгээ авна.

5.3. Мэргэшүүлэх дунд шатны сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан суралцагч ахисан түвшний сургалтанд хамрагдаж гэрчилгээ авна.

5.4. Суралцагч сонгох багцаас сонгон судалж болох бөгөөд сургалтын захиалгыг жил бүрийн эцэст өгч, жилийн төлөвлөгөөнд оруулсан байна.

5.5. Суралцагч нь сургалт зохион байгуулагдах хугацаанд үүрэгт ажлаасаа бүрэн чөлөөлөгдөж, суралцах нөхцлөөр хангагдсан байна.

Зургаа. Сургалтад тавигдах шаардлага, хяналт

Сургалт нь энэхүү журмын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

6.2. Сургалт зохион байгуулахдаа албан ажилтнуудын хэрэгцээг тодорхойлох судалгааг авна.

6.3. Сургалтыг батлагдсан агуулга, хөтөлбөрийн дагуу байршил, цаг хугацаа, давтамжийн хувьд оновчтой зохион байгуулна.

6.4. Сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгаанд суурилсан үр дүнг бодитоор үнэлэх хяналт үнэлгээний арга, хэлбэр тодорхой байна.

6.5. Сургалтын үйл ажиллагаа, хэрэгжилтийн үйл явц, үр дүнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар тогтмол хяналт тавьж ажиллана.

6.6. Гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад мэргэжлийн байгууллагатай хамтран энэхүү журмын хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.

---------- o O o ----------

Хөдөлмөр,нийгмийн хамгааллын сайдын
2020 оны 06 дугаар сарын 26-өдрийн
А/ тушаалын хоёрдугаар хавсралт

ДАВТАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн зорилго: Давтан сургалтын зорилго нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажилтны гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчид үйлчилгээг шуурхай, цогц, хүртээмжтэй, чанартай хүргэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг сайжруулахад чиглэнэ.

Хөтөлбөрийн зорилт: Давтан сургалтын хөтөлбөр нь түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий бүх шатны нийгмийн ажилтны мэргэжлийн болон мэргэшлийн ур чадварыг сайжруулахад чиглэсэн онол, практикийн мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх, ажил, мэргэжлийн холбогдолтой хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах арга зүйн асуудлыг хамарсан байна.

Хоёр. Нийтлэг шаардлага

2.1. Давтан сургалтын хөтөлбөрт дараах нийтлэг шаардлага тавигдана.

2.1.1. ажлын байрны чиг үүрэгт нийцсэн зорилтот бүлэгтэй ажиллах мэргэжил, арга зүй, хөгжлийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан, үндэсний хууль тогтоомж, журам болоод олон улсын жишиг стандарт, шаардлагад нийцсэн байх;

2.1.2. сургалтын арга зүйг тодорхойлон, оролцогчдын мэдлэг чадвар, туршлага, хандлагыг хүндэтгэх;

2.1.3. мэдээлэл технологид суурилсан, туршлага, үр дүнгээ харилцан хуваалцах, шинэ санаачлагыг дэмжих;

2.1.4. танхимын болон ажлын байран дээр нь сургах сургалтын олон талт арга барилыг дэмжсэн, дэвшилтэт арга, технологи, цахим хэрэглэгдэхүүн, тэдгээрийг хэрэгжүүлэх орчин нөхцөлд тавигдах шаардлага нь тодорхой байх;

2.1.5. сургалтад хэрэглэгдэх болон бие даан судлах ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт үүсгэх;

ГУРАВ. ДАВТАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

№	Сургалтын сэдэв, агуулга	Хугацаа (60 минут)
	НЭГ. Чиглүүлэх багц сургалт	
1.1	Монгол Улсын үндсэн хууль	1
1.2	Гэр бүлийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмууд	2
1.3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох дүрэм, журмууд	2
1.4	Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль	1
1.5	Гэр хохирогчийг хамгаалах тухай хууль	2
1.6	Хүүхдийн эрхийн тухай хууль, холбогдох дүрэм, журмууд	2
1.7	Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох дүрэм, журмууд	2
1.8	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, холбогдох дүрэм, журмууд	
1.9	Зөрчлийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмууд	1
1.10	Эрүүгийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмууд	1
1.11	Бусад холбогдох хууль, тогтоомж, олон улсын эрх зүйн баримт бичгүүд	2
	Нийт цаг	***16***
	ХОЁР. Мэргэшүүлэх дунд шатны багц сургалт	
2.1	Гэр бүл, хүүхэд, олон нийттэй ажиллах нийгмийн ажлын онол, арга зүйн асуудал	4
2.2	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгаалал салбар дундын асуудал болох нь	2
2.3	Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал болон жендэрт суурилсан хүчирхийлэлийн тухай ойлголт	2
2.4	Гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч ба хүчирхийлэл үйлдэгчийн сэтгэл зүй	4
2.5	Хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл	4
2.6	Хүүхдийн хөгжил төлөвшил, оролцоо	2
2.7	Хүмүүжлийн эерэг арга, эцэг эх хүүхдийн харилцаа	4
2.8	Хамгааллын алхмууд: Кейс менежментийн нийтлэг арга зүй	4
2.9	Үйлчилгээний маягт бөглөх аргачлал	4
	Нийт цаг	***30***
	ГУРАВ. Мэргэшүүлэх ахисан түвшний сургалт	
3.1	Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн стандарт	4
3.2	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, тэдний гэр бүлийн эрх ба хэрэгцээг нөхцөл байдлын үнэлгээгээр тодорхойлох нь	2

3.3	Гэр бүлийн хүчирхийллийн эрсдлийг үнэлэх аргачлалууд	4
3.4	Гэр бүл, хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх онол арга зүй	4
3.5	Хохирогчид үзүүлэх эрх зүйн зөвлөгөө, туслалцаа	2
3.6	Гэр бүлийн хүчирхийллийн дунд, бага эрсдэлтэй гэр бүлийн хохирогчид зөвлөгөө өгөх арга зүй	2
3.7	Хүчирхийлэл үйлдэгчтэй ажиллах арга зүй, зан үйлд нөлөөлөх албадан ба сайн дурын сургалт, салбар хоорондын зохицуулалт	2
3.8	Хохирогчид үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ	4
3.9	Хүүхэд хамгааллын үйлчилгээ, төлөвлөлт, үе шат, хэлбэрүүд	4
3.10	Үйлчлүүлэгчийн болон өөрийн аюулгүй байдлыг хангах арга зүй	4
3.11	Хүүхэд хамгааллын кейс менежментийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх арга зүй	4
3.12	Хүчирхийллийн хохирогчдод нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх арга зүй	4
3.13	Бэлгийн хүчирхийлэлд болон ураг төрлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм сэтгэл, зүйн зөвлөгөө өгөх арга зүй	4
3.14	Бага насны хүүхдийг аюултай нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх “Хүрэхүй” хөтөлбөр, арга зүй	4
3.15	“Урлагийн сэтгэл засал” гарын авлага	4
3.16	Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий нийгмийн ажилтан болон холбогдох төрийн албан хаагчдад зориулсан гарын авлага	4
	Нийт цаг	***56***
	ДӨРӨВ. Сонгох сургалтууд	
4.1	Хамтарсан багийн гишүүдэд зориулсан багц сургалт	36
4.2	Хүүхэд хүмүүжлийн эерэг арга багц сургалт	36
4.3	Архины хамааралтай гэр бүлтэй ажиллах арга зүй	4
4.4	Хүүхдийн оролцоог дэмжих арга зүй	8
4.5	Мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах арга зүй (Хамтарсан багийн гишүүдэд зориулсан сургалт)	4
4.6	Хүүхдийн хөдөлмөрийн багц сургалт	16
4.7	“Эрх, үүрэг, оролцоо” амьдрах ухааны багц сургалт	40
4.8	Санхүүгийн баримт бүрдүүлэлт болон төсөл боловсруулах арга зүй (Хамтарсан багийн гишүүдэд зориулсан сургалт)	4

ТАНИЛЦУУЛГА

ЖУРМЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН ТУХАЙ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах"; 13.1.2-т "энэ хуулийн 13.1.1-д заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажилтныг давтан сургах хөтөлбөр болон сургалт зохион байгуулах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих" чиг үүргийг Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасны дагуу энэхүү журмын төслийг боловсруулав.

Журмын төслийн зорилго нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажилтны гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчид үйлчилгээг шуурхай, цогц, хүртээмжтэй, чанартай хүргэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, батлагдсан хөтөлбөрийн дагуу тасралтгүй суралцуулах, сургалтыг тодорхой чиглэлийн хүрээнд батлагдсан агуулгын дагуу зохион байгуулахад оршино.

Манай улсад 2005 оноос өмнө Хүчирхийллийн эсрэг үндэсний төв төрийн бус байгууллагын харьяа гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр нийслэлд болон Дундговь аймагт ажиллаж байсан бол өнөөгийн байдлаар төр болон ТББ-ын харьяанд хүчирхийллийн хохирогчдод зориулсан нийт 14 "Түр хамгаалах байр", 17 "Нэг цэгийн үйлчилгээний төв" ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд болох Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, НҮБ-ын Хүүхдийн Сан, Хүн амын сан, Японы Хүүхдийг Ивээх Сан, Дэлхийн зөн Монгол ОУБ гэх мэт байгууллагаас боловсруулсан хөтөлбөр, арга зүй, гарын авлага нь сургалтыг явуулах үндсэн нөөц, суурь болох юм.

Нийгмийн халамж, хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр анхан болон дунд шатанд ажилладаг нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах, тогтвортой ажиллуулах, салбар дундын зохицуулалтыг хангах шаардлагатай байна.

Цаашид Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нийгэмд тулгараад байгаа энэхүү асуудлыг бодлого зохицуулалтаар шийдвэрлэх гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх Нэг

цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байранд ажиллах салбар дундын мэргэжилтнүүдийг бэлтгэх, мэргэшүүлэх зүй ёсны шаардлага үүсээд байна.

Иймээс журмын төсөлд давтан сургалтын хөтөлбөрийн агуулгыг ажил мэргэжлийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга зүйн, мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, дадлагын сургалт гэсэн 3 үндсэн модультай байхаар боловсруулаад байна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 26 өдөр Дугаар А/150 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. "Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам"-ыг хавсралтаар батлалсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан журмыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлж, мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/-т, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар /М.Энх-Амар/-т, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Т.Бадрахбаяр/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т тус тус даалгасугай.

САЙД С.ЧИНЗОРИГ

ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДАЛ ТООЦОХ ЖУРАМ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2020 оны А/150 дугаар тушаалын хавсралт

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн (цаашид "хохирогч" гэх) амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг Түр хамгаалах байранд байрлуулж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах нэг хүнд ногдох хувьсах зардлыг (цаашид "хувьсах зардал" гэх) тооцоход энэхүү журмыг баримтална.

1.2. Энэхүү журамд заасан хувьсах зардлын бүрэлдэхүүн, зардал чиглүүлэгч болон зардлын дундаж нормативыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасны дагуу түр хамгаалах байрны нэгэн адил үйлчилгээ үзүүлдэг Нэг цэгийн үйлчилгээний төвийн хувьсах зардлыг тооцоход ашиглана.

1.3. Түр хамгаалах байранд байрлах хохирогчид төрийн бус байгууллагаас үзүүлсэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төлбөрийг хувьсах зардлаас санхүүжүүлнэ.

Хоёр. Хувьсах зардлын бүрэлдэхүүн

2.1. Түр хамгаалах байранд байрлах нэг хүнд ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүнд дараах бараа, үйлчилгээг хамааруулна.

2.1.1. хоол хүнс;

2.1.2. хувцас, ариун цэврийн хэрэгсэл;

2.1.3. төлбөртэй тусламж үйлчилгээ.

2.2. Түр хамгаалах байрны ажилтны цалин хөлс, урамшуулал болон түр хамгаалах байрны ашиглалтын тогтмол зардлыг хувьсах зардлын бүрэлдэхүүнд оруулан тооцохгүй.

2.3. Төр хариуцах дараах үйлчилгээг хувьсах зардлын бүрэлдэхүүнд оруулж тооцохгүй.

2.3.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.8-д заасан бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээ;

2.3.2. эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эмчилгээ үйлчилгээ;

2.3.3. нийгмийн халамжийн үйлчилгээ;

Гурав. Зардал тооцох

3.1. Түр хамгаалах байранд үйлчлүүлэх хохирогчийн тоог жилд 40-өөс илүүгүй байхаар, нэг хохирогчийн байрлах дундаж хугацааг 5 хоног байхаар тус тус тооцно.

3.2. Тухайн жилд түр хамгаалах байранд байрлах хүний тоо, насны болон хүйсийн харьцааг дараах байдлаар тооцно:

3.2.1. нийт хүний тоог сүүлийн гурван жилийн дунджаар;

3.2.2. байрлах нийт хохирогчийн 20 хувийг насанд хүрэгч, 80 хувийг хүүхэд байхаар;

3.2.3. нийт байрлах насанд хүрэгчдийн 90 хувийг эмэгтэйчүүд байхаар;

3.3. Цалин хөлсний зардлыг түр хамгаалах байранд үйлчлүүлэх хохирогчийн аюулгүй байдлыг хангах, дэмжин туслах үүрэг бүхий 2 орон тоог холбогдох төрийн үйлчилгээний албан тушаалд харгалзах жишгээр тооцно.

3.4. Хоол хүнсний зардлыг түр байрлах хохирогчийн нэг хоногт авах хоол хүнсний илчлэгийн хэмжээг насанд хүрэгчдийн хувьд "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн

шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын холбогдох хавсралтаар баталсан жишгийн дагуу, 1-18 насны хүүхдийн хувьд Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 225/296 тоот хамтарсан тушаалын холбогдох хавсралтаар баталсан жишгийн дагуу тус тус тооцно.

3.5. Тухайн жилд Түр хамгаалах байранд байрлах хохирогч бүр хувийн ариун цэврийн хэрэгслээр хангагдана гэж тооцох ба хувийн ариун цэврийн хэрэгсэл (шүдний оо, сойз, гар нүүрийн алчуур, гарын саван шампунь), ариун цэврийн цаас, хүүхдийн живх, эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэгсэл, дотуур хувцас (дотуур өмд, майк, оймс) зэргийг нэг багц болгож тооцно.

3.6. Төлбөртэй тусламж үйлчилгээнд дараах үйлчилгээг хамруулна:

3.6.1. Эрх зүйн үйлчилгээ: тухайн жилд түр хамгаалах байранд байрлах хохирогчид 100 хувь эрх зүйн туслалцаа (эрх зүйн зөвлөгөө болон өмгөөллийн үйлчилгээ) авна гэж тооцох бөгөөд эдгээр хүмүүсийн 50 хувь нь төлбөрийн чадваргүй иргэнд төрөөс үнэ төлбөргүй үзүүлэх өмгөөллийн үйлчилгээнд хамрагдахаар байна. Хохирогчид эрх зүйн туслалцааг нэг багц болгож үүнд хуулийн байгууллагад хүргүүлэх нотлох баримт бүрдүүлэхэд шаардлагатай нотариатын үйлчилгээ, болон өмгөөллийн үйлчилгээний хөлсийг хамруулна.

3.6.2. Холбон зуучлах үйлчилгээ: тухайн жилд Түр хамгаалах байраар үйлчлүүлэх хохирогчид 100 хувь гадагш гарч бусад үйлчилгээнд шилжиж хамрагдана гэж тооцох бөгөөд үүнд тээврийн хөлс, харилцаа холбооны зардлыг хамруулна. Бичиг баримтжуулах арга хэмжээнд 4 хүн тутмын нэг нь хамрагдана гэж тооцно.

3.6.3. Нөхцөл байдлын үнэлгээ: тухайн жилд Түр хамгаалах байраар үйлчлүүлэгч хохирогчид 100 хувь нөхцөл байдлын үнэлгээ хийлгэнэ гэж тооцож, хохирогчийн амьдарч байсан газарт хүрэх тээврийн хөлс, харилцаа холбооны зардлыг хамруулна.

3.6.4. Сэтгэл зүйн үйлчилгээ: сэтгэл зүйчийн орон тоогүй Түр хамгаалах байраар үйлүүлэгч нийт хохирогчийн 50 хувь нь гэж тооцох бөгөөд үүнд зөвлөгөө өгөх үйлчилгээний төлбөр хамаарна.

3.6.5. Эрүүл мэндийн үйлчилгээ: эмчийн орон тоогүй Түр хамгаалах байраар үйлүүлэгч хохирогчдын 4 хүн тутмын нэг нь хамрагдана гэж тооцох энэ журмын 2.3.1-2.3.2-т зааснаас бусад төлбөртэй тусламж үйлчилгээ болон эм тариа худалдан авах болон унааны зардал багтана.

3.6.6. Хүүхэд хамгаалал, хөгжлийн үйлчилгээ: Түр хамгаалах байранд байрлах хүүхдүүд энэ үйлчилгээнд 100 хувь хамрагдана гэж тооцох бөгөөд үүнд ном, бичиг хэргийн зүйлс, тоглоом худалдан авах зардал багтана.

Дөрөв. Хувьсах зардлын нийт хэмжээг тооцох

4.1. Хувьсах зардлын бүрэлдэхүүнд багтах бараа, үйлчилгээ тус бүрийг энэ журмын хавсралтаар баталсан "Түр хамгаалах байранд байрлах нэг хүнд ногдох хувьсах зардлын дундаж норматив" болон энэ журмын 3 дугаар зүйлд заасан холбогдох зардал чиглүүлэгчийг ашиглан түр хамгаалах байранд хуваарилах нийт хувьсах зардлын хэмжээг тооцоолно.

4.2. Тухайн Түр хамгаалах байрны зардлыг санхүүжүүлэх үүрэг хүлээсэн төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, төрийн бус байгууллага нь энэ журмын 4.1-д заасны дагуу шаардагдах төсвийн тооцооллыг боловсруулж жилийн төсвийн саналдаа тусгаж дээд шатны эсхүл асуудал хариуцсан байгууллагаар дамжуулж шийдвэрлүүлнэ.

Тав. Бусад

5.1. Энэ журмын хавсралтаар баталсан нэг хүнд нэг өдөр ногдох зардлын дундаж нормативыг гурван жил тутамд нэг удаа шинэчилнэ.

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд
ногдох хувьсах зардал тооцох журмын хавсралт

ТҮР ХАМГААЛАХ БАЙРАНД БАЙРЛАХ НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ

№	Хувьсах зардлын бүрэлдэхүүн	Зардлын дундаж норматив (төгрөг)
1.	Хоол хүнс	26,800
2.	Хувцас, ариун цэврийн хэрэгсэл	6,400
3.	Төлбөртэй тусламж үйлчилгээ, Үүнээс:	27,480
3.1	эрх зүйн үйлчилгээ	5,500
3.2	холбон зуучлах үйлчилгээ	4,620
3.3	нөхцөл байдлын үнэлгээ	2,610
3.3	сэтгэл зүйн үйлчилгээ	3,000
3.4	эрүүл мэндийн үйлчилгээ	3,750
3.5	хүүхэд хамгаалал, хөгжлийн үйлчилгээ	2,500
НИЙТ (1+2+3)		60,680

ГАРЫН АВЛАГЫН ЭХНИЙ ХЭВЛЭЛ ДЭЭР АЖИЛЛАСАН СУРГАГЧ БАГШ НАР

Г.Арсланхуяг	ЦЕГ-ын гэмт хэрэгтэй тэмцэх албаны ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа (Багийн ахлагч)
Б.Батзориг	ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа
А.Мөнхсувд	ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад
Ч.Нармөнх	ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн сэтгэл зүйч, цагдаагийн дэслэгч
Э.Баярбаясгалан	УБЦГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад
Б.Цэнгэлбаяр	ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах газрын Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа
Д.Болор	БЗДЦХ-2, хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч
Э.Тэмүүжин	Цагдаагийн сургалтын төвийн Сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН БАГ

Б.Бямбадагва	Баянгол дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор
Т.Жаргалсайхан	Хан-Уул дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор
Г.Батбаяр	Баянзүрх дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор
Г.Золзаяа	Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор
Р.Батнасан	Сүхбаатар дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор
У.Эрдэнэтуяа	УЕПГ-ын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн хяналтын прокурор
А. Дэлгэрмөнх	нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор

ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР (ХУУЧНААР)

С. Энхцэцэг	Тахарын ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БАГ

П.Баярцэцэг	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн шүүхийн сургалт хариуцсан ахлах референт (Багийн ахлагч)
Н.Одонтуул	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч
С.Алтанхуяг	ШЕЗ-ийн Шүүгчийн хүний нөөц хариуцсан референт
Н.Оюунтуяа	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
С.Билгүүн	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээлэл хариуцсан ахлах референт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН БАГ

Д.Сандаг	ШШГЕГ-ын Хууль, тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтсийн ахлах мэргэжилтэн (Багийн ахлагч)
Ц.Ганчимэг	ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх газрын ахлах мэргэжилтэн
Р.Оюун	Хорих 421 дүгээр ангийн сэтгэл зүйч